МОНГОЛ УЛС
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

ДОМИЙН ТӨМӨРТОГОО

МОНГОЛ ХЭЛНИЙ ТҮҮХЭН АВИА ЗҮЙН ҮНДЭС

УЛААНБААТАР
2017

МОНГОЛ УЛС
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН



Домийн ТӨМӨРТОГОО



МОНГОЛ ХЭЛНИЙ ТҮҮХЭН АВИА ЗҮЙН ҮНДЭС

Нэмэн дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл

Эрхлэн хэвлүүлсэн академич Л. БОЛД
профессор Ц. ӨНӨРБАЯН

УЛААНБААТАР
2017

ДАА 414
ННА 81.2-1
Т-587

© Д. Төмөртогоо
МОНГОЛ ХЭЛНИЙ ТҮҮХЭН АВИА ЗҮЙН ҮНДЭС

ISBN 978-99978-892-4-9

Хэвлэлийн эх бэлтгэсэн: А. Амарзаяа
Хавтасны дизайнер: Б. Эрдэнэбулган
Цаасны хэмжээ: 176х250
Хэвлэлийн хуудас: 33,6
Хэвлэсэн тоо: 300 ш

"Соёмбо принтинг" ХХК-д
хэвлэв.

MONGOLIAN ACADEMY OF SCIENCES
INSTITUTE OF LANGUAGE AND LITERATURE

PRINCIPLES OF THE HISTORICAL GRAMMAR OF MONGOLIAN

by
TUMURTOGOO Domii

ULAANBAATAR.
2017

НОМЫН БҮТЭЦ / ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ		9
0.	УДИРДХАЛ	11-159
0.1	**МОНГОЛ ХЭЛНИЙ ХӨГЖИЛИЙН ТҮҮХ, ТҮҮНИЙ ҮЕ ШАТ**	11-11
0.1.1	АЛТАЙН ХЭЛ БА МОНГОЛ ХЭЛ	11-44
0.1.2	МОНГОЛ ХЭЛНИЙ ГАРАЛ ҮҮСЭЛ, ТҮҮХЭН ХУВЬСАЛ	29-35
0.1.2.1	**ӨВӨГ МОНГОЛ ХЭЛ**	35-38
0.1.2.2	**ЭРТНИЙ МОНГОЛ ХЭЛ**	38-41
0.1.2.3	**ДУНДАД ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛ**	41-44
0.1.2.4	**ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛ**	44-44
0.2	**ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛ, АЯЛГУУНУУД**	45-48
0.2.1	ТӨВ МОНГОЛ ХЭЛ	48-53
0.2.2	ӨМНӨД МОНГОЛ ХЭЛ	54-58
0.2.3	ОЙРД ХЭЛ	58-64
0.2.4	БУРИАД ХЭЛ	64-68
0.2.5	МОГОЛ ХЭЛ	69-73
0.2.6	ДАГУУР ХЭЛ	73-78
0.2.7	МОНГОР ХЭЛ	78-82
0.2.8	ДУНСЯН ХЭЛ	82-85
0.2.9	БАОАНЬ ХЭЛ	86-89
0.2.10	ШАР ЁГУР ХЭЛ	89-92
0.3	**МОНГОЛЧУУДЫН ҮСЭГ БИЧИГ, БИЧИГИЙН ХЭЛ**	92-159
0.3.1.	МОНГОЛЧУУДЫН ҮСЭГ БИЧИГ	92-113
0.3.1.1	**ӨВӨГ МОНГОЛЧУУДЫН ҮСЭГ БИЧИГ**	92-97
0.3.1.2	**СОГД-УЙГУРЫН ГАРАЛТАЙ ҮСЭГ БИЧИГ**	97-107
0.3.1.2.1	УЙГУРЖИН МОНГОЛ БИЧИГ, ТҮҮНИЙ СУДАЛГАА	97-101
0.3.1.2.2	ТОД БИЧИГ, ТҮҮНИЙ СУДАЛГАА	101-105
0.3.1.2.3	ВАГИНДРАГИЙН ҮСЭГ, ТҮҮНИЙ СУДАЛГАА	105-107
0.3.1.3	**ЭНЭДХЭГ-ТӨВД ГАРАЛТАЙ ҮСЭГ БИЧИГ**	107-113
0.3.1.3.1	ДӨРВӨЛЖИН БИЧИГ, ТҮҮНИЙ СУДАЛГАА	107-111
0.3.1.3.2	СОЁМБО БИЧИГ, ТҮҮНИЙ СУДАЛГАА	111-113

0.3.2	МОНГОЛ БИЧИГИЙН ХЭЛНИЙ ТҮҮХЭН ҮЕ ШАТ	113-122
0.3.2.1	**СОНГОДОГ БИЧИГИЙН ӨМНӨХ МОНГОЛ БИЧИГИЙН ХЭЛ**	122-125
0.3.2.2	**СОНГОДОГ МОНГОЛ БИЧИГИЙН ХЭЛ**	125-127
0.3.3	МОНГОЛ ХЭЛНИЙ БИЧИГИЙН ДУРСХАЛУУД	127-159
0.3.3.1	**ХИТАН БИЧИГИЙН ДУРСХАЛУУД**	127-129
0.3.3.2	**УЙГУРЖИН МОНГОЛ БИЧИГИЙН ДУРСХАЛУУД**	129-137
0.3.3.2.1	**УЙГУРЖИН БИЧИГЭЭС САЛБАРЛАН ГАРСАН ҮСЭГ БИЧИГИЙН ДУРСХАЛУУД**	138-140
0.3.3.3	**ДӨРВӨЛЖИН БИЧИГИЙН ДУРСХАЛУУД**	140-144
0.3.3.4	**ХИТАД ҮСЭГЭЭР ТЭМДЭГЛЭСЭН МОНГОЛ ДУРСХАЛ**	145-155
0.3.3.5	**АРАБ ҮСЭГЭЭР ТЭМДЭГЛЭСЭН МОНГОЛ ДУРСХАЛ**	155-159
1	**ЭГШИГ АВИА**	160-250
1.1	БОГИНО ЭГШИГИЙН ТОГТОЛЦОО	161-180
1.1.1	**ҮГИЙН ТЭРГҮҮН ҮЕИЙН БОГИНО ЭГШИГ**	161-162
1.1.1.1	ТЭРГҮҮН ҮЕИЙН БОГИНО ЭР ЭГШИГ	162-168
1.1.1.1.1	**Уруулын богино эр эгшиг**	162-164
1.1.1.1.2	**Уруулын бус богино эр эгшиг**	165-168
1.1.1.2	ТЭРГҮҮН ҮЕИЙН БОГИНО ЭМ ЭГШИГ	168-171
1.1.1.2.1	**Уруулын богино эм эгшиг**	168-170
1.1.1.2.2	**Уруулын бус богино эм эгшиг**	170-171
1.1.2	ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН БОГИНО ЭГШИГ	172-176
1.1.2.1	ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН БОГИНО ЭР ЭГШИГ	172-172
1.1.2.1.1	**Уруулын богино эр эгшиг**	172-174
1.1.2.1.2	**Уруулын бус богино эр эгшиг**	174-176
1.1.2.2	ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН БОГИНО ЭМ ЭГШИГ	176-180
1.1.2.2.1	**Уруулын богино эгшиг**	176-178
1.1.2.2.2	**Уруулын бус богино эгшиг**	178-180
1.2	ЭГШИГ АВИАНЫ БАЙР	180-192
1.2.1	**ЭР ЭГШИГ АВИАНЫ БАЙР**	184-188
1.2.1.1	ТЭРГҮҮН ҮЕИЙН ЭР ЭГШИГИЙН БАЙР	184-185
1.2.1.2	ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН ЭР ЭГШИГИЙН БАЙР	186-188
1.2.2	**ЭМ ЭГШИГ АВИАНЫ БАЙР**	188-192
1.2.2.1	ТЭРГҮҮН ҮЕИЙН ЭМ ЭГШИГИЙН БАЙР	188-190
1.2.2.2	ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН ЭМ ЭГШИГИЙН БАЙР	190-192

1.3	ЭГШИГ АВИАНЫ ХУВЬСАЛ	192-250
1.3.1	**УРТ ЭГШИГ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛ, ХУВЬСАЛ**	192-192
1.3.1.1	АНХДАГЧ УРТ ЭГШИГ	193-195
1.3.1.1.1	**Тэргүүн үеийн анхдагч урт эгшиг**	195-195
1.3.1.1.2	**Тэргүүн бус үеийн анхдагч урт эгшиг**	196-196
1.3.1.2	ҮҮСМЭЛ УРТ ЭГШИГ	196-203
1.3.1.2.1	**Өргөлтөөс үүссэн урт эгшиг**	203-203
1.3.1.2.1.1	Өргөлтөт эр эгшигээс үүссэн урт эгшиг	203-206
1.3.1.2.1.2	Өргөлтөт эм эгшигээс үүссэн урт эгшиг	206-210
1.3.1.2.2	**Хагас эгшигээс үүссэн урт эгшиг**	210-212
1.3.2	**ХОС ЭГШИГ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛ, ХУВЬСАЛ**	212-221
1.3.2.1	ҮГИЙН ЭЦЭСИЙН ХОС ЭГШИГ	215-217
1.3.2.2	ҮГИЙН ЭЦЭСИЙН БУС ХОС ЭГШИГ	217-221
1.3.3	**ЭГШИГ АВИАНЫ ИЖИЛШИЛ**	221-228
1.3.3.1	ЭГШИГ АВИАНЫ ДЭВШИХ ИЖИЛШИЛ	228-231
1.3.3.1.1	**Богино эгшиг богино эгшигтэй дэвшиж ижилших нь**	228-230
1.3.3.1.2	**Урт эгшиг богино эгшигтэй дэвшиж ижилших нь**	230-231
1.3.3.2	ЭГШИГ АВИАНЫ УХАРАХ ИЖИЛШИЛ	231-239
1.3.3.2.1	**Богино эгшиг богино эгшигтэй ухарч ижилших нь**	232-234
1.3.3.2.2	**Богино эгшиг урт эгшигтэй ухарч ижилших нь**	234-239
1.3.4	**ЭГШИГ АВИАНЫ СУЛАРАЛ**	240-250
1.3.4.1	ҮГИЙН ТЭРГҮҮН ҮЕИЙН ЭГШИГИЙН СУЛАРАЛ	243-244
1.3.4.2	ҮГИЙН ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН ЭГШИГИЙН СУЛАРАЛ	244-250
1.3.4.2.1	**Бүтүү үеийн богино эгшигийн суларал**	244-247
1.3.4.2.2	**Задгай үеийн богино эгшигийн суларал**	247-250
2.	**ГИЙГҮҮЛЭГЧ АВИА**	251-325
2.1	ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ ТОГТОЛЦОО	251-277
2.1.1	**УРУУЛЫН ГИЙГҮҮЛЭГЧ**	254-258
2.1.1.1	УРУУЛЫН ХАМЖИХ ГИЙГҮҮЛЭГЧ	254-256
2.1.1.2	УРУУЛЫН ШҮРГЭХ ГИЙГҮҮЛЭГЧ	257-258
2.1.2	**ХЭЛНИЙ ГИЙГҮҮЛЭГЧ**	258-277
2.1.2.1	ХЭЛНИЙ УРДУУРХИ ГИЙГҮҮЛЭГЧ	258-258
2.1.2.1.1	**Хэлний урдуурхи, хамжих гийгүүлэгч**	259-260
2.1.2.1.2	**Хэлний урдуурхи хамжин шүргэх гийгүүлэгч**	260-264
2.1.2.1.3	**Хэлний урдуур шүргэх гийгүүлэгч**	265-267

2.1.2.1.4	**Хэлний урдуурхи хамарын гийгүүлэгч**	267-269
2.1.2.1.5	**Хэлний урдуур-хажуугийн гийгүүлэгч**	269-269
2.1.2.1.6	**Хэлний үзүүрийн чичирэх гийгүүлэгч**	270-270
2.1.2.2	ХЭЛНИЙ ДУНДУУРХИ ГИЙГҮҮЛЭГЧ	270-271
2.1.2.3	ХЭЛНИЙ ХОЙГУУРХИ ГИЙГҮҮЛЭГЧ	271-277
2.2	ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ БАЙР	277-294
2.2.1	**ГИЙГҮҮЛЭГЧ-ЭГШИГИЙН БАЙР**	279-282
2.2.2	**ГИЙГҮҮЛЭГЧ-ГИЙГҮҮЛЭГЧИЙН БАЙР**	283-294
2.3	ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ ХУВЬСАЛ	294-325
2.3.1	**ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ ТАГНАЙШИЛ**	294-295
2.3.1.1	ХАМЖИХ ГИЙГҮҮЛЭГЧИЙН ТАГНАЙШИЛ	295-297
2.3.1.2	ШҮРГЭХ ГИЙГҮҮЛЭГЧИЙН ТАГНАЙШИЛ	298-298
2.3.2	**ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ СУЛАРАЛ**	298-312
2.3.2.1	ҮГИЙН ЭХНИЙ ГИЙГҮҮЛЭГЧИЙН СУЛАРАЛ	299-302
2.3.2.2	ҮГИЙН ЭХНИЙ БУС ГИЙГҮҮЛЭГЧИЙН СУЛАРАЛ	302-312
2.3.2.2.1	**Үгийн дундах гийгүүлэгчийн суларал**	302-303
2.3.2.2.1.1	Шүргэх гийгүүлэгчийн суларал	303-305
2.3.2.2.1.2	Хамжих гийгүүлэгчийн суларал	305-307
2.3.2.2.2	**Үгийн эцэсийн гийгүүлэгчийн суларал**	308-312
2.3.3	**ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ СОЛИГДОЛ**	313-323
2.3.4	ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ СЭЛГЭЛТ	323-324
2.3.5	ГИЙГҮҮЛЭГЧ АВИА НЭМЭГДЭХ НЬ	324-325
3.	**ҮЕИЙН БҮТЭЦ, ХУВЬСАЛ**	326-335
3.1	ҮЕИЙН ДОТООД БҮТЭЦ	327-330
3.1.1	**ЗАДГАЙ ҮЕ**	329-329
3.1.1.1	ДАН ЭГШИГЭЭС БҮТСЭН ҮГ /V/	329-329
3.1.1.2	ГИЙГҮҮЛЭГЧ + ЭГШИГЭЭС БҮТСЭН ҮЕ /CV/	329-329
3.1.2	**БИТҮҮ ҮЕ**	330-330
3.1.2.1	ЭГШИГ + ГИЙГҮҮЛЭГЧЭЭС БҮТСЭН ҮЕ /VC/	330-330
3.1.2.2	ГИЙГҮҮЛЭГЧ + ЭГШИГ + ГИЙГҮҮЛЭГЧЭЭС БҮТСЭН ҮЕ /CVC/	330-330
3.2	ҮЕИЙН ТҮҮХЭН ХУВЬСАЛ	331-335
3.2.1	**ҮЕИЙН БҮТЭЦЭНД ГАРСАН ХУВЬСАЛ**	331-333
3.2.2	**ҮЕИЙН ТООНД ГАРСАН ХУВЬСАЛ**	334-335

ӨМНӨХ ҮГ

Монгол хэлний авиа зүйн судалал нь авианы бүтэц, бүрэлдэхүүн, байрлалын тухай асуудалыг багтаадаг бөгөөд тэдгээрийг судалахдаа юуны өмнө хэлний хөгжилийн өөр өөр үе шатны онцлог шинжийг хам цагийн үүднээс тогтоож, уламаар хам цагийн шинжүүдийг нь цуваа цагийн үүднээс харьцуулан судалах нь авиа зүйн судалгааны гол зорилго билээ.

Монгол хэлний авианы бүтэц, тогтолцоог цуваа цагийн үүднээс судалсан нь XIX зууны үеэс эхлэлтэй. Анх оросын эрдэмтэн А. А. Бобровников монгол хэлний урт, хос эгшигийн гаралыг түүхэн хувьсалынх нь талаас авч үзсэн бөгөөд хожим G. J. Ramstedt түүнийг улам гүнзгийрүүлсэн билээ. Түүний дараа академич Б. Я. Владимирцов, профессор N. Ропре, Г. Д. Санжеев, Ш. Хаттори, М. Номура нар монгол хэлний авианы олон талт үзэгдэлийг цуваа цагийн үүднээс тайлбарласан нь монгол хэлний авианы судалалыг шинэ түвшинд хүргэж чадсан байна. Монголын эрдэмтэдээс анх түрүүн академич Ш. Лувсанвандан авианы хувьсалын онолыг монгол хэлнийхээ бодит хөрсөн дээр буулгаж, эх хэлнийхээ эгшиг, гийгүүлэгч авианы хувьсан хөгжиж ирсэн зүй тогтолыг түүхэн үүднээс судалж, өмнөх эрдэмтэдийн судалгааг улам баяжуулан, урагш ахиулж, цаашдын судалгааны чиг хандлагыг тогтоож өгсөн билээ. Миний бие Лувсанвандан багшийнхаа дэргэд судалгааны ажилаа эхэлж, түүний судалгааны арга барилаас суралцан, цуваа цагийн судалгааг илүүтэй сонирхон, эрдэм шинжилгээний үгүүлэл бичиж, монгол хэлний түүхэн хэлзүйн хичээлийг олон жил заасан билээ. Сургалт, судалгааны ажилынхаа туршилга дээр үндэслэн 'Монгол хэлний түүхэн хэлзүй' хэмээх анхны бие даасан бүтээлээ нийтлүүлсэнээс хойш даруй 25 жил өнгөрч, энэ завсар монгол хэлний авианы бүтэц, тогтолцооны талаар гадаад, дотоодод олон шинэ бүтээл гарчээ.

'Монгол хэлний түүхэн хэлзүй' бүтээл маань гадаад, дотоодын их, дээд сургуульд сурах бичигийн чанартайгаар хэрэглэгдэж ирсэн бөгөөд эдүгээ олдоц муутай болж, дахин хэвлүүлэх санал хүсэлтийг хүлээн авсаар ирлээ. Энэ удаа би уул бүтээлийг дахин хэвлүүлэхдээ сүүлийн үеийн судалгааны бүтээлээр баяжуулсанаас гадна монголчуудын үсэг бичиг, бичигийн хэл, эртний бичигийн дурсхалууд, тэдгээрийн судалгааны тойм байдалыг багтаасан дэлгэрэнгүй удирдхал нэмэн оруулсан маань эх хэлнийхээ түүхийг шимтэн суралцах оюутан залууст эрхбиш тус дэм болох буй заа хэмээн итгэж байна.

ЗОХИОГЧ

У Д И Р Д Х А Л

0.1 МОНГОЛ ХЭЛНИЙ ХӨГЖИЛИЙН ТҮҮХ, ТҮҮНИЙ ҮЕ ШАТ

0.1.1 АЛТАЙН ХЭЛ БА МОНГОЛ ХЭЛ

§ 1. **Төрөл хэлний тухай ойлголт.** Түүхэн тодорхой нэгэн үед нийтлэг нэгэн хэв шинж бүхий хэлтэй байсан ард түмэн нийгэм, улс төр, эдийн засагийн бодит нөхцөл байдалаас шалтгаалан минга минган жилээр бие биеэсээ ангид саланги оршин суух болж, уламаар тэдгээрийн хэл аялгууны ялгаа нь улам бүр холдсоор яваандаа биеэ даасан хэд хэдэн өөр өөр хэл үүсэн бүрэлдэхэд хүрдэг байна. Тийнхүү эртний нэгэн хэв шинжтэй хэлнээс салбарлан гарсан язгуур нэгтэй хэлнүүдийг үүсэл гаралынх нь талаас *'төрөл хэл'* гэж нэрлэдэг байна.

Анх XIX зууны эхээр европын хэл шинжилэлчид энэдхэг болон европ хэлнүүдийн хооронд адил төстэй зүйл олон байгааг ажиглаад, тэдгээрийг түүхэн үүднээс харьцуулан судалах аргазүйг эрэлхийлж эхэлжээ. Үүний тул юуны өмнө, хэл тус бүрийн үндэсэн онцлог шинжүүдийг тогтоож, уламаар хэд хэдэн хэлийг харьцуулан судалах хэл шинжилэлийн аргыг боловсоруулжээ. Энэ талаар анх түрүүн германы эрдэмтэн Franz Bopp *'Санскрит хэл болон грек, латин, литов, гот, герман хэлнүүдийн үйл үгийн ялгалын харьцуулсан хэлний зүй'*[1] гэсэн томоохон судалгаа гарсан нь нэг талаар энэдхэг-европ хэлнүүдийн төрөлийг тогтоосон анхны бүтээл болсон төдийгүй, түүхэн харьцуулсан хэл шинжилэлийн онолын суурийг тавьжээ. Түүний дараа Rasmus Rask, Jakob Grimm, Wilhelm Humboldt нарын бүтээлүүд гарсанаар хэлний бодит баримт дээр суурилсан түүхэн харьцуулсан хэл шинжилэлийн онол бүрэлдэн тогтжээ.

Түүхэн харьцуулсан хэл шинжилэлийн хөгжил нь зөвхөн энэдхэг-европ хэлний төрөлийг тогтоогоод зогсоогүй, дэлхийн бусад олон хэлний төрөлийн холбоог тогтоох эхлэлийг тавьсан байна. Эдүгээ дэлхий дээр байгаа 3500 гаруй хэлийг гарал үүсэлийнх нь талаар *афро-азийн, дравидын, кавказын, малай-полинезийн, нигер-конгын, нил-сахарын, хитад-төвдийн, энэдхэг-европын* гэх зэрэг хорь гаруй төрөл хэлнүүдэд багтаан ангилж байна. Тэдгээрийн нэг нь түрэг, монгол, манж-тунгүүс зэрэг хэлнүүдийг багтаасан *'алтайн хэл'* юм.

Тухайн нэгэн хэв шинжит хэлнээс салбарлан гарсан төрөл хэлнүүд нь авианы тогтолцоо, үгийн бүтэц, үгүүлбэрийн байгуулал, үгсийн сангийн язгуур бүрэлдэхүүнийнхээ талаар өөр хоорондоо зохих хэмжээний нийтлэг шинжтэй байдаг бөгөөд тэрхүү нийтлэг шинж нь тухайн хэлнүүдийнхээ салсан цаг хугацаа хийгээд харь хэлний нөлөөлөөс шалтгаалан харилцан адилгүй байдаг байна. Мөн түүнчилэн түүхэн урт удаан хугацаанд айл зэрэгэлдээ оршин сууж, соёл иргэншил, шашин шүтлэг болон амьдарал ахуйн хувид ойр дөт холбоотой байсан

[1] Franz Bopp, Vergleichende Grammatik des Sanskrit, Zen, Griechischen, Lateinischen, Lituaischen, Gothischen und Dutschen, Berlin, 1833-52

төрөл бус хэлтэй ард түмэн ч бие биеэсээ олон тооны үг зээлдэн авч үгсийн сангийнхаа талаар төстэй болох явдал ч бас байдаг байна. Түүгээр ч үл барам, хүн төрөлхитөний хэлний нийтлэг хэв шинжийн хүрээнд төрөл бус хэлнүүд авианы бүрэлдэхүүн, үгийн бүтэц, үгүүлбэрийн бүтэцийнхээ талаар адил төстэй байх тохиолдол цөөнгүй. Тийм учираас төрөл хэлнүүдийг тогтоохдоо үг бүтэх арга, үгүүлбэрийн байгуулал, үгсийн сангийн өнгөц төстэй шинжид тулгуурлаж болохгүй, харин тухайн хэлнүүдийн авианы хувьсан хөгжих дотоод зүй тогтол, үг бүтэх ба хувьсах үндэсэн онцлог, үгүүлбэрийн ерөнхий тогтолцоо, үгсийн сангийн язгуур үгс зэрэгийг түүхэн үүднээс харьцуулан үзвэл зохино.

§ 2. **Алтайн хэлний тухай ойлголт**. Хэл шинжилэлтэнүүд XVIII зууны тэргүүн хагасаас эхлэн Төв Ази, Урал, Сибирээр оршин суугчидын хэл аялгууг харьцуулан судалаад, уламаар тэдгээрийн хооронд авианы тогтолцоо, үгийн бүтэц, үгүүлбэрийн байгуулал, үгсийн сангийн талаар адил төстэй зүйл олон байгааг олж ажиглаад, юуны өмнө, түрэг, монгол, манж-түнгүүс зэрэг хэлнүүдийг нийтэд нь *'алтайн хэл'* хэмээн нэрийдэх болжээ.

Хэл шинжилэл дэх алтайн төрөл хэлний тухай асуудалыг шведийн хэл судалаач Johann von Strahlenberg (1676-1747) анх үндэслэжээ. Тэрвээр Төв Ази, Урал, Сибир, Өвөр Кавказынханы хэл аялгууны үг бүтэх арга дээр тулгуурлан *угор* (финно-угор), *түрэг-татаар, самоед, монгол, манж-түнгүүс* болон Хар тэнгис, Каспийн тэнгисийн хоорондох аймагуудын хэлийг гарал нэгтэй төрөл хэл гэж үзээд тэдгээрийг нийтэд нь *'татаар хэлнүүд'* хэмээн нэрлэжээ.[2] Энэхүү ангилал нь Европ дахинд түүхэн харьцуулсан хэл шинжилэлийн онол бүрэлдэн тогтож, адил хэв шинжтэй төрөл хэлнүүдийг онолын үүднээс тогтоож эхэлсэнээс зуу шахам жилийн өмнөх үед холбогдож байна. Тийм учираас энэ нь түүхэн харьцуулсан хэл шинжилэлийн онол дээр тулгуурласан бус, олон хэл сурч судалсан тухайн судалаачийн гирхай ажиглалт, оновчтой таамаглалын үндэсэн дээр гарсан бүтээл юм. J. Strahlenberg-ийн ангилал нь зарим нэгэн өрөөсхөл хандлагатай ч гэсэн алтайн хэл шинжилэлийн онолыг үндэсийг тавьж, цаашдын судалгааны суурийг тавьж чадсанаараа нэн чухал ач холбогдолтой юм.

Түүнээс зуу гаруй жилийн дараа данийн хэл шинжилэгч Rasmus Rask (1787-1832) Strahlenberg-ийн анх тогтоосон *'татаар хэлнүүд'*-ийн дээр Гринланд, Хойд Америк, Умард Европоор оршин суудаг *эскимо,* Кавказын зарим хэл болон Испанийн баруун эрэгийн *баскчуудын* хэлийг нэмээд нийтэд нь *'скиф хэл'* гэж нэрлэжээ.[3] Rasmus Rask-ийн дараа германы нэрт эрдэмтэн Max Müller (1823-1900) *'скиф хэлнүүд'*-ийн дээр *сиам, төвд, дравид, малай* зэрэг өмнөд азийн хэлнүүдийг нэмээд нийтэд нь *'туран хэлнүүд'* хэмээн нэрийджээ.[4] Дээр дурдсан хэлнүүдийг бөлөглөхдөө тэдгээр хэлнүүдийн бүтэц, тогтолцооны нийтлэг шинжийг олон

---

2 Ph. J. Strahlenberg, Das nord-und östliche Theil von Europa und Asia, Stockholm, 1730

3 R. K. Rask, Den skytische Sproget, *Sammlede tilldels forhen utrykte Afhandlingen*, København, 1834

4 Max Müller, The Languages of the Seat of War in the East, With a Survey of Three Families of Languages, Semitic, Arian, and Turanian, London-Edinburgh-Leipzig,1855

талаар харьцуулан үзэлгүй, гагцхүү үг бүтэх шинжийг нь голлон авч үзсэн тул зөвхөн залгамал бүтэцтэй хэлнүүдийг багтаасан, өрөөсхөл шинжтэй ангилал болжээ. Хэдий тийм боловч харьцуулсан хэл шинжилэлийн түүхэнд төрөл хэлнүүдийг тогтоох зорилготой анхны томоохон ангилалуудын нэг байсан байна.

Алтайн төрөл хэлнүүдийг харьцуулсан хэл шинжилэлийн үүднээс илүү гүнзгийрүүлэн судалж, шинэчилэн тогтооход финий эрдэмтэн Alexander M. Castrén (1813-1852) чухал үүрэг гүйцэдхэжээ. Тэрвээр Төв Ази, Өмнөд Ази, Урал, Сибирь, Умард Европ, Умард Америк, Гринланд, Атландын далайн зүүн эрэг зэрэг өргөн уудам нутагт оршин суугчидын хэл аялгууг багтаасан төрөл хэлний тухай өмнөх ойлголтыг бүтэц, тогтолцооны үүднээс авч үзээд, зөвхөн *финно-угор, самоед, түрэг, монгол, манж-тунгүүс* гэсэн зургаан хэлийг төрөл хэл хэмээн үзэж, тэдгээрийг *'алтайн хэлнүүд'* хэмээн нэрлэжээ.[5] Түүний дараахан германы эрдэмтэн Wilhelm Schott (1802-1889) A. Castrén-ий тогтоосон зургаан хэлийг өөр хоорондоо холбоотой төрөл хэл гэдэгийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийг дотор нь *чүд хэлнүүд* (= финно-угор), *татаар хэлнүүд* (= түрэг, монгол, манж-түнгүүс) гэсэн хоёр бүлэг хэл болгон хуваажээ.[6] Түүний энэ ангилал нь *'урал-алтайн хэл'*-ний онолын суурь болж, яваандаа финно-угор, самоед хэлийг *'урал хэл'*, түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүдийг *'алтайн хэл'* гэж тус тусад нь авч үзэх болсон байна. Урал-алтайн хэлний онолыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх талаар австрийн эрдэмтэн Hugo Winkler (1863-1930), францын эрдэмтэн A. Sauvageot (1897-1945), оросын эрдэмтэн С. М. Широкогоров (1887-1939), финий эрдэмтэн Martti Räsänen (1893-1976) нарын олон бүтээл гарсан байна.[7] Сүүлийн үед урал хэлнүүдийг энэдхэг-европын хэлнүүдтэй гаралын холбоотой гэсэн үзэл санаа ч бас гарах болсон байна.[8]

A. Castrén-ий үндэслэсэн *'алтайн хэлний онол'* нь их төлөв *түрэг, монгол, манж-тунгүүс* хэлнүүдийн хүрээнд хөгжсөөр иржээ. XX зуун гарсаар финий Gustav J. Ramstedt (1873-1950), унгарын Julius Nemeth (1890-1976), Zoltan Gomboz (1877-1935), польшийн Wl. Kotwicz (1872-1944), америкийн Nikolas Poppe (1897-1991) нар *'алтайн хэл'*-ний онолыг цаашид гүнзгийрүүлж, тэдгээр хэлнүүдийн бүтэц, тогтолцооны нийтлэг шинж хийгээд алтайн өвөг хэлний талаар олон томоохон судалгааны бүтээлүүд гаргажээ.[9] Тэдгээрийн олонхи нь эдүгээгийн түрэг,

---

5 A. M. Castren, Über die personalaffixe in den altaischen Sprachen, *Kleiner Schriften*, St. Petersburg, 1862

6 W. Schott, Über das altaische oder finnisch-tatarische Sprachengeschlecht, Berlin, 1849; Altaische Studien oder Untersuchungen auf dem Gebiete der tatarischen (turanischen) Sprachen, Berlin, 1860

7 H. Winkler, Ural-altaische Völker und Sprachen, Berlin, 1884; Das Ural-altaische und seine Gruppen, Berlin, 1886; A. Sauvageot, Recherches sur le vocabulaire des langues ouralo-altaïques{= Coll. Ling. Soc. de Linguistique de Paris, XXX}, Paris, 1930, XLII+142; S. M. Shirokogoroff, Ethnological and Linguistical Aspects of the Ural-Altaic Hypothesis, Peiping,1931; M. Räsänen, Zur Lautgeschichte des türkischen Sprachen, Helsinki, 1949

8 D. Sinor, Indo-européen et ouralo-altaïque, T'P 37, 1944; Altajische Kulturwörter im Slavischen, UAJb 33, 1960, 107-116

9 G. J. Ramstedt, Einführung in der altaische Sprachwissenschaft, I. Lautlehre, {= MSFOu 104:1}, Helsinki, 1957, 192 S. id. II. Formenlehre, {= MSFOu 104:2}, Helsinki, 1952, 3-262;

монгол, манж-түнгүүс хэлнүүдийг өвөг алтайн хэлнээс салбарлан гарсан нэг гаралтай төрөл хэлнүүд гэж үзээд, тэдгээрийн авиа зүй, үгзүй, үгсийн сангийн нийтлэг шинжүүдийг харьцуулан судалсан нь алтай хэл шинжилэлийн онолын гол үндэс нь болсоор иржээ.

XX зууны эхээр G. J. Ramstedt, Е. Д. Поливанов (1891-1938) нар япон, солонгос хэлийг алтайн хэлэнд багтаан үзэх эхлэлийг тавьсан[10] бөгөөд түүнээс хойш оросын эрдэмтэн С. А. Старостин[11], америкийн эрдэмтэн A. Vovin[12] нар ч мөн япон хэлийг алтайн хэлэнд хамааруулан үзсэн байна. Тийнхүү алтайн төрөл хэлний хүрээ тэлж ирсэний хэрээр тэдгээрийг дотор нь *'Микро Алтайн хэлнүүд'* (түрэг, монгол, манж-түнгүүс), *'Макро Алтайн хэлнүүд'* (түрэг, монгол, манж-түнгүүс, япон, солонгос) хэмээн ангилж үзэх шинэ хандлага гарсан байна.

§ 3. **Алтайн хэлний онол**. Алтайн хэлний тухай бүрхэг бүдэг таамаг төдий байсан ойлголтыг түүхэн харьцуулсан хэл шинжилэлийн шинэ судалгаагаар баяжуулан, онолын бодит үндэслэл бүхий тогтолцоотой онол болгосон хүн бол финий нэрт эрдэмтэн G. J. Ramstedt юм. Тэрвээр *түрэг, монгол, манж-түнгүүс* хэлнүүдийн авианы тогтолцоо, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэр хийгээд хувьсан хөгжих ерөнхий зүй тогтолыг нь түүхэн үүднээс харьцуулан судалаад, тэдгээрийн хооронд адил төстэй, нийтлэг зүйл олон байгааг олж тогтоосоныхоо үндэсэн дээр тэдгээр хэлнүүдийг *'өвөг алтайн хэл'*-нээс салбарлан гарсан төрөл хэлнүүд гэдэг онолын үндэсийг боловсоруулжээ. Алтайн хэлний онолын үндэсийг тавьсан түүний эхэн үеийн гол бүтээлүүд гэвэл: *'Халх монгол хэлний үйл ялгалал',*[13] *'Алтайн хэлнүүдийн тооны нэр',*[14] *'Монгол-түрэг хэлнүүдийн үйл үг бүтэх ёс',*[15] *'Монгол хэлний уруулын шүргэх гийгүүлэгчийн түүхэн хувьсал',*[16] *'Монгол-түрэг хэлний*

J. Nemeth, Die türkisch-mongolische Hypothese, ZDMG 66, 1912, 549-576; Z. Gombocz, Zur Laut-geschichteder altaischen Sprachen, KSz 13, 1912, 1-37; Wl. Kotwicz, Les pronouns dans les langues altaïques, *Mémoires de la commision orientaliste* 24, Krakow, 1936, 3-80; Studia nad jezykami altajiskimi, wydal Marian Lewicki, RO 16, 1953, 1-318; N. Poppe, Vergleichende Grammatik der altaischen Sprachen, Teil I, Vergleichende Lautlehre, Wiesbaden, 1960, 1-188; Introduction to Altaic Linguistics, Wlesbaden, 1965, 1-212

10 G. J. Ramstedt, Comparison of the Altaic Languages with Japanese, *Transactions of the Asiatic Society of Japan,* 1924, II, 41-54, Remarks on the Korean Language, JSFOu 58, 1924, 441-458; Е. Д. Поливанов, К вопросу о родственных отношениях корейского и алтайских языков, ИАН СССР, сер. 6, 1927, 1195-1204

11 С. А. Старостин, Алтайская проблема и происхождение японского языка, М., 1991, 1-190

12 A. Vovin, Long-distance Relationships, Reconstruction Methodology and the Origins of Japanese, Diachronice, II, 1994, 95-114

13 G. J. Ramstedt, Über die Konjugation des Khalkha-Mongolischen {= MSFOu 19} Helsinki, 1902, 128

14 G. J. Ramstedt, Über die Zahlwörter der altaischen Sprachen, JSFOu 24, 1907, 1-24

15 G.J. Ramstedt, Zur Verbstammbildungslehre der mongolisch-türkischen Sprachen, JSFOu 28:3, 1912, 86 S.

16 G. J. Ramstedt, Zur Geschichte des labialen Spiranten im Mongolischen, *Festschrift Vilhelm Thomsen*, Leipzig, 1912, 182-187

авианы хувьсалын түүх',[17] *'Монгол-түрэг өвөг хэлний үгийн эхний дуугүй гийгүүлэгч'*[18] зэрэгийг дурдаж болно. Тэрвээр алтайн хэлний онолын талаар олон жил хийсэн судалгаан дээрээ үндэслэн *'Алтайн хэл шинжилэлийн удирдхал'* хэмээх томоохон бүтээл туурвисаныг хожим түүний шавь P. Aalto (1917-1998) нийтлүүлсэн билээ.[19] Тэрхүү бүтээлд түрэг, монгол, манж-түнгүүс, солонгос хэлний эгшиг, гийгүүлэгч авианы тогтолцоо, байрлал, хувьсал хийгээд нэр үг, үйл үгийн бүтэц, холбогдох арга хэлбэр, тооны үг болон төлөөний үгийн бүтэц, тогтолцоо, үг бүтээх дагаваруудыг харьцуулсан тодорхой жишээ баримттайгаар дурджээ. Алтайн язгуурын хэлнүүдийн талаар түүний дэвшүүлэн гаргасан шинэлэг үзэл санаа нь тухайн үеийнхээ хэл шинжээчидэд зохих хэмжээгээр нөлөөлж энэ талаар хэд хэдэн сонирхолтой бүтээлүүд гарчээ. Тухайлвал, мажарын нэрт түрэгч J. Nemeth түрэг, монгол хэлнүүдийн нийтлэг шинж, тэдгээрийн гарал үүсэлийн талаархи Ramstedt-ийн онолын талаар эхэндээ эргэлзээтэй хандаж байсан боловч[20] тэдгээрийн төрөл болохыг яваандаа хүлээн зөвшөөрөхөд хүрсэн төдийгүй, уламаар тэдгээрийн хөгжилийн түүхийг өвөрмөц байдалаар үечилсэн байна.[21] Мөн мажарын хэлшинжилэлч Z. Gombocz дээрхи онолыг цаашид үргэлжилүүлэн манж-түнгүүс, монгол, чуваш хэлний авианы тогтолцоо, тэдгээрийн харилцан уялдаа холбооны талаар онц сонирхолтой үгүүлэл нийтлүүлжээ.[22]

Зөвлөлтийн нэрт монголч Б. Я. Владимирцов (1884-1931) Ramstedt-ийн анх үүсгэсэн алтайн хэлний онолыг дэмжиж *түрэг, монгол, түнгүүс-манж* хэлнүүдийг *'өвөг алтайн хэл'* хэмээх эртний нэгэн нийтлэг хэлнээс салбарлан гарсан төрөл хэл гэж үзжээ.[23] Мөн нэрт алтайч Wl. Kotwicz *түрэг, монгол, манж-түнгүүс* хэлнүүдийг харьцуулан судалаад, тэдгээрийн авианы тогтолцоо, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэрийн талаар харьцуулан судалсан[24] боловч дурдсан хэлнүүдийг нэг гаралтай, төрөл хэлнүүд гэж үзсэнгүй, харин уулаасаа ойр төстэй төрөл бус хэлнүүд бие биедээ нөлөөлсөний үр дүн гэж тайлбарласан байна.[25]

Ramstedt-ийн үндэслэсэн алтайн хэл шинжилэлийн онолыг улам цаашид

---

17 G. J. Ramstedt, Zur mongolisch-türkischen Lautgeschichte. I. KSz 15, 1914, 134-150; II. KSz 16, 1915, 66-84

18 G. J. Ramstedt, Ein anlautender stimmloser Labial in der mongolisch-türkischen Ursprache, JSFOu 32:2, 1916, 10 S.

19 G. J. Ramstedt, Einführung in der altaische Sprachwissenschaft, I. Lautlehre, Bearbeited und herausgegeben von Pentti Aalto, {= MSFOu 104:1}, Helsinki, 1957, 11-192; id. II. Formenlehre, Bearbeited und herausgegeben von Pentti Aalto, {= MSFOu 104:2}, Helsinki, 1952, 3-262

20 J. Nemeth, Die türkisch-mongolische Hypothese, ZDMG 66, 1912, 549-576

21 J. Nemeth, Über den Ursprung des Wortes. *Schaman* und einige Bemerkungen zur türkisch-mongolischen Lautgeschichte, KSz 14, 1914, 240-249

22 Z. Gombocz, Zur Lautgeschichte der altaischen Sprachen, KSz 13, 1912, 1-37

23 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Л., 1929, 44-47

24 Wl. Kotwicz, Contributions aux études altaïques, I-III RO 7(1929-1930) 130-234; IV-V RO 12(1936), 122-142

25 Вл. Котвич, Исследование по алтайским языкам, перевод с польского, М., 1962, 23-46

үргэлжилүүлэн тууштай хөгжүүлсэн хүн бол нэрт эрдэмтэн N. Poppe (1897-1991) юм. Тэрвээр монгол, түрэг хэлнүүдийн авианы тогтолцоо хийгээд үгийн бүтэцийг түүхэн үүднээс харьцуулан судалаад, тэдгээрийн нийтлэг хэв шинжийг тодорхой жишээ баримтуудаар баталгаажуулан гаргасан нь алтайн хэл шинжилэлийн судалалд нэн чухал байр эзэлж байна. Тухайлвал, *авианы түүхэн хувьсалын талаар*: *'Алтайн хэлнүүдийн гийгүүлэгчийн тогтолцоо',*[26] *'Алтайн хэлнүүдийн дуугүй хамжих гийгүүлэгчийн тогтолцоо',*[27] *'Түрэг хэлэнд орсон монгол үгсийн эгшигийн уялдаа холбоо',*[28] *'Алтайн хэлнүүдийн эгшигийн сэлгэлт хийгээд уусан шингэх зарим тохиолдол',*[29] *үгийн бүтэцийн талаар: 'Монгол хэлний нэр үг бүтээх дагаварууд',*[30] *'Алтайн хэлнүүдийн олон тооны дагавар',*[31] *'Урал-алтайн хэлнүүдийн олон тооны дагаварын тухай судалгаа',*[32] *'Алтайн хэлнүүд дэх үйл үг бүтээх зарим дагавар',*[33] *'Алтайн хэлний олон тооны -*t дагавар',*[34] *үгсийн сангийн талаар: 'Дундад үеийн монгол хэлэнд орсон түрэг үгс',*[35] *'Алтайн хэлнүүд дэх орон сууцны холбогдолтой нэрс',*[36] *'Түнгүүс хэлэнд орсон эртний монгол хэлний зарим үгс',*[37] *'Эвенки хэлэнд орсон зарим монгол үгс',*[38] *'Алтайн хэлнүүдийн үгсийн сангийн харьцуулсан судалгаа',*[39] *алтайн хэлнүүдийн нийтлэг хэв шинжийн талаар:' 'Алтайн хэл ба өвөг түрэг хэл',*[40] *'Монгол-түрэг хэлний хэлхээ холбооны тухай асуудал',*[41] *'Алтайн хэлнүүдийн хэв шинж',*[42] *'Урал-алтайн хэлний нийтлэгийн тухай асуудал'*[43] зэрэг үгүүлэлийг дурдаж болно. Мөн тэдгээрээс гадна *'Алтайн хэлнүүдийн харьцуулсан хэл зүй'*[44] хэмээх томоохон бүтээлдээ түрэг, монгол, манж-түнгүүс, солонгос хэлний хамжих, шүргэх, хамжин шүргэх

---

26 Н. Поппе, К консонантизму алтайских языков, ДАН-В 1924, 11-13

27 Н. Поппе, Система глухих смычных в алтайских языках, ДАН-В 1925, 11-13

28 N. Poppe, On Some Vowel Corresondences in Mongolian Loan-Words in Turkic, CAJ 13:3, 1969, 207-214

29 N. Poppe, On Some Cases of Fusion and Vowel Alternation in the Altaic Languages, CAJ 19:4, 1975, 307-322

30 N. Pope, Die Nominalstammbildungssuffixe im Mongolischen, KSz 20, 1923-27, 89-126

31 N. Poppe, Plural Suffixes in the Altaic Languages, UAJb 24, 1952, 65-84

32 N. Poppe, Studies on Altaic and Uralic Plural Suffixes, FUF 31, 1953, 26-31

33 N. Poppe, Über einige Verbalstammbildungssuffixe in den altaischen Sprachen, *Orientalia Suecana* 21, 1973, 119-141

34 N. Poppe, The Altaic Plural Suffix -**t*, SO 47, 1977, 165-174

35 N. Poppe, The Turkic Loanwords in Middle Mongolian, CAJ 1:1, 1955, 36-42

36 N. Poppe, On Some Altaic Names of Dwellings, SO 28:3, 1964, 1-11

37 N. Poppe, On Some Ancient Mongolian Loan-Words in Tungus, CAJ 11:3, 1966, 187-198

38 N. Poppe, On Some Mongolian Words in Evenki, CAJ 16:1, 1972, 95-103

39 N. Poppe, Remarks on Comparative Study of the Vocabulary of the Altaic Languages, UAJb 46, 1974, 120-134

40 N. Poppe, Altaisch und Urtürkisch, UAJb 6, 1926, 94-121

41 N. Poppe, Einige Lautgesetze und ihre Bedeutung zur Frage der mongolisch-türkischen Sprachbeziehungen, UAJb 30:1-2, 1958, 93-97

42 N. Poppe, Der altaische Speachtyp, HdO Bd.V, Abschn. 2, 1964, 1-16

43 N. Poppe, The Problem of Uralic and Altaic Affinity, *Altaica*. Proceedings of the XIX Annual Meeting of the PIAC {=MSFOu 158}, Helsinki, 1977, 221-226

44 N. Poppe, Vergleichende Grammatik der altaischen Sprachen, Teil I.Vergleichende Lautlehre, Wiesbaden, 1960, IX+1-188

гийгүүлэгчид, үгийн тэргүүн болон тэргүүн бус үед орсон богино, урт эгшигүүд болон авианы суларалыг харьцуулан үзсэнээрээ алтайн хэлнүүдийн түүхэн харьцуулсан авиа зүйн судалалд үнэтэй хувь нэмэр болсон билээ. Мөн хожим алтайн хэлнүүдийн ангилал, тэдгээрийн судалгааны хураангуй түүх хийгээд алтайн хэл шинжилэлийн онолын үндэсэн асуудалыг багтаасан дэлгэрэнгүй тойм нийтлүүлсэн нь сургалт, судалгааны чухал ач холбогдолтой бүтээл болсон билээ.[45]

Алтайн төрөл хэлнүүд, тэдгээрийн нийтлэг зүй тогтолын талаар 60-70-аад оны үеэс эхлэн зөвлөлтийн эрдэмтэн Н. А. Баскаков (1905-1994,[46] О. П. Суник (1912-1988),[47] В. И. Цинциус (1903-1983),[48] финландын P. Aalto (1917-1998),[49] америкийн Udo Posch[50] зэрэг олон эрдэмтэдийн судалгааны бүтээлүүд гарчээ.

Алтайн төрөл хэлнүүдийн харьцуулсан судалгаа хийхийн тул юуны өмнө хэл тус бүрийн нарийвчилсан судалгааг хийх нь чухал гэдэгийг алтай судалалын нэрт эрдэмтэн J. Deny (1879-1963), J. Benzing (1913-2001), L. Ligeti (1902-1987), Г. Д. Санжеев (1902-1982), D. Sinor (1916-2004) нар онцлон тэмдэглэсэн байдаг билээ. Өнгөрсөн зууны дунд үеэс эхлэн түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүдийн хэл зүй, үгийн сангийн олон томоохон бүтээлүүд гарсан билээ. Тухайлвал, түрэг хэлний хэл зүйн талаар M. Räsänen (1893-1976), Н. К. Дмитриев (1898-1954), А. Н. Кононов (1906-1986), K. H. Menges (1908-1999), Н. А. Баскаков (1905-1996), Б. А. Серебренников (1915-1989), Э. Р. Тенишев (1921-2004), А. М. Щербак (1926-2008), Н. З. Гаджиева (1926-1991), Л. С. Левитская (1931-2009), M. Erdal (1945-), G. Doerfer (1920-2003), A. Rona-Tas нар[51] монгол хэлний хэл зүйн талаар N. Poppe, Г.

---

45 N. Poppe, Introduction to Altaic Linguistics {= *Ural-Altaische Bibliothek* XIV}, Wiesbaden, 1965, XIII+212 pp.

46 Н. А. Баскаков, Ареальная консолидация древнейших наречий и генетическое родство алтайских языков, ВЯ 4, 1970, 89-96; Материальные схождения алтайских языков (Тюркских, Монгольских и Тунгусо-Маньчжурских) в словоизменении и словообразовании, *'Алтайская семья языков и ее изучение'*, М., 1981, 56-92

47 О. П. Суник, Проблема общности алтайских языков, в кн: *'Проблема общности алтайских языков'*, Лгр., 1971, 7-21; К актуальным проблемам алтаистики, ВЯ 1, 1976, 16-30

48 В. И. Цинциус, Вопросы сравнительной лексикологии алтайских языков, *'Проблема общности алтайских языков'*, Лгр., 1971, 77-89; Задачи сравнительной лексико-логии алтайских языков, *'Очерки сравнительной лексикологии алтайских языков'*, Лгр., 1972, 3-14

49 P. Aalto, Uralisch und Altaisch, UAJb 41, 1969, 323-334; G. J. Ramstedt and Altaic Linguistics, CAJ 19, 1975, 161-193

50 Udo. Posch, On the Affinity of the Altaic Languages, CAJ3, 1957, 267-288; Die altaische Sprach verwandtschaft – Theorie oder Hypothese?, HdO Bd. V, Abschn. 2, 17-34

51 M. Räsänen, Mateialien zur Lautgeschichte der türkischen Sprachen {= StO 15}, Helsinki, 1949, 7-249; *idem.* Mateialien zur Morphologie der türkischen Sprachen {= StO 21}, Helsinki, 1957, 7-254; Н. К. Дмитриев, Исследования по сравнительной грамматике тюркских языков, I. Фонетика. 1955, 3-336; II. Морфология. 3-335; III. Синтаксис. 1961, 3-232; IV. Лексика. 1962, 3-128; А. Н. Кононов, Грамматика современного турецкого языка, М-Л., 1956, 3-570; K. H. Menges, The Turkic Languages and Peoples. An Introduction to Turkic Studies, Wiesbaden, 1968, 248; Н. А. Баскаков, Историко-

Д. Санжеев, Д. Амоголонов, Ш. Лувсанвандан (1910-1983), Чингэлтэй (1924-2013), Jan-Olof Svantesson, J. Janhunen нар,[52] манж-түнгүүс хэлний хэл зүйн талаар В. И. Цинциус, J. Benzing, E. Haenisch (1880-1966), В. А. Аврорин (1907-1977), О. П. Суник, Б. В. Болдырев, L. M. Gorelova нар[53] томоохон бүтээлүүд нийтлүүлжээ.

Мөн энэ хугацаанд түрэг хэлний үгсийн сангийн талаар M. Räsänen,[54] В. М. Наделяев,[55] G. Clauson,[56] Э. В. Севортян,[57], Sergei. A. Starostin -Anna Dybo - Oleg.

типологическая морфология тюркских языков, М., 1979, 3-274; А. М. Щербак, Сравнительная фонетика тюркских языков, Лгр., 1970, 3-198; *idem.* Очерки по сравнительной морфологии тюркских языков (Имя), Лгр., 1977, 3-190; Л. С. Левитская, Историческая морфология фонетика чувашского языка, М., 1976, 3-207; Б. А. Серебренников, Н. З. Гаджиева, Сравнительно-историческая грамматика тюркских языков, Баку, 1979, 3-302; Э. Р. Тенишев (ответст. ред), Сравнительно-историческая грамматика тюркских языков, Фонетика, М., 1984, 3-484; M. Erdal, Old Turkic Word Formation. A Functional Approach to the Lexocon, {= *Turcologica* 7} Vol. I-II, Wiesbaden, 1991, 3-874; G. Doerfer, Türkische und mongolische Elemente im Neupersischen, I-IV, Wiesbaden, 1963-1975; A. Rona-Tas, An Introduction to Turkology {= *Studia Uralo-Altaica* 33}, Szeged, 1991, 3-17

52 N. Poppe, Khalkha-mongolische Grammatik, Mit Bibliographie, Sprachproben und Glossar, Wiesbaden, 1951, XII+188; Introduction to Mongolian Comparative Studies, Helsinki, 1955, 300; Mongolian Language Handbook {= *Language Book Series*}, Washington, 1970,XV+175; Г. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, часть 1. 1953, 3-238; Д. Д. Амоголонов, Современный бурятский язык, Улан-Удэ, 1958, 5-336; Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний зүй I. Монгол хэлний авианы бүтэц, 1967, 3-129; II. Монгол хэлний үг, нөхцөл хоёр, 1968, 3-148; Чингилтэй, Odu üy-e-yin mongγol kelen-ü jüi, ÖMAKQ, 1979; Jan-Olof Svantesson and others, The Phonology of Mongolian, Oxford, 2005, XVI+1-314; J. Janhunen (ed.) The Mongolic Languages {= *Routledge Language Family Series*}, 2003, XXIX + 429; *idem,* Mongolian {= *London Oriental and African Language Library* 19}, Amsterdam | Philadelphia, XV + 1-320

53 В. И. Цинциус, Сравнительная фонетика тунгусо-маньчжурских языков, Лгр., 1949, 3-344; J. Benzing, Die tungusischen Sprachen. Versuch einer vergleichenden Grammatik, Wiesbaden, 1956, 4-145; E. Haenisch, Mandschu Grammatik mit Lesestücken und 23 Texttafeln, VEB Verlag Enzyklopädie, Leipzig, 1961, 91 S; В. А. Аврорин, Грамматика нанайского языка, М-Л., 1961, 3-283; О. П. Суник, Глагол в тунгусо-маньчжурских языках, М-Л., 1962, 3-363; Б. В, Болдырев, Словообразование имен существи-тельных в тунгусо-маньчжурских языках в сравнительно-историческом освещении, Новосибирск, 1987, 3-207; L. M. Gorelova (ed.), Manchu Grammar. HdO VIII, Brill, 2002, 142 pp.

54 M. Räsänen, Versuch eines etymologischen Wörterbuchs der Türkischen, Helsinki, 1969, XVI + 1-533 +1 + 135

55 В. М. Наделяев, Д. М. Насилов, Э. Р. Тэнишев, А. М. Щербак, Древнетюркский словарь, Лгр., 1969, XX + 1-676

56 G. Clauson, An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish, Oxford, 1972, 48 + 989 pp

57 Э. В. Севортян, Этимологический словарь тюркских языков: (Общетюркские и межтюркские основы, М., «Наука», I (1974):768 стр. II (1978):349 стр. III (1980):395 стр. IV (1989):291 стр. V (1997 pdf. 19 Mb), VI (2000 pdf. 2Mb), VII (2003 4 Mb)

Mudrak,[58] Д. М. Насилов - И. В. Кормушин - А. В. Дыбо - У. К. Исабеков,[59] монгол хэлний үгсийн сангийн талаар А. Mostaert,[60] Я. Цэвэл,[61] Ц. Норжин,[62] Л. Болд,[63] манж-түнгүүс хэлний үгсийн сангийн талаар В. И. Цинциус[64] нарын эмхэдхэн боловсоруулсан томоохон толь бичигүүд гарчээ.

§ 4. Алтайн хэлний онолыг үгүйсгэх чиглэл. Алтайн язгуурын хэлэнд багтаан үздэг түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүдийг эртний нэгэн өвөг хэлнээс салбарлан гарсан төрөл хэлнүүд гэж үзэх онол уламжилан хөгжиж ирсэн боловч XX зууны дунд үеэс тэрхүү онолыг үгүйсгэх хандлага гарч иржээ. Алтайн хэл шинжилэлийн талаар олон бүтээл туурвисан шведийн эрдэмтэн Björn Collinder (1894-1983) өвөг түрэг, өвөг монгол, өвөг түнгүүс хэл байсан гэдэгийг үгүйсгээгүй боловч Өвөг Алтайн хэл гэсэн эртний нэгэн нэгдмэл өвөг хэл байсан гэдэг онолыг үгүйсгэсэн байна.[65] Мөн яг тэр үеэр нэрт алтайч эрдэмтэн Wl. Kotwicz түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүдийг харьцуулан судалаад, тэдгээрийн хооронд авианы тогтолцоо, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэрийн талаар адил төстэй зүйлс байгаа ч гэсэн тэр бүхэн нь төрөл хэлнүүдийн шинж биш, харин төрөл бус хэлнүүдийн харилцан нөлөөлөлийн үр дүн гэж үзсэн байна.[66] Түүнчилэн унгарын эрдэмтэн L. Ligeti, данийн эрдэмтэн K. Grönbech (1901-1957), германы түрэгч эрдэмтэн G. Doerfer, америкийн эрдэмтэн D. Sinor нар өвөг алтайн хэлний онол болон түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүдийн харилцан хамааралын асуудалд эргэлзэж, цаашид хэл тус бүрийн нарийвчилсан судалгааг гүнзгийрүүлэх, юуны өмнө, түрэг-монгол, монгол-манж, манж-солонгос, япон-солонгос хэлний харьцуулсан судалгааг нарийвчилан хийх нь чухал гэж үзэцгээж байв.[67]

---

58 S. A. Starostin, A. Dybo, O. Mudrak (with assistance of Ilya Gruntov and Vladimir Glumov) An Etymological Dictionary of the Altaic Languages, {= *Handbook of Oriental Studies:* Uralic & Central Asian Studies 8/1-3), Leiden / Boston: E. J. Brill, 2003, vol. I-III 2096 pp.

59 Д. М. Насилов, И. В. Кормушин, А. В. Дыбо, У. К. Исабеков (eds.), Древнетюркский словарь, Издание второе, пересмотренное, Астана, 2016, XLVIII + 1-708

60 A. Mostaert, C.I.C.M. Dictionnaire Ordos, {=*Monumenta Serica* V}, Peking, I (1941):XII + 390; II (1942): 391-767; III (1944):769-950

61 Я. Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Уб., 1966, X + 1-911 // Монгол хэлний товч тайлбар толь, Нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл. (Үг, утга, жишээ, тайлбар, хавсралт тэргүүтнийг нэмж хянасан Ц. Шагдарсүрэн) Уб., 2013, XXII + 1-1311

62 Ц. Норжин (ed.), Mongγol kelen-ü toli, ÖMAKQ, 1997, 1-3142

63 Л. Болд (ed.), Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, Уб., 2008, I-V 3278

64 В. И. Цинциус, Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков, Материалы к этимологическому словарью, Лгр., том I. (1975) XXIX + 1-672, том II, 1977, 1-992

65 B. Collinder, Ural-Altaisch, UAJb 24, 1952, 1-26; Über das Problem der Verwandtschaft der uralischen Sprachen, Uppsala, 1948; Comparative Grammar of the Uralic Languages, Uppsala, 1960

66 Вл. Котвич, Исследование по алтайским языкам, Перевод с польского, М.,1962, 23-46

67 L. Ligeti, La théorie altaïque et la lexicostatistique, Researches un Altaic Languages, Budapest, 1974, 99-115; K. Grönbech, An Introduction to Classical (Literary) Mongolian, Wiesbaden, 1958,15; G. Doerfer, Türkische und mongolische Elemente im Neue-persischen, Bd. I. Wiesbaden, 1963, 51-105; Zur Verwandtschaft der altaischen Sprachen, IF 71, 1966, 81-123; Zwei wichtige Probleme der Altaistik, JSFOu 69, 1968, 1-21; Можно ли проблему родства алтайских языков разрещать с позиций индоевро-пейстики? ВЯ 3, 1972, 50-66;

Алтайн хэлнүүдийн гаралын тухай асуудал эрдэмтэдийн анхааралыг ихээхэн татаж, яваандаа өвөг алтайн хэлний онолыг үгүйсгэсэн сөрөг чиглэл бий болоход хүрчээ. Хамагийн түрүүнд англиийн түрэгч эрдэмтэн G. Clauson (1891-1974) *'Алтайн хэлний онолыг эсэргүүцэхийн учир'* гэдэг үгүүлэлдээ: *'Түрэг, Монгол хэлний эртний бичгийн дурсхалуудын үгсийн сангийн идэвхитэй үгсийн хооронд адил төстэй үгс нэн цөөн байгаа бөгөөд тэдгээрийн олонхи нь түрэг хэлнээс монгол хэлэнд орсон үгс байна* '[68] гэж тэмдэглээд уламаар түрэг, монгол аймагууд нь XII зуунаас өмнө олон зуун жил ойр дөт харилцаатай байсан тул тэдүгсийн сангийнхаа талаар адил төстэй гэж дүгнэжээ. Тэрвээр монгол хэлэнд орсон түрэг үгсийн тухай үгүүлэлдээ түрэг, монгол, түнгүүс хэлтэнүүд нь бүр манай эриний V зууны үеэс эхлэн олон зуун жил нягт хэлхээ холбоотой байсан тул тэдний хооронд үгсийн сангийн нийтлэг шинж бүрэлдэн бий болсон гэсэн дүгнэлт хийжээ.[69] Профессор G. Clauson эртний хэлнүүдийн салсан хугацааг үгсийн сангийн тооцоолон бодох аргаар тодорхойлох тухай америкийн хэл шинжилэлч Morris Swadesh-ийн боловсоруулсан арга[70] дээр тулгуурлан түрэг, монгол, түнгүүс хэлнүүдийн үгсийн сангийн язгуур үгийн харьцуулсан судалгаа хийжээ. Тухайлвал, VII зууны түрэг бичгийн дурсхал, XIV зууны монгол бичгийн дурсхал, XVIII зууны манж хэлний толь бичгээс 200 орчим үгийг сонгон авч, харьцуулан үзэхэд, түрэг-монгол хэлний хооронд тохирох үг дөнгөж 2 орчим хувь, монгол-манж хэлний хоорондын тохирох үг 3,5 хувь байна гэсэн тооцоо гарчээ.[71] Тэрхүү судалгааныхаа үндэсэн дээр түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүд нь гарал нэгтэй төрөл хэл бус, харин олон зуун жилийн турш айл хөрш байж, хэлнийхээ талаар харилцан нөлөөлсөний үр дүнд үгсийн сангийнхаа талаар нийтлэг шинжтэй болсон өөр өөр хэлнүүд юм гэж дүгнэсэн байна. Гэвч энэхүү судалгаа нь нэг талаар, энэдхэг-европ хэлний салсан оныг тооцоолон гаргах аргыг алтайн хэлний хэмжээнд шууд хэрэглэсэн, нөгөө талаар, өөр хоорондоо олон зуун жилийн зөрөөтэй дурсхалуудыг адил түвшинд харьцуулан үзсэнээрээ өрөөсхөл болсон талаар зарим эрдэмтэд шүүмжилсэн байдаг.[72]

---

idem. Базисная лексика и алтайская проблема, ВЯ 4, 1981, 33-44; D. Sinor, Observations on a New Comparative Altaic Phonology, *Bull. of the School of Oriental and African Studies,* 26, 1963, 133-144

68 G. Clauson, The Case against the Altaic Theory, CAJ 2, 1956, 182

69 G. Clauson, The Earliest Turkish Loan Words in Mongolian, CAJ 4, 1959, 174-187; The Turkish Elements in 14th Century Mongolian, CAJ 5, 1959-60, 301-316

70 Morris Swadesh, Towards Greater Accuracy in Lexicostatistic Dating, *International Journal of American Linguistics,* 21:18 1955, 121-137; Lexicostatistic Dating of Prehistoric Ethnic Contacts, *Proceedings of the American Philosophical Society,* vol. 96, 1952, 452-463

71 G. Clauson, A Lexicostatistical Appraisal of the Altaic Theory, CAJ 13, 1969, 1-23; *idem.* Лексико-статистическая оценка алтайской теории, ВЯ 5, 1969, 22-41

72 Л. Лигети, Алтайская теория и лексикостатистика, ВЯ 3, 1971, 23; L. Ligeti, La théorie altaïque et la lexico-statistique, *Researches in Altaic Languages,* Budapest, 1974, 99-115; G. Doerfer, Можно ли проблему родства алтайских языков разрещать с позиций индоевропейстики? ВЯ 3, 1972, 50-66; *idem.* Базисная лексика и алтайская проблема, ВЯ 4, 1981, 33-44

Профессор G. Clauson-ы энэхүү судалгаа гарсаны дараахан нэрт түрэгч А. М. Щербак (1928-2008) *'Хэл шинжилэл дэх алтайн хэлний тухай таамаглал'* гэдэг үгүүлэл нийтлүүлжээ.[73] Тэрвээр уул үгүүлэлдээ алтайн хэлний онолын талаар гарсан өмнөх судалгаануудын талаар тоймлон дурдаад, түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүдийн адил төстэй шинжийг төрөл хэлний ул мөр үү, эсвэл төрөл бус хэлнүүдийн харилцан нөлөөлөлийн үр дүн үү гэдэгийг эдүгээ хүртэл бүрэн тодорхойлж чадахгүй байгаа талаар дурджээ. Тэрвээр түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүдийн үгийн сангийн язгуур үгс болон үг бүтээх дагавар, үг холбох нөхцөлүүдийг харьцуулсан хэд хэдэн цуварал үгүүлэл нийтлүүлсэн[74] бөгөөд тэдгээр үгүүлэлдээ дурдсан хэлнүүдийн хоорондох адил төстэй шинж нь төрөл хэлний ул мөр бус, харин Төв Азийн нутаг дэвэсхэр дээр олон зуун жилийн турш айл хөрш оршин сууж, аж ахуй, шашин, соёлынхоо талаар харилцан хамааралтай байсаны уламаас бие биедээ нөлөөлж, олон тооны үгсийг зээлдэн хэрэглэж байсаны үр дүн юм гэсэн дүгнэлт хийжээ. Проф. Щербак хожим нийтлүүлсэн *'Түрэг-монгол хэлний эртний хэлхээ холбоо'*[75] гэдэг бүтээлдээ XIII-XIV зууны үеэс уламжилан үлдсэн эртний бичигийн дурсхалууд болон амьд хэл аялгуунуудын бодит материал дээр тулгуурлан төрөл саданы нэр томъёо, бие эрхтэний нэрс болон түгээмэл тохиолдож байгаа үгсийг харьцуулан үзээд, уламаар тэдгээр үгсийг түрэг хэлнээс хоёр үе шаттайгаар монгол хэлэнд нэвтэрэн орсон үгс гэж үзжээ.[76] Мөн 2005 онд хэвлүүлсэн *'Түрэг-монгол хэлний хэлхээ холбоо хийгээд монгол хэлний түүх'*[77] гэдэг томоохон бүтээлдээ эртний бичигийн дурсхалууд болон түрэг, монгол хэл дундын 430 орчим үгсийн харьцуулсан жишээг жагсааж, уламаар тэдгээрийг монгол хэлэнд орсон түрэг үгс хэмээн үзжээ.[78] Түрэг-монгол хэлний дундын үг бүрийг гагцхүү түрэг гаралтай үг хэмээн үзэх нь нэн өрөөсхөл хандлага гэдэгийг дурдвал зохино.

1987 онд Америкийн Станфорд хотноо болсон *'Хэлний хувьсал ба сэргээн тогтоох аргазүй'* гэсэн сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал дээр алтайн хэлний тухай асуудалаар хэлэлцүүлэг болж, S. Martin, J. Whitman, Larry Clark, J. M. Unger нар алтайн хэлнүүдийн нийтлэгийн тухай, өвөг алтайн хэлний онолын тухай асуудалд нилээд шүүмжилэлтэй хандсан байна. 1990-ээд оны сүүлчээр Германы

---

73 А. М. Щербак, Об алтайской гипотезе в языкознании, ВЯ 6, 1959, 51-63;

74 А. М. Щербак, О методике исследования языковых параллелей (в связи с алтайской гипотезой) *XXV Международный конгресс востоковедов,* М., 1960; О характере лексических взаимосвязей тюркских, монгольских и тунгусо-маньчжурских языков, ВЯ 3, 1966, 21-35; Содержание урало-алтайской гипотезы, ее обоснование и оценка, ИАН Азерб. ССР, 1, 1968, 62-70; О тюрко-монголо-тунгусских связах в морфологии, НАА 1, 1968, 104-116; *idem.* Тюркско-монгольские языковые связи. (К проблеме взаимо-действия и смешения языков), ВЯ 4, 1986, 47-59

75 А. М. Щербак, Ранние тюркско-монгольские языковые связи. (VIII-XIV вв.),СПб., 1997, 291 стр.

76 А. М. Щербак, Ранние тюркско-монгольские языковые связи, 15-224

77 А.М. Щербак, Тюркско-монгольские языковые контакты и истории монгольских языков, СПб., 2005, 195 стр.

78 А. М. Щербак, Тюркско-монгольские языковые контакты и истории монгольских языков, СПб., 2005, 19-69

Бонн их сургуулийн профессор Stefan Georg, Америкийн Иллинойз их сургуулийн профессор Peter A. Michaelove, Wayne их сургуулийн профессор Alexis Manaster Ramer, Австралийн Мельбурн их сургуулийн профессор Paul J. Sidwell нар хамтаран *'Ерөнхий хэл шинжилэлчид алтайн судалалын талаар үгүүлэх нь'*[79] гэсэн томоохон үгүүлэл нийтлүүлж, түүндээ алтайн хэлнүүдийн гарал үүсэл, өвөг алтайн хэлний онол, алтайн хэлнүүдийн цар хүрээ, хэв шинж хийгээд үгсийн сангийн нийтлэг тал, өвөг хэлний бүтэцийг сэргээн тогтоох аргазүй зэрэг алтайн хэл шинжилэлийн онолын гол чухал асуудалыг хөнджээ. Зохиогчид энд алтайн хэл шинжилэлийн суурь онол хийгээд түүнийг үгүйсгэгчидийн үзэл баримтлалын талаар дэлгэрэнгүй үгүүлээд эцэст нь *'Макро Алтайн хэл'*-нүүдийн хамааралыг зөвшөөрч байгаагаа дурдсан байна.

Америкийн эрдэмтэн, Хавай их сургуулийн профессор A. Vovin анхандаа түнгүүс, солонгос, япон хэлнүүдийг нийтлэг шинжтэй төрөл гэж үзэж байсан боловч сүүлийн үед уул саналаасаа ухарч, түрэг, монгол, манж-түнгүүс, япон, солонгос хэлийг төрөлийн холбоогүй гэж үзсэн бий.[80]

Алтайн хэлнүүдийн нийтлэг шинжийг үгүйсгэж байгаа эрдэмтэдийн олонхи нь алтайн хэлнүүдийн нийтлэг шинжийг тогтоохдоо гагцхүү үгийн сангийн төстэй шинжээс гадна авианы бүтэц, тогтолцоо, хувьсах зүй тогтол болон үгийн бүтэц, хэл зүйн хэлбэрүүд дээр тулгуурлах нь чухал хэмээн үзэж байна.

§ 5. **Алтайн төрөл хэлнүүд.** Сүүлийн зуугаад жилийн дотор алтайч эрдэмтэдийн хийсэн судалгаанууыг нэгдхэн үзвэл, түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүд бүр J. Strahlenberg-ийн үеэс A. M. Castrén, G.J. Ramstedt, Б. Я. Владимирцов, N. Poppe, Н. А. Баскаков, О. Суник, В. И. Цинциус, P. Aalto, J. Street нарын бүтээлд алтайн төрөл хэл гэдэг ойлголтын гол цөм нь байсаар иржээ. Хэдий тийм боловч алтайн хэлэнд багтах хэлнүүдийн хүрээг тодорхойлох асуудал өнөө хүртэл маргаантай байгаа билээ. Өнгөрсөн зууны эхээр солонгос, япон хэлийг алтайн хэлний хүрээнд хамааруулан үзэх шинэ хандлага гарч ирсэн бөгөөд энэ талаар G. Ramstedt-ийн' *Алтайн хэлнүүдийг япон хэлтэй харьцуулах нь'*,[81] *'Солонгос хэлний тэмдэглэл'*,[82] Е. Д. Поливановын *'Алтайн хэлнүүд ба солонгос хэлний төрөлийн хамааралын тухай асуудалд'*[83] зэрэг үгүүлэл гарчээ. XX зууны дундаас эхлэн япон, солонгос хэлийг алтайн хэлэнд хамааруулан үзэх талаар Sh.

---

79 Stefan Georg, Peter A. Michalove, Alexis Manaster Ramer, Paul J. Sidwell, Telling General Linguists about Altaic, JL, 35, 1998, 65-98

80 A. Vovin, The End of the Altaic Controversy, CAJ 49, 2005, 71-132; *idem.* Japanese, Korean, and Other *'Non-Altaic'* Languages, CAJ 53, 2009, 105-147

81 G. J. Ramstedt, Comparison of the Altaic Languages with Japanese, *Transactions of the Asiatic Society of Japan,* 1924, II, 41-54; Remarks on the Korean Language, MSFOu 58, 1928, 441-453

82 G. J. Ramstedt, Remarks on the Korean Language, MSFOu 58, 1928, 441-453

83 Е. Д. Поливанов, К вопросу о родственных отношениях корейского и алтайских языков, ИАН СССР сер. 6, 1927, 1195-1204

Hattori,[84] Ki Moon Lee,[85] Sh. Ozawa,[86] R. A. Miller,[87]A. Vovin,[88] Stefan Georg[89] нарын сонирхолтой бүтээлүүд гарч, алтайн төрөл хэлнүүдийн тухай ойлголтын хүрээ зохих хэмжээгээр тэлэхэд хүрчээ. Түүнчилэн профессор N. Poppe[90] өвөг алтайн хэлнээс салбарлан гарсан төрөл хэлнүүдийн гарал үүсэлийн тухай онолын төсөөлөлдөө солонгос хэлийг багтаасан бол John Ch. Street[91] мөн япон, солонгос хэлнүүдийг алтайн хэлэнд багтаасан байна.

Алтайн төрөл хэлнүүдийн дотороос хамагийн өргөн уудам нутагийг хамарсан, хамагийн олон үндэстэн ярилцдаг хэл нь түрэг хэл юм. Эдүгээ түрэг хэлээр ярилцагчид нь Түрк, Азербайжан, Дагестан, Түркмен, Узбек, Казах, Тажик, Киргиз, Башкир, Татар, Чуваш, Алтайн хизгаар, Тува, Якутын нийт газар нутаг хийгээд Македони, Грек, Болгар, Афганистан, Иран, Хитадын Шинжан-Уйгурын өөртөө засах ороны зарим хэсэгээр оршин сууж байна. Өөрөөр хэлвэл, түрэг хэлтэнүүд нь Адриатикийн тэнгисийн умард эрэгээс эхлэн Бага Азийн хойг, Умард Кавказ, Ижил мөрөний адаг, Дундад Дорнод, Дундад Ази, Баруун Сибирь, Умард Сибирь болон Хитадын Түрэгстаныг хүртэлхи өргөн уудам нутагийг хамарч байна.

Түрэг хэлнүүдийг гарал үүсэл, газар нутагийн байршил, авианы онцлог шинжийн талаас нь авч үзсэн олон ангилал байдаг бөгөөд бид энд проф. N. Poppe-гийн ангилалыг баримтлав. Нийт түрэг хэлнүүдийг гарал үүсэл, хэлний онцлог шинжээр нь чуваш хэл, түрэг хэлнүүд гэж хоёр үндэсэн хэсэгт хуваааж болох бөгөөд чуваш хэлтэнүүд нь ОХУ-ын Чувашын өөртөө засах улсад оршин суудаг ажээ. Түрэг хэлнүүдийг дотор нь 5 бүлэг хэлэнд хуваан үздэг байна. Үүнд: 1. *Якут,* 2. *Тува-хакасын бүлэг хэлнүүд* (Тува, Карагас, Шар Ёгур, Шор) 3. *Кыпчакын бүлэг хэлнүүд* (Карай, Кумык, Балкар, Крымийн Татаар, Ижилийн Татаар, Башкир, Ногай, Каракалпак, Хасаг, Киргиз, Алтай) 4. *Чагаадайн бүлэг хэлнүүд* (Узбек, Уйгур, Салар) 5. *Туркмений бүлэг хэлнүүд* (Туркмен, Гагауз, Турк, Азербайжан) эдгээр болно.

Алтайн төрөл хэлэнд багтах хоёрдох гол хэл нь монгол хэл юм. Монгол хэлтэнүүд нь Монгол улс болон ОХУ-ын Дорнод Сибирь, Ижил мөрөний адаг, БНХАУ-ын Өвөр Монгол, Манжуурын зарим хэсэг, Ганьсу, Цинхай муж,

---

[84] Sh. Hattori, The Relationship of Japanese to Ryukyu, Korean and Altaic Languages, *Transactions of the Asiatic Society of Japan*, 1948, 3rd Series 1, 103-033

[85] Ki-Moon. Lee, A Comparative Study of Manchu and Korean, UAJb 30, 1958, 104-120

[86] Sh.,Ozawa, A Comparative Study of Some Words in Old Japanese and Middle Mongolian, Tokyo, 1968, 147

[87] R. A. Miller, Japanese and the Other Altaic Languages, Chicago, 1971, XVIII+331

[88] A. Vovin, Korea-Japonica: A Re-evaluation of a Common Genetic Origin. Hawaii Studies on Korea. Honolulu: University of Hawai'i Press, 296 pp.

[89] Stefan Georg, Japanese, the Altaic Theory, and the Limits of Language Classification, *'Perspectives on the Origin of the Japanese Language'* edited by A. Vovin & T. Osada, Kyoto, 2003, 429-450

[90] N. Poppe, Introduction to Altaic Linguistics, p. 147

[91] op. cit. 147

Шинжаан, Афганистаны Херат, Маймана зэрэг мужуудаар оршин сууж байна. Үүнд: 1. *Төв монгол хэл* (Халх, Дархад, Дарьганга) 2. *Өмнөд Монгол хэл* (Цахар, Ордос, Баарин, Харчин, Хорчин, Шилийн гол) 3. *Ойрд хэл* (Дөрвөд, Захчин, Торгууд, Баяд, Мингад, Халимаг) 4. *Буриад хэл* (Хори, Барга-буриад, Баргуузин, Эхирит, Булгат, Алар, Түнкин, Цонгоол, Сартуул) 5. *Могол хэл* (Херат, Бадакшан, Маймана) 6. *Монгор хэл* (Минхэ, Хүцү) 7. *Дагуур хэл* (Хайлаар, Чичигаар, Бутха, Кульжа) 8. *Дунсян хэл,* 9. *Баоань хэл* 10. *Зүүн Уйгур хэл* эдгээр болно. Монгол угсаатан нийтдээ 8 сая орчим боловч барагцаалвал 6 сая орчим хүн монгол хэлээр хэлэлцэж байна.

Алтайн төрөл хэлэнд багтах гурав дахь хэл нь манж-түнгүүс хэл юм. Манж-түнгүүс хэлтэнүүд нь Аргунь мөрөн, Амур мөрөн, Енисей мөрөний сав газар, Хабаровын хизгаар, Камчаткийн хойг, Сахалины арал, Агнуурын тэнгисийн эрэг, Манжуурын баруун хойд районоор нутаглан сууж байгаа бөгөөд тэдгээр хэлээр хэлэлцэгчидийн сүүлийн үеийн нарийвчилсан тоо энэ хэр тодорхойгүй байна. Манж-түнгүүс хэлийг дотор нь хоёр үндэсэн бүлэгт хуваадаг. Үүнд: 1. *Манж бүлэгийн хэл* (Жүчин, Манж, Голди /Нанай/, Ульча, Орочи, Ороки, Уде), 2. *Түнгүүсбүлэгийн хэл* (Негидаль, Эвенки, Ламут, Солон) эдгээр болно.

Алтайн төрөл хэлэнд багтаан үзэж байгаа солонгос хэлээр умард, өмнөд солонгосын үндэсэн хүн амаас гадна БНХАУ, ОХУ-ын Алс дорнод нийтдээ 75 сая хүн ярьдаг бөгөөд солонгос хэл нь дотроо 6 үндэсэн аялгуутай. Алтайн язгуурын өөр нэгэн хэл болох япон хэлээр 125 сая орчим хүн ярилцдаг тэр нь дотроо гурван гол аялгуутай ажээ.

§ 6. **Алтайн хэл шинжилэлийн маргаантай асуудалууд**. Алтайн хэл шинжилэлийн гол бүтээлүүдийг нийтэд нь авч үзвэл алтайн хэл шинжилэлийн өнөөгийн төвшинд хараахан шийдэгдээгүй буюу шийдэхэд нэн бэрхшээлтэй хэд хэдэн зангилаа асуудал байна. Үүнд: 1. Алтайн нэгдмэл өвөг хэл байсан уу? 2. Хэрэв алтайн өвөг хэл гэж байсан гэж үзвэл түрэг, монгол, манж-түнгүүс зэрэг төрөл хэлнүүд чухам хэдийд салсан бэ? 3. Алтайн язгуурын хэлэнд багтах төрөл хэлнүүд нь нэгдмэл өвөг хэлнээсээ хэрхэн салбарласан бэ? гэх зэрэг болно.

Нэгдүгээр асуудалын талаар алтайч эрдэмтэдийн санал бүрэн нэгдээгүй, маргаантай хэвээр байна. G. Ramstedt, Б. Я.Владимирцов, N. Poppe, John. Ch. Street нарын зэрэг эрдэмтэд эдүгээгийн түрэг, монгол, манж-түнгүүс зэрэг хэлнүүдийн өвөг болсон эртний нэгэн нэгдмэл хэл байсан гэж үзээд түүнийгээ *'нийт алтайн хэл', 'өвөг алтайн хэл', 'алтайн нэгдмэл хэл'* гэх мэт нэрлэсээр иржээ. Гэтэл B. Collinder, Wl. Kotwicz, G. Clauson, G. Doerfer, A. M. Щербак, A. Vovin нар *'өвөг алтайн хэл'*-ний онолыг үгүйсгээд зогсоогүй, алтайн хэлнүүдийн төрөл болох тухай асуудалыг ч эрс эсэргүүцдэг талаар өмнө дурдсан билээ. Тэдгээр эрдэмтэдийн хэн нь ч алтайн хэлний гаралын тухай өөрсдийн үзэл бодолоосоо татгалзаагүй учир уг асуудал маргаантай хэвээрээ байна гэж үзэхээс өөр аргагүй. Хэдий тийм боловч түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүдийг хамагийн өргөн хүрээнд харьцуулан судалсан эрдэмтэдийн ихэнхи нь тэдгээр хэлнүүдийн олон талын нийтлэг шинжүүдийг тохиолдолын төстэй шинж биш, харин гарал нэгтэй

төрөл хэлнүүдийн нийтлэг шинж мөн гэдэгийг хэлний баримтуудаар батлан гаргасан билээ.

Хэрэв алтайн хэлнүүдийн төрөлийн холбоог үгүйсгэгчидийн саналыг зөвшөөрвөөс түрэг, монгол, манж-түнгүүс хэл нь хүн төрөлхитөний хэлний нийтлэг шинжээс гадуур, бусад ямар ч хэлтэй хэлхээ холбоогүй, тус тусдаа биеэ даасан эртний өвөг хэлнээс гаралтай, ганцаардмал (*isolated*) хэлнүүд гэж үзэхэд хүрнэ. Нөгөө талаар, эдүгээ дэлхий дээр байгаа 3500 гаруй хэлнүүд нь өөр хоорондоо хамааралтай 20 гаруй төрөл хэлэнд багтаж байгаа атал дээр дурдсан хэлнүүд нь өөр ямар ч хэлтэй холбоогүй байдаг нь ямар учиртай вэ гэдэг асуулт гарч ирнэ. Энэ мэт маргаантай асуудал гарсаны гол шалтгаан нь алтайн хэлнүүдийн нийтлэг хэв шинжийг тогтоох талаар хэрэглэж ирсэн онол, арга зүй оновч муутай байсантай холбоотой байж магадгүй. Газар зүйн байрлал, түүхэн уламжилал, шашин соёл, аж амьдаралын харьцангуй төстэй хэвшил бүхий түрэг, монгол, манж-түнгүүс угсаатаны хэл аялгууны нийтлэг бүтэц, тогтолцоог олон түвшинд илэрүүлж чадахуйц оновчтой аргазүйг боловсруулан хэрэглэх нь чухал байна.

Хоёрдугаар асуудалын талаар шийдвэрлэхэд нэн бэрх бөгөөд энэ тухай судалан бичсэн зүйл ч харьцангуй бага байна. Нэрт алтайч эрдэмтэн Вл. Котвич *'Алтайн хэлний судалал'* гэдэг бүтээлдээ *'...хэд хэдэн төрөл хэлнүүдийг өөрөөсөө салбарлуулан гаргасан нийт алтайн хэлний тухай асуудал нь эргэлзээтэй байна. Тийм нэгдмэл хэл байсан байлаа ч гэсэн тэр нь маш эрт цагт, манай эриний эхэн үеэс цааших үед хамаарагдах ёстой'* гэжээ.[92] Гэтэл түрэг, монгол хэлний эртний бичигийн дурсхалуудын хэлийг түүхэн харьцуулсан хэл шинжилэлийн үүднээс авч үзвэл, тэдгээр хэлний анх салсан цаг үе нь W. Kotwicz-ийн баримжаалан таамагласан тэр үеэс ч хавьгүй өмнөх үед хамаарагдах нь тодорхой байна. Өдгөө манай үед уламжилан үлдсэн түрэг бичигийн дурсхалын хамагийн эртнийх нь м. э. VII-VIII зууны үед, монгол бичигийн дурсхалын хамагийн эртнийх нь XIII-XIV зууны үед тус тус хамаарагдаж байна. Тэдгээр бичигийн дурсхалуудыг орчин цагийн амьд хэл аялгуутай нь харьцуулан үзвэл, түрэг хэлний хувид 1200-1300 жилийн зөрөө, монгол хэлний хувид 700 орчим жилийн зөрөө гарч байна. Гэтэл өөр хоорондоо 1200-1300 жилийн зөрөөтэй байгаа эртний түрэг, орчин цагийн түрэг хоёрын ялгаа, 700-гаад жилийн зөрөөтэй байгаа монгол бичигийн дурсхалын хэл, орчин цагийн монгол хэл хоёрын ялгаа нь харьцангуй маш бага байна. Өөр хоорондоо хэдхэн зуун жилийн зөрөөтэй байгаа эртний түрэг бичигийн дурсхалын хэл, монгол бичигийн дурсхалын хэл хоёр нь маш их ялгаатай байна. Тэгвэл эртний түрэг, орчин цагийн түрэг хэл хоёрын хоорондох багахан ялгаа гарах хүртэл 1200-1300 жил болсон бол нэгэн өвөг хэлнээс салбарлан гарсан эртний түрэг, эртний монгол хэлний хооронд байгаа үлэмжхэн хэмжээний ялгаа зөрөө гарах хүртэл хичнээн хугацаа шаардагдсан бэ гэдэг асуулт аяндаа гарах болно. Алтайн төрөл хэлнүүдийн дотороос өөр хоорондоо харьцангуй нилээд ойр гэж үзэж байгаа монгол, манж хоёр хэлний салсан хугацааг M. Swadesh-ийн аргаар тооцоолсон анхны туршилтаас үзвэл, тэдгээр нь одоогоос 3400 жилийн өмнө салсан гэсэн

[92] Вл. Котвич, Исследование по алтайским языкам, перевод с польского, М., 1962, 351

баримжаа гарсан байна. Хэрэв тийм бол бие биеэсээ ихээхэн ялгаатай байгаа түрэг, монгол хэлнүүд нь түүнээс ч бүр өмнө салсан байж таарна.

Гуравдугаар асуудалын талаар эрдэмтэдийн санал эдүгээ хүртэл бүрэн нэгдэж чадаагүй байна. Тодоруулвал, эдүгээгийн түрэг, монгол, манж-түнгүүс болон бусад төрөл хэлнүүд эртний өвөг хэлнээс тус тусдаа биеэ дааж салсан уу, эсвэл бүлэг хэл болж салсан уу гэдэг асуудалыг тогтоох явдал юм. Үүнийг тогтоохын тул юуны өмнө, орчин үеийн төрөл хэлнүүд болон тэдгээрийн эртний бичигийн дурсхалуудын хэлийг харьцуулан үзэх ёстой. Алтайн төрөл хэлнүү-дийн судалгаа төдий л гүнзгийрээгүй байсан Академич Б. Я. Владимирцов өвөг алтайн хэлнээс монгол-түрэг хэл хамтдаа, түнгүүс хэл тусдаа салж гарсан гэж төсөөлж байжээ.[93] Үүнд:



Профессор John Ch. Street өвөг алтайн хэлийг өрнөд, дорнод гэж хуваагаад өрнөд алтайн хэлнээс түрэг, чуваш хэл, дорнод алтайн өвөг хэлнээс монгол, түнгүүс хэл салбарлан гарсан гэж үзжээ.[94] Үүнд:



[93] Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языкаи халхаского наречия. Введение и фонетика, Лгр., 1929, стр. 47

[94] John C. Street, Rev: N. Poppe, Vergleichende Grammatik der altaischen Sprachen. Teil. I. Vergleichende Lautlehre, Wiesbaden, 1960, *Language* 38, 1962, 95

Түүний дараа профессор N. Poppe *'Алтайн хэл шинжилэлийн удирдхал'* хэмээх номдоо алтайн хэлнүүдийн салсан байдалыг дээрхээс арай өөрөөр тодор-хойлжээ.Тухайлвал, өвөг алтайн хэлнээс чуваш-түрэг, монгол-манж-түнгүүс гэсэн хоёр бүлэг хэл болж салаад дараа нь тус бүрдээ биеэ даасан хэл болсон гэж үзжээ.[95] Үүнд:



§ 7. **Алтайн хэлнүүдийн нийтлэг шинжүүд**. Адил хэв шинжтэй эртний нэгэн язгуур хэлний бүрэлдэхүүнд багтаж байгаа түрэг, монгол, түнгүүс зэрэг хэлнүүд нь авианы үндэсэн бүрэлдэхүүн, тэдгээрийн хувьсан хөгжих зүй тогтол, үгийн бүтэц, тэдгээрийн харилцан холбогдох арга, үгсийн сангийн язгуур үг, үгүүлбэрийн байгуулалынхаа талаар өөр хоорондоо зохих хэмжээний нийтлэг шинжтэй байна. Үүнд:

Урт эгшиг. Алтайн хэлнүүдийн урт эгшиг нь биеэ даан фонемийн утга ялгадаг бөгөөд тэдгээрийг дотор нь анхдагч урт эгшиг, үүсмэл урт эгшиг гэж хоёр хувааж болно. Бүр өвөг алтайн хэлний үеэс уламжилан үлдсэн анхдагч урт эгшиг нь зарим Түрэг (түркмен, якут), Монгол (монгор, дагуур, могол), Манж-Түнгүүс (эвенк, солон, негидал, ороки, орочи, нанай) хэлнүүдэд зохих хэмжээгээр хадгалагдан үлдсэн бөгөөд энэ талаар Sh. Hattori, N. Poppe, M. Nomura, L. Ligeti, M, Weiers нарын судалгаа бий.[96]

Mo. *dalu*. Trkm. *yāl,* Yak. *sāl,* Mog. *dālu*, Ev. *dālu*. Cf. Kha. *dal*
Mo. *modun*. Mngr. *mōdi,* Dag. *mōd,* Mog. *mōdun*, Cf. Kha. *mod*
Mo. *dörben*. Trkm. *dȫrt*, Mngr. *diēran.* Cf. Kha. *dörwön*

---

95 N. Poppe, Introduction to Altaic Linguistics {UAB XIV}, Wiesbaden, 1965, 147

96 Sh. Hattori, The Length of Vowels in Proto Mongol, SM 1:12, 1959, 3-10; N. Poppe, The Primary Long Vowels in Mongolian, JSFOu 63:2, 1962, 3-19; On the Long Vowels in Common Mongolian, JSFOu 68:4, 1967, 3-31; M. Nomura, Long Vowels in Monguor and the Possible Existance of Long Vowels in Proto Mongolian, *'Collection of Articles in Commemoration of the 10th Anniversaries of the Faculty of Letters'*, Nagoya University, 1959; L. Ligeti, Les voyelles longues en Moghol, AOH 17:1, 1964, 1-48; M.Weiers, Zu den langen Vokalen in der Moghol Sprache, ZAS 4, 1970, 467-473

Өвөг алтайн хэлний анхдагч урт эгшигийн ул мөр харьцангуй цөөн хэл аялгуунд уламжилан үлдсэн бөгөөд ихэнхи хэлнүүдэд богино эгшиг болжээ. Харин үүсмэл урт эгшиг нь их төлөв VC, VCV гэсэн байранд утга ялгах өргөлтөт эгшигээс үүссэн байна.

Өргөлт. Нийт алтайн хэлнүүдэд хүчилэх ба амисхалын түрэлтэт өргөлт зонхилдог бөгөөд тэр нь биеэ даасан фонемийн үүрэггүй ажээ. Олонхи түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүдийн хүчилэх ба амисхалын түрэлтэт өргөлт нь үгийн тэргүүн үед тохиолдож, эгшиглэх өргөлт их төлөв эцэсийн үедээ байдаг байна.

Эгшигийн зохицол. Эгшигийн зохицол нь нийт алтайн хэлний хамагийн түгээмэл үзэгдэл юм. Алтайн хэлний эгшигийн зохицолыг цуваагаар зохицохуй, уруулаар зохицохуй, тагнайгаар зохицохуй гэх мэтээр ангилан үздэг байна.

Гийгүүлэгчийн зохицол. Түрэг, монгол хэлний зарим гийгүүлэгч эр, эм үгэнд ялгаатай хэрэглэгддэг тусхай зохицол байдаг байна. Үүнд: хэлний урдуур хамжих ***g, k*** нь ямагт эм үгэнд, хэлний угаар хамжих ***γ, q*** нь ямагт эр үгэнд тохиолддог ажээ. Эдгээрээс гадна морфемуудын зааг дахь гийгүүлэгч авианууд дуутай, дуугүйн талаараа зохицох ёс бий.

Үгийн бүтэц. Алтайн төрөл хэлнүүдийн үгийн бүтэц нь залгамал байрлалттай юм. Үгийн утгын цөм болсон хамагийн бага нэгж нь тухайн үгийнхээ эхэнд байрлаж, түүний араас шинэ үг бүтээх дагаварууд болон үг холбох нөхцөлүүд дараалан ордог тогтсон байрлалтай байдаг.

Нэрийн тийн ялгал. Алтайн хэлнүүдийн тийн ялгалын нөхцөлүүдийн хооронд утга, хэлбэрийн талаар нийтлэг тал олон бий.

Gen.	Turk.	*-ny,*	*-yn*		Mon. *-ni,* *-in*
	Tun.	*-ni,*	*-in*		
	Sol.	*-n,*	*-i*		
D-L.	Turk.	*-da,*	*-a*		
	Mon.	*-da,*	*-du,*	*-a*	
	Tun.	*-du*			
Acc.	Turk.	*-y,*	*-ny,*	*-γ*	
	Mon.	*-i,*	*-yi,*	*-g*	
	Tun.	*-ja,*	*-ye*		
Dir.	Turk.	*-ru*			
	Mon.	*-ru*			
	Sol.	*-ru*			

Биеийн төлөөний нэр

Нэгдүгээр биеийн төлөөний нэр

	Ганц тоо	Олон тоо
Tur.	bän män	biz
Mon.	bi(*bin *min)	man
Tun.	bi(min)	bu, mun

Хоёрдугаар биеийн төлөөний нэр

	Ганц тоо	Олон тоо
Tur.	sän	siz
Mon.	či (čin *tin)	ta (*tan)
Tun.	si,	sin

Алтайн хэлнүүдийн нэрээс нэр үг, үйл үг бүтээх дагаваруудын хооронд адил төстэй зүйл олон байгааг Wl. Kotwicz, G. J. Ramstedt, N. Poppe, A. M. Щербак нарын судалгааны бүтээлүүдээс тодорхой мэдэж болно.[97]

Үгүүлбэрийн бүтэц: Алтайн язгуурын төрөл хэлнүүдийн үгүүлбэрийн ерөнхий бүтэц нь S-O-P гэсэн бүтэцтэй байдаг байна.

0.1.2 МОНГОЛ ХЭЛНИЙ ГАРАЛ ҮҮСЭЛ, ТҮҮХЭН ХУВЬСАЛ

§ 8. **Монгол хэлний гарал үүсэл.** Алтайн нуруунаас Хинганы уулс, Байгал нуураас их Цагаан хэрэм хүртэлхи өргөн уудам нутаг дээр монголчуудын дээд өвөг болох олон овог аймагууд үе дамжин нутагласаар иржээ. Тэдгээр овог аймагууд нь бие биеэсээ харьцангуй ялгаатай хэл аялгуугаар харилцаж байжээ.

---

[97] G. J. Ramstedt, Zur Verbstammbildungslehre der mongolisch-türkischen Sprachen, JSFOu 28:3, 1912, 86; Wl. Kotwicz, Contributions aux études altaïques I. (Notice prelim-minaire); II. (Les noms de nombre); III. (Les noms de couleurs), RO 7, 1931, 130-234; IV. (Sons intercalaires); V. (*n* nominal), RO 12, 1936, 122-142; Les pronouns dans les langues altaïques, *Mémoires de la commission orientaliste*, Kraków, 1936; Вл. Котвич, Исследование по алтайским языкам, M., 1962, 23-46; N. Poppe, Die Nominalstammbildungssuffixe im Mongolischen, KSz 20, 1923-27, 89-126; N. Poppe, Über einige Verbalstammbildungssuffixe in den altaischen Sprachen, *Orientalia Suecana* 21, 1973, 119-141; G. Doerfer, Türkische und mongolische Elemente im Neuepersischen, Bd. I, Wiesbaden, 1963, 51-105

Монгол хэлийг гарал үүсэлийнх нь талаас авч үзвэл алтайн язгуурын өвөг хэлнээс салбарлан гарсан төрөл хэлнүүдийн нэгэн билээ. Авианы тогтолцоо, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэр, үгүүлбэрийн байгуулал хийгээд үгсийн үндэсэн сангийнхаа талаар алтайн язгуурын бусад хэлнүүдээс ялгаатай, биеэ даасан онцлог шинж бүхий хэлийг монголчуудын дээд өвөг бүрдүүлэн тогтоож, минган минган жилийн турш тээн хөгжүүлсээр иржээ.

Манай эриний өмнөх III зууны үеэс түүхийн тавцан дээр тодорон гарч 300 гаруй жил оршин тогтоносон хүннүчүүдийн хэл аялгууны тухай асуудал одоо хүртэл төдий л тодорхой мэдэгдээгүй байна. Хүннүчүүд нь зарим эрдэмтэдийн үзсэн шиг ганцхан түрэг угсаатан, эсвэл ганцхан монгол угсаатанаас бүрдэж байгаагүй, харин түрэг, монгол, жүрчин зэрэг Төв Азийн олон угсаатаныг нэгдхэсэн их гүрэн байсан гэж үзэх нь үнэнд нийцэх буй заа. Тийнхүү хүннүчүүдийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болсон монгол угсаатанууд нь бүр Хүннү гүрэн үүсэн бүрэлдэхээс ч өмнө өөрийн гэсэн өвөрмөц хэл аялгуутай байсан гэдэг нь эргэлзээгүй билээ. Тиймээс монгол хэл нь дорно дахины эртний түүхтэй хэлнүүдийн нэг мөн билээ.

Хүннү гүрэн суларан задарч, түүний орон суурин дээр Сяньби нарын холбоо үүсэн бүрэлдсэн бөгөөд тэд Байгал нуураас урагш, одоогийн Монгол улсын зүүн хойд хэсэг болон түүнтэй зэрэгэлдээх Хитадын нутаг дэвэсхэр дээр оршин сууж байжээ. Эртний хитадын зарим түүхэн сурвалж бичигт Сяньби хэлний зарим үг хэллэгийг хитад ханз үсэгээр тэмдэглэсэн нь уламжилан үлдсэн бөгөөд тэдгээр үг хэллэгийн талаар K. Shiratori, P. Boodberg, L. Bazin, L. Ligeti зэрэг эрдэмтэд уншиж судалсан байна[98]. Тэдний судалгааны дүнгээс үзвэл Сяньби хэлний үгсийн дотор түрэг, монгол хэлний аль алиных нь үгс байна гэсэн дүгнэлт гарсан байна. Түүнээс үндэслэн сяньбичуудын холбоонд түрэг, монгол угсаатануудын аль аль нь багтаж байсан гэж зарим эрдэмтэд үзжээ.

Сяньбичуудын дараа түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн жүжанчууд ч бас л монгол хэлтэн байсан гэж судалаачид тэмдэглэсээр иржээ. Манай тоололын IV зууны үеэс эхлэн түүхэнд тэмдэглэгдэж, X зууны үеэс Умард Хитадыг эзэлээд 907 оноос 1125 оныг хүртэл Ляо хэмээх эзэнт улсыг мандуулж байсан хитанчууд нь эртний Сяньбигаас тасарсан монгол угсаатан байсан тухай дорно дахины судалаачид бараг нэгэн дуугаар хүлээн зөвшөөрч байна. Хитанчууд нь 920 онд хитад утгын бичиг дээр тулгуурлан 3000 гаруй тэмдэгт бүхий *'их бичиг'*-ийг зохиож, түүнээсээ таван жилийн дараа *'бага бичиг'*-ийг тус тус зохион хэрэглэсэн байна. Эдүгээ хитан бичигийн нилээд тооны дурсхал уламжилан үлдсэн бөгөөд тэдгээрийг уншин

---

98 K. Shiratori, Über die Sprache der Hiung-nu-Stammes und der Tung-hu-Stämme, 1900, 14; P. A. Boodberg, The Language of the To-pa Wei, HJAS 1, 1936, 167-185; L. Bazin, Recherches sur les parlers To-pa, T'P XXXIX, 1950, 228-329; L. Ligeti, Mots de civilization de la Haute Asie en transcription chinoise, AOH 1, 1950, 141-185; Le Tabghatch, un dialecte de la langue sien-pi *'Mongolian Studies'*, 1970, 9-22 || Табгачский язык диалект сяньбийского, НАА 1, 1969,107-117

тайлах талаар японы эрдэмтэн Sh. Murayama, D. Tamura, францын эрдэмтэн L. Hambis, америкийн эрдэмтэн Th. Carrol, оросын эрдэмтэн Л. Рудов, В. С. Стариков, В. С. Таскин, В. Шавкунов, Унгарын эрдэмтэн G. Kara, хитадын эрдэмтэн Чен-най сюн, Чингэлтэй зэрэг эрдэмтэд олон тооны туршилт судалгаа хийсээр иржээ. Хэдийгээр хитан бичигийн дурсхалуудыг бүрэн төгөс уншин тайлаагүй ч гэсэн эдүгээ хүртэлхи судалгааны үр дүнд *'Хитанчуудын хэл нь монгол хэлний бүлэгт хамаарна'* гэсэн дүгнэлтэд бараг санал нэгтэй хүрээд байгаа билээ. Гэвч хитанчуудыг түрэг хэлтэн байсан, түнгүүс угсаатан байсан гэсэн саналтай эрдэмтэд ч бас бий билээ.

XIII зуунаас өмнөх үеийн монгол нүүдэлчин аймагуудын нийгэм ахуй, гадаад нөлөөлөл, бичиг соёлын байдалыг олон талаас нь авч үзвэл, тэд бие биеэсээ нилээд ялгаатай аялгуунуудаар ярилцаж байсан нь эргэлзээгүй билээ. Харин *'Хамаг монгол'* улс үүсэн бүрэлдсэн хийгээд хожим XIII зууны үеэс Монголын нэгдсэн гүрэн байгуулагдаж, сайтар хэвшин тогтсон нэгдмэл бичигийн хэлээр харилцах болсон зэрэг нь монгол угсаатаныг нягтаруулж, хэл аялгууныхаа талаар илүү ойртох нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж болно. Үүнийг бид XIII-XIV зууны үеэс уламжилан үлдсэн уйгуржин монгол, дөрвөлжин, хитад, араб үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсхалуудын хэлнээс баримжаалан мэдэж болно. Хэдий тийм боловч зах хизгаарын монгол аймагууд хэл аялгууныхаа эртний шинжийг тогтвортой хадгалсаар байсан бөгөөд түүнийг бид эдүгээгийн зарим амьд хэл аялгуунуудаас ажиглаж болно.

§ 9. **Монгол хэлний түүхэн хувьсал.** Ер аливаа хэл нь олон үеийн турш хүмүүсийн харилцааны үүрэгийг гүйцэдхэж ирэхдээ өөрийнхөө дотоод зүй тогтолын дагуу хэлний хөгжилийн нэгэн хэвшилээс дараагийн хэвшилд дэвшин шилжих замаар хувьсан өөрчилөгддөг жамтай билээ. Тийнхүү тухайн хэлний дамжин өнгөрүүлсэн үе шат бүрийн онцлог шинжүүдийг хэлний хувьсан хөгжих зүй тогтолын үүднээс сэргээн тогтоох нь түүхэн хэл шинжилэлийн гол зорилго болно. Өөрөөр хэлвэл, энэ нь тухайн хэлнийхээ түүхэн хөгжилийг цуваа цаг (*diachrony*)-ийн үүднээс үечилж байгаа хэрэг юм.

Монгол хэл нь олон минган жилийн турш хэлний хөгжилийн хэд хэдэн өөр үе шатыг дамжин хөгжсөөр ирсэн бөгөөд түүний тодорхой нэгэн үе шатны хэв шинж нь нэг талаар, өмнөх үеийнхээ хөгжилийн үр дүн нь болж, нөгөө талаар, дараах үеийнхээ хөгжилийн үндэс суурь нь болсоор иржээ. Тийм учираас бид монгол хэлний хөгжилийн урт удаан түүхийг авч үзэхдээ түүний дамжин өнгөрүүлсэн үе шат бүрийн үндэсэн хэв шинжүүд, тухайлвал, авианы тогтолцоо, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэр, үгийн сангийн онцлогийг түүхэн үүднээс харьцуулан судалах ёстой билээ. Түүний тул нэг талаас, монгол хэлний хөгжилийн өөр өөр үе шатны онцлогийг тусхасан бичигийн дурсхалуудын хэлний онцлог шинж, нөгөө талаас, эдүгээгийн амьд хэл аялгуунуудын хэлний онцлог шинжийг монгол хэлнийхээ хувьсан хөгжих ерөнхий зүй тогтолын үүднээс авч үзэх болно.

Эдүгээ бидэнд уламжилан үлдсэн монгол хэлний эртний бичигийн дурсхалууд нь түүний хөгжилийн бүх үе шатны онцлог шинжийг бүрэн тусхаж чадахгүй ч

гэсэн лавтайяа сүүлийн минга гаруй жилийн түүхийг тусхаж байгаа билээ. Монгол хэлний бичигийн дурсхалуудын хамагийн эртнийх нь бүтээгдсэн цаг үеийнхээ хувид XIII зууны тэргүүн хагаст холбогдож байгаа боловч тэдгээр дурсхалуудад тусч байгаа хэлний онцлог шинж нь түүнээс хэдэн зуун жилийн өмнөх үе буюу барагцаалвал IX-X зууны үед холбогдоно. Мөн эдүгээгийн амьд хэл аялгуунуудын зарим нь монгол хэлний хөгжилийн харьцангуй эрт үеийн онцлог шинжийг зохих хэмжээгээр хадгалагдан үлдсэн байна. Ерөнхийд нь авч үзвэл, эдүгээгийн амьд хэл аялгуунуудад уламжилан үлдээгүй эртний монгол хэлний зарим онцлог шинж бичигийн дурсхалуудад тохиолддог бол эртний бичигийн дурсхалуудад үлдээгүй зарим онцлог шинж амьд хэл аялгуунуудад хадгалагдан үлдсэн байдаг билээ. Тийм учираас монгол хэлний бичигийн дурсхал болон амьд хэл аялгууны материал нь зарим талаар бие биеэ нөхөн монгол хэлний эртний шинжийг илэрхийлж байна.

Монгол хэлний хөгжилийн түүхийг үечилэх тухай хамагийн анхны судалгааг нэрт монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов хийсэн байна. Тэрвээр 1929 онд нийтлүүлсэн *'Монгол бичигийн хэлийг халхын аман аялгуутай харьцуулсан хэл зүй'* гэдэг бүтээлдээ монгол хэлний хөгжилийн түүхийг дор дурдсан дөрвөн үе шат болгон үечилж, үе тус бүрийн онцлог шинжийг тодорхойлсон байна.[99] Үүнд:

1. Нийт монгол хэл |Обще-монгольский наречия|
2. Эртний монгол хэл |Древне-монгольские наречия|
3. Дундад үеийн монгол хэл |Средне-монгольские наречия|
4. Шинэ үеийн монгол хэл |Новые монгольские наречия|

Дээр дурдсан дөрвөн үе шатыг цаг хугацааных нь талаас авч үзвэл, өвөг алтайн хэлнээс түрэг, түнгүүс зэрэг хэлнүүдтэй нэгэн зэрэг салбарлан гарч, биеэ даасан хэл болсон тэр үеийн онцлог шинжийг *'нийт монгол хэл'*-ний үед, монгол бичигийн хэлэнд хэвшин тогтсон онцлог шинжийг *'эртний монгол хэл'*-ний үед, XIII-XIV зууны монгол хэл аялгууны шинжийг *'дундад үеийн монгол хэл'*-ний үед, түүнээс хойшхи үеийн монгол хэлийг *'орчин үеийн монгол хэл'*-ний үед тус тус хамааруулан үзсэн байна. Өнгөрсөн зууны тавиад оны дундуур акад. L. Ligeti проф. Г. Д. Санжеевийн нийтлүүлсэн *'Монгол хэлнүүдийн харьцуулсан хэл зүй'* номын тухай шүүмждээ монгол хэлний хөгжилийн түүхийг мөн дөрвөн үе шат болгон хуваж үзэх саналыг дэвшүүлсэн[100] бөгөөд түүний үечилэл нь хамаарах цаг хугацааныхаа хувид Б. Я. Владимирцовын үечилэлээс нилээд ялгаатай юм. Тухайлвал, XIII-XIV зууны үеийн монгол бичигийн дурсхалуудад туссан хэлний онцлог шинжийг *'дундад үеийн монгол хэл'*-ний үед, түүний өмнөх уттал үеийн онцлог шинжийг *'эртний монгол хэл'*-ний үед тус тус хамааруулан үзсэн байна. Өөрөөр хэлвэл, Б. Я. Владимирцовын *'нийт монгол хэл'*-ний үеийг *'эртний монгол хэл'*-ний үед, *'эртний монгол хэл'*-ний үеийг *'дундад үеийн монгол хэл'*-ний үед тус тус урагшилуулан үечилсэн байна. Харин тэрвээр *'өвөг монгол хэл'* болон *'эртний*

---

[99] Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Лгр., 1929, 47

[100] Л. Лигети, Рец. на кн: Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, М., 1953, ВЯ. 5, 1955), 133-139

монгол хэл'-нд монгол хэлний хөгжилийн аль үеийг багтаах талаар огт дурдаагүй нь харамсалтай. Мөн профессор N. Poppe *'Монгол бичигийн хэлний зүй'* (1951) хэмээх зохиолдоо монгол хэлний хөгжилийн түүхийг 1. *Нийт монгол хэл,* 2. *Дундад үеийн монгол хэл,* 3. *Орчин үеийн монгол хэл* гэж гурван үе шат болгон үечилээд, уламаар үе тус бүрийн онцлог шинжийн талаар товч дурдсан бий.[101] Тэрвээр хожим *'Монгол хэлнүүдийн харьцуулсан судалгааны удирдхал'* хэмээх алдарт бүтээлдээ монгол хэлний хөгжилийн түүхийг мөн дээрхийн адил гурван үе шат болгон хуваагаад, үе тус бүрийн хэлний онцлог шинжийг авианы түүхэн хувьсалын дараалалыг баримтлан гаргажээ.[102] Үүнд:

1. Нийт монгол хэл /Common Mongolian/

а. Үгийн эхний хамжих $*f < *\rho$ гийгүүлэгч хадгалагдсаар байсан.
б. **аγа, *аγи* гэх мэт цогцууд хэвээрээ үлдсэн.
в. **q, *γ*-гийн арын **ï* нь **k, *g*-гийн дараах **i* хоёр нь ялгаатай
г. Дээрхээс бусад байранд байсан **ï* нь тангнайшин *i* болж, уламаар өмнөх **d, *t*-г тагнайшуулж *dž, tš* болгосон.

2. Дундад үеийн монгол хэл /Middle Mongolian/

а. Үгийн эхний $*f < *\rho$ нь шүргэх $h < \chi$ болсон
б. **аγа, *аγи* гэх мэт цогцын доторх **γ, *g* сугарсан
в. **i* нугарч, **e* уруулшиж эхэлсэн байна.

3. Орчин үеийн монгол хэл /Modern Mongolian/

а. **аγа, *аγи* гэх мэт цогцын байран дээр урт эгшиг үүссэн
б. **e* эгшиг байрлалаасаа шалтгаалан заримдаа уруулшсан
в. **i* эгшиг байрлалаасаа шалтгаалан заримдаа өөр эгшиг болсон

Саяхан Хельсинкийн их сургуулийн профессор Juha Janhunen нэн эртний монгол хэлний түүхийг өвөг монгол хэлээр гол баримжаа болгон *'өвөг монгол хэлний угтал үе'* (Pre-Proto-Mongolic), *'өвөг монгол хэлний дараах үе'* (Post-Proto-Mongolic)хэмээн барагцаалан авч үзсэн байна.[103] Тэрвээр өвөг хэлний цаг үе болон түүний хэлний үндэсэн шинжийн талаар баримжаалах баримт байхгүй тухай хэдэнтээ дурдсан хэдий ч эртний Дунху аймагийн үеэс (м. э. ө. 300 он) аваад Сяньбийн үеийг (м. э. 300 он) хүртэлхи үеийг *'өвөг монгол хэлний түрүү үе'*-д хамааруулан үзсэн бол монгол бичигийн хэлний бичлэгээр үндэсэн шинж нь илэрч байгаа монгол хэлийг *өвөг монгол хэлний хожуу үе'*-д хамааруулан үзэх саналтай байна. Мөн *'өвөг монгол хэл'*-ний онцлог шинжтэй холбогдуулан эгшиг, гийгүүлэгч авианы бүрэлдэхүүн, авианы ижилшил, суларал, тагнайшилын талаар дурдсанаас

---

101 N. Poppe, Grammar of Written Mongolian {PLO I}, Wiesbaden, 1954, 1-2
102 N. Poppe, Introduction to Comparative Studies {= MSFOu. 110}, Helsinki, 1955, 15-16
103 The Mongolic Languages, edited by Juha Janhunen, {= *Routledge Language Family Series* 5}, London & New-York, 2003, 1-3

гадна нэр, үйл үгийн бүтэц, холбох арга, төлөөний нэр, тооны нэрийн талаар нилээд дэлгэрэнгүй дурдсан бий.[104]

Монгол хэлний хөгжилийн түүхийг үечилсэн дээрхи судалгаануудад монгол хэлний хувьсал хөгжилийг зохих хэмжээгээр, зөв зүйтэй тусхажээ. Ялангуяа академич Б. Я. Владимирцовын үечилэл нь өвөг алтайн хэлнээс монгол хэл биеэ даан салж гарсан тэр цагаас өдгөө хүртэлхи монгол хэлний хөгжилийн үндэсэн хэвшилүүдийг бүхэлд нь бүрэн багтаасан байна. Харин академич L. Ligeti монгол бичигийн хэлээр илэрч байгаа монгол хэлний үеийг *'эртний монгол хэл'*-ний үеэс хойш ухараан *'дундад үеийн монгол хэл'*-ний үед хамааруулсан аталаа хэлнийх нь онцлог шинжийг илдхэсэн ямар ч бичигийн дурсхал уламжилан үлдээгүй монгол хэлний хөгжилийн хамагийн бүрхэг бүдэг эртний үеийг чухам ямар баримжаагаар *'өвөг монгол хэл'*, *'эртний монгол хэл'* гэсэн бүхэл бүтэн хоёр үед хуваан үзсэнийг тайлбарлах аргагүй. Түүнчилэн XIII-XV зууны үеэс уламжилан үлдсэн хитад, дөрвөлжин, араб үсэгийн дурсхалуудын хэлийг монгол хэлний хөгжилийн аль ч үед хамааруулалгүй орхижээ.

Профессор N. Poppe-гийн үечилэлийг өнгөц харвал, XII зуунаас өмнөх үеийн монгол хэлийг бүхэлд нь *'нийт монгол хэл'*-ний үед хамааруулсан мэт ойлгогдох боловч тэрвээр уул номдоо *'... өвөг монгол хэл нь яваандаа эртний монгол хэл болж хөгжсөн'* хэмээн тэмдэглэсэн буй.[105] Тэрвээр монгол бичигийн хэлний онцлогийг *'эртний монгол хэл'*-ний үед, XIII-XIV зууны үеийн монгол хэлний шинжийг *'дундад үеийн монгол хэл'*-ний үед тус тус хамааруулсан нь уттаа Б. Я. Владимирцовын үечилэлтэй адил байна. Харин профессор J. Janhunen-гийн судалгааны хувид гэвэл, тэрвээр монгол хэлний түүхэн хөгжилийг бүхэлд нь авч үзээгүй, зөвхөн өвөг монгол хэлний түвшинд авч үзсэнээрээ өмнөх эрдэмтэдийн судалгаанаас өөр юм.[106]

§ 10. **Монгол хэлний хөгжилийн түүхийн үечилэл.** Алтай язгуурын өвөг хэлнээс монгол хэл чухам хэдийд салбарлан гарч, биеэ даан хөгжиж эхэлсэн цаг үеийг өнөөгийн төвшинд нарийвчилан тогтоох боломжгүй юм. Хэдий тийм боловч, нэг талаас, монгол хэлний хөгжилийн ерөнхий зүй тогтол, нөгөө талаас, бусад төрөл хэлний хөгжилийн нийтлэг хандлагатай уялдуулан авч үзсэний үндэсэн дээр монгол хэлний хөгжилийн түүхийг баримжаалан үечилэх боломжтой юм.

Ер аливаа хэлний хөгжилийн түүхийг үечилэхдээ тухайн хэлний түүхэнд гарсан үндэсэн хэвшилүүдийг гол баримжаа болгодог учираас монгол хэлний хөгжилийн түүхийг үечилэх нь уттаа түүний дамжин өнгөрүүлж ирсэн гол онцлог шинжүүдийг зохих хэмжээгээр сэргээн тогтооно гэсэн үг юм.

---

104 ibid., 1-25

105 N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 15

106 J. Janhunen(ed.) The Mongolic Languages, 2003, 4-8

Монгол хэл нь түүхэн хөгжилийнхөө явцад хэлний хөгжилийн нэг хэвшилээс нөгөө хэвшилд дэвшин хувисч ирэхдээ өөр хоорондоо тоо ба чанарын ялгаа бүхий онцлог шинжтэй үе шатуудыг дамжин ирсэн бөгөөд тэдгээр ялгаатай шинжүүд нь түүний үе шат бүрийн онцлог тал болно.

Монгол хэлний түүхийг үечилэхдээ онолын чиг баримжаагаас гадна түүний хөгжилийн үе шатуудын онцлог шинжүүдийг тусхасан бодит баримтад түшиглэх нь зайлшгүй чухал билээ. Тийм бодит баримт нь нэг талаас, эртний бичигийн дурсхал, нөгөө талаас, хэлний хөгжилийн харьцангуй эртний шинжийг хадгалан үлдсэн амьд хэл аялгуунуудын материал юм. Харин монгол хэлний хөгжилийн нэн эртний онцлог шинжийг тусхасан хангалттай баримт сэлт бидний үед уламжилан ирж чадаагүй нь харамсалтай. Эдүгээ уламжилан үлдсэн эртний бичигийн дурсхалуудын хэл нь авианыхаа шинжээр бүтээгдсэн цаг үеэсээ өмнөх үеийн онцлог шинжийг тусхаж байгаа учир бид монгол хэлний хөгжилийн сүүлийн минган жилийн үндэсэн шинжийг баримжаалан мэдэх бүрэн боломжтой байгаа билээ. Хэрэв эдүгээ бидний үед уламжилан үлдсэн хитан бичигийн дурсхалуудыг хэл шинжилэлийн үүднээс бүрэн уншин тайлваас монгол хэлний хөгжилийн эрт үеийн онцлог шинжийг илүү тодорхой мэдэх таатай боломж олдохсон билээ.

Эдүгээ бид монгол хэлний эртний бичигийн дурсхалууд болон монгол хэлний эртний зарим шинжийг хадгалан үлдсэн хэл аялгууны материалыг цуваа цагийн аргаар харьцуулан судалсаны үндэсэн дээр монгол хэлний сүүлчийн минга гаруй жилийн үндэсэн шинжийг тогтоох боломжтой төдийгүй, монгол хэлний хувисан хөгжих ерөнхий зүй тогтолын үүднээс дотоод сэргээлт (*internal reconstruction*)-ийн аргаар эдүгээ бидэнд тодорхой мэдэгдэхгүй байгаа өвөг монгол хэлний үндэсэн шинжийг ч баримжаалан тогтоох боломжтой юм.

Монгол хэлний хөгжилийн түүхийг үечилсэн өмнөх туршилга болон монгол хэлний бичигийн дурсхал, хэл аялгуунуудын баялаг материалыг түүхэн үүднээс харьцуулан үзвэл монгол хэлний хөгжилийн түүхийг дөрвөн үндэсэн үе шат болгон үечилэх нь монгол хэл шинжилэлийн өнөөгийн төвшинд хамагийн тохиромжтой гэж бид үзэж байна. Бид энд монгол хэлний авианы түүхэнд гарсан гол гол томоохон хувьсалууд дээр тулгуурлан монгол хэлний хөгжилийн үе шат тус бүрийн үндэсэн онцлог шинжийг харьцуулан үзүүлэе.

0.1.2.1 ӨВӨГ МОНГОЛ ХЭЛ

§ 11. Өвөг монгол хэлний тухай тойм. Өвөг алтайн хэлнээс түрэг, түнгүүс хэлтэй бараг нэгэн зэрэг салбарлан гарсан тэр цагаас эхлээд эдүгээ бид *'эртний монгол хэл'* хэмээн нэрийдэж байгаа монгол хэлний хөгжилийн хоёрдугаар үеийг хүртэлхи хугацааг бүхэлд нь *'өвөг монгол хэл'*-ний үед хамааруулан үзэж байна. Тухайн үеийнх нь хэлний онцлог шинжийг тусхасан ганц ч баримт материал уламжилан үлдээгүй монгол хэлний хөгжилийн бүрхэг бүдэг тэр үеийг нийтэд нь нэгэн үе шат болгон үзэхээс өөр боломж одоогоор байхгүй байгаа билээ. Монгол хэлний түүхэн судалалд *'өвөг монгол хэл'*-ний талаар тусхайлан дурдсан судалгаа нэн хомс байна. Профессор N. Poppe *'дундад үеийн монгол хэл'*-ний өмнөх үеийг

бүхэлд нь *'нийт монгол хэл'*-ний үед багтааж, түүний хэлний онцлог шинжийн талаар дурдсан зүйл нь бидний энд томъёолж байгаа *'өвөг монгол хэл'*, *'эртний монгол хэл'* хоёрыг хамтад нь авч үзсэн хэрэг юм.

Нэг талаас, алтайн язгуурын төрөл хэлнүүд, нөгөө талаас, монгол хэлний хөгжилийн эртний шинжийг хадгалан үлдсэн бичигийн дурсхалууд болон хэл аялгууны материалыг монгол хэлний авианы хувьсан хөгжих ерөнхий зүй тогтолын үүднээс харьцуулан авч үзсэний үндэсэн дээр *'өвөг монгол хэл'*-ний онцлог шинжүүдийг баримжаалан тогтоох боломжтой. Аливаа хэлний язгуур-дагавар, үндэс-нөхцөлийн бүтэцэд гарсан өөрчилөлт бүхэн нь гагцхүү авианы хувьсалын үр дүн байдаг учир бид энд монгол хэлний авианы гол гол хувьсал, тэдгээрийн үр дүнг хэлний хөгжилийн үе шат тус бүрээр авч үзнэ.

1. Хэлэгдэх хүчдэлийнхээ талаар харилцан эсэрэгцэлдсэн 8 үндэсэн богино эгшигтэй байжээ.

Эр эгшиг(= хэлний хойгуур)	*a,	*o,	*u,	*ï
Эм эгшиг(= хэлний урдуур	*e,	*ö,	*ü,	*i

2. Үгийн тэргүүн үеийн өргөлтөт эгшиг нь дараах үеийнхээ эгшигийг хүчдэлийнхээ талаар зохицуулан тогтоодог байжээ. Өөрөөр хэлвэл, дэд үеийн эгшигүүд нь тэргүүн үеийн эгшигтэйгээ эр, эм шинжээрээ нарийн зохицдог байжээ.

РМ	*oran	СМ	oron (Kha.)	*'орон'*
РМ	*bulaγ	СМ	bulağ (Kha.)	*'булаг'*
РМ	*edür	СМ	ödör (Kha.)	*'өдөр'*
РМ	*örgen	СМ	örgön (Kha.)	*'өргөн'*

3. Эртний түрэг, түнгүүс хэлнүүдийн нэгэн адил анхдагч урт эгшигтэй байсан бөгөөд тэр нь орчин үеийн цөөн зарим хэл аялгуунд уламжилан үлджээ.

РМ	*tābun	СМ	tāwun (Dag.)	*'таван'*
РМ	*mōdun	СМ	mōdi (Mngr.)	*'мод'*
РМ	*dālu	СМ	dālu (Mog.)	*'дал'*
РМ	*dō̃ rben	СМ	diēran (Mngr.)	*'дөрвөн'*

4. Орчин цагийн монгол хэлний урт эгшигийн байранд утга ялгах өргөлтөт эгшиг байжээ.

PM	*qa**γ**á**n**	CM	χān (Kha.)	*'хаан'*
PM	*deg**é**l	CM	dēl (Kha.)	*'дээл'*
PM	*da**γ**ú**n**	CM	dū (Kha.)	*'дуу'*
PM	*eg**ű**len	CM	ūle (Kha.)	*'үүл'*

5. Утга ялгах өргөлтөт эгшигийн өмнө шүргэх ***γ/g*** гийгүүлэгч тогтвортой хадгалагдаж байжээ.Өөрөөр хэлвэл, хоёр эгшигийн хоорондох ***-γ/g***-гийгүүлэгчийн арын эгшиг нь утга ялгах өргөлттэй байжээ.

PM	*a**γ**úla	CM	ūlɒ (Kha.)	*'уул'*
PM	*ebtig**ű**n	CM	öwtšū (Kha.)	*'өвчүү'*
PM	*temeg**é**	CM	temē (Kha.)	*'тэмээ'*
PM	*sa**γ**ī́n	CM	sain (Kha.)	*'сайн'*

6. Орчин үеийн монгол хэл аялгуунуудын үгийн эцэсийн хос эгшиг болон ***ī*** [*<ei*]-гийн байранд ****vj*** (= **aj, *ej, *uj, *üj*) гэсэн цогц байжээ.

PM	*dal**aj**	CM	dalai (Kha.)	*'далай'*
PM	*k**ej**	CM	χī (Kha.)	*'хий'*
PM	*qaraŋq**uj**	CM	χaraŋχui (Kha.)	*'харанхуй'*
PM	*ked**üj**	CM	χedī (Kha.)	*'хэдий'*

7. Орчин цагийн монгол хэлний үгийн эцэсийн бус үеийн хос эгшигийн байранд ****vγï/vgi*** (= **aγï, *oγï, *uγï, *ügi*) гэсэн цогц байжээ. Өөрөөр хэлвэл, эцэсийн бус үеийн хос эгшиг үүсэн бүрэлдээгүй байсан байна.

PM	****aγ́ïl***	CMail (Kha.)	*'айл'*
PM	****oγ́ïmasun***	CMoimos (Kha.)	*'оймос'*
PM	****uγ́ïla-***	CMuilă- (Kha.)	*'уйл-'*
PM	****ügíle***	CMüilə (Kha.)	*'үйл'*

8. Орчин цагийн монгол хэлний эгшигээр эхэлсэн олон үгсийн эхэнд уруулын шүргэх ****φ-*** гийгүүлэгч тогтвортой хадгалагдаж байжээ.

PM	****φ**odun**	CModŏ (Kha.)	*'од'*
PM	****φ**arban**	CMarwan (Kha.)	*'арван'*
PM	****φ**ulaγán**	CMulān (Kha.)	*'улаан'*
PM	****φ**ünesün**	CMünes (Kha.)	*'үнэс'*

9. Монгол бичигийн хэлний *i* эгшигийн өмнө орсон хамжин шүргэх *ǰ*, *č*гийгүүлэгчийн байранд хамжих **d*, **t* гийгүүлэгч байжээ.

РМ.	*t**i**nar	АМ.	činar	*'чанар'*
РМ.	*g**üdi**gé	АМ.	güǰige	*'гүзээ'*
РМ.	*t**i**laγun	АМ.	čilaγun	*'чулуу'*
РМ.	*qï**dï**γár	АМ.	kiǰaγar	*'хизгаар'*
РМ.	*ge**di**ge	АМ.	geǰige	*'гэзэг'*

10. Аливаа хэлний биеийн төлөөний нэр нь гурван бие, ганц, олон тоогоор ялгагддаг харилцан уялдаа бүхий тодорхой тогтолцоотой үгс байдаг байна. Ямар ч үндэстэн биеийн төлөөний нэрийг өөр хэлнээс зээлдэн авдаггүй тул тэдгээр нь тухайн хэлнийхээ үгийн сангийн хамагийн уугуул үгс байдаг. Нөгөө талаар, өвөг монгол хэлний биеийн төлөөний нэр нь түүхэн урт удаан хөгжилийнхөө явцад авианы хувьсалын олон үе шатыг дамжин хүрч ирсэн өвөрмөц бүлэг үгс юм. Тийм учираас энд биеийн төлөөний нэрийн дотоод бүтэцэд гарсан хувьсалыг хэлний хөгжилийн үе шат тус бүрээр авч үзэх болно. Монгол хэлний биеийн төлөөний нэрс нь авианы тагнайшил, солигдол, суларал гэх зэрэг авианы олон төрөлийн хувьсалуудыг дамжин ирсэнийг харьцуулсан жишээнээс үзэж болно.

	Ганц тоо	Олон тоо
I	*min	*man
II	*tïn	*tan
III	*φïn	*φan

0.1.2.2 ЭРТНИЙ МОНГОЛ ХЭЛ

§ 12. **Эртний монгол хэлний тухай тойм.** Барагцаалвал, XI-XII зуунаас урагш өвөг монгол хэлний сүүлч хүртэлхи үеийг *'эртний монгол хэл'*-ний үед хамааруулан үзэж байна. Эртний монгол хэлний онцлогийг тусхайлан судалсан бүтээл ховор гарчээ. Профессор N. Poppe *'Эртний монгол хэл'*[107] гэсэн тусхай үгүүлэл нийтлүүлсэн бөгөөд түүнд үгүүлсэн хэлний онцлог шинж нь их төлөв өвөг монгол хэлний үед холбогдож байгаа билээ. Түүнээс гадна эртний монгол хэлний үндэсэн шинжийг тодорхойлох арга зүйн талаар профессор Г. Санжеев, L. Ligeti, M. Weiers нарын сонирхолтой үгүүлэлүүд бий.[108]

---

[107] N. Poppe, Ancient Mongolian, *'Tractata Altaica'*, Wiesbaden, 1976, 463-478

[108] Г. Д. Санжеев, Некоторые вопросы сравнительно-исторической монголистики, RO 21 (1957), 373-384; *idem.* Место лингвистической реконструкции в монголистике, Доклады делегации на XXV Международном конгрессе востоковедов, М., 1960, 3-11; Л. Лигети, Рец. на кн: Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, М., 1953, ВЯ 5 (1955), 133-139; M. Weiers, Zur Frage des Verhältnisses des Altmongolischen zum Mittelmongolischen, *'Mongolian Studies'*, Budapest, 1970, 581-590

Эртний монгол хэлний онцлог шинжийг бүхэлд нь тусхасан бичигийн дурсхал үлдээгүй боловч XIII-XIV зууны үед уйгуржин монгол үсэгээр тэмдэглэсэн хөшөө чулууны бичээс, ном бичигийн дурсхалуудаас эртний монгол хэлний сүүлч үеийн онцлог шинжийг бараг төлөв тодорхойлон гаргаж болно. Тийм учираас XIII-XIV зууны үеийн уйгуржин монгол бичигийн дурсхалуудын хэлний тухай судалгаа нь эртний монгол хэлний судалалд шууд холбогдоно. Түүнчилэн X-XII зууны үеэс уламжилан үлдсэн хитан үсэгийн дурсхалууд нь эртний монгол хэлний үед холбогдох боловч тэдгээрийн судалгааны өнөөгийн түвшин нь тэдгээрийг хэлний бодит материал болгон ашиглах хэмжээнд хүрээгүй байгаа билээ.

XIII-XIV зууны үеийн монгол бичигийн дурсхалуудын хэлний онцлог шинжийг авианы хувьсан хөгжих ерөнхий зүй тогтолын үүднээс авч үзсэний үндэсэн дээр эртний монгол хэлний онцлог шинжийг тодорхойлон гаргаж болно. Энд бид өвөг монгол хэлний үеийн үндэсэн шинж болгон авч үзсэн онцлогуудтай уялдуулан эртний монгол хэлний онцлогийг баримжаалан тогтоох болно.

Эртний монгол хэлний үндэсэн шинжийн талаар профессор N. Poppe XIII-XIV зууны үеийн уйгуржин монгол бичигийн дурсхалуудын хэлний онцлог дээр тулгуурлан эртний монгол хэлний авианы үндэсэн шинжийг цуваа цагийн үүднээс тоймлон гаргавал:

1. Өвөг монгол хэлний үед хэлний хойгуур хүчдэлтэй хэлэгдэж байсан */ï/* фонем нь хүчдэлээ алдаж, суларсаар эртний монгол хэлний үед бие даасан фонемийн шинжээ алдаж, хэлний урдуурхи, хүчдэлгүй */i/*-тэй адил байранд хэлэгдэх болсон байна. Энэхүү хувьсалын үр дүн нь нийт эгшиг фонемийн бүрэлдэхүүнд нөлөөлж, 7 үндэсэн эгшиг авиалбартай болжээ.

2. Өвөг монгол хэлний үгийн тэргүүн үеийн эгшиг нь дараах үеийн эгшигүүдийг хүчдэлийнхээ талаар зохицуулах үүрэгээ хэвээр хадгалсаар байжээ.

AM. edür	CM.	ödör	*'өдөр'*
AM. oran	CM.	oron	*'орон'*
AM. örgen	CM.	örgön	*'өргөн'*
AM. ǰirüken	CM.	ǰürex	*'зүрэх'*
AM. toγān	CM.	tō	*'тоо'*

3. Эртний монгол хэлний үндэсэн шинжийг тусхасан уйгуржин монгол бичигийн дурсхалуудад өвөг монгол хэлний үед байсан анхдагч урт эгшигийг огт тэмдэглээгүй байна. Гэвч орчин үеийн Монгор, Дунсян, Дагуур зэрэг хэлнүүдэд анхдагч урт эгшигийн ул мөр хадгалагдан үлдсэнээс үзвэл, эртний монгол хэлний зарим аялгуунд хадгалагдаж байсан нь мэдээж хэрэг.

4. Өвөг монгол хэлний үед утга ялгах өргөлттэй байсан эгшиг нь эртний монгол хэлний сүүлч үеэс сунжиран урт эгшиг үүсчээ. Гэвч тэр нь монгол бичигийн хэлэнд тусаагүйгээс үзвэл бичигийн хэлний суурь аялгуунд хараахан үүсч амжаагүй байсан бололтой.

AM	aγūla	PM	*aγúla	*'үүл'*
AM	qaǰaγār	PM	*qadïγár	*'хазаар'*
AM	irügēr	PM	*firügér	*'ерөөл'*
AM	egüle	PM	*egűle	*'үүл'*

5. Өвөг монгол хэлний V + γ/g + V гэсэн цогцын доторхи шүргэх ***γ/g***гийгүүлэгч нь арынхаа үүсмэл урт эгшигийн нөлөөгөөр суларч эхэлсэн боловч үе зааглах үүрэгээ хадгалсаар байжээ.

AM	daγūn	PM	daγún	*'дуу'*
AM	toγān	PM	toγá	*'хойно'*
AM	egüle	PM	uγí la-	*'уйл'*
AM	üyīle	PM	ügíle	*'үйл'*

6. Өвөг монгол хэлний үгийн эцэсийн үеийн эгшигийн дараа орсон тагнайн шүргэх ***j*** (= **aj, *ej, *uj, *üj*) гийгүүлэгч нь аниралхаг шинжээ алдаж, ***i*** эгшиг болсоны уламаас хос эгшиг үүсэх нөхцөл бүрджээ.

AM	dalai	PM	*dalaj	*'далай'*
AM	kei	PM	*kej	*'хий'*
AM	qarangqui	PM	*qaraŋquj	*'харанхуй'*
AM	kedüi	PM	*kedüj	*'хэдий'*

7. Өвөг монгол хэлний үеийн **vγí/vgí* (= **aγí, *oγí, *uγí, *ügí*) гэсэн цогцын эцэсийн өргөлтөт ***í*** эгшиг нь эртний монгол хэлний үед сунжиран уртаар дуудагдах болсоноос өмнө талынх нь шүргэх ***γ/g*** гийгүүлэгч арынхаа тагнайн урт эгшигийн нөлөөгөөр суларч,тагнайн шүргэх ***y*** болжээ.

AM	**ayīl**	PM	*aγíl	*'айл'*
AM	**sayīn**	PM	*saγín	*'сайн'*
AM	**uyīla-**	PM	*uγíla-	*'үйл'*

8. Өвөг монгол хэлний эхний уруулын шүргэх ****φ-*** гийгүүлэгч нь эртний монгол хэлний олонхи аялгуунд уруулын шинжээ алдаж, шүргэх ***χ*** болжээ. Гэвч орчин үеийн Монгор, Дунсян, Баоань зэрэг хэлэнд тэрхүү уруулын шүргэх гийгүүлэгчийн ул мөр уламжилан үлдсэнээс үзвэл тэр нь эртний монгол хэлний зарим аялгуунд хадгалагдаж байжээ. Харин уйгуржин монгол бичигийн хэлний суурь аялгуунд тухайн шүргэх гийгүүлэгч шүргэх шинжээ бүрмөсөн алдсан учир түүнийг тусхайлан тэмдэглээгүй байна.

AM	*χon	PM	*φon	*'он'*
AM	*χuǰajūr	PM	*φuǰaγúr	*'язгуур'*
AM	*χulaγān	PM	*φulaγán	*'улаан'*
AM	*χüker	PM	*φüker	*'үхэр'*

9. Өвөг монгол хэлний ***i*** эгшигийн өмнө орсон хамжих ***d***, ***t*** гийгүүлэгч нь арынхаа эгшигийн нөлөөгөөр тагнайшин хамжин шүргэх ***ǰ***, ***č*** болсон байна.

AM	ǰirum	PM *dirum	*'дүрэм'*
AM	güǰige	PM. *güdige	*'гүзээ'*
AM	čilaγun	PM. *tïlaγun	*'чулуу'*
AM	geǰige	PM. *gedige	*'гэзэг'*

10. Дундад үеийн монгол хэлний үгийн эцэсийн ***-n*** гийгүүлэгчийн суларалын уламаас CVC гэсэн бүтэцтэй язгуур нь CV бүтэцтэй болжээ.

	Ганц тоо	Олон тоо
I	bi < *bin < *min	ba < *ban < *man
II	či < *čin < *tïn	ta < *tan < *tan
III	*χi < *χin < *φïn	*χa < *χan < *φan

0.1.2.3 ДУНДАД ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛ

§ 13. **Дундад үеийн монгол хэлний тухай тойм.** Барагцаалвал, XI-XII зуунаас XV-XVI хүртэлхи үеийг *'дундад үеийн монгол хэл'*-ний үед хамааруулан үзнэ. Дундад үеийн монгол хэлний онцлог шинжийн талаар профессор Poppe *'Монгол хэлний харьцуулсан судалгааны удирдхал'*-даа цухас дурдсанаас[109] гадна хитад, дөрвөлжин, араб-перс дурсхалын материал дээр тулгуурлан дундад үеийн монгол хэлний шинжийг илүү дэлгэрэнгүй дурдсан тусхай үгүүлэл нийтлүүлсэн билээ.[110] Хожим Хельсинки их сургуулийн профессор V. Rybatzki Монголын эзэнт гүрэний оршин тогтоносон үеэс аваад XIV зуун хүртэлхи үеийг дундад үеийн монгол хэлний үед хамааруулан үзжээ.[111] Тэрвээр дундад үеийн монгол хэлний эгшиг, гийгүүлэгч авианы бүрэлдэхүүн, авианы сугарал, ижилшил болон үг бүтээх дагавар, нэр, үйлийн холбох арга, тооны нэр, төлөөний нэрийн бүтэцийн талаар нилээд тодорхой дурджээ.[112]

Дундад үеийн хэлний авианы онцлог шинж нь дөрвөлжин, хитад, араб үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсхалуудад тодорхой туссан байна. Харин үгийн бүтэц, хэл зүйн хэлбэр, үгсийн бүрэлдэхүүн, хэл найруулга нь XIII-XV зууны үеийн уйгуржин монгол бичигийн дурсхалуудад уламжилан үлдсэн байдаг. Тийм ч учираас V. Rybatzki сонгодог бичигийн монгол бичигийн дурсхалуудын хэлийг дундад үеийн монгол хэлний шинжид хамааруулан үзжээ.

---

109 N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 15-16

110 N. Poppe, Das Mittelmongolische, Handbuch der Orientalistik, Bd. V, Leiden / Köln, 1964, 96-103

111 Volker Rybatzki, Middle Mongol, in: The Mongolic Languages, edited by J. Janhunen, 2003, 57

112 ibid., 57-82

AM	aγūla	PM	*aγúla	*'уул'*
AM	qaǰaγār	PM	*qadïγár	*'хазаар'*
AM	irügēr	PM	*firügér	*'ероөл'*
AM	egŭle	PM	*egŭle	*'үүл'*

5. Өвөг монгол хэлний V + γ/g + V гэсэн цогцын доторхи шүргэх ***γ/g***гийгүүлэгч нь арынхаа үүсмэл урт эгшигийн нөлөөгөөр суларч эхэлсэн боловч үе зааглах үүрэгээ хадгалсаар байжээ.

AM	daγūn	PM	daγún	*'дуу'*
AM	toγān	PM	toγá	*'хойно'*
AM	egŭle	PM	uγí la-	*'үйл'*
AM	üyīle	PM	ügíle	*'үйл'*

6. Өвөг монгол хэлний үгийн эцэсийн үеийн эгшигийн дараа орсон тагнайн шүргэх ***j*** (= **aj, *ej, *uj, *üj*) гийгүүлэгч нь аниралхаг шинжээ алдаж, ***i*** эгшиг болсоны уламаас хос эгшиг үүсэх нөхцөл бүрджээ.

AM	dal**ai**	PM	*dalaj	*'далай'*
AM	k**ei**	PM	*kej	*'хий'*
AM	qarangq**ui**	PM	*qaraŋquj	*'харанхуй'*
AM	ked**üi**	PM	*kedüj	*'хэдий'*

7. Өвөг монгол хэлний үеийн **vγí/vgí* (= **aγí, *oγí, *uγí, *ügí*) гэсэн цогцын эцэсийн өргөлтөт ***í*** эгшиг нь эртний монгол хэлний үед сунжиран уртаар дуудагдах болсоноос өмнө талынх нь шүргэх ***γ/g*** гийгүүлэгч арынхаа тагнайн урт эгшигийн нөлөөгөөр суларч,тагнайн шүргэх ***y*** болжээ.

AM	**ayīl**	PM	*aγíl	*'айл'*
AM	**sayīn**	PM	*saγín	*'сайн'*
AM	**uyīla-**	PM	*uγíla-	*'үйл'*

8. Өвөг монгол хэлний эхний уруулын шүргэх ****φ-*** гийгүүлэгч нь эртний монгол хэлний олонхи аялгуунд уруулын шинжээ алдаж, шүргэх ***χ*** болжээ. Гэвч орчин үеийн Монгор, Дунсян, Баоань зэрэг хэлэнд тэрхүү уруулын шүргэх гийгүүлэгчийн ул мөр уламжилан үлдсэнээс үзвэл тэр нь эртний монгол хэлний зарим аялгуунд хадгалагдаж байжээ. Харин уйгуржин монгол бичигийн хэлний суурь аялгуунд тухайн шүргэх гийгүүлэгч шүргэх шинжээ бүрмөсөн алдсан учир түүнийг тусхайлан тэмдэглээгүй байна.

AM	*χon	PM	*φon	*'он'*
AM	*χuǰaǰūr	PM	*φuǰaγúr	*'язгуур'*
AM	*χulaγān	PM	*φulaγán	*'улаан'*
AM	*χüker	PM	*φüker	*'үхэр'*

9. Өвөг монгол хэлний ***i*** эгшигийн өмнө орсон хамжих ****d, *t*** гийгүүлэгч нь арынхаа эгшигийн нөлөөгөөр тагнайшин хамжин шүргэх ***ǰ, č*** болсон байна.

AM	ǰirum	PM *dirum	*'дүрэм'*
AM	güǰige	PM. *güdige	*'гүзээ'*
AM	čilaγun	PM. *tïlaγun	*'чулуу'*
AM	geǰige	PM. *gedige	*'гэзэг'*

10. Дундад үеийн монгол хэлний үгийн эцэсийн ***-n*** гийгүүлэгчийн суларалын уламаас CVC гэсэн бүтэцтэй язгуур нь CV бүтэцтэй болжээ.

	Ганц тоо	Олон тоо
I	bi < *bin < *min	ba < *ban < *man
II	či < *čin < *tïn	ta < *tan < *tan
III	*χi < *χin < *φïn	*χa < *χan < *φan

0.1.2.3 ДУНДАД ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛ

§ 13. **Дундад үеийн монгол хэлний тухай тойм**. Барагцаалвал, XI-XII зуунаас XV-XVI хүртэлхи үеийг *'дундад үеийн монгол хэл'*-ний үед хамааруулан үзнэ. Дундад үеийн монгол хэлний онцлог шинжийн талаар профессор Poppe *'Монгол хэлний харьцуулсан судалгааны удирдхал'*-даа цухас дурдсанаас[109] гадна хитад, дөрвөлжин, араб-перс дурсхалын материал дээр тулгуурлан дундад үеийн монгол хэлний шинжийг илүү дэлгэрэнгүй дурдсан тусхай үгүүлэл нийтлүүлсэн билээ.[110] Хожим Хельсинки их сургуулийн профессор V. Rybatzki Монголын эзэнт гүрэний оршин тогтоносон үеэс аваад XIV зуун хүртэлхи үеийг дундад үеийн монгол хэлний үед хамааруулан үзжээ.[111] Тэрвээр дундад үеийн монгол хэлний эгшиг, гийгүүлэгч авианы бүрэлдэхүүн, авианы сугарал, ижилшил болон үг бүтээх дагавар, нэр, үйлийн холбох арга, тооны нэр, төлөөний нэрийн бүтэцийн талаар нилээд тодорхой дурджээ.[112]

Дундад үеийн хэлний авианы онцлог шинж нь дөрвөлжин, хитад, араб үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсхалуудад тодорхой туссан байна. Харин үгийн бүтэц, хэл зүйн хэлбэр, үгсийн бүрэлдэхүүн, хэл найруулга нь XIII-XV зууны үеийн уйгуржин монгол бичигийн дурсхалуудад уламжилан үлдсэн байдаг. Тийм ч учираас V. Rybatzki сонгодог бичигийн монгол бичигийн дурсхалуудын хэлийг дундад үеийн монгол хэлний шинжид хамааруулан үзжээ.

---

109 N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 15-16

110 N. Poppe, Das Mittelmongolische, Handbuch der Orientalistik, Bd. V, Leiden / Köln, 1964, 96-103

111 Volker Rybatzki, Middle Mongol, in: The Mongolic Languages, edited by J. Janhunen, 2003, 57

112 ibid., 57-82

Уйгуржин монгол, хитад, дөрвөлжин, араб-перс үсэгээр тэмдэглэсэн бичигийн дурсхалуудын хэлний шинжийг харьцуулан үзсэний үндэсэн дээр дундад үеийн монгол хэлний үндэсэн онцлог шинжийг цуваа цагийн үүднээс баримжаалан тогтоовол:

1. Эртний монгол хэлний үеийн 7 үндэсэн богино эгшиг нь дундад үеийн монгол хэлэнд хэвээрээ хадгалагдан үлджээ. Харин дөрвөлжин бичигт найман богино эгшиг буй боловч *é* үсэг нь биеэ даасан фонем биш, үгийн эхэнд орохдоо *e* эгшигийн уйтан хувилбарыг, үгийн эцэст орохдоо хос эгшигийн бүрэлдэхүүн дэх *i* эгшигийг тус тус ялган зааж байна.

2. Эртний монгол хэлний үед нэгэн цуваанд дараалан орсон эгшиг авианууд дундад үеийн монгол хэлний үед өөр хоорондоо хүчдэлээрээ зохицоод зогсохгүй, аль хүчтэй эгшигтээ татагдан хэлэгдэх байдалаараа адил байранд хэлэгдэх болжээ. Өөрөөр хэлвэл, сул байранд хэлэгдэж байсан эгшиг нь тэргүүн үеийнхээ өргөлттэй эгшиг болон дараах үеийнхээ хүчтэй эгшигт татагдан ижилшсэн байна.

ММ	üdür	АМ	edür	*'өдөр'*
ММ	oron	АМ	oran	*'орон'*
ММ	örgön	АМ	örgen	*'өргөн'*
ММ.	ǰürüken	АМ.	ǰirüken	*'зүрэх'*
ММ	to'ōn	АМ	toγān	*'тоо'*
ММ.	du'ūn	АМ	daγūn	*'дуу'*

3. Өвөг монгол хэлний үед байсан анхдагч урт эгшиг эртний монгол хэлний зарим аялгуугаар дамжин дундад үеийн монгол хэлний зах хизгаарын зарим аялгуунд ч хадгалагдан үлдсэн байжээ. Түүнийг эдүгээгийн Дагуур, Монгор, Могол зэрэг хэлнүүдэд хадгалагдан үлдсэн анхдагч урт эгшигийн ул мөр баталж байгаа билээ. Харин тэр нь дундад үеийн монгол хэлний онцлогийг тусхасан бичигийн дурсхалуудад тэмдэглээгүй байна.

4. Эртний монгол хэлний сүүлчээр үүсэн бүрэлдсэн урт эгшиг нь дундад үеийн монгол хэлний үед хэвээрээ хадгалагдан үлдсэн нь хитад, дөрвөлжин, араб үсэгийн монгол дурсхалуудад тодорхой тэмдэглэгдсэн байна.

ММ	to'ōsun	АМ	toγāsun	*'тоос'*
ММ	bö'ēsün	АМ	bögēsün	*'бөөс'*
ММ	siba'ūn	АМ	sibaγūn	*'шувуу'*
ММ	seri'ūn	АМ	serigūn	*'сэрүүн'*
ММ	se'ūl	АМ	segūl	*'сүүл'*

5. Эртний монгол хэлний үед хоёр эгшигийн хооронд тохиолдож байсан шүргэх *γ/g* гийгүүлэгч арынхаа үүсмэл урт эгшигийн нөлөөгөөр суларан сул шүргэх *h*, тагнайн шүргэх *y*, уруулын шүргэх *w* болж, уламаар бүрмөсөн сугарсан байна..

MM	awūla > a'ūla	AM	aγūla	*'уул'*
MM	ewūle > e'ūle	AM	egüle	*'үүл'*
MM	dawūn > da'ūn	AM	daγun	*'дуу'*
MM	sayin > sa'in	AM	saγīn	*'сайн'*

6. Эртний монгол хэлний үед үүссэн үгийн эцэсийн хос эгшиг хэвээрээ хадгалагдан үлджээ.

MM	dal**ai**	AM	dalai	*'далай'*
MM	**kei**	AM	kei	*'хий'*
MM	qaraŋq**ui**	AM	qaraŋqui	*'харанхуй'*
MM	ked**üi**	AM	kedüi	*'хэдий'*

7. Эртний монгол хэлний үед тагнайн урт ***i*** эгшигийн өмнөх шүргэх ***y*** гийгүүлэгч суларан сугарсаны уламаас түүний хоёр талын эгшигүүд нь нэгэн үед багтан үгийн эцэсийн бус үеийн хос эгшиг үүсэн бүрэлджээ.

MM	**ail**	AM	ayīl	*'айл'*
MM	q**oi**na	AM	χoyīna	*'хойно'*
MM	**ui**la-	AM	uyīla-	*'үйл'*
MM	**üi**le	AM	üyīl	*'үйл'*

8. Эртний монгол хэлний үед байсан үгийн эхний шүргэх ***χ*** гийгүүлэгч нь дундад үеийн монгол хэлний үед сул шүргэх ***h*** болжээ.

MM	**h**on	AM	*χon	*'он'*
MM	**h**üker	AM	*χüker	*'үхэр'*
MM	**h**ula'ān	AM	*χulaγān	*'улаан'*
MM	**h**ünesün	AM	*χünesün	*'үнэс'*

9. Эртний монгол хэлний үед тагнайшилын уламаас үүссэн хамжин шүргэх ***dž, tš*** гийгүүлэгчид тогтовортой хадгалагдан үлджээ.

MM	**č**inar	AM.	činar	*'чанар'*
MM	**č**isun	AM	čisun	*'цус'*
MM	güǰige	AM.	güǰige	*'гүзээ'*
MM	ǰida	AM	ǰida	*'жад'*
MM	geǰige	AM	geǰige	*'гэзэг'*

10. Эртний монгол хэлний биеийн төлөөний нэр дундад үеийн монгол хэлний үед бараг хэвээрээ үлджээ. Харин гуравдугаар биеийн төлөөний нэр нь олонхи аялгуунд бие даасан байдалаа алдаж, түүний үүрэгийг заах үгээр орлуулан хэрэглэх болжээ.

	Ганц тоо	Олон тоо
I	bi < *bin < *min	ba < *ban < *man
II	či < *čin < *tĭn	ta < *tan < *tan
III	i < hi < *χin < *φin	a < han < *χan < *φan

0.1.2.4 ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛ

§ 14. **Орчин үеийн монгол хэлний тухай тойм**. Барагцаалвал, XVI-XVII зуунаас хойшхи үеийн монгол хэлийг *'орчин үеийн монгол хэл'*-ний үед хамааруулан үзнэ. Энэ үеийн монгол хэлний үндэсэн шинжийг бүхэлд нь тусхасан бичигийн дурсхал үгүй боловч түүний эхэн үеийн зарим онцлог шинжийг XVII зууны үед Ойрд Зая бандида Намхайжамцын зохиосон *'тод үсэг'*-ийн дурсхалуудаас тоймлон мэдэж болно. Мөн түүний дараахан зохиогдсон *'соёмбо бичиг'* ч бас орчин үеийн монгол хэлний үед холбогдох боловч түүгээр бичсэн ном судар нэн ховор, бичлэгийн дүрэм зүй нь нарийн хэвшин тогтоогүйн уламаас тухайн үеийнхээ хэлний шинжийг төлөөлөх ямар ч боломжгүй ажээ.

Түүнчилэн энэ үед холбогдох монгол бичигийн ном судар, түүхэн сурвалж бичигүүдийн үгийн сангийн бүрэлдэхүүн нь бүр эртний монгол хэлний үеэс уламжилан үлдсэн боловч орчин үеийн уншигчидад бүрэн ухагдаж байгаагаараа орчин үеийн монгол хэлэнд ч нэгэн адил хамаарна. Харин *'орчин үеийн монгол хэл'*-ний сүүлч үеийн онцлог шинжийг эдүгээгийн амьд хэл аялгуунуудаас тодорхой ажиглаж болно.

Монгол хэл аялгуунуудын зарим нь урт удаан хөгжилийнхөө явцад бие биеэсээ холдон салж, яваандаа биеэ даасан хэл болсон бол бас зарим нь өөр хоорондоо харилцаа холбоотой байж, уугуул хэлнийхээ нийтлэг шинжийг тогтвортой хадгалсаар иржээ. Тухайлвал, Монгор, Дунсян, Баоань, Шар Ёгур, Могол, Дагуур зэрэг хэлнүүд нь монгол хэлний хөгжилийн харьцангуй эртний шинжийг хадгалан үлдсэн бол Ойрд, Буриад болон Өмнөд монгол хэлнүүдэд монгол хэлний эрт үеийн зарим онцлог шинж уламжилан үлдсэн байдаг. Харин халх аялгуунд тулгуурласан Төв монгол хэлний шинж нь монгол хэлний урт удаан түүхэн хөгжилийн одоог хүртэлхи хамагийн эцэсийн түвшинд хүрсэн тул тэр нь монгол хэлний хөгжилийн түүхийг цуваа цагийн үүднээс харьцуулан судалахад нэг талын хизгаар нь болж өгдөг билээ. Тийм учираас монгол хэлний хөгжилийн өөр өөр түвшиний онцлог шинжийг зохих хэмжээгээр хадгалан үлдсэн монгол хэлнүүдийн өвөрмөц шинжүүд нь бие биеэ нөхсөөр монгол хэлний түүхэн судалалын үнэтэй чухал материал болдог билээ.

0.2 ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛ, АЯЛГУУНУУД

§ 15. **Орчин цагийн монгол хэл аялгуунуудын тойм.** Эдүгээ монгол угсаатанууд Монгол улсаас гадна БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Орон, Хөхнуур, Ганьсу, Хар мөрөн мужийн зарим хэсэг, ОХУ-ын Буриадын Бүгд Найрамдах улс, Эрхүү мужийн Усть-Ордын Буриадын тойрог, Чита мужийн Агын тойрог, Ижил мөрөний адаг орчимд Халимагийн Бүгд Найрамдах улс болон Астрахань, Ростов, Волгоград, Ставрополийн хизгаарын зарим хэсэг, Афганистан улсын Херат, Маймана, Бадакшан муж, Киргиз улсын Иссык-куль нуур зэрэг өргөн уудам нутагт тархан суурьшиж, өөр өөр хэл аялгуу, соёл иргэншил, шашин шүтлэгийн нөлөөн дор аж төрөн сууж байна. Өөр өөр түүхэн нөхцөл байдалын дор уугуул нутагаасаа салан тасарсан монгол угсаатануудын хэл аялгуу нь нэг талаар, эх хэлнийхээ эртний шинжийг зохих хэмжээгээр хадгалан үлдэж, нөгөө талаар, харь хэлний нөлөөнд ихээхэн автагдаж, зарим нь хэрэг дээрээ холимог хэлний шинжтэй болсон байна. Тийнхүү Төв Азийн өргөн уудам нутагт тархан суугаа монгол угсаатануудын хэл аялгууны ялгаатай болон адил төстэй талыг харгалзан ангилах асуудал эрдэмтэдийн анхааралыг татсаар иржээ. Энэ талаар хамагийн анхны ангилалыг хийсэн хүн бол оросын эрдэмтэн А. Д. Руднев юм.[113] Тэрвээр тухайн үедээ мэдэгдэж байсан монгол хэл аялгуунуудыг газар зүйн байрлалаар нь *дорнод, өрнөд, умард* гэж 3 хуваагаад, *Дорнод* салбарт Ордос, Цахар, Түмэд, Сөнөд, Хорчин, Харчин, Баарин, Хишигтэн, Горлос, Халх аялгууг, *Өрнөд* салбарт Халимаг, Баяд, Хошууд аялгууг, *Умард* салбарт буриад аялгууг тус тус багтаасан байна. Түүний дараа академич Б. Я. Владимирцов монгол хэл аялгуунуудыг *Баруун салаа, Дорнод салаа* гэж хоёр хуваагаад *Өрнөд* салаанд Астрахан болон Ховдын Дөрвөд, Торгууд, Ховдын ойрдууд, *Дорнод* салаанд Буриад, Барга, Дагуур, Харчин, Горлос, Найман, Цахар, Ордос зэрэг өвөрлөгч аялгуунууд болон халх аялгууг багтаажээ.[114] 1950-аад оны эхээр профессор Г. Д. Санжеев монгол хэл аялгуунуудыг *Монгол хэл, Ойрд хэл, Буриад монгол хэл, Дагуур хэл, Монгор хэл, Могол хэл* гэсэн 6 төрөл болгон ангилжээ.[115] Тэрвээр *'монгол хэл'*-нд Халх, Цахар, Ордос, Хорчин, Харчин зэрэг Ар Монгол, Өвөр Монголын аялгуунуудыг хамтад нь багтаажээ. Түүний дараахан проф. N. Poppe монгол хэл, аялгуунуудыг *Өрнөд, Дорнод* гэсэн хоёр салаа болгон ангилж, *Дорнод салаанд* Дагуур, Монгор (Монгор, Дунсян, Шар Ёгур), Дорнод монгол (Халх, Ордос, Харчин, Цахар), Буриад (Эхирит, Түнхин, Бохан, Алар, Баргузин, Хори, Ага, Барга буриад, Цонгоол), *Өрнөд салаанд* Могол, Ойрд, Халимаг хэлийг тус тус багтаажээ.[116]

---

[113] А. Д. Руднев, Опыт классификации монголов по наречиям, in: Г. І. Рамстедт, Сравнительная фонетика монгольскаго письменнаго языка и халхаско-ургинскаго говора, С-Петербургь, 1908, IV-VI

[114] Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монголького письменного языка, Введение и Фонетика, Лгр., 1929, 5-12

[115] Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, М., 1953, 27-71; Современный монгольский язык, М., 1959, 8

[116] N. Poppe, Introduction to Comparative Studies, 23; Introduction to Altaic Linguistics {= UAB. 14}, Wiesbaden, 1965, 7-15

Монгол хэл аялгуунуудыг илүү бодьтойгоор ангилсан хүн бол академич Ш. Лувсанвандан юм. Тэрвээр нийт монгол хэл аялгуунуудыг 4 үндэсэн аялгуу болгон хуваажээ.[117] Үүнд:

Нэг. Төв аялгуу
1. Халхын аман аялгуу
2. Цахарын аман аялгуу
3. Ордосын аман аялгуу

Хоёр. Дорнод аялгуу
1. Хорчины аман аялгуу
2. Харчины аман аялгуу

Гурав. Өрнөд аялгуу
1. Шинжааны Ойрдын аман аялгуу
2. Ижил мөрөний Ойрдын аман аялгуу

Дөрөв. Умард аялгуу
1. Байгалын өмнөд буриадын аман аялгуу
2. Байгалын хойд биеийн буриадын аман аялгуу

Жараад оны дундуур германы эрдэмтэн G. Doerfer[118] орчин үеийн монгол хэл аялгуунуудыг 1. *Өрнөд монгол хэл*, 2. *Дорнод монгол хэл*,3. *Алслагдсан монгол хэл* гэж гурав хуваасаныг хураангуйлан үзүүлвэл:

Нэг. Өрнөд Монгол хэл

1.1 Халимаг (Дөрвөд, Бузава, Торгууд, Уралын халимаг, Оренбур-гийн халимаг, сарт-халимаг)

1.2 Ойрд (Дөрвөд, Баяд, Торгууд, Урианхай, Мингад, Торгууд, Дамби-өөлд)

Хоёр. Дорнод Монгол хэл

2.1 Өмнөд Монгол (Улаанцав, Ордос, Цахар, Түмэд, Харчин, Жу-үд, Хорчин)

2.2 Төв Монгол (Халх, Хотгойд, Дархад)

2.3 Хойд Монгол (Өрнөд буриад, Дорнод буриад, Баргуузин, Барга-буриад, Өмнөд буриад)

Гурав. Алслагдсан монгол хэл

3.1 Могол

---

[117] Ш. Лувсанвандан, Монгол хэл аялгууны учир, Уб., 1959, 41 тал

[118] G. Doerfer, Klassification und Verbreitung der mongolischen Sprachen, HdO 5:2, 1964, 34-50

3.2 Монгор (монгор, арагва, дунсян, шар ёгур)
3.3 Дагуур

Профессор Чингэлтэй БНХАУ-ын нутаг дэвсхэр дээрхи монгол хэл аялгуунуудыг Монгол, Монгор, Дунсян, Баоань, Шар Ёгур, Дагуур гэсэн 6 хэл болгон ангилсан буй.[119]

1980-аад оны сүүлчээр Канадын монгол хэл судалаач эрдэмтэн Robert I. Binnick *'Монгол хэлнүүдийг ангилах тухай'*[120] гэсэн үгүүлэлдээ монгол хэл аялгуунуудыг нутаг дэвсхэрийн хуваариар бус хэлнийх нь онцлог шинжээр ангилахыг чухалчилж, монгол хэл аялгуунуудын авиа зүй, үг зүйн олон шинжүүдийг онцлон дурдсан боловч тодорхой ангилал хийсэнгүй.

Профессор J. Janhunen саяхан нийтлүүлсэн *'Монгол хэлнүүд'* гэсэн томоохон бүтээлдээ Өвөр Монголын монгол хэл аялгуунуудыг засаг захиргааны хуучин хуваарийг баримтлан 1. *Жиримийн,* 2. *Жу-үдийн,* 3. *Зостын,* 4. *Улаанцавын,* 5. *Шилийн голын* бүлэг аялгуу гэж таван гол аялгуунд хувааж, дээр нь Монгол улс дахь Халх, Дарьганга, Дархад, Хотгойд зэрэгийг нэг бүлэг аялгуу болгон нэмээд, тэдгээрийг газар зүйн байрлалаар умард, төв, дорнод аялгуу гэсэн гурван том бүлэгт хуваажээ.[121] Үүнд:

Нэг. Умард монгол аялгуу: Халх, Шилийн гол
Хоёр. Төв Монгол аялгуу: Улаанцав (цахар) аялгуу
Гурав. Дорнод аялгуу: Жирим (хорчин), Жу-үд, Зост (харчин)

Тэрвээр Буриад, Ойрд, Ордос зэрэг аялгууг хөрш зэрэгэлдээ хэл аялгуу хэмээн үзсэн буй.[122]

Монгол хэлтэнүүд нь хэд хэдэн өөр улсад тархан суурьшсан учир тэдгээр хэл аялгууг ангилах асуудал зарим талаар маргаантай хэвээрээ байна. Жишээлэхэд, ОХУ, БНХАУ-д оршин суудаг монгол угсаатанууд тухайн улсын доторхи олон үндэстэний нэг, тэдний хэл нь мөн биеэ даасан *'хэл'* гэж ойлгогдоно. Гэтэл Монгол улсын талаас авч үзвэл ОХУ дахь Халимаг, Буриад, БНХАУ-д оршин суугаа Ойрд, Буриадууд нь Монгол улс дахь Ойрд, Буриадуудын нэг хэсэг, тэдний хэл аялгуу нь Ойрд, Буриад аялгууны хилийн чанад дахь салбар аялгуу болно. Бүр хөндлөнгөөс авч үзвэл дээрхи гурван улсад тархан оршин суугаа Буриад, Ойрдуудын хэл нь бие биеэ нөхөж, бие биетэйгээ нийлээд нэгэн бүхэл бүтэн *'Буриад хэл', 'Ойрд хэл'*-ийг бүрдүүлж байгаа билээ. Иймээс нөхцөлд тэдгээрийг *'биеэ даасан хэл'* гэж үзэх үү, нэг

---

[119] Чингэлтэй, Dumdadu ulus-un mongγol törül kele ayalγun-u yirüngkei bayidal, *'Činggeltei-yin ǰokiyal bütügel-ün tegübüri'*, 1, 2010, 221-561

[120] Robert I. Binnick, On the Classification of the Mongolian Languages, CAJ 31:3-4, 1987, 178-195

[121] J. Janhunen (ed.), The Mongolic Languages {= Rourledge Language Family Series}, London & New York, 2003, 178-181

[122] ibid., 180

хэлний *'салбар аялгуу'* гэж үзэх үү гэдэг асуудал маргаантай байгаа билээ. Өөр өөр улсад оршин сууж байгаа нэг хэлний салбар аялгуутанууд тус тусдаа бичигийн хэлтэй байвал тэдгээрийг *'биеэ даасан хэл'* гэж үзнэ гэсэн зарчим олон улсын хэмжээнд үйлчилсээр байна. Тэрхүү зарчимыг баримталвал, дээрхи гурван улсад харъяалагдаж байгаа Ойрд, Буриадууд өөр өөр бичигийн хэлтэй байгаа учир тус тусдаа биеэ даасан *'хэл'* болж таарна.

Харин Монгор, Дунсян, Баоань, Шар Ёгур, Дагуур, Моголчуудын өөр зууpаа харилцах уугуул хэл нь уугуул монгол хэлнээсээ олон зуун жилийн өмнө салж, өөр харь хэлний нөлөөнд автаж, ихэнхидээ холимог хэлний шинжтэй болсон учир тэдгээрийг биеэ даасан хэл гэж үзэхэд маргах зүйлгүй. Сүүлийн үед зарим эрдэмтэд Монгор, Дунсян, Баоань, Шар Ёгурчуудын хэлийг газар зүй болон хэл аялгууных нь нийтлэг шинжийг харгалзан *'Ганьсу-Хөхнуурын бүлэг хэл'* гэж нэрлэсэн бий.[123] Монгол хэл аялгуунуудын дотороос Төв Монгол, Өмнөд Монгол, Ойрд, Буриад хэл нь бусад хэлний нөлөөнд автаагүй, монгол хэлнийхээ дотоод зүй тогтолын дагуу хөгжиж ирсэн зонхилох шинжтэй хэлнүүд юм.

Бид энд монгол хэл аялгуунуудыг шинэчилэн ангилахыг зориогүй, олон улсын монгол судалалын хэмжээнд баримтлаж ирсэн ангилалын дагуу хэл тус бүрийн тухай товч мэдээлэл, судалгааны тойм, хэлний онцлог шинжийг монгол хэлний хөгжилийн үе шатуудын шинжтэй уялдуулан авч үзнэ. Энд бид монгол хэл аялгуунуудын бие биеэсээ ялгагдах шинжийг голлосонгүй, харин монгол хэлний эртний шинжийг хэрхэн хадгалж үлдсэн байдалыг нь чухалчилсан болно.

0.2.1 ТӨВ МОНГОЛ ХЭЛ

§ 16. **Төв монголчуудын тухай**. Төв монгол хэлний гол цөм нь болсон халхчуудын дээд өвөг нь болох *'Халх түмэн'*нь бүр XIV зууны үед байсан бөгөөд тэд Их Монгол улс задарсаны дараа *'зургаан түмэн'*-ий зүүн гарт багтаж байжээ. Хожим XVI зууны үед Батмөнх даян хаан Халх түмэнийг өөрийн хүү Гэрсэнзэд хуваарилан өгч, Гэрсэнзээс хойш түүний долоон хүү халхыг хуваан авчээ. Тэр цагаас хойш Ар Халхын долоон отог үүссэн бөгөөд тэдгээр нь яваандаа *'халх'* гэсэн нэгэн нэрийн дор нэгдэсэн нь эдүгээгийн халхчуудын дээд өвөг юм.

Халх аялгууг дотор нь *Төв халх, Өрнөд халх, Дорнод халх* гэсэн гурван аман аялгуунд хуваан үздэг. Төв халхын аман аялгуунд дан халх аялгуу багтах бөгөөд Өрнөд халхын аман аялгуунд халхаас гадна, *Хотгойд, Дархад, Элжигэний* аман аялгуу, Дорнод халхын аман аялгуунд *Дариганга, Үзэмчин* аман аялгуу багтдаг. 2015 оны хүн амын тооллогоор нийт халх аялгуутанууд нь 2 561 473 байсан байна.

Халхын бүрэлдэхүүнд хожим ирж нийлсэн угсаатаны бүлэгүүдийн гаралын талаар товч дурдая.

---

[123] J. Janhunen (ed.) The Mongolic Languages, 1

Баруун халхад багтах хотгойдууд нь XVI зууны үед халхын баруун хизгаарт ирж нийлсэн ойрдуудаас гаралтай бөгөөд хожим XVIII зууны үед Манжийн эрх баригчид тэднийг халхын ноёдод хуваан өгсөнөөр хэд хэдэн өөр хошуунд харъяалагдах болжээ. Хотгойдууд нь эдүгээ Монгол улсын баруун бүсийн Хөвсгөл, Завхан аймагийн зарим хэсэгээр оршин суудаг бөгөөд халхчуудын дунд олон зуун жил оршин суусан тул хэл аялгуугаар ярих боловч ойрд аялгууны зарим шинжийг хадгалсан байдаг байна.

Дархадууд нь XVII зууны сүүлчээр халхын шарын шашины тэргүүн Өндөр гэгээн Занабазарын шавь болж, аливаа алба татвараас чөлөөлөгдөн дархан эрхтэй болсон хүмүүсээс гаралтай ажээ. Эдүгээ дархадууд нь Монгол улсын умард талаар оршин суудаг бөгөөд тэдний хэл аялгуунд ойрд, буриад хэлний нөлөө ажиглагддаг байна.

Мөн Баруун халхад багтдаг элжигэнчүүд нь эртнээс нааш язгуурын монголчуудын бүрэлдэхүүнд багтаж, Их Монгол улсын үеэс Төвийн түмэнд багтах болжээ. Элжигэнчүүд XVI зууны үеэс Гэрсэнзийн удамынханд харъяалагдан Хангайн нуруу орчимоор нутаглаж байгаад XVIII зууны эхээр Алтайн уулс тийш нүүжээ. Эдүгээ элжигэнчүүд нь Монгол улсын баруун бүсийн хэд хэдэн аймагт тархан сууж байна.

Дорнод халхад багтах даригангачууд нь XVII зууны сүүлчээр халхын зүүн өмнөд хэсэг, Өвөр Монголын зүүн хойд хошууны нутагаас таслан авч, манжийн хааны сүрэгийг адуулах эзэмшилийн бүс байгуулж, газар газараас тэнд аваачсан сүрэгчингүүдээс бүрэлдсэн угсаатаны бүлэг юм. Эдүгээ даригангачууд нь Монголын дорнод бүсийн Сүхбаатар аймагийн зарим суманд оршин сууж байна. Мөн Дорнод халхад багтдаг үзэмчинүүд XVI зууны үеэс зүүн Монголын харъяанд багтаж байсан цахарын дөрвөн отогийн нэг бөгөөд XVII зууны үеэс одоогийн Өвөр Монголын Шилийн голын чуулганы харъяанд багтах болжээ. Хожим XX зууны дундуур тэдний зарим нь Монгол улсад шилжин ирж, Монгол улсын дорнод бүсийн Дорнод, Сүхбаатар аймагийн зарим сумдад оршин суух болжээ.

Халхчууд нь Монгол улсын нийт хүн амын гуравны хоёр хувийг эзэлдэг бөгөөд тэдний хэл аялгуу нь өөр хоорондоо харьцангуй нэгдэлтэй юм. Орчин цагийн монгол утга зохиолын хэлний зөв бичих дүрэм, дуудлагын хэм хэмжээ нь халх аялгуун дээр тулгуурласан төдийгүй, төрийн албан ёсны бүх ажиллагаа, сонин хэвлэл, радио телевиз зэрэг мэдээлэлийн бүх хэрэгсэл, театр, кино зэрэг урлагийн олон төрөл, бүх шатны сургалт гагцхүү Төв аялгуун дээр тулгуурлаж байна. Харин утга зохиолын хэлний үгсийн сан нь зөвхөн халх аялгуугаар хизгаарлагдахгүй, бусад олон монгол хэл аялгууны үг хэллэг, харь хэлний үг, нэр томъёогоор байнга баяжиж байдаг билээ.

§ 17. **Төв монгол хэл аялгууны судалгааны тойм**. Төв монгол хэлний судалгааны гол цөм нь халх аялгууны судалгаа юм. XX зууны эхээр профессор G. J. Ramstedt халхын аман аялгууны талаар хамагийн анхны дэлгэрэнгүй судалгаа хийжээ. Тэрвээр Их Хүрээ орчимын халх аялгууны талаар цуглуулсан материалаа

монгол бичигийн хэлтэй харьцуулан тухайн аялгууны авиа зүйн онцлогийг хэл шинжилэлийн үүднээс нарийвчилан гаргажээ.[124] Мөн тэрвээр халх аялгууны үйл үгийн ялгалын тухай томоохон судалгаа нийтлүүлсэн бий.[125] Түүний дараахан академич Б. Я. Владимирцов бараг нийт халх аялгууг бараг бүхэлд нь хамарсан томоохон суурь судалгаа хийсэн бөгөөд түүндээ халх аялгууны эгшиг, гийгүүлэгчийн тогтолцоо, урт, хос эгшигийн гарал, эгшиг авианы суларал, ижилшил, солигдол, сэлгэлт, гийгүүлэгчийн тагнайшил, солигдол зэрэг өргөн хүрээтэй асуудалыг багтаажээ.[126] Халх аман аялгууг цаашид нарийвчилан судалсан бүтээлийг Н. Поппе өнгөрсөн зууны гучаад оны дундуур нийтлүүлсэн[127] бөгөөд хожим түүнийгээ нэмэн дэлгэрүүлж герман хэлээр гаргасан нь[128] эдүгээ хүртэл тухайн аялгууны бие даасан бүтээл болсоор байна. Түүний дараахан халх аялгууны авианы үндэсэн шинжийг фонологийн түвшинд авч үзсэн бүтээлийг Don. G. Stuart & M. Haltod, В. М. Наделяев нар нийтлүүлсэн нь халх аялгууны судалгааны хүрээг фонологийн түвшинд хүргэсэн билээ.[129] Жараад оны үед John C. Street, J. Bosson, Beffa Marie-Lise &, R. Hamayon, Ш. Лувсанвандан нар халх аялгууны авиа зүй, үг зүйн шинжийг бүтэц хэлний зүй (*structural grammar*), товчоолох хэлний зүй (*descriptive grammar*)-н аргаар судалсан томоохон бүтээлүүд гаргасан байна.[130]

Жар-далаад оны үед халхын аман аялгууг нарийвчилан судалах эрдэм шинжилгээний ангийг удаа дараалан зохион байгуулж явуулсаны үр дүнд Монгол улс дахь халхын аман аялгууг бүхэлд нь хамарсан нилээд өргөн хүрээтэй судалгаа хийжээ. Түүний үр дүнд Э. Вандуй, А. Лувсандэндэв, Ж. Төмөрцэрэн, Ж. Цолоо нарын олон үгүүлэлүүд нийтлэгджээ.[131]

---

124 G. J. Ramstedt, Das Schriftmongolische und die Urgamundart phonetisch verglichen, JSFOu 21, 1903, 1-56; *idem.* Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, СПб., 1908, 65 стр.

125 G. J. Ramstedt, Über die konjugation des Khalkha-mongolischen {MSFOu 21}, XV + 4-126

126 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Лгр., 1929, 437 стр.

127 Н. Поппе, Строй халха-монгольского языка, Лгр., 1936, 24 стр.

128 N. Poppe, Khalkha-Mongolische Grammatik. Mit Bibliographie, Sprachproben und Glossar, Wiesbaden, 1951, XI +188

129 Don. G. Stuart, M. Haltod, The Phonology of the Word in Modern Standard Mongolian, *Word.* 13, 1957, 65-99; В. М. Наделяев, Состав фонем в звуковой системе современного монгольского языка, ВЛГУ Сер. ист. и лит-ры, Вып. I, 1957, 123-131

130 John. C. Street,, Khalkha Structure {= UAS. 24}, Bloomington, Indiana, 1963, 1-255; J. E. Bosson, Modern Mongolian: A Primer and Reader {= UAS. 38}, 1964, 256; Beffa, Marie-Lise, Roberte Hamayon, Éléments de grammaire mongole, Paris, 1975, 286; Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Авиа, авиалбар хоёр нь, 1-р дэвтэр, Уб., 1967, 3-129

131 Э. Вандуй, Халхын дорнод дэд аман аялгуу, МС. 6, 1967, 3-17; Халхын аялгуу, түүний үгсийн сан, *'Халх аялгуу'*, 1970, 4-132;А. Лувсандэндэв, Дариганга аялгууны авиазүйг судалсан туршлагаас, *'ШУХ-ийн бүтээл'*, 2, 1957, 49-64; Ж. Цолоо, Баруун халхын аман аялгуу, *'Халх аялгуу'*, Уб., 1970, 133-222; Орчин цагийн монгол хэлний авиа зүй, Уб., 1976, 3-158; Ж. Төмөрцэрэн, Үзэмчин аялгууны зарим онцлогоос, МС 4:13, 1964, 1-4; Халхын аялгуун дахь гийгүүлэгч зохьцлын ул мөр, ШУАМ. 1, 1966, 99-102; Халхын аман аялгууны уужимсах зохьцол, МС 7:19, 1970, 243-2

Мөн далаад оны эхээр профессор N. Poppe халх аялгууны эгшиг, гийгүүлэгч авианы тогтолцоо, эгшигийн зохицол, үеийн бүтэц, үг бүтэх, үг холбох арга, үгсийн аймагийн онцлог шинжийг хэл шинжилэлийн шинэлэг аргаар бичсэн сонирхолтой бүтээл нийтлүүлжээ.[132] XXI зууны эхээр шведийн монголч эрдэмтэн Jan-Olof Svantesson нар монгол хэлний эгшигийн зохицол, үгийн өргөлт, үеийн бүтэц, хэт богино эгшигийн тухай бүтээлүүдээ[133] халх аялгуунд тулгуурлан бичсэнээс гадна *'Монгол хэлний фонологийн судалгаа'* гэсэн хамтын бүтээлдээ халх аялгууны авиалбар зүйн шинжийн талаар дэлгэрэнгүй үгүүлсэн бий.[134]

Түүнчилэн халх аялгуунд багтах, Дархад, Дариганга, Үзэмчин аялгууны талаар Г. Санжеев,[135] А. Лувсандэндэв,[136] G. Kara[137] нарын судалгааны бүтээл гарсан бий. Мөн халх аялгууны үгсийн сангийн тусхай толь бичиг[138] гарсанаас гадна халхын аялгуун дээр суурилсан орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн тайлбар толь[139] болон монгол-орос,[140] монгол-англи,[141] монгол-герман[142] толь бичигүүд гарсан байна.

---

132 N. Poppe, Mongolian Language Handbook {= *Center for Applied Linguistics*}, Washington, 1970, XVI + 175; Jan-Olof Svantesson, Vowel Harmony Shift in Mongolian, *Lingua,* 67, 1985, 283-327: Vowel Palatalization in Mongolian, *Actes du XII Congrès XII Congrès international des sciences phonétiques*, 1991, 5:102-105; Mongolian Syllable Structure, WP Lund 42, 1994, 225-239; (with Vivan Franzén), Mongolian Schwa, *The First Seoul International Conference on Phonetic Sciences,* 1996; Khalkha, in: *The Mongoilic Languages,* edited by J. Janhunen, 154-176

134 Jan-Olof Svantesson, Anna Tsendina, Anastasia Karlson, & Vivan Franzén, The Phonology of Mongolian, Oxford University Press, 2005, XIX + 1-314

135 Г. Д. Санжеев, Дархатский говор и фольклор {= ММК 15}Лгр., 1931, 112 стр.

136 А. Лувсандэндэв, Дариганга аялгууны авиа зүйг судалсан туршлагаас, ШУХ-ийн бүтээл, 2, Уб., 1957, 49-64; A. Rona-Tas, A Studyon Dariganga Phonology, AOH 10, 1960, 1-29

137 G. Kara, Sur le dialecte üǰümüčin, AOH 14, 1962, 145-172; Un glossaire üǰümüčin, AOH 15, 1962, 1-43.

138 Б. Амаржаргал, БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг I, Халх аялгуу, Уб., 1988, 718 тал

139 Я. Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Уб., 1966, X + 11-911 || Нэмэн дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл. Үг, утга, жишээ, тайлбар, хавсралт тэргүүтнийг нэмж хянасан Ц. Шагдарсүрэн, Уб., 2013, XXII + 1-1301; Л. Болд (ed.) Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, Уб., 2008, XXXX + 1-3278; И. Дамбажав, Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж, Уб., 2006, XIII+ 3-1238 тал

140 А. Лувсандэндэв (ed.), Монгол-орос толь // Монгольско-русский словарь, М.,1957,3-715; А. Лувсандэндэв, Ц. Цэдэндамба (eds.) Mongγol-oros-delgerenggüi yeke toli // Большой академический монгольско-русский словарь, М., том I. (2001), XX + 1-486; II. (2001), XXII + 1-507; III. (2001), XX + 1-438; IV. (2002), XXI + 1-497

141 F. Lessing (ed.) Mongolian-English Dictionary compiled by Mattai Haltod, John Gombojab Hangin, Serge Kassatkin, & F. Lessing, University of Californea Press, Berkeley & LosAngeles, 1960, XV + 1-1217; Gombojab Hangin with John R. Krueger & Paul D. Buell, William V. Rozycki, Robert G. Service, A Modern Mongolian-English Dictionary, Indiana University, 1986, XXI + 1-900; D. Tömörtogoo, A Modern Mongolian-English-Japanese

§ 18. **Төв монгол хэлний үндэсэн шинж.** Төв монгол хэлний халх аялгууны судалгаан дээр тулгуурлан тухайн хэлний онцлог шинжийг цуваа цагийн хувьсалын үр дүнтэй уялдуулан авч үзэе.

1. Эртний монгол хэлэнд үүсэн бүрэлдсэн 7 богино эгшиг фонем орчин үеийн Төв монгол хэлэнд хэвээрээ хадгалагдан үлджээ.

2. Өвөг монгол хэлний үеэс уламжилан ирсэн эгшиг авианы хүчдэл (эр, эм)-ээр зохицох ёс хэвээрээ хадгалагдан үлдсэн төдийгүй, тэргүүн ба тэргүүн бус үеийн аль хүчтэй эгшигтээ татагдан ижилшсэн байна.

TMon.	džarğal	AM	ǰirγal	*'жаргал'*
TMon.	neg	AM	nigen	*'нэг'*
TMon.	oron	AM	oran	*'орон'*
TMon.	ödör	AM	edür	*'өдөр'*
TMon.	nüdə	AM	nidün	*'нүд'*

Тэргүүн үедээ уруулын ***o, ö*** эгшигтэй үгийн дэд үед орсон уруулын бус урт, богино эгшигийн аль аль нь өмнө талынхаа хүчтэй эгшигт татагдан дэвшиж ижилшсэн байна.

ÖMon.	olon	AM	olan	*'олон'*
ÖMon.	örgön	AM	örgen	*'өргөн'*
ÖMon.	tō	AM	toγā	*'тоо'*
ÖMon.	tȫ	AM	tögē	*'төө'*

3. Өвөг монгол хэлний үед байсан анхдагч урт эгшиг орчин үеийн Төв монгол хэлэнд хадгалагдан үлдсэнгүй.

4. Дундад үеийн монгол хэлний үүсмэл урт эгшигүүд нь эдүгээгийн Төв монгол хэлэнд хадгалагдан үлдэж, бусад богино эгшигтэйгээ эсэрэгцэлдэн бие даасан фонемийн үүрэгээ гүйцэдхэсээр байна.

TMon.	χān	AM	qaγān	*'хаан'*
TMon.	temē	AM	temegēn	*'тэмээ'*
TMon.	χalūn	AM	qalaγūn	*'халуун'*
TMon.	serūn	AM	serigūn	*'сэрүүн'*

Dictionary, Tokyo, 1979, 1-802 + 1-9; Ch. Bawden, Mongolian-English Dictionary, London & New York, 1997, IV + 1-595

[142] H-P Vietze, Wörterbuch Mongolish-Deutsch, Langenscheidt, Verlag Enzyklopädie, Leipzig / Berlin / München / Wien / Zürich / New York, 1988, 7-417

5. Эртний монгол хэлний үед үүссэн үгийн эцэсийн хос эгшиг Төв монгол хэлэнд хосорхог шинжээ хадгалсаар байна. Харин үгийн эцэсийн ***ei*** гэсэн хос эгшигийн бүтэцэн дэх ***e*** эгшиг нь арынхаа тагнайн ***i*** эгшигэндээ татагдан ***ī*** болсон байна. Түүнчилэн ***ai, ei, ui, üi*** гэсэн хос эгшиг нь Өрнөд халхын аман аялгуунд ***ā, ā̄ , ū, ū̄,*** Дорнод халхын аман аялгуунд ***ē, ī*** болсон байна.

TMon.	dalai / dalā / dalā̄	*'далай'*
TMon.	noχoi / noχā / noχā̄	*'нохой'*
TMon.	χamtsui / χaŋtsū	*'ханцуй'*
TMon.	delχī / delχē	*'дэлхий'*

6. Дундад үеийн монгол хэлний эцэсийн бус үед үед байсан Vyi гэсэн цогцийн доторхи тагнайн шүргэх ***y*** гийгүүлэгч суларан сугарсаны уламаас түүний хоёр талын эгшигүүд нь нэгэн үед багтаж, хос эгшиг болжээ. Харин нэгэнт үүссэн хос эгшиг нь Дархад, Хотгойд, Өөлд зэрэг Өрнөд халхын зарим салбар аман аялгуунд хосорхог шинжээ алдаж, ихэнхидээ ***ā̄ , ū̄, ū*** болжээ. Мөн ***eyi*** гэсэн цогцын доторхи эгшигүүд нь хос эгшигийн шатыг дамжаад уламаар цааш арынхаа урт эгшигт татагдан ижилшээд урт ***ī*** болсон байна.

TMon.	sain / sā̄ n	AM	sayin	*'сайн'*
TMon.	uil- / ūl-	AM	uyila-	*'үйл-'*
TMon.	üil / ū̄l	AM	üyile	*'үйл'*
TMon.	īm	AM	eyimü	*'ийм'*

7. Дундад үеийн монгол хэлний үгийн эхний шүргэх ***h-*** гийгүүлэгч нь Төв монгол хэлний аль ч аялгуунд уламжилан үлдсэнгүй.

8. Дундад үеийн монгол хэлний үед тагнайшилын үр дүнд үүссэн хамжин шүргэх ***dž, tš*** нь их төлөв хэвээр уламжилан үлдсэнээс гадна зарим тохиолдолд хамжин шүргэх ***dz, ts*** болсон бий.

TMon.	džidɒ/ džadɒ	AM	ǰida	*'жад'*
TMon.	tšidal / tšadal	AM	čidal	*'чадал'*
TMon.	dzam	AM	ǰam	*'зам'*
TMon.	tsetseg	AM	čečeg	*'цэцэг'*

9. Биеийн төлөөний нэрийн эртний үндэсүүд нь их төлөв харьяалах тийн ялгалд хадгалагдан үлджээ.

ганц тоо		олон тоо
I	bi min- (Gen.)	bidɒ, bidə bidan-, biden-
II	tši tšin- (Gen.)	ta / tānar tan- / tānar-

0.2.2 ӨМНӨД МОНГОЛ ХЭЛ

§ 19. **Өмнөд монголчуудын тухай**. Өмнөд монголчуудын дээд өвөг нь бүр Хүннү, Сяньби, Жүжан, Тоба, Хитаны үеэс аваад Юань гүрэн, Мин гүрэний үеийг хүртэл бусад ар монголчуудтайгаа хамт монгол угсаатаны гол цөм нь болсоор ирсэн бөгөөд хожим Чин улсын үеэс нутаг дэвэсхэр, хил хизгаар тусхаарлан салсан угсаа гарал, хэл соёл, зан заншил, шашин мөргөл нэгтэй монголчууд юм.

XV-XVI зууны үеийн Монголд улс төрийн бутарал эхэлж, уламаар Батмөнх даян хааны үед *'Зургаан түмэн монголчууд'* нь дотроо *'Баруун түмэн', 'Зүүн түмэн'* болон хуваагдсан нь Ар Монгол, Өвөр Монгол хуваагдахын эхлэл болжээ. Бүр VIII зууны үеэс Алтай, Хангайн завсарт нутаглаж, хожим Даян хааны захиргаанд байсан эртний түүхтэй Найманчууд, Юань гүрэний Баруун гарын гурван түмэнд багтаж байсан ордосууд, Чингис хааны үеийн хишигтэн цэрэгээс уламжилалтай хорчингууд, Зүүн гурван түмэний нэг болох цахарууд, Бодончарын үеэс гаралтай бааринчууд, эртний Дарлигин овогийн удамтай горлосууд цөм Өмнөд Монголд багтаж байна. Тэдний хэл аялгуу нь зарим талаар монгол хэлний эртний шинжийг хадгалж байгаагаас гадна бичигийн хэлний олон зуун жилийн уламжилал дээр тулгуурласан нэгдмэл бичигийн хэлтэй, арвин баялаг үгсийн сантай биеэ даасан хэл юм.

Өмнөд монгол хэлтэнүүд нь БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орон болон Хэйлунзян, Гирин, Ляонин мужийн зарим хэсэгээр оршин суух бөгөөд нийт хүн ам нь 2010 оны тооллогоор 5 981 840 байв. (*Tabulation on the 2010 Population Census of the People's Republic of China*)

§ 20. Өмнөд монгол хэл аялгууны судалгааны тойм. Өмнөд монгол хэлийг анхлан судалсан хүн бол А. Д. Руднев юм. Тэрвээр өнгөрсөн зууны эхээр өвөрлөгчидийн хэл аялгууны баялаг материал цуглуулж уламаар *'Дорнод монголын хэл аялгууны материал'* гэдэг томоохон бүтээл нийтлүүлжээ.[143] Уул номд өмнөд монгол хэлний Ар-хорчин, Горлос, Түмэд, Үзэмчин, Ордос зэрэг хэд хэдэн аялгууны аман зохиолын материал, авиа зүй, үгзүйн судалгаа, аман аялгуунуудын харьцуулсан толь зэрэгийг багтаасан нь монгол хэл аялгуунуудын судалалд чухал ач холбогдолтой судалгаа болсон юм.

Бельгийн нэрт монголч A. Mostaert 1920-оод оноос эхлэн ордос газар олон жил суухдаа тэдний хэл аялгуу, аман зохиолыг нарийвчилан судалж, ордос аман аялгууны онцлог шинжийн тухай тусхай судалгаа болон аман зохиолын баялаг өв сангаас дээжилсэн материалыг нийтлүүлсэнээс[144] гадна гурван боть ордос-франц

---

143 А. Д. Руднев, Материалы по говорам Восточной Монголии, СПб., 1911, III-XXXII + 1-258

144 A. Mostaert, Le dialecte des mongols Urdus (Sud.), Etude phonétique, *Anthropos*, 21(1926), 851-869,22 (1927), 160-186, 25 (1930) 725-727; Textes oraux ordos recueillis et publiés avec

томоохон толийг эмхэдхэн гаргасан нь[145] зөвхөн ордос аялгуу төдийгүй нийт монгол хэлний судалалд дорвитой хувь нэмэр болсон билээ.

Тавиад оны дундуур БНХАУ дахь монгол хэл аялгуунуудыг судалах ажил хүчтэй өрнөж, монгол угсаатан оршин суудаг бүх нутаг оронд судалаачидын томоохон баг ажиллаж, монгол хэл аялгууны баялаг материал цуглуулж, анхны томоохон тойм судалгаа нийтлэгджээ.[146] Дундад улс дахь тэр үеийн нийгэмийн нөхцөл байдалаас шалтгаалан монгол хэл аялгууны талаар цуглуулсан материалын нарийвчилсан судалгаа гарч чадсангүй, харин уул хээрийн судалгааны ажилд биечилэн оролцсон оросын эрдэмтэн Б. Х. Тодаева тус судалгааны багийнханы уридчилан боловсоруулсан тайлан болон өөрийн цуглуулсан материалыг боловсоруулж, 1960-аад оны эхээр анхны тойм судалгааг[147] нийтлүүлсэн бөгөөд хожим 1980-аад онд илүү дэлгэрүүлсэн судалгааны бүтээлээ гаргажээ.[148]

Тэр үеэс эхлэн өмнөд монголын хэлний аман аялгуунуудыг судалах ажил нилээд идэвхиж, тухайлвал, Ордос аман аялгууны авианы онцлог шинжийн талаар N. Poppe, J. Street, Хас-Эрдэнэ, Ц. Норжин, Мөнхбуян, Чи. Сэчин - М. Баатар - Сэнгээ, Stefan Georg нар,[149] Цахар аман аялгууны талаар Sh. Hattori, Жагчидсэцэн - A. Dien, Ц. Норжин, Хас-Эрдэнэ, Сэцэнбаатар нар,[150] Харчин, Хорчин аман аялгууны талаар M. Nomura, J. Bosson - Үнэнсэцэн, Хас-Эрдэнэ, Тулгуур нар,[151]

---

introduction, notes morphologiques, commentaires et glossaire. {= *Monumenta. Serica.* Monograph Series No. 1}, Peiping, 1937, LXX + 1-765

145 A. Mostaert, Dictionnaire Ordos, {= *Monumenta. Serica.* Monograph Series V}, I-III, Peking: Catholic University, 1941-1944, 966 p.

146 Чингилтэй, Dumdadu ulus-un mongγol kele nügüd ba ayalγu-nuγud-un bayidal, MKB 1957:11(44-57), 12(25-52), 1958:1(44-48), 3(32-39), 4(29-49), 6(35-39), 7(26-32), 12(19-57)

147 Б. Х. Тодаева, Монгольские языки и диалекты Китая, М., 1960, 3-135;

148 Б. Х. Тодаева, Язык монголов Внутренней Монголии. Материалы и словарь, М., 1981, 105-274; Язык монголов внутренней Монголии. Очерки диалектов, М., 1985, 3-129

149 N. Poppe, Das Ordossische {= *Handbuch der Orientalistik* V, 2}, 1964, 134–136; John. C. Street, Urdus Phonology. UAJb 38, 1966, 92-111; Хас-Эрдэнэ, Ordos-un aman ayalγun-u ončaliγ, MKJT 1, 1959, 30-42; 4(1959) 3-13; Мөнхбуян, Ordos aman ayalγun-u abiyalburi-yin sistem, MKB 90, 1990, 25-36; Чи. Сэчин, Т, Баатар, Сэнгээ, Ordos aman ayalγun-u sudulul, ÖMAKQ, 2002, 1-388; Stefan Georg, Ordos, in: The Mongolic Languages, edited by J. Janhunen, 2003, 193-208

150 Sh. Hattori, Phonemic Structure of Mongol (Chakhar Dialect), JLSJ 19-20, 1951, 68-102; Jagchid S & Dean, A. E, Spoken Chakhar Mongolian, *'Inter University Program for Chinese Language Studies'*, 1964, 288; Ц. Норжин, Čaqar aman ayalγun-u abiyalburi-yin sistem-ün ončaliγ, ÖMBDS 1, 1981, 20-38; Хас-Эрдэнэ, Čaqar aman ayalγun-u abiyan-u toγtača, ÖMBDS 3, 1989, 1-15; Сэцэнбаатар, The Chakhar Dialect of Mongol: A Morphological Description {= MSFOu 243} 2003, Helsinki, 215 pp.

151 M. Nomura, Remarks on the Kharchin Central Banner Dialect of Mongolian, JLSJ 9, 1941, 80-91; *idem.* Supplementary Notes and Additions to Remarks on the Diphthong */wa/* in the Kharachin Dialect of the Mongol Language, JLSJ 17-18, 1951, 149-156; *idem.* On Some Phonological Developments in the Kharachin Dialect, *'Studia Altaica'* {= UAB. 5}, Wiesbaden, 1957, 132-136; *idem.* On Phonological Developments in the Kharachin Dialect Parallel to the Dagur Dialect of the Mongol Language, MFL NU 22 (1960), 1-16; J. E.

Баарин аман аялгууны талаар Чингэлтэй, Баярмэнд нар[152] судалгааны тусхайлсан бүтээлүүд нийтлүүлжээ.

Сүүлийн үед Өвөр монголын эрдэмтэд өмнөд монгол хэлний аман аялгуунуудын онцлог шинжийн талаар бичсэн олон сонирхолтой үгүүлэл *'Монгол хэл бичиг', 'Монгол хэл, утга зохиол', 'Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэдхүүл', 'Дундад улсын монгол судалал'* зэрэгт гарсаар байна.

§ 21. **Өмнөд монгол хэлний үндэсэн шинж**. Өмнөд монгол хэлний талаархи эрдэмтэдийн судалгаанд тулгуурлан тухайн хэлний онцлог шинжийг цуваа цагийн хүрээнд авч үзэе.

1. Өмнөд монгол хэлний зонхилох аялгуунуудад долоон богино эгшиг фонем буй бөгөөд Харчин, Түмэд, Барин, Ар-хорчин зэрэг аман аялгууны эгшигийг фонетикийн талаас авч үзвэл илүү урагшилж, үлэмж уйтаншсан хувилбарууд бий болсон байна.

2. Өмнөд монгол хэлэнд эгшиг авианы хүчдэлийн зохицол хэвээрээ хадгалагдаж байна. Тэргүүн үедээ уруулын *o, ö* эгшигтэй үгийн дэд үед орсон урт, богино эгшигийн аль аль нь өмнө талынхаа хүчтэй эгшигт татагдан дэвшиж ижилшсэн байна.

ÖMon.	olon	AM	olan	*'олон'*
ÖMon.	örgön	AM	örgen	*'өргөн'*
ÖMon.	tō	AM	toγā	*'тоо'*

Уруулын богино *u, ü* болон мөн урт *ū, ǖ*-гийн өмнөх үед орсон уруулын бус богино эгшиг нь арынхаа эгшигт татагдан ихэнхидээ ухаран ижилшжээ.

ÖMon.	tömör	AM	temür	*'төмөр'*
ÖMon.	tšusɒ/ tšusu	AM	čisun	*'цус'*
ÖMon.	dū	AM	daγūn	*'дуу'*
ÖMon.	nǖ-	AM	negǖ-	*'нүү-'*

3. Өвөг монгол хэлний үе байсан анхдагч урт эгшиг Өмнөд монгол хэлэнд хадгалагдан үлдсэнгүй.

4. Дундад үеийн монгол хэлний үеэс уламжилж ирсэн үүсмэл урт эгшиг нь бие даасан фонемийн үүрэгээ хадгалсаар байна.

Bosson, B. Ünensečen, Some Notes on the Dialect of the Khorchin Mongols, *'American Studies in Altaic Linguistics'*{= UAS.13}, Bloomington, Indiana, 1962, 23-44: Тулгуур, Qorčin aman ayalγun-u egesig abiyalburi-yin ončaliγ, ÖMÜBDS 4, 1996, 49-62

[152] Чингэлтэй, Baγarin aman ayalγun-u abiya ǰ üi ba üges-ün ǰüi, SM 2, 1961, 243-450; *idem*.Notes on the Barin Phonology, AOH 13, 1961, 295–303; Баярмэнд, Baγarin aman ayalγun-u sudulul, ÖMAKQ, 1997, 1-235

ÖMon.	āli	AM	aγāli	*'ааль'*
ÖMon.	temē	AM	temegēn	*'тэмээ'*
ÖMon.	sū- /sō-	AM	saγū-	*'суу-'*
ÖMon.	χüdžū	AM	küǰügūn	*'хүзүү'*

5. Цахар, Шилийн голоос бусад бүх аялгуунуудад үгийн эцэсийн хос эгшиг нь хосорхог шинжээ алдаж, уртаар хэлэгдэх болжээ.

ÖMon.	dalai / dalā	AM	dalai	*'далай'*
ÖMon.	tolğoi / tolğō	AM	toluγai	*'толгой'*
ÖMon.	duğui / duğī	AM	duγui	*'дугуй'*
ÖMon.	tūχī	AM	tügūkei	*'түүхий'*

6. Үгийн эцэсийн бус хос эгшигийн хувид гэвэл, Ордос, Цахар, Шилийн гол зэрэг төв аялгуунуудад их төлөв хэвээрээ үлдэж, бусад аялгуунуудад ижилшилийн уламаас үндэсэн эгшигтээ татагдан урт эгшиг болжээ.

ÖMon.	ail / āl	AM	ayīl	*'айл'*
ÖMon.	noir / nōr	AM	noyīr	*'нойр'*
ÖMon.	uila- / ūla-	AM	uyīla-	*'уйл-'*
ÖMon.	χüiten / χīten	AM	küyīten	*'хүйтэн'*

7. Өмнөд монгол хэлэнд үгийн эхний шүргэх ***h-*** гийгүүлэгчийн ул мөр уламжилан үлдсэнгүй.

8. Эртний монгол хэлний үеэс уламжилан үлдсэн хамжин шүргэх *ǰ, *č тогтвортой хадгалсаар иржээ.

ÖMon.	džam	AM	ǰam	*'зам'*
ÖMon.	tšitšig	AM	čečeg	*'цэцэг'*
ÖMon.	tšus / džus	AM	čisun	*'цус'*
ÖMon.	džütgel	AM	ǰidkül	*'зүдхэл'*

9. Биеийн төлөөний нэрийн ерөнхий систем хэвээр уламжилагдан ирсэн төдийгүй тэдгээрийн эртний зарим үндэсүүд ч бас хадгалагдан үлджээ.

	ганц тоо	олон тоо
I	bi min (Gen.)	biden man- | men
II	tši tšin-	ta |tadan tan- | tadan-

0.2.3 ОЙРД ХЭЛ

§ 22. **Ойрдуудын тухай товч.** Ойрдууд нь нүүдэлчин монгол угсаатаны нэгэн бүлэг бөгөөд тэдний дээд өвөг нь X зууны үеэс язгуурын монголчууд-тайгаа хамт Төв Азийн уудам талаар нутаглаж байжээ. Хожим тэд XII-XIII зууны үед Енисей мөрөний эх, Байгал нуурын баруун эрэг, Тагнын нуруу, Хөвсгөлийн ой тайгаар нутаглах болсон тул тэднийг *'ойн иргэд'* хэмээн нэрлэх болжээ. Тэр цагаас эхлэн ойрдууд Их Монгол улсын захиргаанд багтан орж, уламаар Их Монгол улсын баруун жигүүрийн түмэнд харъяалагдаж, *'дөрвөн минган'* болж, уламаар Зүүн гар (Чорос буюу Өөлд), Торгууд, Дөрвөд, Хошуудыг багтаасан *'дөрвөн ойрд'* үүсэн бүрэлджээ. Ойрдууд XIII зууны үеэс эхлэн ой тайгын нутагаа орхиж, өрнө зүг нүүдэллэсээр аажимдаа Алтайн уулсын тэнд шилжин суурьшсан байна. 1670 оноос 1727 он хүртэл Галдан бошогт, түүний залгамжилагч Цэвээнравдан нарын удирдлагын дор ойрдууд нэгдэн, Зүүнгарын хаант улсыг байгуулж, Алтайн нуруунаас Тэнгэр уул, Или-ийн хөндий хүртэл, Увс нуураас Балхаш нуур хүртэлхи өргөн уудам нутагийг эзэмшин хүчирхэгжиж байжээ. Зуу шахам жил оршин тогтсон Зүүнгарын хаант улс Манж Чин улсад эзэлэгдэн, ийш тийш тархан суурьшихад хүрчээ. Тухайлвал, хошууд голдуу ойрдууд Хөхнуурт шилжин суурьшсанаас гадна Торгууд, Дөрвөд голдуу ойрдууд Ижил мөрөн хүртэл нүүдэллэн очиж, суурьшсан нь эдүгээгийн халимагчууд[153] юм.

[153] Г. В. Вернадский, Историческая основа Русско-Калмыцких отношений, *'Kalmyk-Oirat Symposium'* {= *Kalmyk Monograph Series* Nr. 2}, Philadelphia, 1966, 11-48; Paula G. Rubel, The Kalmyk Mongols {= UAS. 64} 1967, 11-23

Эдүгээ ойрд угсаатан нь Монгол, БНХАУ, ОХУ-д тархан сууж байна. Тухайлвал, Монгол улсын Увс, Ховд аймагт Баяд, Дөрвөд, Торгууд, Захчин, Мингад, Урианхай, Өөлд, Хотон, БНХАУ-ын Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Ороны Бортал, Баян-уул, Ховогсайр, Или, Тарвагатай зэрэг газар Торгууд, Өөлд, Хошууд, Дөрвөд, Урианхайчууд, Хөхнуур мужийн Хайси, Хенан зэрэг хошууд, Ганьсу мужийн Сүбэй хошуунд Хошууд, Торгууд суурьшин сууцгааж байна. Түүнчилэн Өвөр Монголын Алшаа, Эзнэй гол, Хөлөнбуйрын Имин голд цөөн тооны ойрдууд нутаглаж байна. Мөн ОХУ-ын Халимагийн Бүгд Найрамдах улс болон Астрахань, Ростов, Волгоград, Оренбург, Ставрополийн хизгаарын зарим хэсэгт Дөрвөд, Торгуудууд оршин сууж байна. Мөн Киргиз улсын Иссык-куль нуурын орчимоор цөөн тооны халимагууд оршин суудаг байна. Ойрд хэлээр хэлэлцэгчид нь нийт 700 000 орчим бөгөөд тэдгээрээс Монгол улсад 185 000, ОХУ-д 180 000, Хитад улсад 220 000 орчим ойрдууд оршин сууж байна.

Ойрдууд XVII зууны дунд үеэс ойрдын бичигийн их хүн Зая бандида Намхайжамц (1599–1662)-ын зохиосон *'тод үсэг'*-ийг 300-гаад жил хэрэглэж байгаад XX зууны дундуур ОХУ дахь халимагууд (1938), Монгол улс дахь ойрдууд (1942) бараг нэгэн зэрэг кирил үсэг хэрэглэх болжээ.

Хилийн чанад дахь ойрд, халимагууд нь ойрд аялгуугаа хадгалсаар ирсэн боловч хүрээлэн байгаа орчиныхоо нөлөөгөөр Орос, Татаар, Уйгур, Төвд хэлний нөлөөг ихээхэн хүртсэн байна.

§ 23. **Ойрд хэл, аялгууны судалгааны тойм**. Ойрд хэлний судалгааны хамагийн анхны бүтээлүүд бүр XIX зууны дундуур гарчээ. Казаны их сургуулийн профессор А. Попов Астрахань, Саратов, Кавказын өвөр бэлээр оршин суудаг халимагуудын хэл аялгуу, аман зохиолыг газар дээр нь очиж судалаад *'Халимаг хэлний зүй'*[154] гэдэг бүтээлээ 1847 онд нийтлүүлжээ. Түүний дараахан нэрт монголч А. А. Бобровников халимаг хэлний авиа, үг, үгүүлбэрийн бүтэц, тогтолцоог монгол, тод үсэгийн баялаг жишээн дээр харьцуулан үзсэн томоохон бүтээл туурвисан байна.[155] Мөн герман эрдэмтэн Н. А. Zwick халимаг хэлний зүйн бүтээл нийтлүүлжээ.[156]

XX зууны эхээр академич Б. Я. Владимирцов баруун монголын баяд, дөрвөдүүдийн хэл аялгууг газар дээр нь очиж судалаад, хэд хэдэн тайлан бичсэн нь ойрд хэлний судалалд шинэлэг хувь нэмэр болжээ.[157] Мөн профессор В. Котвич

---

[154] А. Попов, Грамматика калмыцкого языка, Казань, 1851, 390 стр.

[155] А. А. Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, Казань, 1849, VIII + 3 + 400

[156] H. A. Zwick, Grammatik der Westmongolischen, das ist Oirat oder Kalmückischen Sprache, Königsfeld, 1853, 147 S.

[157] Б. Я. Владимирцов, Отчет к Кобдоским дэрбэтам летом 1908 г. *Изв. Русск. Геогр. общ-ва,* т. 46, Вып. 8-10, СПб., 323-355; Отчет Б. Владимирцова о командировке к дэрбэтам Кобдинского округа летом 1908 г. *Изв. Русск. Ком. для изуч. Средн. и Восточн. Азии,* СПб., 1909, 9, 47-60; Отчет Б. Владимирцов о командировке к баитам Кобдосского

халимагчуудын хэл аялгууг биечилэн судалсан дүнд *'Халимаг ярианы хэл зүй'*[158] хэмээх томоохон бүтээл нийтлүүлсэн нь ойрд хэлний судалгааг баяжуулсан байна.

XX зууны дунд үеэс өрнө дахины эрдэмтэд Халимаг, Ойрд аялгууны талаар нилээд олон бүтээл гаргасан бөгөөд тэдгээрийн дотороос G. Kara, Udo Posch, J. Street, J. Benzing, J. Krueger нарын бүтээлийг юуны өмнө дурдвал зохино.[159]

Жараад оноос орос, монголын эрдэмтэд эх хэл аялгуугаа нягтлан судалах талаар идэвхитэй ажиллаж, ойрд хэлний авиа зүй, үг зүйн онцлог шинжийг илүү нарийвчилан гаргасан судалгааны бүтээлүүд туурвижээ. Үүнтэй холбогдуулан халимаг хэлний авианы бүтэц, хувьсалын талаар профессор П. Ц. Биткеевийн цуварал үгүүлэл[160] болон А. Ш. Кичиков,[161] Д. А. Павлов,[162] П. Ц. Биткеев,[163] Ж. Цолоо,[164] Э. Вандуй,[165] Б. Бадмаев,[166] Н. Н. Убушаев,[167] Э. Ч. Бардаев[168] нарын хэл

округа, *Изв. Русск. Ком. для изуч. Средн. и Восточн. Азии,* Сер. 11, С-Петербург, 1912, 100-10

158 В. Котвич, Опыт грамматики калмыцкого разговорного языка, СПб., 1915, 175 стр.

159 G. Kara, Notes sur les dialects oïrat de la Mongolie Occidentale, AOH 8, 1959, 111-168; Udo Posch, Das kalmückische und verwandte Dialekte, HdO 5:2, 1964, 200-226; John Ch. Street, Kalmyk Schwa, *'American Studies in Altaic Linguistics'* {= UAS 13}, Bloomington, Indiana, 1963, 263-291; J. Benzing, Kalmückische Grammatik zum Nachschlagen, Wiesbaden, 1985, 195 S.

160 П. Ц. Биткеев, Неясные гласные калмыцкого языка, *Уч. зап. КНИИЯЛИ,* Вып. 3, Элиста,1964, 69-92; Квантативные изменения гласных в монгольских языках, *'Материалы по истории и филологии Центральной Азии',* Вып. 5, Улан-Удэ, 1970, 41-51; Твердорядный гласный *ї* в монгольском языке Тувы, *Уч. зап. КНИИЯЛИ,* Вып. II, Сер. Филол. Элиста, 1973, 110-117; Количественные и качественные изменения гласных непервых слогов в калмыцком языке, *'Проблемы этногенеза народов Сибири и Дальнего Востока',* Новосибирск, 1973, 171-173; Мягкие согласные в алтайских языках, *'Проблемы алтаистики и монголоведения',* Вып. 2, М., 1975, 340-353; Проблемы фонетики калмыцкого языка. (Квантативные и квалитативные изменения гласных), Элиста, 1975, 163 стр.; Сравнительно-типологическая характеристика гласных фонем монгольского и калмыцкого языков, *'Исследования по монгольской филологии',* М., 1978,97-106; Калмыцкий и ойратский вокализм. (на материале экспериментально-фонетических исследований и старо-письменных данных), *Автореферат диссертации* на соискание ученой степени доктора филологических наук, М., 1980, 32 стр.; Основные закономерности развития калмыцких гласных, *'Языки и фольклор народов Севера',* Новосибирск, 1981, 178-183

161 А. Ш. Кичиков, Дербетский говор: фонетико-морфологическое исследование, Элиста, 1963, 88 стр.

162 Д. А. Павлов, Состав и классификация фонем калмыцкого языка, Элиста, 1963, 3-107; Современный калмыцкий язык: Фонетика и графика, Элиста, 1968, 3-239; Фонетика современного калмыцкого языка, Элиста, 1983, 208 стр.

163 П. Ц. Биткеев, Согласные фонемы калмыцкого языка, Элиста, 1965, 3-67; Проблемы фонетики калмыцкого языка: квантативные и квалитативные изменения гласных, Элиста, 1975, 3-162; Языки и письменные системы монгольских народов, Москва / Элиста, 1995, 3-193; П. Ц. Биткеев, Р. П. Дораева, Д. А. Павлов, Г. Ц. Пюрбеев, Грамматика калмыцкого языка. Фонетика и Морфология, Элиста, 1983, 335 стр.

164 Ж. Цолоо, Захчины аман аялгуу, Уб., 1965, 3-214

зүйн бүтээлүүдийг дурдвал зохино. Мөн Халимаг, Ойрд аялгууны адил төстэй талыг авиа зүй, үг зүйн түвшинд харьцуулсан судалгааг профессор В. И. Рассадины удирдлагаар орос, монголын эрдэмтэд хамтаран хийсэн бий.[169]

Ойрд хэлний үгсийн сангийн судалал нь 300 гаруй жилийн түүхтэй билээ. Шведийн хэл судалаач P. J. Strahlenberg 1730 онд халимаг хэлний хамагийн анхны толь бичиг[170] нийтлүүлсэн бол түүнээс 100 жилийн дараа мөн шведийн санваартан Cornelius Rahmn Ижил мөрөний халимагуудын дундаас цуглуулсан материалаа эмхэдхэн 7000 орчим үгтэй толь бичиг эмхэдхэсэнийг нь саяхан хэл шинжилэлч эрдэмтэн Jan-Olof Svantesson нийтлүүлсэн нь[171] халимаг хэлний үгсийн сангийн судалалд үнэтэй чухал материал боллоо.

XX зууны эхээр А. М. Позднеев *'Халимаг-орос толь'*[172] эмхэдхэн гаргасан бол түүний дараа профессор G. Ramstedt-ийн *'Халимаг-герман толь'*[173] нийтлэгдсэн нь эдүгээ хүртэл ойрд хэлний үгсийн сангийн сонгодог бүтээл болсоор байна. 1960-70-аад оны үед А. Борманшинов, Загадинов нарын *'халимаг-англи толь'*,[174] John R. Krueger-ийн *'Ойрд-Монгол толь бичиг'*,[175] Б. Д. Муниевын *'халимаг-орос толь бичиг'*[176] нийтлэгджээ. Монгол улс дахь ойрд аялгуутаны үгсийн сангийн толийг профессор Ж. Цолоо наяад оны эхээр эмхэдхэсэн нь ойрд хэлний үгсийн сангийн хөмөрөгийг ихээхэн баяжуулжээ.

§ 24. **Ойрд хэлний үндэсэн шинж**. Ойрд хэлний олон аялгуунуудын тухай судалгаан дээр тулгуурлан тухайн хэлний онцлог шинжийг цуваа цагийн хувьсалын үр дүнтэй уялдуулан авч үзэе.

---

[165] Э. Вандуй, Дөрвөд аман аялгуу, Уб., 1965, 3-174

[166] Б. Бадмаев, Грамматика калмыцкого языка, Морфология, Элиста, 1966, 115 стр.

[167] Н. Н. Убушаев, Фонетика торгутского говора калмыцкого языка, Элиста, 1979, 196 стр.

[168] Э. Ч. Бардаев, Современный калмыцкий язык: лексикология, Элиста, 1985, 159

[169] В. И. Рассадин, С. М. Трофимова, Ц. Шагдарсүрэн, Л. Болд, Б. Даваасүрэн, Историческая связь калмыцкого языка с языком ойратов Монголии, Элиста-Уб., 2010, 3-180

[170] P. J. Strahlenberg, Vocabularium Calmucko-mungalicum. In das Nord und Östliche Theil von Europa und Asia, Stockholm, 1730 // The Kalmyk-Mongolian Vocabulary in Stralenberg's Geography of 1730, {=*Asiatica Suecana*. Early 18th Century Documents and Studies vol. 1}, Almqvist & Wiksell International Stockholm, 1975, 7-204

[171] Cornelius Rahmn's Kalmuck Dictionary, translated and edited by Jan-Olof Svatesson {= *Turcology* 93}, Harrassowitz Verlag, Wiesbaden, 2012, 1-199

[172] А. М. Позднеев, Калмыцко-русский словарь. В пособие к изучению русского языка в калмыцких начальных школах, СПб., Тип. Имп. АН, 1911, 306 стр.

[173] G. R. Ramstedt, Kalmückisches Wörterbuch {= *Lexica Societalis Fennogricae* V}, Helsinki, 1935, 560 S.

[174] A. Bormanshinov, G. Zagadinov, Kalmyk-English Dictionary {= Bell and Howel Co.}, Cleveland, 1963, 447 pp.

[175] John R.Krueger, Materials for an Oirat Mongolian to English Citation Dictionary, Part I: The Vowels, 1978, 1-204; Part II: The Consonants, Bloomington, 1984, 205-816

[176] Б. Д. Муниев, Калмыцко-русский словарь, М., 1977, 764 стр.

1. Эртний болон дундад үеийн монгол хэлний үед байсан долоон үндэсэн эгшиг фонем ойрд хэлэнд хэвээр хадгалагдаж байна. Зарим эрдэмтэд хэл шинжилэлд *'ива'* (shwa) хэмээн нэрлэгддэг хэт богино эгшигүүдийг хамтад нь нэгэн биеэ даасан фонем гэж үздэг ажээ.

2. Өмнөд монгол хэлэнд эгшиг авианы хүчдэлийн зохицол хэвээрээ хадгалагдаж байна. Тэргүүн үедээ уруулын ***о, ӧ*** эгшигтэй үгийн дэд үед орсон урт, богино эгшигийн аль аль нь өмнө талынхаа хүчтэй эгшигт татагдан дэвшиж ижилшсэн байна.

Oir.	olan	MM	olan	*'олон'*
Oir.	örgönə	MM	örgen	*'өргөн'*
Oir.	tō/ toā	MM	to'ā	*'тоо'*
Oir.	tȫ/ töē	MM	tö'ē	*'төө'*
Oir.	dolān / doloān	MM	dolo'ān	*'долоон'*
Oir.	noğān / noğoān	MM	noγo'ān	*'ногоон'*

3. Өвөг монгол хэлний үе байсан анхдагч урт эгшиг ойрд хэлэнд уламжилан үлдсэнгүй.

4. Утга ялгах өргөлтөт эгшигээс үүссэн урт эгшиг ихэнхи тохиолдолд хэвээр хэлэгдэж байна.

Oir.	atsān	MM	ačiyān	*'ачаа'*
Oir.	dzē	AM	ǰigē	*'зээ'*
Oir.	bȫrə	AM	bögēre	*'бөөр'*
Oir.	dūn	AM	daγūn	*'дуу'*
Oir.	dȗ	AM	degȗ	*'дүү'*

Гэвч орчин үеийн олонхи монгол хэл аялгуунуудад урт эгшигтэй хэлэгддэг үгсийн зарим нь ойрд хэлэнд богиноор хэлэгдэж байна.

Oir.	dewəl	AM	degēl	*'дээл'*
Oir.	nurgɒn	AM	niruγūn	*'нуруу'*
Oir.	χurğan	AM	quruγūn	*'хуруу'*

Дээр дурдсан үгс нь эртний монгол хэлний аялгуунуудад хоёр өөр хувилбартай байсан бөгөөд тэдгээр үгсийн зарим нь ойрд хэлэнд хэвээрээ уламжилан үлджээ. Бас бусад монгол хэл аялгуунд богино эгшигтэй хэлэгддэг зарим үг ойрд хэлэнд урт эгшигтэй хэлэгдэж байна. Тэдгээр нь бас л нэг үгийн хоёр өөр хувилбарын нэг юм.

Oir.	nȗl	AM	nigȗl / nigül	*'нүгэл'*
Oir.	ā̆m	AM	egēm / egem	*'эгэм'*

5. Үгийн эцэсийн хос эгшигийн бүтэцэн дэх үндэсэн эгшиг нь арынхаа уйтан эгшгийг өөртөө татан ижилшүүлж, хосорхог шинжээ бүрмөсөн алджээ.

Oir.	dalā̈	AM	dalai	*'далай'*
Oir.	delkā̈	AM	delekei	*'дэлхий'*
Oir.	χamtsū	AM	qančui	*'ханцуй'*
Oir.	χaraŋgū	AM	qaranγui	*'харангуй'*

6. Үгийн эцэсийн бус үеийн хос эгшигүүд дээрхийн нэгэн адил ижилшээд ихэнхидээ дан урт эгшиг (монофтонги) болсон байна.

Oir.	ā̈l	AM	ayīl	*'айл'*
Oir.	sā̈n	AM	sayīn	*'сайн'*
Oir.	kīs-	AM	keyīs-	*'хийс-'*
Oir.	īm	AM	eyīmü	*'ийм'*
Oir.	ō̈msün	AM	nō̈r	*'оймос'*
Oir.	nō̈r	AM	noyīr	*'нойр'*
Oir.	ṻl	AM	uyīla-	*'уйл-'*
Oir.	tṻl	AM	tuyīl	*'туйл'*

7. Ойрд хэлэнд үгийн эхний шүргэх гийгүүлэгч уламжилан үлдсэнгүй.

8. Тагнайшилын уламаас үүссэн хамжин шүргэх ***dž, tš*** ихэнхидээ хэвээр үлдсэн бөгөөд Захчин, Баяд, Урианхай аман аялгуунд хамжин шүргэх ***ts***, шүргэх ***z*** гарч иржээ.

Oir.	džolā	AM	ǰiluγā	*'жолоо'*
Oir.	tširā̈	AM	čirai	*'царай'*
Oir.	kezē	AM	keǰiyē	*'хэзээ'*
Oir.	atsā	AM	ačiyān	*'ачаа'*

9. Эртний монгол хэлний үед тагнайшилын уламаас буй болсон хамжин шүргэх ***dž, tš*** гийгүүлэгч нь дараах эгшигийнхээ хувиралтаас үл хамааран ихэнхидээ хэвээр уламжилан үлдсэн боловч хаяа зарим үгэнд хамжин шүргэх ***ts***, шүргэх ***z*** үүссэн байна.

Oir.	bitšig	AM	bičig	*'бичиг'*
Oir.	tšusɒn	AM	čisun	*'цус'*
Oir.	dšidɒ	AM	ǰida	*'жад'*
Oir.	dšorā	AM	ǰiruγā	*'жороо'*
Oir.	tsutχūr	AM	čidquγūr	*'цудхуур'*
Oir.	zürkən	AM	ǰirüken	*'зүрх'*

10. Ойрд хэлэнд биеийн төлөөний нэрийн зарим эртний үндэс хадгалагдан үлдсэн байна.

ганц тоо		олон тоо
I	bi min- (Gen.)	manɒr / manūs/ bidə man-/ bidən- (Gen.)
II	tšin- (Gen.)	tatan- (Gen.)

Мөн биед тусхайлан хамаадуулах морфемуудын дотор нэгдүгээр биеийг заасан ***-m***, хоёрдугаар биеийг заасан ***-tin*** гэсэн бүтэц байгаа нь угтаа тухайн төлөөний нэрийн түүхэн гаралтай шууд холбоотой юм.

0.2.4 БУРИАД ХЭЛ

§ 25. **Буриадуудын тухай товч.** Буриадууд нь Монгол улсын Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймагийн зарим сумд, ОХУ-ын Буриадын Бүгд Найрамдах улсын Эрхүү мужийн Усть-Ордын буриад үндэстэний тойрог, Чита мужийн Агын үндэстэний тойрог, БНХАУ-ын Манжуурын зүүн хойд талаар оршин сууж байна. Буриад хэл нь дотороо Ага, Алар, Барга-буриад, Баргузин, Бохан, Сартуул, Түнхин, Хори, Цонгоол, Эхирид-булагад зэрэг олон аман аялгуутай бөгөөд нийтдээ 400000 орчим хүн амтай. Үүнээс ОХУ-д 314000 орчим нь амьдаран суудаг ажээ.

Буриадуудын дээд өвөг болох Хори, Түмэд, Баргууд нь Дундад Сибирийн өмнөд хэсэгээр нэгэн аймагийн холбоонд багтан эртнээс нааш ан гөрөө, мал ахуйг хослон эрхэлж ирсэн язгуурын монголчуудын нэг салаа юм. XIII зууны эхэн үед Их Монгол улсын харьяанд орж, хэдэн зуун жил захирагдсаар иржээ. Харин XVII зууны сүүлчээр Хаант Оросын харьяанд орсон бөгөөд XX зууны эхэн үеэр тэдний зарим нь Монгол улсад нүүдэллэн ирсэн бөгөөд тэднийг Ерөө гол, Хэрлэн гол, Онон гол, Улз гол, Халх гол, Нөмөрөг голын хошуунуудад хуваан захируулжээ. 1930-аад оны сүүлээр засаг захиргааны шинэчилэлт хийхэд тухай тухайн газарынхаа аймаг, суманд харьяалагдах болжээ.

Буриадууд уулаасаа монгол бичигийг хэрэглэж байсан бөгөөд XX зууны эхээр (1907) буриадын цанид хамба Агваандоржиев (1853-1938) монгол бичигийг буриад аялгууны онцлогт ойртуулан нэмэж зассан шинэ цагаан толгойг боловсоруулсан нь зохиогчийнхоо номын нэрээр *'Вагиндрагийн үсэг'* хэмээн нэрлэгдэж ирсэн бөгөөд тэр нь тодорхой хүрээнд хэрэглэж эхэлсэн боловч төдий л өргөн дэлгэрсэнгүй. ОХУ дахь буриадууд 1938 оноос, Монгол улс дахь буриадууд 1942 оноос кирил үсэгийг хэрэглэж эхэлсэн байна.

Монгол улсын 2015 оны хүн амын тооллогын дүнгээс үзвэл 38 000 орчим буриадууд оршин сууж байгаа бөгөөд тэдгээрийн дотор Цонгоол, Ага, Түнхэн, Хори, Барга аялгуутанууд байна.

§ 26. **Буриад хэл аялгууны судалгаа.** XIX зууны дундуур финий эрдэмтэн М. А. Castren буриад хэлний хамагийн анхны хэл зүйг бичиж нийтлүүлжээ.[177] Түүнээс хойш хагас зуу шахам жил биеэ даасан дорвитой судалгаа гарахгүй байсаар XX зууны тэргүүн хагасаас тухайн аялгууны хэл зүйн бүтээлүүд гарч эхэлсэн байна. Тухайлвал, 1930-аад оны сүүлчээр Н. Поппе, Г. Санжеев нарын хэлзүйн ерөнхий тойм бүтээлүүд[178] гарсан бөгөөд 1950-60-аад онд Д. Амоголонов,[179] N.Poppe,[180] И. Д. Бураев,[181] Г. Д. Санжеев,[182] Т. А. Бертагаев,[183] У-Ж. Ш. Дондуков,[184] Л. Д. Шагдаров[185] нар буриад хэл аялгууны авиа зүй, үг зүй, үгсийн сангийн онцлог шинжүүдийг тусхасан ганц сэдэвт зохиолууд нийтлүүлсэн байна.

Буриад хэлний аман аялгуунуудын онцлог шинжийг нарийвчилан судалах нь зөвхөн буриад аялгуу төдийгүй, нийт монгол хэлний хөгжилийн түүхийг судалахад чухал ач холбогдолтой билээ. Буриад хэлний олон аман аялгуунуудын дотороос хамагийн анх Хори-буриад аман аялгууны тухай профессор А. Д. Рудневийн бүтээл,[186] дараа нь Алар аман аялгууны тухай профессор N. Poppe-гийн томоохон бүтээл[187] нийтлэгджээ. Түүнээс хойш бусад аман аялгуунуудын талаар Г. Д. Санжеев, И. Д. Бураев, А. Дарбеева, Д. А. Абашеев, Б. В. Матхеев, Ц. Б. Будаев, Э. Р. Раднаев, М. П. Хомонов, Ц. Б. Будаев нарын судалгааны үгүүлэлүүд гарсан байна.[188] Буриад аман аялгуунуудыг тийнхүү тус тусд нь судалсанаас гадна нийт

---

177 M. A. Castren,Versuch einer burjätischen Sprachlehre nebst kurzem Wörterverzeichnis, St. Peterburg, 1857, 244 S.

178 Н. Н. Поппе, Грамматика бурят-монгольского языка, М-Л., 3-268; Г. Д. Санжеев, Грамматика бурят-монгольского языка, М-Л., 1941, 5-188

179 Д. Амоголонов, Современный бурятский язык, Улан-Удэ, 1958, 337 стр.

180 N. Poppe, Buriat Grammar {= UAS 2}, Bloomington, Indiana, 1960, 129 pp.

181 И. Д. Бураев, Звуковой состав бурятского языка, Улан-Удэ, 1959, 3-195; *idem.* Становление звукового строя бурятского языка, Новосибирск, 1987, 185 стр.

182 Г. Д. Санжеев (ed.) Грамматика бурятского языка, Фонека и Морфология, М., 1962, 7-340

183 Т. А. Бертагаев, О морфологическом строе бурятского языка, М., 1961, 31 стр. Т. А. Бертагаев, Ц. Б. Цыдендамбаев, Грамматика бурят-монгольского языка. Синтаксис, М.,1962, 317 стр.

184 У-Ж. Ш. Дондуков, Аффиксальное словообразование частей речи в бурятском языке, Улан-Удэ, 1964, 3-246; Словообразование монгольских языках, Улан-Удэ, 1993, 4-196

185 Л. Д. Шагдаров, Становление единых норм бурятского литературного языка в советскую эпоху, Улан-Удэ, 1967, 108 стр.

186 А. Д. Руднев, Хори-бурятский говор. Опыт исследования, тексты, перевод и примечания, Вып. I, СПб., 1913-1914, 120 стр.

187 Н. Н. Поппе, Аларский говор, ч. I, Фонетика и Морфология, Лгр.,1930, 3-130

188 Г. Д. Санжеев, Фонетические особенности говора нижнеудинских бурят, Д. А. Абашаев, Тункинский говор, *'Исследование бурятских говоров* I', Улан-Удэ, 1965, 3-34; М. П. Хомонов, Боханский говор, *op. cit.*35-70; Э. Р. Раднаев, Баргузинский говор, *op. cit.* 71-107; Ц. Б. Будаев, Цонгольский говор, *op. cit.*151-186; И. Д. Бураев, Некоторые фонетические особенности говора аларо-унгинских бурят, *op. cit.*117-135; Сартульский говор,*'Исследование бурятских говоров* II',1968, 108-150; Б. В. Матхеев, Очерки эхирит-булагатского говора, *op. cit.* 3-45

буриад аялгуунуудыг ангилах талаар Ц. Б. Цыден-дамбаев, Д. А. Алексеев, И. Д. Бураев нар тусхайлан судалж, зохих ангилал хийжээ.[189] Түүнчилэн буриад аман аялгуунуудын онцлог шинжийг олон талаас нь авч үзсэн хамтын бүтээлүүд[190] гарсаны дээр буриад хэлний авианы бүтэц, тогтолцоо, хэл зүйн хэлбэрүүд, тэдгээрийн хувьсан хөгжилийг түүхэн үүднээс авч үзсэн томоохон бүтээлийг Ц. Б. Цыдендамбаев, Ц. Б. Будаев, В. И. Рассадин нар нийтлүүлжээ.[191]

Буриад хэлний үгсийн сангийн баялаг уламжилал бол зөвхөн буриад хэл төдийгүй, нийт монгол хэлний үгсийн сангийн үнэ цэнэтэй бүрэлдэхүүн хэсэг мөн билээ. Буриад хэлний үгсийн сангийн анхны толийг М. А. Castren гаргасан[192] бөгөөд хожим 1950-аад оны эхээр К. М. Черемисов 25 000 үгтэй буриад хэлний томоохон толийг[193] эмхэдхэн нийтлүүлсэн билээ. Тэрвээр уг толио нэмэн баяжуулсаар 1970-аад оны эхээр 44 000 үгтэй том толь[194] болгон дахин хэвлүүлсэн нь эдүгээ буриад хэлний үгсийн сангийн тулгуур бүтээл болсоор байна. Саяхан монголын эрдэмтэн Г. Гантогтох буриад хэлний язгуур үгсийн утгыг тайлбарласан томоохон толь бичиг[195] эмхэдхэн гаргасан нь монгол хэлний үгсийн сангийн судалалд шинэ хувь нэмэр болсон билээ. Дээр дурдсан толь бичигүүдээс гадна буриад хэлний үгсийн сангийн судалалын холбогдолтой судалгааны бүтээлүүд цөөнгүй гарчээ.[196]

---

189 Ц. Б. Цыдендамбаев, О диалектальных различиях в разговорном бурятском языке, Труды БКНИИ СО АН СССР, сер. вост. 1960,111-117; Д. А. Алексеев, Диалекты бурят-монгольского языка, *Уч. зап. Ленингр. ун-та*, 1949, № 98, вып. 1, 161-202; И. Д. Бураев, Проблемы классификаций бурятских диалектов, *'Проблемы бурятской диалектологии'*, Улан-Удэ, 1996, 3–16.

190 Исследование бурятских говоров, Вып.I. Улан-Удэ, 1965, 3-188; Вып. II. Улан-Удэ, 1968, 3-196; Исследование бурятских говоров, Улан-Удэ, 1977, 3-220; К изучению бурятского языка, Улан-Удэ, 1969, 4-154; Грамматическое своеобразие бурятского языка, Улан-Удэ, 1987, 3-192; Исследования по бурятской филологии, Улан-Удэ, 1978, 4-108; Лексико-грамматические исследования бурятского языка, Улан-Удэ, 1989, 3-180

191 Цыдендамбаев, Ц. Б. Грамматические категории бурятского языка в историко-сравнительном освещении, М., 1979, 3-147; Ц. Б. Будаев, Бурятские диалекты (опыт диахронического исследования), Новосибирск,1992, 3-217; Лексика бурятских диалектов в сравнительно-историческом освещении, Новосибирск, 1979, 3-302; В. И. Рассадин, Очерки по исторической фонетике бурятского языка, М., 1982, 198 стр.

192 M. A. Castren,Versuch einer burjätischen Sprachlehre nebst kurzem Wörterverzeichnis, St. Peterburg, 1857, 87-175

193 К. М. Черемисов, Бурят монгольско-русский словарь, М., 1951, 852 стр.

194 К. М. Черемисов, Бурят монгольско-русский словарь, М., 1973, 803 стр

195 Г. Гантогтох, Буриад аялгууны толь, Уб., 2010, 5-720

196 С. Б. Будаев, Лексика бурятских диалектов в сравнительно-историческом осве-щении, Новосибирск, 1979, 3-302; У-Ж. Ш. Дондукова, Развитие лексики монголь-ских языков в сравнительном освещении с тюркскими языками, Улан-Удэ, 2007, 3-246; Бурятские антронимы и топонимы, Улан-Удэ, 1981, 5-100; Лексико-фразео-логическое своеобразы бурятского языка, Улан-Удэ, 1985, 5-128

§ 27. Буриад хэлний үндэсэн шинж

1. Богино эгшигийн бүрэлдэхүүний хувид гэвэл, бусад олонхи хэл аялгуунуудын адил долоон үндэсэн богино эгшигтэй байна.

2. Монгол хэлний эгшиг авиа хүчдэлээрээ зохицох ёс буриад хэлэнд хэвээрээ хадгалагдан үлдсэн төдийгүй дэд үеийн богино, урт эгшигийн аль аль нь тэргүүн үеийнхээ уруулын эгшигт татагдан дэвшин ижилшсэн байна.

Bur.	oron	AM	oran	*'орон'*
Bur.	olon	AM	olan	*'олон'*
Bur.	tō	AM	toγā	*'тоо'*
Bur.	bō̆rö	AM	bögēre	*'бөөр'*

Мөн үгийн тэргүүн үеийн уруулын бус, урт эгшигүүд дараах үеийнхээ уруулын, урт эгшигт татагдан ухарч ижилшсэн байна. Харин тагнайшсан гийгүүлэгчийн арын богино ***и, й*** эгшиг заримдаа ухарч ижилшсэнгүй, хэвээр үлджээ.

Bur.	üdür	AM	edür	*'өдөр'*
Bur.	übül	AM	ebül	*'өвөл'*
Bur.	nüden	AM	nidün	*'нүд'*
Bur.	šuhan	AM	čisun	*'цус'*

3. Өвөг монгол хэлний үе байсан анхдагч урт эгшиг буриад хэлэнд уламжилан үлдсэнгүй

4. Утга ялгах өргөлтөөс үүссэн урт эгшиг нь зохих богино эгшигтэйгээ эсэрэгцэлдэн үг, морфемийн утга ялгах үүрэгээ хадгалсаар байна.

Bur.	ulān	AM	*χulaγān	*'улаан'*
Bur.	emēl	AM	emegēl	*'эмээл'*
Bur.	χatū	AM	qataγū	*'хатуу'*

Гэтэл орчин үеийн олонхи монгол хэл аялгуунуудад урт эгшигтэй хэлэгддэг зарим үгс буриад хэлний зонхилох аялгуунуудад богиноор хэлэгддэг бөгөөд тэдгээр үгс нь ойрд хэлний зохих үгстэй дуудлагынхаа талаар бараг тохирч байгаагаас үзвэл тухайн үгс нь угтаа эртний монгол хэлний үед байсан нэгэн хувилбар дуудлагын бодтой ул мөр мөн буй заа.

5. Дорнод буриадын аман аялгуунуудад үгийн эцэсийн хос эгшиг тохиолдох боловч ерөнхийд нь авч үзвэл, буриад хэлний хос эгшиг хосорхог шинжээ алдаж дан урт эгшиг (монофтонги) болох хандлагатай байна.

Bur.	dalai / dalā̆	AM	dalai	*'далай'*
Bur.	χaranχī	AM	qaranqui	*'харангуй'*

Bur.	χī	AM	kei	*'хий'*
Bur.	noχoi / noχ̄ā	AM	noqai	*'нохой'*

6. Үгийн эцэсийн бус үеийн хос эгшиг олонхи аман аялгуунд уламжилан үлдсэн боловч зарим аман аялгуунд хосорхог шинжээ алдаж эхэлсэн байна.

Bur.	hain / hān	AM	sayīn	*'сайн'*
Bur.	χoino / χ̄önö	AM	qoyīna	*'хойно'*
Bur.	uila- / ūila-	AM	uyīla-	*'уйл-'*
Bur.	üile / ūile	AM	üyīle	*'үйл'*

7. Буриад хэлэнд үгийн эхний шүргэх гийгүүлэгчийн аль нэг хувилбар уламжилан үлдсэнгүй.

8. Олонхи монгол хэл аялгууны хамжин шүргэх ***dž*** гийгүүлэгч буриад хэлэнд шүргэх ***ž, z*** бас зарим аялгуунд ***š, s*** болсоноос гадна ***i***-гийн өмнө орсон ***č*** нь шүргэх ***s, š***, Эхирид-булагад зэрэг зарим аман аялгуунд бүр сул шүргэх ***j*** болжээ.

Bur.	žada	AM	ǰida	*'жад'*
Bur.	ezen	AM	eǰen	*'эзэн'*
Bur.	šulūn	AM	čilaγūn	*'чулуу'*
Bur.	seseg	AM	čečeg	*'цэцэг'*
Bur.	jarğal	AM	ǰirγal	*'жаргал'*

9. Биеийн төлөөний нэрийн зарим үндэс тухайн хэлний авианы өвөрмөц хувьсалаас шалтгаалан нилээд өөр болсон боловч тэдгээрийн систем нь тогтвортой хадгалагдсаар байна.

	ганц тоо	олон тоо
I	bi min- (Gen.)	bide man-
II	ši šin- (Gen.)	ta / tānar tan- (Gen.)

0.2.5 МОГОЛ ХЭЛ

§ 28. **Моголчуудын тухай товч.** Моголчууд нь XIII зууны эхээр Хорезмын газар нутаг дээр үлдэж хоцорсон монголчуудын уг удам гэж түүхчид үздэг бөгөөд эдүгээ Афганистаны Херат, Кандахар, Гор, Маймана, Бадакшан мужуудад тархан суудаг байна. Могол хэл нь дундад үеийн монгол хэлний зарим онцлог шинжийг хадгалж үлдсэнээс гадна тажик, пушту, перс үндэстэнүүдтэй холилдон олон зуун жил айл зэрэгэлдээ амьдарсан учир тэдгээр хэлний нөлөө ихээхэн нэвтэрч, холимог шинжтэй хэл болжээ. Моголчуудын олонхи нь эх хэлээ мартсан төдийгүй, өөрсөдийнхөө гарал үүсэл, уг удамаа ч бараг мэдэхгүй болжээ.

§ 29. **Могол хэлний судалгааны тойм**. Могол хэлний талаар хамагийн анх ажиглан тэмдэглэсэн хүн бол XIX зууны эхээр энэдхэгт алба хааж байсан англий офицер R. Leech гэдэг хүн юм. Тэрвээр баруун өмнөд Азийн хэд хэдэн хэлийг харьцуулан судалахдаа могол хэлний зуу гаруй үгийн жагсаалтыг хавсаргасан нь[197] могол хэлний тухай хамагийн анхны тэмдэглэл юм. Хожим H. Gabalentz уул материалд тулгуурлан *'Хазарууд болон Аймагийн хэл'* гэсэн сонирхолтой үгүүлэл нийтлүүлсэн билээ.[198] Мөн XIX зууны эцэсээр энэдхэгт хил, гаалийн ажилтан байсан англий офицер W. R. H. Merk могол хэлний 180 гаруй үг тэмдэглэн үлдээсэнийг хожим профессор M. Weiers судалж тайлбарласан нь[199] могол хэлний үгийн сангийн судалалд үнэтэй чухал материал юм.

XX зууны эхээр профессор G. J. Ramstedt Орос-Афганы хил дээр тавхан өдөрийн хугацаанд могол хүнтэй уулзаж, тэмдэглэж авсан материал дээрээ тулгуурлан могол хэлний тухай үгүүлэл бичсэн нь могол хэлийг хэл шинжилэлийн үүднээс авч үзсэн анхны судалгаа болжээ.[200] Хожим 1930-аад оны үед академич L. Ligeti моголчуудын дунд эрдэм шинжилгээний томилолтоор ажиллаж, нийтдээ 4000 гаруй үгийн хүрээнд багтах жишээ сэлт цуглуулсанаа нягтлан боловсоруулж, моголчууд болон тэдний хэл аялгууны тухай хэд хэдэн цуварал үгүүлэл нийтлүүлжээ.[201] Мөн тэрвээр могол хэлний үгийг анх олж тэмдэглэсэн R. Leech-ийн толины тухай маш сонирхолтой үгүүлэл[202] нийтлүүлсэн билээ. Түүний дараа тавиад оны эхээр профессор Sh. Iwamura, H. Shurmann нар Афганистанд очиж, тэдний аж амьдарал, хэл аялгууны тухай баялаг материал цуглуулаад *'Афганистаны монголчуудын тухай тэмдэглэл'*, *'Афганистаны монголчууд'* зэрэг

---

197 R. Leech, Epitome of the Grammars of the Brahuiky, the Balochky, and the Panjabi languages, with Vocabularies of the Baraky, the Pashi, the Laghmani, the Cashgari, the Teerhai, and the Deer Dialects, JASB Vol. 7, Part 2, Calcutta, 1838, 785-787

198 H. C. Gabelentz, Über die Sprache der Hazaras und Aimaks, ZDMG 20,1866, 327-334

199 M. Weiers, Das Moghol-Vokabular von W. R. H. Merk, ZAS 5, 1971, 157–89

200 G. J. Ramstedt, *Mogholica.* Beiträge zur Kenntnis der Moghol Sprache in Afghanistan, JSFOu. 23:4 (1905), 1-60

201 Л. Лигети, О монгольских и тюркских и диалектах Афганистана, АОН. 4 1954, 93-114; Монгольские элементы в диалектах Хазара в Афганистана, *Кр. сообщ. Ин-та Народов Азии,* Вып. 83, 1964, 5-22; *idem.* Les voyelles longues en Moghol, AOH 17, 1964, 31-48

202 L. Ligeti, Le lexique moghol de R. Leech', AOH 4, 1955, 119–58

тойм судалгаа[203] нийтлүүлсэнээс гадна проф. Sh. Iwamura перс үсэгээр тэмдэглэсэн гар бичмэл олсоноо нарийвчилан судалж *'Зирни-ийн гар бичмэл'* гэсэн томоохон бүтээл гаргажээ.[204] Энэхүү гар бичмэл нь зөвхөн могол хэлээр барахгүй, дундад үеийн монгол хэлийг судалахад ч чухал ач холбогдолтой материал юм. Хожим 1969-1972 онд профессор W. Heissig-ийн удирдсан хээрийн судалгааны баг моголчуудын дунд судалгааны ажилаар очиж, хэл аялгууны болон гар бичмэл материал цуглуулж, тэдгээрийг судалгаанд зориулан нийтлүүлсэнээс[205] гадна профессор M. Weiers Херат мужийн могол хэлний тухай биеэ даасан тусхай судалгаа гаргажээ.[206] Мөн тэрвээр могол хэлний талаар цуглуулсан материал дээрээ тулгуурлан *'Могол хэлний урт эгшгийн тухай асуудалд'*, *'Афганистаны могол хэлний онцлог шинж'*, *'Афганистан дахь монгол хэл, хазар хэлний үгсийг үгсийн сангийн тооцоолон бодох аргын талаас авч үзэх нь'* гэх зэрэг хэд хэдэн үгүүлэл нийтлүүлжээ. Түүнчилэн энэдхэгт хил, гаалийн ажилтан байсан Английн офицер W. R. H. Merk-ийн тэмдэглэсэн монгол хэлний үгийн тухай, Херат мужаас перс үсэгээр тэмдэглэсэн 5 хэлний толийн хэсэг олдсон тухай тэмдэглэлүүд[207] нь сонирхолтой юм.

Могол хэлийг газар дээр нь судалсан дээрхи судалгаануудаас гадна нэгэнт нийтлэгдэн гарсан материалуудад түшиглэсэн тойм, тэмдэглэл, дам судалгааны бүтээл ч бас нилээд бий билээ.[208]

§ 30. **Могол хэлний үндэсэн шинж.** Могол хэлний талаар өмнө гарсан судалгаанууд дээр тулгуурлан тухайн хэлний онцлог шинжийг бусад монгол хэлнүүдийн үндэсэн шинжтэй уялдуулан авч үзэе.

---

203 Sh. Iwamura, H. F. Schurmann, Notes on Mongolian Groups in Afghanistan, *Silver Jubilee Volume of the Zinbun-Kagaku Kenkyu syo, Kyoto University,* Kyoto, 1954, 480-517; H. F. Schurmann, The Mongols of Afghanistan: An Ethnography of the Moghols and Related Peoples of Afghanistan, Leiden, 1962, 435 pp

204 Sh. Iwamura, The Zirni Manuscript. A Persian-Mongolian Glossary and Grammar, Kyoto, 1961, IX + 161 + 42 plates

205 Wolfram Hesche, Wolf-Dieter Hildebrand und Andreas Thermann, Das Moγoli in Badachschan (Afghanistan), CAJ. 23,1979, 177-236; W. Heissig, Schriftliche Quellen in Mogholi, 1. Teil: *Texte in Faksimile*, Opladen, 1974; M. Weiers, 1 (1975a) Schriftliche Quellen in Mogholi, 2. Teil: *Bearbeitung der Texte*, Opladen, 1975; *idem.* Schriftliche Quellen in Mogholi, 3. Teil: Poesie der Mogholen, Opladen, 1977; *idem.* Eine fünfsprachige Wörtersammlung aus dem Gebiet der Moghol von Herat in Afghanistan, ZAS 7, 1973, 503–23.

206 M. Weiers, Die Sprache der Moghol der Provinz Herat in Afghanistan. Sprachematerial, Grammatik, Wortliste, Opladen, 1972, 188 S.

207 M. Weiers, Das Moghol-Vokabular von W. R. H. Merk, ZAS 5, 1971, 157–89; Eine fünfsprachige Wörtersammlung aus dem Gebiet der Moghol von Herat in Afghanistan, ZAS 7, 1973, 503–523.

208 Л. Шагдаров, Л. М. Казанцева, О языке моголов Афганистана (поматериалом Ш. Ивамура и Х. Ф. Шурмана), *'О зарубежных монголоведных исследованиях по языку'*, Улан-Удэ, 1968, 67-92; G. Doerfer, Turkish and Mongolian Languages of Persia and Afghanistan, *'Current Trends in Linguistics'*, vol. 6, 1970, 217-234; O. Pritsak, Das Mogholische, HdO 5:2, 1964,159-184; Бөх, Moγol kelen-ü sudulul, ÖMYSKQ, 1996, 1-410

1. Дундад үеийн монгол хэлний үед байсан долоон богино эгшиг фонем хэвээрээ хадгалагдан үлджээ.[209] Гэвч зарим эрдэмтэд могол хэлэнд таван богино эгшиг фонем бий гэж үзсэн байна.[210]

2. Эгшиг авиа хүчдэлээрээ зохицох ёс могол хэлэнд хэвээрээ хадгалагдан үлджээ. Үгийн тэргүүн бус үеийн уруулын эгшигийн өмнөх уруулын бус богино эгшигүүд их төлөв ухаран ижилшсэн бол тэргүүн үеийн *o, ö*-гийн дараа орсон богино эгшиг дэвшин ижилшээгүй байна.

Mog.	modun	AM	modun	*'мод'*
Mog.	noχai	AM	noqai	*'нохой'*
Mog.	üdür	AM	edür	*'өдөр'*
Mog.	čusun	AM	čisun	*'цус'*

Дундад үеийн монгол хэлний үед суларан сугарсан шүргэх *-γ-/-g-* гийгүүлэгчийн хоёр талд байсан эгшигүүд өөр хоорондоо ижилшиж амжилгүй, тус тусынхаа хэлэгдэх байдалыг хэвээр хадгалан үлджээ.

Mog.	aulo	AM	a'ūla	*'уул'*
Mog.	döün	AM	de'ǖ	*'дүү'*
Mog.	toa	AM	to'ā	*'тоо'*
Mog.	böära	AM	bö'ēre	*'бөөр'*

3. Өвөг монгол хэлний үед байсан анхдагч урт эгшигийн ул мөр хадгалагдан үлдсэн цөөхөн хэлний нэг нь могол хэл юм.

Mog.	dālu	Mo.	ḍalu	‘дал’
Mog.	tābun	Mo.	tabun	‘тав’
Mog.	mōdun	Mo.	modun	‘мод’

4. Дундад үеийн монгол хэлний үед байсан үүсмэл урт эгшигүүд ихэнхидээ хэвээр хадгалагдаж байгаа бөгөөд харьцуулан ажиглавал дундад үеийн монгол хэлний үед суларан сугарсан *-γ- /-g-*гийн хоёр талын эгшиг адил байсан тохиолдолд л ийнхүү урт хэвээрээ үлдсэн ажээ.

Mog.	ulān	MM	hula'ān	‘улаан’
Mog.	dēra	MM	de'ēre	‘дээр’
Mog.	qurū	MM	quru'ū	‘хуруу’
Mog.	χüdžūn	MM	küjü'ün	‘хүзүү’

---

209 N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 25-52; O. Pritsak, Das Mogholische, 162

210 M. Weiers, Die Sprache der Moghol der Provinz Heart in Afghanistan. Sprachematerial, Grammatik, Wortliste, Opladen, 1972, 108

5. Бүр өвөг монгол хэлний үед байсан анхдагч урт эгшиг зарим цөөн үгэнд хадгалагдан үлджээ.

Mog.	dōlu	PM	*dālu	'дал'
Mog.	tābun	PM	*tābun	'таван'
Mog.	mōdun	PM	*mōdun	'мод'
Mog.	adāli	PM	*adāli	'адил'

6. Могол хэлэнд эртний монгол хэлний сүүлчээр үүссэн үгийн эцэсийн хос эгшиг ихэнхидээ хэвээр хадгалагдан үлджээ.

Mog.	noqai	AM	noqai	*'нохой'*
Mog.	malgei	AM	malaγai	*'малгай'*
Mog.	χaraŋγui	AM	qaraŋγui	*'харанхуй'*
Mog.	moγoi	AM	moγai	*'могой'*

7. Мөн дундад үеийн монгол хэлний сүүлчээр үүсэн бүрэлдсэн үгийн эцэсийн бус хос эгшиг ч бараг төлөв хадгалагдан үлдсэн байна.

Mog.	sōin	AM	sayīn	*'сайн'*
Mog.	χoin	AM	qoyīna	*'хойно'*
Mog.	uīla-	AM	uyīla-	*'уйл-'*
Mog.	noir	AM	noyīr	*'нойр'*

8. Дундад үеийн монгол хэлний үед байсан үгийн эхний сул шүргэх ***h***-гийгүүлэгч бүрмөсөн суларан сугарчээ.

Mog.	arbōn	AM	harban	*'арван'*
Mog.	ilka	AM	heligen	*'элэг'*
Mog.	ulān	AM	hula'ān	*'улаан'*
Mog.	unasun	AM	hünesün	*'үнэс'*

9. Эртний монгол хэлний үед тагнайшилын нөлөөгөөр үүссэн хамжин шүргэх ***dž, tš*** гийгүүлэгч хэвээр хадгалагдан үлдсэн бөгөөд арынх нь ***i*** эгшиг ч их төлөв ухаран ижилшсэнгүй.

Mog.	džil	AM	ǰil	*'жил'*
Mog.	džirō	AM	ǰiruγā	*'жороо'*
Mog.	tšisu	AM	čisun	*'цус'*
Mog.	tšido-	AM	čida-	*'чад-'*

10. Могол хэлэнд биеийн төлөөний нэрийн зарим нилээд эртний үндэс хадгалагдан үлджээ.

ганц тоо		олон тоо	
I	bi min (Gen.)	- man (Gen.)	bida, bidad bidan (Gen.)
II	tši tšin (Gen.)	to (ta) ton (tan)	tod (tadan)
III	-in (Gen.)	-an (Gen.)	

0.2.6 ДАГУУР ХЭЛ

§ 31. **Дагуурчуудын тухай товч.** Дагуурчууд нь БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах ороны Хөлөнбуйр аймаг, Хар мөрөн мужийн Чичигар хот, Нони гол, мөн Шинжааны Кулжа зэрэг газараар нутаглан сууцгааж байна. Нийт хүн ам нь 2010 оны тооллогоор 131992 байжээ. (Tabulation on the 2010 Population Census of the People's Republic of China).

Дагуурчуудын дээд өвөг нь Амур мөрөний дунд хэсэгээр оршин сууж байгаад XVII зууны үед хитадын нутаг руу нэвтэрэн орж, уламаар бие биеэсээ салж холдсоор эдүгээ дотороо дөрвөн аялгуутай болжээ. Үүнд:

(1) Дагуурчуудын 90 орчим хувь нь Өвөр Монголын Хөлөнбуйр аймагийн Дагуурын өөртөө засах ороны Нонни голын хөндийгөөр оршин суух бөгөөд тэднийг дотор нь *Морин дабааны дагуур, Бутха Дагуур, Чичигар Дагуур Мэргэн Дагуур* гэж хуваадаг ажээ.

(2) Хөлөнбуйр аймагийн Эвэнкийн өөртөө засах оронд оршин суух дагуурчуудыг *Хайларын дагуур* гэдэг бөгөөд тэд нийт дагуурчуудын 5 орчим хувийг эзэлдэг байна.

(3) Амур мөрөний дунд орчимоор олон үе дамжин оршин суусаар ирсэн цөөн тооны дагуурчуудыг *Амурын дагуур* гэдэг бөгөөд тэд нар Хэйхэ мужийн хитадуудтай холилдон амьдардаг байна.

(4) XVIII зууны үед эх нутагаасаа гарч Шинжаан-Уйгурын өөртөө засах оронд шилжин суусан дагуурчуудыг *Шинжааны дагуур* (Кульжа-гийн дагуур ч гэдэг) гэж нэрлэдэг.

§ 32. **Дагуур хэлний судалгааны тойм.** Дагуур хэлийг хамагийн анх оросын эрдэмтэн А. О. Ивановский судалж, *'Солон, Дагуур хэлний жишээ'* гэсэн судалгаандаа дагуурчуудын түүхэн гарал, оршин суух орон нутаг, хэлний онцлогийн талаар нилээд тодорхой дурдаад эцэст нь солон, дагуур хэлний 2000 орчим үгсийн жагсаалт хавсаргажээ.[211]

[211] А. О. Ивановский, *Manjurica.* Образцы солонского и дахурского языков, СПб., 1894, 36-56

XX зууны эхээр (1906-1908) оросын хэл судалаач Ф. В. Муромский Шинжааны дагуур аялгууг судалж, 2000 орчим үгийг багтаасан уридчилсан тайлан нийтлүүлсэн[212] бөгөөд хожим түүнийг польш эрдэмтэн S. Godzinski, S. Kaluzynski нар орчин үеийн хэл шинжилэлийн аргаар эмхэлэн боловсоруулж, нийтлүүлсэн байна.[213]

1920-иод оны сүүлчээр профессор N. Poppe Улаанбаатар хотод оршин сууж байсан цөөн тооны дагуурчуудын хэл аялгууг тэмдэглэн авч, уламаар дагуур хэлний авиа зүй, үг зүйн гол онцлогийг 1200 орчим үгийн хамт багтаасан тусхай бүтээл хэвлүүлсэн нь дагуур хэлний судалал, ялангуяа, хайлаар аман аялгууны судалалд чухал хувь нэмэр болсон билээ[214]. Мөн тэрвээр хожим манж-дагуур хэлний зүйл хуваасан нэгэн товч толь бичигийг үндэслэн түүний хэл зүйн онцлогийн тухай үгүүлэл гаргасанаас гадна дагуур хэлний онцлогийн тухай товч тойм нийтлүүлжээ.[215]

1950-иад оны дундуур хитад, зөвлөлтийн эрдэмтэд дагуур хэлний талаар нилээд материал хамтаран цуглуулсан бөгөөд уул ажилд биечилэн оролцсон Б. Х. Тодаева тухайн хэлний талаар товч тойм нийтлүүлж, хожим бутха аялгууны авиа зүй, үг зүйн онцлогийг нилээд тодорхой тусхасан нэг сэдэвт зохиол гаргажээ.[216] Мөн америкийн эрдэмтэн W. M. Austin, S. Martine нар дагуур гаралтай профессор Онон Өргөнгөөгийн хэл аялгууг судалан дагуур хэлний тухай товч үгүүлэл, хэлний зүй зэрэгийг тус тус бичиж нийтлүүлсэн байна.[217] Хожим профессор M. Weiers Тайваньд сууж байсан бутха гаралтай дагуур хүнээс тэмдэглэж авсан материал дээрээ тулгуурлан сонирхолтой үгүүлэл нийтлүүлсэн бий.[218]

Наяад оны эхнээс эхлэн Өвөр монголын эрдэмтэд дагуур хэлний авиа зүй, үг зүй, үгсийн сангийн талаар нилээд олон бүтээл нийтлэгджээ. Тухайлвал, Намсрай, Хас-Эрдэнэ нар *'Дагуур хэл ба монгол хэлний харьцуулал'*[219] гэдэг томоохон бүтээлдээ тухайн хэлний авиа зүй, үг зүй, үгүүлбэр зүйн онцлог шинжүүдийг тодорхой жишээний хамт дэлгэрэнгүй үгүүлсэнээс гадна 4500 гаруй үгсийн жагсаалт, аман зохиолын материалыг хавсаралт болгон оруулсанаараа дагуур

---

212 Ф. В. Муромский, Предварительный отчет о поездке в Кульджинский район, командированного Русским Комитетом, студента Факультета Восточных Языков Ф. В. Муромского в 1906 г. *Изв. Русск. Ком.для изуч. Средн. и Вост. Азий,* 7, 1907, 55-59; Отчет о поездке в Кульджинский район Ф. В. Муромского в 1907-1908 гг., 1908, 5 стр.

213 S. Kaluzynski, Dagurisches Wörterverzeichnis, RO 33:1-2 (1969), 107-144, 33:2 (1970), 109-143; S. Godzinski, Deux contes dagours de région de Kouldja. D'apès les matèriaux dy F. V. Muromskij, *'Mongolian Studies'*, 1970, 149-165

214 Н. Поппе, Дагурское наречие {ММК 6}, 1930, 158стр.

215 N. Poppe, Über die Sprache der Daguren, AM. 10 (1935), 1-32

216 Б. Х. Тодаева, Монгольские языки и диалекты Китая, М., 1960,53-71.

217 W. M. Austin, A Brief Outline Dagur Grammar {= *Studies in Linguistics* X}, New Haven, 1952, 65-75; S. Martin, Dagur Mongolian Grammar, Texte and Lexicon based on the Speech of Peter Onon {= UAS 4}, Bloomington, Indiana, 1961, 336 pp.

218 M. Weiers, Bemerkungen zur Phonetik der dagurischen Mundart von Butha, ZDMG 128 (1978), 125-160

219 Намсарай, Хас-Эрдэнэ, Dayur kele mongγol kelen-ü qaričaγulul, ÖMAKQ, 1983, 1-651

хэлний судалалд үнэтэй хувь нэмэр болсон билээ. Түүний дараахан М. Эрдэнэбат *'Дагуур хэл ба монгол хэл'*, *'Дагуур хэлний үгс'*, *'Дагуур хэлний үг хэллэгийн материал'* гэсэн 3 цуваралыг[220] эрхэлэн гаргасан нь Дагуур хэлний судалалыг бодит материалаар баяжуулж, Дагуур хэлний судалалын түвшинг урагш ахиулжээ.

Дагуур хэлний үгсийн сангийн судалал нь бүр XIX зууны сүүлч үеэс эхэлжээ. Тухайлвал, анх А. О. Ивановский солон, дагуур хэлний тухай судал-гаандаа тухайн хэлний 2000 орчим үгийн толийг хавсаргасан нь[221] дагуур хэлний үгсийн сангийн судалалын эхлэл нь болсон байна. Түүнээс хойш Н. Поппе Хайлаарын дагуурын тухай судалгаандаа 1500 орчим үгийн жагсаалт[222] хавсаргасан бол S. Martin, Б. Х. Тодаева нар өөрсдийн судалгаандаа тус бүр 2000 орчим үгийн жагсаалт[223] хавсаргасан байна. Саяхан оросын судалаач, Хайлаарын дагуур гаралтай Г. Тумурдэйн бичиж тэмдэглэсэн 5900 үгсийг ОХУ-ын ШУА-ын Сибирийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан Б. Д. Цыбенов орос хэлээр орчуулан хэвлүүлсэн нь[224] эдүгээ дагуур хэлний хамагийн олон үгтэй үгсийн сангийн бүтээл болж байна. Дээр дурдсанаас гадна N. Poppe, T. Tsumagari, J. Janhunen, Sh. Shiotani, H. Kuribayashi, Б. Х. Тодаева зэрэг эрдэмтэд дагуур хэлний талаар тоймлон танилцуулсан үгүүлэлүүд нийтлүүлжээ.[225]

§ 33. Дагуур хэлний үндэсэн шинж

1. Эртний болон дундад үеийн монгол хэлэнд байсан 7 үндэсэн богино эгшиг фонемийн дотороос уруулын ***ö, ü*** эгшигүүд бие даасан фонемийн үүрэгээ алдаад ***o, u*** эгшигийн хувилбар шинжтэй болжээ.

---

220 М. Эрдэнэбат, Dayur kele ba mongyol kele {= *Mongyol törül kele ayalyun-u sudulul-un čuburil* 004} 1984, Dayur kelen-ü üges {= *Mongyol törül kele ayalyun-u sudulul-un čuburil* 005},1984, 1-337; Dayur kelen-ü üge kelelge-yin materiyal {= *Mongyol törül kele ayalyun-u sudulul-un čuburil* 006} 1985, 1-414

221 А. О. Ивановский, *Manjurica.* Образцы солонского и дахурского языков, СПб., 1894, 15-56

222 Н. Поппе, Дагурское наречие {= ММК 6}, 1930, 67-102

223 S. Martin, Dagur Mongolian Grammar, Texte and Lexicon based on the Speech of Peter Onon {= UAS 4}, Bloomington, Indiana, 1961, 109-237

224 Г. Тумурдэй, Б. Д. Цыбенов, Краткий дагурско-русский словарь, БНЦ СО РАН, Улан-Удэ, 2014, 3-235

225 N. Poppe, Die dagurische Sprache, HdO, V, 1961, 137-142; T. Tsumagari, Toshiro, Daguurugo Hairaruhougen kisogoi, *Mongoru Kenkyuu* 17, 1986, 2–38; J. Janhunen, A Revival of Dagur Studies, FUF 48, 1988, 308–16; H. Kuribayashi, Daguurugo, *Gengogaku Daijiten* 2, 1989, 597–603; Sh. Shiotani, Daguurugo Hairaru Hougen no Kougo Shiryou: Tekisuto to Chuushaku, *Nihon Mongoru Gakkai Kiyou* 21, 1990, 47–95; Б. Х. Тодаева, Дагурский язык, *Монгольские языки – Тунгусо-маньчжурские языки – Японский язык – Корейский язык*{= Языки Мира}, М., 1997, 51–60

2. Нэг үгэнд дараалан орсон эгшигүүд хэлэгдэх хүчдэлээрээ зохицох ёс хадгалагдаж байна.

Үгийн тэргүүн бус үед байсан богино, урт эгшигийн аль аль нь тэргүүн үеийнхээ уруулын эгшигт татагдан дэвшин ижилшсэн жишээ нилээд тохиолдож байна.

Dag.	χolo	AM	qola	*'хол'*
Dag.	džowloŋ	AM	ǰobalan	*'зовлон'*
Dag.	tō	AM	toγā	*'тоо'*
Dag.	bōr	AM	bögēre	*'бөөр'*

Үгийн тэргүүн бус үед орсон уруулын богино эгшигийн өмнөх үеийн уруулын бус богино эгшиг ихэнхидээ ухарч ижилшсэн байна.

Dag.	udur	AM	edür	*'өдөр'*
Dag.	ugul	AM	ebül	*'өвөл'*
Dag.	džus	AM	ǰisün	*'зүс'*
Dag.	nugul	AM	nigül	*'нүгэл'*

Үгийн тэргүүн үеийн ***i*** эгшиг тун цөөн тохиолдолд ухаран ижилшиж, ихэнхидээ хэвээр хадгалагдан үлджээ.

Dag.	tšos	AM	čisun	*'цус'*
Dag.	džağas	AM	ǰiγasun	*'загас'*
Dag.	tšinar	AM	činar	*'чанар'*
Dag.	nide	AM	nidün	*'нүд'*

Үгийн тэргүүн бус үед орсон уруулын урт ***u, ü*** эгшигийн өмнөх ***a, e*** эгшигүүд ухаран ижилшсэнгүй, тус тусынхаа хэлэгдэх байдалыг тогтвортой хадгалан хосорхог шинжтэй болсон байна.

Dag.	aula	AM	aγūla	*'уул'*
Dag.	dau	AM	daγūn	*'дуу'*
Dag.	deu	AM	degū	*'дүү'*
Dag.	eulen	AM	egūlen	*'үүл'*

3. Өвөг монгол хэлний үед байсан анхдагч урт эгшигийн ул мөр зарим цөөн үгэнд хадгалагдан үлджээ.

Dag.	mōd	PM	*mōdun	*'мод'*
Dag.	tābun	PM	*tābun	*'таван'*
Dag.	bulār	PM	*bulāγ	*'булаг'*

4. Эртний монгол хэлний үед үүсэн бүрэлдсэн урт эгшигийн өмнөх үеийнх нь богино эгшиг дараах үеийнхээ урт эгшигтэйгээ адил байсан буюу эсвэл уйтан *i*байсан бол тухайн урт эгшиг дагуур хэлэнд хэвээрээ үлдсэн байна.

Dag.	bātur	AM	baγatur	*'баатар'*
Dag.	dēr	AM	degēre	*'дээр'*
Dag.	χorō	AM	quruγūn	*'хуруу'*
Dag.	ulān	AM	ulaγān	*'улаан'*

5. Үгийн эцэсийн хос эгшиг нь өмнөх эгшигээсээ үл хамааран зарим тохиолдолд богино, заримдаа урт, бас хааяа хосорхог байдалтай хэлэгдэж байна.

Dag.	ğağa	AM	γaqai	*'гахай'*
Dag.	nogo	AM	noqai	*'нохой'*
Dag.	χaraŋgui	AM	qaraŋγui	*'харанхуй'*
Dag.	mogoi	AM	moγai	*'могой'*

6. Үгийн эцэсийн бус үеийн хос эгшиг ихэнхидээ хосорхог шинжээ хадгалж байна.

Dag.	sain	AM	sayin	*'сайн'*
Dag.	χoina	AM	qoyina	*'хойно'*
Dag.	noir	AM	noyir	*'нойр'*
Dag.	uile	AM	üyile	*'үйл'*

7. Эртний монгол хэлний үед үгийн эхэнд байсан шүргэх ***χ*** гийгүүлэгч нилээд үгийн эхэнд хадгалагдан үлджээ.

Dag.	χarban	AM	*χarban	*'арван'*
Dag.	χeleg	AM	*χeligen	*'элэг'*
Dag.	χulan	AM	*χulaγān	*'улаан'*
Dag.	χunur	AM	*χünir	*'үнэр'*

8. Эртний монгол хэлний үед тагнайшилын уламаас үүссэн хамжин шүргэх ***dž, tš*** гийгүүлэгч тогтвортой хадгалагдаж байна.

Dag.	džalū	AM	ǰalaγū	*'залуу'*
Dag.	džirgō	AM	ǰirγuγān	*'зургаан'*

Dag.	tšinar	AM	činar	*'чанар'*
Dag.	tšolō	AM	čilaγūn	*'чулуу'*

8. Дагуур хэлэнд биеийн төлөөний нэрийн зарим маш эртний үндэс хадгалагдан үлдсэн нь монгол хэлний биеийн төлөөний нэрийн судалалд чухал хувь нэмэр болж байна

	ганц тоо	олон тоо
I	bi min- (Gen.)	bā / bed man- (Gen.)
II	sin- (Gen.)	tan- (Gen.)
III	īn- (Gen.)	

0.2.7 МОНГОР ХЭЛ

§ 34. **Монгорчуудын тухай товч**. Эдүгээгийн монгорчуудын дээд өвөг нь XIII зууны тэргүүн хагаст Хөхнуур хүртэл цөмөрөн орсон монголчуудын удам угсаа гэж үздэг байна. Монгорчууд их төлөв газар тариалангийн ажил эрхэлэх бөгөөд бүддийн шүтлэгтэй. Монгорчууд БНХАУ-ын Хөхнуур мужийн Хуцу, Датун, Минхэгийн өөртөө засах тойрог болон Ганьсу мужийн Төвдийн өөртөө засах тойрогт оршин сууж байна. Монгор хэл нь доторoo *Минхэ, Хүцү* гэсэн хоёр үндэсэн аялгуутай, Минхэ аялгуу нь хитад хэлний нөлөө ихтэй, Хүцү аялгуу нь төвд хэлний нөлөө ихтэй ажээ. Монгорчууд нь 2010 оны хүн амын тооллогоор 289565 байжээ.

Монгорчуудын түүх, шашин, соёл, угсаатан судалалын талаар католик шашины санваартан Louis M. J. Schram, C. I. C. M, Dominik Schröder, нарын тусхай бүтээлүүд бий.[226]

§ 35. **Монгор хэлний судалгааны тойм**. Монгор хэлний талаар хамагийн анх тэмдэглэсэн хүн бол оросын газар зүйч эрдэмтэн Г. Н. Потанин юм. Тэрвээр 1893 онд хэвлүүлсэн *'Тангад-Төвдийн хизгаар ба Төв монгол'* гэдэг томоохон номдоо монгорчуудын тухай анх мэдээлж, тэдний хэл аялгууны 650 орчим үгсийн жагсаалт гаргажээ.[227] Хожим XX зууны эхээр Бельгийн эрдэмтэн A. de Smedt, A. Mostaert нар монгор хэлний авиа зүй, үг зүй, үгсийн санг хамарсан гурван дэвтэр томоохон цуварал судалгаа гаргасан нь өнөөг хүртэлхи монгор хэлний хамагийн гол тулгуур

---

226 Louis M. J. Schram, C. I. C. M. The Monguors of the Kansu-Tibetan Frontier: Their Origin, History, and Social Organization, vols 1–3 {=*Transactions of the American Philosophical Society*}, Philadelphia, New Series 44, 1954 ,1, 47, 1959 /1, 51, 1961/; Dominik Schröder, Zur Religion der Tujen des Sininggebietes (Kukunor)', *Anthropos* 47, 1952, 1–79, 620–58, 822–70; 48, 1953, 202–59; Aus der Volksdichtung der Monguor, 1. Teil: Das weisse Glücksschaf (Mythen, Märchen, Lieder), 2. Teil: *In den Tagen der Urzeit* (*Ein Mythus vom Licht und vom Leben*) {= AF 6} 1970, 158 S.

227 Г. Н. Потанин, Тангутско-тибетская окраина Китая и Центральная Монголия. Путешествие Г. Н. Потанина 1884-1886, т. 1-2, СПб., 1893, 410-425

бүтээл болсоор байна.[228] Тэрхүү судалгааны материал нь тухайн хэлийг цаашид нарийвчилан судалах таатай боломжийг бүрдүүлсэн учир түүний судалгаан дээр тулгуурлан M. Nomura, D. Schröder, A. Rona-Tas нарын судалгааны үгүүлэлүүд гарчээ.[229]

1950-иад оны дундуур хитад, зөвлөлтийн эрдэмтэдийн хамтарсан хээрийн судалгааны анги Монгор хэлний талаар ихээхэн материал цуглуулсан бөгөөд хожим Б. Х. Тодаева уул материалдаа тулгуурлан Монгор хэлний авиа зүй, үгзүйн онцлогийг багтаасан нэг сэдэвт зохиол нийтлүүлжээ.[230] Хожим наяад оны эхээр Өвөр Монголын эрдэмтэд Монгор хэлийг дахин нарийвчилан судалж *'Монгор хэлний үгс'* (1986), *'Монгор хэлний үг хэллэгийн материал'* (1988), *'Монгор хэл ба монгол хэл'* (1989) гэсэн гурван цуварал бүтээл[231] гаргасан нь Монгор хэлний судалалыг бодьтой шинэ баримт материалаар баяжуулаа. Монгор хэлний талаар гарсан дээрхи судалгааны материалууд дээр тулгуурлан Зуунаст, M. Kakudo, Чулуу, Hans Nugteren, Keith W. Slater, S. Georg нарын бүтээлүүд гарч, Монгор хэлний судалгааг улам баяжуулсан байна.[232]

---

[228] A. de Smedt etA. Mostaert, Le dialecte monguor parlé par les Mongols du Kansou Occidental, I[e] partie: Phonétique, *Anthropos* 24 (1929), 145-165, 801-815, 25 (1930), 657-669, 961-973; II[e] partie: Grammaire, Peking, 1945, 205 pp.; III[e] partie: Dictionnaire monguor-francais, Peip'ing, 1933, XIII + 521; The Mongols of Kansu and Their Language, *'Bull. of the Catholic University of Peking'*, Nr. 8, Peking, 1931, 75-89;

[229] M. Nomura, Long Vowels in Monguor and the Possible Existance of Long Vowels in Proto Mongolian, *'Collection of Articles in Commemoration of the 10th Anniversaries of the Faculty of Letters'*, Nagoya University, 1959; On Long Vowels in Monguor Dialect and Reconstruction of Long Vowel Phonemes in Proto Mongolian, *'Memoirs of the Research Department of the Toyo-Bunko'*, 18, 77-89; (япон хэлээр)/ D. Schröder, Der Dialekt der Monguor, HdO 5:2, 1964, 143-184; A. Rona-Tas, Remarks on the Phonology of the Monguor Language, AOH 10, 1960, 263-267; On Some Finals of the Monguor Language, AOH 14:3, 1962, 283-290

[230] Б. Х. Тодаева, Монгорский язык. Исследование, тексты, словарь, М., 1973, 389 стр.

[231] Činggeltei, Li Keyu, Mongγor kele ba Mongγol kele {= *Mongγol törül kele ayalγun-u sudulul-un čuburil* 013} ÖMAKQ, 1988; Qasbaγatur, Mongγor kelen-ü üges {= *Mongγol törül kele ayalγun-u sudulul-un čuburil* 014} ÖMAKQ, 1985; Mongγor kelen-ü üge kelelge-yin mareriyal {= *Mongγol törül kele ayalγun-u sudulul-un čuburil* 015} ÖMAKQ, 1986

[232] Зуунаст, Čaγan Mongγol (Mongγor) kelen-ü Minghe ayalγu-yi toyimučilan ügülekü ni, MKUJ 2, 1983, 4-23; M. Kakudo, Subdialects of Monguor Language, *Oosaka Gaikokugo Daigaku Gakuhou* 75, 1987, 49–63; *idem.* Remarks on the Tianzhu Dialect of the Monguor Language, *Osaka Gaikokugo Daigaku Ronshuu* 17, 1997, 33–61; Ü. Chuluu, *Introduction, Grammar, and Sample Sentences for Monguor* {= *Sino-Platonic Papers* 57}, Philadelphia: University of Pensylvania, Department of Asian and Middle Eastern Studies, 1994; Hans Nugteren, Hans, On some Turkic Loanwords in Monguor, Bao'an and Dongxiang', Lars Johanson (ed.) The Mainz Meeting: *Proceedings of the Seventh International Conference on Turkish Linguistics*, Wiesbaden: Otto Harrassowitz, 1998, 683–96; W. Keith Slater, A Grammar of Mangguer: A Mongolic Language of China's Qinghai-Gansu Sprachbund {= *Curzon Asian Linguistic Series* 2}, London, 2003, XVIII + 382; *idem.* Mangguer, *'The Mongolic Languages'*, edited by J. Janhunen, 2003, 307-324; St. Georg, Mongghul, *'The Mongolic Languages'*, edited by J. Janhunen, 2003, 286-30

§ 36. **Монгор хэлний үндэсэн шинж**. Монгор хэлний талаархи эрдэмтэдийн судалгааг үндэслэн тухайн хэлний онцлог шинжийг цуваа цагийн үүднээс авч үзвэл:

1. Дундад үеийн монгол хэлний үед байсан долоон үндэсэн богино эгшиг фонемийн дотороос ***ө, ү*** нь хэлний урдуурхи шинжээ алдаж, уламаар ***о, и***-тайгаа адил хэлэгдэх болсоноос нийт эгшиг фонемийн бүрэлдэхүүнд нь өөрчилөлт гарч, бүгд таван эгшигтэй болжээ.

2. Нэгэн үгийн дотор дараалан орсон үеийн эгшигүүд нь хэлэгдэх хүчдэлээрээ зохицож байсан төдийгүй, зарим тохиолдолд хэлэгдэх байдалаараа өөр хоорондоо ижилшсэн байна.

а. Үгийн тэргүүн бус үед орсон хүчтэй эгшигийн нөлөөгөөр өмнө талынх нь урт, богино эгшигүүд ухаран ижилшсэн жишээ ч цөөнгүй тохиолдож байна.

Mngr.	maχa	AM	miqan	*'мах'*
Mngr.	udur	AM	edür	*'өдөр'*
Mngr.	dū	AM	daγūn	*'дуу'*
Mngr.	ūr	AM	aγūr	*'уур'*

б. Үгийн тэргүүн бус үеийн богино, урт эгшигийн аль аль нь тэргүүн үеийнхээ уруулын эгшигт татагдан дэвшин ижилшсэн цөөвтөр жишээ тохиолдож байна. Гэвч үгийн эхний эгшиг балархайшсан хийгээд зарим эгшиг өвөрмөц маягаар хувиссан зэрэгээс шалтгаалан эгшиг авиа дэвшин ижилшиж чадаагүй жишээ ч бас нилээд тохиолдож байна.

Mngr.	uluon	AM	olan	*'олон'*
Mngr.	χolo	AM	qola	*'хол'*
Mngr.	tō	AM	toγā	*'тоо'*
Mngr.	bōro	AM	bögēre	*'бөөр'*

3. Өвөг монгол хэлний үед байсан анхдагч урт эгшиг цөөн зарим үгэнд хадгалагдан үлдсэн байна.

Mngr.	mōdi	PM	*mōdun	*'мод'*
Mngr.	dāli	PM	*dālu	*'дал'*
Mngr.	tāwen	PM	*tābun	*'таван'*
Mngr.	durān	PM	*durān	*'дур'*

4. Дундад үеийн монгол хэлний үед байсан үүсмэл урт эгшигүүд их төлөв хадгалагдан үлдсэн боловч бас зарим нь үг морфемийн утга ялгах үүрэгээ алдаж, богиноор хэлэгдэх болсон байна.

Mngr.	fulān	MM	hula'ān	*'улаан'*
Mngr.	niur	MM	ni'ūr	*'нүүр'*

Mngr.	dere	MM	de'ēre	*'дээр'*
Mngr.	xuri	MM	quru'ūn	*'хуруу'*

5. Эртний монгол хэлний сүүлч үеэр үүсэн бүрэлдсэн эцэсийн хос эгшиг нь Монгор хэлний Хүцү аялгуунд их төлөв урт, Минхэ аялгуунд ихэнхидээ хос болсон боловч заримдаа богиноор хэлэгддэг байна.

Mngr.	noχui	AM	noqai	*'нохой'*
Mngr.	malğa	AM	malaγai	*'малгай'*
Mngr.	χaraŋgu	AM	qaraŋqui	*'харанхуй'*
Mngr.	mugui	AM	moγai	*'могой'*

Харин үгийн эцэсийн бус үеийн хос эгшиг нь ихэнхидээ уртаар дуудагдах болжээ.

Mngr.	sēn	AM	sayīn	*'сайн'*
Mngr.	χuēno	AM	qoyīna	*'хойно'*
Mngr.	ulā-	AM	uyīla-	*'уйл-'*
Mngr.	nōr	AM	noyīr	*'нойр'*

6. Өвөг монгол хэлний үед үгийн эхэнд байсан уруулын шүргэх ***φ*** гийгүүлэгч монгор хэлний хүцү аялгуунд их төлөв уруулын эгшигийн өмнө хадгалагдан үлдсэн байна.

Mngr.	fōdi	PM	*fōdun	*'од'*
Mngr.	fulān	PM	*fulaγan	*'улаан'*
Mngr.	funir	PM	*fünir	*'үнэр'*
Mngr.	fuguor	PM	*füker	*үхэр'*

Мөн эртний монгол хэлний үед үгийн эхэнд байсан шүргэх ***χ*** гийгүүлэгч их төлөв уруулын бус эгшигийн өмнө хадгалагдан үлдсэн байна.

Mngr.	χarwan	AM	*χarban	*'арван'*
Mngr.	χani-	AM	*χani-	*'ани'*
Mngr.	kelige	AM	*χeligen	*'элэг'*
Mngr.	χalğa	AM	*χalaγan	*'алага'*

7. Эртний монгол хэлний үед тагнайшилын нөлөөгөөр үүссэн хамжин шүргэх ***dž, tš*** гийгүүлэгч хэвээр уламжилан үлдсэн бөгөөд түүний арын ***i*** эгшиг ч бас ихэнхидээ ухаран ижилшсэнгүй.

Mngr.	šira	AM	šira	*'шар'*
Mngr.	tšise	AM	čisun	*'цус'*
Mngr.	džida	AM	ǰida	*'жад'*
Mngr.	tšimuge	AM	čimüge	*'чөмөг'*

8. Монгор хэлний зарим эгшиг авианы солигдолын уламаас биеийн төлөөний нэрийн үндэс эвдэрсэн боловч түүний ерөнхий систем нь бараг төлөв хадгалагдан үлджээ.

	ганц тоо	олон тоо
I	bi /bu min /mun (Gen.)	buda (< bida)
II	tši tšin (Gen.)	tatan (Gen.)

0.2.8 ДУНСЯН (Санта) ХЭЛ

§ 37. **Дунсянчуудын тухай товч.** Дунсянчууд өөрсдийгөө Төв Азиас эрт цагт нүүж ирэгсэдийн удам гэж үздэг боловч зарим түүхчид тэднийг Төв Азийн худалдаачид, хитад гар урчууд, монгол цэрэгүүдийн дундаас гарсан холимог угсаатан гэж үздэг ажээ. Шашин шүтлэгийн хувид гэвэл, тэднийг ислам шашинд орсон монголчууд, эсвэл монголжсон исламчууд гэж өөр өөрөөр үздэг байна. Харин тэдний ахмад үеийнхэний зарим нь исламын шашины сургаал номлолыг араб үсэгээр уншдаг уламжилалтай байжээ. Дунсянчуудын ахмад үеийнхэн нь төрөлхи хэлээ хадгалсаар ирсэн бол сургууль соёлоор дамжсан залуу үеийнхэн нь хитад хэлээр боловсорол эзэмшиж, ажил мэргэжилийнхээ эрхээр төрөлхи эх нутагаасаа хол амьдарч ажилласанаас эх хэлээ хэрэглэхгүй, мартах нь цөөнгүй болжээ. Тэд уулаасаа бичиг үсэггүй байсан бөгөөд саяханаас дунсян хэлний авиаг латинчилан тэмдэглэх үсэгийг зохион, дүрэмийг нь боловсруулж, туршилтын журамаар хэрэглэж байгаа юм байна.

Дунсянчууд (*зүүн тосхон* гэсэн үг) нь БНХАУ-ын Гансу мужийн Линшиа хошуугаар голлон нутаглах бөгөөд нийт хүн ам нь 2010 оны тооллогоор 621500 байжээ. (Tabulation on the 2010 Population Census of the People's Republic of China)Энэ нь хүн амынхаа тоогоор монгол угсаатануудын дотор дөрөвдүгээр байранд орж байна гэсэн үг юм.

Дунсянчуудын хэл аялгуу нь Монгор хэлний минхэ аялгуу болон Баоань хэлтэй илүү ойр гэдэгийг эрдэмтэд үздэг байна. Түүнчилэн Хөхнуур мужийн Жианжа хошуунд дунсян, баоань хэлний дундын шинж бүхий хэл аялгуутай *Канжиа* хэмээх цөөн тооны монгол хэлтэнг оршин суудаг тухай сүүлийн үеийн судалгаануудад дурдсан бий.[233] Дунсян хэл нь дотороо авианы дуудлага болон үгсийн сангийнхаа талаар бие биеэсээ бага зэрэг ялгаатай гурван аман аялгуутай байж болох тухай зарим судалаачид дурджээ.[234]

---

[233] Stephen S. Kim, Santa, The Mongolic Languages, edited by J. Janhunen, 2003, 347

[234] ibid., 347

§ 38. **Дунсян хэлний судалгааны тойм.** Дунсян хэлний талаар хамагийн анх Г. Н. Потанин тэмдэглэж үлдээсэн[235] бөгөөд бүр хожим 1950-иад оны дундуур хитад, зөвлөлтийн эрдэмтэд хамтаран судалж уламаар тухайн хэлний үндэсэн онцлог шинжийн талаар Б. Х. Тодаева, Насанбаяр нар судалгааны бүтээл нийтлүүлжээ.[236] Наяад оны эхээр Өвөр Монголын эрдэмтэд Дунсян хэлийг дахин нягтлан судалж, *'Дунсян хэлний үгс'* (1983), *'Дунсян хэл ба монгол хэл'*(1985), *'Дунсян хэлний үг хэллэгийн материалаас'* (1987) гэсэн цуварал бүтээлүүд[237] гарсан нь дунсян хэлний судалал төдийгүй монгол хэлний түүхэн харьцуулсан судалалд үнэтэй чухал хэрэглэгдэхүүн болж байгаа билээ байна.

1990-ээд оноос Дунсян хэлний судалал идэвхиж, хитадын эрдэмтэн Liu Zhao xiong, японы эрдэмтэн M. Kakudo нарын бүтээл[238] гарсанаас гадна америкийн судалаач L. Field Kenneth *'Санта монгол хэлний хэлний зүйн тойм'*[239] гэсэн сэдэвээр, Stephen S. Kim *'Дунсян хэлний үг зүйн судалгаа'*[240] гэсэн сэдэвээр докторын зэрэг хамгаалжээ.

§ 39. **Дунсян хэлний үндэсэн шинж**

1. Дундад үеийн монгол хэлний үед байсан долоон богино эгшиг фонемийн дотороос уруулын ***ö, ü*** эгшигүүд нь хэлний урдуур хэлэгдэх шинжээ алдаж, уламаар хэлний хойгуурхи ***o, u***-тайгаа адил байранд хэлэгдэх болсоноос нийт эгшиг фонемийн бүрэлдэхүүнд зохих өөрчилөлт гарч, бүгд таван эгшигтэй болсон байна.

2. Өвөг монгол хэлний үед байсан анхдагч урт эгшигийн ул мөр дунсян хэлэнд уламжилан үлдсэнгүй.

---

235 Г. Н. Потанин, Тангутско-тибетская окраина Китая и Центральная Монголия. Путешествие Г. Н. Потанина 1884-1886, т. 1-2, СПб., 1893, 346-347

236 Б. Х. Тодаева, Überdie Spracheder Tunghsiang', AOH9, 1959, 273–310; Дунсянский язык, М., 1961, 3-147; Дунсянский язык, Языки мира, М., 1997, 60-66; Насанбаяр, Dungsiyang kelen-ü temdeglel, SM 3, 1961, 53-106

237 Böke, Düngsiyang kele ba mongγol kele {= *Mongγol törül kele ayalγun-u sudulul-un čuburil* 007} ÖMAKQ, 1985, 1-265; *idem.* Düngsiyang kelen-ü üges {= *Mongγol törül kele ayalγun-u sudulul-un čuburil* 008} ÖMAKQ, 1983, 1-192; *idem.* Düngsiyang kelen-ü üge kelelge-yin materiyal {= *Mongγol törül kele ayalγun-u sudulul-un čuburil* 009} } ÖMAKQ, 1987

238 M. Kakudo, Phonemic System of the Dongxiang Language, *Osaka Gaikokugo Daigaku Ronshuu* 13, 1995, 31–56 (япон хэлээр); Liu Zhaoxiong, Grammatical Sketch of Dungxiang, Chinese National Minority Languages Grammatical Sketch Series, Beijing, 1981 (хитад хэлээр)

239 L. Field Kenneth, A Grammatical Overview of Santa Mongolian, *A Dissertation submitted in partial satisfaction of the requirement for the degree of Doctor of Philosophy in Linguistics, University of Californea, Santa Barbara,* 1997, 463 pp.

240 Seogyeong Stephen Kim, A Study of Dongxiang Morphology, Ph. D. Dissertation, The Central University of Nationalities, Beijing, 1998 (in Chinese)

3. Дундад үеийн монгол хэлний үед байсан үүсмэл урт эгшигүүд бие даасан фонемийн үүрэгээ алдаж, богино эгшиг болжээ.

Dun.	ulan	MM	hula'ān	*'улаан'*
Dun.	nu	MM	ni'ūr	*'нүүр'*
Dun.	džiere	MM	de'ēre	*'дээр'*
Dun.	guru	MM	χuru'ūn	*'хуруу'*

4. Эртний монгол хэлний сүүлчээр үүсэн бүрэлдсэн үгийн эцэсийн хос эгшигийн дотороос зөвхөн ***ai, ei*** гэсэн хос эгшигийн байранд гагцхүү ***ei*** тохиолдох бөгөөд бусад хос эгшиг нь хосорхог шинжээ бүрмөсөн алджээ.

Dun.	nogei	MM	noχai	*'нохой'*
Dun.	mağala	MM	malaχai	*'малгай'*
Dun.	dulei	MM	dülei	*'дүлий'*
Dun.	mogei	MM	moγai	*'могой'*

Харин үгийн эцэсийн бус үеийн хос эгшигүүд нь ихэнхи тохиолдолд хэвээр хадгалагдан үлджээ.

Dun.	saiχan	MM	sayiqan	*'сайхан'*
Dun.	χuina	MM	qoyina	*'хойно'*
Dun.	uila-	MM	uyila-	*'уйл-'*
Dun.	uira	MM	oyira	*'ойр'*

5. Үгийн тэргүүн бус үеийн богино, урт эгшигүүд нь тэргүүн үеийнхээ уруулын эгшигт дэвшин ижилшсэн жишээ нилээд тохиолдож байна.

Dun.	olon	AM	olan	*'олон'*
Dun.	bogoni	AM	boγuni	*'богино'*
Dun.	tori-	AM	toγāri-	*'тойр-'*
Dun.	χosun	AM	qoγāsun	*'хоосон'*

Мөн үгийн тэргүүн бус үед орсон хүчтэй эгшигийн нөлөөгөөр өмнө талынх нь богино, урт эгшигийн аль аль нь ухаран ижилшжээ.

Dun.	udu	AM	edür	*'өдөр'*
Dun.	nudun	AM	nidün	*'нүд'*
Dun.	ula	AM	aγūla	*'уул'*
Dun.	χalun	AM	qalaγūn	*'халуун'*

Харин тагнайн ***š, dž, tš***-гийн дараа орсон***i***эгшиг заримдаа ухаран ижилшиж бас заримдаа ижилшээгүй хэвээр үлдсэн байна.

Dun.	tšusun	AM	čisun	*'цус'*
Dun.	džire	AM	ǰirüken	*'зүрх'*

Dun.	šira	AM	šira	*'шар'*

6. Өвөг монгол хэлний үед үгийн эхэнд байсан уруулын шүргэх **φ* гийгүүлэгч уруулын эгшигийн өмнө хадгалагдан үлджээ.

Dun.	fulan	AM	*fulaγan	*'улаан'*
Dun.	funiesun	AM	*fünesün	*'үнэс'*
Dun.	fugieri	AM	*füker	*'үхэр'*
Dun.	fure	AM	*füre	*'үр'*

Мөн эртний монгол хэлний үед үгийн эхэнд байсан шүргэх **χ* гийгүүлэгч зарим цөөн үгийн эхэнд уламжилан үлдсэн байна.

Dun.	χani-	AM	*χani-	*'ани-'*
Dun.	χoŋ	AM	*χon	*'он'*
Dun.	χoduŋ	AM	*χodun	*'од'*
Dun.	χuja-	AM	*χuya-	*'уя-'*

Түүнээс гадна дундад үеийн монгол хэлний үед үгийн эхэнд байсан сул шүргэх ***h***- гийгүүлэгч ч бас уруулын болон уруулын бус эгшигийн өмнө үлдсэн жишээ нилээд тохиолдож байна.

Dun.	hatši	MM	hači	*'ач'*
Dun.	haruan	MM	harban	*'арван'*
Dun.	hanǧa	MM	halaγan	*'алага'*

7. Эртний монгол хэлний үед ***i***-гийн өмнөх ****d, *t***-гээс үүссэн хамжин шүргэх ***dž, tš*** гийгүүлэгч дунсян хэлэнд хэвээрээ хадгалагдаж байна.

Dun.	džaǧasun	AM	ǰiγasun	*'загас'*
Dun.	džure	AM	ǰirüken	*'зүрх'*
Dun.	tšusun	AM	čisun	*'цус'*
Dun.	tšumege	AM	čimuge	*'чөмөг'*

9. Дунсян хэлэнд биеийн төлөөний нэрийн зарим нэн эртний үндэс уламжилан үлджээ.

ганц тоо		олон тоо
I	bi min- (Gen.)	ma-tan | bi-den
II	tši tšin- (Gen.)	ta
III	he <*hi hen- <*hin-	

0.2.9. БАОАНЬ ХЭЛ

§ 40. **Баоаньчуудын тухай товч.** Баоаньчуудын дээд өвөг нь XVI зууны үеэс умард Төвдийн Амдогийн нутаг дээр бүддийн шашин шүтсээр ирсэн ард түмэн юм. Баоаньчуудын олонхи нь Хөхнуур Шунхуа, Ганьсугийн Линшиа тийш шилжин суурьшсан бөгөөд тэдний ахмад үеийнхэн нь монгол хэлний харьцангуй эртний шинжтэй хэлээр ярьсаар ирсэн бол залуу үеийнхэн нь төрөлхи хэлээсээ хөндийрөх нь нийтлэг шинжтэй болжээ. Хөхнуурт оршин суудаг баоаньчууд нь бүддийн шашинаа хадгалж үлдсэн бөгөөд хэл аялгуу нь төвд хэлний нөлөө ихтэй, Ганьсуд оршин суудаг баоаньчууд нь XIX зууны дунд үеэс исламын шашинд орсон бөгөөд хэл аялгуу нь хитад хэлний нөлөө ихтэй, үгсийн сангийнх нь 40 орчим хувь нь хитад үг байдаг ажээ. Бас түрэг гаралтай үгс ч бас байдаг байна.[241]

Эдүгээ баоаньчууд нь БНХАУ-ын Гансу мужийн Линся Хуй өөртөө засах ороны Бонан, Дунсян Саларын хошуу, Хөхнуур мужийн Шунхуа хошуу, Ланжоу хот болон түүний ойролцоох хошуудаар оршин сууж байгаа бөгөөд нийт хүн ам нь 2010 оны тооллогоор 20074 байжээ. (Tabulation on the 2010 Population Census of the People's Republic of China) Баоаньчуудын бараг 90 хувь нь Ганьсу мужид, үлдэх хувь нь Хөхнуурт аж төрдөг ажээ.

Баоаньчууд нь уулаас үсэг бичиггүй бөгөөд залуу үеийнхэн нь сургуульд хитад хэлээр суралцдаг байна.

§ 41. **Баоань хэлний судалгааны тойм.** Баоань хэлний талаар хамагийн анх Г. Н. Потанин тэмдэглэсэн[242] бөгөөд бүр хожим 1950-иад оны дундуур хитад-зөвлөлтийн хамтарсан хээрийн судалгаагаар тус хэлний талаар хэл аялгуу судалалын тусхай хөтөлбөрөөр судалгаа хийсэн бөгөөд түүний үр дүнд Б. Х. Тодаева Баоань хэлний тухай тойм үгүүлэл болон нэг сэдэвт зохиол нийтлүүлсэн байна.[243] Наяад оны эхээр профессор Чен найшиюн (Chen Naixiong), Y. Хөгжилтү нар Хөхнуурын баоаньчуудын хэл аялгууг дахин нарийвчилан судалсаны дүнд *'Баоань хэлний үгс'* (1986), *'Баоань хэл ба монгол хэл'* (1987), *'Баоань хэлний үг, хэллэгийн материал'* (1987) гэсэн гурван цуварал материал гаргасан байна.[244]

---

241 Nugteren, Hans (1998) On some Turkic Loanwords in Monguor, Bao'an and Dongxiang', in: Lars Johanson (ed.) The Mainz Meeting: *Proceedings of the Seventh International Conference onTurkish Linguistics,* Wiesbaden, Otto Harrassowitz, 1998, 683–696.

242 Г. Н. Потанин, Тангутско-тибетская окраина Китая и Центральная Монголия. Путешествие Г. Н. Потанина 1884-1886, т. 1-2, СПб., 1893, 224-225

243 B. Ch. Todaeva. Einige Besonderheitender Paoan-Sprache, AOH 16, 1963, 175-197; Баоаньский язык, М., 1964, 155 стр.

244 Баоаньский язык, М., 1964, 155 стр.

244 Chen Naixiong, Bou an kele ba mongγol kele, {= *Mongγol törül-ün kele ayalγun-u sudulul-un čuburil* 010}, ÖMAKQ, 1986, 395 + 8; Bou an kelen-ü üges {= *Mongγol törül-ün kele ayalγun-u sudulul-un čuburil* 011}, ÖMAKQ 239 + 14; Bou an kelen-ü üge kelelge-yin

§ 42. **Баоань хэлний үндэсэн шинж**. Баоань хэлний тухай судалгааны бүтээлүүд дээр тулгуурлан тухайн хэлний онцлог шинжийн талаар товч дурдвал:

1. Дундад үеийн монгол хэлний үед байсан долоон богино эгшиг фонемийн дотороос уруулын ***ö, ü*** эгшигүүд нь хэлний урдуур хэлэгдэх шинжээ алдаж, уламаар хэлний хойгуурхи ***o, u***-тайгаа адил байранд хэлэгдэх болсоноос нийт эгшиг фонемийн бүрэлдэхүүнд зохих өөрчилөлт гарч, бүгд таван богино эгшигтэй болжээ.

2. Өвөг монгол хэлний үед байсан анхдагч урт эгшигийн ул мөр Баоань хэлэнд уламжилан үлдсэнгүй.

3. Утга ялгах өргөлтөт эгшигээс үүссэн урт эгшиг нь их төлөв ганц үет үгэнд, хааяа хоёр үет үгийн тэргүүн үед тохиолдож байна. Мөн богиноор хэлэгдэх болсон жишээ ч цөөнгүй буй.

Bao.	felaŋ	AM	*fulaγān	*'улаан'*
Bao.	sū-	AM	saγū-	*'суу-'*
Bao.	bū-	AM	baγū-	*'буу-'*
Bao.	ōle	AM	aγūla	*'уул'*

4. Үгийн эцэсийн хос эгшиг ихэнхидээ хэвээр хадгалагдан үлджээ.

Bao.	nogui	AM	noqai	*'нохой'*
Bao.	mogui	AM	moγai	*'могой'*
Bao.	malge	AM	malaγai	*'малгай'*
Bao.	gui-	AM	γuyi-	*'гуй-'*

Харин үгийн эцэсийн бус хос эгшиг ихэнхидээ богино, хааяа урт, маш цөөн тохиолдолд хосорхог шинжтэй хэлэгдэж байна.

Bao.	san	AM	sayin	*'сайн'*
Bao.	χuine	AM	qoyina	*'хойно'*
Bao.	lā-	AM	uyila-	*'уйл-'*
Bao.	nor	AM	noyir	*'нойр'*

5. Үгийн тэргүүн бус үеийн богино, урт эгшигийн аль аль нь тэргүүн үеийнхээ уруулын эгшигт татагдан, дэвшин ижилшсэн жишээ цөөнгүй тохиолдож байна.

Bao.	oloŋ	AM	olan	*'олон'*
Bao.	oroŋ	AM	oran	*'орон'*
Bao.	tōr-	AM	toγāri-	*'тойр-'*
Bao.	χoson	AM	qoγāsun	*'хоосон'*

materiyal {= *Mongγol törül-ün kele ayalγun-u sudulul-un čuburil* 010}, ÖMAKQ, 1986, 9 + 1-148

Баоань хэлний үгийн тэргүүн үеийн эгшиг суларан сугарсан хийгээд тэргүүн бус үеийн ***u, ü*** эгшиг идэвхитэй уруулын шинжээ алдсан зэрэг шалтгаанаас богино эгшиг богино эгшигтэйгээ ухаран ижилших боломж бараг үгүй болжээ. Харин богино эгшиг урт эгшигтэй ухаран ижилшсэн жишээ цөөн боловч тохиолдож байна.

Bao.	uder	AM	edür	*'өдөр'*
Bao.	arūn	AM	ariγūn	*'ариун'*
Bao.	dun	AM	daγūn	*'дуу'*
Bao.	ōle	AM	aγūla	*'уул'*

Мөн тагнайн шүргэх ***š*** болон хамжин шүргэх ***dž, tš***-гийн дараа орсон ***i*** эгшиг ухаран ижилшсэнгүй, хэвээр хадгалагдаж байна.

Bao.	džirgon	AM	ǰirγuγān	*'зургаан'*
Bao.	džirge	AM	ǰirüken	*'зүрх'*
Bao.	tšison	AM	čisun	*'цус'*
Bao.	šira	AM	šira	*'шар'*

6. Өвөг монгол хэлний үед үгийн эхэнд байсан уруулын шүргэх ****f*** гийгүүлэгч цөөн тооны үгэнд уламжилан үлджээ.

Bao.	fuda	PM	*fuγuta	*'уут'*
Bao.	fure	PM	*füre	*'үр'*
Bao.	felan	PM	*fulaγan	*'улаан'*
Bao.	fune-	PM	*funa-	*'уна-'*

Мөн эртний монгол хэлний үед үгийн эхэнд байсан шүргэх ****χ*** гийгүүлэгч нилээд үгэнд хэвээр хадгалагдан үлджээ.

Bao.	χalge	AM	*χalaγan	*'алага'*
Bao.	χelge	AM	*χeligen	*'элэг'*
Bao.	χoŋ	AM	*χon	*'он'*
Bao.	χoduŋ	AM	*χodun	*'од'*

Дээр дурдсанаас гадна дундад үеийн монгол хэлний үед үгийн эхэнд байсан сул шүргэх ***h-*** гийгүүлэгч цөөн зарим үгийн эхэнд тохиолдож байна.

Bao.	harwan	MM	harban	*'арван'*
Bao.	hanera-	MM	hamura-	*'амар-'*
Bao.	hē-	MM	hegē-	*'ээ-'*
Bao.	hgude-	MM	hükü-	*'үх-'*

7. Эртний монгол хэлний үед тагнайшилын уламаас үүссэн хамжин шүргэх ***dž, tš*** гийгүүлэгч их төлөв ***i*** эгшигийн өмнө тохиолдож байна. Холбогдох жишээг эгшиг авианы ижилшилтийн тухай хэсэгээс үзнэ үү.

10. Баоань хэлний биеийн төлөөний нэрсийн дотор зарим эртний үндэсүүд хадгалагдсаар байна.

ганц тоо		олон тоо
I	be men- (Gen.)	mange | bede\ man- | bedan- (Gen.)
II	tše tšen- (Gen.)	ta tan- (Gen.)

0.2.10 ШАР ЁГУР ХЭЛ

§ 43. **Шар Ёгурчуудын тухай товч**. Шар Ёгурчууд нь БНХАУ-ын Ганьсу мужийн төв хэсэгийн Сунан Ёгурын хошуу болон Канле, Хуанчен, Дахе тойрогт оршин суух бөгөөд нийт хүн ам нь 2010 оны тооллогоор 14378 байсан (Tabulation on the 2010 Population Census of the People's Republic of China) бөгөөд тэдгээрийн 70 орчим хувь нь түрэг хэлээр, үлдсэн 30 орчим хувь нь монгол хэлээр ярилцдаг ажээ. Монгол хэлээр хэлэлцэгч шар ёгурчууд нь уулаас монгол хэлтэн үү, эсвэл монголжсон түрэгүүд үү гэдэг асуудал эдүгээ хүртэл тодорхой-гүй байна.

§ 44. **Шар Ёгур хэлний судалгааны тойм**. Оросын эрдэмтэн Г. Н. Потанин Шар Ёгур хэлний талаар анх түрүү мэдээлж, 200 гаруй үгсийн жагсаалт гаргасан[245] нь тухайн хэлний судалалын эхлэл нь болжээ. Түүний дараахан финий аялагч G. Mannerheim шар ёгурчуудын тухай тэмдэглэлдээ тэдний хэл ярианы холбогдолтой 270 орчим үгийн жагсаалт хавсаргасаны дотор тооны нэр, бие эрхтэний нэр, мал амьтан, садан төрөлийн нэр, өнгө зүс зэрэг өргөн хэрэглээний үгс багтсан байна.[246] 1950-иад оны үед нэрт монголч эрдэмтэн W. Kotwicz урид Г. Потанин, G. Mannerheim, С. Е. Малов нарын цуглуулсан материал дээр тулгуурлан Шар Ёгур хэлний талаар сонирхолтой үгүүлэл нийтлүүлжээ.[247] Уг үгүүлэлд шар ёгурчуудын гарал үүсэл, тэдний хэлний авиа зүй, үг зүйн зарим онцлог шинж болон тооны нэр болон биеийн төлөөний нэрсийг оролцуулвал 500 шахам үгсийн жагсаалтыг оруулсан байна.

Өнгөрсөн зууны тавиад оны дундуур хитадын эрдэмтэд Гансу, Хөхнуур мужийн монгол хэл аялгууны тухай материал цуглуулахдаа Шар Ёгур хэлний тухай эрдэм шинжилгээний тайлан үйлдсэн бөгөөд хожим Б. Х. Тодаева уул

---

[245] Потанин, Г. Н. Тангутско-тибетская о краина Китая и Центральная Монголия. Путешествие Г. Н. Потанина 1884-1886, т. 1-2, СПб., 1893, 411-423

[246] Mannerheim, G. A. A Visit to the Sarö and Shera Yögurs, JSFOu 27, 1911, 1-7

[247] Kotwicz, Wl. La langue mongole parlée par les Ouigours Jaunes prés de Kantcheou, RO 16, 1953, 435-465

материал дээр тулгуурлан судалгааны товч тойм үгүүлэл нийтлүүлжээ.[248] Тус үгүүлэлд Шар Ёгур хэлний тухай товч тойм болон эгшиг, гийгүүлэгч авианы тогтолцоо, нэр, үгийн бүтэц, тэдгээрийн хэл зүйн хэлбэр, төлөөний нэрийн ялгалал, тооны нэрийн тухай тодорхой жишээтэй үзүүлсэн нь өмнөх бүх судалгаануудаас илүү дэлгэрэнгүй, тодорхой болсон байна.

Наяад оны эхээр Өвөр Монголын эрдэмтэд Шар Ёгур хэлийг дахин нягтлан байцааж *'Зүүн Ёгур хэл ба монгол хэл'* (1985), *'Зүүн Ёгур хэлний үгс'* (1987), *'Зүүн Ёгур хэлний үг, хэллэгийн материал'* (1991) гэсэн цуварал[249] бүтээлийг нийтлүүлсэнээс гадна Шар Ёгурчуудын хэл соёл, шашин шүтлэг, хүн ам хэл аялгууны талаар тойм үгүүлэлүүд гарчээ.[250] Мөн Шар Ёгур хэлний үгсийн сангийн талаар A. Rona-Tas, Hans Nugteren нарын бүтээлүүд бий.[251]

§ 45. **Шар Ёгур хэлний үндэсэн шинж.** Шар Ёгур хэлний талаар гарсан судалгаанууд дээр үндэслэн уул хэлний гол шинжийн талаар товч дурдвал:

1. Эртний болон дундад үеийн монгол хэлний үед байсан үндэсэн долоон богино эгшиг хэвээр уламжилан үлджээ.

2. Өвөг монгол хэлний үед байсан анхдагч урт эгшигийн зарим ул мөр цөөн үгэнд хадгалагдаж үлдсэн байна.

SY.	mūden	PM	*mōdun	*'мод'*
SY.	dāla	PM	*dālu	*'дал'*
SY.	tāwen	PM	*tābun	*'таван'*

3. Дундад үеийн монгол хэлний үед байсан үүсмэл урт эгшиг олонхи тохиолдолд хэвээр уламжилан үлджээ.

---

248 Тенишев, Э. Р. Тодаева, Б. Х. Язык желтых уйгуров, М., 1966, 45-81

249 Bulučilaγu, Jegün Yoγur kele ba Mongγol kele{= *Mongγol törül-ün kele ayalγun-u sudulul-un čuburil* 016}, ÖMAKQ, 1986; Jegün Yoγur kelen-ü üges {= *Mongγol törül-ün kele ayalγun-u sudulul-un čuburil* 017}, ÖMAKQ, 1987, XX + 132; Jegün Yoγur kelen-ü üge kelelge-yin materiyal {= *Mongγol törül-ün kele ayalγun-u sudulul-un čuburil* 018}, ÖMAKQ, 1991

250 Б. Х. Тодаева, Об изучении языка шира югуров, *Проблемы алтаистики и монголоведения,* Вып. 2, Сер. Лингвистики, М., 1975, 234-242; Li Xue Wei & Kevin Stuart, Population and Culture of the Mongols, Tu, Baoan, Dongxiang, and Yugu in Gansu, *Mongolian Studies,* 12, 1989, 71-93

251 A. Rona-Tas, Tibetan Loan-words in the Shera Yogur Language, AOH 15, 1962, 259-71; Hans Nugteren, and Marti Roos, Common Vocabulary of the Western and Eastern Yugur Languages: The Turkic and Mongolic Loanwords, AOH 49, 1996, 25–91; *idem.* Common Vocabulary of the Western and Eastern Yugur Languages: The Tibetan Loanwords', *Studia Etymologica Cracoviensia* 3, 1998, 45–92.

SY.	lān	MM	ula'ān	*'улаан'*
SY.	dūda-	MM	da'ūda-	*'дуу-'*
SY.	dēre	MM	de'ēre	*'дээр'*
SY.	χurūn	MM	quru'ūn	*'хуруу'*

4. Үгийн эцэсийн хос эгшиг олонхи үгэнд тогтвортой хадгалагдаж байна.

SY	noχoi	AM	noqai	*'нохой'*
SY	χaranqui	AM	qarangqui	*'харанхуй'*
SY	mogoi	AM	moγai	*'могой'*
SY	malağai	AM	malaγai	*'малгай'*

Мөн үгийн эцэсийн бус үеийн хос эгшигүүд ч гэсэн ихэнхидээ хэвээр уламжилан үлджээ.

SY	sain	AM	sayin	*'сайн'*
SY	χoino	AM	qoyina	*'хойно'*
SY	noiton	AM	noyitan	*'нойтон'*
SY	χuila-	AM	quyila-	*'хуйл-'*

5. Үгийн тэргүүн бус үеийн богино, урт эгшигийн аль аль нь тэргүүн үеийнхээ уруулын эгшигт татагдан ижилшсэн жишээ цөөн боловч тохиолдож байна.

SY	oron	AM	oran	*'орон'*
SY	hodon	AM	*χodun	*'од'*
SY	xūle	AM	qoγālai	*'хоолой'*

Мөн тэргүүн бус үеийн богино эгшигүүд ч арынхаа хүчтэй эгшигт татагдан ухарч ижилшсэн жишээ нилээд олон байна.

SY	odor	AM	edür	*'өдөр'*
SY	nüdün	AM	nidün	*'нүд'*
SY	arūn	AM	ariγūn	*'ариун'*
SY	tšūl-	AM	čiγūla-	*'чуул-'*

Харин тагнайн шүргэх ***š***, хамжин шүргэх ***dž, tš***-гийн ард орсон ***i*** эгшиг нь дараах эгшигийнхээ хэлэгдэх байдалаас үл шалтгаалан зарим тохиолдолд ухаран ижилшиж, заримдаа ижилшээгүй үлдсэн байна.

SY	šölön	AM	silün	*'шөл'*
SY	tšuqul	AM	čiqul	*'чухал'*
SY	tšider	AM	čidür	*'чөдөр'*
SY	džirğal	AM	ǰirγal	*'жаргал'*

6. Дундад үеийн монгол хэлэнд үгийн эхэнд байсан сул шүргэх ***h*** гийгүүлэгч нилээд үгэнд хэвээр хадгалагдан үлджээ.

SY	harban	AM	harban	*'арван'*
SY.	helegen	AM	heligen	*'элэг'*
SY.	hodon	AM	hodun	*'од'*
SY.	hüsün	AM	hüsün	*'үс'*

7. Эртний монгол хэлний үед тагнайшилын үр дүнд үүссэн хамжин шүргэх ***dž, tš*** гийгүүлэгч нь ***i*** эгшиг болон ухаран ижилшсэн бусад эгшигийн өмнө тохиолдож байна.

8. Биеийн төлөөний нэрийн зарим үндэс нь авианы хувьсалын уламаас нилээд хувирчээ.

ганц тоо		олон тоо
I	bu mun- (Gen.)	buda | budas man- (Gen.)
II	tše tšen- (Gen.)	ta tan- (Gen.)

0.3. **МОНГОЛЧУУДЫН ҮСЭГ БИЧИГ, БИЧИГИЙН ХЭЛ**

0.3.1. МОНГОЛЧУУДЫН ҮСЭГ БИЧИГ

Монголчуудын үсэг бичигийн түүх нь хүн төрөлхитөний үсэг бичигийн түүхийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг юм. Монголчуудын өвөг дээдэс чухам хэдийгээс үсэг бичиг хэрэглэж ирсэн тухай асуудал тодорхой биш боловч Хүннүгийн үеэс үсэг бичиг хэрэглэж байсан гэдэгийг эрдэмтэдийн судалгаа батлаж байна. Бид энд монголчуудын хэрэглэж ирсэн үсэг бичигийн түүхэн тоймыг тэдгээрийн гарал үүсэл, бүтэц тогтолцоог нь харгалзан доор дурдсан гурван зүйлээр ангилан үзэх болно.

0.3.1.1 ӨВӨГ МОНГОЛЧУУДЫН ҮСЭГ БИЧИГ

§ 46. Өвөг монголчуудын үсэг бичигийн тухай товч. Монголчуудын дээд өвөг болох хүннүчүүд нь манай эриний өмнөх III зууны үеэс түүхийн тавцанаа тодорон гарч, одоогийн түрэг, монгол, түнгүүс зэрэг Төв Азийн олон угсаатаныг нэгдхэсэн хүчирхэг гүрэнийг байгуулан 300 гаруй жил оршин тогтоносон түүхтэй. Хүннүчүүд үсэг бичигтэй байсан уу, хэрэв байсан бол ямар бичиг хэрэглэж байсан тухай асуудал эрдэмтэдийн анхааралыг татсаар иржээ.

Эртний хитадын зарим сурвалж бичигт хүннүчүүдийг *'бичиг үсэггүй, амаар болзоо тогтоодог'* хэмээн тэмдэглэсэн байдагийг үндэслэн, тэднийг уулаас бичиг үсэг мэддэггүй байсан гэсэн үзэл байсаар байжээ. Америкийн эрдэмтэн W. Mc. Govern *'Төв Азийн эртний улсууд'* гэдэг номдоо *'Хүннүчүүд хитад үсэг хэрэглэж байсангүй. Ер тэдэнд тийм үсэгийг авч хэрэглэх нь нэн бэрхшээлтэй байжээ'*

хэмээн тэмдэглэсэн байна.[252] Гэтэл манай эриний өмнөх III зууны сүүлч, II зууны эхээр хүннүгийн хаад Сүн улс, Хан улсын хаанд албан бичиг илгээж байсан тухай мэдээ байдаг байна.[253] Тэдгээр мэдээг үндэслэн хүннүчүүд бичиг үсэгтэй байсан гэж үздэг эрдэмтэд ч бас байдаг байна. Тухайлвал, оросын эрдэмтэн Н. Я. Бичурин *'Монголын тухай тэмдэглэл'* хэмээх бүтээлдээ: *'Манай эриний өмнөх II зууны үед Модун хаан олон монгол овогуудыг нэгдхэн ... үсэг бичиг чухал болохыг ойлгоод хитад утгын үсэгийг авч хэрэглэсэн'* гэжээ.[254] Мөн хитад судалаач нэрт эрдэмтэн В. П. Васильев, монголч эрдэмтэн А. М. Позднеев нар эртний хитад сурвалж бичигийн мэдээнд тулгуурлан монголчууд хитад ханз үсэг хэрэглэж байсан гэж дурдсан бий.[255] Хожим монголын эрдэмтэн Н. Ишжамц *'Хүннүгийн оюуны соёлын гол дэвшилт нь хитад бичиг хэрэглэж байсанд оршино'*[256] хэмээн тэмдэглэсэн бол түүхч Ч. Далай *'Хүннүчүүд улс байгуул-снаасаа хойно хитад утгын үсгийг авч хэрэглэсэн'*[257] гэж дурдсан бий. Харин францын эрдэмтэн E. Blochet хүннүчүүдийг арамей төрөлийн нэгэн бичиг авч хэрэглэж байсан бөгөөд тэр нь түрэг рүн бичигтэй адил төстэй байсан гэжээ.[258] Мөн германы эрдэмтэн Franz Altheim, польш эрдэмтэн Edward Tryjarski нар хүннүчүүдийн хэрэглэж байсан үсэг бичигийг эртний түрэгийн рүн бичигтэй холбон үзсэн ажээ.[259] Монголын эрдэмтэн Ц. Доржсүрэн *'Одоо олдоод байгаа* /Хүннүгийн Д. Т./ *14 'тамга' үсэг нь хожим мандсан Орхон Түрэгийн цагаан толгойн үсгүүдийн зариммтай нь тохирч байна. Энэ бол Орхон Түрэг бичээсийн гарал ба Төв Азийн эртний олон аймгийн үсэг бичгийн соёлын түүхэнд чухал ач холбогдол бүхий зүйл гэдгийг дурдвал зохино'*[260] гэж бичсэн бол түүхч Г. Сүхбаатар дээрхи санааг улам тодоруулан *'Хүннүчүүд барагцаалвал манай эрний өмнөх II зууны үеэс аваад үсэг бичиг хэрэглэж байсан'* гэж дурдаад цааш нь *'Хүннүчүүд энэтхэгийн брахми бичгийг зээлдэн хэрэглэж байгаад тэр нь тухайн үед эртний түрэгийн рүн бичиг болсон байх'* хэмээжээ.[261]

Эртний хүннүчүүдийн бичиг үсэгийн талаар ийм өөр өөр санал байгаа бөгөөд эдүгээ хүртэл нэгэн мөрөөр шийдэгдээгүй, маргаантай хэвээр байна. Хүннүгийн дараа Төв Азид үүсэн бүрэлдсэн эртний улсуудын хэл аялгуу, бичиг үсэгийн тухай асуудал эрдэмтэдийн анхааралыг бүр ч илүү татсаар иржээ. Тухайлвал,

---

252 W. Mc. Govern, The Early Empires of Central Asia, 1965, 106

253 Н. Я. Бичурин, Записки о Монголии, т. I, 1828, 201; Г. Сүхбаатар, Хүннү бичигтэй байсан тухай, 74

254 Н. Я. Бичурин, Записки о Монголии, т. I, 1828, стр. 201

255 В. П. Васильев, История древности восточной части Средней Азии, ТВОРАО, ч. IV, 1857, стр. 219; А. М. Позднеев, Лекции по истории монгольской литературы, том I, 1896, стр. 7

256 Н. Ишжамц, Хүннүгийн удам угсаа, нийгмийн байгуулал, *Шинжлэх ухааны хүрээлэнгийн бүтээлүүд,* 1, 1956, 29-р тал

257 Ч.Далай, Монголчуудын бичиг үсгийн түүхийн зарим асуудал, ШУАМ3, 1961, 52

258 E. Blochet, Les inscriptions turques de l'Orkhon, *Revue Archeologique,* 3 serie, XXXII, 1898

259 R. Franz Altheim, Hunnische Runen, Halle, 1948; Ed. Tryjarski, Altes und Neues zur Entstehung der turkischen Runenschrift, RO XLX:1,1985

260 БНМАУ-ын түүх, 1-р боть, 1966, 95-р тал

261 Г. Сүхбаатар, К вопросу о времени появления письменности у народов Центральной Азии, SM VIII, 1971, 141-142

сяньбичуудын хэл аялгуу, бичиг соёлын талаар Fang Chuang-yao, René Grousset, G. Schreiber, Г. Сүхбаатар нар[262] Тобачуудын хэл, бичигийн талаар P. A. Boodberg, W. Eberhard, L. Bazin, Sanping Chen зэрэг эрдэмтэд[263] тусхайлан дурдсан байна.

Сяньбичууд модон дээр элдэв хэрчилээс гарган утга санаагаа дамжуулдаг байсан тухай хитадын эртний түүхэн сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг бөгөөд түүнийг олонхи судалаачид бичиг үсэгийн эртний бүдүүлэг хэлбэр гэж үзсэн бол манай зарим эрдэмтэд түүнийг энгийн бүдүүлэг үсэг бичиг бус, нэгэн зүйлийн боловсон бичиг үсэг байсан байх гэж үзжээ.[264] Тухайлвал, түүхч эрдэмтэн Н. Сэр-Оджав *'Эртний аймгууд мод хэрчин хэрэг тэмдэглэдэг байсан нь улмаар нарийсан боловсорч, түрэг бичгийн эхийг тавьсан бололтой'*[265] гэж дурдсан бол Г. Сүхбаатар *'Хүннү, сяньби хоёрын хэлхээ холбоо, эртний түрэгийн бичгийн тухай хитад сурвалж бичгийн мэдээ, рүн бичгийн бичлэгийн байдал, мод сийлэх тухай мэдээ зэргийг эргэцүүлэн бодоход, сяньби зэрэг аймгийн мод сийлэх гэдэг нь рүн бичиг байсан байх хэмээн хэлж бүрэн болмоор байна'* гэжээ.[266] Мөн Унгарын эрдэмтэн А. Rona-Tas тобачууд рүн бичиг хэрэглэж байсан гэж тэмдэглэсэн бий.[267]

§ 47. **Хитан бичигийн тухай товч тойм**. Өвөг монголчуудын үсэг бичигийн түүхэнд хитан бичиг чухал байр эзэлнэ. Манай эриний IV зууны үеэс түүхэнд анх тэмдэглэгдэж, X зууны үеэс умард хитадыг эзэлж Ляо улсыг байгуулж байсан хитанчууд 920 онд *'их бичиг'* гэгчийг зохиож, уламаар түүнээс тавхан жилийн дараа 925 онд *'бага бичиг'*зохион хэрэглэсэн тухай түүхэн сурвалж бичигүүдэд тэмдэглэсэн байдаг байна. Дээр дурдсан хоёр бичиг нь өөр хоорондоо ямар ялгаатай болох тухайд эрдэмтэд мөн өөр өөр саналтай байна. Олонхи эрдэмтэд *'их бичиг'* нь хитад утгын үсэгт тулгуурласан олон зуун тэмдэгттэй, *'бага бичиг'* нь Орхон Түрэгийн рүн бичигтэй төстэй, харьцангуй цөөн үсэг тэмдэг бүхий авианы бичиг байсан байх гэж үздэг байна.[268] Харин хитадын эрдэмтэн Lo Fu-cheng уул

---

262 Fang Chuang-yao, The Hsien Pei Language, *Yenching Journal of Chinese Studies,* 8, 1930, 1429-1468; René Grousset, L'empire des steppes: Attila, Gengis-khan, Tamerlan, Paris, 1939, 95-103; G. Schreiber, Das Volk der Hsien-pi sur han Zeit, *Mon. Ser* XII, 1947, 145-202; Г. Сүхбаатар, Сяньби нарын бичгийн тухай хэдэн мэдээ, ШУАМ. 2, 1969, 15-28

263 P. A. Boodberg, The Language of the To-pa Wei, HJAS 1, 1936, 167-185; W. Eberhard, das Toba-Reich Nordchinas, 1949; L. Bazin, Recherches sue les parlers To-pa, T'P XXXIX, 1950, 228-329; Sanping Chen, Turkic or Proto-Mongolian? A Note on the Tuoba Language, CAJ 49, 2005,161-173

264 А. Лувсандэндэв, Из истории монгольской письменности, *Современная Монголия,* 2, 1957, 17-18; Г. Сүхбаатар, Сяньби нарын угсаа гарал, соёл, аж ахуй, нийгмийн байгуулал, 1971, 106-108

265 Н. Сэр-Оджав, БНМАУ-ын түүх, 1-р боть, 1966, 130-р тал

266 Г. Сүхбаатар, Сяньби нарын бичгийн тухай хэдэн мэдээ, 16; *idem.* Сяньби нарын угсаа гарал, соёл, аж ахуй, нийгмийн байгуулал, 110

267 A. Rona Tas, Some Notes on the Terminology of Mongolian Writing, AOH VIII, 1965,119

268 Fêng Chia-shêng, The Ch'i-tan Script, JAOS vol.68, № 1, 1948, 15-16, 18; G. Kara, On the Khitan Writing Systems, MS 10, 1986|1987, 19-20; Г. Сүхбаатар, Киданы эртний бичгийн тухай мэдээ, SM VI:7, 1970, 216; S. Murayama, Die Methode der entzifferung der Kitan Schrift, JLSJ 17-18, 1951, S. 20-70

хоёр бичиг нь хоёулаа хитад утгын бичигт тулгуурласан, хувилбарын шинжтэй бөгөөд *'бага бичиг'* нь хилбарчилан хураангуйлсан шинжтэй байсан гэж үзжээ. Профессор G. Kara *'их бичиг'* нь олон үсэгтэй, цувараа *('linear script')* бичлэгтэй, *'бага бичиг'* нь цөөн үсэгтэй, угсарсан *('assembled script')* бичлэгтэй гэж тодорхойлсон нь[269] эдүгээ хитан бичигийн судалалд баримтлах гол баримжаа болж байна.

Хитанчуудын үсэг бичигийн талаар оросын эрдэмтэн И. И. Захаров *'Төв Азийн олон улс үндэстэнүүдийн дотороос өөрийн гэсэн үсэг бичигтэй болохын чухалыг хитанчууд анх түрүүн ойлгосон байна. Гэвч тэд өөрсдөө ямар нэгэн бичигийг шинээр зохиосонгүй, харин хитад үсэгийн олон зурлага сэлтийг эх хэлэндээ тохируулан авч хэрэглэжээ... Хитанчуудын адилаар хитад үсэгийг өөрийнхөө хэлэнд тохируулан хэрэглэсэн өөр нэг чулс урид өмнө байсангүй'* хэмээн тэмдэглэжээ.[270] Мөн япон эрдэмтэн Yamaji Hiroaki хитан бичигийн талаар хэд хэдэн үгүүлэл нийтлүүлсэнээс гадна *'Хитан үсэгийн бүтэцийн судалгаа'*[271] гэдэг номдоо хитан үсэгийн авианы дуудлагын талаар голлон бичсэн ажээ.

Өнгөрсөн зууны жараад онд Зөвлөлтийн эрдэмтэд хитан бичигийн дурсхалуудын бичлэгийн тогтолцоог электрон машинаар тооцоолон бодоод *'Хитанчуудын хэл бол монгол хэлний бүлэгт багтана'*[272] гэж дүгнэсэн нь хитан бичигийн дурсхалын судалгаа болон хитанчуудын угсаа гаралын судалгаанд чухал ахиц болжээ. Дээрхи судалгаанд оролцсон эрдэмтэн Ю. Кнорозов: *'Хитанчууд гадаад хэлбэрээрээ хитад утгын бичигтэй ойролцоо боловч түүнээс огт өөр бүтэцтэй бичиг хэрэглэж байжээ. Тэдний хэл нь хитад хэлтэй төрөл бус, харин монгол хэлтэй гарал болохыг тооцоолон бодох машин тогтоож өглөө'*[273] хэмээсэнийг онцлон тэмдэглэе. Зөвлөлтийн эрдэмтэн В. С. Таскин хитан бичигийн гуч орчим тэмдэгтийг тайлан унших оролдлого хийж, уламаар өөрийнхөө судалгааны туршилга дээр тулгуурлан *'Хитан хэл бол монгол хэлний бүлэгт багтах бөгөөд тэдний бичиг нь үеийн тогтолцоотой байсаныг хитан бичигийг тайлан унших явцад мэдэж болно'* гэж дурдсан байна.[274]

Хитан бичигийн судалгаа өргөжихийн хэрээр шинэ шинэ дурсхалууд олдож, тэдгээрийг уншиж тайлсан судалгааны бүтээлүүд нэмэгдсээр байна. Зөвлөлтийн

---

269 G. Kara, On the Kitan Writing Systems, MS X, 1986-1887, 19-20

270 И. И. Захаров, Полный маньчжурско-русский словарь, СПб., 1875, стр. IV

271 Yamaji Hiroaki, A Philological Study of the Khitan Language, Tokyo, 34

272 В. С. Стариков, М. В. Наделяев, Предварительное сообщение о дешифровке киданьского письма, М., 1964, 2-26; А. Кондратьев, В. С. Стариков, Электронный филолог делает открытие, *Неделя,* № 30, 1964; V. S. Starikov, Catalogue of Graphems of the Kitan Script, Moscow, 1966, 12; *idem.* Материалы по дешифровке киданьского письма, т. 1.Формальный анализ функциональной структуру текста, М., 1970; Т. А. Пробст, О машинной разработке киданьских текстов, *Предварительное сообщение о дешифровке киданьского письма,* М., 1970, 27-34

273 Ю. Кнорозов, Первые успехи в дешифровке письменность киданьского народа, *Неделя,* № 30, 1964

274 В. С. Таскин, Опыт дешифровки киданьской письменности, НАА 1, 1963, 127

эрдэмтэн Л. Н. Рудов дэлхийн хоёрдугаар дайны өмнө хитан бичигийн дурсхалыг шинжилж, олон шинэлэг дүгнэлт бүхий сонирхолтой үгүүлэл бичсэн нь хожим 1963 онд нийтлэгджээ.[275] Тэрвээр хитан бичигийн дурсхалуудын бичлэгийн тогтолцоог судалаад, түүнийг үеийн бичигийн шинжтэй бөгөөд үгийн нөхцөлүүдийг тусхай зурлагаар тэмдэглэдэг тухай дурдсан байна. Мөн зөвлөлтийн эрдэмтэн Э. В. Шавкунов *'Хитан-Жүрчидийн бага бичигийг тайлан унших тухай'*[276] гэсэн үгүүлэлдээ жүрчин бичигийг уншин тайлсан арга зарчим дээр түшиглэн хитан бичигийн дурсхалууд дахь зарим үгийг унших оролдлого хийжээ.

1970-аад оны дундуур профессор Чингэлтэйн удирдсан хитан бичигийн дурсхал судалах эрдэмтэдийн баг байгуулагдаж, юуны өмнө хитад, хитан хоёр хэлээр бичсэн дурсхалууд дахь зарим тусхай нэр, цаг улиралын нэр, тооны нэр зэрэгийг харьцуулан үзээд хитан үсэгийн бичлэгийн тогтолцоо, илэрхийлэх утга, авианы дуудлага зэрэгийг баримжаалан тогтоох илүү тохиромжтой аргазүй боловсруулжээ. Тус багийнхан харьцангуй богино хугацаанд 370 гаруй тэмдэгтээр бичсэн 9500 гаруй үг бүхий 9 томоохон дурсхалын дотороос 130 гаруй үгийн дуудлага, 300 орчим үгийн утгыг тогтоосоноос[277] гадна эдүгээ олдоод байгаа хитан бичигийн дурсхалуудын гэрэл зурагийн эмхэдхэл эрхэлэн хэвлүүлжээ.[278] Мөн профессор Чингэлтэй хитан бичигийн судалгааны тойм болон сүүлийн үеийн судалгааны тухай хэд хэдэн тойм үгүүлэл[279] бичсэнээс гадна *'Хитан бага бичигийг тайлан унших уй'* гэсэн томоохон бүтээлээ 2002 онд Японд хэвлүүлсэн гарсан байна.[280] Сүүлийн үеийн байдалаар 26500 гаруй тэмдэгт бүхий 22 дурсхалын дотороос 100 орчим үгийн авианы дуудлага болон 150 орчим үгийн утгыг баримжаалан тодорхойлжээ. Хитан бичигийн судалалын сүүлийн үеийн ололт нь хитанчуудын хэл аялгууны тогтолцоо, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэрийг

---

275 Л. Н. Рудов, Проблемы киданьской письменности, СЭ 1, 1963, 94

276 Э. В. Шавкунов, К вопросу о расшифровке малой Кидань-чжурчженьской письменности, *Эпиграфика Востока,* XV, 1963, 149-153

277 Research Team for Kidan Studies, Special Issue for the Study of Kitan Small Characters, Research Journal of Inner Mongolia University, No 4, 1997 (хитад хэлээр); Wang Hongli, Researches on the Tomb Inscriptions in Small Kitan Script, MYu, 4, 1986 (хитад хэлээр); Gao Lujia, Researches on the Plural Markers of Kitan Small Characters, *Research Journal of Inner Mongolia University,* No 2, 1988 (хитад хэлээр); Han Baoxing, Textual Research on an Inscription in Chitan Small Characters Discovered on a Memorial Tablet within Yelü Renxian's Tomb. (хитад хэлээр); Chen Naixiong, Yang jiye, Örgental-a daki Liyou ulus-un dörbedüger bulasin-ača oldaγsan kidan baγ-a üsüg-ün kösiyen bičigesü-yi sudulun tayilburilaqu ni, (Olan ulus-un mongγolči erdemted-ün doluduγar yeke qural-un ügülel)

278 Chinggeltei, Liu Fengzhu, Chen Naixiung, Yu Baolin, Xing Fuli, Studies on the Kitan Small Scripts, *Publishing House of Social Sciences of China,* Beijing, 1985, 799 pp. (хитад хэлээр)

279 Чингэлтэй, Хитан үсэгийн судалгааны шинэ байдал, ÖMYS 3, 1987, 106-132; *idem.* A Study of the Small Khitan Characters, *A Collection of Papers on Language and Script,* Huhhot, 1997, 664-701; Pronouncition of the Twelve Year's Names in Lunar Calendar, *idem.* 702-724; Verbal Suffixes in Small Kitan Script, *idem.* 725-740; On the Problems of Reading Kitan Characters, AOH 55, 2002, 99-114

280 Chinggeltei, The Decipherment of Kitan Small Letter), *Institute for the Study of Languages & Cultures of Asia & Africa,* Tokyo University of Foreign Studies, Tokyo, 2002, 1-164 + 1-258 (хитад хэлээр)

баримжаалан тогтоох нөхцөл боломж бүрдүүлэхийн үндэс суурь нь болно гэж монгол судалаачид итгэж байна.

0.3.1.2 СОГД-УЙГУРЫН ГАРАЛТАЙ ҮСЭГ БИЧИГ

0.3.2.2.1 УЙГУРЖИН МОНГОЛ БИЧИГ, ТҮҮНИЙ СУДАЛГАА

§ 48. **Уйгуржин монгол бичигийн тухай товч**. Монголчуудаас олон зуун жилийн турш хэрэглэж ирсэн янз бүрийн тогтолцоотой үсэг бичигийн дотороос жинхэнэ монгол үндэстэний бичиг болтолоо хэвшин тогтсон үсэг бичиг нь гагцхүү согд-уйгураас гаралтай монгол бичиг юм.

Монголчууд уулаас ганцхан эгшиг, арван гурван гийгүүлэгч бүхий уйгур үсэгийг хэл аялгууныхаа онцлог шинж, авианы бүрэлдэхүүнд зохицуулан олон шинэ үсэг нэмэн зохиож, туршин хэрэглэсээр XIII зууны үед монгол хэлний 100 авиа тэмдэглэх 44 үсэг зохион хэрэглэж байсаныг Сажа бандида Гунгаа-жалцангийн *'Зүрхний тольт'*-ын тухай түүхэн сурвалж бичигийн мэдээнээс тоймлон мэдэж болно. Түүнчилэн XIV зууны эхээр нэрт хэл зүйч эрдэмтэн Чойжи-Одсэр *'Зүрхний тольтын тайлбар'* (1305) хэмээх хэл зүйн бичигтээ 7 үндэсэн эгшиг, 17 гийгүүлэгч болон бусад зарим үл хувилах үсэгийн хамт нийт 123 үсэгтэй уйгуржин монгол бичигийн зөв бичих дүрэмийг боловсоруулсан гэдэгийг XVIII зууны үед равжамба Данзандагвын *'Огторгуйн маань'* хэмээх зохиолоос тодорхой мэдэж болно. Монголчууд тийнхүү уйгур үсэгийг хэл аялгуундаа тохируулан нэмэн засч, бичлэгийн дүрэм зүй боловсоруулан хэрэглэж ирэхдээ XVI-XVII зууны үе хүртэл түүний үсэгийн тигийг их төлөв хэвээр нь хадгалж иржээ. Тийм учираас монгол хэлний судалалд XVI-XVII зууны үеэс өмнөх үеийн монгол бичигийг *'уйгуржин монгол бичиг'*, түүнээс хойшхи үеийг *'монгол бичиг'* хэмээн ялган нэрлэж заншсан билээ.

§ 49. **Уйгуржин монгол үсэгийн судалгааны тойм**. Монголчуудын үсэг бичигийн хэрэгцээ, шаардлагыг олон зуун жил хагасаар ирсэн монгол бичигийг хэзээ, хаанаас, хэрхэн авсан тухай асуудал эрдэмтэдийн анхааралыг татсаар иржээ. Монголчууд анх хэдийд уйгур бичигийг авч хэрэглэсэн тухай асуудалд эрдэмтэд анхааралаа хандуулсаар ирсэн боловч бүрэн нэгдэлтэй болж чадаагүй байна. Оросын эрдэмтэн А. Позднеев *'Монгол утга зохиолын түүхийн лекцүүд'* хэмээх бүтээлдээ: *'Монголчууд өөрсдийн үсэг бичигээ XIII зууны эхээр болов-соруулсан бөгөөд түүнээс өмнө уйгур бичигийг ямар ч нэмэлт өөрчилөлтгүй, тэр хэвээр нь хэрэглэж байсан'* гэжээ.[281] Мөн германы эрдэмтэн B. Laufer *'Монгол утга зохиолын тойм'* хэмээх бүтээлдээ: *'Монголчууд Чингис хааны үед уйгур үсэгийг зээлдэн хэрэглэж байгаад Хубилай хааны үед дөрвөлжин үсэг зохиосон учираас түр зуур орхиж байгаад Хайсанхөлөг хааны үеэс дахин хэрэглэх болсон'* гэжээ.[282] Түүнчилэн академич Б. Я. Владимирцов, Цэвэгийн Гомбожав, С. А. Козин нар ч мөн дээрхитэй

---

[281] А. М. Позднеев, Лекции по истории монгольской литературы, т. I, 33

[282] Б. Лауфер, Б. Очерk монгольской литературы, Лгр., 1927, 19, 21

адилавтар саналтай байжээ.[283] Тийнхүү уйгуржин монгол үсэгийн гаралыг XIII зуунтай холбон үзэж байгаа нь нэг талаас, монгол бичигийн хамагийн эртний дурсхал бүтээгдсэн он цагтай, нөгөө талаас, Найманы Тататунгаагаар бичиг заалгасан тухай нэгэн домогийн үгүүлэмжтэй холбоотой байж болох юм.

Профессор G. J. Ramstedt монгол бичигийн хэлний хувьсан хөгжиж ирсэн ерөнхий зүй тогтолыг харгалзан үзээд *'Миний бодоход, сири-уйгурын цагаан толгойг Чингис хаанаас бүр өмнө хэрэглэж байсан гэдэгийг баталж болно.'* гэж тэмдэглэсэн нь[284] монголчууд уйгур бичигийг XIII-XIV зуунаас бүр өмнө авч хэрэглэсэн гэж үзсэн хэрэг юм. Хожим академич Б. Ринчен монголчууд уйгурын бичигийг авч хэрэглэсэн цаг хугацааг тухайн үеийн түүхэн нөхцөл байдалтай уялдуулан авч үзээд: *'Уйгурын туйлын мандаж байсан VIII зууны үеэс монголчууд уйгурын үсэгийг авч, монгол үгээ тэмдэглэсэн байна'*[285] гэж тэмдэглэсэн нь байна. Түүний дараа академич Ш. Лувсанвандан тэрхүү түүхэн цаг хугацааг *'Монголчууд XIII зуунаас хэдэн зуун жилийн өмнө уйгурын үсгийг хэл аялгуундаа тохируулан хэрэглэсээр ирсэн бөгөөд хожим түүнийг Гунгаажалцан эмхэтгэн, монгол үсгийн сурах бичиг зохиосон'*[286] гэж тодорхойл-жээ.

Тухайн үеийн түүхэн нөхцөл байдалыг харгалзан үзвэл, нийтийн тоололын VIII-IX зууны үед одоогийн монгол нутаг дээр хүчирхэгжин хөгжиж байсан Уйгурын хаант улсын үед тэдний хэрэглэж байсан үсэг бичигийг монголчууд авч хэрэглэсэн гэж үзэх үнэнд илүү ойр болно. XIII-XIV зууны үеэс уламжилан үлдсэн уйгуржин монгол бичигийн дурсхалуудын хэл нь анх бүтээгдсэн цаг үеэсээ нилээд өмнөх үеийн шинжийг тусхаж байгаа нь цаг хугацааныхаа хувид IX-X зууны үеийн монгол хэлийг тусхасан гэж үзэх бүрэн боломжтой. Эдүгээ бидний үед уламжилан үлдсэн уйгуржин бичигийн дурсхалууд нь бүтээгдсэн цаг үеийнхээ хувид XIII-XIV зууны үед холбогдох боловч түүний хэлний шинж нь мөн XIII-XIV зуунаас уламжилан үлдсэн хитад, дөрвөлжин, араб үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсхалуудаас нилээд өмнөх үеийн хэлний шинжийг тусхасан байгаа нь монгол бичигийн хэл XIII-XIV зуунаас бүр өмнө бүрэлдэн тогтсон болохыг гэрчилж байгаа хэрэг. Хэрэв монголчууд уйгур үсэгийг XIII зууны үед авсан бол түүний хэлний шинж нь хитад, дөрвөлжин, араб үсэгийн дурсхалуудын хэлтэй яг тохирч байх ёстой билээ.

---

283 Б. Я. Владимирцов, О трёх периодах монгольского письменного языка, *'Монголь-ский сборник рассказов из Pancatantra',* 1921, 42; Г. Цыбиков, Монгольская письменность как орудие национальной культуры, 1928, 4-5; С. А. Козин, Очерк развития письменности и литературы монгольских народов (XIII-XIV вв), *Джангариада,* М., 1940, 12

284 Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, 1908, 3

285 Б. Ринчен, Монгол үсэгийн гарал, хөгжил, 34

286 Ш. Лувсанвандан, Эртний монгол хэлний фонемын систем, МС 5, 1965, 19

Монголчууд үсэг бичигээ уйгураас авсан тухайд эрдэмтэдийн санал бараг нэгдмэл[287] байгаа бөгөөд монголчууд, уйгурчуудын аль аль нь согдын бичигийг нэгэн зэрэг авсан байж ч магадгүй гэсэн санал ч бас бий.[288] Уйгурууд анх араб үсэг хэрэглэж байсанаа манай эриний V зууны үед согд үсэгийг авч хэрэглэсэн[289] бөгөөд түүнийг хэл аялгуундаа тохируулан зассаар VIII-IX зууны үе болж ирэхэд тэд ихээхэн боловсоронгуй үсэг бичигтэй болчихсон байжээ. Монголчууд яг тэр үед нь уйгур бичигийг авсан гэдэг нь цаг хугацааны хувид хамагийн боломжтой. Дээр дурдсанаас гадна монгол бичигийг хитаны бага бичигээр дамжиж ирсэн байж магадгүй гэсэн өвөрмөц таамаглал ч бас бий.[290]

Уйгуржин монгол бичигийн үсэгийн бүрэлдэхүүн хийгээд бичлэгийн онцлогийн тухай асуудал ч бас эрдэмтэдийн анхааралыг татсаар иржээ. Академич Б. Я. Владимирцов *'Монгол бичигийн хэлийг халхын аман аялгуутай харьцуулсан хэлний зүй'* (1929) хэмээх алдарт бүтээлдээ монгол бичигийн үсэгийн бүрэлдэхүүн хийгээд бичигийн дурсхалуудад тохиолддог эртний хэлбэрүүдийг тохиолдох байрлал хийгээд үндэсэн дуудлагынх нь хамт тусхай хүснэгтээр харьцуулан үзүүлсэн нь монгол бичигийн үсэг зүйн талаар гарсан анхны нарийн тогтолцоотой судалгаа юм.[291] Хожим профессор Н. Поппе *'Монгол бичигийн хэлний зүй'* гэдэг номдоо монгол бичигийн үсэг тус бүрийн хэлбэр, хувилбар, байрлал, дуудлага зэрэгийг нилээд тодорхой дурдсан бий.[292] Мөн профессор G. Kara 1970-аад оны эхээр нийтлүүлсэн *'Нүүдэлчин монголчуудын ном'* бүтээлдээ уйгуржин монгол үсэгийг махбодоор задлаад, махбод тус бүрийн хэлбэр дүрс, нийлмэл бүтэцтэй үсэгүүд хийгээд тэдгээрийн байрлал, түүнчилэн XIII-XIV зууны үеэс уламжилан үлдсэн барын болон гар бичмэл дурсхалууд дахь уйгуржин монгол үсэгийн тигүүд, мөн монгол галиг хийгээд эвхмэл үсэгийн тигийн талаар маш тодорхой тэмдэглэсэн билээ.[293] Монголчуудын үсэг бичигийн түүхийг тусхайлан судалсан профессор Ц. Шагдарсүрэн *'Монгол- чуудын үсэг бичигийн товчоон'* хэмээх

---

287 А. М. Позднеев, Лекции по истории монгольской литературы, 33; Б. Лауфер, Очерк монгольской литературы, Лгр., 1927, 19; Г. И. Рамстедт, Uyiγur ulus-un quriyangγui teüke, Neyislel Küriy-e, 1922, 21; Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 19-20; N. Poppe, Introduction to Altaic Linguistics, Wiesbaden, 1965, 13, 65; Б. Ринчен, Монгол үсэгийн гарал, хөгжил, *'Монгол түүх, хэлбичиг'*, Хөххот, 1958, 6-19; Ш. Лувсанвандан, Эртний монгол хэлний фонемын систем, МС 5, 1965, 19-р тал

288 Ц. Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон, 1991, 25-56

289 А. Махмутов, Как возник древнетюркский алфавит, *'Исследование тюркологии'*, Алма-Ата, 1969, стр. 142

290 Л. Лигети, Рец. на кн: Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, 1953, ВЯ 5, 1955, 135

291 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 1929, 71-84

292 Н. Поппе, Грамматика письменно-монгольского языка, 1938, 25-37; Grammar of Written Mongolian, Wiesbaden, 1954, 17-36

293 Г. Кара, Книги монгольских кочевников (семь веков монгольской письменности), М., 1972, 40-68; G. Kara, Books of the Mongolian Nomads. More than Eight Centuries of Writing Mongolian, Bloomington, 2005, 79-162

бүтээлдээ монгол үсэгийн махбодуудын хэлбэр дүрс, хувилбар үсэг, уламжилалт нэрлэлт, тохиолдох байр, гүйцэдхэх үүрэг зэрэгийг нарийн ялган гаргажээ.[294]

Монгол бичиг нь зөвхөн нийт монгол угсаатаны хэмжээгээр зогсохгүй, нэгэн үе олон үндэстэнээс бүрдсэн Их Юань гүрэний төрийн албан ёсны хэлний үүрэгийг гүйцэдхэж байсан гэж үзэж болно. Тухайлвал, Юань гүрэний үеийн их хаадаас Ромын католик шашины тэргүүн хамба пап дөрөвдүгээр Николай, наймдугаар Бонифаци, францын хаан Гоо Филипп болон католик шашины элч нарт илгээж байсан удаа дараагийн захидалууд цөм монгол хэлээр бичсэн байгаа билээ.

XVI-XVII зууны үеэс бүддийн шашины Монгол оронд гуравдахь удаагаа хүчтэй дэлгэрч, бурханы шашины сургаал номлол, бүддийн гүн ухааны онолын зохиолуудыг орчуулан хэвлэх ажил өргөжихийн хэрээр санскрит, төвд хэлний олон зуун үг, нэр томъёо нэвтэрэн орж, уламаар тэдгээрийг нарийн зөв буулган тэмдэглэх бодит шаардлага тулгарчээ. Анхнаасаа зөвхөн монгол хэлний үг, авиаг тэмдэглэхэд зориулан боловсоруулан уйгуржин монгол бичигийн 123 үсэг нь санскрит, төвд хэлний үг хэллэг, нэр томъёонуудыг нарийн зөв тэмдэглэхэд хүрэлцэхгүй болсон учир монгол бичигийн үсэгийн бүрэлдэхүүнийг нэмэн дэлгэрүүлэх бодит шаардлага гарч ирсэн байна. Тухайлвал, уйгуржин монгол бичигт үгийн тэргүүн бус үед орсон ***o, u, ö, ü*** зэрэг дөрвөн эгшиг, үгийн дунд орсон хамжин шүргэх ***ǰ*** , ***č*** зэрэгийг адил дүрсээр тэмдэглэдэг учир санскрит, төвд хэлний үгийн дунд, адагт орсон ***o, u***эгшиг болон ***tsa, tsha, dsa*** авиаг ялган тэмдэглэх боломжгүй байжээ. Түүнчилэн хөөмийн шүргэх ***h*** гийгүүлэгчийг тусхайлан тэмдэглэх үсэггүй байжээ. Тийм учираас Харчины Аюуш гүүш энэхүү бэрхшээлийг шийдвэрлэхийн тулэртний энэдхэгийн *'али гали'* хэмээх галиг үсэгийн зарчим дээр тулгуурлан шинэ галиг үсэг боловсоруулжээ. Тэрвээр цоо шинэ үсэг тэмдэгт зохиосонгүй, санскрит хэлний үгийг нарийн зөв тэмдэглэж чаддаг төвд үсэгийн дуудлагыг харгалзан сонгож, тэдгээрийн дүрсийг босоо бичдэг монгол бичигийн тогтолцоонд маш чадмагаар тохируулан өөрчилж, санскрит үсэгийн тогтсон дараалалыг баримталсан урт, богино 10 эгшиг үсэг, эгшигээр амилсан 40 үе үсэг зохиожээ. Энэхүү галиг үсэг нь биеэ даасан үсэг бичиг биш, зөвхөн монгол бичигийн үсэгийн бүрэлдэхүүнийг өргөдхөсөн нэмэлт шинжтэй боловч монгол бичигийн авиа тэмдэглэх чадавхийг үлэмжхэн нэмэгдүүлж чадсанаараа нэн чухал ач холбогдолтой юм.

Аюуш гүүшийн боловсоруулсан галиг үсэгийн ач холбогдолын талаар академич Б. Ринчен: *'Монгол үсэгт эл галиг үсэг нэмэн зохиосноор даруй шинжлэх ухааны нарийн тэмдэглэл хийх үсэг бүрдэж Аюуш гүүшийн зохиосон галиг үсгээр энэдхэг, төвд үсгийг нарийн тэмдэглэх болсон нь хойно Европын энэдхэгч, төвдчийн зохион боловсруулж латин галиг хийсэнтэй зарчим ив ижил. Энэдхэг, төвд үсгээр бичсэн зүйлийг Аюуш гүүшийн галигаар тэмдэглэх нь европын латин галигаар тэмдэглэх лүгээ ширхэгийн ч зөрөөгүй... XVI зууны үеийн хэл шинжлэлтэн*

[294] Ц. Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, Уб., 2001, 29-38

Аюуш гүүш европ нөхдөөсөө бараг хоёр зуугаад жилийн өмнө тэдний галиглах зарчмыг монгол үсэгтээ хэрэглэсэн байнам' гэжээ.[295]

Аюуш гүүш монгол галиг үсэг зохиогоод түүнийгээ хэрэглэх анхны туршилт болгож *'Банзрагч'* сударыг дахин орчуулж, түүнд гардаг санскрит, төвд үгсийг шинэ дутам зохиосон галиг үсэгээр буулгасан нь амжилттай болж, уламаар XVIIзууны үед *'Ганжуур', 'Данжуур'* тэргүүтэн олон зуун их хөлгөн сударыг орчуулахдаа уул галиг үсэгээ өргөн хэрэглэсэнээр монгол бичигийн хэлний харь хэлний үгийг нарийн зөв тэмдэглэх тогтолцоо бүрджээ. Монгол галиг үсэгээр зөвхөн энэдхэг, төвд төдийгүй, хитад, манж хэлний үгсийг ч бүрэн зөв буулгах боломжтой болсон тухай профессор Г. Кара онцлон дурдсан бий.[296] Аюуш гүүшийн боловсоруулсан галиг үсэгийн талаар Ц. Шагдарсүрэн, Боушиан, Тулгуур, Л. Чулуунбаатар нар тодорхой дурдсанаас[297] гадна түүний гарал үүсэл, үсэг зүйн тогтолцоо, төвд, санскрит үгийг бичиж тэмдэглэх тухай өргөн хүрээтэй асуудлыг багтаасан томоохон бүтээлийг Өвөр Монголын эрдэмтэн Цагаансар гаргасан байна.[298]

Таширамд тэмдэглэхэд, бичиг үсэгийн тухай манай зарим ном зохиолд энэхүү галиг үсэгийг Аюуш гүүшийн зохиосон *'Али галиг үсэг'* хэмээн нэрлэсэн нь цөөнгүй. Гэвч Аюуш гүүш *'Али галиг үсэг'*-ийг шинээр зохиосон биш, эртний энэдхэгээс уламжилалтай *'Али гали'* хэмээх галиг үсэгийн арга зарчим дээр тулгуурласан *'монгол галиг үсэг'* боловсоруулсан гэдэгийг өмнө дурдсан билээ. Ер *'Али гали'* гэсэн нь *'А тэргүүтэн арван зургаан эгшиг, ГА тэргүүтэн гучин дөрвөн үсэг'* гэсэнийг хураангуйлсан үсэг зүйн нэр томъёо юм.[299]

0.3.1.2.2 ТОД БИЧИГ, ТҮҮНИЙ СУДАЛГАА

§ 50. **Тод бичигийн тухай товч.** Уйгуржин монгол бичиг хэвшин тогтсоноос минга шахам жилийн дарааойрд Зая бандида Намхайжамц (*Nam-mkha'i rgya-mtsho*)/1559-1652/ монгол үсэгийг тухайн үеийн хэл аялгуундаа ойртуулан нэмэж зассан нь монгол бичиг соёлын түүхэнд *'тод үсэг'* хэмээх нэрлэгдсээр ирсэн билээ.

Тод бичиг нь зохиогдсон цаг үеэсээ эхлээд Хөхнуурын өндөрлөг дэх Хошууд, Зүүнгарын хаант улс, Европт шилжин суурьшсан торгуудуудын дунд төрийн бичигийн хэмжээнд хэрэглэгдэж байжээ. Тийм ч учираас ойрдын ноёдуудаас оросын муж хизгаарын дарга нараас аваад оросын цагаан хаанд хүртэл тод үсэгээр

---

295 Б. Ринчен, Монгол үсэгийн гарал, хөгжил, 99

296 Г. Кара, Книги монгольских кочевников, 72-77

297 Ц. Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон, 227-239; Боушиан, Mongγol üseg bičig-ün uqaγan, Хөххот, 1984, 92-103; Тулгуур, Mongγol üsüg bičig-ün teüken toyimu, ÖMSKQ, Kökeqota, 1998, 198-228; Л. Чулуунбаатар, Монгол галиг үсэг хийгээд төвд үсэг, *'Төв Азийн нүүдэлчидийн бичиг үсэгийн товчоон',* Уб., 2001, 237-248, *idem.* Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл, 2002, 147-158

298 Цагаансар, Али гали үсгийн судалгаа {= *Corpus Scriptorum* t. IV}, 2005, 1-55 + 161

299 R. A. Miller, Buddhist Hybrid Sanskrit *āli, kāli* as Grammatical Terms in Tibet, HJAS 26, 1966, 125-147

бичсэн захиа илгээж байсанаас гадна тамга тэмдэг, зоосон мөнгө, гэрэлт хөшөөний бичээс зэрэгийг тод үсэгээр бичиж байжээ.

Эдүгээ бидний үед уламжилан үлдсэн тод үсэгийн дурсхалуудаас ажиглавал, бурханы шашины сургаал номлол, бүддийн гүн ухааны зохиол бүтээл, ойрдын түүх, хууль цааз, төрөл бүрийн мэдлэг ухаан, албан бичиг захидал зэрэг үлэмж олон төрөлийн ном зохиолууд бичигджээ. Түүний дотор тод үсэгийг зохиогч Намхайжамц Монгол оронд бурханы шашин дэлгэрүүлэх үйлсэд ихээхэн хүчин зүдхэсэн төдийгүй түүний орчуулсан 170 гаруй зохиолын дотор бурханы шашины сургаал номлол, бүддийн гүн ухааны зохиол бүтээл *'Алтан гэрэл', 'Найман минган шүлэгт', 'Ихэд тонилгогч'* зэрэг олон зохиол багтжээ. Түүнчилэн Зая бандидагийн орчуулсан бүтээлүүдийн дотор зурхайн ухаан, анагаах ухаан, уран зохиол зэрэг өөр олон салбарын ном зохиол багтжээ. Эдүгээ тэдгээр орчуулсан бүтээлүүдээс 60 орчим нь уламжилан үлдсэн бололтой.

Ер эдүгээ хүртэл уламжилан үлдсэн тод бичигийн дурсхалуудаас үзвэл, тэр нь монгол бичигийн нэгэн адил эхэн, дунд, адагт орох гурван хувилбар бүхий 7 эгшиг үсэг, 19 гийгүүлэгчтэйгээс гадна санскрит, төвд хэлний үгсийг бичихэд монгол галиг үсэгийн хувилбаруудыг хэрэглэсээр иржээ.

§ 51. **Тод үсэгийн судалгааны тойм**. Тод бичигийн дурсхалуудын хэл нь дундад үеийн монгол хэлний сүүлч, орчин үеийн монгол хэлний эхэн үеийн зааг дахь онцлог шинжийг тусхасан учир тод үсэгийн бичлэгийг авианы бүтэц, бүрэлдэхүүн, үг, морфемийн бүтэцийн талаас судалах нь нэг талаас, сонгодог монгол бичигийн хэлний онцлогтой, нөгөө талаас, XVII зууны монгол хэлний онцлог шинжтэй шууд холбогдох нэн чухал асуудал юм.

Тод бичигийн талаар гарсан судалгаануудыг ерөнхийд нь ажиглавал, тод бичигийг зохиосон шалтгаан, түүний үүрэг, ач холбогдол, тод бичигийн суурь аялгуу болон үсэг зүйн онцлог шинж зэрэг олон талаас нь судалсан байна. Тэдгээрийн талаар товч тоймлон дурдвал, олон зуун жилийн уламжилалтай монгол бичиг байсаар байтал *'тод үсэг'*-ийг шинээр зохион хэрэглэх болсон учир шалтгааны тухай асуудал эрдэмтэдийн анхааралыг татсаар иржээ. Энэ асуудалыг зарим эрдэмтэн бичигийн хэлний хөгжилтэй, зарим нь хэл аялгууны онцлог шинжтэй, бас зарим нь тухайн үеийн улс төрийн нөхцөл байдалтай холбон авч үзсэн байна. Тухайлвал, академич С. Козин монгол бичигийн хэлийг улам боловсронгуй болгохын тул тод үсэгийг зохиосон гэж үзсэн[300] бол проф. N. Poppe *'Монгол бичигийн хэл, халимаг ярианы хэл хоёр нь ихээхэн ялгаатай болсон байжээ. Тийм учираас Зая бандида бурханы шашин, гүн ухаан хийгээд уран зохиолын ном зохиолуудыг орчуулан гаргахыг зорьж... уламаар ард олондоо шинэ үсэг зохиохоор шийджээ'*[301] гэж тэмдэглэсэн байна. Мөн халимагийн эрдэмтэн Д.

---

300 С. А. Козин, *Гэсэриада*. Сказание о милостивом Гэсэр Мерген хане искоренителе десяти странах света, 1937, стр. 13

301 Н. Поппе, Роль Зая-пандиты в культурной истории монгольских народов, *Kalmyk-Oirat Symposium,* 1966, pp. 63-64

А. Павлов *'Зүүнгарын хаант улс байгуулагдах үед нийт ойрдын нийгэмийн амьдаралын олон талт хэрэгцээг хангаж чадахуйц шинэ үсэг бичиг шаардлагатай болжээ. ...Монгол бичигийн хэл нь аман яриандаасаа ихээхэн холдсон нь Зая Бандидагийн шинэ үсэг зохиох гол шалтгаан болжээ'*[302] хэмээн дурджээ. Харин академич Б. Ринчен *'Манжийн эрхшээлээс дөрвөн ойрдыг тусхаар улс болгож, уламаар тэднийг өөр хооронд нь үсэг бичигийн талаар нэгэдхэн холбохын үүднээс тод үсэгийг зохиосон'*[303] гэж тэмдэглэжээ. Халимагийн эрдэмтэн А. В. Бадмаев ч мөн дээрхийн адил саналтай байна.[304] Тод үсэгтэй холбоотой өөр нэг асуудал бол түүний статусын тухай юм. Тодоруулж хэлвэл, тод үсэг нь уулаасаа биеэ даасан бичиг үү, эсвэл монгол бичигийн хувилбар уу гэдэг асуудал юм. Академич Б. Ринчен *'Зая бандида тод үсэг хэмээх ойрд үсэг зохиосон нь монгол үсгийн нэгэн хувилбар юм'*[305] гэж үзсэн бол Х. Лувсанбалдан *'Зая бандида бурхны ном зохиолыг орчуулан монгол бичгээр буулгаж эхэлтэл тэр нь амьд ярианы хэлнээсээ ихэд зөрөөтэй байсан учраас монгол бичгийг ярианы хэлэнд ойртуулан, тодорхой болгон засварласан'*[306] гэж тэмдэглэжээ. Мөн Б. Я. Владимирцов, Г. Д. Санжеев, N. Ропре, Ш. Лувсан-вандан, Д. А. Павлов нарын зэрэг эрдэмтэд цөм тод үсэгийг монгол үсэгийн цагаан толгой дээр үндэслэн зохиосон ойрд шинэ цагаан толгой гэж үзсэн байна.[307] Дээрхи саналуудаас үзвэл, түүнийг биеэ даасан бичиг гэж шууд дүгнэсэнгүй, харин ойрд аялгуутанд үйлчилэх шинэ бичигийн хэл гэдэг талаас нь голлон авч үзсэн байна. Өөрөөр хэлвэл, *'тод үсэг'* нь хэдийгээр ойрд хэл аялгуун дээр түшиглэсэн бичигийн хэлний үүрэг гүйцэдхэж байсан ч нийт монголчуудын хувид биеэ даасан бичиг үсэг хараахан биш гэдэгийг судалаачид харгалзсан байна. Бодит байдал дээр авч үзвэл, Зая бандида цоо шинэ үсэгийг зохиосон бус, харин амьд ярианы хэлнээсээ холдсон монгол бичигийг хэл аялгуундаа ойртуулан нэмэж зассан хувилбар шинжтэй үсэг боловч монгол-чуудын бичиг соёлын түүхэнд түүний эзлэх байр суурь, ач холбогдол нь нэн их билээ. Тод үсэгийг зохиогчийн бичсэн *'Үзэгийн найрлага оршивой'* гэсэн судартаа *'Омог* (ойрд, ар монголыг хамтад нь багтаасан нэр) *монгол улсын хувьтанд хилбар болгохын тул олон адил дүрстэй үзэг* (үсэг)*-үүдийг онц тус бүр ангид хольцонгуй гийгүүлэн'* гэж дурдсанаас үзвэл уг бичигийг анх зохиохдоо зөвхөн ойрд аялгуутан төдийгүй, халх зэрэг бусад аялгуутаныг ч гэсэн багтаасан болох нь тодорхой байна.

---

302 Д. А. Павлов, К вопросу о создании *тодо бичиг,* Зап. Научн. Тр. Исслед. Ин-та, Язык Литературы и Истории, Вып. 2, 1962, стр. 111-112

303 Б. Ринчен, Тод монгол бичиг, түүний соёлын ач холбогдол, МС VIII, 1971, 293

304 А. В. Бадмаев, Роль Зая Пандиты в истории духовной культуры калмыцкого народа, 1968, 14-16

305 Б. Ринчен, Монгол үсэгийн гарал, хөгжил, 16

306 Х. Лувсанбалдан, Ойрдын Зая Бандидын орчуулгын тухай мэдээ, 94

307 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 25; Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, 32; Н. Поппе, Роль Зая-Пандиты в культурной истории монгольских народов, Н. Поппе, Роль Зая-Пандиты в культурной истории монгольских народов, 64; *idem.* Introduction to Altaic Linguistics, 18; Ш. Лувсанвандан, Кирил үсэг авсаны учир, 4; Д. А. Павлов, К вопросу о создании *тодо бичиг,* 111

Тод үсэгийн судалгаанд эрдэмтэдийн анхааралыг татсан өөр нэг асуудал бол түүний суурь аялгууны тухай асуудал юм. Энэ талаар эрдэмтэд өөр өөр саналтай байна. Тухайлвал, академич Б. Я. Владимирцов *'Зая бандида ойрд аялгуунд тулгуурлан нийт ойрдын бичгийн хэлийг үндэслэсэн'*[308] гэж тэмдэглэсэн бөгөөд хожим профессор Г. Д. Санжеев дээрхи саналыг дэмжин *'Зая бандида монгол үсэгт тулгуурлан ойрдын шинэ бичгийг зохиож, бие даасан ойрд бичгийн хэлний үндэсийг амжилттай тавьжээ. Ойрд шинэ цагаан толгойн үсэгүүд нь тэдний амьд ярианы хэлний бүх фонемийг тэмдэглэхэд бүрэн хүрэлцээтэй юм'*[309] хэмээн дурдсан байна. Түүнчилэн Б. Ринчен, Ш. Лувсанвандан, Д. А. Павлов нар ч дээрхи эрдэмтэдийн нэгэн адил саналтай байжээ.[310] Харин нэрт монголч N. Ропре тод бичгийг халхчуудын ярьдаг дорнод монголын аялгуун дээр тулгуурлан зохиосон гэж тэмдэглэсэн байна.[311] Мөн халимагийн эрдэмтэн А. В. Бадмаев тод үсэгийг анхнаасаа нийт монголчуудын бичиг үсэг болгох зорилготой зохиосон гэж үзээд, түүнийгээ доор дурдсан гурван үндэслэлээр тайлбарлажээ. Үүнд: <u>Нэгдүгээрт:</u> Зая бандида тод үсэгийг *'ойрд үсэг'* гэж нэрлээгүй, <u>хоёрдугаарт:</u> тод үсэгийн зөв бичих дүрэмд халх, ойрд аялгууг хамтадхан тусхасан, <u>гуравдугаарт:</u> Зая бандида өөрөө Чин улсын үед нийт монголчуудын нэгдэлийн төлөө эрмэлзэж байсан гэжээ.[312]

Тод үсэгийг ийнхүү монголчуудын бичиг соёлын түүхтэй холбон судалсанаас гадна түүний үсэгийн бүрэлдэхүүн хийгээд үсэгзүйн онцлог зэрэгийг ойрдаялгууны онцлог шинжтэй уялдуулан авч үзсэн ажиглалт, судалгаанууд бүр XIX зууны үеэс эхэлсэн гэж үзэж болно. Хамагийн анх А. А. Бобровников халимаг хэлний авианы шинжийг тод үсэг болон монгол бичигтэй харьцуулан үзсэн нь тод үсэгийн судалгааны эхлэл нь болжээ.[313]

Академич Б. Ринчен 1956 онд Унгарын ШУА-д хэл шинжилэлийн ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээлдээ тод үсэгийн цагаан толгой болон санскрит, төвд хэлний авиаг тэмдэглэх галиг үсэгийг дөрвөлжин үсэг, латин галигийн хамт хавсаргасан нь энэ талаар гарсан хамагийн анхны дэлгэрэнгүй материал юм.[314] Мөн монголын эрдэмтэн Х. Лувсанбалдан *'Тод үсэг, түүний дурсгалууд'* гэдэг номдоо тод үсэгийн үсэг зүйн онцлог шинж, үсэг тус бүрийн байр, хувилбар, урт, хос эгшиг болон энэдхэг, төвд хэлний авиа тэмдэглэх галиг үсэг зэрэгийг багтаасан

---

308 Б. Я. Владимирцов, Монгольская литература, Вып. II, 1920, 94

309 Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, 32-33

310 Б. Ринчен, Монгол үсэгийн гарал, хөгжил, 16; *idem.* Тод монгол бичиг, түүний соёлын ач холбогдол, 293; Ш. Лувсанвандан, Дөрвөлжин, тод үсгийн зөв бичих дүрэмд монгол хэлний урт эгшгийг тэмдэглэсэн нь, ХЗ VII, 1969, 106; Д. А. Павлов, К вопросу о создании *тодо бичиг,* 111; *idem.* Зая-пандита - создатель старо-калмыцкой письменности и калмыцкого литературного языка, в кн: *320 лет старокалмыцкой письменности,* 1970, 40-79

311 Н. Поппе, Об отношении ойратской письменности к калмыцкому языку, *'Kalmyk-Oirat Symposium',* Philadelphia, 1966, p. 191

312 А. В. Бадмаев, Роль Зая Пандиты в истории духовной культуры калмыцкого народа, 16

313 А. А. Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, 14-19

314 Б. Ринчен, Монгол хэлний зүйн бичиг, Уб., 2015, 72-84

байна.[315] Профессор Ц. Шагдарсүрэн *'Монгол үсэг бичгийн товчоон'* гэдэг бүтээлдээ тод үсэгийн цагаан толгойг хавсаргасанаас гадна тод үсэгийн махбод болон нэмэлт тэмдэгтүүд, үсэг тэмдэгтийн нэр томъёо зэрэгийг жагсааж тайлбарласан бий.[316] Тэдгээрээс гадна N. Ропре, G. Кага, Д. А. Павлов, Х. Лувсанбалдан нар тод бичигт монгол хэлний эгшиг, гийгүүлэгч авианууд, ялангуяа, уруулын эгшиг, урт болон хос эгшигийг хэрхэн тэмдэглэдэг тухай тодорхой дурдсан нь нэг талаар, үсэг зүйн судалгаа, нөгөө талаар, авиазүйн шинжтэй судалгаа болсон байна.[317] Далаад оны эхээр тод үсэг судалаач Г. Жамъян тод үсэгийн *'удаан'* хэмээгч тэмдэгийн үсэг зүй-авиа зүйн үүрэгийн талаар шинэлэг санал гаргасан нь тод үсэгийн дурсхалуудыг уншиж буулгах уламжилалт аргад зохих өөрчилөлт гаргаж чадсан билээ.[318] Тод үсэгийн *'удаан'* хэмээх тэмдэгийг зөвхөн өмнөх эгшигийнхээ уртыг ялган заах тэмдэг гэж үзсээр иржээ. Харин Г. Жамъян түүнийг богино эгшигийн дараа орсон ***ā, ē*** эгшигийг тэмдэглэдэг гэж үзсэнээс гадна тод үсэгийн ***оu, uu, öü, üü*** гэсэн цогц нь ганц урт эгшигийг тэмдэглэсэн биш, харин зөвхөн сүүлчийн ***u, ü*** нь л урт эгшигийг тэмдэглэдэг гэж үзжээ. Академич Ш. Лувсанвандан Жамъянгийн дэвшүүлсэн шинэлэг саналыг дэмжин: *'Ер нь хэлний өнгөрсөн үеийн дурсгалын зүйлийг галиглахдаа зөвхөн бичсэн үсгийнх нь хэмжээн дотор дотроос нь сэргээн босгох аргыг хэрэглэж, юуны өмнө тухайн үеийн авианы системийг бүхэлд нь сэргээн босгох зорилго тавих хэрэгтэй байна. ... Тод үсгийн зөв бичих дүрэмд эгшгийг тэмдэглэсэн систем нь дундад үеийн монгол хэлний эгшгийн системтэй их ойртох төдийгүй, эртний монгол хэлнийхтэй ямар нэгэн хэмжээгээр холбогдож байна.*[319] гэжээ.

0.3.1.2.3 ВАГИНДРАГИЙН ҮСЭГ, ТҮҮНИЙ СУДАЛГАА

§ 52. **Вагиндрагийн үсэгийн тухай товч**. Монгол үсэгээс салбарлан гарсан өөр нэг үсэг бол 1907 оны буриадын цанид хамба Агваандоржиев (1853-1938)-ын зохиосон шинэ үсэг юм. Тэрвээр Ази, Европын арав гаруй ороноор явж, дэлхийд алдартай олон том эрдэмтэдтэй холбоотой байсан сэхээтэн хүн юм. Монголчуудын олон зуун жил хэрэглэж ирсэн монгол бичигийн нилээд олон үсэг нь нэг ижил дүрсээр хэд хэдэн өөр авиаг тэмдэглэдэг учир сурахад бэрхшээлтэйгээс гадна ярианы хэлнээс ихээхэн зөрөөтэй болсон тул бичигийн хэлээ амьд хэл аялгуундаа ойртуулж, авиа тус бүрийг тодорхой ялган тусхасан үсэг тэмдэгттэй болгохын

---

315 Х. Лувсанбалдан, Тод үсэг, түүний дурсгалууд, Уб., 1975, 26-45

316 Ц. Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон, 119-126

317 Н. Поппе, Об отношении ойратской письменности к калмыцкому языку, Kalmyk-Oirat Symposium {= *Kalmyk Monograph Series* No 2}, Philadelpia, 1966, 194-203; Г. Кара, Книги монгольских кочевников (семь веков монгольской письменности), М., 1972, 80-83; Д. А. Павлов, К вопросу о создании *тодо бичиг,* Зап. Научн. Тр. Исслед. Ин-та, Язык Литературы и Истории, Вып. 2, 1962, стр. 111-112; Х. Лувсанбалдан, Тод үсэг, түүний дурсгалууд, 1975, 37-46

318 Г. Жамъян, Тод үсгийн зөв бичих дүрэмд урт эгшгийг тэмдэглэсэн тухай асуудалд, МС 7:20, 1969, 257-270; *idem.* Обозначение долгих гласных в ойратском ясном письме, НАА 5, 1970, 150-152

319 Ш. Лувсанвандан, Ойрдын тод үсгийн дурсгалын зүйлийг галиглах тухай асуудалд, МС 3:3, 1975, 37, 42-43

үүднээс тэрхүү шинэ үсэгийг боловсоруулжээ. Вагиндрагийн үсэгийн хэлбэр дүрс, үндэсэн бүрэлдэхүүн хийгээд ерөнхий тогтолцоог ажиглавал, нэг талаар, тод үсэгийн нөлөө, нөгөө талаар кирил үсэгийн тогтолцоог ашигласан болох нь тодорхой мэдэгддэг байна. Энэхүү үсэгийг Байгал нуурын хойд биеийн буриад аялгууг суурь болгон зохиосон гэж үздэг зарим судалаачид үздэг. Гэвч тэрвээр *'Шинэ, хуучин үсэгүүдийн ялгал тэргүүтэнийг бичсэн дэвтэр оршив'* гэдэг бүтээлдээ: *'Qamiγ-a γaǰar-un mongγol ulus-un kele dokiy-a üge-yi tere keb-iyer bičikü-dür masi kilbar bolai'*[320] гэж бичсэнээс үзвэл зөвхөн буриадын нэг аман аялгуу төдийгүй, аль ч аялгуутан хэрэглэж болохоор үсэг зохиосон бололтой. Зохиогчийнхоо номын нэрээр *'Вагиндрагийн үсэг'* хэмээн алдаршсан энэхүү бичиг нь 8 эгшиг, 28 гийгүүлэгч, 10 орчим цэг тэмдэгтэй байгаа бөгөөд тэдгээр нь үгийн аль ч үед хэлбэр дүрсээ өөрчилдөггүй тул сурахад хилбар болсон гэж зохиогч нь онцлон тэмдэглэсэн байна.[321] Шинээр зохиосон тэрхүү үсэгийг буриад даяар өргөн хэрэглүүлэхээр Петербург хотноо хорголжин барын үсэг цудхуулан, сургалтын цагаан толгой болон зүйр цэцэн үгс, онисхо таавар, явган үлгэр, бурхан багшийн сургаал зэрэг бэсрэг ном зохиол хэвлэж эхэлсэн байна. Тэгсэн хэдий ч дэлхийн нэгдүгээр дайн, дараа нь аравдугаар сарын хувисхал гэх мэт нийгэм, улс төрийн тогтворгүй нөхцөл байдал үүссэн учир уул бичигийг дэлгэрүүлэх таатай орчин нөхцөл бүрдсэнгүй.

§ 53. **Вагиндрагийн үсэгийн судалгааны тойм**. Вагиндрагийн үсэгийн талаар буриадын эрдэмтэн Н. Амагаев, Аламжи мэргэн нар анх танилцуулсан[322] бөгөөд хожим академич Б. Ринчен, Г. Кара нар уул үсэгийн талаар илүү дэлгэрэнгүй дурдсан бий.[323] Түүний дараа проф. Ц. Шагдарсүрэн монголчуудын үсэг бичигийн түүхийн тухай судалгаандаа Вагиндрагийн үсэгийн бүрэлдэхүүн хийгээд тэдгээрийн онцлогийн талаар илүү тодорхой тэмдэглэжээ.[324] Мөн монголчуудын үсэг бичигийн түүхийг тоймлон бичсэн Булаг, Боушиан, Тулгуур, Чулуунбаатар нар өмнөх эрдэмтэдийн бүтээлд тулгуурлан уул бичигийн талаар товч дурдсан бий.[325] Эрдэмтэн Г. Гантогтох Вагиндрагийн үсэгийг *'тод үсэг'*-тэй харьцуулсан сонирхолтой судалгаа хийсэнээс гадна уул үсэгийг зохиох болсон шалтгаан, түүний үсэгзүйн онцлог, холбон бичих арга, буриад аялгууг тусхасан байдал

---

320 Sine qaučin üsüg-üd-ün ilγal terigüten-i bičigsen debter orusiba, 7-р тал

321 *'deger-e dour-a oruqui-daγan dürsü qubilal-ün keb yangǰa-bar bičigdekü tula bilig kediü moquduγ bolbaču aqurqan čaγ-tu üsüg taniqu bolumui'* (Sine qaγučin üsüg-üd-ün ilγal terigüten-i bičigsen debter orusiba, 7-р тал)

322 Н. Амагаев, Аламжи-мэргэн, Новый монголо-бурятский алфавит, 1910, 3-55

323 Б. Ринчен, Монгол бичгийн хэлний зүй, 1-р дэвтэр, 1964, 171-177; Г. Кара, Книги монгольских кочевников, 95-98

324 Ц. Шагдарсүрэн, Монгол үсэг зүй, 115; *idem.* Монголчуудын утга соёлын товчоон, 1991, 126-128; Монголчуудын үсэг бичигийн товчоон, 175-177

325 Булаг, Mongγol üsüg bičig-ün tobči teüke, Kökeqota, 1983, 236, 238-239; Боушиан, Mongγol üsüg bičig-ün uqaγan, ÖMSKKQ, 1984, 178-180; Тулгуур, Mongγol üsüg bičig-ün teüken toyimu, ÖMSKKQ, Kökeqota, 1998, 248-254; Л. Чулуунбаатар, Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл, 2002, 188-193; Гарди, Dumdadu erten-ü mongγol kelen-ü sudulul, LÜKQ, 2001, 123-125, 135-157, 194-239; *idem.* Dumdadu erten-ü mongγol kelen-ü sudulul-un uduridqal, ÖMAKQ, Kökeqota, 2008, 105-190

хийгээд түүний цаашдын хувь заяаны талаар дэлгэрэнгүй дурдсан тусхай үгүүлэл нийтлүүлжээ.[326] Түүнчилэн тус үсэгийг зохиогчийн намтар түүх, үсэг зүйн онцлог шинжийн талаар хэл шинжээч эрдэмтэн Ё. Жанчив дэлгэрэнгүй дурдсан байна.[327]

0.3.1.3 ЭНЭДХЭГ-ТӨВД ГАРАЛТАЙ ҮСЭГ БИЧИГ
0.3.1.3.1 ДӨРВӨЛЖИН БИЧИГ, ТҮҮНИЙ СУДАЛГАА

§ 54. **Дөрвөлжин үсэгийн тухай товч**. Хубилай хаан хитад, жүрчин, монгол, уйгур, түрэг, төвд зэрэг нүүдэлийн болон суурин хэвшилийн олон соёлтой, бөөгийн мөргөл, күнзийн суртал, бомбын ёс, буддагийн сургаал, ислам, нестор зэрэг өөр өөр шашинтай олон угсаатаныг багтаасан их гүрэнийг байгуулаад, гүрэнийхээ дотор багтаж байсан олон угсаатаны хэл аялгууг адил тэгш тэмдэглэж чадах шинэ бичиг зохион хэрэглүүлэх төрийн бодлого болов-соруулжээ. Түүний тул их гүрэндээ багтаж байсан аль нэгэн үндэстэний бичиг үсэгийг тусхайлан сонгосонгүй, шинэ бичигийг зохион хэрэглэхийг зорьж, төвдийн эрдэмтэн Пагба лам Лодойжалцан (*'Phags-pa bLa-ma bLo-gros rgyal-mts'an*)/1235-1280/-д шинэ үсэг зохиохыг даалгажээ.

Пагба лам хөндлөн бичдэг төвд үсэгийн дүрсийг босоо бичдэг монгол үсэгийн тогтолцоотой хослуулан 8 эгшиг үсэг, 31 гийгүүлэгч үсэг, гадаад үгэнд хэрэглэдэг 2 хагас эгшиг бүхий нэгэн зүйлийн шинэ үсэг боловсоруулсан нь түүхэнд *'дөрвөлжин бичиг'* буюу *'Пагбагийн бичиг'* хэмээн алдаршжээ. Дөрвөлжин бичиг нь монгол бичигийн нэгэн адил босоо бичдэг, үсэгүүд нь үеэр тасарах бөгөөд ихэнхи үсэг нь баруун гар талаараа холбогддог байна.

Хубилай хаан шинэ дутам зохиосон дөрвөлжин бичигийг *'төрийн бичиг'* болгон тунхаглаж, Юань гүрэн даяар түгээн дэлгэрүүлэхийн тул дөрвөлжин бичигт сургах сургуулийг олоноор байгуулж, аливаа зарлиг тушаал, хууль цааз, пайз тамга зэрэгийг дөрвөлжин үсэгээр бичих, урид уйгуржин бичигээр бичсэн төрийн түүх, хууль цаазын бичиг зэрэгийг дөрвөлжин үсэгээр буулгах арга хэмжээ авчээ. Түүний үр дүнд Юань гүрэн оршин тогтоносон зуугаад жилийн хугацаанд дөрвөлжин бичигээр хаадын зарлиг, төрийн албан бичиг төдийгүй, бурханы шашины сургаал номлол, буддийн гүн ухааны зохиол бүтээлүүдийг дөрвөлжин бичигээр бичих байжээ.

Юань гүрэний үед идэвхитэй хэрэглэгдэж байсан дөрвөлжин бичиг нь их гүрэн задарсаны дараа уул их гүрэний дотор багтаж байсан аль ч үндэстэний бичиг үсэг болон үлдэж чадсангүй, нийтийн хэрэглээнээс аяндаа гарсан байна.

---

326 Г. Гантогтох, Vagindra-giyin üzüg kigēd todo üzüg-in düngcülül, *'Kele ba orčiγuly-a'*, Ürümči, 1991, No 3, 27-33; Вагиндра үсэг, *'Төв Азийн нүүдэлчдийн бичиг үсгийн товчоон'*, Уб., 2001, 307-328

327 Ё. Жанчив, Вагиндрын үсэг, АН VIII, 2007, 76-87; Вагиндра үсгийн дурсгалууд {= *Corpus Scriptorum* VIII}, Уб., 2010, 3-15

§ 55. **Дөрвөлжин бичигийн судалгааны тойм.** Монгол дөрвөлжин үсэгийн тогтолцоо нь бүхэлдээ дундад үеийн монгол хэлний үндэсэн шинжийг тусхасан үнэтэй чухал хэрэглэгдэхүүн мөний учир түүнийг нарийвчилан судалах нь монгол хэлний түүхэн судалалд нэн чухал ач холбогдолтой билээ.

XIX зууны үеэс эхлэн монгол дөрвөлжин бичигийн хөшөө чулууны бичээс, пайз тамганы бичигүүд шинээр олдсон нь өрнө дахины эрдэмтэдийн анхааралыг ихээхэн татаж, тул юуны өмнө, дөрвөлжин үсэг, түүний үсэг тэмдэгтүүдийг танилцуулсан нилээд судалгаа гарсан байна. Үүнтэй холбогдуулан H. C.Gabelentz,[328] J. Schmidt,[329] M. G. Pauthier,[330] А. М. Позднеев[331] нарын бүтээлийг дурдвал зохино.

XIII-XIV зууны үед монгол хэл аялгуунд сайтар хэвшин тогтсон уйгуржин монгол бичиг байсаар байтал дөрвөлжин үсэгийг шинээр зохион хэрэглэсэн тухай асуудал эрдэмтэдийн анхааралыг татсаар иржээ. Энэ талаар нэрт монголч А. М. Позднеев анх тэмдэглэхдээ: *'Хубилай хааны үед хуучин хэрэглэж байсан уйгуржин монгол бичгээс илүү сайн, нийт Юань гүрэний бичигийн хэрэгцээг хангаж чадахуйц тийм шинэ бичиг зохиох гэж оролдсон нь дөрвөлжин бичиг юм'* гэжээ.[332] Хожим Б. Я. Владимирцов *'Дөрвөлжин бичиг бол нийт Юань гүрэний дотор багтаж байсан олон угсаатаны хэлэнд тохирсон олон улсын бичиг'* хэмээн тодорхойлсон билээ.[333] Мөн С. А. Козин, Н. Поппе, Г. Д. Санжеев, Б. Ринчен нарын зэрэг эрдэмтэд дөрвөлжин бичигийг Юань гүрэний бичиг үсэгийн хэрэгцээнд зориулан зохиосон тухай тодорхой дурдсан бий.[334]

Нөгөө талаар, Юань гүрэн мөхсөний дараа дөрвөлжин бичиг нийтийн хэрэглээнээс гарсан шалтгааныг эрдэмтэд харилцан адилгүй өөр өөрөөр тайлбарласан байна. Тухайлвал, А. А. Бобровников, Д. Банзаров, А. М. Позднеев нар Хубилай хааныг таалал төгөссөн, Юань гүрэн мөхсөнтэй холбож үзсэн бол академич Б. Ринчен *'... дөрвөлжин үсэгт алтан ургийн боржигон аялгууг гол болгосон нь Юань улс мөхөхөд хааны ургийн аялгуу төвлөн голлох суурια алдаад ... дөрвөлжин үсэг аяндаа орхигдож, монгол үсэг ялсан...'* гэж тэмдэглэсэн байна.[335]

---

328 H. C. Gabelentz, Versuch über eine alte mongolische Inschrift, ZKM II, 1839, 1-21

329 J. Schmidt, Über eine mongolische Quadratschrift aus der Regierungszeit der mongoli-schen Dynastie Jüan in China, Bulletin 4:9, 1848

330 G. Pauthier,Observations sue l'alphabet de P'a-sse-pa et sur la tentative faite par Khoubilai-Khan, au XIII^{e} siècle de notre ére, pour transcrire la langue figurative des chinois au moyen d'une écriture alphabétique, JA 5:19, 1862, 8-14, 24-25, 34-37

331 А. М. Позднеев, Лекции по истории монгольской литературы, т. II,17-29, 83-87, 171-176, 182-189

332 А. М. Позднеев, Лекции по истории монгольской литературы, т. II, 167-172

333 Б. Я. Владимирцов, Монгольский международный алфавит XIII века, {= *Культуры и письменности Востока*}, 1931, кн. X, 32

334 С. А. Козин, Очерк развития письменности и литературы монгольских народов, 22; Н. Поппе, Квадратная письменность, 10; Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, I, 23; Б. Ринчен, Монгол бичгийн хэлний зүй, 72

335 Б. Ринчен, Монгол бичгийн хэлний зүй, 72

Юань гүрэний эцэс, Мин гүрэний эхэн үеийн монголын бичиг соёлын хэрэгцээ шаардлага, дөрвөлжин үсэгийн хэрэглээ зэрэгийг олон талаас нь авч үзээд, дөрвөлжин бичиг нийтийн хэрэглээнээс гарсан шалтгааныг доор дурдсан гурван зүйлээр тайлбарлаж болно. Үүнд:

1. Юань гүрэний доторхи олон угсаатан цөм өөр өөрийн үсэг бичигтэй байсаар атал хааны зарлиг, төрийн дарамтаар дөрвөлжин үсэгийг шинээр зохиолгож, хүчээр хэрэглүүлсэн учир эзэнт гүрэн мөхсөний дараа аяндаа хэрэглээнээс гарсан

2. Дөрвөлжин бичиг нь Юань гүрэний дотор багтаж байсан олон үндэстэн угсаатаны хэл аялгууны дундын байдалыг сайн тусхаж чадаагүйгээс гадна XIII-XIV зууны үеийн монгол хэл аялгуунуудын дундын байдалыг ч бүрэн тусхаж чадаагүй.

3. Юань гүрэнд багтаж байсан олон угсаатанууд албадан хэрэглүүлсэн дөрвөлжин үсэгийн хажуугаар өөр өөрийн уламжилалт бичиг үсэгээ зэрэгцүүлэн хэрэглэсээр байсан тул тэдэнд дөрвөлжин бичигийг авч хэрэглэх хэрэгцээ, шаардлага уулаас байсангүй.

Өөр нэг сонирхол татсан асуудал бол дөрвөлжин бичигийн суурь аялгууны тухай асуудал юм. Акададемич Б. Я. Владимирцов дөрвөлжин бичигийг хааны ордоныхоны аялгуун дээр тулгуурласан[336] гэж анх дурдсан бол хожим академич Б. Ринчен энэ талаар: *'Хубилай сэцэн хааны үед дөрвөлжин үсгийг зохиоход тэр үсгийг зохиогчидын тэмдэглэсэн аялгуу нь 'Монголын нууц товчоон' хийгээд өдгөөгийн монгор аймгийн аялгуутай ойршоолтой нь Хубилайн үед ч мөнхүү түүний омог буюу аанай боржигон аймгийн аялгууг голлосон...'* хэмээн дурдсан байна.[337] Дээр дурдсанчилан XIII зууны үеийн дорнод монголын аялгуун дээр тулгуурлан дөрвөлжин бичигийг зохиосон гэдэгтэй ихэнхи судалаачид санал нэгтэй байна.

XX зуун гарсаар дөрвөлжин үсэгийн судалгаа улам гүнзгийрч, түүний үсэгийн бүрэлдэхүүн, үсэг зүйн шинжийг дундад үеийн монгол хэл аялгууны авианы онцлог шинжтэй уялдуулан судалах болсон байна. Тухайлвал, P. Pelliot,[338] N. Poppe,[339] G. Clauson,[340] Б. Ринчен,[341] Kara,[342] Боушиян,[343] Ц. Шагдарсүрэн,[344]

---

336 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика., 23

337 Б. Ринчен, Монгол хэлний зүй 1956, (хорголжин барын хэвлэл) 72

338 P. Pelliot, P. Sur l'origine de l'alphabet dit 'Phags-pa, JA Avril-Juin, 1927, 372

339 Н. Поппе, Квадратная письменность, 27-43; The Mongolian Monuments in hP'ags-pa Script, 19-34, 35-43

340 G. Clauson, The hP'ags-pa Alphabet, BSOAS 22, 1959, 306-323

341 Б. Ринчен, Монгол хэлний зүйн бичиг, Уб., 2015, 43-48

342 Г. Кара, Книги монгольских кочевников, 28-30; Books of the Mongolian Nomads, 53-56

343 Боушиан, Mongγol üsüg bičig-ün uqaγan, 132-158

344 Ц. Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон {= *Bibliothca Mongolica:* Monograph 1} Centre for Mongol Studies, National University of Mongolia, Уб., 2001, 80-114

Тулгуур,[345] Гарди[346] нар дөрвөлжин бичгийн үсэг тус бүрийн хэлбэр дүрс, хувилбар үсэг зэрэгийг тодорхойлон гаргасан буй. Түүнчилэн Ц. Шагдарсүрэн,[347] Зууннаст,[348] Д. Төмөртогоо[349] нар дөрвөлжин бичигийн үсэг зүйн тогтолцоог нэг талаар, уйгуржин монгол бичигийн үсэг зүйн тогтолцоотой, нөгөө талаар, дундад үеийн монгол хэлний авианы тогтолцоотой холбон авч үзсэн судалгаа нийтэлсэн байна. Мөн дөрвөлжин бичигийн үсэг зүйн онцлог шинжийг нарийвчилсан судалах асуудал, тухайлвал, урт эгшигийн өмнөх *'шанагана'*,[350] үгийн тэргүүн үеийн ***e***, ***é*** үсэг,[351] үгийн эхний шүргэх ***h***- гийгүүлэгч[352] болон нийлмэл дүрстэй үсэгийн[353]

---

345 Тулгуур, Mongγol üsüg bičig-ün teüken toyimu, 166-198

346 Гарди, Dumdadu erten-ü mongγol kelen-ü sudulul, LÜKQ, 2001, 136-151, 194-239

347 Ц. Шагдарсүрэн, Дөрвөлжин бичгийн үсэг зүйн нэг онцлог хослол, ХЗ 13, 1978, 57-64; *idem.* Монгол дөрвөлжин бичгийн үсэг зүйн онцлог, ач холбогдол, МХШ 1, 1996, 11-17; Монголчуудын үсэг бичгийн товчоон, Уб., 2001, 82-101

348 Зууннаст, Dörbelǰin üsüg-ün egesig üsüg-ün dürsü-yin asaγudal daki qoyar ǰüyil-ün sistem, *Ündüsün-ü kele bičig,* 4,1987; Some Remarks on the 'Phags-pa Letter of *'*, MYu 1, 1988, 1-8; On the Sign of a Null Consonant in 'Phags-pa Script, MYu 2, 1989, 29-36; The Letter for the Voiceless Sound in 'Phags-pa Script, MYu 2, 1989; On the Orthographical System of the 'Phags-pa Script, *The Third International Symposium on Mongolian Studies,* August 1998, Huhhot; Comparative Analysis of Vowel Letters of Mongolian and 'Phags-pa Script, MYu 3, 1999, 6-11; On the Three Different Graphemic Types of 'Phags-pa Script, *Minzu wen hua yi chan* /The Heritage of Nationalities/, Beijing, 2004, 63-64; Phonetic Systems of the Phags-pa Scripts, *The Fourth International Symposium on Mongolian Studies,* August, 2004, Huhhot, Thesis Abstract 49-50 (хитад хэлээр)

349 Д. Төмөртогоо, Монгол дөрвөлжин бичгийн *'möŋke'* хэмээх үгийн бичлэгийн учир, MCIV:10, 1967, 11-15; Дөрвөлжин бичгийн эгшиг үсэгийн бичлэгийн онцлог хийгээд түүнийг галигт тусгах нь, ХЗ 22:12, 1988, 106-120 // *Mongolian Studies* (Korean Association for Mongol Studies) No 4, 1996, 193-197; Монгол дөрвөлжин бичигийн эгшигийн зурлагын тогтолцоо, *'Олон улсын монголч эрдэмтдийн V их хурал',* II, 1992, 94-96

350 Ш. Лувсанвандан, Дөрвөлжин үсгийн дурсгалын зүйлд эгшгийн урт богиныг ялгасан нь, ХЗ 4, 1966, 27-35; *idem.* Монгол дөрвөлжин үсгийн их ***a***, шанаган ***a***-гийн тухай асуудалд, SM 6, 1980, 31-32; Анчи, Монгол дөрвөлжин үсэгийн цагаан толгойн /шанаган/ ***a*** хийгээд түүнд холбогдох асуудалууд, МХУЗ 1, 1980, 23-37; Jirannige, Mongγol dörbelǰin bičig-ün *sinaγan* ***a*** üsüg-ün tuqai, MKUJ 2, 1996, 15-20; Jalsan, Sinaγan ***a***-yin tuqai toduraγuluγusitai kedün asaγudal, ÖMYS 4, 2001, 7-11 // *'Erdem-ün qaryui, elbeg bütügel'* ÖMYS, 2002, 312-316; Ман Мөрөн, Dörbelǰin üsüg-ün *sinaγan* ***a*** temdeglüge qolbuγdaqu asaγudal-un tuqai, MKUJ 1, 1993, 4-27; U. Kürel-baγatur, Dörbelǰin üsüg-ün sinaγan ***a***-yin tuqai suduluγan-du debsigülekü sanal ǰöblelge, MKUJ 4, 1989, 95-100

351 Sh. Hattori, On the 'Phags-pa Script. Especially Concerning the Letters ***e*** and ***'*** II, *Gengo,* 13:8, 1984, 116-121; The 'Phags-pa Letter ***e*** and ***'*** Represent One and the Same Mongolian Vowel, *'Gedanke und Wirkung'.* Festschrift zum 90 Geburtstag von Nikolaus Poppe, Wiesbaden, 1989, 146-151; Y. Хөгжилтү, Dörbelǰin üsüg-ün ***e*** ba ***ė***-yin tuqai, ÖMYS 3, 1983, 53-60; Ё. Жанчив, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал дахь хоёр зүйл ***e*** эгшгийн тухай, *Mon. Ser.* 26, 2006, 54-58

352 G. Clauson, S. Yoshitake, On the Phonetic Value of the Tibetan Characters *'*and ***h*** and the Equivalent Characters in the hP'ags-pa Alphabet, JRAS 1929, 843-862; Н. Поппе, Квадратная письменность, 35-43; Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, I, 24

талаар нилээд олон сонирхолтой судалгаа гарчээ. Мөн L. Ligeti дөрвөлжин үсэгийн үгийн эхний эгшиг үсэгийн байрлал ба дуудлагын тухай үгүүлэлийг нийтлүүлжээ.[354]

Дөрвөлжин үсэгийн дурсхалуудад эртний монгол хэлний үгийн эхний гийгүүлэгч авианы суларалын үр дүнд үүссэн шүргэх гийгүүлэгч, хоёр эгшигийн дундаас суларан сугарсан амисхалын түрэлт, утга ялгах өргөлтөөс сунжиран үүссэн урт эгшиг, хагас эгшигийн хувьсалын уламаас үүссэн хос эгшиг, авианы харилцан нөлөөлөлийн дүнд бий бүрэлдсэн эгшиг авианы ижилшил зэрэг дундад үеийн монгол авианы олон шинж тодорхой туссан учир тийнхүү эрдэмтэдийн анхааралыг ихээхэн татсаар иржээ. Тийм ч учираас профессор Г. Санжеев *'Дөрвөлжин бичигийн монгол дурсхалуудыг судалах нь XIII зууны эцэсээс XIV зууны эхэн үе хүртэлхи өмнөд монгол хэл аялгуунуудын бодит байдалтай танилцах боломж олгоно'* хэмээн дурдсан билээ.[355]

0.3.1.3.2 СОЁМБО БИЧИГ, ТҮҮНИЙ СУДАЛГАА

§ 56. **Соёмбо үсэгийн тухай товч**. Монголчуудын зохион хэрэглэсэн энэдхэг, төвд гаралтай өөр нэг бичиг бол *'соёмбо үсэг'* юм. XVII зууны сүүлчээр (1686) Халхын Өндөр гэгээн Занабазар (Jṅānavajra)/1635-1723/ энэдхэгийн нагар үсэгт тулгуурлан монгол, санскрит, төвд хэлний үгсийг адил тэгш тэмдэглэх зорилгоор *'соёмбо'* үсэгийг зохиожээ. Соёмбо үсэг нь тухайн үеийнхээ монгол хэлний зонхилох аялгууны урт, хос эгшиг, эгшигийн ижилшил, гийгүүлэгчийн тагнайшил зэрэг бодит шинжүүдийг тусхажээ. Гэвч зарим тохиолд монгол бичигийн хэлний тогтсон бичлэгийг шууд тусхасан жишээ ч тохиолдож байна. Соёмбо үсэг нь бичиг үсэгээ улам боловсронгуй болгох гэсэн оролдлогын нэгэн үр дүн, монголчуудын оюуны соёлын үнэт өвийн нэг мөн билээ.

Занабазарын зохиосон соёмбо үсэг нь 7 үндэсэн эгшиг, 2 хос эгшиг, 71 үе үсэгтэй, үсэг холбон бичихдээ санскрит уламжилалын дагуу хөндлөн бичдэг.

---

353 Ц. Шагдарсүрэн, Дөрвөлжин бичгийн үсэг зүйн нэг онцлог хослол, 57-64; Jaγunasutu, Dörbelǰin üsüg-ün egesig üsüg-ün dürsü-yin asaγudal daki qoyar ǰüyil-ün sistem, *Ündüsün-ü kele bičig*, 4, 1987; *idem.* Comparative Analysis of Vowel Letters of Mongolian and 'Phags-pa Script, MYu 3, 1999, 6-11; Д. Төмөртогоо, Монгол дөрвөлжин бичигийн эгшигийн зурлагын тогтолцоо, ОУМЭИХ V, боть II, 1992, 94-96; *idem.* Монгол дөрвөлжин бичигийн эгшиг үсэгийн бичлэгийн онцлог, түүнийг галигт тусгах нь, МХШ 1, 1996, 16-20; Монгол бичиг болон дөрвөлжин бичигийн үсэг зүйн тогтолцоог харьцуулах нь, *The Third International Symposium on Mongolian Studies*, August, 1998, Huhhot; *Aleph* ба *титэм, 'Монгол судлалын өгүүллийн түүвэр'*, 2006, 101-104; Жалсан, Dörbelǰin üsüg-ün ***ö, ü*** bolun ' egesig-ün tuqai, *'Research Paper of the Inner Mongolia University'*, 2, 1989, 58-63; Г. Цэцэгдарь, Монгол дөрвөлжин бичгийн нийлмэл дүрстэй эгшиг үсгийн бичлэгийн онцлог, МХШ № 1, 1996, 31-34

354 L. Ligeti, Trois notes sur l'écriture 'Phags-pa, AOH XIII:1-2, 1961, 201-237

355 Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, 24

Соёмбо үсэгийн тухай тайлбарласан хэд хэдэн томоохон бүтээл байдаг бөгөөд тэдгээрийн ихэнхийг өнгөрсөн зууны гучаад онд Гомбожав агримба төвд хэлнээс орчуулжээ. Тухайлвал, Ширбазарын зохиосон *'Соёмбо жояади хэмээг-дэх монгол үсэгийн утгыг тийн бөгөөд нээгч Занабазарын таалалын чимэг'*, номч тойн Лувсандагвадаржаагийн *'Соёмбо жояади хэмээгдэх үсэгийн түүхийг товчилон хурааж үзүүлсэн тус амагалангийн линхуаг дэлгэрүүлэгч Огторгуйн чандмани'*, *'Соёмбо үсэгийн утгыг товч үзүүлсэн бичээч цоржийн зохиол оршивой'* гэх зэрэг арав гаруй бүтээл бий бөгөөд тэдгээрт соёмбо үсэгийг, хэдийд хэрхэн зохиосон хийгээд цагаан толгой болон түүнийг зохиосон учир шалтгааны талаар тодорхой дурджээ.

§ 57. **Соёмбо үсэгийн судалгааны тойм**. Соёмбо үсэгийн талаар өрнө дахинд анх танилцуулсан хүн бол академич Б. Ринчен билээ. Тэрвээр 1950-аад оны эхээр нийтлүүлсэн *'XVII зууны үеийн монголын урид мэдэгдээгүй хоёр бичиг'* гэсэн үгүүлэлдээ соёмбо үсэгийг хэдийд, хэн зохиосон тухай тодорхой мэдээлэлийг багтаасанаас гадна соёмбо үсэгийн цагаан толгойг төвд үсэг, латин галигийн хамт хавсаргасан нь эрдэмтэдийн анхааралыг ихээхэн татсан байна.[356] Хожим профессор Г. Кара *'Нүүдэлчин монголчуудын ном'* хэмээх бүтээлдээ соёмбо үсэгийн гарал үүсэл, үсэгийн бүрэлдэхүүн, бичлэгийн онцлог шинжийн талаар тодорхой дурджээ.[357]

Профессор Ц. Шагдарсүрэн *'Монголчуудын үсэг бичигийн товчоон'* гэсэн томоохон бүтээлдээ соёмбо үсэгийн цагаан толгойн үсэг тус бүрийн бичлэг, нэмэлт тэмдэг, бүрдүүлэгч махбод, тохиолдох байр, зэрэгийг тодорхойлж, холбогдох жишээг дагалдуулсан нь тухайн үсэгийн талаар танилцуулсан хамагийн дэлгэрэнгүй тайлбар болжээ.[358] Мөн профессор Г. Гантогтох соёмбо үсэгийн гарал үүсэл, зохиогдсон учир шалтгаан, түүний суурь аялгуу, үсэг зурлагын онцлог шинж, дотоод билгэдэл, нийтэд түгэн дэлгэрээгүй шалтгаан зэрэгийг нилээд дэлгэрэнгүй танилцуулсан байна.[359]

Өндөр гэгээн Занабазар соёмбо бичигээс гадна *'хэвтээ дөрвөлжин'* хэмээх өөр нэгэн зүйлийн бичиг зохиосон талаар анх P. S. Pallas мэдээлж, дараа нь Д. Банзаров, A. Wylie, А. М. Позднеев нар цухас дурдаж, цөөн зарим үсэгийг бие биеэсээ дамжуулан хуулсаар иржээ. Хожим академич Б. Ринчен уул үсэгийн талаар илүү тодорхой мэдээлсэн[360] бөгөөд түүний дараа G. Kara уул бичигийн талаар илүү

---

356 B. Rintschen, Zwei unbekannte mongolische alphabete aus dem XVII Jahr-hundert, AOH II, 1953, 63-71

357 Д. Кара, Книги монгольских кочевников (семь веков монгольской письменности) М., 1972, 90-93 // Books of the Mongolian Nomads. More than Eight Centuries of Writing Mongolian, First English Edition Translated from the Russian by John R. Krueger, Indiana University, Bloomington, 2005, 163-167

358 Ц. Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон, 133-148

359 Г. Гантогтох, Соёмбо үсэг, *'Төв Азийн нүүдэлчдийн бичиг үсгийн товчоон'*, 2001, 263-286

360 B. Rintschen, Zwei unbekannte mongolische alphabete aus dem XVII Jahrhundert, 66

дэлгэрүүлэн тайлбарласан бий.[361] Наяад оны эхээр профессор Ц. Шагдарсүрэн *'Монгол үсэг зүй'* хэмээх номдоо хэвтээ дөрвөлжин үсэгийн цагаан толгой, тэдгээрийн дуудлага болон монгол, төвд, санскрит үгийг тэмдэглэхэд хэрхэн оролцдог байдал зэрэгийг тусхайлан тэмдэглэсэн[362] бөгөөд хожим *'Монголчуудын үсэг бичгийн товчоон'* гэдэг бүтээлдээ түүний цагаан толгой, тэдгээрийн байр болон хэрэглээний талаар нэн дэлгэрэнгүй үгүүлсэн билээ.[363]

Ерээд оны сүүлчээр судалаач Р. Бимбаа *'хэвтээ дөрвөлжин'* үсэгийн талаар анхааран судалж, уул бичигийг хэдийд хэрхэн зохиосоноос аваад судалагдсан байдал, цагаан толгой болон үсэг тус бүрийн онцлог шинжийн талаар тодорхой дурджээ.[364] Тэрвээр бас монгол, төвд, санскрит хэлээр бичсэн хэвтээ дөрвөлжин үсэгийн дурсхалуудын эхийг хавсаргасан нь тухайн үсэг бичигийн судалалд чухал хувь нэмэр болж байна. Зохиогч уул бүтээлийнхээ нэмэн зассан хоёр дахь хэвлэлдээ уул бичигийн гарал үүсэл, судалгааны талаар илүү дэлгэрүүлэн дурдсанаас гадна монгол, төвд, санскрит хэлээр бичсэн хэвтээ дөрвөлжин үсэгийн дурсхалын гэрэл зураг, орчуулга, тайлбар зэрэгийг нэмэн оруулсан нь тухайн бичигийн судалгааны хүрээг ихээхэн өргөдхөсөн судалгаа болжээ.[365] Мөн залуу эрдэмтэн Ё. Жанчив хэвтээ дөрвөлжин үсэгийн талаар нилээд дэлгэрэнгүй тойм судалгаа хийсэн бий.[366]

0.3.2 МОНГОЛ БИЧИГИЙН ХЭЛ, ТҮҮНИЙ ҮЕ ШАТ

§ 58. **Монгол бичигийн хэлний тухай тойм**. Аливаа улс үндэстэний хэл нь аман ярианы хэл, бичигийн хэл гэсэн хоёр үндэсэн хэлбэрээр илэрдэг. Аман ярианы хэл нь хэл найруулга, үгсийн бүрэлдэхүүнийхээ талаар уридаас шилэн сонгож, бодож боловсоруулаагүй, зөвхөн харилцан ярилцах тэрхэн агшинд илэрэн гардаг хэл ярианы энгийн хэлбэр юм. Гэтэл бичигийн хэл нь тогтсон дүрэм зүй, сонгосон үг хэллэг, хэвшсэн хэл найруулга бүхий илүү боловсо-ронгуй хэл ярианы хэлбэр юм.

Ер бичигийн хэл үүсэн бүрэлдэж, хэвшин тогтоно гэдэг бол урт удаан хугацаа шаарддаг, алгуур хувьсалтай түүхэн үзэгдэл юм. Аль ч бичигийн хэл нь тухайн нэгэн хэл аялгуунд тулгуурлан үүсэн бүрэлдэж, хэвшин тогтохдоо аман ярианыхаа хэлэнд гарсан аливаа өөрчилөлт хувьсалыг даган тусхадаггүй, анх хэвшин тогтсон уугуул хэв шинжээ бараг төлөв тогтвортой хадгалдаг байна. Тийм ч учираас аль нэгэн бичигийн хэл анх үүсэн бүрэлдэх үедээ тухайн хэлнийхээ бодит дуудлагатай тохирч байдаг боловч тасаралтгүй хувьсан хөгжиж байдаг ярианы хэлнээсээ

---

361 Д. Кара, Книги монгольских кочевников, 93 // Books of the Mongolian Nomads, 168-171

362 Ц. Шагдарсүрэн, Монгол үсэг зүй, 98-112

363 Ц. Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, Уб., 2001, 159-174

364 Р. Бямбаа, Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд, 1997, 89 тал

365 Р. Бямбаа, Занабазарын дөрвөлжин үсэг, *Монгол билиг,* ЭШБ, 2005, 1-146

366 Ё. Жанчив, Хэвтээ дөрвөлжин үсгийн судлалын асуудалд, МУИС МХСС ЭШБ 135, 1998, 166-179; *idem.* Хэвтээ дөрвөлжин үсэг, *'Төв Азийн нүүдэлчдийн бичиг үсгийн товчоон'*, 289-304

яваандаа хоцорч, цаг хугацаа өнгөрөх дутам улам их зөрөөтэй болж хоцордог нийтлэг жамтай ажээ. Тийнхүү бичигийн хэл аман ярианы хэлнээсээ хоцорч холдох нь хоцорогдол бишь, харин амьд хэл яриандаа мартагдаж хуучирсан эртний шинжийг хадгалан үлдсэнээрээ тухайн хэлнийхээ түүхийн бодит баримт, үнэт дурсхал нь болдог байна. Тийм учираас боловсоронгуй бичигийн хэл гэдэг нь аман яриаыхаа хэлтэйгээ тохирч байгаадаа бус, бат тогтвортой хэвшин тогтсон бичлэгийн дүрэм зүй, арвин баялаг үгсийн сан, нандин тансаг сайхан хэл найруулгатайдаа байдаг ажээ.

Монголчууд нь дорно дахины өндөр соёлт улс үндэстэнүүдийн нэгэн адил хэдэн минган жилийн тэртээгээс аман зохиол, аман бичигийн хэлнийхээ баялаг уламжилал дээр тулгуурлан бичигийн хэлтэй болсон ард түмэн. Монголчуудын дээд өвөг, тухайлвал, эртний Хүннү, Сяньби, Жүжан, Тоба, хожим Хитанчууд их төлөв хитад ханз үсэгийн утгыг нь бус, дуудлагыг нь ашиглан үе үсэгийн үүрэгээр хэрэглэж байсан бололтой. Тэдний хэрэглэж байсан үсэг бичиг нь монгол бичигийн хэлний эхний үе шат байсан боловч хэлнийхээ бүтэц тогтолцоог тусхах хэмжээнд боловсорч хараахан чадсангүй байсаар аяндаа хэрэгцээнээс гарсан ажээ. Түүнээс хойш хэд хэдэн өөр үсэг бичиг зохион хэрэглэсээр ирсэн бөгөөд тэдгээрийг тус тусдаа биеэ даасан өөр өөр бичигийн хэл гэж үзэх аргагүй, харин монгол хэлний хөгжилийн өөр өөр үе шатны онцлог шинжийг өөр өөр үсэгээр тэмдэглэсэн хувилбарын шинжтэй гэж үзвэл зохино. Учир нь, нэгэн хэл дээр тулгуурласан хэд хэдэн өөр бичигийн хэл байх боломжгүй билээ.

Бидний өвөг дээдэсээс олон зуун жилийн турш боловсоруулан хэрэглэсээр ирсэн янз бүрийн тогтолцоотой үсэг бичигийн дотороос монголчуудын бичигийн хэлний хэрэгцээ шаардлагыг хамагийн удаан хангасаар үндэсний бичиг болж хэвшин тогтсон нь согд-уйгурын үсэг дээр тулгуурлан хэвшин тогтсон бичигийн хэл юм.

Монгол бичигийн хэл нь анхандаа монгол хэлний зонхилох нэгэн аялгууны онцлог шинж дээр тулгуурлан үүсэн бүрэлдсэн бөгөөд уламаар бусад олон аялгууныхаа аман бичигийн хэлний уламжилал, үгсийн сангийн баялаг өвөөр сэлбэгдэн баяжсаар яваандаа бараг нийт монгол туургатаны бичигийн хэл болон хэвшин тогтжээ. Монгол бичигийн хэл нь тийнхүү хэвшин тогтож хувьсан хөгжиж ирэхдээ аман ярианыхаа хэлэнд гарсан аливаа хувьсал өөрчилөлтийг тэр бүр даган хувиссангүй, анх хэвшин тогтсон үндэсэн шинжээ харьцангуй тогтвортой хадгалсаар иржээ. Тийм учираас монгол бичигийн хэл нь тасаралтгүй хувьсан хөгжсөөр ирсэн аман ярианы хэлнээсээ хоцорч, уламаар бичигийн хэл, аман ярианы хэл хоёрын хооронд зохих хэмжээний ялгаа гарч ирсэн байна. Тэрхүү ялгаа нь XIII-XIV зууны үеэс уламжилан ирсэн монгол бичигийн дурсхалуудын хэлийг мөн тэр үед хитад, дөрвөлжин, араб үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний бичигийн дурсхалтай харьцуулан үзэхэд нэн тодорхой мэдэгдэнэ. Бичигийн хэл, ярианы хэлний зөрөө нь XIII-XIV зуунаас хойш улам нэмэгдсээр иржээ. Тийнхүү эртний монгол хэлний сүүлчээр хэвшин тогтсон монгол бичигийн хэл эдүгээгийн монгол хэлнээс зөрөөтэй болсон нь дундад үеийн англи хэлний үед хэвшин тогтсон англи бичигийн хэл орчин үеийн англи хэлний бодит дуудлагаас ялгаатай болсонтой яг

адил үйл явц юм. Тийм учираас уйгуржин монгол бичигийн эртний дурсхалууд болон монгол бичигийн хэлний хэвшсэн бичлэгээр бичсэн аливаа эхээс бүр IX-X зууны үеийн монгол хэлний авианы бүрэлдэхүүн, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэр, үгсийн сангийн онцлог зэрэгийг тодорхой мэдэж болно. Тийнхүү монгол хэлний түүхэн хөгжилийн нэн эртний шинжийг олон үе дамжуулан тогтвортой хадгалан үлдэж, өөрөө хэлний түүхийн бодит баримт болж байгаа нь монгол бичигийн хэлний гол үнэ цэнэтэй тал нь юм.

XIII зуун гарсаар монголын нэгдсэн гүрэн бүрэлдэн тогтож, уламаар түүнд нэгдэн орсон олон овог аймагууд улс төр, эдийн засаг, шашин соёлынхоо талаар ойртож, яваандаа нэгэн нэгдмэл бичигийн хэлтэй болох шаардлага буй болжээ. Түүний үр дүнд урид цөөн зарим аймагийнханы дунд хэрэглэгдэж байсан уйгуржин бичиг нь нийт монгол хэл аялгуутаны дундын байдалыг адил тэгш тусхасан илүү боловсоронгуй бичигийн хэл болох эхлэл нь тавигджээ. Нөгөө талаар, XIII-XIV зууны үеэс монгол газар бурханы шашин дахин хүчтэй дэлгэрч, шашины сургаал номлол хийгээд дуун ухаан, анагаах ухаан, зурхайн ухаан, учир шалтгааны ухааны өдий төдий ном зохиолыг монгол хэлээрээ орчуулан гаргах болсон нь бичигийнхээ хэлийг цаашид улам боловсоронгуй болгоход чухал түлхэц болсон байна.

Өдгөө энэ үед уламжилан үлдсэн монгол бичигийн дурсхалуудын хамагийн эртнийх нь XIII-XIV зууны үед холбогдох бөгөөд тэдгээр нь сайтар хэвшсэн бичлэгийн дүрэм, арвин баялаг үгсийн сан, яруу тансаг хэл найруулгатай боловсоронгуй хэлээр бичигджээ. Түүнээс үзвэл, монгол бичигийн хэл анх үүсэн бүрэлдэж, хэвшин тогтсон цаг хугацаа нь XIII-XIV зуунаас хэдэн зуун жилийн өмнөх үед холбогдох нь тодорхой байна.

§ 59. **Монгол бичигийн хэлний судалгааны тойм**. Монгол бичигийн хэлний гарал үүсэл, хувьсал хөгжил, бүтэц системийн тухай асуудал нь эрдэмтэдийн анхааралыг ихээхэн татсаар иржээ. XIX зууны сүүлч үеэс эхлэн J. Schmidt, O. M. Ковалевский, A. A. Бобровников, A. M. Позднеев нар монгол бичигийн хэл, түүний дурсхалуудын талаар анхны томоохон судалгаануудыг гаргажээ.[367] XX зууны эхээр проф. G. J. Ramstedt *'Монгол бичигийн хэл, Хүрээний халх аялгууны харьцуулсан авиа зүй'* гэдэг бүтээлдээ монгол бичигийн хэлний гарал үүсэл, хувьсал хөгжилийг түүхэн үүднээс авч үзээд *'Монгол бичигийн хэл нь маш эртний түүхтэй юм. Монгол хэлний үгсийг тэмдэглэж байгаа тогтсон бичлэг нь жинхэнэ бодит дуудлагатайгаа дүйж байсан цагаас нааш ярианы хэл нь авиа зүйн хувид өөрчлөгдсөөр яваандаа огт өөр хэлбэртэй болжээ'* гэж тэмдэглэсэн нь монгол бичигийн хэлний хөгжилийг түүхэн үүднээс авч үзсэн анхны дүгнэлт болсон байна.[368] Мөн профессор N. Ропре монгол бичигийн хэлний зүй болон *'Гэсэрийн*

---

[367] И. Я. Шмидт, И. Я., Грамматика монгольского языка, СПб., 1832, VII + 184; О. М. Ковалевский, монгольского книжного языка, Казань, 1835, 1-197; А. А. Бобров-ников, Грамматика монгольско-калмыцкого языка, Казань, 1849, VIII + 3 + 400

[368] Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, СПб., 1908, 1

туужс'-ийн хэлний онцлогийн тухай судалгаа нийтлүүлсэн нь монгол бичигийн хэлний судалалд үнэтэй хувь нэмэр болжээ.[369] Хожим профессор Г. Санжеев монгол бичигийн хэлний үсэгзүй, авиа зүй, хэлзүйн онцлог шинжийн талаар бие даасан хэд хэдэн бүтээл нийтлүүлсэн билээ.[370]

Монгол бичигийн хэлний тухай судалгаа нь түүний суурь аялгуу, бүрэлдэн буй болсон цаг хугацаа, хөгжилийн үе шатуудын тухай асуудалд голлон чиглэсэн байх бөгөөд тэдгээр асуудал нь зарим талаар өнөө хүртэл маргаантай хэвээр байсаар байна.

Бид энд эхлээд монгол бичигийн хэлний суурь аялгууны талаархи эрдэмтэдийн саналын талаар товч дурдая. Академич Б. Я. Владимирцов монгол бичигийн хэлийг бүр Чингис хааны үеэс өмнө Найман, Хэрэйд аймагийн дунд үүсэн бүрэлдсэнийг монголчууд тэр хэвээр нь зээлдэн авч хэрэглэсэн гэдэг онолыг гаргажээ.[371] Тэрвээр *'Монгол утга зохиолын хэл'* гэсэн өөр нэгэн томоохон үгүүлэлдээ монгол бичигийн хэлний онцлог байдал нь эдүгээгийн торгууд аман аялгуутай ойролцоо гэж тэмдэглээд, уламаар торгуудын аялгууг хэрэйдийн аялгуунд хамааруулан үзжээ.[372] Түүний энэ саналыг хожим Н. Н. Поппе, Г. Д. Санжеев нар ерөнхийд нь дэмжсэн байдаг.[373] Гэтэл найманчуудын угсаа гаралын тухай асуудал эдүгээ хүртэл маргаантай хэвээрээ байгаа билээ. Бүр Giovanni Di Plano Carpini-аас J. Schmidt, D'Osson, А. М. Позднеев, Б. Я. Владимирцов нар Найманыг монгол угсаатан гэж үзсэн бол А. А. Бобровников, H. H. Howorth, P. Poucha, Sh. Murayama, L. Ligeti, Л. Л. Викторова нар түрэг угсаатан гэж үзжээ.

Тавиад оны эхээр L. Ligeti монгол бичигийн хэлийг найманчуудын дунд бишд, харин хитанчуудын дунд хэвшин бүрэлдээд, уламаар тэндээс бусад монгол овог аймагуудын дунд дэлгэрсэн байж болно гэсэн шинэ таамаглалыг дэвшүүлсэн[374] бөгөөд түүнийг зөвлөлтийн эрдэмтэн Л. Л. Викторова дэмжсэн байдаг.[375] Ер

---

369 N. Poppe, Beiträge zur Kenntnis der altmongolischen Schriftsprache, AM 1:1, 1924, 668-675; *Geserica.* Untersuchungen der sprachlichen Eigentümlichkeiten der mongolischen Version des Gesserkhan, AM 3, 1926, 1-32, 167-193; Грамматика письменно-монгольского языка, 1937, 3-196; Bemerkungen zum vorklassischen Schriftmongolisch, ZAS 3, 1969, 105-128; Altaic Linguistics An Overview, *Science of Language,* 1975, 130-186

370 Г. Д. Санжеев, Старо-письменный монгольский язык, М., 1964, 3-89; Лингвис-тическое введение в изучение истории письменности монгольских народов, Улан-Удэ, 1977, 159 с.

371 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка., 20

372 Б. Я. Владимирцов, Монгольские литературные языки, Зап. Ин-та Вост. АН. 1, 1931, 6

373 Н. Поппе, Грамматика письменно-монгольского языка,1937, 13; Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. 1. 14-15

374 Л. Лигети, Рец. на кн: Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. 1, 1953, - ВЯ 5, 1955, 135

375 Л. Л. Викторова, К вопросу о найманской теории происхождения монгольского литературного языка и письменности (XII-XIII вв.) Уч. Зап. ЛГУ, Серия Вост. Наук,

Уйгурын хаант улс цэцэглэн мандаж, шашин, соёлынхоо талаар хөрш зэрэгэлдээ улс оронууддаа ихээхэн нөлөөтэй байсан тэр үед хитанчууд ч бас ид хүчирхэгжин, уйгур улстай ойр нягт холбоотой байсан учир хитанчууд уйгурын үсэгийг зээлдэн авч хэрэглэсэн байж болохыг үгүйсгэх аргагүй билээ. Хэрэв Найманчууд нь уулаас түрэг хэлтэн аймаг байсан бол монголчууд тэднээр дамжуулан бичигийн хэлийг уламжилан авсан байх боломжгүй гэдэгийг дурдвал зохино. Ийнхүү монгол бичигийн хэлний үүсэл гаралын тухай асуудал нь угтаа монгол овог аймагуудын удам угсааны хамаадалтай нягт холбоотой бөгөөд нэг талаас, найманы удам угсааны тухай асуудал, нөгөө талаас, хитаны хэл соёлын тухай асуудал бүрэн судалагдаагүй энэ үед монгол бичигийн хэлний гарал үүсэл найман, хитантай хэрхэн холбогдох талаар илүү нарийвчилан тогтоох боломжгүй байна.

Ер монголчуудын аман зохиол, аман бичигийн хэл нь бүр хэдэн минган жилийн баялаг түүхтэй бөгөөд харин түүнийг бичиг үсэгт буулган тэмдэглэх болсон цаг үе нь мэдээж харьцангуй хожуу үеийн хэрэг буй заа. Нөгөө талаар, бичиг үсэг хэрэглэх болсон, нийтээр дагаж мөрдөх бичигийн хэлтэй болсон хоёр нь цаг хугацааны хувьд ч, хэрэглээний хувьд ч харьцангуй ялгаатай ойлголт юм.

Монголчууд үсэг бичиг анх авч хэрэглэх болсон нь угтаа бичигийн хэл үүсэн бүрэлдэхийн эхлэл бөгөөд энэ талаар эрдэмтэд харилцан адилгүй саналтай байна. Профессор. G. J. Ramstedt *'... бүр Чингисээс өмнө сири-уйгур үсэгээр монгол хэлийг тэмдэглэж байсан'*[376] гэж дурдсан бол академич. Б. Я. Владимирцов *'энэхүү бичигийн хэлний шинж нь монгол хэлний хамагийн эртний онцлогийг хадгалсан аялгуунаас ч хавьгүй илүү эртний шинжийг тусхаж байна'*[377] гэжээ. Гэтэл А. М. Позднеев, B. Laufer, Г. Д. Санжеев, N. Poppe, G. Kara нар монгол бичигийн хэлийг XII-XIII зууны үед хэвшин тогтсон гэж тэмдэглэжээ.[378] Таширамд дурдахад, дээр дурдсан саналууд нь зөвхөн согд-уйгурын гаралтай үсэг бичигт тулгуурласан бичигийн хэлний тухайд холбогдоно.

§ 60. **Монгол бичигийн хэлний үечилэл**. Монгол бичигийн хэлний хувьсан хөгжиж ирсэн түүхэнд холбогдох өөр нэг анхаарал татсан асуудал бол түүнийг үечилэх асуудал юм. Монголчуудын үсэг бичиг, бичигийн дурсхалын талаар анхлан судалсан О. Ковалевский, А. М. Позднеев нарын зэрэг эрдэмтэд монгол бичигийн хэлний хөгжилийн түүхийг цуваа цагийн үүднээс авч үзсэнгүй. Хожим

Вып. 12, No 305. 1961, 154; *Монголы*. Происхождение народа и истоки культуры, М., 1980, 151-152

376 Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, СПб., 1908, 3.

377 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 19

378 А. М. Позднеев, Лекции по истории монгольской литературы, т. 1, 1896, СПб., стр.145;B. Laufer, Skizzeder mongolischen Literatur, KSz 8, 1907, 165-261; Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, М., 1953,14-15; Лингвис-тическое введение в изучение истории письменности монгольских народов, Улан-Удэ, 1977, 4; N. Poppe, Grammar of Written Mongolian {= PLON.S. 1}, Wiesbaden, 1954, 1; Д. Кара, Книги монгольских кочевников, 15-20

нэрт монголч G. J. Ramstedt энэ асуудалыг хэлний бодит баримт материал дээр тулгуурлан *'Монгол бичигийн хэл бол маш эртний түүхтэй юм. Монгол хэлний үгсийг өдгөө тэмдэглэж байгаа тогтсон бичлэг нь жинхэнэ бодит дуудлагатайгаа дүйж байсан цагаас нааш ярианы хэл нь авиа зүйн хувид ихээхэн өөрчлөгдсөөр яваандаа огт өөр хэлбэртэй болжээ'* гэж тэмдэглэжээ.[379] Түүний дараа монгол бичигийн хэлний хэвшилийн талаар илүү нарийвчилан судалсан хүн бол академич Б. Я. Владимирцов юм. Тэрвээр *'Монгол бичигийн хэлний гурван үе шатны тухай'* гэсэн тусхай үгүүлэлдээ монгол бичигийн хэлний хөгжилийн түүхийг гурван үндэсэн үе шат болгон хувааж, уламаар үе шат тус бүрийн онцлог шинжийг тодорхойлон гаргасан билээ.[380] Тухайлвал, эдүгээ бидэнд тодорхой мэдэгдэхгүй байгаа нэн эртний үеэс аваад XIII зууны эцэс хүртэлхи үеийг монгол бичигийн хэлний 1-р үед, XIV зууны эхнээс XVI зууны эцэс хүртэлхи үеийг 2-р үед, XVII зууны эхэн үеэс хойшхи үеийг 3-р үед тус тус хамааруулан үзжээ. Үе шат тус бүрийн онцлог шинжийнх нь тухайд гэвэл, монголчууд уйгурын үсэгийг анх ямар ч нэмэлт засваргүй авч хэрэглэсэнээс эхлээд уламаар түүнийг хэл аялгууныхаа онцлогт тохируулан нэмэн засч, бичлэгийн дүрэм, хэл зүй зохион боловсоруулж эхэлсэн зэрэгийг 1-р үед, Бичигийн хэлний дүрэм зүй, үгсийн сан, хэл найруулга нь зохих хэмжээгээр боловсорон, биеэ даасан бичигийн хэл болж, түүгээр ном зохиол олоноор хэвлэх болсон зэрэгийг 2-р үед, Монгол бичигийн хэл цаашид улам боловсорongуй болж, нийт монголчуудын дунд өргөнөөр түгэн дэлгэрч, ном зохиол барлан хэвлэх ажил үлэмжхэн хөгжсөн зэрэгийг 3-р үед тус тус багтаан үзсэн байна.Тэрвээр *'Монгол бичигийн хэлийг халхын аман аялгуутай харьцуулсан хэл зүй'* гэдэг алдарт бүтээлдээ монгол бичигийн хэлний хөгжилийн түүхийг мөн дээрхийн адил гурван үе шат болгон хуваагаад 2, 3-р үеийн онцлог шинжийн талаар зарим нэгэн баримт нэмэн дурдсан байна. Тухайлвал, монгол бичигийн хэлний 2-р үед бурханы шашины ном зохиол олоноор орчуулан гаргах явцад бичлэгийн дүрэм зүй улам бүр боловсорongуй болж, үгсийн сан нь нэг талаас, Согд, Хотон, Кучар-Карашар, Перс зэрэг Дундад Азийн соёлт ард түмэнүүдийн хэлний үгсээр баяжиж, нөгөө талаас, олон амьд хэл аялгуунуудын нөлөөгөөр шинэчилэгдэж ирсэн тухай тодорхой дурджээ.[381] Түүний энэхүү үечилэл нь дараах үеийн эрдэмтэдийг судалгааны гол чиглэл болсоор ирсэн билээ. Тухайлвал, академич С. А. Козин түүний үзэл санаанд тулгуурлан монгол бичигийн хэлний эхэн үеийн онцлог шинжийн хэд хэдэн сонирхолтой үгүүлэл нийтлүүлжээ.[382]

Мөн проф. Н. Н. Поппе монгол бичигийн хэлний үүсэл хөгжилийн талаар хэд хэдэн сонирхолтой үгүүлэл[383] нийтлүүлсэний дээр *'Монгол бичигийн хэл зүй'* гэдэг

---

379 Г. И. Рамстедт, Сравнительная фонетика., 3

380 Б. Я. Владимирцов, О трёх периодах монгольского письменного языка, *'Монголь-ский сборник рассказов из Pancatantra'*, Петербург, 1921, 42-54

381 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика., 21-22

382 С. А. Козин, Язык первого периода истории монгольской литературы, ИАН СССР, Отд. общ. наук, М-Л., 1935, 477-500; Очерк развития письменности и литературы монгольских народов (XIII-XIVвв.), *'Джангариада'*,М-Л., 1940, 3-58

383 N. Poppe, Beiträge zur Kenntnis der altmongolischen Schriftsprache, AM 1, 1924, 668-675; *Geserica.* Untersuchungen dere sprachlichen Eigentümlichkeiten der mongolischen Version des *Gesserkhan,* AM 3, 1926, 1-32, 167-193; Bemerkungen zum vorklassischen

номдоо монгол бичигийн хэлийг мөн өмнөх уламжилалын дагуу гурван үе шат болгон үечилжээ. Үүнд:

1-р үе: XII зуунаас XVII зуун хүртэлхи үе
2-р үе: XVII зуунаас Октябрийн хувисхалыг хүртэлхи үе
3-р үе: Октябрийн хувисхалаас хойшхи үе

Тэрвээр энд монгол бичигийн хэлний нэгдүгээр үеийн онцлог шинжийг тодорхойлохдоо, үгсийн сангийн бүрэлдэхүүнд нь хуучин үг хэллэг үлэмж хэмжээгээр хадгалагдаж байсан, түрэг зэрэг харь хэлний үгс цөөрсөн, үсэгийн тиг дүрс нь уйгур бичигийн шинжийг хадгалсаар байсан зэрэгийг дурдсан байна.[384] Мөн монгол газар бурханы шашин хүчтэй дэлгэрсэний уламаас төвд зэрэг харь хэлний үгс үлэмжхэн нэмэгдэж, утга санаа нь мэдэгдэхгүй болсон хуучин үг хэллэгүүд орхигдсон хийгээд үсэгийн хэлбэр дүрс, бичлэгийн дүрэм зүй нь улам бүр нарийсч, харь хэлний үгсийг тэмдэглэх үсэг шинээр зохиосон зэрэгийг бичигийн хэлний хоёрдугаар үеийн онцлогтой холбогдуулан авч үзсэн байна.[385] Зохиогч хожим уг номынхоо нэмэн засварласан хоёрдох хэвлэлдээ мөн өмнөх үечилэлээ хэвээр нь үлдээсэн байна.[386]

Профессор Г. Д. Санжеев *'Монгол хэлнүүдийн харьцуулсан хэл зүй'* гэдэг томоохон бүтээлдээ монгол бичигийн хэлийг XII зууны эцэс, XIII зууны эхэн үеэр үүссэн гэж дурдаад, түүний хөгжилийн түүхийг дээрхийн нэгэн адил гурван үе болгон хуваажээ.[387] Мөн профессор G. Doerfer монгол бичигийн хэлний тухай үгүүлэлдээ монгол бичигийн хэлний хөгжилийн түүхийг мөн л гурван үе шат болгон ангилсан бий.[388] Хожим профессор А. Лувсандэндэв монгол бичигийн хэлний түүхийг мөн дээрхийн адил гурван үе шат болгон үечилсэн нь цаг хугацааныхаа хувид өмнөх үечилэлүүдтэй тохирч байгаа боловч үе шат тус бүрийн онцлог шинжийн талаар арай өөр санал дэвшүүлжээ.[389] Үүнд:

I. Эртний үе /Үл мэдэгдэх үеэс XIII зуун хүртэл/

Энэ үед хэлний хойгуурхи ***а, ӣ, о, и,*** хэлний дундуурхи ***ӓ, і, ӧ, ӱ*** гэсэн найман богино эгшигтэй, хоёр эгшигийн хоорондох ***γ/g*** болон үгийн эхний ***ρ*** (f, h) хадгалагдаж үлдсэн.

Schriftmongolisch, ZAS 3, 1969, 105-128; Altaic Linguistics – An Overview, *Science of Language,* Tokyo, 1975, 130-186

384 Н. Поппе, Грамматика письменно-монгольского языка, 13

385 Н. Поппе, Грамматика письменно-монгольского языка, 13-14

386 N. Poppe, Grammar of Written Mongolian {= PLO NS 1}, Wiesbaden, 1954, 2-3

387 Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, М., 1953, 15

388 G. Doerfer, Die mongolische Schriftsprache, HdO 5:2, 1964, 81

389 А. Лувсандэндэв, К вопросу о периодизации монгольского литературного языка, ХЗ 9, 1972, 19-21

II. Дундад үе /XIV зуунаас XVII зуун хүртэл/

1-р шат (XIII зууны эхнээс XIV зууны эх хүртэл)-нд хэлний хойгуурхи *ï*нь саармаг ***i*** болж, хэлний дундуурхи ***a, o, u*** гарч ирсэн. Үгийн эхний ***h***-хэвээрээ хадгалагдаж, хоёр эгшигийн хоорондох ***γ/g*** сугарч, хос эгшиг үүссэн.

2-р шат (XIV-XVII зуун)-нд урт эгшиг үүсч, үгийн эхний ***h***- гээгдсэн, тоо, хүйсийн зохьцол алдагдаж, уйгур, перс хэлний үг олоноор орж ирсэн.

III. Шинэ үе. /XVII зууны дунд үеэс XX зуунаас хойш/

1-р шат (XVII-XX зууны дунд үе)-нд монгол бичигийн хэлний одоогийн үндэсэн шинж хэвшин тогтжээ.

2-р шат (1940-өөд оноос хойш)-нд кирил үсэгт үндэслэсэн шинэ бичигийг хэрэглэж эхэлсэн. Хэл зүйн зарим хуучирсан хэлбэрүүд өөрчилөгдөж, шинэ шинэ үг ухагдахуун, нэр томъёо, европ хэлний олон үгс орж ирсэн.

Мөн зөвлөлтийн эрдэмтэн М. Н. Орловская монгол бичигийн хэлийг үечилэх тухай өөрийн саналыг дэвшүүлжээ.[390] Үүнд:

I. Эртний үе /VII-XII зуун/
II. Дундад үе /XIV-XVI зуун/
III. Сонгодог үе /XVII-XX зуун хүртэл/
IV. Орчин үе /XX зуунаас хойш/

Дээр дурдсан үечилэлүүд нь монгол бичигийн хэлний хөгжилийн түүхийг зөв зүйтэй тусхасан боловч зарим талаараа өрөөсхөлдүү шинжтэй зүйл ч бас бий билээ.

Монгол бичигийн хэлний хувьсал хөгжил, түүний хөгжилийн үе шатын талаар профессор N. Poppe, E. Haenisch, Ц. Дамдинсүрэн, Б. Ринчен, Ж. Надмид, L. Ligeti, Ш. Лувсанвандан, G. Kara, Igor de. Rachewiltz, Ц. Биткеев, Sh. Ozawa, Д. Төмөртогоо, Ц. Шагдарсүрэн, Д. Заяабаатар нарын бүтээлүүд нийтлэгдсэн бол[391]

---

390 М. Н. Орловская, О периодизации истории развития монгольского письменного литературного языка, *Mongolica.* Памяти акад. Б. Я. Владимирцова, М., 1986, 80-90

391 N. Poppe, Beiträge zur Kenntnis der altmongolischen Schriftsprache, AM 1,1924, 668-675; E. Haenisch, Beiträge zur mongolischen Schrift und Volkssparache, MSOS 28,1925, 170-185; Ц. Дамдинсүрэн, Монгол бичигийн хэл, *'Монгол хэл бичгийн тухай',* Уб., 1957, 112-120; Б. Ринчен, Монгол бичгиийн хэлний зүй, Уб., 1964, 3-248; Ж. Надмид, Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм, Уб., 1967, 15-21, 23-32, 39-40, 86-98; Ш. Лувсанвандан, Монгол бичгиийн хэл, МС 7:5, 1975, 48-50; L. Ligeti, A propos de quelques textes mongols préclassiques, AOH 18, 1970, 251-284; Д. Кара, Книги монгольских кочевников, М., 1972, 32-35, 68-72, 100-103 // Books of the Mongolian Nomads. More than Eight Centuries of Writting Mongolian. Bloomington, 2005, 25-50, 160; Igor de. Rachewiltz, Some Remarks on Written Mongolian, *'International Symposium on Mongolian Culture',* Meng-Tsang Wei-yüan-hui,Taipei, 1993, 123-136; Some Reflections on

монгол бичигийн хэлболон түүний дурсхалуудын хэлний онцлог шинжийн талаар N. Poppe, L. Hambis, Г. Д. Санжеев, M. Weiers, С. Гарди, Д. Заяабаатар нарын бүтээл гарсан бий.[392]

Ер аливаа бичигийн хэл үүсэн бүрэлдэж, хэвшин тогтохдоо харьцангуй урт удаан хугацаа шаарддаг түүхэн үзэгдэл билээ. Гэтэл монгол бичигийн хэлний түүхэн хөгжилийг үечилсэн эрдэмтэд цаг хугацааны хувид хэт огцом хуваасан учир бичигийн хэлний тухайн нэгэн үеийн онцлог шинжийг өмнөх, хойдох үеэс нь тодорхой ялган зааглахад бэрхшээлтэй болсон байна. Хэрэв Б. Я. Владимирцовын энэхүү үечилэлийг цаг тооны бичигийн дагуу хатуу баримтал-вал, монгол бичигийн хэлний хоёрдугаар үе нь XIV зууны эх буюу бүр тодоруулан хэлвэл 1301 оноос эхлээд XVI зууны эцэс буюу 1600 он хүртэлхи үеийг хамаарах болно. Хэрэв тэгвэл Перст сууж байсан ил хаадаас европын вангууд болон Ромын пап ламд илгээсэн захидалуудын зарим нь (1289, 1290) монгол бичигийн хэлний нэгдүгээр үед хамаарагдаж байхад бас зарим нь (1302, 1305) хоёрдугаар үед хамаарагдах болж байна. Тэр ч байтугай нэг хүний хоёр өөр онд бичсэн зүйл ч бичигийн хэлний хоёр өөр үед багтахад хүрэх болно. Өөр хоорондоо хэдхэн жилийн зайтай бичигдсэн ил хаадын захидалуудыг харьцуулан үзвэл, тэдгээрийн хооронд бие биеэсээ ялгагдах ямар ч онцлог шинж ажиглагдахгүй байгаа билээ. Мөн зарим эрдэмтэдийн үечилэлд тухайн үеийн улс төр-үзэл сурталын байдалаас шууд шалтгаалсан өрөөсхөл хандлага ч харагдаж байна. Тэр ч байтугай зарим бүтээлд хэлний хөгжилийн үечилэлийг бичигийн хэлний үечилэлтэй худхасан ташаарал ч гарчээ.

§ 61. **Монгол бичигийн хэлний хөгжилийн үе шат**. Монгол бичигийн хэлний хөгжилийн түүхийг үечилэх нь олон зуун жилийн түүхтэй бичигийн хэлнийхээ туулан өнгөрүүлсэн хэв шинжүүдийг аль болох бодьтойгоор авч үзэх аргазүйн

So-called Written Mongolian, *'Studia Tibetica at Mongolica'* {= *Indica et Tibetica* 34}, Swisttal-Odendorf, 1999, 235-246; П. Ц. Биткеев, Языки и письменные системы монгольских народов, Москва-Элиста, 1995, 121-172; Д. Төмөртогоо, Монгол бичгиийн хэл, *'Монгол хэл шинжилэлийн онол, түүхийн асуудалууд'*, Уб., 2002, 290-322; Шагдарсүрэн, Ц. Монголчуудын бичиг үсгийн шинэчлэлтийн түүхийн асуудалд, SM (20), 1984, 119-124 || К вопросу истории реформ монгольских письменностей, ХЗ 19, 1987, 91-93; Сонгодог бичгийн хэл буюу монгол судрын хэлний зарим онцлогоос, AMo 2, 2003, 17-30; Д. Заяабаатар, Монгол бичгийн хэлний түүхэн хөгжлийг судлах асуудалд, МУИС МХСС ЭШБ 19, 2003, 53-66; Сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгалууд монгол хэлний түүхэн хөгжлийн баримт болох нь, AMon. 4, 2005, 75-86

392 Н. Поппе, Грамматика письменно-монгольского языка, М-Л., 1937, 11-196; N. Poppe, Grammar of Written Mongolian {= PLO NS 1}, Wiesbaden, 1954, 1-195; L. Hambis, Grammaire de la langue mongole écrite (*Premiére Partie*), Adrien-Maisonneuve, Paris, 1945, XXII+1-108; Санжеев, Г. Д. Старо-письменный монгольский язык, М., 1964, 7-88; Weiers, M. Untersuhungen zu einer historischen Grammatik der präklassi-schen Schriftmongolisch {= AF 28}, Wiesbaden, 1969, 1-238: Гарди, Dumdadu erten-ü mongγol kelen-ü sudulul {= *Dumdadu ulus-un mongγol sudulul-un kömürge*}, LUKQ, 2001, 1-742; Д. Заяабаатар, XIII-XVI зууны монгол бичгийн дурсгалын авиазүй, үгзүйн тогтолцоо, Уб., 2011, 1-204

асуудал билээ. Монгол бичигийн хэл нь түүхэн урт удаан хугацааны турш хөгжилийн нэгэн хэвшилээс дараагийн шинэ хэвшилд дэвшин орох замаар хувьсан өөрчилөгдсөөр ирсэн бөгөөд тэдгээр хэвшилүүд нь бие биеэсээ зохих хэмжээний ялгаатай байжээ. Тийм учираас бичигийн хэлний тухайн нэгэн үе шат нь авиа зүй, үгсийн бүрэлдэхүүн, тэр ч байтугай хэрэглээний хүрээгээрээ ч зохих хэмжээний ялгаатай байх ёстой. Тийм учираас монгол бичигийн хэлний хөгжилийн түүхийг үечилэхдээ, нэг талаас, холбогдох бичигийн дурсхалуудын хэлний онцлог шинж, нөгөө талаас, зарим эрдэмтэдийн саналыг үндэслэн монгол бичигийн хэлний хөгжилийн түүхийг ерөнхийд нь *'сонгодог монгол бичигийн хэл'*, *'сонгодог монгол бичигийн өмнөх үе'* гэсэн хоёр үндэсэн үе болгон ангилах нь зүйтэй гэж үзэж байна.

Монгол бичигийн хэлний түүхийг судалсан зарим эрдэмтэд XVII-XIX зууны үед холбогдох монгол бичигийн хэлийг *'сонгодог монгол бичигийн хэл'* гэж нэрлэсэн боловч түүнийгээ бичигийн хэлний түүхэн үе шаттай уялдуулан холбож үзсэнгүй. Учир зүйн талаас авч үзвэл, *'сонгодог монгол бичигийн хэл'*-ний нөгөө талд сонгодог шатанд хүрээгүй угтал үе гэж байх нь тодорхой билээ. Нөгөө талаар, монгол бичигийн хэлний дурсхалуудын хэлний шинж байдалыг бичигийн хэлний хэм хэмжээний үүднээс авч үзвэл бичлэгийн дүрэм зүй, хэл найруулга, үгсийн сангийнхаа талаар өөр өөр түвшинтэй байгааг ажиглаж болно. Тэр бүхэнийг үндэслэн монгол бичигийн хэлний хөгжилийн түүхийг 1. Сонгодог бичигийн өмнөх үе, 2. Сонгодог бичигийн үе гэж хоёр үндэсэн үечилэл болгон хуваах нь зүйтэй гэж үзэж байна.[393]

0.3.2.1 СОНГОДОГ БИЧИГИЙН ӨМНӨХ МОНГОЛ БИЧИГИЙН ХЭЛ

§ 62. **Сонгодог бичигийнөмнөх монгол бичигийн хэлний тухай.** Монгол хэл аялгуун дээр тулгуурласан бичигийн хэл үүсэн бүрэлдсэн тэр цагаас эхлээд уул бичигийн хэл бүрэн тогтвортой хэвшин тогтсон XVI-XVII зууны үеийг сонгодог бичигийн өмнөх монгол бичигийн хэлний үед хамааруулан үзнэ. Барагцаалвал, манай эриний VIII-IX зууны үед монголын зарим овог аймагууд согд гаралтай уйгур бичигийг зээлдэн авч уламаар түүнийг хэл аялгуундаа тохируулан засч хэрэглэсэн нь жинхэнэ биеэ даасан монгол бичигийн хэл үүсэн бүрэлдэхийн эхлэл болжээ

Ер XIII-XIV зууны үеэс үлдсэн уйгуржин монгол бичигийн дурсхалын хэлний шинж нь мөн тэр үеийн амьд хэл аялгууг сайтар тусхасан хитад, дөрвөлжин, араб үсэгийн дурсхалуудаас нилээд өмнөх үеийн хэв шинжийг тусхасан байгаа нь тодорхой ажиглагдаж байгаа билээ. Тэр нь монгол бичигийн хэл анх үүсэн бүрэлдсэн тэр цагийн монгол хэлний шинжийг тусхасан гэдэг нь эргэлзээтэй бишээ. Тэдгээр дурсхалуудын хэлний шинжийг түүхэн үүднээс харьцуулан үзвэл, монгол бичигийн хэл нь XIII-XIV зуунаас хэдэн зуун жилийн өмнөх үе буюу тухайлвал, монголчууд анх уйгур бичигийг хэл аялгуундаа тохируулан авч

---

393 Д. Төмөртогоо, Монгол бичгийн хэл, *'Монгол хэл шинжилэлийн онол, түүхийн асуудалууд'*, 2002, 298-320

хэрэглэсэн тэр үе буюу VIII-IX зууны үеийн монгол хэлний үндэсэн шинжийг тусхасан байна гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Энэ талаар профессор N. Ропре, Ш. Лувсанвандан нар цухас тэмдэглэсэн зүйл бий.[394] Энэ бүхэнээс үзвэл, монгол бичигийн хэл үүсэн бүрэлдсэн цаг үе нь гадаад түүхэн нөхцөлөөрөө ч, хэлний онцлог шинжээрээ ч VIII-IX зууны үед үүсэн бүрэлдсэн байна. Уйгуржин монгол бичигийн гарал үүсэлтэй холбогдуулан энэ тухай өмнө тодорхой дурдсан билээ.

XIII зуун дөнгөж гарсаар түүхийн тавцан дээр монголын нэгдсэн гүрэн бүрэлдэн тогтож, түүнд нэгдэж байсан олонхи овог аймагууд улс төр, шашин, соёлынхоо талаар бие биетэйгээ зохих хэмжээгээр ойртон нэгдэж ирэхийн сацуу анх цөөн аймагийн бичигийн хэрэгцээнд үйлчилж байсан монгол бичигийн хэлний хэрэглэгдэх цар хүрээ нь улам бүр өргөжин тэлж, уламаар нийт монголчуудын бичигийн хэлний үүрэгийг гүйцэдхэх шаардлагатай болсон байна. Тэрхүү шаардлагын уламаас анх цөөн зарим аймагийн хэл аялгуун дээр үүсэн бүрэлдсэн бичигийн хэлийг нийт монгол хэл аялгуунуудын дундын байдалыг адил тэгш тусхасан илүү боловсронгуй бичигийн хэл болгох хэрэгтэй болжээ. Нөгөө талаар, уулаас арван дөрөвхөн үсэгтэй уйгур үсэг нь монгол хэлний авиаг бүрэн тэмдэглэх боломжгүй байсан тул түүнийг хэл аялгууныхаа онцлогт тохируулан нэмэж засах зайлшгүй шаардлага урган гарсан байна. Тийнхүү монгол хэл аялгуунуудын дундын байдалыг сайтар тусхасан бичигийн хэлийг боловсоруулан тогтооход XIII зууны үеийн хэл зүйч эрдэмтэн Сажа бандида Гунгаажалцан (1188-1251)-гийн зохиосон *'Зүрхний тольт'* хэмээх хэл зүйн бичиг чухал үүрэг гүйцэдхэжээ. Тэрвээр уул зохиолдоо уйгурын 14 үсэгийг монгол хэл аялгуунуудын онцлог байдалд тохируулан 100 авиа тэмдэглэж чадах 44 үсэг болгон нэмээд, уламаар үсэгийн дүрэм, хэлний зүй зэрэгийг болов-соруулжээ.

XIII-XIV зууны үеэс энэдхэгийн бурханы шашин монгол газар хүчтэй дэлгэрч, бурханы шашины сургаал номлол, бүддийн гүн ухааны зохиол бүтээлүүд болон дуун ухаан, анагаах ухаан, зурхайн ухаан, учир шалтгааны ухааны өдий төдий ном зохиолыг орчуулан гаргах болсон нь монгол бичигийн хэлийг улам боловсронгуй болгоход чухал түлхэц болсон байна. Монгол бичиг нь Юань гүрэний үед *'төрийн бичиг'* болон тунхаглагдаж, эзэнт төрөөс өндөр дэмжлэг хүлээж байсан дөрвөлжин бичигтэй зуу шахам жил эн зэрэгцэн өрсөлдөж, уридын байр суурия хадгалан үлдэж чадсан байна. Хайсанхүлэг хаан (1281-1311)-ы зарлигаар их эрдэмтэн Чойжи-Одсэр уйгуржин монгол үсэгийн бүрэлдэхүүнийг нэмэн дэлгэрүүлж, үсэгийн дүрэм, хэлний зүйг багтаасан *'Зүрхний толтын тайлбар'* хэмээх хэл зүйн бичиг туурвисан нь сонгодог бичигийн өмнөх монгол бичигийн хэлийг оргил үед нь хүргэж, бурханы шашины сургаал номлолыг олоноор орчуулан гаргажээ. Энэ тухай *'Банзрагч'* (Их минган ертөнцийг магад дарагч таван сахияа нэрт их хөлгөн судар)-ийн төгөсгөлийн үгэнд:

[34] tegün-ü qoyina terigülügči tere qaγan-u
delekei-yin eǰen bolγan erke ögtegsen

---

394 N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 15; Ш. Лувсанвандан, Монгол бичгийн хэл, МС 7:5, 1979, 49

ded köbegün-ü γutuγar üy-e-dür inü
tengsel-ügei Qayisan neretü törüǰü bürün

[35] köbegün čaγ-ačaγan ber uridus-dur
kösigürkegsen-i kölüg-iyer-iyen ülüdkeǰü
gür ulus-un eǰen bolγaγdaǰu bürin-e
Külüg qaγn kemen aldarsiγsan ken bögesü

[36] ünen uduriduγči ögülegčid-ün naran
učiraǰu Čos-kyi Odser neretü kelemüči-lüge
üy-e qoyar arγ-a bilig-ün küčün-iyer
oor mongγol-un ayalγu-bar nom-i delgeregülǰükü

[37] tengsel-ügei tere boγda-yin degü inü
degedü Buyantu qaγan ber burqan-u nom-i
tegünčilen kü delgeregülkü-yin eǰen bolǰu
tegün-eče ber aγui ta delgeregülügsen aǰuγu

гэж үгүүлсэн байдаг. Хайсанхүлэг хааны дараа Буянт (Аюурбарвада) хаан/1285-1320/-ы үед уйгуржин монгол үсэгээр уридаасаа ч илүү олон ном зохиол гарчээ. Тийм ч учираас Юань гүрэн оршин тогтож байсан тэр үеэс уламжилан үлдсэн монгол бичигийн дурсхалууд нь дөрвөлжин бичигийн дурсхалаас илүү олон байгаа билээ.

Сонгодог бичигийн өмнөх үеийн монгол бичигийн хэлэнд холбогдох олон тооны бичигийн дурсхалуудын дотор их хаадын дурсхалд зориулсан хөшөө чулууны бичээс, бүддийн сургаал номлол, ил хаадын захидал, энэдхэг, төвдийн сонгодог зохиолын орчуулга, пайз тамганы бичиг зэрэг олон тооны бичигийн дурсхал уламжилан үлдсэн бөгөөд тэдгээрийн тухай хойно тодорхой дурдах болно.

XIII-XIV зууны үеийн монгол бичигийн хэлний талаар профессор Г. Д. Санжеев дүгнэн бичихдээ: *'Хуучин монгол бичигийн хэл нь бүр XIII зууны үед сайтар хэвшин тогтсон дүрэм зүй, хэл найруулга бүхий боловсронгуй бичигийн хэл байсанаас үзвэл тэр нь монгол гүрэн бүрэлдэн тогтохоос ч бүр өмнө үүсэн бүрэлдсэн бололтой'* гэжээ.[395]

Хэдий тийм боловч сонгодог бичигийн өмнөх монгол бичигийн дурсха-луудыг ажиглавал, бичлэгийн дүрэм нь бүрэн жигдэрээгүй, үгсийн сан нь харьцангуй хизгаарлагдмал, хэл найруулгын өнгө аясын нарийн ялгарал тодорхой гараагүй, харь хэлний үгийг тэмдэглэн бичих үсэг тэмдэгт хүрэлцээгүй байсан зэрэг өрөөсхөл талууд ч байсаар байжээ. Мөн орчуулгын зохиолын дотор харь хэлний үгүүлбэрийн бүтэцэд баригдан, эх хэлнийхээ үгүүлбэрийн бүтэц, үгсийн тогтсон дараалалыг алддагдуулсан жишээ ч цөөнгүй тохиолдож байна. Түүнээс гадна тухайн үеийнхээ аман ярианы хэлэнд гарсан авианы ижилшил, сугарал, үе

[395] Г. Д. Санжеев, Старо-письменный монгольский язык, М., 1964, 8

хураагдах зэрэг хувьсалуудыг дууриан тусхаж, урид нэгэнт тогтсон бичлэгийн дүрэм зөрчигдсөн тохиол ч нилээд дайралдаж байна. Энэ бүхэн бол тэр үеийн бичигийн хэл бүх талаар бүрэн жигд хэвшин тогтоогүй байсаныг харуулж байгаа бөгөөд тийм ч учираас бид тэр үеийн бичигийн хэлийг нийтэд нь сонгодог бичигийн өмнөх үед хамааруулан үзэж байгаа билээ.

Барагцаалвал, VIII-IX зууны үеийн монгол хэл аялгуун дээр үндэслэн хэвшиж тогтсон монгол бичигийн хэл нь XIII-XIV зууны үе болж ирэхэд аман ярианыхаа хэлнээс ихээхэн зөрөөтэй болсон байжээ. XIII зууны сүүлчээр Юань гүрэнд багтаж байсан олон угсаатаны үсэг бичигийн хэрэгцээг адил тэгш хангаж чадах шинэ үсэг зохиох тухай Хубилай хааны зарлигийн дагуу *'дөрвөлжин үсэг'*-ийг зохиохдоо бичигийн хэлээ аман ярианыхаа хэлэнд ойртуулах гэсэн хандлагыг ч давхар тусхажээ. Тийм учираас дөрвөлжин бичигийн дурхалуудын хэл нь тухайн үеийнхээ амьд хэл аялгууны дуудлагад түшиглэсэнээрээ уйгуржин монгол бичигийн дурсхалуудаас ихээхэн ялгаатай болсон байдаг билээ. Хэдий тийм боловч дөрвөлжин бичиг нь уйгуржин монгол бичигт туссан авианы үндэсэн бүрэлдэхүүн, хэл зүйн тогтолцоо, үгсийн сангийн баялаг уламжилалыг залган авсан учир тэр нь биеэ даасан бичигийн хэл бус, сонгодог бичигийн өмнөх монгол бичигийн хэлний шууд үргэлжилэл мөн болно.

0.3.2.2 СОНГОДОГ МОНГОЛ БИЧИГИЙН ХЭЛ

§ 63. **Сонгодог монгол бичигийн хэлний тухай.** XVI-XVII зууны үеэс монгол газар бурханы шашин дахин хүчтэй дэлгэрсэн нь монголын нийгэм, соёлын амьдаралд хүчтэй нөлөөлж бурханы шашины сургаал номлол болон энэдхэг, төвдийн сонгодог ухааны зохиол бүтээлүүдийг монгол хэлээр орчуулан хэвлэх ажил ихэд өрнөжээ. Тийнхүү олон тооны ном зохиол орчуулан гаргахад бичлэгийн дүрэм, хэлний зүйгээ улам сайжируулан, харь хэлний үг ухагда-хууныг нарийн зөв тэмдэглэх, элдэв ухааны нэр томъёог нягтлан боловсоруулах, үгийн сангаа арвижуулан, хэл найруулгаа яруу тодорхой болгох шаардлага аяндаа урган гарчээ. Тухайн үедээ урган гарсан тэдгээр шаардлагын дагуу тэр цагийн бичигийн мэргэд хичээнгүйлэн оролцжээ. Бичлэгийн дүрэм, хэл зүйн хувид гэвэл, бандида Гунгаа-Одсэрийн *'Монголын зуун найман үсэг оршив'*, Алшаагийн рабжамба Данзандагва (*bsTan-hjin-grags-pa*)-ын *'Зүрэхний толтын тайлбар үсэгийн эндүүрэлийн харанхуйг арилгагч Огторгуйн маань'*, Урад гүүш Билигийн далайн *'Монгол үсэгийн хүртээл зүрхний толт'*, *'Монгол үсэгийн ялгал ба махбодын өчүүхэн товчнууд'* зэрэг бүтээл гарч, тэдгээрт зөв бичих ёс, авианы байрлалын хууль, хэл зүйн үндэсэн хэлбэрүүд, тэдгээрийг хэрхэн холбох арга, зарим үгсийн найруулгын үүрэг зэрэг олон чухал асуудалыг багтаасан байна. Мөн Харчины Аюуш гүүш 10-р жарны улаагчин гахай жил (1587) эртний энэдхэгийн *'али гали'* үсэгийн зарчим дээр тулгуурлан *'монгол галиг'* үсэгийг боловсоруулж, монгол бичигийн үсэгийн бүрэлдэхүүнийг үлэмжхэн баяжуул-санаар самгард, төвд зэрэг харь хэлний үгсийг нарийн зөв тэмдэглэх бүрэн боломжтой болжээ.

Бурханы шашины сургаал номлол, бүддийн гүн ухааны ном зохиолуудыг орчуулах явцад нэг ухагдахууныг олон янзаар буулгах, оноолт муутай үг, нэр

томъёо олон гарах болсон тул бүддийн гүн ухааны нийтлэг нэр томъёонуудыг жигдлэн тогтоох шаардлагатай болжээ. Энэ талаар тухайн үеийн олон мэргэд зөвлөлдөн хэлэлцээд, бурханы шашины их таван ухааны нэр томъёонуудыг нэгэн мөрөөр оновчтой тогтоохоор нэрт орчуулагч Жанжаа хутагт Ролби-доржийн удирдлагын дор мэргэн гүүш нар хүч хавсаран ажиллаад *'Мэргэд гарахын орон'*хэмээх төвд-монгол нэр томъёоны толийг эмхэдхэн гаргажээ. Тэр бүхний үндэсэн дээр бурхан багшийн сургаал номлол болон дорно дахины их таван ухааны 5500 орчим зохиолыг багтаасан *'Ганжуур'*, *'Данжуур'*-ын их хөлгөн сударуудыг орчуулахдаа тэдгээрт гардаг олон зуун нэр томъёог гагцхүү шинэ боловсоруулсан толиороо жигдлэн тогтоож, самгард, төвд хэлний олон үгсийг *'монгол галиг'* үсэгээрээ нарийн нягт тэмдэглэсэн байна.

Хэл найруулгын хувид, анх аман бичигийн хэлний уламжилал дээр тулгуурлан хөгжиж ирсэн найруулах арга ухааныг цаашид улам баяжуулан, тухайн зохиолын төрөл зүйл, онцлог шинжид тохирсон өнгө аясын нарийн ялгааг зааглан тогтоох талаар бичигийн мэргэд улам бүр туршилгажсаар иржээ. Эртний энэдхэгийн яруу найрагийн онолч Дандины *'Зохист аялгуу'* тэргүүтэй энэдхэг, төвдийн яруу найруулгын онолын зохиолуудаас орчуулан, тайлбар сэлтийн хамт гаргаж байсан нь бичигийн хэлний найруулах арга зарчимд чухал нөлөө үзүүлсэн байна. Ингэсэнээр монгол бичигийн хэлний найруулах арга нь шашин номын, гүн ухааны, албан бичигийн, уран зохиол, яруу найрагийн, төрөл бүрийн мэдлэг ухааны гэх зэрэг олон төрөл зүйлээр ялгарч, хойш хойшдоо улам бүр нарийсан хөгжжээ. Тийнхүү монгол бичигийн хэл нь бичлэгийн дүрэм, хэлний зүй, үгсийн сан, хэл найруулгынхаа талаар улам бүр боловсорсоор жинхэнэ сонгодог бичигийн хэл болж чаджээ. XVII-XVIII зууны үед *'Ганжуур'* (108 боть), *'Данжуур'* (225 боть)-аас аваад *'Алтан товч'*, *'Эрдэнийн товч'*, *'Эрдэнийн эрих'*, *'Болор эрих'* гэх мэт олон арван боть түүхэн сурвалж бичигүүд, бүддийн гүн ухаан, хэл шинжилэл, тэжээхүй ухаан, учир шалтгааны ухаан, уран зохиол, бурханы шашины сургаал номлол зэрэг өдий төдий ном зохиолыг хэвлэн гаргасан нь монгол бичигийн хэл чухам л сонгодог бичигийн хэлний зиндаанд хүрсэний жинхэнэ бодитой баримт болж байгаа билээ.

XIX зууны үед Алшаа лхарамба Агваандандар, буриадын Сумадираднаа /Лувсанринчен/, Түмэдийн Галсан, хуажин ширээт Дэлэгжунай нарын зэрэг нэрт эрдэмтэдийн хэл зүйн бүтээлүүд гарсан нь сонгодог монгол бичигийн хэлийг улам боловсронгуй болгоход доривтой хувь нэмэр болжээ.

Энэ завсар бичигийн хэлээ аман яриандаа ойртуулах гэсэн оролдлого удаа дараалан гарч, XVII зууны дундуур *'тод үсэг'*, түүний дараахан *'соёмбо үсэг'*, хожим XX зууны эхээр *'Вагиндрагийн үсэг'* зохиогдсон бөгөөд тэдгээр нь нэг талаар монгол бичигийн хэлний үргэлжилэл болон хөгжиж, нөгөө талаар, тухайн үеийнхээ амьд ярианы хэлийг бодьтойгоор тусхасан үнэтэй чухал хэрэглэг-дэхүүн болж байна.

Эдүгээ бид төв монгол хэлний халхын аман аялгуун дээр тулгуурлан боловсоруулсан кирил бичигийг хэвшүүлэн хэрэглэсээр хагас зуу гаруй жил болсон

бөгөөд энэ нь авианы тогтолцоо, хэл зүйн шинж, үгсийн сан, хэл найруулгаараа сонгодог бичигийн хэлний шууд үргэлжилэл мөн билээ. Учир нь, бид бичигийн хэлний түүхийг үечилэхдээ үсэг бичигийн ялгаа болон хэлний өнгөц шинжийг гол болгохгүй, зөвхөн тухайн бичигийн хэлний үндэсэн суурь шинжийг гол баримжаа болгодог билээ. Хэрэв түүхэн өөр өөр үед зохиогдсон янз бүрийн тогтолцоотой үсэг бичиг тус бүрийг биеэ даасан бичигийн хэлний үндэс суурь болно гэж үзвэл тэр нь бичигийн хэлний үечилэл биш, бичиг үсэгийн ангилал болохсон билээ. Тийм учираас одоогийн бичигийн хэл нь монгол бичигийн хэлний түүхийн хоёрдугаар үе буюу сонгодог бичигийн хэлний үед шууд хамаарна.

0.3.3 МОНГОЛ ХЭЛНИЙ БИЧИГИЙН ДУРСХАЛУУД, ТЭДГЭЭРИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

0.3.3.1 **ХИТАН БИЧИГИЙН ДУРСХАЛУУД**

§ 64. **Хитан бичигийн дурсхалууд, тэдгээрийн судалгаа**. Анх XIX зууны үед Өвөр Монголын Жу-үд аймагийн Баарин баруун хошууны *'Цагаан суварга'* хэмээх эртний хотын тууринаас үл мэдэгдэх үсэгээр бичсэн хэд хэдэн бичээс олдсон бөгөөд хожим XX зууны эхээр мөн тэндээс хөшөө чулууны бичээс, тамага, пайз, зоосны бичиг зэрэг нилээд олон дурсхал олджээ. Тэдгээр дурсхалууд нь манай эриний X-XII зууны үед холбогдох хитан үсэгийн дурсхал болохыг Н. Я. Бичурин, А. М. Позднеев A. Wylie нар анх таниж мэдээд, энэ талаар өрнө дахинд мэдээлсэн байна.[396] Хожим хитадын эрдэмтэн Wang Jing-ju, Lo Fu-cheng нар дээрхи дурсхалуудын дотор хитан гүрэний эзэн хаан Дао-зун, хатан хаан Сюань-и, Жэн-и нарын дурсхалд зориулсан хөшөөний бичээс болохыг тогтоож, уламаар хаад ноёдын цол хэргэм, цаг тоолол, тоо хэмжээ, од эрхэсийн холбогдолтой тавь гаруй нийлмэл дүрсийн утгыг тайлсан байна.[397] Түүний дараа японы эрдэмтэн Jitsuo Tamura, Yukio Kobayashi нар дээрхи дурсхалуудын үсэг, тэмдэгтүүдийг *'Монголын нууц товчоо'*-ны хитад ханз үсэгийн тогтолцоотой харьцуулан судалаад *'XI зууны үед Дорнод Монголоос олдсон Лиао улсын эзэн хааны бунхан ба түүний ханын зураг'*[398] гэсэн хоёр боть бүтээл туурвижээ.

Хитан бичигийн дурсхалуудын судалгаа нь юуны өмнө хитан хэл ямар хэлэнд хамааралтай болохыг тогтоох, уламаар тухайн хэлний бүтэц, тогтол-цооны онцлог шинжийг баримжаалан тодоруулахад чиглэгдсээр иржээ. Тухайлвал, нэрт алтайч эрдэмтэн W. Kotwicz хитан бичигийн судалгааны эхний үр дүн дээр тулгуурлан

---

396 Н. Я. Бичурин, Собрание сведений о народах обитавших в Средней Азий в древние времена, I, М-Л., 1950, 362-369; А. М. Позднеев, Лекции по истории монгольской литературы, т. I. 5-7; A. Wylie, On an Ancient Inscription in the Neuchin Language, JRAS, 2, 1860, 331-345

397 Wang Jing-ju, The First Deciphering of the Tombstone Letters Dedicated to the Emperor Tao-tsun and Queen Hsüan-i, *Bulletin of the Institute of History and Philology,* Academia Sinica, vol. 3:2, 5:4

398 Jitsuo Tamura, Yukio Kobayashi, Tombs and Mural Paintings of Ching-Ling, Liao Imperial Mausoleum of Eleventh Century A. D. in Eastern Mongolia, vol. I (Text), vol. II (Plates), Kyoto, 1953

'хитанчууд бол монгол хэлтэнүүдийн дээд өвөг' гэсэн дүгнэлт гаргажээ.[399] Мөн францын эрдэмтэн L. Hambis хитанчуудын хэл аялгууг мөн монгол хэлэнд хамааруулан үзсэн байна.[400] Түүнчилэн академич L. Ligeti *'Хитан бичигийн дурсхалуудаас зуу гаруй үгсийн утгыг оноцын бэрхшээлгүй тайлан уншиж боломжтой бөгөөд хитанчуудын хэл нь монгол хэлэнд холбогдоно гэдэгийг тэдгээр үгс маргаангүй гэрчилж байна. Хитан хэл нь XIII-XIV зууны үеийн монгол хэлийг бодвол нилээд эртний шинжтэй байсан гэдэгийг тогтооож болно'* гэж тэмдэглэсэн бий.[401] Тэрвээр бас уйгуржин монгол бичиг нь угтаа хитаны *'бага бичиг'*-ээс гаралтай байж магадгүй гэсэн өвөрмөц саналыг ч бас дэвшүүлсэн билээ.[402]

Жараад оны үед зөвлөлтийн эрдэмтэд хитан бичигийн дурсхалын үсэг тэмдэгтийг электрон машинаар тооцоолон бодоод *'Хитанчуудын хэл бол монгол хэлний бүлэгт багтана'*[403] гэж дүгнэсэн нь хитан бичигийн дурсхалын судалгаанд ч, хитанчуудын угсаа гаралын асуудалыг тогтооход ч чухал ахиц болсон гэж үзэж болно. Дээрхи судалгаанд оролцсон эрдэмтэн Ю. Кнорозов: *'Хитанчууд гадаад хэлбэрээрээ хитад утгын бичигтэй ойролцоо боловч түүнээс огт өөр бүтэцтэй бичиг хэрэглэж байжээ. Тэдний хэл нь хитад хэлтэй төрөл бус, харин монгол хэлтэй гарал болохыг тооцоолон бодох машин тогтооож өглөө'*[404] хэмээжээ.

Мөн зөвлөлтийн эрдэмтэн В. С. Таскин хитан бичигийн гуч орчим тэмдэгтийг тайлан унших оролдлого хийж, уламаар судалгааныхаа туршилга дээр тулгуурлан *'Хитан хэл бол монгол хэлний бүлэгт багтах бөгөөд тэдний бичиг нь үеийн тогтолцоотой байсаныг хитан бичигийг тайлан унших явцад мэдэж болно'* хэмээн дурдсан байна.[405]

Далаад оны дундаас хитадын эрдэмтэд хитан бичигийн дурсхалыг судалах эрдэмтэдийн баг байгуулж, юуны өмнө хитад, хитан хоёр хэлээр бичсэн дурсхалуудад тохиолдож байгаа зарим тусхай нэр, цаг улиралын нэр, тооны нэр зэрэгийг харьцуулан үзээд, хитан бичигийн бичлэгийн тогтолцоо, илэрхийлэх утга хийгээд дуудлага зэрэгийг баримжаалан тогтоох тохиромжтой аргазүй

---

399 W. Kotwicz, Les Khitai et leur écriture, RO VII, 1925, 248-250

400 L. Hambis, Premier essai de dechiffrement de la langue khitan, *Comptes Rendus de l'Academie des inscription et Belles-lettres,* Paris, 1953, 121-134

401 Л. Лигети, Рец. на кн: Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, 138

402 ibid., 136-138

403 В. С. Стариков, М. В. Наделяев, Предварительное сообщение о дешифровке киданьского письма, 1964, 2-26; А. Кондратьев, В. С. Стариков, Электронный филолог делает открытие, *Неделя,* № 30, 1964; V. S. Starikov, Catalogue of Graphems of the Kitan Script, Moscow, 1966, 12; *idem.* Материалы дешифровке киданьского письма, 1. Формальный анализ функциональной структуру текста, 1970; Т. А. Пробст, О машинной разработке киданьских текстов, *Предварительное сообщение о дешиф-ровке киданьского письма,* 1970, 27-34

404 Ю. Кнорозов, Первые успехи в дешифровке письменность киданьского народа, *Неделя,* № 30, 1964

405 В. С. Таскин, Опыт дешифровки киданьской письменности, НАА 1, 1963, 127

боловсоруулжээ. Тус багийн судалаачид эдүгээ хүртэл олдоод байгаа хитан бичигийн дурсхалуудын гэрэл зурагийн эхийг багтаасан тусхай эмхэдхэлийг[406] хэвлүүлсэнээс гадна 370 гаруй тэмдэгтээр бичсэн 9500 гаруй үг бүхий 9 томоохон дурсхалын дотороос 130 гаруй үгийн дуудлага, 300 орчим үгийн утгыг тогтоосон байна.[407]

Хитан бичигийн дурсхалуудын судалгааны тойм байдалын талаар проф. G. Kara,[408] D. Sinor,[409] Ц. Шагдарсүрэн,[410] Liu Fengzhu,[411] Чингэлтэй,[412] Matsukawa Takashi[413] нарын бүтээлүүд гарсан бий.

Хитан бичигийн судалгаа энэ мэт ахицтай байгаа хэдий ч үсэг тэмдэгт тус бүрийн бодит дуудлагыг сэргээн тогтоож чадаагүй учир уул хэлний авианы тогтолцоо, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэрүүдийг хэл шинжилэлийн үүднээс баримжаалан тогтоох боломж хараахан бүрдээгүй байна.

0.3.3.2 УЙГУРЖИН МОНГОЛ БИЧИГИЙН ДУРСХАЛУУД

§ 65. **Уйгуржин монгол бичигийн дурсхалууд,тэдгээрийн судалгаа**. Өдгөө манай үед уламжилан үлдсэн монгол бичигийн хэлний хамагийн эртний дурсхалууд нь XIII-XIV зууны үед холбогдох бөгөөд тэдгээр нь анх бүрэлдэн тогтсон цаг үеийнхээ хэлний үндэсэн шинжийг хадгалсан тул хэлний хөгжилийн үе шатны хувид *'эртний монгол хэл'*-ийг, бичигийн хэлний үечилэлийн хувид *'сонгодог бичигийн өмнөх монгол бичигийн хэл'*-ийг тус тус тусхасан байна.

---

406 Chinggeltei, Liu Fengzhu, Chen Naixiung, Yu Baolin, Xing Fuli, Studies on the Kitan Small Scripts, Publishing House of Social Sciences of China, Beijing, 1985, 799 pp. (хитад хэлээр)

407 Research Team for Kidan Studies, Special Issue for the Study of Kitan Small Characters, Research Journal of Inner Mongolia University, No 4, 1997 (хитад хэлээр); Wang Hongli, Researches on the Tomb Inscriptions in Small Kitan Script, MYu, 4, 1986 (хитад хэлээр); Gao Lujia, Researches on the Plural Markers of Kitan Small Characters, *Research Journal of Inner Mongolia University,* No 2, 1988 (хитад хэлээр); Han Baoxing, Textual Research on an Inscription in Chitan Small Characters Discovered on a Memorial Tablet within Yelü Renxian's Tomb. (хитад хэлээр); Chen Naixiong, Yang jiye, Örgental-a daki Liyou ulus-un dörbedüger bulasin-ača oldaγsan kidan baγ-a üsüg-ün kösiyen bičigesü-yi sudulun tayilburilaqu ni, (Olan ulus-un mongγolči erdemted-ün doluduγar yeke qural-un ügülel)

408 G. Kara, On the Kitan Writing Systems, MS X, 1986-1987, pp. 20-22

409 D. Sinor, Western Information on the Kitans and Some Related Questions, JAOS 112:2, 1995, 262-269

410 Ц. Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичгийн товчоон, 11-18

411 Liu Fengzhu, Seventy Years of Khitan Small Script Studies, SO 87, 1999, 159-169

412 Chinggeltei, On the Problems of Reading Kitan Characters, AOH 55, 2002, 99-114

413 Matsukawa Takashi, The New Materials and Recent Studies of Qidan Script in Mongolia, *Tokyo University of Foreign Studies*. Institute of Asian and African Studies, 2008, 101-108

Эдүгээ бидэнд мэдэгдэж байгаа уйгуржин монгол бичигийн дурсхалуудыг дотор нь 1. хөшөө чулууны бичээс, 2. барын ном судар, 3. бичмэл ном судар, захидал бичигийн дурсхал, 4. пайз, тамганы бичиг хэмээн ангилж болно.

§ 66. **Хошоо чулууны бичээс**. Эдүгээ бидний үед хорь шахам хөшөөний бичээс, ханын бичээсүүд уламжилан үлдсэн бөгөөд тэдгээрийн хамагийн эртнийх нь 1225 оны Йисүнхэгийн бичээс, хамагийн цөөн үгтэй нь 1240 оны Өгөдэй хааны зарлиг 15 үгтэй, хамагийн олон үгтэй нь 1330 гаруй үгтэй Индү вангийн гэрэлт хөшөөний бичээс юм. Тэдгээр дурсхалын олонхи нь БНХАУ-ын нутаг дэвсхэр дээр байгаа ажээ. Тухайлвал Өгөдэй хааны зарлигийн хөшөө (1240), Мөнх хааны зарлигийн хөшөө (1254) Хубилай хааны зарлигийн хөшөө (1261) гурав нь Хэнан мужид, Чан йин-жүйн дурсхалд зориулсан хөшөөний бичээс (1335), Жигүндэйн дурсхалд зориулсан хөшөөний бичээс (1338) хоёр нь Өвөр Монголын Улаанхад хотын Оннигуд хошууны нутагт, Индү вангийн дурсхалд зориулсан хөшөөний бичээс нь Ганьсу мужийн Лианжоу хотын орчимд, Аруг вангийн хөшөө нь Юннань мужид тус тус анх босхосон газараа хадгалагдаж байна. Харин 1257 оны Мөнх хааны хөшөө (1362), Хар хорумын бичээсүүд нь Монгол улсын нутагаас олджээ. Ханан бичээсүүдийн тухайд гэвэл, гуч гаруй бичээс бүхий Дунхуаны агуй нь БНХАУ-ын Ганьсу мужид, гурван хэсэг том бичээс бүхий Аржайн агуй нь Өвөр Монголын Ордосын нутагт байна.

Анхандаа *'Чингисийн чулууны бичээс'* хэмээн алдаршсан Йисүнхэгийн хөшөөний бичээсийн талаар бүр XIX зууны сүүлчээр Я. Шмидт, Д. Банзаров, А. Позднеев зэрэг эрдэмтэд удаа дараалан уншиж судалсан[414] нь уйгуржин монгол бичигийн дурсхалуудын судалгааны эхлэл нь болсон байна. Хожим энэхүү бичээсийн талаар Sh. Murayama, L. Hambis, Х. Пэрлээ, Igor de Rachewiltz нарын судалгааны бүтээлүүд[415] гарсан билээ.

Уйгуржин монгол үсэгийн бичээсүүдийн дотор хамагийн томоохон нь хитад-монгол бичээсүүд юм. Профессор F. W. Cleaves өнгөрсөн зууны дундаас эхлэн тэдгээр дурсхалуудыг дагнан судалж, олон цуварал үгүүлэл нийтлүүлсэн билээ.[416]

---

414 Я. Шимдт, О новом переводе монгольской надписи на известном памятнике Чингис-хана, Санкт-Петербургские ведомости, No 224, 1839; Д. Банзаров, Объяснение монгольской надписи на памятнике князя Исунке, племянника Чингис-хана, Черная вера, или шаманство у монголов, Ст. Петербург, 1891, 88-105 || Собрание сочинений, М., 1955,187-206; М. Позднеев, Лекции по истории монгольской литературы, том. I.С-Петербург, 1896, 51-79

415 Sh. Murayama, Über die Inschrift auf dem *'Stein des Čingis',Or.* 3, 1950, 108-112; L. Hambis, À propos de la *'Pierre de Gengis-khan', Mélanges publiés par l'Institut des Hautes Etudes Chinoises* II, Paris, 1960, 141-157; Х. Пэрлээ, Чингисийн чулууны бичээс, SM 3:13, 1962, 3-23; I. de Rachewiltz, Some Remarks on the Stele of *Yisüngge, Tractata Altaica,* Wiesbaden, 1976, 487-508

416 F. W. Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1362 in Memory of Prince *Hindu,* HJAS 12, 1949, 1-133; The Sino-Mongolian Inscription of 1335 in Memory of Chang Ying-jüi, HJAS 13, 1950, 1-131; The Sino-Mongolian Inscrip-tion of 1338 in Memory of Jigüntei,

Хитад-монгол бичээсүүдийн дотороос Мөнх хааны хөшөөний бичээсийн талаар Б. Ринчен, N. Poppe нар,[417] Аруг вангийн хөшөөний бичээсийн талаар Х. Лувсанбалдан, G. Kara нар[418] тус тус судалгааны үгүүлэл нийтлүүлжээ. Хожим 1980-аад оны үед олдсон Мөнх хаан, Хубилай хааны зарлигийн хөшөөний бичээсүүдийн талаар японы эрдэмтэн J. Nakamura-T. Matsukawa, Добу-Зуунаст нар[419] тусхай үгүүлэл гаргасан нь тухайн дурсхалын талаархи анхны судалгаанууд юм .

Ханан бичээсүүдийн судалгааны тухайд гэвэл, Дунхуаны агуйн зарим бичээсийн талаар XX зууны эхээр профессор P. Pelliot[420] анх мэдээлсэн бөгөөд хожим өвөр монголын эрдэмтэн Хас-Эрдэнэ, Гарди нарын цуварал үгүүлэл[421] болон нэгдхэсэн материал[422] гарсан билээ.

F. W. Cleaves,[423] N. Poppe,[424] G. Kara,[425] I de Rachewiltz,[426] J. Nakamura-T. Matsukawa[427] нарын судалгааны бүтээлүүд бий.

HJAS 14, 1951, 1-104; The Sino-Mongolian Inscription of 1346, HJAS 15, 1952, 1-123; The Lingji of *Aruy* of 1340, HJAS 25, 1964-65, 31-78

417 Y. Rinčen, L'inscriptrion sino-mongole de la stele en l'honeur de *Möngke qayan,* CAJ 4, 1958, 130-138; N. Poppe, Notes on the Monument in Honour of *Möngke Khan,* CAJ 6, 1961, 14-18

418 Х. Лувсанбалдан, Аруг вангийн хөшөөний бичиг, SM 4:6, 1962, 123-136; G. Kara, L'inscription mongole d'Aruγ, prince de Yun-nan, AOH 17, 1964, 145-173 + 3

419 J. Nakamura, & T. Matsukawa, A Newly Discovered Inscription of Mongolian-Chinese Bilingual Edicts from *Shao-lin si* Temple, SIAL, VIII, 1993, 32-48; Matsukawa, Takashi, The Sino-Mongolian Inscription of 1348 from Qaraqorum, Society of Central Eurasian Studies, SIAL XII, 1997, pp. 83-98; *idem.* Three Newly Published Mongolian Edicts, *Research on Political and Economic Systems under Mongol Rule,* Osaka, 2002, 55-59 (япон хэлээр); Dob, Junast, Textual Research and Explanation of an Inscription of Imperial Edict both in Uighur Mongolian and hP'ags-pa Script Unearthed at Shaolin Temple of Deng-feng County, Henan Province, MYu 6, 1993, 59-64; Textual Research and Explanation of an Inscription of Imperial Edict both in Uighur Mongolian and hP'ags-pa Script Unearthed at Shaolin Temple of Dengfeng County, Henan Province, II. The Edict of Khubilai of the Yeare of Dragon, MYu 1, 1994, 31-37 (хитад хэлээр)

420 Mission Pelliot I, Les grottes de Touen-houang. Tome Premier, Grottes 1 à20. Paris, 1920, Planche XII

421 Qas-Erdeni, Garudi, Dunquang-un Mo gou kü daki Yuvan ulus-un üy-e-yin uyiγurjin mongγol bičig-ün Töleg tegüs-ün bičigesü-yi ungsiγsan ni, ÖMNŠU 4, 1988, 81-89; S. Garudi, Decipherment of Mongolian Inscription on the Southern Wall in the Dunhuang Grotto No 61, DYa (= *Dunhuang Research*) 1, 1989 (хитад хэлээр)

422 Archeological Academy of Dunhuang, Research Institute and Mongol Character Department of Inner Mongolia Teacher's College, A Report of the Examination of the Uighur Form's Mongol Inscriptions in the Dunhuang Grottoes, DYa (=*Dun-huang Research*) 4, 1990, 1-19 + 30 Plates (хитад хэлээр); Dunhuang Academy, Northern Grottoes of Mogaoku, Dunhuang, Beijing, 2004, Vol. II. 376-386; Vol. II. 397-419 + Tables (хитад хэлээр)

423 F. W. Cleaves, The Sino-Mongolian Edict of 1453 in the Topkapi Sarayi Müzesi, HJAS 13, 1950, 431-446;

424 N. Poppe, Notes on the Monument in Honor of *Möngke Khan,* CAJ 6, 1961, 14-18; The *Twelve Deeds of Buddha*. A Mongolian Version of the *Lalitavistara*. Mongolian Text, Notes

§ 67. **Барын ном зохиолын дурсхалууд.** Эдүгээ судалгааны эргэлтэд орсон барын ном сударын 30 гаруй дурсхал байгаагийн олонхи нь цөөн тооны томоохон номын сангуудад хадгалагдаж хадгалагдаж байна. Тухайлвал, *'Бурхан багшийн арван хоёр зохионгуй үйлс'* хэмээх 65 тал бүхий барын ном Санкт-Петербургийн их сургуулийн номын санд, 1312 онд Бээжин хотын Цагаан суваргат их сүмд барласан *'Бодичария-аватарагийн тайлбар'* болон *'Махагалын магтаал', 'Хутагт сайн явдалын ерөөлийн хаан', 'Билигийн зүрхэн'* зэрэг 30 шахам дурсхал Берлин хотын номын санд, Күнзийн номлолын *'Тахимдуу ном'* хэмээх 38 тал бүхий барын сударын Бээжин хотын хааны ордоны номын санд тус тус хадгалагдаж байна.

Уйгуржин монгол бичигээр барласан ном сударыг эх бичиг судалалын арга зүйгээр судалсан бүтээлүүд XX зууны тавиад оны үеэс эхлэн гарчээ. Германы монголч эрдэмтэн E. Haenisch Берлин дэх Турфаны цуглуулгын тусхай хөмөрөгт хадгалагдаж буй *'Бодичария-аватарагийн тайлбар'*-ын 12 хуудас эхийн гэрэл зурагийг латин галиг, герман орчуулгын хамт нийтлүүлсэн[428] нь тухайн дурсхалын анхны судалгаа болсон төдийгүй, түүнийг цаашид нарийвчилан судалах эхлэлийг тавьсан байна. Мөн профессор F. W. Cleaves уул дурсхалын бүрэн эхийг эрдэм шинжилгээний галигаар буулгаж, дэлгэрэнгүй удирдхал, үгсийн хэлхээ, англи орчуулга, гэрэл зурагийн хуулбар, 350 гаруй тайлбарын хамт нийтлүүлсэн нь зөвхөн тухайн дурсхал төдийгүй, цаашид эртний бичигийн дурсхалуудыг эх бичиг судалалын үүднээс судалахад үлгэр загвар болохуйц нягт нимбай арга зүйтэй судалгаа болсон билээ. Мөн профессор E. Haenisch-ийн нийтлүүлсэн *'Турфаны цуглуулга дахь монгол дурсхалууд'*-ын хоёрдугаар дэвтэрт[429] *'Махагалын магтаал', 'Хутагт сайн явдалын ерөөлийн хаан', 'Билигийн зүрхэн'* зэрэг барын ном сударын

and English Translation {=AF 23}, Wiesbaden, 1967, 173 + 6; The Diamond Sutra. Three Mongolian Version of the *Vajracchedikā Prajñāpāramitā*, {=AF 35}, Wiesbaden, 1971, 230 pp.

425 G. Kara, L'inscription mongole d'Aruγ, prince de Yun-nan (1340), AOH 17, 1964, 145-173;

426 Igor de. Rachewiltz, Some Remarks on Töregene's Edict of 1240, PFEH 23, 1981, 38-63;

427 J. Nakamura, & T. Matsukawa, A Newly Discovered Inscription of Mongolian-Chinese Bilingual Edicts from *Shao-lin si* Temple, SIAL, VIII, 1993, 32-48; Matsukawa, Takashi, The Sino-Mongolian Inscription of 1348 from Qara-qorum, Society of Central Eurasian Studies, SIAL XII, 1997, pp. 83-98; *idem.* Three Newly Published Mongolian Edicts, *Research on Political and Economic Systems under Mongol Rule,* Osaka, 2002, 55-59 (япон хэлээр)

428 E. Haenish, Mongolica der Berliner Turfan Sammlung. I. Ein buddhistisches Druck-fragment vom Jahre 1312, ADAW Nr. 3, 1953, Berlin, 1954, 1-22 + 24

429 E. Haenish, Mongolica der Berliner Turfan Sammlung. II. Mongolische Texte der Berliner Turfan-Sammlung in Faksimile, ADAW Nr. 1, 1959, Berlin, 1959, S. 9-21, 24-26

гуч гаруй тасархай хуудас багтаж байгаа бөгөөд тэдгээрийн талаар H. Franke,[430] G. Kara,[431] Д. Цэрэнсодном[432] нарын үгүүлэлүүд нийтлэгджээ.

Академич Д. Цэрэнсодном, M. Taube нар[433] Турфаны цуглуулга дахь монгол дурсхалыг бүхэлд нь багтаасан томоохон бүтээлдээ *'Бодичария-аватарагийн тайлбар'* болон бусад барын номын бүх дурсхалыг латин галиг, герман орчуулга, үгсийн хэлхээ, тайлбарын хамт багтаасан нь монгол хэлний эртний бичигийн дурсхалуудын судалалд дорвитой хувь нэмэр болсон билээ.

Бээжингийн номын санд буй *'Тахилдуу ном'*-ын талаар W. Fuchs - A. Mostaert нар[434] анх түрүүн мэдээлсэн бөгөөд монголын эрдэмтэн Х. Лувсан-балдан түүний тухай анхны дэлгэрэнгүй судалгааг нийтлүүлжээ.[435] Түүний дараа I de. Rachewiltz уг дурсхалын талаар улам дэлгэрүүлэн судалсан[436] бол профессор F. W. Cleaves түүний бүлэг тус бүрээр илүү нарийвчилсан цуварал судалгаа нийтлүүлжээ.[437] Мөн

---

430 H. Franke, Mittelmongolische Kalendarfragmente aus Turfan, SBAW 2, München, 1964, 1-45; Ein Bruchstücke einer buddhistischen Schrift über die Sündenfolgen aus den mongolischen Turfan-Fragmenten, SSECA 1968, S. 37-44; Kleine Nachlese zu der mongolischen *Mahākālī-Hymne* aus Turfan, ZAS 15, 1981,11-26

431 G. Kara, Un fragment mongol de Tourfan, AOH 24, 1971, 165-171; Weitere mittelmongolische Brüchstücke aus der Berliner Turfansammlung, AoF 6, 1979, 181-203; Zu den mittelmongolischen Kalendarausdrücken aus der Berliner Turfansammlung, AoF vol. II, 1984, 347-352

432 Д. Цэрэнсодном, Турфаны цуглуулгын ТМ 38, МС5, 1966, 113-122; Турфаны цуглуулгын ТМ8, ТII, Т662, МС VI, 1967, 38-42; Турфаны цуглуулгын Т 11, D 159, МС VI, 1968, 127-135; Турфаны цуглуулгын 2-р дэвтэр дэх ТМ (5), Т 130, МС 7:3, 1969, 39-49; Памятники турфанской коллекции, *Альманах.* Библиофила. Книга Монголии, вып. 24, М., 1988, 253-259; Sur un texte mongol extrait du recueil de Turfan, EM 2, 1971, 1-31; Ein mongolisches Gedichtfragment über die *Prajñnāparamitā* aus der Berliner Turfan-Sammlung, AoF 8, 1981, S. 333-335

433 D. Cerensodnom, M. Taube, Die Mongolica der Berliner Turfansammlung {= *Berliner Turfantexte* XVI}, Berlin, 1993, 230 S. + Tafel I-LVII

434 W. Fuchs – A. Mostaert, Ein Ming-Druck einer chinesisch-mongolischen Ausgabe des *Hsiao-ching,Monumenta Serica* 4, 1939/1940, 325-329

435 Х. Лувсанбалдан, Ачлалт номын тухай, SM 3:12, 1961, I-IV + 149 + 38

436 I de. Rachewiltz, Igor de. The Preclassical Mongolian Version of the *Hsiao-ching*, ZAS 16, 1982, 7-109; More about the Preclassical Version of the *Hsiao-ching*, ZAS 19, 1986, 27-37

437 F. W. Cleaves, The First Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching,* AOH 36, 1982, 69-88; The Second Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching, 'Documenta Barborum'.* Festschrift für W.Heissig zum 70 Geburtstag, Wiesbaden, 1983, 272-281; The Eighteenth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching*, HJAS 45, 1985, 242-254; The Third Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching,* MS 14, 1991, 117-143; The Fourth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching,* MS 15, 1992, 137-150; The Fifth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching,* MS 16, 1993, 19-40; The Sixth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching,* MS 17 1994, 1-20; An Early Mongolian Version of the *Hsiao-ching,* (The Book of Filial Piety), Chapters 7, 8, and 9. Transcription, Translation, Commentary. Chapters 10 through 17, Transcription, Translation, The Mongolia Society. *Occasional Papers,* Bloomington, Indiana, No 23, 2001, 7-106; An Early Mongolian Version of the *Hsiao-ching*,

§ 67. **Барын ном зохиолын дурсхалууд**. Эдүгээ судалгааны эргэлтэд орсон барын ном сударын 30 гаруй дурсхал байгаагийн олонхи нь цөөн тооны томоохон номын сангуудад хадгалагдаж хадгалагдаж байна. Тухайлвал, *'Бурхан багшийн арван хоёр зохиогуй үйлс'* хэмээх 65 тал бүхий барын ном Санкт-Петербургийн их сургуулийн номын санд, 1312 онд Бээжин хотын Цагаан суваргат их сүмд барласан *'Бодичария-аватарагийн тайлбар'* болон *'Махагалын магтаал'*, *'Хутагт сайн явдалын ерөөлийн хаан'*, *'Билигийн зүрхэн'* зэрэг 30 шахам дурсхал Берлин хотын номын санд, Күнзийн номлолын *'Тахимдуу ном'* хэмээх 38 тал бүхий барын сударын Бээжин хотын хааны ордоны номын санд тус тус хадгалагдаж байна.

Уйгуржин монгол бичигээр барласан ном сударыг эх бичиг судалалын арга зүйгээр судалсан бүтээлүүд XX зууны тавиад оны үеэс эхлэн гарчээ. Германы монголч эрдэмтэн E. Haenisch Берлин дэх Турфаны цуглуулгын тусхай хөмөрөгт хадгалагдаж буй *'Бодичария-аватарагийн тайлбар'*-ын 12 хуудас эхийн гэрэл зурагийг латин галиг, герман орчуулгын хамт нийтлүүлсэн[428] нь тухайн дурсхалын анхны судалгаа болсон төдийгүй, түүнийг цаашид нарийвчилан судалах эхлэлийг тавьсан байна. Мөн профессор F. W. Cleaves уул дурсхалын бүрэн эхийг эрдэм шинжилгээний галигаар буулгаж, дэлгэрэнгүй удирдхал, үгсийн хэлхээ, англи орчуулга, гэрэл зурагийн хуулбар, 350 гаруй тайлбарын хамт нийтлүүлсэн нь зөвхөн тухайн дурсхал төдийгүй, цаашид эртний бичигийн дурсхалуудыг эх бичиг судалалын үүднээс судалахад үлгэр загвар болохуйц нягт нимбай арга зүйтэй судалгаа болсон билээ. Мөн профессор E. Haenisch-ийн нийтлүүлсэн *'Турфаны цуглуулга дахь монгол дурсхалууд'*-ын хоёрдугаар дэвтэрт[429] *'Махагалын магтаал'*, *'Хутагт сайн явдалын ерөөлийн хаан'*, *'Билигийн зүрхэн'* зэрэг барын ном сударын

and English Translation {=AF 23}, Wiesbaden, 1967, 173 + 6; The Diamond Sutra. Three Mongolian Version of the *Vajracchedikā Prajñāpāramitā*, {=AF 35}, Wiesbaden, 1971, 230 pp.

425 G. Kara, L'inscription mongole d'Aruγ, prince de Yun-nan (1340), AOH 17, 1964, 145-173;

426 Igor de. Rachewiltz, Some Remarks on Töregene's Edict of 1240, PFEH 23, 1981, 38-63;

427 J. Nakamura, & T. Matsukawa, A Newly Discovered Inscription of Mongolian-Chinese Bilingual Edicts from *Shao-lin si* Temple, SIAL, VIII, 1993, 32-48; Matsukawa, Takashi, The Sino-Mongolian Inscription of 1348 from Qara-qorum, Society of Central Eurasian Studies, SIAL XII, 1997, pp. 83-98; *idem.* Three Newly Published Mongolian Edicts, *Research on Political and Economic Systems under Mongol Rule,* Osaka, 2002, 55-59 (япон хэлээр)

428 E. Haenish, Mongolica der Berliner Turfan Sammlung. I. Ein buddhistisches Druck-fragment vom Jahre 1312, ADAW Nr. 3, 1953, Berlin, 1954, 1-22 + 24

429 E. Haenish, Mongolica der Berliner Turfan Sammlung. II. Mongolische Texte der Berliner Turfan-Sammlung in Faksimile, ADAW Nr. 1, 1959, Berlin, 1959, S. 9-21, 24-26

гуч гаруй тасархай хуудас багтаж байгаа бөгөөд тэдгээрийн талаар H. Franke,[430] G. Kara,[431] Д. Цэрэнсодном[432] нарын үгүүлэлүүд нийтлэгджээ.

Академич Д. Цэрэнсодном, M. Taube нар[433] Турфаны цуглуулга дахь монгол дурсхалыг бүхэлд нь багтаасан томоохон бүтээлдээ *'Бодичария-аватарагийн тайлбар'* болон бусад барын номын бүх дурсхалыг латин галиг, герман орчуулга, үгсийн хэлхээ, тайлбарын хамт багтаасан нь монгол хэлний эртний бичигийн дурсхалуудын судалалд дорвитой хувь нэмэр болсон билээ.

Бээжингийн номын санд буй *'Тахимдуу ном'*-ын талаар W. Fuchs - A. Mostaert нар[434] анх түрүүн мэдээлсэн бөгөөд монголын эрдэмтэн Х. Лувсан-балдан түүний тухай анхны дэлгэрэнгүй судалгааг нийтлүүлжээ.[435] Түүний дараа I de. Rachewiltz уг дурсхалын талаар улам дэлгэрүүлэн судалсан[436] бол профессор F. W. Cleaves түүний бүлэг тус бүрээр илүү нарийвчилсан цуварал судалгаа нийтлүүлжээ.[437] Мөн

---

430 H. Franke, Mittelmongolische Kalendarfragmente aus Turfan, SBAW 2, München, 1964, 1-45; Ein Bruchstücke einer buddhistischen Schrift über die Sündenfolgen aus den mongolischen Turfan-Fragmenten, SSECA 1968, S. 37-44; Kleine Nachlese zu der mongolischen *Mahākālī-Hymne* aus Turfan, ZAS 15, 1981,11-26

431 G. Kara, Un fragment mongol de Tourfan, AOH 24, 1971, 165-171; Weitere mittelmongolische Brüchstücke aus der Berliner Turfansammlung, AoF 6, 1979, 181-203; Zu den mittelmongolischen Kalendarausdrücken aus der Berliner Turfansammlung, AoF vol. II, 1984, 347-352

432 Д. Цэрэнсодном, Турфаны цуглуулгын TM 38, MC5, 1966, 113-122; Турфаны цуглуулгын TM8, TII, T662, MC VI, 1967, 38-42; Турфаны цуглуулгын T 11, D 159, MC VI, 1968, 127-135; Турфаны цуглуулгын 2-р дэвтэр дэх TM (5), T 130, MC 7:3, 1969, 39-49; Памятники турфанской коллекции, *Альманах.* Библиофила. Книга Монголии, вып. 24, M., 1988, 253-259; Sur un texte mongol extrait du recueil de Turfan, EM 2, 1971, 1-31; Ein mongolisches Gedichtfragment über die *Prajñnāparamitā* aus der Berliner Turfan-Sammlung, AoF 8, 1981, S. 333-335

433 D. Cerensodnom, M. Taube, Die Mongolica der Berliner Turfansammlung {= *Berliner Turfantexte* XVI}, Berlin, 1993, 230 S. + Tafel I-LVII

434 W. Fuchs – A. Mostaert, Ein Ming-Druck einer chinesisch-mongolischen Ausgabe des *Hsiao-ching,Monumenta Serica* 4, 1939/1940, 325-329

435 Х. Лувсанбалдан, Ачлалт номын тухай, SM 3:12, 1961, I-IV + 149 + 38

436 I de. Rachewiltz, Igor de. The Preclassical Mongolian Version of the *Hsiao-ching*, ZAS 16, 1982, 7-109; More about the Preclassical Version of the *Hsiao-ching*, ZAS 19, 1986, 27-37

437 F. W. Cleaves, The First Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching,* AOH 36, 1982, 69-88; The Second Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching, 'Documenta Barborum'.* Festschrift für W.Heissig zum 70 Geburtstag, Wiesbaden, 1983, 272-281; The Eighteenth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching*, HJAS 45, 1985, 242-254; The Third Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching,* MS 14, 1991, 117-143; The Fourth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching,* MS 15, 1992, 137-150; The Fifth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching,* MS 16, 1993, 19-40; The Sixth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching,* MS 17 1994, 1-20; An Early Mongolian Version of the *Hsiao-ching,* (The Book of Filial Piety), Chapters 7, 8, and 9. Transcription, Translation, Commentary. Chapters 10 through 17, Transcription, Translation, The Mongolia Society. *Occasional Papers,* Bloomington, Indiana, No 23, 2001, 7-106; An Early Mongolian Version of the *Hsiao-ching,*

академич L. Ligeti дээр дурдсан судалгаануудын дотороос Х. Лувсанбалдан, I de. Rachewiltz нарын судалгааг уг дурсхалын жинхэнэ эх болон хожим гарсан дөрвөн өөр очуулгуудтай харьцуулан үзсэн тусхай үгүүлэл нийтлүүлсэн бий.[438] Уйгуржин бичигийн өөр нэг томоохон дурсхал болох *'Бурхан багшийн арван хоёр зохионгуй үйлс'*-ийн тухай профессор N. Popppe анхны бие даасан тусхай бүтээлдээ уул зохиолын латин галиг, англи орчуулга, үгсийн тайлбар, гэрэл зурагийн эх зэрэгийг багтаажээ.[439] Мөн академич L. Ligeti тус дурсхалын талаар тусхай үгүүлэл нийтлүүлсэнээс гадна түүний бүрэн эхийн галигийг үгсийн хэлхээсийн хамт *'Monumenta Linguae Mongolicae Collecta'* цуваралын тусхай дэвтэр болгон хэвлүүлжээ.[440]

§ 68. **Гар бичмэл дурсхалууд**. Эдүгээ уйгуржин монголоор бичсэн 80 орчим гар бичмэл дурсхал бүрдхэгдэж судалагдсаны дотор *'Эрдэнийн сан Субашид', 'Сулхарнайн тууж',* ил-хаан Авага, Аргун, Хасан, Өлзийт, Абу Сайд нарын захидал, Алтан ордоны үйсэний бичиг, Олон сүмээс олдсон *'Бодичарияа-аватара'* зэрэг томоохон дурсхалууд бий. Тэдгээрийн олонхи нь Парис, Ватикан, Берлин, Будапешт, Москва, Санкт Петербург, Истанбулын номын сан, архивт хадгалагдаж байгаа билээ.

Монгол гар бичмэл дурсхалуудаас эрдэмтэдийн анхааралыг хамагийн анх татсан нь Перст сууж байсан монгол хаадаас францын ванд илгээсэн захидалууд юм. Ил хаан Аргун, Өлзийт нараас францын Гоо Филипп ванд илгээсэн хоёр захидал Парисын үндэстэний архивт хадгалагдаж байсаныг XIX зууны сүүлчээр R. Bonaparte *'XIII-XIV зууны үеийн монгол дурсхалууд'* хэмээх дурсхал бичигийн цомогтоо бүрэн эхээр нь оруулсан нь уул дурсхалыг цаашид нарийвчилан судалах аятай боломжийг олгожээ.[441] XX зууны эхээр оросын судалаач И. Клюкин ил-хаан Өлзийтийн захидалын тухай үгүүлэл[442] нийтлүүлсэн нь уул дурсхалын талаар гарсан анхны судалгаа юм. 1940-өөд оны сүүлчээр профессор E. Haenisch илхаан Аргун, Өлзийт нарын захидалыг галиглан буулгаж, герман хэлээр орчуулаад 60

Chapters 10 to 13, AOH 59, 2006, 395-405; An Early Mongolian Version of the *Hsiao-ching*, Chapters 14 to 17, AOH 60, 2007, 145-158

438 L. Ligeti, Propos de la traduction mongole préclassique du *Hiao-King,* AOH 38, 1984, 303-349

439 N. Poppe, The Twelve Deeds of Buddha. A Mongolian Version of the *Lalitavistara.* Mongolian Text, Notes and English Translation {= AF 23}, Wiesbaden, 1967, 173 + 65 Tables

440 L. Ligeti, A propos de la version des *Douzes Actes du Bouddha,* AOH 20,1967, 59-73; Les douze actes du Bouddha. *Arban qoyar ǰokiyangγui üiles* de *Chos-kyi od-zer, Traduction de Šes-rab sen-ge*{= MLMC V}, Budapest, 1974, 9-175;Les douze actes du Bouddha. *Arban qoyar ǰokiyangγui üiles* de *Chos-kyi 'od-zer traduction de Šes-rab sen-ge* {= IVLMMT V}, Budapest, 1974, 5-514

441 R. Bonaparte, Documents de l'époque mongole des XIIIe et XIVe siècles, Paris, 1895, Pl. XIV

442 И. А. Клюкин, Письмо Ульдзэйту илхана к Филиппу красивому, Эдуарду 1-му прочим крестоносцам, Труды Государственного Дальневосточного Университета, Серия 6, Владивосток, 1926, 40 s.

гаруй үг хэллэгийн тайлбарын хамт гаргасан нь ил-хаадын захидалуудыг багтаасан анхны томоохон судалгаа болжээ.[443] Мөн профессор Wl. Kotwicz ил-хаадын захидалын талаар танилцуулж, уламаар дээрхи хоёр захидалыг дахин уншиж судалаад, тэдгээрийн латин галиг, франц орчуулгыг ная гаруй үгийн тайлбарын хамт нийтлүүлжээ.[444] Ил-хаан Аргун, Өлзийт нарын захидалын талаархи хамагийн дэлгэрэнгүй судалгааг A. Mostaert, F. W. Cleaves нар[445] хийжээ.

Ил-хаан Авага, Аргун, Хасан нараас Ромын католик шашины тэргүүн хамба IV Николай, VIII Бонифаци нар болон католик шашины элчид шийдхэн олгосон бичиг зэрэг гурван дурсхал Ватиканы нууц архивт хадгалагдаж байсаныг A. Mostaert, F. W. Cleaves нар нарийвчилан судалаад томоохон үгүүлэл[446] хэвлүүлсэн нь тухайн дурсхалуудын хувид анхны судалгаа болсон байна. Перст сууж байсан монгол хаадын хамагийн сүүлчийн хаан Абу сайдын захидал Техераны музейд байгааг P. Pelliot[447] анх мэдээлж, хожим F. W. Cleaves[448] нарийвчилан судалсан байна. Мөн Абусайдын өөр нэгэн зарлиг Иранаас олдсоныг G. Herrmann, Doerfer нар судалжээ.[449]

Монгол гар бичмэл дурсхалын хамагийн томоохон нь *'Эрдэнийн сан Субашид'* юм. Академич L. Ligeti Субашидын төвд-монгол хадмал эхийг өнгөрсөн зууны хориод онд Өвөр Монголоос олоод 1948 онд гэрэл зурагийн эхийг хэвлэж,[450] хожим далаад оны эхээр түүний бүрэн эхийн галигийг үгсийн хэлхээсийн хамт нийтлүүлсэн[451] нь уул дурсхалын талаар гарсан хамагийн бүрэн судалгаа болсон байна.

---

443 E. Haenisch, Zu den Briefen der mongolischen Il-khane *Argun* und *Öljeitü* an den König Philipp den Schönen von Frankreich (1289 und 1305), Or. 2, 1949, 216-235

444 W. Kotwicz, Quelques mots encore sur les lettres des Il-khans de Perse retrouvées par Abel Rémusat, CO 10, 1936, 1-22 // RO 16, 1950, 405-427; En marge des lettres des Il-khans de Perse retrouvées par Abel-Rémusat, CO 4, 1933, 1-48 || RO 16, 1953, 369-404

445 A. Mostaert et F. W. Cleaves, Les Lettres de 1289 et 1305 des Ilkhan Aryun et Ölǰ eitü a Philippe le Bel {= *Scripta Mongolica. Monograph Series,* vol.1}, Harvard-Yenching Institute, Cambridge Mass.1962, VII + 104 + 12 Plates

446 A. Mostaert et F. W. Cleaves, Trois documents mongols des Archives secrètes vaticanes, HJAS 15, 1952, 419-506 + 8

447 P. Pelliot, Les documents mongols du Musée de Téhéran, Athar-é-Iran: *Annales du Service Archéologique de l'Iran* I, Paris, 1936, 37-44, Fig.29-31

448 F. W. Cleaves, The Mongolian Documents in the Musée de Téhéran, HJAS XVI, 1953, 1-107

449 G. Herrmann, Doerfer, Ein persisch-mongolischer Erlaß aus dem Jahr 725|1325, ZDMG 125:2, 1975, 341-346

450 L. Ligeti, Le *Subhāsitaratnanidhi* mongol, Un document du moyen mongol, Partie I^re^. Le manuscript tibéto-mongol en reproduction phototypique avec une introduction {= BOH VI}, Budapest, 1948,XIII + 124

451 L. Ligeti, Trésor des sentences. *Subhāsitaratnanidhi* de Sa-skya pandita. Traduction de Sonom gara, {= MLMC IV}, Budapest, 1973, 5-146; Trésor des sentences. *Subhāsita-ratnanidhi* de Sa-skya pandita. Traduction de Sonom gara {= IVLMMT IV}, Budapest, 1973, 5-339

Эртний гар бичмэл дурсхалуудын дотор Турфаны цуглуулга дахь Сулхар-найн тууж, Александр хааны магтаал зэрэг томоохон дурсхалаас гадна нэр нь тодорхойгүй гуч гаруй тасархай хэсэг[452] бий. Тэдгээрийн дурсхалуудын талаар N. Poppe,[453] J. Bosson,[454] H. Franke[455] нарын судалгааны бүтээлүүд гарчээ. Академич Д. Цэрэнсодном, M. Taube нар *'Турфаны цуглуулга дахь монгол дурсхалууд'* хэмээх бүтээлдээ тус хөмөрөгийн доторхи бүх гар бичмэл дурсхалуудыг галиглан буулгаж, герман орчуулга, үгсийн хэлхээ, хэл зүйн тайлбар, гэрэл зурагийн хамт оруулсан байна.[456]

Монгол гар бичмэл дурсхалуудын дотор *'Алтан ордоны үйсний бичиг'* хэмээн алдаршсан үйсэн дээрхи бичиг томоохон байр эзэлдэг. 1930 онд Сибирээс олдсон энэхүү дурсхалыг профессор Н. Поппе уншиж, судалсан[457] нь эдүгээ хүртэл тухайн дурсхалын гол судалгаа болсон хэвээрээ байна. Дээр дурдсан дурсхалуудаас гадна Олон сүмээс олдсон монгол гар бичмэл материалуудын талаар профессор Sh. Hattori,[458] W. Heissig[459] нар, Хархотоос олдсон G. Kara,[460] Умард Ираны Ардабил хотоос олдсон монгол гар бичмэл дурсхалын талаар G. Doerfer[461] нарын судалгааны бүтээл гарчээ.

---

452 E. Haenish, Mongolica der Berliner Turfan Sammlung. II. Mongolische Texte der Berliner Turfan-Sammlung in Faksimile, ADAW Nr. 1, 1959, Berlin, 1959, S. 29-48, 21, 24-26

453 N. Poppe, Eine mongolische Fassung der Alexandersage, ZDMG 107, 1957, 105-129; Ein mongolisches Gedicht aus den Turfan-Funden, CAJ 5, 1959, 257-294

454 J. E. Bosson, A Treasury of Aphoristic Jewels: The *Subhāsitaratnanidhi* of Sa-skya Pandita in Tibetan and Mongolian {= UAS 92}, Bloomington, Indiana, 1969, 398 pp.

455 H. Franke, Bruchstücke einer buddhistischen Schrift über Sündenfolgen aus den mongolischen Turfan-Fragmenten, SSRCA 1968, 42-43; Ein weiteres mongolisches Reisebegleitschreiben aus *Čaγatai,* ZAS 2,1968, 7-14; Ein mongolischer Freibrief aus dem Jahre 1369, UAJb 47, 1975, 64-71; Ein mongolisches Freibrief-Fragment aus dem Turfanfunden (TM 92), *Folia Rara* (Festschrift Wolfgang Voigt.), Wiesbaden, 1976 [VOHD (*Verzeichnis der orientalischen Handschriften in Deutschland*)], Supplementband 19, Wiesbaden, 1976, 29-33; Additional Remarks on the Mongolian Turfan Fragment TM 92, *Canada-Mongolia Review* 3, No 1, 1977, 3-39; H. Franke, A 14th Century Mongolian Letter Fragment, AM 11, 1965, 120-127; Zwei mongolische Textfragmente aus Zentral-asien, *Mongolian Studies,* ed. by L. Ligeti, Budapest, 1970, 137-145;

456 D.Cerensodnom, M. Taube, Die Mongolica der Berliner Turfansammlung {= *Berliner Turfantexte* XVI}, Berlin, 1993, 165-201

457 Н. Поппе, Золотоорынская рукопись на бересте, СВ 2, 1941, 81-134

458 Sh. Hattori, On the Mongolian Documents Excavated at Olon Süme, *Tōhō Gakuhō,* 11:2, 1940, 257-278

459 W. Heissig, On a Preclassical Mongolian Prayer from Olon süme, *'Studies in General and Oriental Linguistics'* Presented to *Shiro Hattori* on the Occasion of His Sixtieth Birthday, Tokyo, 1970, 230-234; Die mongolischen Handschriften-Reste aus *Olon Süme* Innere Mongolei (16.-17. Jahrhundert) [= AF 46], Wiesbaden, 1976, 634 S. (13-64, 251-263)

460 G. Kara, Mediaeval Mongolian Documents from Kharakhoto and Eastern Turkestan in St. Petersburg, *Manuscript Orientalia*, vol. 9, No 2, Moscow, 2003, 3-40

461 G. Doerfer, Mongolica aus Ardabīl, ZAS 9, 1975, 190-248; G. Herrmann, G. Doerfer, Ein persisch-mongolischer Erlaß des Ğalāyeriden Šeyh Oveys, CAJ 19, 1975, 55-84

Эдүгээ бидний үед уйгуржин монгол үсэгээр бичсэн 4 пайз (гэрэгэ) болон Их Монгол Улсын хааны тамганы бичиг уламжилан үлдсэн бөгөөд тэдгээрийн талаар А. М. Позднеев, Д. Банзаров, Н. Ц. Мункуев, P. Pelliot, F. W. Cleaves, I. de Rachewiltz нарын судалгааны бүтээлүүд гарчээ.[462]

Уйгуржин монгол бичигийн дурсхалын тусхайлсан судалгаанаас гадна олон ороны музей, номын сан, хувийн цуглуулгад хадгалагдаж байгаа дурсхалууд болон тэдгээрийн талаар гадаад, дотоодод гарсан эрдэм шинжилгээний ном бүтээлүүдийг бүрдхэн цуглуулж, эмхэдхэн гаргах нь эрдэмтэн судалаачидын үнэтэй чухал гарын авлага болдог байна. Энэ талаар гарсан анхны томоохон бүтээл нь 1974 онд академич L. Ligeti-ийн нийтлүүлсэн *'Сонгодог бичигийн өмнөх дурсхалууд'*[463] хэмээх бүтээл юм. Тус бүтээлд Монгол, Хитад, Түрэгстан, Иран, Алтан Ордоноос олдсон 70 орчим дурсхалыг багтаажээ. Хожим 2000 оны эхээр залуу эрдэмтэн Ё. Жанчив *'Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсхалууд'*[464] хэмээх эмхэдхэлдээ 46 зүйл, 210 дурсхалын нэрсийг судалгааны номзүйн хамт жагсааж, хөшөө чулууны бичээс, барын болон гар бичмэл ном бичиг, пайз тамга зэрэг 35 дурсхалын гэрэл зурагийг багтаасан нь уйгуржин монгол бичигийн дурсхалын судалалд үнэтэй хувь нэмэр болжээ. Мөн түүний дараа проф. Д. Төмөртогоо уйгуржин монгол бичигийн дурсхалуудын талаар гадаад дотоодын эрдэмтэдийн судалгааны бүтээлийг шүүрдэн цуглуулсан материал дээрээ тулгуурлан хөшөө чулууны бичээс, барын болон гар бичмэл ном судар, захидал бичиг, пайз тамга зэрэг 130 орчим дурсхалыг эрдэм шинжил-гээний галигаар бүрэн буулгаж, дурсхал тус бүрийн судалгааны тойм, үгсийн хэлхээс, тусхай нэрсийн болон хэлц үгсийн жагсаалт, судалгааны номзүй, нийт бичигийн дурсхалуудын гэрэл зурагийн хэсэгийг хавсаргасан эмхэдхэлийг нийтлүүлжээ.[465]

---

462 А. М. Позднеев, Лекции по истории монгольской литературы, СПб.,Том. II, 1897, 150-151; Д. Банзаров, Разъяснение одной монгольской надписи на серебряной дощечке, найденной в Екатеринославской губерни в имени барона А. фон-Штиглиц, *Собрание сочинений*, Москва, 1955, 125-139; N. Ts. Munkuyev, A New Mongolian Pai-tzu from Simferopol, AOH, 31, 1971, 185-215; P. Pelliot, Les Mongols et la Papauté, Revue de l'Orient Chrétien, III, 1922-23, 22-25; F. W. Cleaves, Le sceau du grand khan Güyüg, HJAS 15, 1952, 485-495; Igor de Rachewiltz, *Qan, qaγan* and the Seal of *Güyüg, Documenta Barbarorum.* Festschrift für W. Heissig zum 70 Geburtstag. {= *Veröffent-lichungen der Societas Uralo-Altaica* 18], 1983, 272-281

463 L. Ligeti, Monuments Préclassiques I. XIII^{e} et XIV^{e} siècles {= MLMC II}, Budapest, 1972, 5-294; Monuments Préclassiques I. XIII^{e} et XIV^{e} siècles {= IVLMMT I}, Budapest, 1970, 3-168; Monuments Préclassiques I. XIII^{e} et XIV^{e} siècles {= IVLMMT II}, Budapest, 1972, 7-382

464 Ё. Жанчив, Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсхалууд {= *Corpus Scriptorum* II} Уб., 2005, 5-240

465 Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI centuries) Introduction, Transcription and Bibliography, edited by D. Tumurtogoo with the Coolaboration of G. Cecegdari {= *Language and Linguistic Monograph Series* A-11}, Institute of Linguistics, Academia Sinica, 2006, XIX + 1-722

0.3.3.2.1 УЙГУРЖИН БИЧИГЭЭС САЛБАРЛАН ГАРСАН ҮСЭГ БИЧИГИЙН ДУРСХАЛУУД

§ 69. **Тод бичигийн дурсхалууд, тэдгээрийн судалгааны тойм**. Тод үсэгээр бичсэн олон тооны дурсхал уламжилан үлдсэн бөгөөд тэдгээр нь хугацааныхаа хувид XVII-XIX зууны үед хамаарч байна. Тод бичигийн дурсхалууд нь Монгол улсын үндэстэний номын сан, ШУА-ийн номын сан, ОХУ-ын Санкт Петер-бургийн их сургуулийн номын сан, Халимагийн архив, германы номын санд бас нилээд ном байгаа ажээ. Мөн БНХАУ-ын Шинжааны өөртөө засах оронд оршин суух өөлдүүдийн дунд олон үе уламжилан ирсэн тод үсэгийн ном сударууд олон байгаа бөгөөд тухай тодорхой мэдээлэл бий бөгөөд сүүлийн үед тэдгээрийг бүрдхэх, гэрэл зурагийн хуулбар авах ажилыг хийгдэж, уламаар тэдгээрийн гэрэл зурагийн эхийг хэвлэх ажил амжилттай эхэлж байна. Тухайлвал, Бээжингийн Төвийн үндэстэнүүдийн их сургуулийн багш Эрдэмт энэ ажилыг олон жил эрхэлэн хийж, барын болон гар бичмэл номын цэсийг гаргаж[466] эхний 9 боть номыг нийтэлж, судалгааны эргэлтэд оруулаад байна.

Тод бичигийн дурсхалуудын хэл нь дундад үеийн монгол хэлний сүүлч, орчин үеийн монгол хэлний эхэн үеийн онцлог шинжийг тусхасанаараа өвөрмөц шинжтэй учир эрдэмтэдийн анхааралыг ихээхэн татсаар иржээ.

Тод бичигийн ном зохиолуудыг танилцуулах ажил бүр XIX зууны үеэс эхэлсэн боловч тэдгээрийг бичигийн дурсхалынх нь хувид эх бичиг судалалын аргаар судалах ажил өнгөрсөн зууны жараад оноос эхэлжээ. Хамагийн анх акад. Б. Ринчен тод үсэгээр бичсэн ойрд Зая бандидагийн *'Сараны гэрэл', 'Гэсэр', 'Улгэрийн далай'*-н эхүүдийг нийтлүүлсэнээс[467] гадна анагаах ухааны нэгэн сонирхолтой сударын гэрэл зурагийн эхийг хэвлүүлсэн[468] нь тод бичигийн дурсхалуудын анхны судалгаа болсон байна. Мөн америкийн эрдэмтэн John R. Krueger тод үсэгээр бичсэн ном зохиол, сурвалж бичигүүдийг уншин судалахад ихээхэн анхаарч, хэд хэдэн сонирхолтой үгүүлэл[469] нийтлүүлсэнээс саяхан германы Моравын архивт хадгалагдаж байгаа 80 гаруй захидалыг уншиж судалаад латин галиг, англи орчуулгын хамт

---

466 Sinǰiyang-un Ili-yin qasaγ ündüsüten-ü öbertegen ǰasaqu Jeu-yin ögeled mongγolčud-un qadaγalaǰu bayiγ-a mongγol nom bičig-ün γarčiγ, 2009, 1-207

467 B. Rinchen, Rabjamba Caya bandida-yin tuγuǰi *Saran-u gerel* kemekü ene metü bolai, CSM 5:2, 1959, Version oirate des chansons de Guesser, CSM IX:1, 1960, 3-176; Oirat Version of Damamukonamasutra, CSM XVI:2, 1970, 120

468 B. Rinchen, Unknown Medical Tractate in Oirat Characters, CSM V:6, 7 (1968), 161, 256 pp.

469 John R. Krueger, Remarks on the Oirat Vajracchedika in Vienna, *Kalmyk-Oirat Symposium* {=*Kalmyk Monograph Series* 2}, Philadelphia, 1966, 223-227; The Arthasiddhi Avadāna -Tale in Oirat-Mongolian, *The Mongolia Society Bulletin* 6:1, 1967, 29-33; Three Oirat-Mongolian Diplomatic Documents of 1691, CAJ 12:4, 1969, 286-295; Oirat Literary Resources and Problems of Oirat Lexicology, Semi-Centennial Volume, Middle West Branch, American Oriental Society, Bloomington, 1969, 134-157; The Ch'ien-lung Inscriptions of 1755 and 1758 in Oirat-Mongolian, CAJ 16:1 1972, 59-69; New Materials on Oirat Law and History, Part I: The Jinǰ il Decrees, CAJ 16:3, 1972, 194-205; New Materials on Oirat Law and History, Part II: The Origin of the Torguts, CAJ 18:1, 1974, 30-42

нийтлүүсэн нь тод үсэгийн судалалд үнэтэй хувь нэмэр болсон байна[470]. Монголын эрдэмтэн Ж. Цолоо тод үсэгээр бичсэн *'Зая бандидагийн намтар'*-ыг 1967 онд нийтлүүлж,[471] хожим профессор G. Kara-гийн хамт *'Алтан эрих'* хэмээх түүхэн сурвалжийн бүрэн эхийг Будапешт хотноо хэвлүүлжээ.[472] Мөн эрдэмтэн Х. Лувсанбалдан олон жилийн турш тод үсэгийн ном зохиол цуглуулан бүрдхэж, хэд хэдэн сонирхолтой үгүүлэл[473] бичсэнээс гадна *'Тод үсгийн дурсгалууд'* гэдэг томоохон бүтээлдээ *'Эрдэнийн сан Субашид'*, *'Эрдэнийн сан Субашидын тайлбар'*, *'Bodhicariyavatara'*, *'Дөрвөн ойрдын түүх'*зэрэг хэд хэдэн томоохон зохиолуудын гэрэл зурагийн эхийг латин галигийн хамт нийтлүүлсэн[474] нь тод бичигийн дурсхалын судалалд үнэтэй хувь нэмэр болжээ. Сүүлийн жилүүдэд түүхч эрдэмтэн На. Сүхбаатарын идэвхи санаачилгаар буй болсон *Bibliotheca Oiratica* цуваралд ойрд бичиг соёлын түүхийн холбогдолтой нилээд олон бүтээл нийтлүүлсэний дотор тод үсэгээр тэмдэглэсэн хэд хэдэн түүхэн сурвалж бичигийг дэлгэрэнгүй удирдхал, эрдэм шинжилгээний галиг хийгээд үгсийн хэлхээсийн хамт багтаасан нь ойрдын хэл соёл, түүхийн судалалд үнэтэй чухал хувь нэмэр болж байна.[475] Дээр дурдсан бүтээлүүдээс гадна Н. П. Шастина, G. Kara, N. Poppe, A. B. Бадмаев нарын бичсэн үгүүлэлүүд[476] нийтлэгдсэн буй.

§ 70. **Вагиндрагийн үсэгийн дурсхал, тэдгээрийн судалгаа.**

XX зууны эхээр шинэ дутам зохиосон тус үсэгийг тэр үеийн Буриадын сэхээтэнүүд тодорхой хэмжээнд хэрэглэж байсанаас гадна 1905-1910 оны хооронд Петербург хотноо үсэгийн дүрэм, үлгэр домог, Бурхан багшийн намтар зэрэг нилээд хэдэн ном чулуун бараар хэвлэгдсэнээс эдүгээ 6 дурсхал уламжилан үлдсэн байна.

---

470 John R. Krueger, Service, Robert, G. Kalmyk Old-Script Documents of Isaak Jacob Schmidt 1800-1810; Todo biciq Texts, Transcription, Translation from the Moravian Archives at Herrnhut, Harrassowitz Verlag, Wiesbaden, 2002, 214 pp.

471 J. Coloo, Biography of Caya Pandita in Oirat Characters, CSM 5:2-3, 1967

472 G. Kara, J. Tsoloo, The History of a Jakhachin Buddhist Monstery Dharmabhadra's Golden Rosary, *Debter* {= *Materials for Central Asiatic and Altaic Studies* 12}, 1997, 169 pp.

473 Х. Лувсанбалдан, Тод үсгийн барын ном болон Зая бандидын орчуулгын тухай дахин мэдээлэх нь, ХЗ 7, 1970, 297-300; Даваач ноёны бичиг, ШУАМ 3, 1970, 94-96; Х. Лувсанбалдан, А. В. Бадмаев, Калмыцкое ксилографическое издание сутры *Алтан гэрэл,'320 лет старо-калмыцкой письменности'*, 1970; Kh. Luvsanbaldan, *Subhasita-ratnanidhi* Oïrate du Zaya Pandita, AOH 26, 1972, 195-225

474 Х. Лувсанбалдан, Тод үсгийн дурсгалууд, Уб., 1976, 3-433

475 На. Сүхбаатар, Монголын түүхийн тод бичгийн сурвалжууд {= *Bibliotheca Oiratica* I}, 2006, 212 тал. Дөрвөн Ойрадын түүх оршив {=*Bibliotheca Oiratica* II}, 2006, 165 тал. Дармаабадраа, Шашны алтан нарны гэрлийн илч тогтоон өгүүлсэн өлзий цагаан бадам номлол бүтээл өргөн дэлгэр сүмийн эх туурвил Алтан эрих хэмээх оршив {= *Bibliotheca Oiratica* VIII}, 2008, 6-306

476 Н. П. Шастина, Письма Лувсан-тайджи в Москву, Из истории русско-монгольских отношений в XVII в, *'Филология и история монгольских народов'*, М., 1959, 275-289; G. Kara, Le colophon de *Altan gerel* oïrat, AOH 10:3, 1960, 255-261; N. Poppe, An Oyrat *Vajracchedika* Fragment from Turfan, CAJ 7:3, 1962, 170-178; А. В. Бадмаев, Историко-литературные памятники старо-калмыцкой письменности, *'320 лет старо-калмыцкой письменности'*, 1970

Вагиндрагийн үсэгээр тэмдэглэсэн ном бичигийн зүйл харьцангуй цөөн үлдсэн бөгөөд тэдгээрийн талаар мэдээлсэн зүйл ч бас цөөвтөр бий. Тухайлвал проф. Ц. Шагдарсүрэн *'Монголчуудын үсэг бичигийн товчоон'* хэмээх томоохон бүтээлдээ Вагиндрагийн үсэгээр бичсэн *'Буриад шинэ үсэгт тааруулсан зүрхэн тольт', 'Буриад хөөр'* гэсэн номын зарим хуудасын гэрэл зурагийг хавсар-гажээ.[477] Түүний дараа залуу эрдэмтэн Ё. Жанчив XX зууны эхээр Петербург хотноо хэвлэгдсэн *'Шинэ, хуучин үсэгүүдийн ялгал тэргүүтэнийг бичсэн дэвтэр', 'Буриад хөөр', 'Ухаан сургаж, сэдхэл сайжируулах үлгэрнүүд оршив', 'Бурхан багшийн гэгээний хураангуй намтар болон Буянт хан хөвгүүний намтар оршивой', 'Буриад шинэ үсэгт тааруулсан зүрхэн толт'* зэрэг 6 дурсхалыг латин галиг, кирил үсэгийн хөрвүүлэг болон гэрэл зурагийн хамт нийтлүүлсэн нь Вагиндра үсэгийн дурсхалын талаар гарсан хамагийн өргөн хүрээтэй томоохон судалгаа болж чадсан байна.[478] Өвөр Монголын эрдэмтэн Соёлмаа Вагидрагийн үсэг, тэдгээрийн дурсхалын талаар нилээд олон жил дагнан судалаад, саяхан *'Вагиндра үсэгийн сурвалж бичигийн судалал'*[479] гэсэн томоохон бүтээлийг нийтлүүлсэн байна. Тус бүтээлд Вагиндра үсэгийг зохиох болсон нөхцөл шалтгаан, үсэг тус бүрийн бичлэг хийгээд төвд, манж, монгол үсэгтэй харьцуулсан хүснэгт зэрэгийг багтаажээ. Мөн энд Вагиндра үсэг болон түүний дурсхалуудын талаар гарсан судалгааны талаар тодорхой дурдаж, холбогдох номзүйг хавсаргасанаас гадна эдүгээ хүртэл уламжилан үлдсэн Вагиндра үсэгийн арав гаруй дурсхалынгэрэл зурагийн эх, эрдэм шинжилгээний галиг, үгсийн хэлхээс, монгол бичигин хөрвүүлэг, үгсийн тайлбарын хамт оруулсан нь өмнөх судалгаануудын дотороос хамагийн өргөн хүрээтэй эх бичиг судалалын иж бүрэн судалгаа болж чадсан байна.

0.3.3.3 ДӨРВӨЛЖИН ҮСЭГИЙН ДУРСХАЛУУД

§ 71. **Дөрвөлжин үсэгийн дурсхалууд, тэдгээрийн судалгаа.** Эдүгээ бидний үед уламжилан үлдсэн дөрвөлжин бичигийн дурсхалууд нь XIII-XIV зууны үед бүтээгдсэн учир тэдгээр нь хэлний хөгжилийн үе шатны хувид *дундад үеийн монгол хэл*-ийг, бичигийн хэлний үечилэлийн хувид *сонгодог бичигийн өмнөх монгол бичигийн хэл*-ийг тус тус тусхасан байна.

Монгол судалалын хүрээнд мэдэгдэж, судалгааны эргэлтэд орсон дөрвөлжин бичигийн нийт дурсхалууд нь ная орчим байгаа бөгөөд тэдгээрийн дотор хөшөө чулууны бичээс 20 орчим, барын болон гар бичмэл ном бичиг 30 гаруй, пайз, тамганы бичиг болон бусад жижиг дурсхал 20 гаруй байна. Сэдэвийн талаас авч үзвэл, дөрвөлжин бичигийн дурсхалуудын тал хувь нь Юань гүрэний хаадын зарлиг байгаа бөгөөд тэдгээрийн ихэнхи нь хөшөө чулуун дээр сийлж үйлдсэн, мөн нилээд нь сайн чанарын цаасан дээр гараар нимбайлан бичиж, тамга дарж,

---

[477] Ц. Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, 178-180

[478] Ё. Жанчив, Вагиндра үсгийн дурсгалууд {= *Corpus Scriptorum* VIII}, Уб., 2010, 134 + I-LII

[479] Соёлмаа Шүрхүү. Vagindr-a üsüg-ün surbalǰi bičig-ün sudulul {= *Mongγol surbalǰi bičig-ün čiγulγan*: Kele bičig}, ÖMSKKQ, 2017, 1-12 + 1-8 + 1-70 + 1-9 + 1-776

баталгаажуулсан байна. Хөшөө чулууны бичээсээс бусад дурсхалуудын ихэнхи нь цаасан дээр, мөн алт, мөнгө, хүрэл, төмөр, мод, шаазан, ваар, торгон дээр бичсэн дурсхалууд бий.

Монгол дөрвөлжин бичигийн дурсхалын олонхи нь БНХАУ-ын музей, номын сангуудад байгаагаа гадна зарим нь ОХУ, Герман, Түрк, Япон, Монгол зэрэг улсад хадгалагдаж байна.

Дөрвөлжин бичигийн монгол дурсхалуудын тухай судалгаа нь XIX зууны сүүлчээс эхэлжээ. Тухайлвал, J. Schmidt,[480] В. Григорьев,[481] П. Р. Савельев,[482] M. G. Pauthier,[483] A. Wylie,[484] А. Бобровников,[485] А. М. Позднеев,[486] Ed. Chavannes[487] нарын судалгааны бүтээлүүд гарсан байна. XX зууны дунд үеэс M. Lewicki,[488] E. Haenisch,[489] Н. Поппе,[490] Б. Ринчен[491] нарын зэрэг эрдэмтэд тухайн үедээ мэдэгдэж байсан дөрвөлжин үсэгийн дурсхалуудыг эмхэдхэн гаргасан нь сургалт, судалгааны түвшинд өргөн хэрэглэгдсээр иржээ. Хожим Турфаны цуглуулгад хадгалагдаж

---

480 И. Я. Шмидт, Монгольская квадратная надпись из времен монгольского влады-чества, Санкт-Петербургския Ведомости, 249, 1846; // Über eine mongolische Quadratschrift aus der Regierungszeit der mongolischen Dynastie Jüan in China, *Bulletin* 4:9, 1848, 129-141

481 В. Григорьев, Монгольская надпись времен Мöнгкэ-хана, найденная в Восточной Сибири, Чтение и перевод архимандрита Аввакума, издана с присовокуплением исследования о письменнах у монголов, СПб, 1846, 26 стр.; Объяснение древней монгольской надписи, найденной в Сибири, ЗМВД 16, 1846, 126-149

482 П. Р. Савельев, В. Григорьев, Монгольская надпись времен Мöнгкэ-хана, Протоколы 9-го заседания Археол. Нумизм. Общ. от 17 апреля 1847, ЗСПАНО, СПб., 1849, 112-113; Монгольское пайзе найденной в Забайкальской области, ТВОИРАО 2, 1856, 161-165

483 G. Pauthier, De l'alphabet de Pa'-sse-pa, et de la tentative faite par Khoubilai-Khan, au XIIIe siècle de notre ére, pour transcrire la langue figurative des chinois au moyen d'une écriture alphabétique, JA 5:19, 1862, 8-14, 24-25, 34

484 A. Wylie, Sur une inscription mongole en characteres p'a-sse-pa, JA XIX:4, 1862, 461-471; On an Ancient Buddhist Inscription at Keu-yung-kwan in North Cjina, JRAS V:1, 1870, 14-44

485 А. А. Бобровников, Памятники монгольского квадратного письма с дополнениями В. В. Григорьева, ТВОИРАО, СПб., 1870, 1-90

486 А. М. Позднеев, Объяснение древней монгольской надписи на чугунной дощечке доставленной в Императорскую Академию Наук г. Винокуровым, ЗИАН 39:2, 1881, 31-43; Лекции по истории монгольской литературы, том II, IX+221

487 Ed. Chavannes, Note préliminaire sur l'inscription de Kiu-yong Koan, I[e] partie. Les inscriptions chinoise et mongoles, JA sér. 9, 1894, 354-373; Le Sūtra de la paroi occidentale de l'inscription de Kiu-yong Koan, Mélanges Charles de Harlez., Leyde 1896, 60-81

488 M. Lewicki, Les inscriptions mongoles indites en écriture carrée, CO 12, 1937, 1-72

489 E. Haenisch, Steuergerechtsame der chinesischen Klöster unter der Mongolen-herrschaft. Eine kulturgeschichtliche Untersuchung mit Beigabe dreier noch unveröffentlichter Phagspa-Inschriften, *'Berichte über die Verhandlungen der Sächsischen Akademie der Wissenschaften'*. Phil.-hist. Klasse, Bd. 92:2, 1940, 1-74 + 4 tables

490 Н. Поппе, Квадратная письменность, 167 pp. // The Mongolian Monuments in hP'ags-pa Script {= GAF 8I}, 2nd Edition translated and edited by John R. Krueger, 1957, Otto Harrassowitz, 147 pp.

491 Б. Ринчен, Монгол хэлний зүйн бичиг (1956) Уб., 2015, 49-72

байгаа дөрвөлжин үсэгийн ном бичигийн тасар-хайнуудын талаар G. J. Ramstedt, P. Aalto, T. F. Carter, J. E. Bosson, L. Ligeti нарын үгүүлэлүүд гарчээ.[492] Мөн далаад оны эхээр академич L. Ligeti дөрвөлжин үсэгээр бичсэн хөшөө чулууны бичээс, ном бичигийн дурсхал, пайзны бичээс зэрэг хорь орчим дурсхалыг багтаасан тусхай эмхэдхэлийг үгсийн хэлхээсийн хамт гаргасан[493] нь урид өмнө гарсан бүтээлүүдээс илүү олон дурсхалыг багтаажээ.

Сүүлийн хагас зуун жилийн хугацаанд дөрвөлжин үсэгийн олон шинэ дурсхалууд олдож, тэдгээрийг уншиж судалах ажил ч эрчимжсэн байна. Үүнтэй холбогдуулан Юань гүрэний их хаадын зарлигуудын талаар профессор Зууннастын цуварал үгүүлэлүүдийг юуны өмнө дурдвал зохино.[494] Дээрхээс гадна Өвөр Монголоос олдсон алтан пайзын талаар профессор Боушияан,[495] Чавчаал боомтын хаалган дээрхи дөрвөлжин үсэгийн бичээсийн талаар түүхч эрдэмтэн Шонхор,[496] Хайсанхөлөг хааны зарлигийн талаар профессор Хасбагана[497] нарын судалгааны үгүүлэл гарчээ. Мөн Буянт хаан (1314), Тогоонтөмөр (1335) хааны зарлигийн

---

492 G. J. Ramstedt, Ein Fragment mongolischer Quadratschrift, JSFOu 27:3, 1911-12, 1-4; A Fragment of Mongolian Quadratic Script, C. G. E. Mannerheim, Across Asia from West to East in 1906-1908, 1940, 1-5; P. Aalto, Fragmente des mongolischen *Subhāsitaratnanidhi* in Quadratschrift, MIO Bd. III, 1955, 279-290; A Second Fragment of the *Subhāsita-ratnanidhi* in Mongolian Quadratic Script, JSFOu LVII, 1953/1954, 1-5; Zu den Berliner Turfan-Fragmenten T III D 322, JSFOu LXI:6, 1959, 1-21; T. F. Carter, Fragmente des mongolischen *Subhāsitaratnanidhi* in Quadratschrift, MIO, 3:2, 1955, 379-390; J. E. Bosson, A Rediscovered Xylograph Fragment from the Mongolian 'Phagspa Version of the *Subhāsitaratnanidhi*, CAJ 6, 1961, 85-102; L. Ligeti, Les fragments du *Subhāsita-ratnanidhi* mongol en écriture 'phagspa. Mongol Préclassique et moyen mongol, AOH XVII, 1964, 239-29; Le Po kia sing en écriture 'Phags-pa, AOH 6, 1956, 1-52

493 L. Ligeti, Monuments en écriture 'Phags-pa {= MLMC II}, Budapest, 1972, 9-127; Monuments en écriture 'Phags-pa {= IVLMMT III}, Budapest,1973, 9-112

494 Зууннаст, Yisüntemür qaγan-u quluγan-a ǰ il-ün γurbaduγar sar-a-yin ǰ arliγ, ÖMNŠU 4, 1993, 94-102; Yisüntemür qaγan-u quluγan-a ǰ il-ün arbaduγar sar-a-yin ǰ arliγ, MKUJ No 1, 1994, 4-10; Mongγol dörbelǰin üsüg-ün luu ǰil-ün ǰarliγ, *Mongolica,* 6, 1995, 118-125; Sin-e-ber oldaγsan Toγuγantemür qaγan-u qonin ǰil-ün ǰarliγ-un tuqai, ÖMYS 2, 2004, 22-27; Textual Research and Explanation of an Inscription of Imperial Edict both in Uighur Mongolian and 'Phags-pa Script unearthed at Shaolin Temple of Deng-fang County, Henan Province, MYu 5, 1993, 1-3; 6, 1993, 59-71; 1, 1994, 32-40; A New Textual Research of Emperor Ölǰeitü of the Year of Horse, MYu 3, 1995, 49-50; Two Mongolian Imperial Edicts in 'Phags-pa Script Discovered from Bao Yansi Temple of Lin County, MYu 3, 1996, 48-55; A Dragon Year's Imperial Edict in 'Phags-pa Script, MYu 4, 1996, 45-49; The Imperial Edict of the Year of Dragon in 'Phags-pa, MYu 4, 1996, 45-49; The Edict of Togontemür of the Year of Tiger, *'A Collection of Papers and Commemorative Essays',* 1997, 228-241 (хитад хэлээр)

495 Bousiyang, Künming deki 1340 on-u mongγol kösiyen-ü bičig-i dakin ungsiγsan ni, MKUJ, 1, 1980, 38-50 // *Erdem-ün qaryui, elbeg bütügel*, ÖMYS, 2002, 280-289; The Golden Pai-tzu in 'Phags-pa script Recently Discovered from Inner Mongolia, JIMU 4, 2000 // {= MSBC I} *Mongγol kele*, ÖMYS, 2006, 191-194 (хитад хэлээр)

496 Hasbagana, Ölǰei, Textual Interpretation of the Imperial Edict from the Qingxu Temple in Ping-yao County, JIMNU vol. 29, No. 6, 2000, 47-50 (хитад хэлээр)

497 Šongqur, Čabčiyal boγumtu-yin tarni-yin bičig-ün tuqai sudulul, MKUJ 4, 1984, 7-31

талаар, японы эрдэмтэн M. Sugiyama,[498] 1312 оны Буянт хааны зарлигийн талаар J. Nakamura, T. Matsukawa нар[499] шинэ дутам олдсон Ананд, Хайсанхолөг хаадын зарлигийн талаар T. Matsukawa[500] тус тус судалсан байна. Залуу эрдэмтэн Ё. Жанчив Юань улсын сүүлчийн хаан Тогоонтөмөрийн хоний жилийн зарлигийг анхлан уншиж нийтлүүлсэнээс[501] гадна Монгол улсын нутагаас шинэ дутам олдсон дөрвөлжин үсэгийн дурсхалуудын тухай томоохон үгүүлэл[502] бичсэн нь дөрвөлжин үсэгийн судалалд шинэ зүйл болсон билээ. Сүүлийн жилүүдэд Хүйтэн голын бичээс, Рашаан хадны бичээс, Чавчаалын адагийн бичээс зэрэгийг манай залуу эрдэмтэд уншиж судалсан байна.[503] Мөн дээр дурдсан Рашаан хадны бичээсийн талаар японы эрдэмтэдийн хамтаран судалсан бүтээл ч бас гарчээ.[504] Саяхан японы Васеда их сургуулийн профессор J. Yoshida, Өвөр Монголын их сургуулийн профессор Ж. Чимиддорж нар *'Хархотоос олдсон монгол дурсхалын судалгаа'*[505] гэсэн томоохон бүтээлдээ наяад оны эхээр Хархотын тууринаас олдсон дөрвөлжин үсэгийн дурсхалуудын гэрэл зурагийн эхийг латин галигийн хамт оруулсан нь монгол дөрвөлжин үсэгийн дурсхалын сан хөмөрөгийг ихээхэн баяжуулсаныг онцлон тэмдэглэмээр байна.

Эдүгээ судалгааны эргэлтэд орсон монгол дөрвөлжин үсэгийн дурсхалуудыг нэгэн дор нэгдхэн гаргах нь дөрвөлжин бичигийн дурсхалын судалгаа төдийгүй, дундад үеийн монгол хэлний судалал, түүхэн хэл зүйн судалалд нэн чухал шаардлагатай. Тийм ч учираас үе үеийн эрдэмтэд тухай үедээ мэдэгдэж байсан бичигийн дурсхалуудыг эмхэдхэн гаргасаар ирсэн сайхан уламжилалтай. Тухайлвал, анх гучаад оны сүүлч, дөчөөд оны эхээр M. Lewicki, E. Haenisch нар монгол дөрвөлжин бичигийн 4-6 дурсхалыг багтаасан эмхэдхэл[506] гаргасан бол

---

498 M. Sugiyama, The 'Phags-pa Mongolian Inscription of the *Buyantu-qayan's* Edict in Yuan-shixian, belonging to *Čaqa'an-balaqasun*, MRIHS No 22, 1987, 17-24; The 'Phags-pa Mongolian Inscription of *Toγontemür qayan's* Edict, MRDTB, No 46, 1988, 1-6+1 plate

499 J. Nakamura, T. Matsukawa, A Newly Discovered Inscription of Mongolian-Chinese Bilingual edicts from Shaolin si Temple, SIAL VIII, 1993, 1-93 (япон хэлээр)

500 T. Matsukawa, The Sino-Mongolian Inscription of 1348 from *Qara-qorum,* SIAL XII, 1997, 83-97; Three Newly Published Mongolian Edicts, *Research on Political and Economic Systems under Mongol Rule*,Osaka, 2002, 55-67

501 Ё. Жанчив, Монгол дөрвөлжин үсгээр бүхий Тогоонтөмөр хааны хонин жилийн зарлиг, Mon.S 15(153), 2000, 77-86

502 Ё. Жанчив, Монгол улсын нутаг дахь дөрвөлжин үсгийн дурсгалууд, AMon, 8, 2008, 209-240

503 А. Очир, Хүйтэн голын монгол ба дөрвөлжин бичгийн дурсгалын тухай, *Mongolica* 11, 2001, 93-97; Л. Галсанцэрэн, Хүйтэн голын хадны бичээс, МХШ V(XXVII), 1999, 216-221; Л. Батбилиг, Рашаан хадны дөрвөлжин бичээс, АН VII, 2006, 16-19;

504 K. Matsuda, H. Muraoka, T. Matsukawa, Rock Writings of Arshan-Qada in Kentii Province, *Bulletin of Japan Association for Mongol Studies,* No 36, 2006, 77-82 (япон хэлээр)

505 Yoshida, J. Chimeddorji, J. Study on the Mongolian Documents found at Qara-qota, Tokyo, 2008, 410 (япон хэлээр)

506 M. Lewicki, Les inscriptions mongoles indites en écriture carrée, CO 12, 1937, 1-72; E. Haenisch, Steuergerechtsame der chinesischen Klöster unter der Mongolenherrschaft. Eine kulturgeschichtliche Untersuchung mit Beigabe dreier noch unveröffentlichter Phagspa-

профессор Н. Поппе 13 дурсхалыг судалгааны хамт нийтлүүлсэн билээ.[507] Түүнээс гучаад жилийн дараа академич L. Ligeti дөрвөлжин үсэгийн 22 дурсхалыг багтаасан эмхэдхэл[508] гаргасан бол 90-ээд оны эхээр профессор Зууннаст *'Монгол дөрвөлжин үсэгийн дурсхалууд'* гэсэн томоохон эмхэдхэлдээ[509] нийт 40 дурсхалыг багтаажээ.

2000 оны эхээр Д. Төмөртогоо *'Монгол дөрвөлжин үсэгийн дурсхалын судалгаа'*[510] номдоо 57 дурсхалыг латин галиг, үгсийн хэлхээс, номзүй, гэрэл зурагийн хамт нийтлүүлсэн бол Ё. Жанчив *'Дөрвөлжин үсгийн монгол дурсгал'*[511] гэсэн бүтээлдээ дөрвөлжин үсэгийн 60 дурсхалыг үсэгийн галиг, кирил үсэгийн хөрвүүлэг, үгсийн хэлхээс, номзүйн хамт гаргажээ. Дээрхи хоёр бүтээл гарсаны дараахан Өвөр Монголын их сургуулийн профессор Ү. Хөгжилтү *'Монгол дөрвөлжин үсэгийн дурсхалын эмхэдхэл'*[512] хэмээх томоохон бүтээлдээ 58 дурсхалыг дөрвөлжин үсэгийн бичлэг, латин галиг, монгол бичигийн хөрвүүлэг, дурсхал бүрийн товч танилцуулга, тов тодорхой гэрэл зурагийн хамт багтаасан нь дөрвөлжин бичигийн судалгааг улам цааш өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлсэн байна. Мөн түүний дараахан Д. Төмөртогоо *'Mongolian Monuments in Phags-pa Script'* гэсэн бүтээлдээ одоогоор мэдэгдээд байгаа 70 дурсхалыг багтаасан нь одоогоор хамагийн олон дурсхалыг хамарсан эмхэдхэл болсон юм.[513] Уул бүтээлд хөшөө чулууны бичээс, барын болон гар бичмэл, пайз тамаганы бичиг бүрийг үсэгийн болон дуудлагын галигаар буулгаж, дурсхал тус бүрийн судалгааны номзүйг дагалдуулсанаас гадна хэл зүйн толь, оноосон нэрсийн жагсаалт, нийт үгсийн англи орчуулга, дэлгэрэнгүй номзүй, гэрэл зурагийн эх зэрэгийг хавсаргажээ. Зохиогч 2015 онд нийтлүүлсэн *'Хубилай хааны зарлигууд'* гэдэг номдоо их хааны долоон зарлигийг латин галиг, кирил үсэгийн хөрвүүлэг, судалгааны ном зүй, удирдхалын хамт нийтлүүсэн бий.[514]

Inschriften, Berichte über die Verhandlungen der Sächsischen Akademie der Wissenschaften. Phil.-hist. Klasse, Bd. 92:2, 1940, 1-74 + 4 tables

507 N. Poppe, The Mongolin Monuments in hP'gags-pa Script {= GAS 8}, Second Edition. Translated and edited by John R. Krueger, Otto Harrassowitz, Wiesbaden, 1957, XII + 1-142

508 L. Ligeti, Monuments en écriture 'Phags-pa {= MLMC II}, 1972, 9-127

509 Junast, Basibazi ho Meng-ku yü wen-hsien /The Mongolian Monuments in 'Phags-pa Script/ II. {= *Collection of Monuments*}, Institute for the Study of Languages & Cultures of Asia & Africa, Tokyo University of Foreign Studies, Tokyo, 1991, 228 pp. (хитад хэлээр)

510 Д. Төмөртогоо, Монгол дөрвөлжин үсэгийн дурсхалын судалгаа {= *Monuments in Mongolian Language,* IAMS II} 2002, IV + 1-182

511 Ё. Жанчив, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал {= *Monumenta Mongolica* III}, 2002, 195 pp.

512 Hugǰiltu & Sarula, A Collection of 'Phags-pa Monuments in Mongolian, Inner Mongolia People's Publishing House, 2004, 537 pp. (хитад хэлээр)

513 D. Tumurtogoo, Mongolian Monuments in Phags-pa Script. Introduction, Texts, Transcription and Bibliography With the collaboration of G. Cecegdari {= *Language and Linguistics Monographs Series* 2}, Academia Sinica, Institute of Linguistics, Taipei, Taiwan, 2010, 226 + Plates

514 Д. Төмөртогоо, Хубилай хааны зарлигууд, Уб., 2015, 3-92

0.3.3.4 ХИТАД ҮСЭГЭЭР ТЭМДЭГЛЭСЭН МОНГОЛ ХЭЛНИЙ ДУРСХАЛУУД

§ 72. **Хитад үсэгийн дурсхалууд, тэдгээрийн судалгаа**. Дундад үеийн монгол хэлний онцлогийг тусхасан дурсхалуудын нэг нь хитад үсэгээр тэмдэглэсэн дурсхалууд юм. Хитад үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсхалуудын хамагийн том нь Мин улсын эхэн үед ханз үсэгээр буулгасан *'Монголын нууц товчоо'* (МНТ) юм. Эдүгээ бидний үед Цянь Да-шин, Гү Гуан-чи, Йэ Дэ-хуй нарын хуулан буулгасан гурван өөр хувилбар уламжилан үлдсэн бөгөөд дээрхээс гадна тодорхой судалагдаагүй бусад зарим хувилбарууд байгаа тухай мэдээ бий. Бээжин хот дахь оросын загалмайтаны шашины төлөөлөгч Архимандрит Палладий (Петр Иванович Кафаров)/1817-1878/ XIX зууны сүүлчээр 15 бүлэг бүхий *'Монголын нууц товчоо'*-ны нэгэн эхийг олж, түүнийг орос хэлээр орчуулж, 1866 онд нийтлүүлсэн[515] нь уул зохиолыг өрнөдөд танилцуулсан хамагийн анхны бүтээл болжээ. П. И. Кафаровын олсон уул эхийг нэрт монголч эрдэмтэн А. М. Позднеев орос үсэгээр галиглан буулгаад орос орчуулга дагалдуулж, 1897 онд хэвлүүлжээ.[516] Бүр хожим 1960-аад оны эхээр уул номын бүрэн эхийн гэрэл зурагийг Б. И. Панкратов нийтлүүлсэн билээ.[517] МНТ бол хүүрнэл, үгүүлэмж, харилцан яриа, яруу хэллэгээр баялаг учир үтийн сан нь ч баялаг, хэл зүйн хэлбэр нь ч баялаг. МНТ-оос өөр нэг томоохон дурсхалгэвэл 1389 онд зохиосон *'Hua-i ih-yü'* гэдэг хитад-монгол толь бичиг болон түүний дагалдуулал болох *'Хитад-Монголын харилцааны бичиг'* хэмээх 12 захидал юм. Мөн хожим зохиосон *'T'a-tan-kuan-i-yü', 'Zhi-yuan yi-yu', 'Denthan Bijiu', 'Bei-lu yi-yu'* гэх зэрэг хитад-монгол толь бичигүүд багтана.

Хитад ханз үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсхалуудын дотороос хамагийн их судалагдсан нь *'Монголын нууц товчоо'* юм. Бид энд МНТ-ны олон талт судалгааны дотороос зөвхөн эх бичиг, хэл шинжилэлийн томоохон судалгааны талаар тоймлон дурдах болно. МНТ-ны эх бичигийн анхны судалгаа нь өнгөрсөн зууны гучаад оны сүүлчээс эрчимтэй эхэлсэн байна. Энд бид юуны өмнө МНТ-ны эхийг галиглан буулгасан судалгааны талаар дурдая. Ер аливаа эх бичвэрийг галиглана гэдэг бол тухайн бичвэрийг тайлан уншиж, нарийвчилан буулгана гэсэн үг юм. Анх түрүү германы эрдэмтэн E. Haenisch,[518] оросын эрдэмтэн С. А. Козин[519] нар МНТ-ны бүрэн эхийг галиглан буулгасан бол түүний дараахан японы эрдэмтэн K. Shiratori МНТ-ны хитад ханз, хадмал орчуулгын хажуугаар латин галиг нэмэн

---

515 Арх. Палладий, Старинное монгольское сказание о Чингис-хане, Предисловие, Труды членов Российской духовной миссии в Пекине, том IV, СПб., 1866

516 А. М. Позднеев, Транскрипція палеографического текста *Юань-чао-ми-ши,* СПб., 1897, 1-112

517 Б. И. Панкратов, *Юань-чао би-ши.* (Секретная история монголов), том I, 15 цзюаней, Текст. Издания текста и предисловие Б. И. Панкратова, 1962, 5-18 + 9-602

518 E. Haenisch, *Manghol-un Niuča Tobča'an* (Yuan-ch'ao pi-shi). Die *Geheime Geschichte der Mongolen,* aus der chinesischen Transcription im mongolischen Wortlaut wieder-hergestellt, Leipzig, 1937, 5-140

519 С. А. Козин, *Сокровенное сказание.* Монголькая хроника 1240 г. подназванием *Mongyol-un niγuča tobčiyan,* Юань чао би ши, монгольский обыденный изборник, Введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии, 1941, 5-619

хадсан[520] нь тухайн үедээ МНТ судалалын түүхэн дэх хамагийн анхны бүрэн судалгаа болжээ. Мөн францын эрдэмтэн P. Pelliot[521] МНТ-ны бүрэн эхийг галиглан буулгаж, эхний 6 бүлэгийг франц хэлээр орчуулсаныг нь мөн дөчөөд оны сүүлчээр хэвлэн гаргасан байна.

1960-аад оны эхээр академич L. Ligeti өөрийн багш Pelliot-ийн буулгасан галигийг үндэс болгон МНТ-ны бүрэн эхийг шинэчилэн буулгасан нь[522] эдүгээ хүртэл олонхи судалаачидын мөрдлөг болгодог найдвартай эх болсоор байна. Түүний дараа Австралийн Үндэстэний их сургуулийн профессор Igor de Rachewiltz урид мөн Pelliot-ийн буулгасан галиг дээр тулгуурлан МНТ-ны бүрэн эхийг шинэчилэн галигласан нь[523] МНТ-ны судалалд томоохон хувь нэмэр болж, эдүгээ хүртэл эрдэмтэн судалаачидын ширээний ном болсоор байгаа билээ.

Наяад оны эхээр Өвөр Монголын эрдэмтэн профессор Баяр МНТ-ны хитад ханзаар тэмдэглэсэн эх, хадмал орчуулгын хажуугаар латин галиг, монгол хөрвүүлэг дагалдуулсан[524] нь Хитад улс дахь МНТ-ны судалалын хувид хамагийн анхны дэлгэрэнгүй судалгаа болсон байна. Мөн наяад онд японы нэрт эрдэмтэн Sh. Ozawa[525] *'Монголын нууц товчооны бүрэн судалгаа'* хэмээх зургаан боть бүтээлдээ МНТ-ны бүрэн эхийн ханз үсэгийн галиг, хитад хадмал орчуулга, латин галиг, япон орчуулгыг хэл зүйн дэлгэрэнгүй тайлбарын хамт багтаасан нь МНТ-ны судалалд гарсан хамагийн том судалгааны нэг болсон билээ. Монгол улсын эрдэмтэн Б. Сумъяабаатар монгол авиаг тэмдэглэсэн хитад ханз үсэгийг олон жил судалж, 570 гаруй ханз үсэгт түлхүүр код хийж, түүнийгээ ашиглан МНТ-ны бүрэн эхийг шинэчилэн галиглаж, 1990 онд хэвлүүлжээ.[526]

2000 он гарсаар МНТ-г уншиж, галиглах ажил амжилттай үргэлжилсээр байна. Японы Тохоку их сургуулийн профессор H. Kuribayashi, Өвөр Монголын их сургуулийн профессор Х. Чойжинжав нар[527] МНТ-ны гэрэл зурагийн эхийг эрдэм шинжилгээний галиг, үгсийн хэлхээсийн хамт нийтлүүлсэн нь сургалт, судалгааны

---

520 K. Shiratori, Onyaku - môbun - genchô - hishi. A Romanized Representation of *the Yüan-ch'ao-pi-shi. Secret History of the Mongols* in its Original Mongolian Sound. The Toyô Bunko Publication Series C. Volume VIII, Tokyo , 1942, XIV + 610 pp.

521 P. Pelliot, *Histoire secrète des Mongols*. Restitution du texte mongol et traduction française des chapitres I a VI, Paris, 1949, 198 pp.

522 L. Ligeti, Histoire secrète desMongols {= MLMC I}, Budapest, 1971, 263 pp.

523 I de. Rachewiltz, Index to the *Secret History of the Mongols*{= UAS 121}, 1972, 347

524 Баяр, Mongγol-un niγuča tobčiyan, ÖMAKQ, 1981, I(1-394), II(395-1099), III (1101-1467)

525 Sh. Ozawa, *Genchō hishi* zenshaku (A Complete Commentary of Secret History of the Mongols), Kazama-shobō Publisher, Tokyo, I(1984), 1-503, II(1985), 1-531, III (1986), 1-596, IV (1988), 1-430, V(1989), 1-564, VI (1990), 1- 732

526 Б. Сумъяабаатар, *Mongγol-un niγuča tobčiyan,* Үгсийн галиг, Уб., 1990, 7-965

527 H.Kuribayashi, Choijinjab, Word- and Suffix-Index to the *Secret History of the Mongols* based on the Romanized Transcription of L. Ligeti, {= CNEAS *Monograph Series* 4}, Tohoku University, Sendai, 2001, VI+1-954; Word- and Suffix-Index to the *Secret History of the Mongols* with Chinese Transcriptions and Glosses, {= CNEAS *Monograph Series* 33}, Tohoku University, Sendai, 2009, 1-538 pp.

ажилд өргөн хэрэглэгдэж байна. Саяхан Өвөр Монголын эрдэмтэн Булаг, Чимиддорж, Батсайхан нар *'Монголын нууц товчоо'*-ы хитад ханз бичигийн эхийг латин галиг болон монгол бичигийн буулгалтын хамт хоёр ботиор гаргасан нь МНТ-ны эх бичигийн судалалыг улам баяжуулсан чухал бүтээл болжээ.[528] Хамагийн сүүлд Бээжингийн Төвийн үндэстэний их сургуулийн профессор Хас-Эрдэнэ[529] хитад ханз үсэгийн эх, нангиад хадмал орчуулга, латин галиг, олон улсын галиг, монгол бичигийн хөрвүүлэгийг багтаасан шинэ судалгаа хийж хэвлүүлжээ.

'Монголын нууц товчоо'-ны хамагийн анхны эх нь XIII зууны дундуур уйгуржин монгол бичигээр бичигдсэн гэдэг нь нэгэнт тодорхой тул уул эхийг сэргээх оролдлого эрдэмтэдийн анхааралыг татсаар ирсэн бөгөөд тэр нь цаашдаа МНТ судалалын нэг чиглэл болоход хүрчээ. Анх 1897 онд нэрт монголч А. М. Позднеев уг зохиолын эхний 96 зүйлийг монгол бичигээр сэргээн бичсэн байна.[530] Түүнээс хойш наяад жилийн дараа Sh. Ozawa МНТ-ны нэгдүгээр бүлэгийн 68 зүйлийг уйгуржин монгол бичигийн эртний тигээр буулгаж, *'Монголын нууц товчооны бүрэн судалгаа'* хэмээх бүтээлийнхээ тэргүүн ботид хавсаргасан нь энэ талаар хийсэн анхны оролдлого юм.[531] Түүний дараа Их Мингаадай Иринчин, Ш. Гаадамба, Шонхор нар МНТ-ны уйгуржин монгол үсэгийн эхийг сэргээн тогтоох зорилго бүхий эхүүдийг тус тусдаа бэлдхэн нийтлүүлсэн байна.[532] Мөн Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан МНТ-ны бүрэн эхийг 1312 онд Бээжин хотноо хэвлэсэн *'Bodhicaryavatara-yin tayilburi'*-гийн барын тигээр буулгаж, Төрийн түүхийн музейд хадгалуулсан билээ. МНТ-ны анхны эхийг сэргээн тогтоохын тул зөвхөн монгол бичигийн хуучин тиг төдийгүй, сонгодог бичигийн өмнөх монгол бичигийн хэлний авианы тогтолцоо, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэрийг сайтар харгалзах нь зүйтэй.

МНТ судалалд түүний үгсийн сангийн судалал чухал байр эзэлнэ. Хамагийн анх 1939 онд профессор E. Haenisch МНТ-үгсийн толийг[533] нийтлүүлсэн бол 1970-

---

528 Булаг, Чимиддорж, Батсайхан, «*Mongγol-un niγuča tobčiyan*»-u uyiγurǰin mongγol bičig-ün dakin sergügelte, latin γaliγlal. // *The Secret History of the Mongols Reconst-ruction in Uighur-Mongolian Script and Romanized Transcription*/ ÖMKB, 2013, I. 1-97 + 112-540; II. 543-1229

529 Хас-Эрдэнэ, Tabun ǰüyil-ün üsüg qabsuryaγsan «*Mongγol-un niγuča tobčiyan*», *'Qas-Erdeni-yin ǰokiyal bütügel-ün čiγulγan'* ÖMSKQ, 10, 2014, 1-1038

530 А. М. Позднеев, Транскрипція палеографическаго текста *'Юань-чао-ми-ши'*, История монгольской литературы, Факультет восточных языков, Санкт-Петер-бургского Университета, 1897, 61-90

531 Sh. Ozawa, *Genchō-hishi* zenshaku / A Complete Study of *Secret History of the Mongols*/ I (1984), 365-448

532 Их Мингаадай Иринчин, *Mongγol-un niγuča tobčiyan*, Yekemingγadai Irinčin-ü sergügelte, ÖMYSKQ, 1987, 287; Ш. Гаадамба, *Монголын нууц товчоо*. Худам монгол бичгээр нягталж сэргээсэн сийрүүлгэ эх, тайлбар, 1990; Шонхор, *Mongγol-un niγuča tobčiyan*-u sergügelte, ÖMAKQ, 2002, 1-3 + 1-488 + 1-5

533 E. Haenisch, Wörterbuch zu *Manghol-un Niuča Tobča'an* (Yüan-ch'ao pi-shi) Geheime Geschichte der Mongolen, Leipzig, 1939, 3-196

аад оны эхээр I de Rachewiltz түүний нийт үгсийн хэлхээг[534] хэл зүйн хэлбэр болон давтамжийн хамт гаргасан нь уул зохиолын хамагийн анхны бүрэн хэлхээс болсон билээ. Хожим профессор Sh. Ozawa *'Монголын нууц товчооны бүрэн судалгаа'* хэмээх бүтээлдээ түүний бүх үгсийн хэлхээг хэсэгчилэн багтаажээ.[535] Түүний дараа Профессор H. Kuribayashi МНТ-ны үгсийн сангийн дэлгэрэнгүй хэлхээг дахин боловсорулж гаргахдаа эрдэм шинжилгээний галиг, хитад ханз үсэгийн бичлэг болон хэл зүйн хэлбэрүүдийг багтаажээ.[536]

МНТ-ны үгсийн сангийн судалалд түүний үгсийн бүрэлдэхүүнээс гадна утга санаа нь хуучирч бүдгэрсэн өдий төдий үг хэллэг, нэр томъёо, овог аймагийн нэр зэрэгийг хэл шинжилэл, түүхийн үүднээс тайлбарлах нь нэн чухал шаардлагатай болжээ. Элдэнтэй тэргүүтэй судалаачидын багэнэ талаар анхаарч, бүр жараад оны үеэс эхлэн МНТ-г уншиж судалсан E. Haenisch, C. Козин, L. Ligeti нарын судалгаанд гарсан ташааралуудыг заларуулсан хэд хэдэн үгүүлэл нийтлүүл-жээ.[537] Тус багийнхан МНТ-ны олон зуун үг хэллэгийг монгол хэл, аялгуунууд болон хитад, манж, түрэг хэлний баялаг материалтай харьцуулан судалсаныхаа үр дүнд минга гаруй үгсийн тайлбарыг багтаасан томоохон бүтээл туурвиж, 1981 онд хитад хэлээр, 1991 онд монгол хэлээр хэвлүүлжээ.[538] Элдэнтэйн хүү Ардажавын хамт МНТ-ны бүрэн эхийг монгол бичигээр дахин сийрүүлж хэвлүүлэхдээ өмнө хийсэн тайлбараа хавсаралт болгон оруулсан нь сургалт, судалгааны хэрэглээнд илүү өргөн хэрэгцээтэй бүтээл болж чадсан билээ.[539]

Монголын эрдэмтэн Ш. Гаадамба мөн жараад оны үеэс МНТ-ны үг хэллэгийг тайлсан цуварал үгүүлэлүүд[540] бичиж, хожим тэдгээрийг нэгдхэн тусхай ном'[541]

---

534 Igor de. Rachewiltz, Index to the *Secret History of the Mongols* {=UAS 121}, 1972, 347;

535 Sh. Ozawa, Genchō-hishi zenshaku */A Complete Study of Secret History of the Mongols/*, Tokyo, tom I:1984, 283-362; tom II:1985, 387-434; tom III:1986, 357-408; tom IV:987, 375-399; tom V:1988, 317-351; tom VI:1989, 567-609

536 H. Kuribayashi, Word- Index to the *Secret History of the Mongols*. Chinese Transcription and Glosses, CNEAS, Tohohoku University, Sendai, 2009, 538 pp.

537 Элдэнтэй, Kozin-u γaliγlan orčiγuluγsan «*Mongγol-un niγuča tobčiyan*»-u tasiyaraγsan büridkel, Liget-ün «*Yuvan čou mi si*»-yi latin üsüg-iyer γaliγčilaqu-du tasiyaraγsan üges-ün küsünügtü, Heniš-ün «*Mongγol-un niγuča tobčiyan-u üges-ün toli*»-yin endegürel-i ǰalaraγulqu anu, MKUJ 1, 1985, 36-70

538 Элдэнтэй, Оюундалай, Асаралту, «*Mongγol-un niγuča tobčiyan*»-u ǰarim üges-ün tayilburi, ÜKQ, Begeǰing, 1991, 1-564

539 Элдэнтэй, Ардажав, *«Mongγol-un niγuča tobčiyan»-seyiregülül, tayilburi,* ÖMSKKQ, 1986, 1044 тал

540 Ш. Гаадамба, *'Монголын нууц товчоо'*-ны нэг уран хэллэгийн учир, МС 4, 1964, 145-153; *'Монголын нууц товчоо'*-ны «*өрлүүд*» гэдэг үгийн учир, ШУАМ 1, 1966, 81-89; 'Нууц товчоо'-ны «*тоног*» гэдэг үгийн учир, ХЗ 5, 1967, 67-78; *'Монголын нууц товчоо'*-ны «*шинчи байан*» гэдэг үгийн учирт, ЭС 4, 1969, 15-28; *'Монголын нууц товчоо'*-ны зарим үг хэллэг, ШУАМ 4, 1970, 25-35

541 Ш. Гаадамба, Нууц товчооны нууцаас, Уб., 1976, 173 тал.

болгосоны дээр 1990 онд нийтлүүлсэн *'Монголын нууц товчоо'*[542] гэдэг томоохон бүтээлдээ 700 шахам үг хэллэгийн тайлбарыг хавсаргажээ. Түүний дараахан академич Д. Цэрэнсодном МНТ-г монгол үсэгээр буулгахдаа хитад хадмал орчуулгатай нь сайтар дүйлгэн нягталж, мөн 700 гаруй үг хэллэгийн дэлгэрэнгүй тайлбарыг хавсаргасан нь[543] уул зохиолын цаашдын судалалд үнэтэй хувь нэмэр болсон билээ.

Профессор Sh. Ozawa *'Монголын нууц товчооны бүрэн судалгаа'* гэдэг бүтээлдээ тус зохиолд гарч байгаа үг бүтээх дагавар, хэл зүйн хэлбэрүү-дийн тухай хэл шинжилэлийн олон тайлбарыг хавсаргажээ.[544] МНТ-ны үг хэллэг, оноосон нэрс, нэр томъёо зэрэгийг хамагийн өргөн дэлгэр тайлбарласан өөр нэг том бүтээл бол Igor de Rachewiltz-ийн *'Арван гуравдугаар зууны үеийн уран яруу түүхэн товчоон'*[545] хэмээх гурван боть судалгаа юм. Тэрвээр уул бүтээлдээ МНТ-нд гардаг эртний овог аймаг, хаад ноёд, түүхэн газар усны нэрсээс аваад эдүгээ утга санаа нь хуучирсан өдий төдий үг хэллэг, нэр томъёоны чанартай олон зуун үгийн гарал үүсэл, бүтэц тогтолцоо, утга агуулгын талаар асар баялаг материал түшиглэн тайлбарласан нь зөвхөн тухайн зохиол төдийгүй монгол хэл, түүх судалалын нэвтэрхий толийн дайтай бүтээл болсон билээ. Энэхүү бүтээлийн зөвхөн үгсийн тайлбар нь 820 тал, номзүй нь 110 гаруй тал болсоноос уул бүтээлийн цар хүрээ тодорхой харагдаж байна

Саяхан профессор Ш. Чоймаа *'Монголын нууц товчоо'*-г дахин шинэчилэн буулгахдаа хитад ханзаар тэмдэглэсэн дуудлагыг аль болохоор тусхасанаас гадна хуучирсан үг хэллэгүүдийн тайлбарыг хэсэг бүлэг тус бүрийн ард хавсаргасан байна.[546] МНТ-ны хитад ханз үсэгээр тэмдэглэсэн эхэд аль болохоор ойртуулсан шинэ сийрүүлэл боловсоруулан хуучирсан үг хэллэгүүдийн дэлгэрэнгүй тайлбар хавсаргажээ.[547] Түүний энэхүү бүтээлд урид өмнөх судалгаануудад дурдсанаас өөрөөр авч үзсэн тайлбар нилээд байгаа нь шинэлэг төдийгүй, МНТ-ны цаашдын судалалд чухал ач холбогдолтой юм. Чехийн Карлын их сургуулийн зочин

---

[542] Ш. Гаадамба, *Монголын нууц товчоо*, Qudam mongγol bičig-iyer mongγol bičig, udqa sudulul-un egüden-eče Šangǰimitab-un Γadamba-yin tösügelen niγtalaǰu sergügegsen seyiregülge eke tayilburi, Уб., 1990, 221-416

[543] Д. Цэрэнсодном, *Mongγol-un niγuča tobčiyan*-u orčiγulγ-a tayilburi, Begejing, ÜKQ, 1993, 272-498

[544] Sh. Ozawa, *Genchō hishi* zenshaku (A Complete Commentary of *Secret History of the Mongols*), Kazama-shobō Publisher, Tokyo, I(1984), 1-503, II(1985), 1-531, III (1986), 1-596, IV (1988), 1-430, V(1989), 1-564, VI (1990), 1- 732

[545] Igor de Rachewiltz,*The Secret History of the Mongols*. A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century. Translated with a Historical and Philological Commentary, Brill, Leiden / Boston, 2004. vol. I:CXXVI + 1-642, vol. II:643-1347; vol.III(2013):XXIII+1-226

[546] Ш. Чоймаа, *Монголын нууц товчоо*. Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг (Шинээр хөрвүүлж, тайлбар үлдсэн доктор, профессор Ш. Чоймаа), Уб., 2011, 290 тал

[547] Ш. Чоймаа, *Монголын нууц товчоо*. {= *Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал* 1}, 2006, 238 тал. // *Монголын нууц товчоо*.Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг, 3-291

профессор Ж. Лувсандорж саяхан МНТ-г дахин шинээр буулгаж, зүйл тус бүрд тохиолдож байгаа хуучирсан үг хэллэг, хүний нэр, газар усны нэрийн тайлбарыг тусхайд нь хавсаргажээ.[548] Тэрвээр МНТ-ны үг хэллэг, нэрлэлт бүрийг монгол хэл, сэдхэлгээ, уламжилалт зан заншилын үүднээс тайлбарласан нь зарим талаар өвөрмөц бөгөөд бас зарим талаар таамагийн шинжтэй тайлбар ч бас цөөнгүй бий.

'Монголын нууц товчоо' бол дундад үеийн монгол хэлний авианы үндэсэн шинжийг тусхасан хамагийн том дурсхал мөн тул түүний хэлний онцлог шинжийг цуваа цагийн үүднээс судалах, ялангуяа тухайн үеийн хэлний шинжийг тусхасан бусад бичигийн дурсхалуудтай харьцуулан үзэх асуудал эрдэмтэдийн анхааралыг ихээхэн татсан байна. Энэ талаар хамагийн анх германы эрдэмтэн E. Haenisch 1950-аад оны дундуур МНТ-ны хэлний онцлог шинжийн тухай тусхай үгүүлэл[549] нийтлүүлсэн бол түүний дараахан америкийн эрдэмтэн John Ch. Street *'Монголын нууц товчооны хэл'*[550] гэсэн ганц сэдэвт зохиолыг бүтээлийг гаргажээ. Мөн тэрвээр МНТ-г эх бичвэрийн утга агуулгыг бүрэн зөв ухаж ойлгоход шаардлагатай цэг тэмдэгүүдийг нэмэж оруулах зүйтэй гэж үзээд, эх бичвэрт байхгүй цэг тэмдэгүүдийг нөхөж тэмдэглэсэн тусхай бүтээл нийтлүүлжээ.[551] Түүний дараа МНТ-ны хэлний шинжийн талаар гарсан өөр нэг томоохон бүтээл бол профессор Sh. Ozawa-гийн *'Монголын нууц товчооны хэлний зүй'* хэмээх бүтээл юм. Уг бүтээлд дундад үеийн монгол хэлний үед үүсэн бүрэлдсэн урт эгшиг, хос эгшиг, авианы суларал, ижилшил болон үйл үгийн хэв, төлөв, бие, цагийн тогтолцоог дэлгэрэнгүй тусхасан байна.[552]

Эдүгээ МНТ-г дэлхийн гуч орчим хэлээр орчуулсан бөгөөд тэдгээрийн ихэнхи нь тухайн зохиолын утга агуулгыг танилцуулах уншигч олонд танилцуулах зорилготой ажээ. Хамагийн анх оросын эрдэмтэн Архимандарит Палладий (Петр Иванович Кафаров) МНТ-ны хитад орчуулгаас орос хэлэнд орчуулан 1866 онд Санкт-Петербург хотноо хэвлүүлжээ.[553] Түүний дараа профессор А. М. Позднеев мөн МНТ-ны хитад галигийг орос үсэгээр галиглан буулгаад орос хадмал

---

548 Ж. Лувсандорж, *Монголын нууц товчоон*{=*Monograph Series* 6} Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв, Уб., 2014, 570 тал

549 E. Haenisch, Grammatische Besonderheiten in der Sprache des *Manghol-un Niuča Tobča'an,* SO 14, 1950, 3-24

550 John C. Street, The Language of the *Secret History of the Mongols,* {= *American Oriental Series* 42}, New Haven, 1957, 1-89; On the 14th Century Punctuation of Mongolian in the *Yüan-ch'ao pi-shih,* Bloomington, Indiana, 1986, 7-103

551 John C. Street, On the 14th Century Punctuation of Mongolian in the *Yüan-ch'ao pi-shih,* Bloomington, Indiana, 1986, 7-103

552 Sh. Ozawa, A Grammar on the Language of *'Secret History of Mongols',* Kazama Shobo, Tokyo, vol. I (1994) 647 pp. vol.II (2000), 525 pp

553 П. И. Кафаров, Старинное монгольское сказаніе о Чингисхане, Труды членов Российской духовной миссии в Пекине, 1866, 258 стр.

орчуулгыг дагалдуулжээ.[554] XX зууны эхээр японы эрдэмтэн Naka Michiyo[555] уг зохиолыг орчуулж, *'Чингис хааны үнэн түүх'* гэсэн нэртэйгээр гаргасан байна.

Түүнээс хойш МНТ-г орчуулах ажил нилээд тасалдсаны дараа дөчөөд онд E. Haenisch-ийн герман орчуулга,[556] С. Козины орос орчуулга,[557] P. Pelliot-ийн франц орчуулга[558] гарсан бөгөөд орчуулагчид нь цөм монголч эрдэмтэн байсан тул тэдгээр орчуулга нь МНТ-ны эрдэм шинжилгээний орчуулгын эхлэл нь болжээ. Ер эрдэм шинжилгээний орчуулга гэдэг нь тухайн зохиолын үг хэллэг бүрийн утга санаа, үгүүлбэр бүрийн хэл найруулга, үндэсний онцлог, түүхэн баримт зэрэгийг тал талаас нь нягтлан үзэж, адил тэгш харгалзсан байх ёстой билээ. Тавиад онд Бельгийн нэрт монголч A. Mostaert тэдгээр гурван орчуулгыг жинхэнэ эхтэй нь дүйлгэн үзээд, тэдгээрт байгаа андуу ташаа ухаарч орчуулсан үг хэллэгүүдийг заларуулан тайлбарласан томоохон бүтээл туурвисан нь жинхэнэ эрдэм шинжилгээний орчуулгын шаардлагын дагуу хийгдсэн үнэтэй судалгаа болсон билээ.[559]

Дал, наяад оноос эхлэн МНТ-ны нилээд олон орчуулгууд гарсан байна. Тэдгээрийн дотороос МНТ-ны судалалыг гүнзгийрүүлэхэд чухал ач холбогдол бүхий хэд хэдэн англи орчуулга байгааг онцлон дурдвал зохино. МНТ-ны англи орчуулгуудын дотороос хамагийн анх нийтлэгдсэн нь Artur Waley-гийн хэсэгчилсэн орчуулга юм.[560] Харин МНТ-ны эрдэм шинжилгээний анхны бүрэн орчуулгыг Igor de Rachewiltz хийж, Австралийн Үндэстэний их сургуулиас эрхэлэн гаргадаг *'Алс дорнодын түүхийн судалал'* сэдхүүлд далаад оны эхнээс цуваруулан гаргажээ.[561] Зохиогч уул орчуулгаа улам сайжируулан засаад 2000 оны эхээр дахин

---

554 А. М. Позднеев, Транскрипція палеографическаго текста *'Юань-чао-ми-ши'*, История монгольской литературы, лист. Факультет восточных языков, СПб-кого Университета, 1897, 112 стр.

555 Naka Michiyo, Seijishi kan jitsuroku, 1909

556 E. Haenisch,Die *Geheime Geschichte der Mongolen* aus einer mongolischen Niederschrift des Jahres 1240 von der Insel Köde'e im Kelüren-Fluß erstmalig übersetz und erlautert; zweite verbesserte Auflage, Leipzig, 1941, 196

557 С. А. Козин, *Сокровенное сказание.* Монгольская хроника 1240 г. Под названием *Mongγol-un niγuča tobčiyan, Юань чао би ши,* монгольской обыденный изборник, том I. Введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии, 1941, 79-199

558 P. Pelliot, *Histoire secrètedes Mongols*. Restitution du texte mongol et traduction française des chapitres Ia VI, Paris, 1949, 121-196

559 A. Mostaert, Sur quelques passages de *l'Histoire secrète des Mongols*, Harvard Yenchin Institute, Cambridge, Mass. 1953, XX + 1-277

560 A. Waley, *The Secret History of the Mongols* and Other Pieces, 1963, 320 pp.

561 I de Rachewiltz, The *Secret History of the Mongols,Papers in Far-Eastern History*, Australian National University, Canberra, vol. 4(1971):115-163; vol. 5(1972):149-175; vol. 10(1974):55-82; vol. 13(1976):41-75; vol. 16(1977):27-65; vol.16 (1978):43-80; vol. 18(1980):17-57; vol. 21(1981):111-146; vol. 26(1982):39-84; vol. 30(1984):81-160; vol. 31(1985):21-33; vol. 33(1986):129-137

хэвлүүлсэн байна.[562] Түүний дараахан гарсан өөр нэг орчуулга бол профессор F. W. Cleaves-ийн орчуулга юм.[563] Тэрээр уул орчуулгаа бүр тавиад оны үед хийж дууссан боловч наяад оны эхээр нийтлүүлжээ. Одоогоос долоон зуу гаруй жилийн өмнө зохиогдсон МНТ-ны хуучирсан үг хэллэг, хэл найруулгын өнгө аясыг орчуулгадаа тусхахын тул XVII зууны эхээр орчуулсан Библийн хэл найруулгыг загвар болгосон нь сонирхолтой юм. 2000 он гарсаар Профессор Өргөнгөө *'Нууц товчоо'*-ны өөр нэг орчуулга гаргасан байна.[564] Орчуулагч нь уулаас монгол хүн учираас уул зохиолын доторхи монгол ахуй амьдаралтай холбоотой үг хэллэгийн нарийн утга учирыг ухаарч ойлгох, ухаарч ойлгосоноо илэрхийлэн буулгах талаар давуутай болсон байдал ажиглагддаг билээ. Таширамд дурдахад,тавиад оны сүүлчээр Энэдхэгийн Муслим их сургуулийн хитад судалаач Wei Kwei Sun МНТ-ны хитад хадмал орчуулгыг эш болгон англиар орчуулсан[565] бол жараад оны дундуур Калифорни их сургуулийн профессор Kuo-Yi Pao (Үнэнсэчин) МНТ-ны эхний 9 бүлэгийг англи хэлээр орчуулжээ.[566] Наяад оны дундуур америкийн зохиолч Paul Kahn МНТ-ны эхийг F. Cleaves-ийн орчуулгад тулгуурлан яруу найрагийн хэлбэрээр орчуулсан байна.[567] Мөн Монголын орчуулагч Н. Доржготов, З. Эрэндоо нар МНТ-ны бас нэгэн шинэ орчуулыг гаргасан билээ.[568]

Англи хэлнээс гадна герман, франц зэрэг европын томоохон хэлээр хэд хэдэн орчуулга гарчээ. Тухайлвал, нэрт монголч W. Heissig, M. Taube нарын герман орчуулга[569] францын эрдэмтэн Marie-Dominique Even, Румыны монголч эрдэмтэн Rodica Pop нарын франц орчуулга тус тус гарсан байна.[570]

---

562 Igor de Rachewiltz, *The Secret History of the Mongols*. A Mongolian Epic Chronicle of the ThirteenthCentury. Translated with a Historical and Philological Commentary, Brill, Leiden | Boston, 2004. vol. 71:1-218

563 F. W. Cleaves, *The Secret History of the Mongols*, Vol.I: Translation. Cambridge, Mass.: Harvard University Press, 1982, 1-228

564 Urgunge Onon, *The Secret History of the Mongols*. The Life and Times of Chinggis Khan, Translated, Edited and with an Introduction by Urgunge Onon, Curzon Press, 2001, 37-278

565 Wei Kwei Sun, *The Secret History of Mongol* Dynasty (*Yuian-chao Pi-shi*), Muslim University ofAligarh, Publications of the Department of History, No 12, 1957, 199 pp.

566 Kuo-Yi Pao, Studies on the *Secret History of the Mongols,* {UAS 58},1965, 163 pp.

567 *The Secret History of the Mongols*. The Origin of Chingis Khan. An Adaptation of the Yuan Ch'ao Pi Shih, Based on the English Translation by Francis Woodmen Cleaves. By Paul Kahn, North Point Press, San Francisco, 1984, 204 pp + Tables

568 N. Dorjgotov, Z. Erendo, The Secret History of Mongols, Edited by D. Tumurtogoo, Ulaanbaatar, Monsudar, 2006, 238 pp.

569 W. Heissig, *Die Geheime Geschichte der Mongolen,* 1981; M. Taube, *Die Geheime Geschichte der Mongolen,* Herkunft, Leben und Aufstieg Cinggis Qans, Leipzig-Weimar, 1989

570 *Histoire secrète des Mongols*. (Chronique mongole du XIII[e] siècle) traduit du mongol-présénte et annoté par Marie-Dominique Even et Rodica Pop. preface de Roberte N. Hamayon, {= *Connaissance de l'Orient*}. Collection UNESCO d'oeuvres representatives. Gallimard, 1994, 7-350

XX зууны дөчөөд онд японы эрдэмтэн T. Kobayashi[571], K. Shiratori,[572] Sh. Iwamura[573] нар, дал, наяад оны үед профессор M. Murakami,[574] Sh. Ozawa[575] нар тус тус МНТ-ны япон хэлээр орчуулсан бол Сиэ Зайнань, Яо Цуньу, Жагчид Сэцэн нар орчин үеийн хитад хэлээр орчуулжээ.

МНТ-ноос гадна хитад ханз үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний өөр нэг томоохон дурсхал бол Мин улсын эхэн үед холбогдох *'Хитад Монголын харилцааны бичиг'* болон 1389 онд эмхэдхэсэн *'Хуа-й й-юү'* хэмээх арван долоон зүйл бүхий хитад-монгол зүйл хуваасан толь бичиг юм. Мөн XIV зууны үед хитад, монгол хаадын харилцан бичсэн арван хоёр захидал байдаг бөгөөд МНТ-ны нэгэн адил хитад ханз үсэгээр бичсэн тэдгээр захидалыг *'Хуа-й й-юү'* толь бичигийн нэгэн бүрэлдэхүүн мэт хамтад нь авч үзсээр иржээ. Мин улсын эхэн үед хитад хүнд монгол хэл сургахад тэдгээр захидалуудыг дээрхи толийн хамт унших материал болгон ашиглаж байсанаас тийнхүү хамтад нь авч үзэх болсон буй заа.

Тэдгээр дурсхалын анхны томоохон судалгааг өнгөрсөн зууны дөчөөд оны сүүлчээр Польшийн монголч эрдэмтэн M. Lewicki хийсэн байна. Тэрвээр дурдсан хоёр дурсхалын бүрэн эхийн галиг, нийт үгсийн хэлхээс, франц орчуулга болон гэрэл зурагийн эхийг нийтлүүлсэн[576] нь тухайн дурсхалыг өрнө дахинд танилцуулсан анхны томоохон бүтээл болсон төдийгүй, монгол хэлний түүхэн судалалын үнэтэй бүтээл болон эдүгээ хүртэл хэрэглэгдсээр байна. Түүний дараа профессор E. Haenisch *'Хитад Монголын харилцааны бичиг'*-ийг галиглан буулгасанаас[577] гадна *'Хуа-й й-юу'* толийн бүх үгсийг монгол бичиг, хитад ханз, дөрвөлжин үсэг, хитад ханзны бичлэгийг герман орчуулгын хамт хэвлүүлжээ.[578] Хожим далаад оны эхээр L. Ligeti *'Monumenta Linguae Mongolicae Collecta'* цуваралынхаа гуравдугаар дэвтэрт *'Хитад Монголын харилцааны бичиг'*-ийн эхийг багтаажээ.[579] Мөн нэрт монголч эрдэмтэн монголч A. Mostaert дээрхи судалгаанууд гарахаас өмнө, бүр хориод оны сүүлчээс эхлэн уул дурсхалуудын эхийг судалж эхэлсэн боловч судалгаагаа бүрэн дуусхаж амжаагүй үлдээсэнийг хожим профессор Igor de Rachewiltz гүйцээн судалж, Брюсель хотноо гардаг *'Mélanges*

---

571 T. Kobayashi, Mōko no hishi, Tokyo, 1940

572 K. Shiratori, Onyaku mōbun *Genchōhishi,* Tōyōbunko, Tokyo, 1942

573 Sh. Iwamura, *Genchōhishi,* Chingisqan kiroku, Tokyo, 1963

574 M. Murakami, Mongoru hishi Chingisu kan monokatari, I(1970), II(1972), III(1976)

575 Sh. Ozawa, *Genchō hishi* zenshaku, Tokyo, I (1984), 1-503; II (1985), 1-531; III (1986), 1-596; IV (1988), 1-430; V(1989), 1-564; VI (1990), 1- 732

576 M. Lewicki, La langue des transcriptions chinoises du XIVe siècle. Le *Hua-yi yi-yu* de 1389,vol. I.Wroclaw, 1949, 5-233; vol II. Vocabulaire-Index, 1959, 7-89

577 E. Haenisch, Sino-mongolische Dokumente vom Ende des 14. Jahrhunderts. Abh. der DeutschenAkademie d. Wiss. zu Berlin, Jg. 1950, Nr 4, Berlin, 1952, 60 S.

578 E. Haenisch, Sino-mongolische Glossare. I. Das *Hua-i ih-yü*. Abh. der Deutschen Akademie d. Wiss. zu Berlin, Jg. 1956. Nr 5, Berlin, 1957, 37 S.

579 L. Ligeti, Pieces de chancellerie en transcription chinoise {= MLMC III}, 1972, 135-165; Pieces de chancellerie en transcription chinoise {= IVLMMTIII}, 1973, 117-242

chinois et bouddhiques' цуваралаар хоёр дэвтэр болгон нийтлүүлжээ.[580] Дурдсан бүтээлийн тэргүүн дэвтэрт *'Хитад Монголын харилцааны бичиг'*-ийн бүрэн эхийг галигийг *'Хуа-й й-юү'*толь бичиг болон арван хоёр захидалын үгсийн нэгдсэн хэлхээ, франц орчуулгын хамт багтаасан бол дэд дэвтэрт нь уул *'харилцааны бичиг'*-ийн үг хэллэгийн дэлгэрэнгүй тайлбар багтсан байна.

1990-ээд оны үед Өвөр Монголын эрдэмтэн Ө. Мандах дээр дурдсан дурсхалуудыг тусхайлан судалж, *'Монгол й-юү толь бичиг', 'Хуа-й й-юү'* гэсэн хоёр томоохон бүтээл туурвисан байна.[581] Таширамд дурдахад, өнгөрсөн зууны тавиад оны үед манай ахмад эрдэмтэн Х. Лувсанбалдан Өвөр Монголын эрдэмтэн Боушияаны хамт *'Хуа-й й-юү'* толийг галиглан буулгаж, эрдэм шинжилгээний сэдхүүлд цуварал болгон нийтлүүлсэн[582] нь тухайн дурсхалын талаар гарсан анхны судалгааны нэг болсон юм. Мөн Өвөр Монголын эрдэмтэн Шонхор нар *'Хуа-й й-юү'* толийн тухай хэд хэдэн цуварал үгүүлэл нийтлүүлсэн байна.[583] Саяхан японы эрдэмтэн H. Kuribayashi *'Хуа-й й-юү'* толь бичиг болон *'Хитад-монголын харилцааны бичиг'*-ийн гэрэл зурагийн эхийг латин галиг, үгсийн хэлхээсийн хамт дахин нийтлүүлжээ.[584]

'Хуа-й й-юү' толь бичигээс гадна Мин улсын үед хитад ханз үсэгээр тэмдэглэсэн *'Dengtan Bijiu', 'Zhi-yuan Yi-yu', 'Chih-yuan yi-yu', 'Da-da yi-yu'* зэрэг хитад-монгол толиуд гарсан бөгөөд тэдгээрийн талаар анх японы эрдэмтэн Ishida Mikinosuke анх танилцуулсан байна.[585] Хожим *'Zhi-yuan Yi-yu'* толийн талаар Шонхор,[586] L. Ligeti,[587] G. Kara,[588] O. Sayuri,[589] Igor de Rachewiltz,[590] П. О. Рыкин,[591]

---

580 A. Mostaert, La matérial Mongol du *Houa i i iu* de Houng-ou (1389) I. {= *Mélanges Chinois et Bouddhiques* XVIII}, ed. par Igor de Rachewiltz, Bruxelles, 1977, XXIII + 127 pp. // II. {= *Mélanges Chinois et Bouddhiques* XXVII}, ed. par Igor de Rachewiltz, 1995, XXII +144 pp.

581 Ө. Мандах, *Mongγol i-iyi* toli bičig {= MTBČ}, ÜKQ, 1993, 691; *Qoa-i i-iyi.* Sin-e-ber kinan emkidkeǰü γaliγlaǰu tayilburi kigsen Ö. Manduqu, ÖMSKKQ, 1998, 389

582 Х. Лувсанбалдан, *Hua-i i-yü* toli bičig-ün ǰarim keseg, MKJT 7, 1959, 11, 1959, 17-28, 12, 1959, 24-34; 1, 1960) 40-47

583 Шонхор, *'Quwa-i i-iyui bičig'*-ün mongγol kelen-ü egesig abiyan-u toγtalčaγ-a, *'Erten-ü mongγol kelen-ü sudulul',* ÖMSKKQ, 1996, 89-123; *'Quwa-i i-iyui bičig'*-ün mongγol üges-ün uyiγurǰin körbegülge ba γaliγlal, *ibid.* 352-411; *'Quwa-i i-iyui bičig'*-ün üges-ün sang-un sudulul, *ibid.* 412-441; *Quwa-i i-iyui bičig'*-ün sunǰilege, ibid. 695-725; *'Quwa-i i-iyui bičig'*-ün mongγol üge-yi abiyačilaγsan kitad üsüg-ün sudulul, ibid. 726-789

584 H. Kuribayashi, Word- and Suffix-Index to *Hua-yi yi-yü* based on the Romanized Transcription of L. Ligeti {= CNEAS8}, Tohoku University, 2003, 178 pp.

585 Ishida Mikinosuke, *'Zhiyuan Yiyu'* nit suite Tōyōgaku ronsō 1, 1934: Roryū sairyaku. Lu long sai lüenimietaru kanmō taiyaku goi nit suite, Kōkogaku 2, 1938

586 Шонхор, Ji yuwan i-iyui bičig-ün sudulul, *'Erten-ü mongγol kelen-ü sudulul',* ÖMSKKQ, 1996, 124-139; Bei-lu i-iyui bičig-ün sudulul, ibid. 140-148

587 L. Ligeti, Un vocabulaire sino-mongol des Yuan le *Tche-yuan yi-yu,* AOH 44, 1990, 259-277

588 G. Kara, *Zhiyuan Yiyu.*Index alphabetique des mots mongols, AOH 44:3, 1990, 279-344

589 Ochi Sayuri, Phonology of Middle Mongolian in Da-da yi-yu, Kyoto University Linguistic Research, Vol. 23, 115-144

590 Igor de Rachewiltz, Some Remarks on the *Chih-yüan i-yü* Alias *Meng-ku i-yü,* the First Known Sino-Mongol Glossary, AOH 59, 2006, 11-28

Д. Бүргэд[592] нар, *Yi-yu* (Beilu Yi-yuan) толийн талаар A. B. Apotóczky[593] нар судалгааны бүтээл гаргасан байна. Дээрхи судалгаануудаас гадна *'Хуа-й й-юу'* хэмээх толь бичигийг хэдийд, хэн зохиосон талаар H. Serrruys, Roy A. Miller нарын үгүүлэл гарсан бий.[594]

0.3.3.5 АРАБ ҮСЭГЭЭР ТЭМДЭГЛЭСЭН МОНГОЛ ДУРСХАЛ

§ 73. **Араб үсэгийн монгол дурсхалууд, тэдгээрийн судалгаа**. Дундад үеийн монгол хэлний онцлогийг тусхасан дурсхалуудын нэг нь араб үсэгээр тэмдэглэсэн монгол дурсхалууд юм. Араб үсэгээр тэмдэглэсэн дундад үеийн монгол хэлний арав шахам дурсхал Ташкент, Лейден, Истанбул, Ром, Парис, Мюнхен, Аден, Кэмбрижийн номын санд хадгалагдаж байгаа бөгөөд тэдгээрт хитад, дөрвөлжин үсэгийн дурсхалуудын нэгэн адил XIV-XV зууны үеийн монгол хэлний авианы бүтэц тогтолцоо, урт, хос эгшиг, эгшигийн ижилшил, авианы суларал, үеийн бүтэц зэрэг онцлог шинжүүдийг маш нарийн туссан байна. Араб үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсхалын хамагийн том нь XII зууны үеийн Хорезмийн нэрт эрдэмтэн Абул-Касим Махмуд бин Омар ал-Замахшар (*Abdū'l-Qāsim Mahmūd b. Umar al-Zamahšarī*)-ийн зохиосон *'Muqaddimat al-adab'* хэмээх араб-перс толийн монгол хадмал орчуулга юм. Бүгд 3500 гаруй үгтэй тус толь бичиг нь дундад үеийн монгол хэлний авианы онцлог төдийгүй, үгийн бүтэц, хэл зүйн хэлбэрүүдийг тусхасанаараа монгол хэлний түүхэн судалгааны үнэтэй чухал дурсхал юм. Түүнчилэн XIV зууны үед персийн эрдэмтэн Ибн ал-Муханна (*Jamāl-ad-Dīn Ibn Muhannā*)-ын зохиосон перс-монгол толийн гурван өөр хувилбар (800 гаруй монгол үгтэй), Лейден хотын их сургуулийн номын сан дахь *Kitâb Majmû Turjumân Turkî wa-'ajamî wa-Muğalî* хэмээх монгол-перс, араб-монгол толь (640 монгол үгтэй), Хамдуллаха Казвини (*Hamdullāh al-Mustaufī al-Qazwīnī*)-ий *'Зүрэхний гэрэл'* хэмээх ан амьтан нэрийн толь (40 орчим монгол үг), XV зууны перс эрдэмтэн Imād al-Qarāhisāri-ийн зохиосон *'Šamil ül-luya'* хэмээх араб-перс-түрэг-монгол толь (400 орчим монгол үгтэй), Расулидын ван Al-Malik al-Afdal al-'Abbas b.'Ali хэмээгчийн зохиосон *'Хааны толь'* хэмээх араб, перс, турк, грек, армен, монгол зэрэг зургаан хэлний толь (900 орчим монгол үгтэй), Афганистанаас Зирни хэмээх газараас олдсон монгол хэлний гар бичмэл толь (360 монгол үгтэй) зэрэгийг дурдаж болно.

---

591 П. О. Рыкин, Китайско-монгольский словарь начала XVII в. *Дада-юй*' Татарские слова': введение в изучение памятника, *'Проблемы исторического развития монгольских народов'*, СПб., 2007, 112-126

592 Kerejidiin D. Bürgüd, A Study of a Sino-Mongol Glossary Known as the *Bei-lu yi-yu,* Ulaanbaatar, 2017, 225 pp.

593 A. B. Apatczky, *Yiyu* (Beilu yiyu): A Middle Mongolian Dictionary of the *Dengtan Bijiu,* ALTAICA. *Budapestinensin* MM 11. Proceedings of the 45th PIAC. Budapest, Hungary, June 23-28, Edited by Alice Sarközi and Attila Rakos, BP 2003, 8-12; *Yi-yu* (Beilu Yi-yuan) Indexed Critical Edition of a Sixteenth-Century Sino-Mongolian Glossary, Global Oriental, 2009, IX-XVIII + 1-227

594 H. Serrruys, The Dates of the Mongolian Documents in *Hua-i i-yü,* HJAS 17, 1954, 419-427; Roy A. Miller, Qoninči, Compiler of the *Hua-i i-yü* of 1389. UAJb 38, 1966, 112-121

Араб үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсхалуудын дотороос XIV зууны үед персийн эрдэмтэн Ибн ал-Муханны зохиосон перс-монгол толь хамагийн анх судалагджээ. Бүгд 25 хэсэгтэй зүйл хуваасан энэхүү толийн нэгэн хувилбарыг оросын эрдэмтэн П. М. Мелиоранский анх олж, уг толийн бүх үгсийг үсэгийн дараалалд оруулан, араб бичлэг, орос орчуулга, дуудлагын галиг хийгээд үг тус бүрийн монгол бичлэгийн хамт сийрүүлэн буулгасан нь араб үсэгийн монгол дурсхалуудын хамагийн анхны судалгаа болжээ.[595] Тэрвээр мөн уул дурсхалын авианы болон бүтэцзүйн гол шинжийн талаар тусхай тэмдэглэл хавсаргажээ.[596] Түүний дараа профессор Н. Поппе тус толийн Истанбулд хэвлэгдсэн өөр нэгэн хувилбарыг олж, латин галиг, араб бичлэг, орос орчуулгын хамт *Мукаддимат ал-Адаб* толийн тухай судалгаандаа хавсаралт болгон гаргажээ.[597] Далаад оны эхээр Бонн их сургуулийн профессор M. Weiers[598] Ром хотын Корзины номын санд хадгалагдаж байсан гурав дахь хувилбарыг олж, латин үсэгийн дараалалд оруулан, латин галиг, герман орчуулга, гэрэл зурагийн хамт нийтлүүлжээ.

Өнгөрсөн зууны 20-30-аад онд араб үсэгээр тэмдэглэсэн хэд хэдэн ховор дурсхалууд судалагдсан байна. Тэдгээрийн хамагийн анхных нь XIV зууны үеийн персийн эрдэмтэн Хамдуллаха Казвини *(Hamdullāh al-Mustaufī al-Qazwīnī)*-ы зохиосон *'Зүрэхний гэрэл'* хэмээх бүтээл юм. Уул дурсхалд перс, түрэг, монгол гурван хэлээр бичсэн ан амьтаны нэрс байгаа бөгөөд проф. Н. Поппе тэдгээрээс дөч гаруй монгол үгийг олж, монгол бичигийн бичлэг болон монгол хэл аялгууны зарим дурсхалтай харьцуулан судалаад орос галиг, орос орчуулгатай нийтлүүлжээ.[599] Түүний дараахан P. Pelliot уул дурсхалын дотороос ная гаруй монгол үгийг монгол, түрэг хэлний зарим материалтай харьцуулан судалжээ.[600] Мөн энэ үед судалагдсан өөр нэг чухал дурсхал бол Холланд улсын Лейден хотын их сургуулийн номын сан дахь *Kitâb Majmû Turjumân Turkî wa-'ajamî wa-Muğalî* гэсэн нэртэй гар бичмэл толь юм. Нийт 76 хуудастай уг толийн сүүлчийн арав гаруйхан хуудсанд 240 үгтэй монгол-перс толь, 400 орчим үгтэй араб-монгол толь багтаж байгаа бөгөөд түүнийг анх профессор N. Ропре анхлан судалжээ.[601] Тэрвээр уул толийн араб үсэгээр бичсэн монгол үгсийг өмнө судалагдсан араб үсэгийн бусад дурсхалтай харьцуулан судалаад, латин галиг, герман орчуулгын хамт нийтлүүлжээ. Таширамд дурдахад японы эрдэмтэн Y. Saito уул дурсхалын галиг, англи орчуулга, эх бичигийн хуудас, мөрийн тоо зэрэгийг зэрэгцүүлэн жагсааж,

---

595 П. М. Мелиоранский, Араб филолог о монгольском языке, 1903, 107-154

596 ibid., 155-171

597 Н. Поппе, Монгольский словарь Мукаддимат ал-Адаб {ТИВ 14}, т. I-II, 1938, 432-451

598 M. Weiers, Ein arabisch-mongolischer Worterspiegel aus der Biblioteca Corsini in Rom, ZAS 6, 1972, 7-29

599 Н. Поппе, Монгольские названия животных в труде Хамдуллаха Казвини, Зап. Колл. Вост. том 1, 1925, 195-208

600 P. Pelliot, Les Formes turques et mongoles dans la nomenclature zoologique du Nuzhatu-l-kulub, BSOS 6:3, 1931, 556-578

601 N. Poppe, Das mongolische Sprachmaterial einer Leidener Handschrift,*Bull. de l'acad. des Sc.de l'URSS,* 1927 (1009-1040, 1251-1274), 1928 (55-80)

өнгөт гэрэл зурагийн хамт саяхан нийтлүүлсэн[602] нь араб үсэгийн монгол дурсхалын судалалд чухал хувь нэмэр болжээ.

XX зууны үед судалагдсан араб үсэгийн монгол дурсхалын хамагийн том нь XII зууны үеийн Хорезмийн нэрт эрдэмтэн Абул-Касим Махмуд бин Омар ал-Замахшарийн зохиосон *'Мукаддимат ал-Адаб'* хэмээх араб-перс толийн монгол хадмал орчуулга юм. Бүгд 3500 орчим толгой үгтэй уг дурсхалыг профессор Н. Поппе анхлан судалсан байна. Тэрвээр уулаас зүйл хуваасан бүтэцтэй уул толийн бүх үгсийг латин үсэгийн дараалалд оруулан, галигаар буулгаж, араб бичилгэ, орос орчуулга дагалдуулсан нь уншиж судалахад нэн дөхөмтэй болжээ.[603] Тавиад оны дундуур японы эрдэмтэн Sh. Iwamura-гийн удирдсан хээрийн шинжилгээний анги Афганистаны нутагаас араб үсэгээр тэмдэглэсэн 40 нүүр гар бичмэл материал олж, Tadashi Yamazaki, Natsuki Osada нарын хамт судалсан байна. Тэд уул гар бичмэлийг галиглан буулгаж, англи хэлээр орчуулсанаас гадна уул текстийн дотороос 360 гаруй монгол үгсийг түүвэрлэн авч, нарийвчилан галиглаад дундад үеийн монгол хэлний бусад бичигийн дурсхалууд болон зарим хэл аялгууны материалтай харьцуулан үзжээ.[604] Жараад оны эхээр академич L. Ligeti Истанбул хотын номын санд хадгалагдаж байсан *'Шамил ул-луга'* хэмээх түрэг-перс гар бичмэл толийг анхлан судалсан байна. Барагцаалвал XV зууны эцэс, XVI зууны эхээр 'Imād al-Qarāhisāri хэмээгчийн зохиосон уул толь бичигийн сүүлчийн 22 хуудасанд хавсаралт маягаар дагалдуулсан араб, перс, түрк, монгол хэлний бэсэрэгхэн толь нь монгол хэлний судалалд нэн чухал материал болж байна. Энэхүү дөрвөн хэлний орсон 400 орчим монгол үгсийг L. Ligeti латинаар галиглаж, араб бичлэг, франц орчуулга, гэрэл зурагийн эхийг дагалдуулсанаас гадна үг тус бүрийг *Мукаддимат ал-Адаб, Ибн-Муханны толь, Лейдений толь, Монголын Нууц Товчоо, Хуа-й й-юу* гэх зэрэг бусад дурсхалууд болон монгол хэлний эртний шинжийг зохих хэмжээгээр хадгалан үлдсэн хэл аялгууны материалтай харьцуулан авч үзсэн байна.[605]

Өнгөрсөн зууны дундуур Йемен улсын Аден хот дахь хувийн цуглуулгаас Расулидын ван Al-Malik al-Afdal al-'Abbas b.'Ali хэмээгчийн зохиосон араб, перс, турк, грек, армен, монгол зургаан хэлний толийг олсон нь дундад үеийн монгол хэлний нэгэн чухал дурсхал болж байна. Түүхэнд *'Хааны толь'* хэмээн алдаршсан уг толийг бүр жараад оны үеэс эхлэн судалсан боловч олон хэлний толийг нэгдхэн судалах нь нэн бэрхшээлтэй байсан тул ихээхэн удааширсаар 2000 онд хэвлэгдэж[606] судалгааны эргэлтэд орсон нь монгол хэлний түүхэн судалалд нэн чухал шинэ

---

602 Yoshio Saito, The Mongolian Words in *Kitab Majmu Turjuman Turki wa-'ajami wa-Mugali:* Text and Index, Shoukadon, Kyoto, 2006, I-XIII + 1-49 + Tables

603 Н. Поппе, Монгольский словарь Мукаддимат ал-Адаб, 3-393

604 Shinobu Iwamura, The Zirni Manuscript. A Persian-Mongolian Glossary and Grammar, 1961, 84-150

605 L. Ligeti, Un vocabulaire mongol d'Istanboul, AOH 14, 1962, 14-76

606 Peter B. Golden, The King's Dictionary. The Rasulid Hexaglot: Fourteenth Century Vocabularies in Arabic, Persian, Turkic, Greek, Armenian and Mongol. Edited with Notes and Commentary by Peter. B. Golden, Brill. Leiden-Boston-Köln, 2000, XIII + 418 + Ms. p. 186-211

материал болж байна. Эцэхүү толийн дотор 900 орчим монгол үг багтсан байгааг эдүгээ тогтоогоод байгаа билээ.

Дээр дурдсан дурсхалуудаас гадна XVII зууны сүүлчээр Османы зохиолч Эвлия Челеби гэгч Умард Кавказ дахь Дагестаны Кайтакчуудын үг хэллэгийг тэмдэглэсэн хураангуй толиндоо их төлөв ан амьтаны нэр голлосон дөч орчим монгол гаралтай үг оруулсаныг P. Pelliot тусхайлан судалж, дөч орчим монгол үгийг араб бичлэг, латин галиг, түрэг хувилбар, франц орчуулга болон дэлгэрэнгүй тайлбарын хамт багтаасан сонирхолтой үгүүлэл нийтлүүлжээ.[607]

2000 оны эхээр японы эрдэмтэн Yo. Saito Лейдений гар бичмэл толийн бүрэн эхийн өнгөт гэрэл зурагийг нийт үгсийн цэс, монгол үгсийн галиг, бодит дуудлага, англи орчуулга, монгол бичигийн тогтсон бичлэгийн хамт нийтлүүлсэн нь араб үсэгийн монгол дурсхалын найдвартай эх сурвалж болж чадсан билээ.[608] Мөн Kanno Hiroomi, Yoshio Saito нар Узбекистанд очиж, Ташкент хотын Alisher Navoi-н нэрэмжит утга зохиолын улсын музейн удирдлагатай зөвшилцсөний дагуу тус музейд хадгалагдаж байсан *'Мукаддимат ал-Адаб'* хэмээх араб-перс-чагаадай-монгол гар бичмэл толийн гар бичмэл эхийг бүрэн эхээр нь хэвлэх зөвшөөрөл авч, нийтлүүлсэн нь[609] араб үсэгийн дурсхалын судалгааг улам нарийвчилан судалах таатай боломжийг олгож байна. Түүнчилэн профессор Y. Saito уг толийн доторхи бүх үгсийн цэсийг (анхны гар бичмэл эх болон хожим Н. Поппегийн нийтлүүлсэн судалгааны бүтээл дэх хуудас, мөрийн тоо), илэрхийлэх утга, авианы болон дуудлагын галиг, англи орчуулгын хамт эрэмбэлэн жагсаасан томоохон бүтээл нийтлүүлсэн нь[610] зөвхөн *'Мукаддимат ал-Адаб'* толийн монгол хадмал орчуулга төдийгүй, араб үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсхалууд болон дундад үеийн монгол хэлний судалалд үнэтэй материал болсон байна.[611] Дундад үеийн монгол хэлийг тэмдэглэсэн араб үсэгийн дурсхалуудын хэлний онцлог шинжийн талаар Y. Saito,[612] Г. Цэцэгдарь[613] нар судалгааны үгүүлэл нийтлүүлжээ.

---

607 P. Pelliot, Le prétendu vocabulaire mongol des kaitak de Daghestan, JA 12:9, 1927, 279-294

608 Y. Saito, The Mongolian Words in *Kitâb Majmû Turjumân Turkî wa-'ajamî wa Muğalî:* Text and Index, Kyoto, 2005, 28-47

609 The Muqaddimat al-Adab: A Facsimile Reproduction of the Quadrilingual Manuscript (Arabic, Persian, Chagatay and Mongol), The Alishir Navoi State Museum of Literature (Academy of Sciences, Republic of Uzbekistan) and The Japan Society for the Promotion of Science. Tokyo, 2008, 1-22 + 001a-534b

610 The Mongolian Words in the *Muqaddimat al-Adab:* Romanized text and Word Index, {The Japan Society for the Promotion of Science Grant-in-Aid for Scientific Research (B) No 17320061, 2005-2007}, Tokyo, 2008, Text 1-546, Index 1-261

611 Y. Saito, The Mongolian Words in the Muqaddimat al-Adab: Romanized Text and Word Index, Tokyo, 2008, Text 1-546 + Index 1-261

612 Yo. Saito, Formation of Secondary Long Vowels and Arabic Transcription of Muqaddimat al-Adab, Scripts and Sound in Middle Mongolian, Kyoto, 2003, 211-224

613 Цэцэгдарь, Ибн-Муханны толийн хувилбарууд, *Bulletin International Associa-tion forMongol Studies,* (2000), 75-80; (2001), 58-61, (2002), 97-118; Араб үсэгийн монгол дурсхалын судалгаа {= *Monuments in Mongolian Language* III}, Уб., 2002, 172 т.

Өнгөрсөн зуу гаруй жилийн хугацаанд өөр өөр арга зүй, өөр өөр үсэгээр буулгасан араб үсэгийн монгол дурсхалуудыг цаашид нэгдэлтэй тогтоосон тодорхой хөтөлбөр, арга зүйгээр илүү нарийвчилан судалах шаардлагатай байгаа билээ.

1. ЭГШИГ АВИА

§ 74. **Эгшиг авианы тогтолцоог судалсан нь.** Монгол хэл аялгууны авианы онцлог шинжийг ажиглан судалсан олон эрдэмтэд XIX зууны тэргүүн хагасаас эхлэн эгшиг авианы бүтэц бүрэлдэхүүн, тохиолдох байрын талаар удаа дараалан тэмдэглэсээр иржээ. Харин эгшиг авианы тогтолцоог түүхэн үүднээс авч үзсэн судалгаа харьцангуй нилээд хожуу эхэлжээ. Нэрт монголч G. J. Ramstedt, Б. Я. Владимирцов, Г. Санжеев, N. Poppe, M. Nomura нар монгол хэлний хөгжилийн нэн эртний шатанд ***a**, **e**, **ï**, **i**, **o**, **u**, **ö**, **ü*** гэсэн найман богино эгшиг фонемтой байсаныг нягтлан тогтоожээ.[614]

Монгол бичигийн дурсхалуудын хэлний талаар О. Ковалевский, G. J. Ramstedt, Б. Я. Владимирцов, Г. Д. Санжеев, N. Poppe, M. Lewicki, J. Street, L. Ligeti, M. Weiers нарын хийсэн судалгаа нь эртний ба дундад үеийн монгол хэлний эгшигийн тогтолцоог тогтоох гол баримжаа болж байна.[615] Монгол хэлний түүхэн хөгжилийн явцад эгшигийн бүтэц бүрэлдэхүүн, тохиолдох байрлал, хувьсал өөрчлөлтийн талаар M. Nomura, N. Poppe, K. Thomsen зэрэг эрдэмтэдийн сонирхолтой бүтээлүүд гарчээ.[616] Түүнчилэн орчин үеийн олон монгол хэл аялгуунуудын эгшиг авианы тогтолцооны талаар олон тооны үгүүлэл нийтлэгдсэн байна.[617] Мөн Ш.

---

614 G. J. Ramstedt, Zur mongolisch-turkischen Lautgeschichte, KSz 15, 1914, 118; Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 118-119; Г. Д. Санжеев, Заметки по тюрко-монгольскому вокализму, *'Studies in General and Oriental Linguistics'*, Tokyo, 1970, 508; N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 24; Vergleichende Grammatik der altaischen Sprache. Teil I. Vergleichende Lautlehre {= PLO. N.S. 4}, Wiesbaden, 1960, 92; M. Nomura, Vowel Phoneme System of Common Mongolian, MFL NU. 58 (1973), 27-33

615 О. М. Ковалевский, Краткая грамматика монгольского книжного языка, Казань, 1835, 3-197; Г. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, 37-54; Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 143-170; Г. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, 72-76; Н. Поппе, Монгольский словарь Мукаддимат ал-Адаб, ч. I. 29-31; N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 24-58; N. Poppe, The Mongolian Monuments in hP'ags-pa Script, Second Edition. Translated and edited by John R. Krueger {= GAF. 8} Wiesbaden, 1957, 29-31; Vergleichende Grammatik der altaischen Sprache. Teil I. Vergleichende Lautlehre, 91-147;M. Lewicki, M., La langue mongole des transcriptions chinoises du XIVe siècle, Le *Houa-yi yi-yu* de 1389 {= *Travaux de la Sociéte et des Lettres de Wroclaw*, Sér. A, Nr. 29}, Wroclaw, 1949, 89-107; John. Ch.Street, The Language of the *Secret History of the Mongols* {= *American Oriental Series* 42}, New Haven, 1957, 6-9; L. Ligeti, Notes sur le vocabulaire mongol d'Istanboul, AOH 16 (1963), 121-136; M. Weiers, Untersuchungen zu einer historischen Grammatik des präklassischen Schriftmongolisch {= AF. 28}, 1969, 56-62

616 M. Nomura, Vowel Phoneme System of Common Mongolian, MFL NU 58 (1973), 27-33; N.Poppe, Remarks on the Vocalism of the Second Syllable in Mongolian, HJAS 14:1-2 (1951), 189-208 (япон хэлээр); K. Thomsen, Bemerkungen über das mongolische Vokalsystem der zweiten Silbe, AO 24 (1959), 1-4

617 Sh. Hattori, Phonemic Structure of Mongol (Chakhar Dialect), JLSJ 19-20 (1951), 68-102; M. Nomura, On Some Phonological Developments in the Kharachin Dialect, *Studia*

Лувсанвандан монгол бичигийн үсэг зүйн тогтолцоонд тулгуурлан эртний монгол хэлний фонемийн бүрэлдэхүүн ба байрлалыг сэргээн тогтоосон билээ.[618]

1.1 БОГИНО ЭГШИГИЙН ТОГТОЛЦОО

1.1.1 **ҮГИЙН ТЭРГҮҮН ҮЕИЙН БОГИНО ЭГШИГ**

§ 75. **Тэргүүн үеийн богино эгшигийн тогтолцоо**. Монгол хэлний эгшиг авианы хувьсан хөгжих ерөнхий зүй тогтол хийгээд алтайн язгуурын төрөл хэлнүүдийн эгшигийн тогтолцоонд тулгуурлан өвөг монгол хэлний үгийн тэргүүн үеийн богино эгшиг фонемийн тогтолцоог түүхэн үүднээс сэргээн гаргах бүрэн боломжтой юм.

	уруулын бус			уруулын	
	уужим	дунд	уйтан	дунд	уйтан
хүчдэлтэй (эр)	/*a/		/*ï/	/*o/	/*u/
хүчдэлгүй (эм)		/*e/	/*i/	/*ö/	/*ü/

Эртний монгол хэлний сүүлч үеийн онцлогийг тусхасан монгол бичигийн үсэг зүйн тогтолцоонд тулгуурлан тухайн үеийн эгшиг авианы бүрэлдэхүүнийг баримжаалан тогтоож болно. Монгол үсэгийг анх хэл аялгуундаа тохируулан боловсоруулсан тэр цагт өвөг монгол хэлний үед байсан 8 богино эгшиг хэвээрээ хадгалагдаж байсан учир тэдгээрийг монгол бичигийн цагаан толгойн дөрвөн үсэгт хос хосоор нь багтаан тэмдэглэсэн байна.

aleph *a/e*
yod *ï/i*

Altaica{= UAB. 5}, Wiesbaden, 1957, 132-136; В. М. Наделяев, Состав фонем в звуковой системе современного монгольского языка, ВЛГУ. Сер. ист. яз. илит-ры, Вып. I, 8 (1957), 123-131; Don. G. Stuart, M. Haltod, The Phonology of the Word in Modern Standard Mongolian, W.13(1957), 76-78, 82-84, 89-90, 92-93; И. Д. Бураев, Звуковой состав бурятского языка, Улан-Удэ, 1959, 3-194; A. Rona-Tas, Remarks on the Phonology of the Monguor Language, AOH 10, 1960, 263-267; J. E. Bosson, B. Ünensečen, Some Notes on the Dialect of the Khorchin Mongols, *'American Studies in Altaic Linguistics'* {= UAS. 13}, Bloomington, Indiana, 1962, 23-44; Udo Posch, Das Kalmückische und verwandte Dialekte, HdO 5:2, 1964, 205-214; John. C. Street, Urdus Phonology, UAJb 38, 1966, 92-111; П. Ц. Биткеев, Основные закономерности развития калмыцких гласных, *'Языки и фольклор народов Севера'*, Новосибирск, 1981,178-183; Сравнительная типология вокализма в монгольских языках, ОУМЭИХ, IV, II боть, 1984, 198-206; Sh. Luvsanvandan, The Khalkha-Mongolian Phonemic System, AOH 17:2, 1964, 175-185; Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний эгшгийн тогтолцоо, ХЗ 15:4, 1980, 29-32; В. И. Рассадин, Очерки по исторической фонетике бурятского языка, М., 1982, 6-68; В. И. Золхоев, Сильные и слабые позиции гласных фонем в бурятском языке, *'Вопросы бурятской филологии'*, Вып. II, Улан-Удэ, 1973, 44-51; И. В. Рассадин и. др., Историческая связь калмыцкого языка с языком ойратов Монголии, Элиста-Уланбатор, 2010, 7-23

618 Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Авиа, авиалбар хоёр нь, 1-рдэвтэр, Уб., 1967,95-97

waw	*o/u*
waw + yod	*ö/ü*

Монгол хэлний хөгжилийн цаашдын явцад уулаас хүчдэлтэй, хэлний хойгуурхи /*ï/ нь хүчдэлтэй шинжээ аажимаар алдаж, яваандаа хүчдэлгүй /i/-тэйгээ адил байранд хэлэгдэх болжээ. Ийнхүү /*ï/ эгшигийн хэлэгдэх байдалд гарсан хувьсал нь уламаар нийт эгшиг фонемийн бүрэлдэхүүнд өөрчилөлт гаргахад хүргэжээ. Дундад үеийн монгол хэл хийгээд орчин үеийн монгол хэлний эгшигийн тогтолцооны хувид гэвэл, нэг талаас, авианы хувьсан хөгжих зүй тогтол, нөгөө талаас, холбогдох бичигийн дурсхалууд болон хэл аялгууны материалд тулгуурлан тогтоож болно.

Жич: Орчин үеийн олон монгол хэл аялгуунуудын эгшиг фонемийн хувилбарууд нь зэрэгэлдээх авианыхаа нөлөөгөөр урагшилан тагнайших, уруулшин ижилших, суларан балархайших зэрэгээр ихээхэн хувиссаныг монголч эрдэмтэд янз бүрийн тогтолцоотой галиг үсэгээр ялган тэмдэглэсээр иржээ. Бид энд монгол хэлний эгшиг фонемийн нийтлэг тогтолцоог үндэс болгон өөр өөр тогтолцоотой галигуудыг хилбарчилан нэгэн мөр болгосоныг энэ даширамд дурдая.

Монгол хэлний үгийн тэргүүн үеийн богино эгшиг нь бүр өвөг монгол хэлний үеэс өдгөө хүртэл олонхи хэл аялгуунуудад бүрэн тод хэлэгдэх байдалаа тогтвортой хадгалсаар иржээ. Харин Монгор, Баоань хэл болон буриад хэлний зарим аман аялгууны үгийн тэргүүн үеийн (гагцхүү үгийн эхний Д. Т.) богино эгшиг бие даасан фонемийн үүрэгээ алдаж, уламаар бүрмөсөн хэлэгдэхгүй болсон жишээ нилээд тохиолдож байна.

1.1.1.1. ТЭРГҮҮН ҮЕИЙН БОГИНО ЭР ЭГШИГ

1.1.1.1.1 **Уруулын богино эгшиг**

<u>o (< *o)</u>

Үгийн тэргүүн үеийн *o* (< *o) нь хүчдэлтэй, уруулын, хэлний хойгуурхи, дунд, тод хэлэгдэх богино эгшиг. Гагцхүү хүчдэлтэй эгшигийн өмнө тохиолддог энэхүү эгшиг нь өдгөөгийн монгол хэл аялгуунуудад уруулын шинжээ тогтвортой хадгалсаар байна.

PM	*o	Mog.	o
AM	o	Dag.	o [o, oa]
MM	o	Kalm.	o [o, ö]
Mngr.	o	Oir.	o [o, ȯ , ö, u]
Dun.	o	Bur.	o
Bao.	o	TMon.	o [o, ȯ]
SY.	o	ÖMon.	o [o, ö]

(a) **a, ā** (< *a)-гийн өмнө орсон */o/* [o, oa, uo]

PM **olan* 'олон', AM *olan* Precl. (= Ar. 2, Bod, Chang, Ölǰ.); MM *olan* (D,Mu, IM, L.), *olon* (MNT, KMQB, Hy, D, Mu.); CM *olan* (Kalm, NÜd.), *woalaŋ* (Ha.)

PM **foqar* 'охор', AM **xoqar,* MM *hoqar* (D, Mu, L, Ist.), *oqor* (MNT, Hy, Mu.); CM *oqar* (Mar, KT.), *oxɒr* (Her, Kalm.), *uoqar* (Dag.), *huakare* (But.)

PM **doluγan* 'долоон', AM *doluγān* Precl. (Bod, Chan, Hin, Taq.); MM *dolo'ān* (MNT, KMQB, Hy), *dolān* (Mu, IM, L, Ist.); CM *dolān* (Kalm, Oir.)

(b) **i** (< *i), **i** (< ï)-гийн өмнө орсон */o/* [o, ȯ]

PM **qonïn* 'хонь', AM *qoni* Precl. (= Ber, Jum, Turf. 7, Bur.); MM *qonin*(MNT, Hy, Mu, Ist.), *qoni* (Tk, L, IM.); CM *χonin* (Mog, Tunk.), *χoni* (Mngr, Bao, Dag, Bur, Kha, Ord.), *χonĭ* (Kha.)

PM **qoγïna* 'хойно', AM **qoγīna / qoyīna* Precl. (Bod, Qqor, Aruγ, Jig.); MM *qoyīna* (MNT, KMQB, Hy, Mu, D.), *qoina* (L.); *qoina* (Mog.), *χoino* (Min, Bur, Kha, Cha, Učab.), *koina* (Leech.), *χȫ ĭno* (Alar.), *χȫ nö* (Kalm.), *χoaina* (Dag.)

Дэд үедээ тагнайн ***i*** эгшиг бүхий үгийн тэргүүн үеийн ***o*** эгшиг өдгөөгийн Халимаг, Ойрд хэлнүүд болон Төв ба Өмнөд монгол хэлний зонхилох аялгуунуудад уул тагнайн эгшигийн нөлөөгөөр урагшилан [ȯ , ö] болсон байна. Мөн Дагуур хэл болон Өмнөд монгол хэлний Харчин аялгуунд ***a***-гийн өмнө орсон тэргүүн үеийн ***o*** нь арынхаа эгшигт татагдан [oa, ua, woa] гэсэн хосорхог эгшиг болжээ.[619]

u (< *u)

Үгийн тэргүүн үеийн ***u*** (< *u) нь хүчдэлтэй, уруулын, хэлний хойгуурхи, уйтан, тод хэлэгддэг богино эгшиг. Хэлний хойгуурхи эгшигийн өмнө тохиолддог энэхүү эгшиг орчин үеийн монгол хэл аялгуунуудад уруулын шинжээ хадгалсаар байна.

PM	u	Mog.	u
AM	u	Dag.	u [u, ua]
MM	u	Kalm.	u
Mngr.	u	Oir.	u
Dun.	u	Bur.	u
Bao.	u	TMon.	u
SY.	u	ÖMon.	u

619 Н. Н. Поппе, Дагурское наречие {= ММК 6}, 1930, 110-111; M. Nomura, Remarks on the Diphthong /wa/ in the Kharachin Dialect of the Mongol Language, JLSJ16, 1950, 126-142; Supplementary Notes and Additions to Remarks on the Diphthong /wa/ in the Kharachin Dialect of the Mongol Language, JLSJ 17-18, 1951, 149-156

(a) **a, ā**-гийн өмнө орсон ***u*** [u, ua, oa]

PM **dumda* ‘дунд’, AM *dumda* Precl. (Bod, Jum, Teh.); MM *dumda* (MNT, Hy, D, Mu, IM, L.); CM *dunda* (Mngr, Min, Dun, SY, Mog, Kalm, Oir, Bur, Kha, Ord.), *dund* (Dör, Zakh, Kho, Akor, Gor, Barin, Jal, Khar, Khor, Cha, Tum, Učab.), *duanda* (Dag.), *duande* (But.), *duand* (Kul.), *doand* (Ha.), *dwanda* (Khar.)

PM **duγar* ‘дугаар’, AM *duγār* Precl. (= Chang, Hin, Jig, Taq.); MM *duwār* (KMQB.), *du’ār* (MNT)

(b) **i**(< *i), **ï** (< *ï)-гийн өмнө орсон ***u***

PM **gulïr* ‘гурил’, AM **γulir*, MM *γulir* (Mu, L.), *qulir* (IM, Ist.); CM *ğulir*(Ord.), *ğuril* (Mngr, Mar, Kalm, Bur, Kha, AKhor, Barin, Cha, Jal, Jar, Khar, Khor, Naim, Onn, Tüm.), *ğurir* (Mngr.), *ğujir* (Dör, Khor.)

PM **ugïla-* ‘уйл-’, AM *ugīla-* (Bur.), *uγīla-* (Taq.); MM *uyīla-* (MNT), *uila-* (Mu, IM, L, Ist.); CM *uila-* (Mog.), *ujila-* (Man, Mar.), *uwīla-* (KT.), *ūle-*(Akhor, Barin, Gor, Jal, Naim, Onn, Khar, Khor, Kesh, Tüm.), *woail-* (Ha.), *waila-* (Kul.), *uaila-* (But.), ūil- (Üz.)

Дэд үедээ тагнайн ***i*** (< *i), ***ï*** (< *ï) эгшиг бүхий үгийн тэргүүн үеийн ***o*** эгшиг нь өдгөөгийн Төв ба Өмнөд монгол хэлний олонхи аялгуунуудад урагшилж ***u, ü*** болжээ. Мөн Дагуур хэл болон Өмнөд монгол хэлний Харчин аялгуунд ***a***-гийн өмнө орсон тэргүүн үеийн ***u*** нь арынхаа эгшигт татагдан [ua, oa] гэсэн хосорхог эгшиг болсон байна.

(c) **u, ū**-гийн өмнө орсон ***u***

PM **usun* ‘ус’, AM *usun* Precl. (= Bod, Chang, Qqor.); MM *usun* (MNT, KMQB, Hy, Tk, D, Mu, IM, L, Ist.), *usu* (MNT, D.); CM *fudzu* (Mngr.), *husun* (SY), *usun* (Mog, Zir, Leech, Mar, Man, Oir.), *uhuŋ* (NÜd.), *usu*(Min, Bao, Dun, Her, Kalm, Ord.), *uhu* (Bar, Barg.)

PM **uγu- ‘yy-’*, AM *uγū-* Precl. (= Bur, Sul.); MM *uwū- / u’ū-* (MNT)

1.1.1.1.2 Уруулын бус богино эгшиг

а (< *a)

43. Үгийн тэргүүн үеийн ***а*** (< *a) нь хүчдэлтэй, уруулын бус, хэлний хойгуурхи, уужим, тод хэлэгдэх богино эгшиг. Орчин үеийн монгол хэл аялгуунуудад дээрхи онцлог шинжээ тогтвортой хадгалсаар иржээ.

PM.	*a	Mog.	a
AM.	a	Dag.	a [a, ȧ]
MM.	a	Kalm.	a [a, ä]
Mngr.	a	Oir.	a [a, ȧ]
Dun.	a	Bur.	a [a, ȧ]
Bao.	a	TMon.	a [a, ȧ]
SY	a	ÖMon.	a [a, ȧ , ä]

(a) **а, ā** (< *a)-гийн өмнө орсон /***а***/

PM. **aman* ‘ам’, AM. *aman* Precl. (= Chang, Hin, Taq, Bur.); MM. *aman* (MNT, Hy, Mu, L, Ist.), *ama* (MNT, Tk, Mu.); CM. *aman* (SY, Mog, Zir, Kun, Bao, Dör, Tor, Zakh, Tunk.), *amaŋ* (Dun, Bao, Kalm, Alar, Khori.), *ama* (Mngr, Dag, Kalm, Ord.), *amɒ* (Kha, Oir.)

PM. **qaγan* ‘хаан’, AM. *qaγān* Precl. (= Ar.I, Bod, Mön, Ölǰ.); MM. *qahān* (MNT, KMQB, Hy.), *qa’ān* (MNT, Tk, D, Ist.)

(b) **u, ū** (< *u)-гийн өмнө орсон /***а***/

PM. **nasun ‘нас’*, Precl. (= Chang, Hin, Jig, Sul.); MM. *nasun* (MNT, D, Mu, IM, L.); CM. *nasun* (Min, Dun, Ord.), *nasu* (Dag, Ord.)

PM **dayun* ‘дуу’, AM *dayūn* Precl. (= Bod, Chang, Maha, Taq.); MM *dawūn* (MNT, Hy.), *dawū* (KMQB.), *da’ūn* (MNT, Mu.), *da’ū* (TM.); CM. *daūn* (Zir, KT.), *daun* (Mog.), *dau* (Ha, But.)

(c) **i** (< *ï), **ī** (< *i)-гийн өмнө орсон /**а**/ [ä, a, ä]

PM **alïn* ‘аль’, AM *ali* Precl. (= Bod, Chang, Qqor, Ölǰ.); MM *ali* (MNT, KMQB, D, Mu, IM, Ist.); CM *alin* (Bokh.), *ali* (Mngr, Dun, But, Bur, Cha, Ord, Učab.), *ani* (Dun, Kul.), *alǐ* (Ha, Kha, Dg.), *alɒ* (Alar.), *alki* (Dör.), *älkin* (Ö, Tor, Ur, Zakh.), äl (Dör, Ba, Oir, ÖMon.)

PM **ayïl* ‘айл’, AM **ayīl* > *ayīl* Precl. (= Turf. 1); MM *ayīl* (MNT, Mu.), CM. *ajil* (Mngr.), *aile* (Dag.), *ail* (Kul, Bur.), *ail* (Ha, Kha, Dg, Cha, Učab.)

Дэд үедээ тагнайн ***i, ī*** эгшиг бүхий үгийн тэргүүн үеийн ***a***нь өдгөөгийн Дагуур, Халимаг, Ойрд, Төв монгол хэл болон Өмнөд монгол хэлний олонхи аялгуунуудад тагнайн эгшигийнхээ нөлөөгөөр урагшилан [a, ä] болсон байна.

i (< *ï)

Үгийн тэргүүн үеийн ***i*** (< *ï) нь хүчдэлтэй, уруулын бус, хэлний хойгуурхи, уйтан, тод хэлэгдэх богино эгшиг.

PM	*ï	Mog.	i
AM	i	Dag.	i
MM	i	Kalm.	i
Mngr.	i	Oir.	i
Dun.	i	Bur.	i [i, ė]
Bao.	i	TMon.	i [i, ė]
SY.	i	ÖMon.	i [i, ė]

(a) a, ā (< *a)-гийн өмнө орсон i (< *ï)

PM **mïŋγan* ‘минган’ AM *miŋγan* Precl. (= Bod, Jig, Hin, Sul, Taq.); MM *miŋγan* (MNT, KMQB, Hy.), *miŋqan* (D, Mu, L, Ist.); CM *miŋğan* (Mngr, Bur, Kha, Cha, Ord, Učab.), *miŋğɒn* (Kalm.), *miŋxän* (Mngr.), *miŋğa* (Kham.), *miŋğɒ* (Zakh.), *meŋğan* (Dör, Kho, Ur.), *meŋğa* (Üz.), *miaŋğan* (Bur, Kha.), *miangen* (But.), *maŋğɒn* (Ha.), *mäŋğan* (Akhor, Barin, Gor, Jal, Khar, Khor, Tüm.)

PM **nïγa-*‘наа-’, AM *niγā-* Precl. (= Sub.); MM *ni'ā-* (MNT, Mu.); CM. *niā-* (Mngr, Dun, Ha, Bur.)

Дэд үедээ ***a*** эгшиг бүхий үгийн тэргүүн үед орсон ***i*** нь өдгөөгийн Дагуур, Халимаг, Ойрд, Буриад, Төв болон Өмнөд монгол хэлний зонхилох аялгуунд арынхаа хүчдэлтэй, уужим эгшигийн нөлөөгөөр хойшилон /***a***/ [a, ȧ , ä] болсон байна.

(b) i (< *ï), i (< *i)-гийн өмнө орсон i (< *ï)

PM **čïqïn* {< **tïqïn*} ‘чих’, AM *čikin* Precl. (= Turf. 3, Bur, Sub.); MM *čikin* (MNT, Hy, Tk, IM, L, Ist.); CM *tšiqin* (Her.), *tšikin* (Mog, Oir.), *tšiki* (Ha, But, Chi, Kul.), *tšixĭ* (Alar, Kha.), tšiken (Dun.), *šiken* (NÜd, Tünk.), *šixen* (Khori.), *tšixə* (Bur, Kha, Akhor, Khar.), *džixe* (Ord.), *tšiqen* (Zir, Mar.), *tšiqə* (Man.), *tšikən* (SY, Kalm.) .

PM **tïγïraγ* ‘чийрэг’, AM *čigīraγ* Precl. (= Bur.); MM *či'īraq* (KMQB.); CM *tšīrak* (Ord.), *tšīreg* (Kha.)

(c) **u, ū** (< *u)-гийн өмнө орсон **i** (< *ï)

PM **tïsun* ‘цус’, AM *čisun* Precl. (= Maha, Bur, Sub.); MM *čisun* (MNT, Hy, Mu, IM, L.); CM *tšisu* (Her.), *tšiusun* (Bao.), *tšiedzu* (Mngr.)

PM **nïγur* ‘нуур’, AM *niγūr* Precl. (= Maha, Bur, Sub.); MM *ni’ūr* (MNT, Hy, Tk, Mu, IM.), *niyūr* (IM, Ist.); CM *niūr* (Mngr.), njur (SY, Bao.), *njūr* (Barga, Kach.), *niu* (Dun.)

Өвөг монгол хэлний үед хүчдэлтэй, хэлний хойгуур хэлэгдэж байсан /*ï/ эгшиг хэлний хөгжилийн цаашдын явцад хэлний хойгуур хэлэгдэх шинжээ тогтвортой хадгалсаар байсан боловч хүчдэлтэй шинжээ аажимаар алдаж, барагцаалвал, эртний монгол хэлний сүүлчээр үг, морфемийн утга ялгах үүрэгээ бүрмөсөн алджээ. Өөрөөр хэлбэл, урид хүчдэлийн шинж, хэлний байдалаараа эсэрэгцэлдэн утга ялгаж байсан /*ï/, /*i/ фонемууд нь зөвхөн хэлний байдалаараа эсэрэгцэлдэн, нэг фонемийн хоёр хувилбар болсон байна.



Монгол хэлний ***i*** эгшигийн энэхүү хувьсал нь хэдийгээр эгшиг фонемийн бүрэлдэхүүнд зохих өөрчилөлт гаргахад хүргэсэн боловч хүчдэлийнхээ ялгаагаар эсэрэгцэлдсэн эгшиг авианы ерөнхий тогтолцоонд ямар ч өөрчилөлт гаргасангүй. Өөрөөр хэлбэл, эр, эм эгшигийн дундын байдалтай *‘саармаг эгшиг’* үүссэнгүй, харин эр үгэнд ордог хэлний хойгуурхи [ï], эм үгэнд ордог хэлний урдуурхи [i] гэсэн хоёр хувилбар буй болжээ. Монгол хэл зүйчид ***/i/*** фонемийн энэхүү хоёрдмол шинжийг гирхай ажиглан *‘эр эрс’, ‘эм эрс’* хэмээн оновчтой нэрлэжээ.

Эртний монгол хэлний үед хүчдэлтэй шинжээрээ утга ялгаж, хожим нь хэлний хойгуурхи шинжээрээ гагцхүү эр үгэнд орох болсон ***ï*** эгшигийг сонгодог бичигийн өмнөх монгол бичигийн дурсхалд зохих хэмжээгээр тусхажээ.

Монгол бичиг	Сонгодог бичигийн өмнөх бичигийн дурсхал
kiǰaγār	qïǰaγār (Jig, Hin.)
kida-	qïdu- (Sub.)
kilbar	qïlbar (Bod, Sub.)
kilinče	qïlinč (Bod.)
ǰokiyā-	ǰoqïyā- (Bod.)
saki-	saqï- (Hin.)

Дундад үеийн монгол хэлний зарим аялгуунд уул эгшиг нь хэлний хойгуурхи шинжээ тогтвортой хадгалж байсан учир түүний өмнө орсон гийгүүлэгч тагнайшаагүй байсан нь араб-перс үсэгээр тэмдэглэсэн зарим бичигийн дурсхалуудад уламжилан үлджээ.

Монгол бичиг	Араб-перс үсэгийн дурсхал
kiǰaγār	qïǰār (Mu.)
kilbar	qïlbar (Mu.)
kilγasun	qïlγasun (Mu.)
kimusun	qïmusun (Mu, IM, L.)
kina-	qïna- (Mu.)
kirγa-	qïrγa- (Mu.)
kituγa	qïtuγa (Mu.)

Ер монгол хэлний */i/* фонемийн [ï] хувилбар нь зөвхөн бичигийн дурсхалууд төдийгүй, өдгөөгийн зарим хэл аялгуу, тухайлвал, Могол, Дунсян хэлнүүд болон бусад зарим аман аялгуунуудад хадгалагдсаар байгааг эрдэмтэд ажиглан тэмдэглэсээр иржээ.

1.1.1.2 ТЭРГҮҮН ҮЕИЙН БОГИНО ЭМ ЭГШИГ

1.1.1.2.1 **Уруулын богино эм эгшиг**

ö (< *ö)

50. Үгийн тэргүүн үеийн ***ö*** (< *ö) нь хүчдэлгүй, уруулын, хэлний урдуурхи, дунд, тод хэлэгддэг богино эгшиг. Хэлний урдуурхи эгшигийн өмнө тохиолддог энэхүү эгшиг нь орчин үеийн олонхи монгол хэл аялгуунд уруулын шинжээ хадгалсаар иржээ.

PM	*ö	Mog.	ö
AM	ö	Dag.	
MM	ö	Kalm.	ö
Mngr.		Oir.	ö
Dun.		Bur.	ö [ȯ , u]
Bao.		TMon.	ö
SY.		ÖMon.	ö [ȯ , u]

(a) **e, ē** (< *e)-гийн өмнө орсон */ö/*

PM **köke* ‘хөх’, AM *köke* Precl. (= Bod, Maha, Bur, Sub.); MM *köke* (MNT, Tk, Mu, IM.), *kökö* (Hy, Tk.); CM *kökə* (Zir, Kalm.), *χöχe* (Alar, Ord.), *küke* (Ha.), *χüχe* (Bur.), *kuke* (Dun, But.)

PM **bögerek* ‘бөөр’, AM *bögēre* Precl. (= Bur.); MM *bö'ēre* (MNT, Hy, IM.), *bō̈rek* (Ist.), *bō̈re* (L.); CM *böara* (Mog.), *bō̈er* (Dör.), *bō̈rek* (Tor.), *bō̈re* (Dag, Kalm, Bur.)

(b) **ü-гийн өмнө орсон /ö/**

PM **kökü* ‘хөх’, AM *kökü* Precl. (= Bur.); MM *kökö* (MNT, Mu.), *köke* (Mu, IM, Ist.); CM *kökün* (Dör.), *kökŋ* (Tünk.)

PM **födün* ‘өд’, AM **χödün* > *(h)ödün* Precl. (= Sub.); MM *hödün* (Mu.), *ödün* (MNT, Hy, Tk, IM, L, Ist.); CM *ödün* (Dör.)

ü (< *ü)

51. Үгийн тэргүүн үеийн ***ü*** (< *ü) нь хүчдэлгүй, уруулын бус, хэлний урдуурхи, уйтан, тод хэлэгддэг богино эгшиг. Хэлний урдуурхи эгшигийн өмнө тохиолддог энэхүү эгшиг нь орчин үеийн олонхи монгол хэл аялгуунд уруулын шинжээ хадгалсаар иржээ.

PM	*ü	Mog.	u
AM	ü	Dag.	ü
MM	ü	Kalm.	ü
Mngr.		Oir.	
Dun.		Bur.	
Bao.		ÖMo	ü
SY.	u		

(a) **e, ē (< *e)-гийн өмнө орсон /*ü*/**

PM **füker* ‘үхэр’, AM **χüker* > *(h)üker* Precl. (= Ar. 2, Maha, Jig, Bur, Su.); MM *hüker* (MNT, Hy, D, L, Ist.); CM *üxer* (Barg, Ekh-Bul, Tson, Kha, Dg, Akhor, Barin, Gor, Jal, Cha, Khor, Ord, Učab.), *ükər* (Mog, Kalm, Oir.), *ukar* (Man, Marm Leech, Zir, Her.)

PM **düger* ‘дүгээр’, AM *dügēr* Precl. (=Bod, Jig, Hin.); MM *dü'ēr* (KMQB.); CM *dēr* [< *de'ēr* < *dö'ēr* < *dü'ēr*] (Dag.)

(b) **i, ī (< *i)-гийн өмнө орсон /*ü*/ [u, ü, jü]**

PM **düri* ‘дүр’, AM *düri* Precl. (= Hin, Taq, Bur, Sub.); MM *düri* (MNT, KMQB, Ph.); CM *düri* (Klm, Bur, Ord.)

PM **ügíle* ‘үйл’, AM **ügīle* > *üyīle* (MNT, Mu.), *üile* (Mu, IM, L, Ist.); CM *üile* (Bur.), *üilə* (TMon, Cha, Ord, Učab.)

(c) **ü, ṻ** (< *ü)-гийн өмнө орсон /***ü***/

PM **füsün* 'үс', AM **χüsün* > *(h)üsün* Precl. (= Alt, Taq, Bur, Sub.); MM *hüsün* (MNT, Hy, IM, L, Ist.), *üsün* (Mu.); CM *χüsü* (Dag.), *üsün* (Oir.), *usun* (Mog, Kun, Man), *uhun* (Khori, NÜd, Tünk.), *usu* (Zir, Dag, Ord.), *usu* (Mngr.)

PM **dügüreŋ* 'дүүрэн', AM *dügūreŋ* Precl. (= Taq, Sul.); MM *dü'ūreŋ* (MNT, Hy, Ist.), *dūren* (Mu.)

1.1.1.2.2 Уруулын бус богино эм эгшиг

e (< *e)

Үгийн тэргүүн үеийн ***e*** (< *e) нь хүчдэлгүй, уруулын бус, хэлний урдуурхи, дунд, тод хэлэгдэх богино эгшиг. Хэлний урдуурхи эгшигийн өмнө тохиолддог энэхүү эгшиг нь орчин үеийн монгол хэл аялгуунуудад дээрхи онцлог шинжээ тогтвортой хадгалсаар иржээ.

PM	*e	Mog.	e [ė, ėi]
AM	e	Dag.	e
MM	e	Kalm.	e
Mngr.	e [e, ė]	Oir.	e
Dun.	e [e, ė]	Bur.	e[e,ė]
Bao.	e	TMon.	e [e, ė]
SY.	e	ÖMon.	e [e, ė]

(a) **e, ē** (< *e)-гийн өмнө орсон /***e***/

PM **ene* 'энэ', AM *ene* Precl. (= Bod, Chang, Hin, Jig, Mön.); MM *ene* (MNT, KMQB, Mu, IM, L.); *ene* (D, IM.); CM *ene* (Dun, Bao, SY, But, Kul, Ha, Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.), *enə* (Mog, Man, Mar, Her, Kalm, Alar, Khori, Kha.)

PM **degere* 'дээр', AM *degēre* Precl. (= Bod, Chang, Sul, Bur, Sub.); MM *de'ēre* (MNT, KMQB, Hy.), *dēre* (Mu, IM, L.); CM *dēre* (Bur, Ord.), *dērə* (Kalm, Oir, Kha.)

(b) **i, ī** (< *i)-гийн өмнө орсон /***e***/

PM **beri* 'бэр', AM *beri* Precl. (= Jig, СТВ.); MM *beri* (MNT, Hy, Mu, L.); CM *beri* (Mngr, SY, Dag, Bur.), *beiri* (Mog, Zir, Her.), *bieri* (Mngr, Dun.)

PM **egimü* 'ийм', AM **egīmü / eyīmü* Precl. (= Jig, Taq, Bur.); MM *eyīmü* (MNT, Ph.), *eyīmün* (KMQB.); CM *eimər* (Ha.), *eimēre* (But.)

(c) **ü, ǖ** (< *ü)-гийн өмнө орсон */e/*

PM **kedün* ‘хэдэн’, AM *kedün* Precl. (= Ar, Bur, Taq, Sub.); MM *kedün* (MNT, Hy, KMQB, Tk, IM, L.); CM *ketun* (Min.), kedü (Ord.), *xedün* (Akhor, Gor.), *giedun* (Dun.), keden (SY, Ha.), *xeden* (Bur, TMon.)

PM **egülen* ‘үүл’, AM *egǖlen* Precl. (= Bur, Sub.); MM *e'ǖlen* (MNT, Hy, Mu, L.), *e'ǖle* (Tk.), *ǖlen* (Mu, Ist.); CM *ewǖlen* (Kul.), *eülen* (Ha, But, Kul.), *euleŋ* (Chi.), *oulen* (Kul.), *ǖlən* (Kalm, Oir.), *ǖlün* (Oir.), *ǖlə* (TMon.)

49. Үгийн тэргүүн үеийн ***i*** (< *i) нь хүчдэлгүй, уруулын бус, хэлний урдуурхи, уйтан, тод хэлэгддэг богино эгшиг. Хэлний урдуурхи эгшигийн өмнө тохиолддог энэхүү эгшиг нь орчин үеийн монгол хэл аялгуунуудад дээрхи онцлог шинжээ хадгалсаар иржээ.

PM	*i	Mog.	i
AM	i	Dag.	i
MM	i	Kalm.	i
Mngr.	i	Oir.	i
Dun.	i	Bur.	i
Bao.	i	TMon.	i
SY.	i	ÖMon.	i

(a) **e, ē** (< *e)-гийн өмнө орсон ***/i/***

PM **irgen* ‘иргэн’, AM *irgen* Precl. (= Ar, Gü, Hin, Ölǰ, Taq.); MM *irgen* (MNT, KMQB, Hy, D, Mu, L.); CM *irgen* (Kul, Kalm, Kha, Dg, ÖMon.), *irgin* (Dör.)

PM **ǰige* ‘зээ’, AM *ǰigē* (Mo.); MM *ǰe'e* [<*ǰi'ē* < *ǰiyē*] (MNT, Hy.); CM *džiē* (Mngr.)

(b) **i, ī** (< *i)-гийн өмнө орсон ***/i/***

PM **bitik* ‘бичиг’,AM *bičig* Precl. (= Ar, Bod, Gü, Jig, Hin, Ölǰ.); MM *bičig* (MNT, KMQB, Mu, Ph.); *bitik* (Ha.), *bitih* (Kul.), *bitčik* (Mog, Kul, Ord.), *bitčig* (TMon, ÖMon.), *bišik* (Barg, NÜd, Khori, Tunk, Go, Jal, Khor.)

(c) **ü, ǖ** (< *ü)-гийн өмнө орсон */i/*

PM **nidün* ‘нүд’, AM *nidün* Precl. (= Qqor, Bur, Sub.); MM *nidün* (MNT, Hy, Tk, Mu, IM, L, Ist.), *nidü* (MNT, Mu, IM.); CM *nidün* (Bokh.), *nidü* (Dag, Kham)

PM **ǰigür* ‘жигүүр’, AM *ǰigǖr* Precl. (= Ar, Yur, Sub.); MM *ǰi'ǖr* (MNT), *ǰiwǖr* (Hy, Tk.), *ǰü'ǖr* (Hy.), *ǰǖr* (L.); CM *džiwǖr* (Dör, Zakh.), *džǖr* (Akhor, Barin, Jal, Onn.)

1.1.2 ҮГИЙН ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН БОГИНО ЭГШИГ

§ 76. **Тэргүүн бус үеийн богино эгшигийн тогтолцоо.** Монгол хэлний үгийн тэргүүн бус үеийн богино эгшиг нь өвөг монгол хэлний үеэс аваад дундад үеийн монгол хэлний үеийг хүртэл үг, морфемийн утга ялгах үүрэгээ тогтвортой хадгалсаар иржээ. Харин дундад үеийн монгол хэлний үеэс тэргүүн бус үеийн богино эгшигүүд нь зэрэгэлдээх үеийнхээ хүчтэй эгшигт нөлөөгдөн хувирч эхэлсэн бөгөөд тэр нь цаашдаа зарим хэл аялгуунд биеэ даасан фонемийн шинжээ алдаж, улам огцом хэлэгдэх болсон байна.

Орчин үеийн монгол хэл аялгуунуудын үгийн тэргүүн бус үеийн богино эгшигүүдийн хэлэгдэх байдалыг ажиглавал, хэл аялгуу тус бүрд харилцан адилгүй байна. Тухайлвал, Могол, Монгор, Дунсян, Баоань хэлнүүд болон Өмнөд монгол хэлний Ордосын аман аялгуунд бүрэн тод, Дагуур, Буриад хэлэнд бага зэрэг огцом, Төв ба Өмнөд монгол хэлний олонхи аялгуунуудад нилээд огцом, Халимаг, Ойрд хэлэнд хэт огцом хэлэгдэж байна.

Жич: Монгол хэлний үгийн тэргүүн бус үеийн эгшигийн хувьсалын талаар хойно (1.3) тусхайлан дурдах болно.

1.1.2.1 ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН БОГИНО ЭР ЭГШИГ

1.1.2.1.1 **Уруулын богино эр эгшиг**

o (< *a, *u)

MM	o	Dag.	o [o, ŏ]
Mngr.		Kalm.	o [o, ŏ]
Dun.		Oir.	o [o, ŏ]
Bao.		Bur.	o
SY.		TMon.	o [o, ŏ]
Mog.		ÖMon.	o [o, ŏ]

Дундад үеийн монгол хэлний үед эгшиг авианы ижилшил явагдахаас өмнө үгийн тэргүүн бус үед хэлний хойгуурхи, уруулын ***o*** эгшиг огт тохиолддоггүй, гагцхүү уруулын ***u*** (< *u) ордог байжээ. Акад. Б. Я. Владимирцов монгол бичигийн хэлний үгийн тэргүүн үед ***o*** тохиолддоггүй тухай анх ажиглан тэмдэглэсэн бөгөөд хожим профессор N. Poppe мөн энэ талаар дурдсан билээ.[620]

---

620 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Лгр., 1929, 315-316; N. Poppe, Grammar of Written Mongolian {= PLO N. S. 1}, Wiesbaden, 1954, 9-11

(a) **о**-гийн дараа орсон *о* (< *a)

PM **olan* 'олон', AM *olan* Precl. (= Bod, Chang, Hin, Ölǰ, Sul.); MM *olon* (MNT, KMQB, Hy, D, Mu.); CM *olon* (Dun, SY, Bur, TMon, ÖMon.), *olŏn* (Oir.)

PM **ǰobalaŋ* 'зовлон', AM *ǰobalang* Precl. (= Bod, Chang, Hin, Alt.); MM *ǰobolaŋ* (MNT, KMQB, Hy.); CM *džobolon* (Kul.), *džowoloŋ* (Ord.), zoboloŋ (Bur.), *džowlon* (ÖMon.), *džowŏloŋ* (TMon.)

(b) **о**-гийн дараа орсон ***о*** (< *u)

PM **omuɣ* 'омог', AM *omuɣ* Precl. (= Jig, Hin, Bur.); MM *omoɣ* (MNT, KMQB.); CM *omog* (Dör, Kha, ÖMon.)

u (< *u)

PM	*u	Mog.	u
AM	u	Dag.	u
MM	u	Kalm.	u [ŭ, ə]
Mngr	u	Oir.	u [ŭ, ə]
Dun	u	Bur.	u
Bao.	u	TMon.	u [ŭ, ə]

(a) **а**-гийн дараа орсон ***u***

PM **časun* 'цас', AM *časun* Precl. (= sub. */časutu/*); MM *časun* (MNT, Hy, Mu, IM, L, Ist.); CM *časun* (Min, Dun, Bao, Mog.)

PM **dabqur* 'давхар', AM *dabqur* Precl. (= Qqot, Bur, Sub.); MM *dabqur* (MNT, Hy, Mu.); CM *dapkur* (Kul.), *dabxur* (Ha.), *dawxur* (Ord.)

(b) **о**-гийн дараа орсон ***u***

PM **fodun* 'од', AM **χodun>(h)odun* Precl. (= Bur.); MM *hodun* (MNT, Hy, Tk, Mu, IM.); CM *χodun* (Dun, SY.), *χotu* (Min.), *udu* (Ord.)

PM **mōdun* 'мод', AM *modun* Precl. (= Hin, Bur, Sub.); MM *modun* (MNT, Hy, Tk, Mu, IM, Ist.); CM *modun* (Mog, Man, Mar.), *motun* (Dun.), *modu* (Her.)

(c) **i** (< *ï)-гийн дараа орсон ***u***

PM **tïsun* 'цус', AM *čisun* Precl. (= Maha, Bur, Sub.); MM *čisun* (MNT, L.); CM *tšisu* (Her.), *tšiedzu* (Mngr.)

PM **nïlbusun* 'нулмис', AM *nilbusun* Precl. (Bur.); MM *nilbusun* (MNT, Hy, Mu, IM.); CM *nilbusun* (Mog.), *nilbusut* (Zir, KT.), *nilbuse* (Mngr.), *nilbusu* (Kham.), *nigusun* (Dun.)

(d) **u**-гийн дараа орсон ***u***

PM **usun* 'ус', AM *usun* Precl. (= Chang, Jig, Qqor, Sul.); MM *usun* (MNT, KMQB, Hy, Tk, D, Mu, IM, L, Ist.); CM *fudzu* (Mngr.), *husun* (SY.), *usun* (Mog, Man, Mar, Zir, Leech, Her.); CM *usŭn* (Ba, Dör,Kho.), *uhuŋ* (NÜd.), *usu* (Dun, Her, Min, Bao, Ord.), *uhu* (Bar, Barg.)

PM **buγu* 'буга', AM *buγu* (Mo.); MM *buγu* (MNT, Hy, Mu.); CM *buğu* (Mngr, Ord.), *buğŭ* (Kalm, Oir.)

1.1.2.1.2. **Уруулын бус богино эр эгшиг**

a (< *a)

PM	*a	Mog.	a [a, ă]
AM	a	Dag.	a [a, ă]
MM	a	Kalm.	a [a, ɒ]
Mngr.	a	Oir.	a [a, ă]
Dun.	a	Bur.	a [a, ă]
Bao.	a	TMon.	a [a, ɒ]
SY.	a	ÖMon.	a [a, ă]

(a) **a**-гийн дараа орсон ***a***

PM **falaγan* 'алага', AM **χalaγan* > *(h)alaγan* Precl. (= Bod, Bur.); MM *halaγan* (MNT, KMQB, Hy), *halaγa* (L.), *alaqan* (Mu.); CM *χalağan* (Dag.), *xalaha* (Kul.), *halağan* (SY), *alaqa* (Zir.), *alağaŋ* (NÜd.), *alağa* (Dag, Kalm, Bar, Khori, Kha.), *alxan* (Oir.), *alğa* (ÖMon.), *alağa* (Kha.)

PM **aγta* 'арт', AM *aγta* Precl. (= Hin, Sul, Bur, Sub.); MM *aγta* (MNT, Hy.), *aqta* (KMQB.); CM. *agta* (Tunk, Ord.), *axtɒ* (Ha, Kalm, Barg, Kha.)

(b) **i** (< *ï)-гийн дараа орсон ***a***

PM **ïnak* 'янаг', AM *ïnaγ* (Mo.); MM *inaq* (Mu.); CM *inak* (Dag, Khori.), *inag* (Bur, Akhor, Barin, Khori.)

PM **qïlγasun* 'хилгас', AM **qïlγasun>kilγasun* (Mo.); MM *qilγasun* (Mu.), *kilγasu* (MNT); CM *qilğasun* (Mog.), qelğasun (Mar.), *kilghasun* (Leech.), *kilğasu* (Ord.)

(c) **o**-гийн дараа орсон ***a*** [a, ă]

PM **olan* 'олон', AM *olan* Precl. (= Bod, Chang, Hin, Ölǰ, Sul.); MM *olan* (Mu, IM, L, Ph.); CM *olɒn* (Kalm, Oir.), *olɒŋ* (NÜd.)

PM **oran* 'орон', AM oran Precl. (= Chang.); MM *oran* (D, Mu.); CM *orɒn* (Kalm, Oir.)

(d) **u**-гийн дараа орсон ***a*** [a, ă]

PM **bulaγ* 'булаг', AM *bulaγ* Precl. (= Sub.); MM *bulag* (MNT, KMQB.), *bulaq* (Mu, Ist.); CM *bulak* (Alar, Ord.), *bulag* (Mngr, SY, TMon, ÖMon.)

PM **γurban* 'гурван', AM *γurban* Precl. (Čin, Bd, Hin, Bur, Sul.); MM *γurban* (MNT, KMQB, Hy, Tk, Mu, L.), *qurban* (Mu, IM, L.); CM *ğurban* (SY, Man, Mar, Bur.), *qurban* (Her.), *ğurwan* (Dör, Tor, TMon, ÖMon.)

i (< *ï)

PM	*ï	Mog.	i
AM	i	Dag.	i
MM	i	Kalm.	i [i, ə]
Mngr.	i	Oir.	i
Dun.	i	Bur.	i
Bao.	i	TMon.	i
SY.	i	ÖMon.	i

(a) **a**-гийн дараа орсон *i*

PM **adïrγa* 'азарга', AM *aǰirγa* (Mo.); MM *aǰirγa* (MNT, Hy, Mu, IM, L, St, Hq, Eč.); CM *adirag* (Dag.), *adžirğa* (Min, Dör, Zakh.), *adžirag* (Zakh, Ur.), *adžirag* (Akhor, Barin, Gor, Khar, Naim, Onn.), *adžiarğa* (Oir.)

PM **andïsun* 'анжис', AM *anǰisun* (Mo.); *MM *anǰisun* CM *andžison* (Bao.), *andsiŋ* (Zakh.), *ändisən* (Kalm.), *ändžis* (Üz.)

(b) **i** (< *ï)-гийн дараа орсон ***i*** [i, ə]

PM **čïqïn* {<*tïqïn*} 'чих', AM *čikin* Precl. (= Bur, Turf. 3, Sub.); MM *čikin* (MNT, Hy, Tk, IM, L, Ist.); CM *tšiqin* (Her.), *tšikin* (Mog, Oir.), *tšiki* (Ha, But, Kul.), *tšixĭ* (Alar, Kha.) // *tšiken* (Dun.), *šiken* (NÜd, Tünk.), *šixen* (Khori.), *tšixə* (Bur, Kha Akhor, Khar.), *džixe* (Ord.), *tšiqən* (Zir, Mar.), *tšikən* (SY, Kalm.)

(c) **u**-гийн дараа орсон ***i***

PM **yulïr* 'гурил', AM *yulir* (Mo.); MM *yulir* (Mu, L.), *qulir* (IM, Ist.); CM *ğulir* (Ord.), ğuril (Mngr, Mar, Bur, TMon, ÖMon.), *ğurir* (Mngr.), *ğujir* (Dör, Khor.)

PM **qurïm* 'хурим', AM *qurim* Prel. (= Bu.); MM *qurim* (MNT, Hy, Mu.); CM *xurim* (Bur, TMon.), *xürəm* (Kalm.), *xorim* (ÖMon.)

1.1.2.2 ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН БОГИНО ЭМ ЭГШИГ

1.1.2.2.1 **Уруулын богино эм эгшиг**

ö (< *e, *ü)

PM	*e, *ü		Dag.	
AM	e, ü		Kalm.	ö [o, ə]
MM	e, ü, ö		Oir.	ö [ö, ə]
Mngr.			Bur.	ö [ö, ü]
Dun.			TMon.	ö [ö, ə]
Bao.			ÖMon.	ö [ö, ü]

Өвөг монгол хэл болон эртний монгол хэлний үед хэлний урдуурхи, уруулын ***ö*** эгшиг үгийн тэргүүн бус үед огт тохиолддоггүй байсан бөгөөд хожим дундад үеийн монгол хэлний үед эгшигийн ижилшил явагдсанаас хойш уул эгшиг үгийн тэргүүн бус үед хэлэгдэх болжээ. Энэ талаар акад. Б. Я. Владимирцов анх ажиглан дурдсан билээ.[621]

(a) **ö** (< *ö)-гийн дараа орсон ***ö*** (< *e)

PM **köngen* 'хөнгөн', AM *köngen* Precl. (= *köngele-* Chang, Taq.); MM *köŋgen*(Hy.), *köngen* (Mu.), *köngēn* (Ist.); *CM köŋgön* (Ord.), *köngön* (Kalm.), *χöŋgön* (AKhor, Barin, Cha, Khar, Kesh, Ord, Šgol, Tüm.), *χöŋön* (Gor, Jal, Khor.), *köŋgön* (Ba, Dör, Kho.), *χöŋgön* (Kha.)

PM **mören* 'мөрөн', AM *mören* Precl. (= Hin, Sub, Sul.); MM *mören* (Mu, Ist.); CM *mörön* (Kha, AKhor, Barin, Cha, Gor, Jal, Khor, Sgol, Učab.), *mörön* (Ba, Dör, Ö, Tor, Ur, Kho, Zakh.)

(b) **ö** (< *ö)-гийн дараа орсон ***ö***(< *ü)[ö, o, u]

PM **kökü* 'хөх', AM *kökü* (Bur.); MM *kökö* (MNT, Mu.); CM *kökön* (Ur.), *kökö* (Zakh.), *χȯ χȯ* (Khori.), *göxö* (Ord.), *χöχə* (Kha.)

621 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 315-316

PM ***möŋgün*** 'мөнгө', AM möŋgün Precl. (Cf. möŋgü Sub.); MM möŋgün (MNT, KMQB, Hy, Tk, Mu.); CM möngön (Tünk, Cha, Šgol, Učab.), möŋgön (Oir.), möŋgö (Dör, Kha.)

(c) **ö** (< *e)-гийн дараа орсон ***ö*** (< *ü) [ö, ö, u, ə]

PM ***edür*** 'өдөр', AM *edür* Precl. (= Bur.); MM *üdür* (MNT, KMQB, Hy, Tk.), *ödür* (Mu, IM, L, St, Ph.); CM *ödör* (Ekh-Bul, Tünk, Kach, Kha, AKhor, Barin, Gor, Jal, Khar, Khor, Cha, Šgol, Tüm, Učab.), *ödör* (Dör, Zakh, Kha.)

PM *temür* 'төмөр', AM temür Precl. (= Maha, Bur.); MM *temür* (MNT, Hy, Mu, L.); CM *tömör* (Ekh-Bul, Tünk, Kha, AKhor, Barin, Cha, Jal, Gor, Khar, Khor, Šgol, Učab.), *tömör* (Ba, Dör, Kho.), *tömər* (Kalm.)

ü (< *ü)

PM	*ü	Mog.	u [ụ, u]
AM	ü	Dag.	u [ŭ, u]
MM	ü	Kalm.	u [ŭ, u]
Mngr.	u	Oir.	ü [u, u]
Dun.	u	Bur.	ü [u, u]
Bao.	u	TMon.	ü [u, u]
SY.	u	ÖMon.	ü [u, u]

(a) **e**-гийн дараа орсон ***ü*** [ü, u, u, ə]

PM ***ebül*** 'өвөл', AM *ebül* Precl. (= Sul, Bur, Sub.); MM *übül* (MNT, KMQB, Hy, Tk, Ph.), *öbül* (Mu, IM.), *öwül* (L.); CM *ebul* (Mog.), *ewul* (Jar.), *obul* (Tünk.), *ubul* (Mog, Tunk.), *ugul* (Ha.), *uhul* (Kul.), *ubun* (Dun.), *üwül* (Dör, Zakh, Kho.), *üwul* (Oir.), *ugur* (Mngr.)

PM *gedesün 'гэдэс', AM *gedesün* (Mo.); MM *gedesün* (Hy.), *getesün* (Mu.), *gesesün* (L.), *gesüsün* (IM, L.); CM *ketesün* (SY.), *gedisün* (Bao.), kidžesun (Dun.), *gedusu* (Ord.), *getehun* (Khori.)

(b) **i**-гийн дараа орсон ***ü*** [ü, u, u, ə]

PM ***nidün*** 'нүд', AM *nidün* Precl. (= Qqor, Bur, Sub.); MM *nidün* (MNT, Hy, Tk, Mu, IM, L, Ist.), *nidü*(MNT, Mu, IM.); MM *nidün* (Bokh.), *nidu* (Dag, Kham.), *nüdün* (Oir.), *nudun* (Mog, Zir, KT, Mar.), *núdú*(Man, Ord.), *nudun* (Leech, Her.), *nudu* (Mngr.)

PM ***yirsün*** 'есөн', AM *yisün* Precl. (= Bod, Qqot, Bur.); MM *yisün* (MNT, KMQB, Hy, Mu, IM, St, L.); CM *yisun* (Ur, Gor.), *jisu* (Dag, Kham, Ord.), *isun* (KT, SY.), *yesun* (Dag, Bao, Dun.)

(c) ö-гийн дараа орсон ***ü*** [ü, u, u, ə]

PM **mölsün* ‘мөс’, AM *mölsün* Precl. (Taq.); MM *mölsün* (MNT, Hy, Tk, Mu, L, Ist.); CM *mosun* (SY.), *müsün* (Dör.), *mensun* (Dun.), *mosü* (Ord.), *mösön* (Ur, Zakh.), *mösən* (Kalm.), *müsü* (Kham.)

PM **öndür* ‘өндөр’, AM *öndür* Precl. (= Qqor, Bur.); MM *öndür* (Mu.), *ündür* (MNT, Hy, Ph.); CM *öndür* (NÜd, Tünk, Kham.), *ündür* (Dag, Kham, Akhor, Jas, Ord.), *hundure* (But.), *xundur* (Kul.), *undur* (Bao.), *öndür* (Ba, Dör, Kho.), *undur* (Ha.), *undu* (Dun.)

(d) ü-гийн дараа орсон ***ü*** [ü, u, u]

PM **füsün* ‘үс’, AM **xüsün* > *(h)üsün* Precl. (= Taq, Bur, Sub.); MM *hüsün*(MNT, Hy, IM, L, Ist.), *hüsü* (MNT), *üsün* (Mu.); CM *xusu* (Dag.), *usun* (Mog, Kun, Man.), *usuŋ* (Dun.), *uhuŋ*(NÜd, Khori, Tünk.), *usu* (Zir, Dag, Ord.), *usuŋ* (Oir.), *usu* (Ha.), *uhu* (Barg.)

PM **ündüsün* ‘үндэс’, AM *ündüsün* Precl. (= Bur, Sub.); MM *ündüs* (Hy.); CM *undusu* (Dag, Ord.), *ündüsun* (Dör.), *ündüs* (AKhor, Gor.), *unduhu* (Barg.), *undusun* (Kul.), *unduse* (But.)

1.1.2.2.2 **Уруулын бус богино эгшиг**

e (< *e)

PM	*e	Mog.	e [e, ȧ]
AM	e	Dag.	e [e, ə]
MM	e	Kalm.	e [e]
Mngr.	e	Oir.	e [e]
Dun.	e	Bur.	e
Bao.	e	TMon.	e [e, ə]
SY.	e	ÖMon.	e [e, ė]

(a) e-гийн дараа орсон ***e***

PM **egeči* ‘эгэч’, AM *egeči* Precl. (= Bur.); MM *egeči* (MNT, Hy, Tk, Mu, L.); CM *egetši* (SY, But, Ord.), *egeši* (Khori.), *egeše* (Tünk, NÜd.), *egətšĭ* (Ha, Dör, Zakh, Kha.), *egeši* (Bar.)

PM **eden* ‘эд’, AM *ede* Precl. (= Bod, Chang, Taq, Bur, Sub.); MM *ede* (MNT, KMQB, D, L.); CM *ede* (But, Kul, Bur, Ord.), *edən* (Kalm.), *edə* (Ha, Alar, Khori, Kha.), *edə* (Kalm.)

(b) **i**-гийн дараа орсон ***e***

PM **niken* ‘нэг’, AM *nigen* Precl. (= Bod, Chang, Hin, Jig.); MM *niken* (D, Mu, IM, Ist.), *nigen* (MNT, KMQB, Hy, L.); CM *nikan* (Mog.), *nika* (Man, Mar.), *nike* (Mog, Hu.), *nige* (Mngr, Akhor, Gor, Jal.)

PM **sine* ‘шинэ’, AM *sine* Precl. (= Bod, Jig, Qqor, Sub.); MM *sine* (D, Mu.), *sini* (MNT, Hy, Ist.); CM *šine* (Bao, Ord, Tünk, Khori.), *šinə* (Kalm, Oir, TMon, ÖMon.)

(c) **ö**-гийн дараа орсон ***e***

PM **dörben* ‘дөрвөн’, AM *dörben* Precl. (= Bod, Hin, Taq, Ölǰ, Sul.); MM *dörben* (MNT, KMQB, Hy, D, Tk, Mu, IM, L, Ist.); CM *dörben* (SY.), *dörbən* (Alar.), *dörwen* (Akhor, SY.)

PM **möŋke* ‘мөнх’, AM *möŋke* Precl. (= Hin, Mön, Bur, Sub.); MM *möŋke* (MNT, D, L.); CM *möŋkə* (Kalm.), *möŋxe* (Alar.)

(d) **ü**-гийн дараа орсон ***e***

PM **fünegen* ‘үнэг’, AM **xünegen* > *(h)ünegen* Precl. (= Trkm 1); MM *hünegen* (MNT, Hy, Tk, Ph.), *ünegen* (Mu.), *üngen* (L.); CM *funegen* (Dun.), *funige* (Mngr.), *hunehe* (But.), *ünegen* (Zakh, Barg, Alar, Tünk, Gor.), *ünege* (Ord.), *ünegə* (Kha.), *üneg* (Kho, Üz, Akhor, Cha, Naim, Onn, Učab.), *üngən* (Kalm, Tor, Zakh.)

PM **bügüde* ‘бүгэд’, AM *bügüde* Precl. (= Bod, Chan, Aruγ, Sul.); MM *bügüde* (MNT, KMQB, Mu.), *bögde* (L.); CM *bügüde* (Ord, Khori.), *bügüdə* (Kalm, Kha.), *bügede* (But, Bur.), *bügde* (Kalm, Akhor, Gor, Jas.)

i (< *i)

PM	*ï	Mog.	i
AM	i	Dag.	i
MM	i	Kalm.	i [ĭ, ə]
Mngr.	i	Oir.	i [ĭ, ə]
Dun.	i	Bur.	i
Bao.	i	TMon.	i [ĭ, ə]
SY.	i	ÖMon.	i

(a) **e**-гийн дараа орсон ***i***

PM **fekin* ‘эхэн’, AM **xekin>(h)ekin* Precl. (= Гas, Sub.), *eki* (Ölǰ.); MM *hekin* (Mu.), *heikin* (L.), *heki* (MNT, KMQB, Mu.), *eki* (MNT); CM *ekin* (Mog, Her, Zir, Leech.), *ekin* (Man, Mar.), *χeki* (But.), *χegi* (Mngr.), *eki* (Dag, Kul.), *ehi* (But.), *xeki* (Ha, Chi.), *ekin* (Zakh.)

РМ **beri* ‘бэр’, АМ *beri* Precl. (= Jig, СТВ.); ММ beri (MNT, Hy, Mu, L.); СМ *beri* (Mngr, SY, Ha, Kul, But, Dör.), *bieri* (Mngr, Dun.), *beiri* (Mog, Zir, Ner.)

(b) **i**-гийн дараа орсон ***i***

РМ **bitik* ‘бичиг’, АМ *bičig* Precl. (= Ar, Bod, Chang, Gü, Öl.); ММ *bičig* (MNT, KMQB, Mu, D.); СМ *bitih* (Kul.), *bitik* (Ha.), *bitšik* (Mog, Kul, Ord.), *bišik* (Barg, NÜd, Khori, Tünk, Jal, Gor, Khor.), *bitšig* (Sart, Kha, Üz, AKhor, Barin, Cha, Khar, Kesh, Naim, Onn, Ord, Tüm.)

РМ **gički-* ‘гишги-’, АМ *gički-* Precl. (= Bur, Sub.), *gečki-* (Taq.), *geski-* (Sub.); ММ *gički-* (Mu.), *gečki-* (MNT), *gičke-* (IM.); СМ *gišgi-* (Mngr.), *gišxi-* (Kha, Akhor, Barin, Gor, Jal, Khor, Ord, Sgol.), *iški-* (Kalm.)

(c) **ö**-гийн дараа орсон ***i***

РМ **ökin* ‘охин’, АМ *ökin* Precl. (= Chang, Hin, Bur.); ММ *ökin* (MNT, KMQB, Hy, Tk, Mu, L, Ist.), *ögin* (IM.); СМ *ökin* (Tünk.), *okin* (Man, Mar.)

РМ **dötin* ‘дөчин’, АМ *döčin* Precl. (= Jig, СТВ, Ölǰ.); ММ *döčin* (MNT, Hy, KMQB, Mu, IM, L, Ist.); СМ *dötšin* (Dör, Kha.), *döšin* (Bur.)

(d) **ü**-гийн дараа орсон ***i***

РМ **düri* ‘дүр’, АМ *düri* Precl. (= Hin, Taq, Bur, Sub.); ММ *düri* (MNT, Hy, Ph.); СМ *düri* (Ord.), *dürǐ* (Kalm, Barg.), *dürə* (Kha.)

РМ **tülki-* ‘түлхэ-’, АМ *tülki-* Precl. (= Bur.); ММ *tülki-* (Hy.); СМ *tülki-* (Kalm.), *tülkǐ-* (Dag.), *tülxi-* (AKhor, Barin, Jal, Khar, Khor, Urad.), *dülxi-* (Cha, Naim, Onn, Ord, Sgol.), *tülti-* (Bur.), *tülxǐ-* (Kha.)

1.2 ЭГШИГ АВИАНЫ БАЙР

§ 77. **Эгшиг авианы байрыг судалсан нь.** Монгол хэлний бичигийн дурсхалууд болон орчин үеийн монгол хэл аялгуунуудын авианы онцлогийг судалсан эрдэмтэдийн олонхи нь эгшиг авианы байрын талаар анхааран тэмдэглэсээр иржээ.

Монгол хэл зүйчид эх хэлнийхээ эгшиг авианы байрын асуудалд онцгойлон анхаарсаар иржээ. Тухайлвал, XIII-XIV зууны үеэс эхлэн хэл зүйч эрдэмтэн Гунгаажалцан, Чойжи-Одсэр нараас аваад XVIII-XIX зууны үеийн хэл зүйч эрдэмтэн Данзандагва, Билигийндалай, Агваандандар, Сумадирадная, Дэлэг-жунай нар эгшиг авиаг бие биетэйгээ харилцан эсэрэгцэлдсэн *эр, эм* гэсэн хоёр үндэсэн бүлэгт хуваасаар иржээ. Монгол хэл зүйчид эгшиг авиаг эр, эмээр ангилахдаа түүний чухам ямар шинжийг нь гол болгосон тухай эрдэмтэд өөр өөрөөр

тайлбарласан байна. Тухайлвал, G. J. Ramstedt, Б. Я. Владимирцов, N. Poppe нар дурдсан ангилалыг хэлний хойгуур, урдуур хэлэгдэх байдал дээр тулгуурласан хувааръ гэж үзсэн бол А. Бобровников, В. М. Наделяев, И. Д. Бураев нар түүнийг тагнайн шинж дээр түшиглэсэн ангилал гэж үзжээ. Гэтэл профессор Г. Д. Санжеев уул ангилалыг үгийн утга ялгах шинж дээр тулгуурласан фонологийн хувааръ гэж үзсэн байна.[622] Харин академич Ш. Лувсанвандан энэхүү ангилалын гол ялгааг үгүүлэх эрхтэнүүдийн булчин чангарч, суларах хүчдэлийн ялгаан дээр тулгуурласан гэж үзжээ.[623] Үүнтэй холбогдуулан XIX зууны хэл зүйч эрдэмтэн Дэлэгжунай *'Монгол үсэгийн гол ёсыг тододхогч толь'* хэмээх зохиолдоо эр, эм эгшигийн ялгааны талаар хэрхэн дурдсаныг эш татвал: *'Yirtinčü-dür er-e dayun-u ayalyu čingy-a ügülekü kei-yin küčün yeke-lüge adali edeger er-e egesig-ün dayun-u ayalyu čingy-a todu erčimtei tula bolai. Em-e dayun-u ayalyu köndei ügülekü kei-yin küčün sula singgen-lüge adali edeger em-e egesig-ün dayun-u ayalyus singgen köndei ügülekü kei-yin küčün sul tula bolai.'* гэжээ. Энд Дэлэгжунайн дурдсан *'үгүүлэх хийн хүчин'*, академич Лувсанвандангийн дурдсан *'үгүүлэх эрхтэний булчингийн хүчдэл'* гэсэн тодорхойлолтууд нь угтаа утга нэгтэй гэдэг нь ойлгомжтой байна. Монгол хэл зүйчид эгшиг авиаг эр, эм хэмээн ангилсаар ирсэн нь нэгэн цуваанд багтах эгшигийн байрыг тогтоосон ангилал юм.

Энэдхэг-Европ хэл шинжилэлийн аргаар монгол хэлийг судалсан эрдэмтэд ч бас эгшиг авианы байр хийгээд тэдгээрийн авианы орчины талаар онцлон анхаарсаар иржээ. Хамагийн анх нэрт монголч А. А. Бобровников монгол хэлний эгшигийн байрлалын онцлог шинжийг сайтар ажиглан *'... хатуу а, о, и эгшиг нь хөндий е, ӧ, й эгшигтэй нэгэн үгэнд орж болохгүй ... Хэрэв тухайн үгийн доторхи аль нэгэн эгшиг нь мэдэгдэж байвал түүгээр баримжаалан бусад эгшигийн дуудлагыг тогтоож болно'* гэж тэмдэглэсэн байна.[624] Хожим академич Б. Я. Владимирцов уг асуудалын талаар бүр тодоруулан: *'Тухайн нэгэн үгийн доторхи бүх эгшигийн шинж нь тэргүүн үеийнхээ өргөлтөт эгшигийн шинжээс мэдэгдэнэ... Нэгэн үгийн дотор хэлний хойгуурхи эгшиг хэлний урдуурхи эгшигтэй холилдон орохгүй'* гэжээ.[625] Тэрвээр цааш нь үг бүтэх хийгээд үг хувилах явцад залгавар морфемийн бүтэцэн дэх эгшиг нь өмнөх язгуур, үндэсийнхээ доторхи өргөлтөт эгшигтэй зохьцон байрладаг тухай дурдсан байна.[626]

Профессор Г. Д. Санжеев монгол хэлний эгшиг авиа өөр хоорондоо эр, эмээр харилцан зохьцохоос гадна уруулын шинжээрээ бас зохицдог гэж үзжээ.[627] Эгшиг авианы уруулын зохьцол нь монгол хэлний хөгжилийн харьцангуй хожуу үед үүссэн бөгөөд тийм зохьцол нь өдгөөгийн олон монгол хэл аялгуунуудын дотороос Буриад, Халх, Өмнөд монгол хэлний зонхилох аялгуунуудад байдаг тухай

---

622 Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, 83-84

623 Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Авиа, авиалбар хоёр нь, 23

624 А. А. Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, Казань, 1849, 6

625 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 115

626 ibid., 116-117

627 Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, 83

профессор N. Ропре тодорхой дурдсан байдаг билээ.[628] Зөвлөлтийн эрдэмтэн профессор Т. А. Бертагаев монгол хэлний авианы байрын талаар анхааран судалж, тэргүүн үеийн өргөлтөт эгшигийн зохьцуулах үүрэгийн талаар хэд хэдэн үгүүлэл нийтлүүлжээ.[629]

Академич Ш. Лувсанвандан монгол хэлний эгшигийн байрлалд тэргүүн үеийн эгшигийн гүйцэдхэх үүрэгийг тодорхойлохдоо: *'Монгол хэлний үгс нь тэргүүн үедээ заавал гол өргөлттэй байдаг тул тэргүүн үеийн эгшиг нь урт, богино ялгалгүй дэд өргөлттэй болон өргөлтгүй үеийнхээ эгшгүүдээс илүү эрчимтэй байна. Энэ учраас тэр нь гол өргөлттэй үеийн дараа тохиолдох дэд өргөлттэй болон өргөлтгүй үеийнхээ эгшгийг эр, эмээр зохьцуулах төв болно.'* гэжээ.[630]

Дээр дурдсан судалгаануудаас гадна монгол бичигийн хэл болон дундад үеийн монгол хэлний бичигийн дурсхалууд, мөн түүнчилэн орчин үеийн олон монгол хэл аялгуунуудын хэлний онцлогийг судалсан судалгаануудын дотор эгшигийн байрын талаар ажиглан тэмдэглэсэн зүйл олон буй.

Эгшигийн байрын тухай ерөнхий тэмдэглэл. Монгол хэлний эгшигийн байрлал буюу эгшиг зохьцох ёс нь бүр өвөг монгол хэлний үеэс өдгөө хүртэл хэлний хөгжилийн олон үеийг дамжин уламжилж ирсэн эгшигийн дараалалын түгээмэл хууль мөн.

Хэлний авиа үгүүлэхийн эрхтэнүүдээр дамжин цуварч гарахдаа харилцан бие биедээ нөлөөлж, бие биеийнхээ байрыг зохьцуулан тогтоож байдаг ажээ. Өөрөөр хэлбэл, тухайн нэгэн үгийн дотор дурын эгшиг бие биесийн өмнө хойно чөлөөтэй орж болдоггүй, заавал тогтсон байр, дараалалтай байдаг байна. Монгол хэлний эгшигийн байрлалыг тийнхүү зохьцуулан тогтоож байдаг гол хүчин зүйл нь үгийн тэргүүн үеийн эгшигийн бүрэн тод хэлэгдэх шинж юм. Харин түүнийг тухайн үгийн үндэсэн өргөлттэй холбон авч үзэх талаар эрдэмтэдийн санал харилцан адилгүй байна. Олонхи эрдэмтэд монгол хэлний үгийн өргөлт нь гагцхүү тэргүүн үедээ тогтвортой хадгалагддаг гэж үзсээр иржээ.[631] Гэтэл бас зарим эрдэмтэд зөвхөн урт, хос эгшиггүй үгийн өргөлт л тэргүүн үедээ байна. Урт, хос эгшигтэй

---

628 N. Poppe, On the so-called Breaking of ***i*** in Mongolian, UAJb 28:1-2 (1956), 85, 89

629 Т. А. Бертагаев, Чередование фонем и сингармонизм в агглютинативных языках, *'Морфологическая типология и проблема классификация языков'*, М-Л., 1964, 131-140; Сингармонизм, ударение и изменение звукового строя языка, ВЯ. 2 (1968), 106-111

630 Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Авиа, авиалбар хоёр нь, 63

631 И. Я. Шмидт, Грамматика монгольского языка,15; Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, 56; Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 97; А. Д. Руднев, Материалы по говорам Восточной Монголии, СПб., 1911, 197; N. Poppe, Khalkha-Mongolische Grammatik. Mit Bibliographie, Sprachproben und Glossar, 13; Г. Д. Санжеев,Современный монгольский язык, М., 1959, 20; Ш. Лувсанвандан, Монгол хэлний халхын аялгууны балархай эгшгийн тухай асуудалд, ШУАМ. 2 (1964), 113

үгийн өргөлт нь түүнтэй давхцан тохиолдоно гэж үзжээ.[632] Хэрэв бид өргөлтөт эгшигийн байрын тухай саналуудыг нийтэд нь хүлээн зөвшөөрөөд, уламаар өргөлтөт эгшигүүд нь тухайн үгийнхээ доторхи бүх эгшигийн байрыг зохьцуулдаг гэж үзвэл, тэргүүн үеийн өргөлтөт эгшиг нь дараах үеийнхээ бүх эгшигийг, үгийн дунд орсон өргөлтөт эгшиг нь хоёр талынхаа эгшигүүдийг, эцэсийн үеийн өргөлтөт эгшиг нь өмнөх үеийнхээ бүх эгшигүүдийг тус тус захиран тогтооно гэсэн үг болно. Гэтэл хэлний авианы цуваран гарах дараалал хийгээд залгамал хэлний эгшигийн ерөнхий тогтолцоог харгалзан үзвэл эгшигийн зохьцолд шууд нөлөөлдөг гол хүчин зүйл нь тухайн үгийн өөр өөр үед байгаа өргөлтөт эгшигээс шалтгаалахгүй, харин гагцхүү үгийн тэргүүн үеийн эгшигийн бүрэн тод хэлэгдэх байдалаас л шалтгаалдаг жамтай ажээ. Өөрөөр хэлбэл, үгийн тэргүүн үеийн бүрэн тод хэлэгдэх эгшиг нь тухайн үгийнхээ эгшигүүдийг хүчдэлийнх нь талаар зохьцуулах гол төв болно гэсэн үг.

Орчин цагийн монгол хэлний олон үет үгийн доторхи эгшигүүд нь өргөлтөт эгшигээсээ холдох дутам улам балархайшдаг, гэтэл тэргүүн бус үедээ урт, хос эгшигтэй үгийн тэргүүн үеийн богино эгшиг нь хэзээ ч балархайшдагтүй, ямагт бүрэн тод хэлэгддэг нь тэргүүн үеийн эгшигийн онцлог шинж, зохьцуулах үүрэгтэй холбоотой буй заа. Энэ талаар зөвлөлтийн хэл шинжилэлч А. А. Реформатский *'Түрэг мэт залгамал хэлнүүдийн эгшигийн зохьцол нь эгшигийн ижилшилийн олон талыг тусхасан авианы үзэгдэл төдийгүй, авианы нийлц, хэлний бүтэц, түүгээр ч үл барахгүй үгийн бүтэцийн олон асуудалыг хамарсан бүтэц-хэв шинжийн үндэсэн гол үзэгдэл юм'* гэжээ.

Түүнчилэн монгол хэлний эгшигийн зохьцол нь зөвхөн тухайн үгийн үндэсээр зогсохгүй, түүний араас залгавар морфемуудын бүтэцэн дэх эгшигийн байрлалыг ч нэгэн адил тогтооно. Үүнд:

(а) Язгуур морфемийн бүтэцэн дэх эгшигүүд нь залгавар морфемуудынхаа эгшигийг хэлэгдэх хүчдэл (*tension*)-ээр нь зохицуулж өгдөг байна. Тийм ч учираас монгол хэлний язгуур морфемтойгоо зохицсон эр, эм хувилбаруудтай байдаг бөгөөд тэдгээр нь утга ба үүрэгийнхээ талаар харилцан бие биеэ нөхсөн байрлалтай байна. Хэрэв тухайн нэгэн язгуур морфемийн бүтэцэн дэх эгшигийг хэлэгдэх хүчдэлээрээ түүнтэй эсэрэгцэлдсэн өөр эгшигээр сольвол уул язгуурын үгийн сангийн утга өөрчилөгдөөд зогсохгүй, бас түүний араас нэмэн залгах залгавар морфемийн бүтэц ч мөн өөрчилөгдөхөд хүрнэ. Гэхдээ язгуур морфемийн бүтэцэн дэх эгшигийг солиход түүний үндэсэн утга нь өөрчилөгддөг (заримдаа тодорхой утга заах дохио болж чадахгүй Д. Т.) бол залгавар морфемийн доторхи эгшигийг

---

[632] Ш. Лувсанвандан, Монгол хэлний халхын аялгууны балархай эгшгийн тухай асуудалд, ШУАМ 2 (1964), 88-103; Монгол хэлний өргөлтийн тухай асуудалд, *'Монгол хэл шинжлэлийн асуудлууд'*, Уб.,1981, 118-120; M. Shimzu, The Accent of Modern Mongolian, ОУМЭИХ. IV. 2-рботь, 1984, 94-397

зохих эсэрэгцэлдсэн шинжтэй эгшигээр сольвол түүний шинэ үг бүтээх нөөц утга нь алдагдахгүй, зөвхөн өмнөх язгууртайгаа байрааараа тохирохгүй болно.

Жич: *-s, -d, -m, -l, -n, -r* гэх мэт гийгүүлэгчээс бүтсэн дагаварууд болон бүтэцэндээ ***i*** эгшиг бүхий *-či, -čin, -ǰi, -ǰin, -bči, -mǰi* гэх мэт дагаварууд нь ямар ч язгуурын дараа орж болно.

(б) Монгол хэлний үгийн үндэсэн дэх эгшигүүд нь нөхцөлүүдийн бүтэцэн дэх эгшигүүдийн байрыг зохьцуулан тогтоодог байна. Тиймээс нэрийн нөхцөлүүд нь *-un/-ün, -dur/-dür, -da/-de, -ača/-eče, -bar/-ber, -luya/-lüge,* үйлийн нөхцөлүүд нь *-ǰu/-ǰü, -yad/-ged, -basu/-besü, -tala/-tele*зэрэг эр, эм хувилбартай байдаг байна.

1.2.1 ЭР ЭГШИГ АВИАНЫ БАЙР

1.2.1.1 ТЭРГҮҮН ҮЕИЙН ЭР ЭГШИГИЙН БАЙР

a (< *a)-гийн байр

Тэргүүн бус үед				Монгол хэлний хөгжилийн үндэсэн үе шат			
Урууллын оролцоо	Ямар гшиг	Битүү задгай	Гарал	Өвөг монгол хэл	Эртний монгол хэл	Дундад монгол хэл	Одоо монгол хэл
1	2	3	4	5	6	7	8
Урууллын бус	a	зад.	a (<*a)	*aqa	aqa	aqa	aχa
		бит.		*altan	altan	altan	alta
		зад.	ā (< *a)	*qaγan	qaγān	qahān	χān
	i	зад.	i (< *ï)	*barï-	bari-	bari-	bari-
		бит.		*arbïn	arbin	arbin	arbin
		зад.	ī (< *ï)	*aγïl	aγīl	aīl	ail
Урууллын	u	зад.	u (<*u)	*nasun	nasun	nasun	nasa
		бит.		*qamtu	qamtu	qamtu	xamta
		зад.	ū (<*u)	*aγúla	aγūla	a'ūla	ūla

Жич: Тэргүүн үеийн a-гийн дараа o (< *o) тохиолддоггүй.

i (< *ï)-гийн байр

1	2	3	4	5	6	7	8
Урууын бус	a	зад	a (< *a)	*mïqan	miqan	miqan	maχa
		бит		*mïnγan	minγan	minγan	minğa
		зад	ā (< *a)	*nïγá-	niγā-	ni'ā-	nā-
	i	зад	i (< *ï)	*qïlïn	qilin	kilin	χilin
		бит		*bïsïlγal	bisilγal	bisilγal	bisalğal
		зад	ī (< *ï)	*tïγïraγ	čiγīraγ	čiγīraγ	tšīrag
Урууын	u	зад	u (< *u)	*tïsun	čisun	čisun	tsusa
		бит		*nilbusun	nilbusun	nilbusun	nulmis
		зад	ū (< *u)	*nïγú-	niγū-	niγū-	nū-

Жич: Тэргүүн үеийн i-гийн дараа o (< *o) тохиолддоггүй.

o (< *o)-гийн байр

1	2	3	4	5	6	7	8
Урууын бус	a	зад	a (< *a)	*olan	olan	olon	olon
		бит		*ǰolγa-	ǰolγa-	ǰolγa-	dzolgo-
		зад	ā (< *a)	*toγa	toγā	toγā >to'ō	tō
	i	зад	i (< *ï)	*qonïn	qonin	qonin	χoni(n)
		бит		*orγïl	orgil	orgil	orgil
		зад	ī (< *ï)	*noγïr	noγīr	noγīr	noir
Урууын	o	зад	o (< *a)	*oran	oran	oron	oron
		бит		*foγtal-	*xoγtal-	hoγtal-	oχtol-
		зад	ō (< *a)	*noγuγan	noγuγān	noγān	nogōn
	u	зад	u (< *u)	*fodun	*χodun	hodun	odo(n)
		бит		*dobtul-	dobtul-	dobtul-	dobtol-

u (< *u)-гийн байр

1	2	3	4	5	6	7	8
Урууын бус	a	зад	a (< *a)	*uran	uran	uran	uran
		бит		*unta-	unta-	unta-	unta-
		зад	ā (< *a)	*uqaγán	uqaγān	uqa' ān	uχān
	i	зад	i (< *ï)	*urïda	urida	urida	urida
		бит		*unsï-	unsi-	unsi-	unši-
		зад	ī (< *ï)	*uγïla-	ugīla-	uyīla-	uila-
Урууын	u	зад	u (< *u)	*uruγ	uruγ	uruγ	urug/urag
		бит		*nuntuγ	nuntuγ	nuntuγ	nutug
		зад	ū (< *u)	*uγú-	uγū-	u'ū-	ū-

1.2.1.2 ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН ЭР ЭГШИГИЙН БАЙР

а (< *а)-гийн байр

Байрлал	эцэсийн эцэсийн бус	задгай битүү	Өвөг монго хэл	Эртний монгол хэл	Дундад үеийн монго хэл	Одоогийн монгол хэл
1	2	3	4	5	6	7
а (< *а)	эцэсийн бус	зад	*tamaγa	tamaγa	tamaγa	tamağa
		бит	*qaranγui	qaranγui	qaranγui	xaraŋγui
	эцэсийн	зад	*aqa	aqa	aqa	aχa
		бит	*aman	aman	aman	ama(n)
ā (< *a)	эцэсийн бус	зад	*taγála-	taγāla-	ta'āla-	tāla-
		бит	*taγálaγda-	taγālaγda-	ta'ālaγda-	tālagda-
	эцэсийн	зад	*qaγálγa	qaγālγa	qa'ālγa	χālağa
		бит	*arïγátan	ariγātan	ariγātan	arātan
ī (< *ï)	эцэсийн бус	зад	*qïǰaγár	qiǰaγār	kiǰa'ār	χidzār
		бит	*ïmaγta	imaγta	imaγta	jamagta
	эцэсийн	зад	*nïlqa	nilqa	nilqa	nilχa
		бит	*tïn-ar	činar	činar	tšinar
ī (< *ï)	эцэсийн бус	зад	*γaγīqaγūl	γaγīqaγūla	γayīqa'ūl-	ğaiχūl-
		бит	*γaγiqamsi	γayīqamsiγ	γayīqamsiγ	ğaiχamšig
	эцэсийн	зад	*qaγïra	qaγīra	qayīra	χaira
		бит	*aγïmaγ	aγīmaγ	ayīmaγ	aimag
ō (< *o)	эцэсийн бус	зад	*ǰobalan	ǰobalan	ǰobolan	dzobolon
		бит	*oγtaryui	oγtaryui	oγtoryui	oχtorgui
	эцэсийн	зад	*qota	qota	qota	χoto
		бит	*olan	olan	olo-n	olon
ō (< *o)	эцэсийн бус	зад	*futasun	*χutasun	hutasun	utasa
		бит	*umarta-	umarta-	umarta-	umarta-
	эцэсийн	зад	*dumda	dumda	dumda	dunda
		бит	*γurban	γurban	γurban	gurban
ū(< *u)	эцэсийн бус	зад	*aγúlǰaqu	aγūlǰaqu	a'ūlǰaqu	ūldzaχ
		бит	*aγúlǰaldu-	aγūlǰaldu-	a'ūlǰaldu-	ūldzalda-
	эцэсийн	зад	*aγúla	aγūla	a'ūla	ūla
		бит	*maγúqan	maγūqan	ma'ūqan	mūχan

i (< *i)-гийн байр

1	2	3	4	5	6	7
а (< *а)	эцэсийн бус	зад	*amïtan	amitan	amitan	amitan
		бит	*arbïdqa-	arbidqa-	arbidqa-	arbidχa-
	эцэсийн	зад	*barï-	bari-	bari-	bari-
		бит	*taqïl	taqil	takil	taχil

ā (< á)	эцэсийн бус	зад	*daeγárïqu-	daγāriqu-	da'āriqu-	dāiraχ
		бит	*daγárïγda-	daγāriγda	da'āriγda-	dāiragda-
	эцэсийн	зад	*aγálï	aγāli	a'āli	āli
		бит	*tarïγáčin	tariγāčin	tari'āčin	tariāčin
o (< *o)	эцэсийн бус	зад	*foγčïryúl-	χorčiγūl-	horčiγūl-	ortšūl-
		бит	*tonïlγa-	tonilγa-	tonilγa-	tonolgo-
	эцэсийн	зад	*tolï	toli	toli	toli
		бит	*qonïn	qonin	qonin	χonin
ō (< *a)	эцэсийн бус	зад	*boγálčïla-	boγālčila-	bo'ōlčila-	bōltšil-
		бит	*toγárïn	toγārin	to'ōrin	tōirin
	эцэсийн	зад	*noγuγáčïn	noγuγāčin	noγu'āčin	nogōtšin
		бит	*diruγáči	ǰiruγāči	ǰiru'āči	dzurātši
u (< *u)	эцэсийн бус	зад	*urïda	urida	urida	urida
		бит	*qurïmla-	qurimla-	qurimla-	χurimla-
	эцэсийн	зад	*qubï	qubi	qubi	χuwi
		бит	*γulïr	γulir	γulir	ğulir/ğurul
ū (< *u)	эцэсийн бус	зад	*qataγújiqu-	qataγūǰiqu	qata'ūǰiqu	χatūdžiχ
		бит	*qataγújiγči	qataγūǰiγči	qata'ūǰiγči	χatūdžigtši
	эцэсийн бус	зад	*saγúrï	saγūri	sa'ūri	sūiri
		бит	*tuγúrbïl	tuγūrbil	tu'ūrbil	tūrwil

o (< *a, *u)-гийн байр

1	2	3	4	5	6	7
o (*a)	эцэсийн бус	зад	*ǰobalaŋ	ǰobalaŋ	ǰobolaŋ	dzoboloŋ
		бит	*olanqï	olanqi	olonki	olonχi
	эцэсийн	зад	*oŋγača	oŋγača	oŋγoča	oŋgotso
		бит	*olan	olan	olon	olon
o (< *u)	эцэсийн бус	зад	*bosuγa	bosuγa	bosoγa	bosogo
		бит	*solunγa	solunγa	solonγa	soloŋgo
	эцэсийн	зад	*boru	boru	boro	boro
		бит	*omuγ	omuγ	omoγ	omog
ō (< *á)	эцэсийн бус	зад	*toγačaqu	toγāčaqu	to'ōčaqu	tōtsoχ
		бит	*toγálalγa	toγālalγa	to'ōlalγa	tōlologo
	эцэсийн	зад	*toγásqa	toγāsqa	to'āsqa	tōsgo
		бит	*toγálal	toγālal	to'ālal	tōlol
ō (<*a|*u)	эцэсийн бус	зад	*qoγásura	qoγāsura	qo'āsura-	χōsor-
		бит	*qoγárunda	qoγārundu	qo'ārundu	χōrondo
	эцэсийн	зад	*toγúnu	toγūnu	to'ōnu	tōno
		бит	*qoγásun	qoγa:sun	qo'ōsun	χōsun

u (< *u)-гийн байр

1	2	3	4	5	6	7
a (< *a)	эцэсийн бус	зад.	*amuγulaŋ	amuγulaŋ	amuγulaŋ	amağalaŋ
		бит.	*amurliŋγui	amurlŋγui	amurliŋγui	amarliŋγui
	эцэсийн	зад.	*aru	aru	aru	ara
		бит.	*nasun	nasun	nasun	nasa(n)
ā (<*a)	эцэсийн бус	зад.	*nïγalduγul	niγālduγul	ni' ālduγūl	nāldūl-
		бит.	*baγaturliγ	baγāturliγ	ba' āturliγ	bātarlaγ
	эцэсийн	зад.	*arïγatu	ariγātu	ari' ātu	arātu
		бит.	*baγátur	baγātur	ba' ātur	bātar
ï (< *ï)	эцэсийн бус	зад.	ǰiryuγán	ǰiryuγān	ǰiryu'ān	dzurgān
		бит.	*qimulsun	kimusun	kimusun	χumas
	эцэсийн	зад.	*ǰiru-	ǰiru-	ǰiru-	dzura-
		бит.	*ǰiruγ	ǰiruγ	ǰiruγ	dzurag
ï: (< *ï)	эцэсийн бус	зад	*oγīmasun	oyīmasun	oimasun	oimos
		бит.	*taγílulγa	tayīlulγa	tayīlulγa	taillağa
	эцэсийн	зад.	qoγídu	qoyīdu	qoyīdu	χoid
		бит.	daγísun	dayīsun	dayīsun	daisan
o (< *o)	эцэсийн бус	зад.	nomuqan	nomuqan	nomxon	nomxon
		бит.	soyurqal	soyurqal	soyurqal	soyorχol
	эцэсийн	зад.	ordu	ordu	ordo	ordŏ
		бит.	χodun	hodun	odo(n)	odŏ
u (<*u)	эцэсийн бус	зад.	uryumal	uryumal	uryumal	urğamal
		бит.	uruγsi	uruγsi	urugsi	uragšï
	эцэсийн	зад.	urtu	urtu	urtu	urtɒ
		бит.	uruγ	uruγ	urug	urag
ū(<*u)	эцэсийн бус	зад.	qoγūsura-	qo'ōsura-	χōsor-	xōsor-
		бит.	tuγūluγsan	tu'ūluγsan	tūlsan	tūlsan
	эцэсийн	зад.	daγūtu	da'ūtu	dūtu	dūt
		бит.	aduγūsun	adu'ūsun	adūsan	adūs

Жич: Тэргүүн үеийн *и*-гийн дараа о тохиолддоггүй.

1.2.2 ЭМ ЭГШИГ АВИАНЫ БАЙР

1.2.2.1. ТЭРГҮҮН ҮЕИЙН ЭМ ЭГШИГИЙН БАЙР

e (< *e)-гийн байр

1	2	3	4	5	6	7	8
Уруулын бус	e	зад.	e (< e)	*eke	eke	eke	eke
		бит.		*erte	erte	erte	erte
		зад.	ē (< *e)	*gegegen	gegegēn	gege'ēn	gegēn
Уруулын бус	i	зад.	i (< *i)	*fekin	hekin	ekin	exi(n)
		бит.		*elčin	elčin	elčin	eltšin
		зад.	ī (< *i)	*egimü	egīmü	eyīmü	īm

Уруулын	ü	зад.	ü (<ü)	*ebül	ebül	übül	öböl
		бит.		*ergül	ergül	örgül	örgöl
		зад.	ū (<*ü)	*egüden	egūden	e' ūden	ūde(n)

i (< *i)-гийн байр

1	2	3	4	5	6	7	8
Уруулын бус	e	зад.	e (< *e)	*niken	nigen	nigen	nige(n)
		бит.		*irgen	irgen	irgen	irgen
		зад.	ē (< *e)	*ǰige	ǰigē	ǰi'ē	dzē
Уруулын бус	i	зад.	i (< *i)	*bitik	bičig	bičig	bitšig
		бит.		*ilči	ilči	ilči	iltši
		зад.	ī (< *i)	*čigig	čigīg	či' īg	tšīg
Уруулын		зад.		*nidün	nidün	nidün	nüde(n)
		бит.	ü (<*ü)	*čidkür	čidkür	čidkür	tšödχör
		зад.	ū (<*ü)	*ǰigür	ǰigūr	ǰi'ūr	džūr

ö (< *ö)-гийн байр

1	2	3	4	5	6	7	8
Уруулын бус	e	зад.		*köke	köke	kökö	χöχö
		бит.	e (< *e)	*dörben	dörben	dörben	dörbön
		зад.	ē (< *e)	*ögede	ögēde	ö' ēde	ō dö
	i	зад.	i (< *i)	*dötin	döčin	döčin	dötši(n)
		бит.		*öglige	öglige	öglige	öglög
		зад.	ī (< *i)	*kögiten	kögīten	küyīten	χüiten
Уруулын	ö	зад.	ö (< *e)	*bögeǰi	bögeǰi	bögeǰi	bögödži
		бит.		*dörben	dörben	dörben	dörbön
		зад.	ō (< *e)	*bögere	bögēre	bö' ēre	bō rö
	ü	зад.	ö (< *ü)	*förüne	xörüne	hörüne	örönö
		бит.		*öndür	öndür	ündür	ödör
		зад.	ü (< *ü)	*kökü	kökü	kökö	χöχö
		бит.		*mölsün	mölsün	mölsün	mösö
		зад.	ū (< *ü)	*öčügüken	öčügūken	öčūken	ötšūχen

ü (< *ü)-гийн байр

1	2	3	4	5	6	7	8
Уруулын бус	e	зад.	e (< *e)	*ünen	ünen	ünen	ünen
		бит.		*türgen	türgen	türgen	türgen
	i	зад.	i (< *i)	*bürin	bürin	bürin	büren
		бит.		*tülki-	tülki-	tülki-	tülχe-
		зад.	ī (< *i)	*ügile	ügūle	üyīle	üile

Урулын	ü	зад.	ü (< *ü)	*bükü	bükü	bükü	büχe
		бит.		*kündü	kündü	kündü	χünde
		зад.	ū (< *ü)	*dügūreŋ	dügūreŋ	dü' ūreŋ	dūreŋ

1.2.2.2 ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН ЭМ ЭГШИГИЙН БАЙР

e (< *e)-гийн байр

1	2	3	4	5	6	7
e(< *e)	эцэсийн бус	зад	*delekej	delekei	delekei	delχī
		бит	*ebedčin	ebedčin	ebedčin	öbtšin
	эцэсийн	зад	*tere	tere	tere	tere
		бит	*tergen	tergen	tergen	terge (n)
ē(< *e)	эцэсийн бус	зад	*negegdkü	negēgdekü	ne' ēgdekü	nēgdeχ
		бит	*kürigelegde	kürigēlegde	küriyēlegde	χūrēlegde
	эцэсийн	зад	*kegere	kegēre	ke'ēre	χēre
		бит	*ǰögelen	ǰögēlen	ǰö'ēlen	dzō lön
i (< *i)	эцэсийн бус	зад	*ikere	ikere	ikere	iχer
		бит	*iledkel	iledkel	iledkel	iledχel
	эцэсийн	зад	*sine	sine	sine	šine
		бит	*čimeg	čimeg	čimeg	tšimeg
i (< *i)	эцэсийн бус	зад	*degilekü	degīlekü	deyīlekü	dīleχ
		бит	*degilegde-	degīlegde-	deyīlegde-	dīlegde-
	эцэсийн	зад	*ügile	ügīle	üyīle	üile
		бит	*tügimer	tügīmer	tüyīmer	tüimer
ö (<*ö)	эцэсийн бус	зад	*öŋgetü	öŋgetü	öŋgetü	öŋgötö
		бит	*ködelge-	ködelge-	ködölge-	χödölgö-
	эцэсийн	зад	*möŋke	möŋke	möŋke	möŋχö
		бит	*örgen	örgen	örgön	örgön
ü (<e)	эцэсийн бус	зад	*künesü	künesü	künesü	χünes
		бит	*üǰegde-	üǰegde-	üǰegde-	üdzegde-
	эцэсийн	зад	*bügüde	bügüde	bügüde	büged
		бит	*küčüten	küčüten	küčüten	χütšiten
ū (<ü*)	эцэсийн бус	зад	*dügürekü	dügūrekü	dü'ūrekü	dūreχ
		бит	*ügülegde-	ügūlegde-	ügūlegde-	ügūlegde
	эцэсийн	зад	*terigüle-	terigūle-	teri'ūle-	türūl-
		бит	*egūden	egūden	e'ūden	ūde (n)

i (< *i)-гийн байр

1	2	3	4	5	6	7
e (< *e)	эцэсийн бус	зад	*eldigen	elǰigen	elǰigen	ildžigen
		бит	*sedkilten	sedkilten	sedkilten	sedχelten
	эцэсийн	зад	*ergi	ergi	ergi	erig
		бит	*bečin	bečin	bečin	bitšin

ē (< *e	эцэсийн бус	зад	*degeǰile-	degēǰile-	de′ēǰile-	dēdžil-
		бит	*tögerildü-	tögērildü-	tö′ērildü-	tő röld-
	эцэсийн	зад	*degeǰi	degēǰi	de′ēǰi	dēdži
		бит	*degeǰis	degēǰis	de′ēǰis	dēdžis
i (< *i)	эцэсийн бус	зад	*kitige-	kičigē-	kičiyē-	χitšē-
		бит	*biligtü	biligtü	biligtü	biligte
	эцэсийн	зад	*sinǰi	sinǰi	sinǰi	sindži
		бит	*bitik	bičig	bičig	bitšig
ö (< *ö)	эцэсийн бус	зад	*öglige	öglige	öglige	öglög
		бит	*ǰöbsildü-	ǰöbsildü-	ǰöbsildü-	dzöbšild-
	эцэсийн	зад	*söni	söni	söni	söni
		бит	*kögsin	kögsin	kögsin	xögšin
ü (< *ü)	эцэсийн бус	зад	*fünigen	xünigen	hünigen	üneg
		бит	*büdigle-	büǰigle-	büǰigle-	büdžigel-
	эцэсийн	зад	*düri	düri	düri	düre
		бит	*tübsin	tübsin	tübsin	tübšin

ö (< *e, *ü)-гийн байр

1	2	3	4	5	6	7
ö (< *e)	эцэсийн бус	зад	*köndelen	köndelen	köndelen	χöndölön
		бит	*dörbelǰin	dörbelǰin	dörbelǰin	dörböldžin
	эцэсийн	зад	*böke	böke	bökö	böxö
		бит	*örgen	örgen	örgen	örgön
ö (< *ü)	эцэсийн бус	зад	*nöküčel	nöküčel	nöküčel	nöxχtsöl
		бит	*körünge	körünge	körönge	χöröngö
	эцэсийн	зад	*kökü	kökü	kökö	χöχö
		бит	*öndür	öndür	ündür	öndür

ü (<*ü)-гийн байр

1	2	3	4	5	6	7
e (< *e)	эцэсийн бус	зад	*ebügen	ebügen	öbügen	öbögön
		бит	*emüsgel	emüsgel	ömüsgel	ömösχöl
	эцэсийн	зад	*ebüge	ebüge	öbüge	öbög
		бит	*ečüs	ečüs	ečüs	etsüs
ē (< *e)	эцэсийн бус	зад	*degedüle-	degēdüle-	de′ēdüle-	dēdel-
		бит	*degedülekü	degēdülekü	de′ēdülekü	dēdleχ
	эцэсийн	зад	*negekü	negēkü	ne′ēkü	nēχ
		бит	*degedüs	degeēdüs	de′ēdüs	dēdes
i (< *i)	эцэсийн бус	зад	*tilüge	čilügē	čilü′ē	tšölő
		бит	*sitüldü-	sitüldü-	sitüldü-	šütelde-
	эцэсийн	зад	*ildü	ildü	üldü	üldü/Ord./
		бит	*disün	ǰisün	ǰisün	dzüse

ī (< *i)	эцэсийн бус	зад	*kegisbüri	kegīsbüri	keyīsbüri	χīsber
		бит	*degilügde	degīlügde-	deyīlügde-	dīlegde-
	эцэсийн	зад	*egimü	egīmü	eyīmü	īm
		бит	*tegimü	tegīmü	teyīmü	tīm
ö (<*ö)	эцэсийн бус	зад	*görügesün	görügēsün	görü'ēsün	görȭs
		бит	*ölüskülen	ölüskülen	ölöskülen	ölösχölön
	эцэсийн	зад	*örü	örü	örü	örü
		бит	*körüg	körüg	körüg	χörög
ü (<*ü)	эцэсийн бус	зад	*kündüle-	kündüle-	kündüle-	χündel-
		бит	*kürülče-	kürülče-	kürülče-	χürültse-
	эцэсийн	зад	*bükü	bükü	bükü	büχü
		бит	*külüg	külüg	külüg	χülüg
ū (<*ü)	эцэсийн бус	зад	*ǰegüdüle-	ǰegūdüle-	ǰe'ūdüle-	dzūdel-
		бит	*üǰegülügči	üǰegūlügči	üǰe'ūlügči	üdzūlegtši
	эцэсийн	зад	*segültü	segūltü	se'ūltü	sūltü
		бит	*ǰegüdün	ǰegūdün	ǰe'ūdün	dzūde

Жич: 1. Тэргүүн үеийн ***i***-гийн дараа *ö* (< *ö) тохиолддоггүй.
2. Тэргүүн үеийн ***ü***-гийн дараа *ö* (< *ö) тохиолддоггүй.

Эцэст нь дүгнэвэл, монгол хэлний эгшигийн зохьцол гэдэг нь үгийн тэргүүн үеийн эгшиг дараах үеийнхээ эгшигүүдийг хэлэгдэх хүчдэлийнхээ талаар захиран тогтоож, уламаар тэдгээрийг өөртөө татан ижилшүүлж байгаа ерөнхий хандлага юм. Тийм учираас энэ нь нэг талаар, эгшигийн байрлалын хатуу тогтсон хууль, нөгөө талаар, нэгэн үгийн доторхи эгшигүүд хүчдэлээрээ ижилшиж байгаа хэрэг билээ.

1.3 ЭГШИГ АВИАНЫ ХУВЬСАЛ

1.3.1 **УРТ ЭГШИГИЙН ГАРАЛ, ХУВЬСАЛ**

Монгол хэлний урт эгшиг,тэдгээрийн гарал үүсэлийн тухай асуудал бол академич Ш. Лувсанвандан багшийн дүгнэн хэлсэнээр *'Монгол хэлний авианы системд онцгой өөрчлөлт гаргасан төдийгүй, монгол үгийн хэлбэрт өөрчлөлт гаргаж, улмаар хэл зүйн хэлбэрт ч өөрчлөлт гаргахад хүргэсэн чухал асуудал'* билээ. Тийм ч учираас монгол хэлний авианы хувьсалын түүхийг сонирхон судалсан олон эрдэмтэд урт эгшигийн гарал, хувьсалын талаар ихэд анхааран судалсаар иржээ.

Монгол хэлний урт эгшигийн гарал үүсэлийн талаархи зуу гаруй жилийн судалгааны үр дүнд орчин үеийн монгол хэл аялгуунууд дахь урт эгшигийг гарал үүсэлийнх нь талаар *'анхдагч урт эгшиг'*, *'үүсмэл урт эгшиг'* хэмээн хоёр зүйлээр ангилан үзэх боломжтой болжээ.

1.3.1.1 АНХДАГЧ УРТ ЭГШИГ

§ 78. **Анхдагч урт эгшигийн судалгааны тойм.** Орчин үеийн олонхи монгол хэл аялгуунуудад богино эгшигтэй хэлэгддэг үгсийн зарим нь өдгөөгийн Могол, Монгор, Дагуур хэлнүүдэд урт эгшигтэй хэлэгддэгийг G. J. Ramstedt,[633] A. Mostaert,[634] N. Poppe[635] нар анх олж ажигласан боловч түүний учир шалтгааныг түүхэн хэл шинжилэлийн үүднээс тусхайлан судалсангүй. Харин хожим профессор Sh. Hattori өвөг монгол хэлний анхдагч урт эгшиг, түүний ул мөрийн тухай сонирхолтой асуудалыг анх түрүү хөндөн гаргажээ. Тэрвээр *'Өвөг монгол хэлний урт эгшиг'* гэдэг үгүүлэлдээ *'Монгор хэлний материалаас тэргүүн үедээ урт эгшиг бүхий жишээнүүдийг түүвэрлэн жагсаагаад дээр дурдсан үгсийн тэргүүн үед тохиолдож байгаа урт эгшигүүдийн хувьсалд нөлөөлөхүйц фонологийн ямар ч орчиныг монгор хэлнээс олж чадахгүй байна. Тийм учираас эдгээр урт эгшигийг өвөг монгол хэлний үеийн урт эгшиг хэмээн сэргээн тогтоох нь зүйтэй'*[636] хэмээн тэмдэглэжээ. Мөн профессор M. Nomura Монгор хэлний урт эгшигтэй үгсийг Түрэг, Түнгүүс хэлний зохих үгстэй харьцуулан үзсэний үндэсэн дээр *'...Бараг бүх монгол хэл аялгуунуудын богино эгшигтэй тохирч байгаа монгор хэлний урт эгшиг нь зөвхөн дурдсан аялгууны өвөрмөц онцлог төдий бус, харин тухайн үеийнх нь бусад олон аялгуунд урт, богиноороо фонемийн утга ялгаж байсан маш эртний* (монгол Д. Т.) *хэлний авианы ул мөр гэж үзвэл зохино'*[637] хэмээн тэмдэглэсэн байна. Мөн тэрвээр монгол, түрэг хэлнүүдийг харьцуулан үзээд өвөг монгол хэлний анхдагч урт эгшигийг сэргээн тогтоохтой холбогдсон хэд хэдэн үгүүлэл нийтлүүлжээ.[638] Түүнчилэн Монгор, Халимаг хэлний урт эгшигт тулгуурлан өвөг монгол хэлний анхдагч урт эгшигийг сэргээн тогтоох чиглэлээр тусхай үгүүлэл[639] бичсэнээс гадна үгийн язгуур болон үг бүтээх дагаварын бүтэцэн дэх анхдагч урт эгшигийн тухай хэд хэдэн цуварал үгүүлэл нийтлүүлжээ.[640]

---

633 G. J. Ramstedt, *Mogholica.* Beiträge zur Kenntnis der Moghol Sprache in Afghanistan, JSFOu. 23:4 (1905), 1-60

634 A. Mostaert, Le dialecte monguor parlé par les mongols du Kasou Occidental, Premiere partie: Phonétique, *Anthropos* 24 (1929), 145-165, 801-815, 25 (1930), 657-669, 961-973

635 Н. Н. Поппе, Дагурское наречие, 125

636 Sh. Hattori, The Length of Vowels in Proto Mongolian, *'Mongolian Studies'*, Budapest, 1970, 187

637 M. Nomura, Long Vowels in Monguor and the Possible Existance of Long Vowels in Proto Mongolian, *'Collection of Articles in Commemoration of the 10th Aniversaries of the Faculty of Letters'*, Nagoya University, 1959, 6 (япон хэлээр)

638 M. Nomura,A Study on the Vowel Phoneme System of the Proto-Mongolian Language, MFL NU 37, 1965, 1-40; On Long Vowels Reconstructed in Roots or in the First Syllable of Primary Stems, MFL NU. 67 (1968), 483-489; Vowel Phoneme System of Common Mongolian, MFL NU. 58 (1973), 27-33 (япон хэлээр)

639 M. Nomura, On Long Vowels in Monguor Dialect and Reconstruction of Long Vowel Phonemes in Proto Mongolian, *Memoirs of the Research Department of the Toyo-Bunko*, 18, 77-89 (япон хэлээр)

640 M. Nomura, On Long Vowels Reconstructed in Roots or in the First Syllable of Primary Stems, MFL NU 67, 1968, 483-489; On Long Vowels Reconstructed in the Second Syllable of Stems, MFL NU 60, 1966, 1-9; Long Vowels Reconstructed in the Word-formative Elements, MFLNU 52, 1971, 1-3 (япон хэлээр)

Ер монгол хэлний анхдагч урт эгшигийн ул мөр нь зөвхөн Монгор, Дагуур хэлээр барахгүй бас Могол хэлэнд үлдсэн тухай шинэ материалыг профессор L. Ligeti, M. Weiers нар[641] нийтлүүлжээ. Могол хэлний анхдагч урт эгшигийн тухай L. Ligeti-ийн судалгаа гарсаны дараа профессор N. Poppe анхдагч урт эгшигийн тухай судалгаагаа өргөжүүлэн *'Нийт монгол хэлний урт эгшиг'* гэсэн томоохон үгүүлэл нийтлүүлсэн билээ.[642] Дурдсан судалгаанд тэргүүн үедээ урт эгшигтэй 93, тэргүүн бус үедээ урт эгшигтэй 133, дагаварын бүтэцэнд орсон урт эгшигтэй 15 жишээ тус тус олж, тэдгээрийг түрэг, түнгүүс хэлний зохих жишээнүүдтэй харьцуулан үзжээ. Тэнд дурдсан жишээний дотор одоогийн монгол хэл аялгуунуудад харилцан тохирч байгаа үгсийг тоогоор илэрхийлвэл:

Могол, Монгор, Дагуур хэлэнд	3
Могол, Монгор хэлэнд	15
Могол, Дагуур хэлэнд	4
Монгор, Дагуур хэлэнд	1

Бусад 145 жишээнээс Монгорт 98, Моголд 16, Дагуурт 31 үг тус тус оногдож байна.

Монгол хэлний анхдагч урт эгшиг бүхий үгсийг өнөөгийн олон хэл аялгуунуудаас гадна эртний бичигийн дурсхалуудаас эрж олох анхны оролдлогыг профессор Sh. Murayama хийсэн байна. Тэрвээр *'Монголын нууц товчоо'*-ны зарим үгийг Могол, Монгор, Түнгүүс хэлний зохих үгстэй харьцуулан судалжээ.[643]

Таширамд дурдахад, монгол хэлний анхдагч урт эгшигийн талаар дээр дурдсан судалгаануудын үндэсэн дүгнэлтийг үгүйсгэсэн санал ч бас бий. Тухайлвал, профессор G. Doerfer *'Өвөг монгол хэлэнд урт эгшиг байсан уу'* гэдэг үгүүлэлдээ *'Монгор хэлэнд урт эгшиг байгаа нь өвөг монгол хэлэнд урт эгшиг байсаны гэрч болж чадахгүй .... ер нь өвөг монгол хэлэнд урт эгшиг байсаныг батлах ямар ч баримт байхгүй байна.'* гэжээ.[644] Гэвч бие биеэсээ эрт салсан хэд хэдэн өөр хэлэнд ижил утгатай, адил урт эгшигтэй үгс тохиолдож байгаагийн цаад учир шалтгааны талаар профессор G. Doerfer ямар ч тайлбар хийсэнгүй.

Монгол хэлний анхдагч урт эгшигийн тухай асуудалыг нийт алтайн хэлнүүдийн хүрээнд авч үзэх нь нэн чухал бөгөөд энэ талаар профессор N. Poppe тусхайлан судалгаа хийжээ. Тэрвээр уг харьцуулсан судалгаандаа Туркмен, Якут,

---

641 L. Ligeti, Les voyelles longue en Moghol, AOH 1, 1964, 31-48; M. Weiers, Zu den langen Vokalen in der Moghol-Sprache, ZAS 4, 1970, 467-473

642 N. Poppe, On the Long Vowels in Commen Mongolian, JSFOu 68:4, 1967, 1-31

643 Sh. Murayama, Die Entwicklung der Theorie von den primären langen Vokalen im Mongolischen, *'Mongolian Studies'*, Amsterdam, 1970, 359-370

644 G. Doerfer, Langvokale im Urmongolischen ? JSFOu 70:1, 1969, 21

Эвенк, Монгор, Дагуур хэлнүүдийн анхдагч урт эгшигтэй үгсийг хамаруулан нэг гаралтай үгсийг сэргээн тогтоосон байна.[645]

§ 79. **Анхдагч урт эгшиг.** Өдгөөгийн Туркмен, Якут, Чуваш, Эвенк, Солон, Негидал, Ороки, Нанай, Ламут зэрэг алтайн язгуурын төрөл хэлнүүдэд өвөг алтайн хэлний үеэс уламжилан ирсэн анхдагч урт эгшигийн ул мөр байгаа тухай асуудал нэгэнт тодорхой болсон тул монгол хэлэнд ч мөн тийм анхдагч урт эгшиг байж болох тухайд онолын талаас эргэлзэх аргагүй юм. Баримтын талаас авч үзвэл, орчин үеийн олонхи монгол хэл аялгуунуудад богино эгшигтэй хэлэгддэг үгсийн зарим нь Могол, Монгор, Дагуур хэлнүүдэд урт эгшигтэй хэлэгддэг тухай өмнө дурдсан билээ. Бие биеэсээ маш хол алслагдсан хэд хэдэн өөр хэлэнд иймэрхүү адил төстэй үзэгдэл байгаа нь зөвхөн тэдгээр хэлнүүдийн онцлог шинж төдийгүй, монгол хэлний хөгжилийн нэн эртний шатанд харьцангуй нийтлэг тохиолдож байсан авианы шинжийн ул мөр байх бүрэн үндэстэй юм. Харин монгол хэлний анхдагч урт эгшиг нь бүр анхнаасаа тухайн үеийнхээ олон аялгуунуудад адил тэгш байсан уу, эсвэл зарим аялгуунууд урт, бас заримд нь богиноор хэлэгдэж байсан уу гэдэг асуудал тодорхойгүй байна. Хэрэв өвөг монгол хэлний үеэс нийт монгол аялгуунуудад урт эгшиг байсан бол тэр нь ямар учираас орчин үеийн олонхи хэл аялгуунуудад богиноор хэлэгддэг болсоныг авианы бодит хууль зүйн үүднээс тайлбарлах нь чухал болж байна.

1.3.1.1.1 Тэргүүн үеийн анхдагч урт эгшиг

Монгол хэлний үгийн тэргүүн үед гагцхүү анхдагч урт эгшиг л тохиолдож байсан бөгөөд өдгөө түүний ул мөр Могол, Монгор, Шар Ёгур, Дагуур хэлнүүдэд үлджээ.

Mo. dalu, PM *dālu [Cf. dālu (Mog, Ist.)], dōlu [< *dālu] (Mog.); CM. dālū (Mog, Zir.); dāli (Mngr.); dēle SY id.

Mo. tabun, PM *tābun; CM tābun (Zir.), tāwen (Mngr, SY), tāwun (Dag.), tāun (But.) id.

Mo. modun, PM *mōdun; CM mōdun (Zir.), mōdi (Mngr.), mōd (Dag.), mōde (But.), mūden [< *mōdun](SY) id.

Mo. del, PM *dēl, CM dēl (Sol.) /JSFOu. 68:4, 11/; dēlbur (Dag.)

Mo. dörben, PM *dȫ̄ rben, CM tȫ̄ rt (Trkm,), tüort (Yak.)/JSFOu. 68:4, 12/, diēran (Mngr.)

---

645 N. Poppe, The Primary Long Vowels in Mongolian, JSFOu 63:2, 1962, 1-19

1.3.1.1.2 **Тэргүүн бус үеийн анхдагч урт эгшиг**

Үгийн тэргүүн бус үеийн анхдагч урт эгшиг нь үүсмэл урт эгшигтэй адил байрлалтай мэт боловч авианы орчиныхоо хувид ялгаатай байдаг ажээ. Тухайлвал, үүсмэл урт эгшиг нь өмнөө богино эгшиг бүхий шүргэх *-γ/-g*-гийн дараа тохиолддог бол анхдагч урт эгшиг нь их төлөв ***b, r, g, d*** зэрэг гийгүүлэгчээр эхэлсэн битүү үеийн дотор тохиолдож байна.

Mo. arban, PM *farbān; arbān (Mog.) arbōn [< *arbān](Mog.
Mo. duran, PM *durān; CM durān (Mngr.), durān (Mog.) /AOH XVII 137/
Mo. eljigen, PM *eljigēn; CM eljigān (Mog.) eljigōn (Mog.)*id.*
Mo. köngen, PM *köngēn; CM kungān (Mog.), kungōn (Mog.) *id.*
Mo. adali, PM *adāli; CM adāli (Mog.) adōli [< *adāli) (Zir.)

1.3.1.2 ҮҮСМЭЛ УРТ ЭГШИГ

§ 80. **Үүсмэл урт эгшигийн судалгааны тойм.** Монгол хэлний үүсмэл урт эгшигийн гаралын талаар хэл шинжилэлийн үүднээс хамагийн анх судалан тайлбарласан хүн бол А. А. Бобровников юм. Тэрвээр Монгол, Халимаг хэлний урт эгшигийн онцлог шинжийн талаар: *'Монгол, халимаг хэлний аль алинд нь хоёр ерийн богино эгшигтэй тэнцэхүйц удаанаар сунжиран хэлэгдэх эгшигүүд бий. Бид энд тэдгээр эгшигүүдийг урт эгшиг гэж нэрлэж байна. Гэвч тэдгээр авианууды хоёр богино эгшигийн нийлбэрээс үүссэн гэж үзэх аргагүй юм. ... Тэдгээр урт эгшигийн дуудлагыг ажиглавал, түүний уртаар хэлэгдэх байдал нь зөвхөн амисхалын түрэлттэй холбоотой байгааг мэдэж болно. Тиймээс тэдгээр эгшигүүдийг энэхүү шинжээр нь амисхалын түрэлтэт эгшиг хэмээн нэрлэмээр санагдана... Монгол, халимаг хэлнүүдэд байгаа тэдгээр урт эгшигүүд нь уулаасаа байсаар байсан мэт санагдана. Түүнийг батлах тодорхой баримт бидэнд олдохгүй байгаа боловч наад захын зарим тохиолдолд эгшиг авиа нь өмнөх төвөнхийн гийгүүлэгчтэйгээ нийлж нэгэн урт эгшиг болсон гэж үзэж болмоор байна*'[646] гэж дурдаад цааш нь Монгол, Халимаг хэлний урт эгшигийг төвөнхийн гийгүүлэгч, эгшиг хоёрын дундаас үүссэн байж магадгүй гэсэн таамаглал дэвшүүлжээ.[647] Энд дурдаж буй төвөнхийн гийгүүлэгч гэдэг нь угтаа дундад үеийн монгол хэлний үед хоёр эгшигийн хоорондоос сугарсан шүргэх *-γ/-g*-гийн байранд үлдсэн сул шүргэх *-h-* авиатай дүйж байгаа билээ. Тэрхүү сугарсан гийгүүлэгчийн хоёр талын эгшигүүд нь бүр XVII-XVIII зууны үеийг хүртэл ойрд хэлэнд ижилшээгүй байсаныг тод үсэгийн дурсхалаас тодорхой мэдэж болно. Энэ нь тухайн тэр үе хүртэл уул хоёр эгшигийг зааглаж байсан сул шүргэх гийгүүлэгч буюу амисхалын түрэлт хэвээр хадгалагдаж байсаныг гэрчилж байна.

Үүсмэл урт эгшигийн гаралын талаар монгол хэлний судалалд олон жилийн турш баримталсаар ирсэн гол саналыг профессор G. J. Ramstedt анх үндэслэжээ. Тэрвээр монгол хэлний урт эгшигийн гаралыг монгол бичигийн хэлний хоёр

---

646 А. А. Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, 12
647 А. А. Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, 14

эгшигийн хоорондох *-γ/g-* гийгүүлэгчээр баримжаа болгон: *'Бичигийн хэлэнд хоёр эгшигийн хоорондоо олонтаа тохиолддог -γ/g-гийн хоёр талын эгшигүүд нь өдгөөгийн монгол хэл аялгуунуудад өөр хоорондоо нийлж нэгэн урт эгшиг болсон байна'*[648] гэж дурдсан нь угтаа хоёр эгшигийн хоорондоос сугарсан ***γ/g***-гийн хоёр талын эгшигүүд нийлж, нэгэн урт эгшиг үүссэн гэсэн санаа юм. Тэрвээр цааш нь: *'Энэ нь зөвхөн шүргэх γ, хамжих g авианы ялгаа төдийгүй, бас өргөлтийнхөө талаар ч ялгаатай байсан байж магадгүй юм. Үүнтэй холбогдуулан монгол-чуудын ном унших уламжилалт аргын талаар энд зориуд дурдмаар байна'*[649] гээд *dayaqu* 'дагах' // *dayaqu* 'даах'; *unaya* 'унага' // *unaya* 'унаа' гэх мэт адил бичлэгтэй боловч өөр дуудлага, өөр утгатай хэд хэдэн жишээг эш татсан нь байна. Энэ нь угтаа монгол бичигийн хэлний хоёр эгшигийн хоорондох *-γ/-g-*гийн арын эгшиг нь уулаас өргөлттэй байсан байж магадгүй гэсэн таамаг юм.

Академич Б. Я. Владимирцов хоёр эгшигийн дундах гийгүүлэгчийн хоёр талын эгшиг нийлж нэг урт эгшиг болсон гэдэг дээрхи онолыг цаашид улам дэлгэрүүлэн халхын аялгууны урт эгшигийн гаралыг монгол бичигийн хэлний хэд хэдэн өөр цогцтой харьцуулан авч үзжээ. Үүнд:

1. V + **γ** ~ **g** ~ **y** + V гэсэн цогцоос үүссэн урт эгшиг
2. *V + **w** +V гэсэн цогцоос үүссэн урт эгшиг
3. ***V** + **n** + **V*** гэсэн цогцоос үүссэн урт эгшиг
4. *Хагас урт эгшиг*-ээс үүссэн урт эгшиг
5. *V + w гэсэн цогцоос үүссэн урт эгшиг
6. *Ерийн богино эгшиг*-ээс үүссэн урт эгшиг
7. **i**-*ээр төгөссөн хос эгшиг*-ээс үүссэн урт эгшиг
8. ***uva*** гэсэн цогцоос үүссэн урт эгшиг

Тэрвээр монгол бичигийн хэлний VCV гэсэн цогцын доторхи *-γ/g-* зэрэг гийгүүлэгчид бүр XIII зуунаас өмнө сугарч, уламаар уул сугарсан гийгүүлэгчийн хоёр талын богино эгшигүүд нь өөр хоорондоо нийлж, өдгөөгийн монгол хэл аялгуунуудын урт эгшиг үүссэн гэж үзжээ.[650] Хожим профессор Г. Д. Санжеев академич Б. Я. Владимирцовын дээрхи саналыг баримтлан: *'Монгол хэлнүүдийн урт эгшиг нь ихэнхидээ хоёр эгшигийн хоорондох γ, g, y зэрэг шүргэх гийгүүлэгч, бас хаяа w гийгүүлэгч сугарсаны уламаас ... үүссэн болох нь тодорхой байна. Хоёр эгшигийн хоорондох γ, g, y, w гийгүүлэгчид XII-XIII зууны орчимд шүргэх h болж ... XIII-XIV зууны орчим уул h нь сугарч эгшиг + эгшиг гэсэн хоёр үе буй болоод XIV-XV зууны үед тэдгээр нь маш богино хугацаанд хоорондоо нийлж нэгэн үе болжээ'* гэж тэмдэглэсэн байна.[651] Ийнхүү хоёр богино эгшигийн хоорондох ***γ, g*** гийгүүлэгч сугарсаны уламаас урт эгшиг үүссэн гэдэг энэ саналыг профессор N.

---

[648] Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, 20

[649] ibid., 24

[650] Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 193

[651] Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, 77-78

Poppe[652] нэгэн үе баримталж байсанаас гадна халимагийн эрдэмтэн Номинхааны Цэрэндорж, Н. Н. Убушаев, П. Ц. Биткеев, Н. К. Верба нар бүрэн дэмжиж байжээ.[653] Мөн N. Poppe, K. Thomsen, H. Kuribayashi нар монгол бичигийн хэлний ***иуа, йge*** гэсэн цогц болон түүний цаашдын хувьсалын талаар тусхайлан судалсан нь урт эгшигийн гаралтай шууд холбоотой юм.[654]

Өнгөрсөн зууны тавиад оны сүүлээр профессор Sh. Hattori монгол хэлний урт эгшигийн гаралын талаар цоо шинэ, сонирхолтой саналыг дэвшүүлжээ. Тэрвээр *'Өвөг монгол хэлний урт эгшиг'* (1959) гэдэг үгүүлэлдээ: *'Орчин цагийн монгол хэл аялгуунуудын урт эгшиг хийгээд* /VV/, /VgV/ *гэсэн цогцуудын аль аль нь монгол бичигийн хэлний* VγV, VgV-*тэй тохирч байна. Хэрэв бидний бодсончилон монгол бичигийн хэлний дүрэм нь тухайн хэлний хөгжилийн эртний үеийг тусхасан бол орчин цагийн монгол хэлний* VV, VgV *хоёрын ялгааг тайлбарлаж болно. Эртний монгол хэлэнд дэлбэрэх* [**G**], [**g**], *сул шүргэх* [**ʁ**] *гэсэн дуутай, хэлний угийн хоёр өвр авиа байжээ гэсэн таамаглалыг миний бие анх 1939 онд дэвшүүлэн гаргасан билээ. Дээр дурдсан хоёр өвр гийгүүлэгчийн эхнийх нь одоо хүртэл хадгалагдаж байгаа бөгөөд сүүлчийнх нь сугарч хоёр талын эгшигүүд нь нийлж нэгэн урт эгшиг болсон байна. ...Дурдсан цогцуудын янз бүрээр хувьсан хөгжсөн учир шалтгаан нь /***g**/-гийн дараа шууд залган орсон эгшигийн урт богинотой холбоотой гэж үзэх нь зүйтэй мэт санагдана. Ер үгийн дэд үе болон түүнээс хойшхи үед орсон урт эгшигүүд нь мөн адил байранд тохиолдож байсан богино эгшигээсээ илүү хүчтэй, тод хэлэгддэг байсан тул тэдгээр нь өмнө талынхаа гийгүүлэгчийг суларуулахад хүргэсэн байна'*[655] гэжээ. Профессор Hattori-ийн дээрхи үгүүлэл гарсан яг тэр жил N. Poppe *'Монгол хэлний хоёр эгшигийн хоорондох тагнайн хамжих гийгүүлэгч'* гэдэг үгүүлэл нийтлүүлж, түүндээ: *'Монгол бичигийн хэлний хоёр эгшигийн хооронд байсан* ***γ*** *(эр үгийн),* ***g*** *(эм үгийн) хоёр нь орчин цагийн ярианы хэлэнд сугарч үгүй болсон нь тодорхой мэдэгдэж байгаа билээ... Монгол бичигийн хэлний хоёр эгшигийн хооронд байсан бүх* ***γ, g*** *нь аман ярианы хэлэнд сугарч үгүй болсон гэж үзвэл буруу болно. Аман ярианы хэлэнд хоёр эгшигийн хоорондох *****γ/g*** *нь гээгдсэн ба гээгдээгүй байгаа ярианы хэлний жишээг бичигийн хэлнийхтэй жишиж үзвэл, урт эгшигийн өмнөх ****g*** *нь сугараад, богино эгшигийн өмнөх ****g*** *нь сугараагүй үлджээ гэсэн дүгнэлтэнд хүрчээ. ...Үүнээс авч үзвэл, дурдсан гийгүүлэгчийн сугарсан,*

---

652 N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 59-68

653 Ц. Д. Номинханов, К вопросу об общих законах развития долгих гласных в тюркских и монгольских языках, Уч. зап. КНИИЯЛИ, Вып. 3, Сер. филол. Элиста, 1964, 92-100; Н. Н. Убушаев, О возникновении долгих гласных в монгольских языках, *'Лингвогеография, диалектология и история языка'*, Кишинев, 1973, 232-237; П. Ц. Биткеев, Квантитативные изменения гласных в монгольских языках, *'Материалы по истории и филологии Центральной Азии'*, Вып. 5, 1970, 41-51; Н. К. Верба, Древнемонгольский комплекс с интервокальным согласным и его эквиваленты в современных монгольских языках, Автореферат. канд. дисс. М.,1978, 27 стр.

654 N. Poppe, The Groups **uya* and **üge* in Mongol Languages, SO 14:8 (1950), 3-15; K. Thomsen, Entwicklung der Gruppe **uya (*üge*) im Mongolischen, AOH 23 (1958), 263-267; H. Kuribayashi, The Development of **uya* and **üge* in Mongolian, JLSJ 85 (1985), 22-48 (япон хэлээр)

655 Sh. Hattori, The Length of Vowels in Proto Mongolian, *'Mongolian Studies'*, 1970, 183

сугараагүйн учир нь зөвхөн дараах эгшигийнхээ урт богиноос шууд шалтгаалдаг байна'[656] гэж дурдсан нь уттаа Sh. Hattori-ийн дэвшүүлсэн саналтай адилхан байгааг ажиглаж болно.

Мөн профессор M. Nomura 1959 онд нийтлүүлсэн *'Монгор хэлний урт эгшиг ба өвөг монгол хэлэнд урт эгшиг байсан байх боломжийн тухай'* гэсэн үгүүлэлдээ дээрхи хоёр эрдэмтэнтэй тун төстэй санал дэвшүүлсэн нь бүр ч сонирхолтой байна. Тэрвээр: *'Монгор аялгуу нь хитад ханз үсэгээр галигласан Монголын нууц товчооны үеийн хэлийг тусхасан уу, түүнээс ч бүр эрт (наад зах нь X зуун) уйгур үсэгээр тэмдэглэсэн монгол бичигийн хэлний үеийг тусхасан уу,* VγV > V'V > V: *гэсэн авианы хувьсал явагдахаас өмнөх үеийн эгшиг фонемуудын нийлцийн зарим ул мөр буюу тухайлвал, өвөг монгол хэлний урт эгшигийн байдалыг тусхасан уу гэдэг таамаглалын алийг нь ч одоогоор бүрэн тогтооож чадаагүй байна.'* хэмээн тэмдэглээд цааш нь өвөг монгол болон өвөг түрэг хэлэнд фонемийн үүрэгтэй урт эгшиг байсан байх гэсэн таамаглалыг дэвшүүлжээ.[657] Тэрвээр өвөг монгол хэлний урт эгшигийг сэргээн тогтоохтой холбогдсон хэд хэдэн цуварал үгүүлэл нийтлүүлсэн бий.[658] Таширамд дурдахад, дээрхи гурван эрдэмтэн монгол хэлний урт эгшигийн гаралын талаархи үгүүлэлээ яг нэг жил, нэгэн зэрэг нийтлүүлсэн тул бие биеийнхээ санааг тусхасан байх магадлал нэн бага билээ.

Хожим академич Ш. Лувсанвандан '*Орчин цагийн хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд'* гэдэг үгүүлэлдээ эртний монгол хэлний урт эгшигийн гаралын талаар *'Хуучин монгол бичгийн хэлний зөв бичих дүрэмд өргөлт буюу эгшгийн уртыг заасан ямар ч тэмдэг байхгүй байгаагаас үзэхэд анх уйгуржин монгол үсгийг зохион хэрэглэх тэр үед биеэ даасан урт эгшиг фонем байгаагүй, харин тэргүүн бус үед тохиолдох үг, морфемын утга ялгах өргөлт (супрасегментная фонема буюу (secondary phoneme) байсан байж магадгүй гэж таамаглаж болно. Тийм өргөлт тохиолдсон эгшиг нь ерийн богино эгшгээс арай урт сонсогдож байсан байж болох юм. Гэвч ингэж өргөлтөөс болж бяцхан сунжирч хэлэгдэх эгшиг нь биеэ даасан урт эгшиг фонем болоогүй, тухайн богино эгшиг фонемийн хувилбар (аллофон) төдий байсан байж таарна. Жишээ нь: dayaqu > dayáqu; egekü > egékü гэх мэт. Энэ үед монгол бичгийн хэлний* ***aya, ege*** *мэтийн нийлбэрт багтсан авианууд нь цөм биеэ дааж фонемын үүрэг гүйцэтгэж байсан байх гэж*

---

656 N. Poppe, The Primary Long Vowels in Mongolian, JSFOu. 63:2 (1962), 4-6; On the Velar Stops in Intervocalic Position in Mongolian, UAJb 31 (1959), 271

657 M. Nomura, Long Vowels in Monguor and the Possible Existance of Long Vowels in Proto-Mongol, *'Collection of Articles in Commemoration of the 10th Anniversary of the Faculty of Letters'*, Nagoya University, 1959 (япон хэлээр)

658 M. Nomura, On Long Vowels in Monguor Dialect and the Reconstruction of Long Vowel Phonemes in Proto-Mongolian, MFL NU 37, 1965, 1-40; On Long Vowels in Monguor Dialect and Reconstruction of Long Vowel Phonemes in Proto Mongolian, *'Memoirs of the Research Department of the Toyo-Bunko'*, 18, 77-89; On Long Vowels Reconstructed in Roots or in the First Syllable of Primary Stems, MFL NU 67 (1968), 483-489; On Long Vowels Reconstructed in the Second Syllable of Stems, MFL NU 60 (1966), 1-9; idem. Long Vowels Reconstructed in the Word-formative Elements, MFL NU 52 (1971), 1-30 (япон хэлээр)

бодож байна. ...Цаашид дурдсан өргөлтөт үеийн эгшиг сунжирч урт хэлэгдэх нь хэвшин хэвшсээр тогтвортой урт эгшиг болж, үг, морфемын утга ялгах гол үүрэг нь өргөлтөөс урт эгшигт шилжиж монгол хэлэнд биеэ даасан урт эгшиг фонем үүссэн байх гэж бодож байна. Өөрөөр хэлвэл, эртний монгол хэлний үг, морфемын утга ялгаж байсан өргөлт нь урт эгшигт шилжссэн байж болно.[659] гэжээ. Лувсанвандан багш энэ үгүүлэлдээ урт үүссэн шалтгааныг *'утга ялгах өргөлт'*-өөр тайлбарласан нь монгол хэлний урт эгшигийн гаралын тухай онолыг нэг шат урагш ахиулсан гэж үзэж болно. Үүнтэй холбогдуулан нэрт түрэгч эрдэмтэн J. Nemeth бүр XX зууны эхээр якут хэлний өргөлтөт эгшигээс урт эгшиг үүсссэн тухай тэмдэглэж байсаныг[660] дурдмаар байна.

Наяад оны оны эхээр проф. Д. Төмөртогоо нэг талаас, өмнөх эрдэмтэдийн судалгаа, нөгөө талаас, дундад үеийн монгол хэлний авианы харилцан нөлөөлөлийг харгалзан өргөлтөөс үүссэн урт эгшиг болон түүний авианы орчины талаар: *'Эртний монгол хэлний* C (= *γ, g, b, y*) + V *гэсэн үеийн доторхи эгшигүүд нь уулаасаа үг, морфемийн утга ялгах өргөлттэй байсанаа, барагцаалвал, дундад үеийн монгол хэлний эхэн үеэс уул өргөлтөт эгшигүүд нь сунжиран, уламаар биеэ даасан урт эгшиг болсон байна. Тийнхүү шинэ дутам үүсэн бүрэлдсэн урт эгшигийн шууд нөлөөгөөр өмнө талын гийгүүлэгчид нь суларан суларсаар утга ялгах фонемийн үүрэгээ алдаж, уламаар бүрмөсөн сугарчээ. Хэрэв хоёр эгшигийн хоорондох* ***-γ-, -g-, -b-, -y-****гийн арын эгшигүүд нь урт болоогүй байсан бол тэдгээрийн өмнө талын шүргэх гийгүүлэгчид суларан сугарах авианы орчин бүрэлдэхгүй байсан'*[661] хэмээн дурдаад цааш нь *'... Ер монгол бичигийн хэлний* V + C + V *гэсэн энэхүү бүтэцийн доторхи эхний эгшиг нь дараах үеийнхээ эгшигийг сунжиран урт болоход ч, арынхаа гийгүүлэгчийг сугаран гээгдэхэд ч огт нөлөөлөөгүй учир бид түүнийг* C*V гэсэн бүтэцтэй арынх нь үетэй хамт нэгэн цогц болгон үзэх үндэсгүй гэж үзэж байна. Тийнхүү урт эгшигийн үүсэлд огт холбогдолгүй эхнийх нь эгшигийг хасвал* C (= *γ, g, y, b, y*+ V) *гэсэн үе хэвээрээ үлдэх болно'*[662] гэжээ. Энэ нь бүр G. Ramstedt-ийн үеэс Б. Владимирцов, Г. Санжеевийг дамжин эдүгээ хүртэл *'монгол хэлний урт эгшиг* V + C + V *гэсэн салшгүй нэгэн цогцоос үүссэн'* гэдэг онолыг хатуу баримталсаар ирсэнийг үгүйсгэж, үүсмэл урт эгшиг нь V + C + V гэсэн цогцоос үүссэн биш, өмнөө богино эгшигтэй C + V-гийн дотор үүссэн гэсэн санааг дэвшүүлсэн хэрэг юм. Тодоруулан хэлвэл, үүсмэл урт эгшиг бүрэлдэхэд V + C + V-ийн өмнө талын богино эгшигийн оролцоо огт байхгүй, түүний арын гийгүүлэгч ч оролцоогүй, харин сүүлчийн өргөлтөт эгшиг нь өөрөө сунжиран сунжирсаар өөрөө л урт болсон гэсэн үг. Харин уул үүсмэл урт эгшигийн өмнө талын шүргэх гийгүүлэгч, түүний өмнөх богино эгшиг нь урт эгшиг үүсэн бүрдэх гадаад нөхцөлийг бүрдүүлсэн тогтвортой орчин буюу *'хэвлий'* нь юм.

---

659 Ш. Лувсанвандан, Орчин цагийн хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд, ХЗ 4,1967, 21-22

660 J. Nemet, Die Langen Vokale im Jakutischen, KSz XV, Budapest, 1914-1915, 163-164

661 Д. Төмөртогоо, Орчин цагийн монгол хэлний урт эгшигийн гарал, хувьсал, *'Монгол хэл шинжилэлийн онол, түүхийн асуудалууд'*, Уб., 2002, 78-79 // Монгол хэлний түүхэн хэлшинжилэлийн судалгаа, Уб., 2017, 186-201

662 ibid.,78 // 196

Монгол хэлний урт эгшиг үүсэн бүрэлдсэн цаг хугацааны хувид эрдэмтэд харилцан адилгүй саналтай байна. Тухайлвал, акад. Б. Я. Владимирцов энэ талаар *'...маш эрт цагт, ямар ч гэсэн Чингисийн эзэнтулс үүсэн тогтохоос өмнө γ, g гэх мэт шүргэх гийгүүлэгчид нь ихэнхидээ сугарч, уламаар хоёр талынх нь эгшиг өөр хоорондоо нийлэн нэгэн урт эгшиг болсон байна'* гэжээ.[663] Хожим акад. Ш. Лувсанвандан эртний монгол хэлний үеэс дундад үеийн монгол хэлэнд шилжих үе буюу тухайлвал, X зууны эцэсээр утга ялгах өргөлтөт эгшигээс урт эгшиг үүссэн гэж үзсэн нь[664] өмнө дурдсан хугацаатай харьцангуй ойролцоо байна. Харин профессор Sh. Hattori хоёр эгшигийн хоорондох шүргэх /ʁ/-гийн арын эгшиг нь бүр өвөг монгол хэлний үед уртаар дуудагдаж байсан гэж дурдсан нь угтаа түүнийг анхдагч урт эгшиг гэж үзсэнтэй адил хэрэг юм.[665] Гэтэл профессор Г. Д. Санжеев бүр хожим XIV-XV зууны үед урт эгшиг үүссэн гэж үзсэн байна.[666]

Монгол хэлний урт эгшигийн гарал үүсэлийн талаар гарсан дээрхи саналуудыг багцлан үзвэл доор дурдсан чиглэлтэй байна. Үүнд:

1. Монгол бичигийн хэлний V+ *γ/g* +V гэсэн цогцын доторхи гийгүүлэгч нь сугарч, уламаар уул сугарсан гийгүүлэгчийн хоёр талын богино эгшигүүд нийлж, нэгэн урт эгшиг болсон гэж G. J. Ramstedt, Б. Я. Владимирцов, Г. Д. Санжеев нар үзсэн байна.

2. Монгол бичигийн хэлний V+ *γ/g* +V гэсэн цогцын доторхи гийгүүлэгчийн арын эгшиг нь уулаасаа өргөлттэй байсан байх гэсэн саналыг анх G. J. Ramstedt гаргасан бөгөөд хожим академич Ш. Лувсанвандан уул эгшигийг *'утга ялгах өргөлттэй эгшиг'* байсан гэж лавшируулан тайлбарлажээ.

3. Монгол бичигийн хэлний V+ γ/g+V гэсэн цогцын доторхи гийгүүлэгчийн арын эгшиг нь уулаас урт байсан гэсэн саналыг анх проф. Sh. Hattori гаргасан бөгөөд уул саналыг N. Poppe, M. Nomura нар дэмжсэн байна.

4. Монгол бичигийн хэлний V+ γ/g +V гэсэн цогцын доторхи төвөнхийн гийгүүлэгч нь арынхаа эгшигтэй нийлж нэгэн урт эгшиг болсон гэж А. А. Бобровников үзсэн байна.

5. Монгол хэлний үүсмэл урт эгшиг нь V+ γ/g +V гэсэн цогцоос үүссэн бус, харин *'өмнөө богино эгшигтэй шүргэх γ/g-ийн арын өргөлтөт эгшигээс үүссэн'* гэж профессор Д. Төмөртогоо үзжээ.[667]

---

[663] Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 193

[664] Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд, 22

[665] Sh. Hattori, The Length of Vowels in Proto Mongolian, *'Mongolian Studies'*, 1970, 183

[666] Г. Д.Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, 78

[667] Д. Төмөртогоо, Монгол хэлний түүхэн хэл зүй, Уб., 1992, 84

Үүсмэл урт эгшигийн тухай нэмэлт тэмдэглэл. Монгол хэлний урт эгшиг үүсэн бүрэлдсэн нь нийт эгшиг авианы ерөнхий тогтолцоонд үлэмжхэн өөрчилөлт гаргасан төдийгүй, үг, морфемийн бүтэцэнд ч зохих өөрчилөлт гаргахад хүргэсэн авианы түүхэн хувьсал юм. G. J. Ramstedt, Б. Я. Владимирцов, Г. Д. Санжеев, N. Ропре зэрэг эрдэмтэд[668] үүсмэл урт эгшигийн гаралын талаар авч үзэхдээ монгол бичигийн хэлний **VCV** гэсэн салшгүй нэгэн цогцын дотор үүссэн тухай нэгэн дуугаар тэмдэглэжээ. Хожим K. Thomsen, Н. К. Верба, H. Kuribayashi нар эртний монгол хэлний ***иуа/üge***-гийн цаашдын хувьсалын талаар бичсэн нь[669] угтаа мөн л **VCV** гэсэн цогцын тухай асуудал юм. Тэдгээр эрдэмтэд үгийн дундаас сугарсан гийгүүлэгчийн хоёр талын богино эгшигийн нийлбэрээс урт эгшиг үүссэн гэж үзэж байсан учир түүнийг гагцхүү VCV-тэй холбон тайлбарлахаас ч өөр арга байсангүй.

Хэрэв хоёр богино эгшигийн дундаас гийгүүлэгч сугарсан бол тэр нь авианы харилцан нөлөөлөлийн хуулийн дагуу чухам ямар авианы нөлөөгөөр суларан сугарсан бэ гэдэг асуудал зүй ёсоор гарч ирнэ. Гэтэл авианы харилцан нөлөөлөлийн үүднээс авч үзвэл хоёр богино эгшигийн дундаас гийгүүлэгч сугарах ямар ч боломжгүй юм. Харин профессор Sh. Hattori, N. Poppe, Ш. Лувсанвандан нарын үзсэнчилэн хоёр эгшигийн хоорондох ***γ, g*** гийгүүлэгч нь шүргэх шинжтэй байгаад түүний арын эгшиг нь уулаасаа өргөлттэй буюу урт байсан бол уул гийгүүлэгч нь арынхаа эгшигийн нөлөөгөөр суларан сугарах бүрэн боломжтой. VCV гэсэн бүтэцийн дотор гарсан хувьсалын дараалалыг ерөнхийд нь тодорхойлвол, *'гийгүүлэгч сугарсан учираас түүний хоёр талын богино эгшигүүд нийлж нэг урт эгшиг үүссэн'* биш, харин *'урт эгшиг үүссэн учираас түүний өмнөх шүргэх гийгүүлэгч суларан сугарсан'* хэрэг болно. Нөгөө талаар, ***аγа/ege, аγи/egü*** гэх мэт бүтэцэн дэх эхний эгшиг нь арынхаа гийгүүлэгчийг суларан сугарахад нөлөөлөөгүй, дундах ***γ, g*** гийгүүлэгч нь дараах эгшигээ сунжиран урт болоход ч бас нөлөөлөөгүй учир тэдгээрийг хамтад нь салшгүй нэгэн *'цогц'* байсан гэж үзэх ямар ч үндэсгүй байна. Тэрхүү VCV-г авиа зүйн түвшинд авч үзвэл, эхнийх нь дан эгшиг (өмнөө гийгүүлэгчтэй байж ч болно. Д.Т), дараа нь CV гэсэн үе (ардаа гийгүүлэгчтэй байж ч болно. Д.Т) хоёроос бүрдэж байна. Тийм учираас үүсмэл урт эгшигийн нөлөөлөлөөр суларан сугарсан ***γ, g*** гийгүүлэгчийн тухай асуудал нь урт эгшигийн үүсэлд ямар ч холбогдолгүй, цэвэр гийгүүлэгч авианы суларалын тухай асуудал юм

---

668 Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка, 22; Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменногоязыка, 193; Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, 77-78; N. Poppe, Introduction to Comparative Studies, Helsinki, 1955, 60

669 K. Thomsen, Entwicklung der Gruppe ****иγа** (*üge)* im Mongolischen, AOH 23, 1958, 263-267; Н. К. Верба, Монгольские письменные сочетания ***V + j + i*** и репрезентация в современных монгольских языках, *'Вопросы грамматической системы монгольских языков'*, Элиста, 1980, 40-52; H. Kuribayashi, The Development of ****иγа** and ***üge*** in Mongolian, JLSJ. 85 (1985), 22-48

Эцэст нь дүгнэж хэлвэл, монгол хэлний урт эгшиг нь VCV гэсэн цогцоос үүсээгүй, гэвч бас дурын байрлалд ч үүсээгүй, гагцхүү *'өмнөө богино эгшигтэй шүргэх γ/g-ийн арын өргөлтөт эгшигээс үүссэн'* байна. Авианы орчины талаас авч үзвэл, богино эгшигийн дараа орсон CV гэсэн үе (шүргэх *γ, g* + өргөлтөт эгшиг)-ийн дотор үүссэн байгаа бөгөөд ийм байранд үүссэн урт эгшиг нийт үүсмэл урт эгшигийн 90 гаруй хувийг эзэлж байна.

1.3.1.2.1 **Өргөлтөт эгшигээс үүссэн урт эгшиг**

§ 81. *Өргөлтөөс үүссэн урт эгшиг*. Орчин цагийн монгол хэл аялгуунуудын зонхилох урт эгшигүүд нь бүр өвөг монгол хэлний үед байсан утга ялгах өргөлтөөс үүсчээ. Ер бидний үед уламжилан үлдсэн бичигийн дурсхалуудын хэлээр үндэсэн шинж нь бараг төлөв мэдэгдэж байгаа эртний монгол хэлний сүүлч болон дундад үеийн монгол хэлний үед өргөлтөөрөө утга ялгаж байсан тодорхой жишээ баримт мэдэгдэхгүй байна. Хэдий тийм боловч богино эгшигтэйгээ эсэрэгцэлдэн утга ялгаж байгаа орчин үеийн монгол хэл аялгууны урт эгшиг нь угтаа өвөг монгол хэлний утга ялгах өргөлтөт эгшигээс гаралтай гэдгийг үгүйсгэх аргагүй.

Таширамд дурдахад, өдгөөгийн түрэг хэлнүүдэд өргөлтөт эгшигээс үүссэн урт эгшиг байдаг тухай J. Nemeth, L. Ligeti, T. Tekin, A. M. Щербак нар удаа дараалан дурдсан байна.

Өвөг монгол хэлний үед утга ялгах өргөлттэй байсан эгшигүүд нь хэлний урт удаан түүхэн хөгжилийн явцад сунжирсаар, барагцаалвал, эртний монгол хэлний сүүлч үеэс биеэ даасан урт эгшиг болж, урид өргөлттэй,өргөлтгүйгээрээ утга ялгаж байсан эгшигүүд нь урт богиноороо эсэрэгцэлдэн утга ялгах болсон байна.

1.3.1.2.1.1 **Өргөлтөт эр эгшигээс үүссэн урт эгшиг**

(а) *γa* гэсэн бүтэцтэй үеийн дотор үүссэн урт эгшиг

PM *a + *γa > AM a + γā > MM a + hā > a + 'ā > ā

PM **qaγan* 'хаан', AM *qaγān* Precl. (= Bod, Chang, Mön.); MM *qahān* (MNT, KMQB.), *qa'ān* (MNT, Tk, D, Ist.), *qān* [< qa'ān] (Tk, Mu, L.); CM *χān* (SY, Oir, Bur, TMon, ÖMon.), *χān* (Ha, Ord, Kha.)

PM **čaγaγan* 'цагаан', AM *čaγaγān* Precl. (= Bod.); MM *čaγa'ān* (MNT), *čaqa'ān* (D.), *čaγān* [< čaγa'ān] (Mu, IM.); CM *tšağān* (ÖMon.), *tsağān* (Kalm, Oir, TMon.), *sağān* (Bur, ÖMon. /= Dörb, Gor, Jal, Khor./), *tšiğan* (Mngr, Dag.), *tšiğaŋ* (Dun.), *tšeğān* (SY.)

PM **ǰayaγan* 'заяа', AM *ǰayaγān* Precl. (= Chang, Jig, Hin, Bod.); MM *ǰaya'ān* < ǰayahān] (MNT, KMQB.), *ǰayān* [< ǰaya'ān] (KMQB, Ph.); CM *džayān* (ÖMon.), *dzayā* (Oir, TMon.), *zayā* (Kalm, Bur.), *džiäyān* (Mngr.), *džiyā* (Dag, Ord.), *džān* (SY.)

PM *i + *γá > AM I+ γā > i + yā > MM i + 'ā > a'ā > CM ā

PM *atïγán 'ачаа', AM *ačiγān > ačiyān* (Mo.); MM *ačiyā* (Ist.), *ači'ā* (MNT, Mu, IM.) > *ači'ān > ača'ān* (KMQB.) > *ači'ā > ača'ā > ačā* (Mu, IM.); CM *ačiyā* (Man. L. Ligeti, AOH XIV:1, 15), *ačān* (SY.), *atšā* (TMon, ÖMon.), *atsān* (Kalm, Oir.), *ašā* (Bur.)

PM *tariyan 'тариа', AM tariyān* Precl. (= Sub.), *tariyān* Precl. (= Bod, Aruγ, Hin, Bur.); MM *tariyān* (MNT), *tari'ān* (Mu, IM.), *tarān* [< tara'ān < tari'ān] (L.); CM *tarjā* (Bur.), *tariā* (TMon.), *tarā* (Učab, Šgol.), *tarān* (SY, Kalm, Oir. /= Dör, Tor./*tarā* (Mngr, ÖMon./= Barin, Tüm, Khar, Urad, Naim./)

*PM *ǰïγa* 'заа-', AM *ǰiyā-* Precl. (= Chang, Hin, Taq.); MM *ǰi'ā-* [< ǰiyā-] (MNT), *ǰa'ā-* (KMQB, Hy, Mu.); *ǰā-* (Mu.); CM *dž'iā-* (Mngr.), *džā-* (Dag, Bao, ÖMon.), *dzā-* (TMon, Oir.), *zā-* (Bur, Kalm.)

PM *o + *γa > AM o + γā > MM o + wā > o + 'ā

PM *γoγa 'гоо'; AM *γoγā/*γobā*, MM *γowā* Precl. (= Bur.), *γo'ā* (MNT, Mu.); CM *ǧō* (Kalm, Oir, Bur, TMön.)

PM *toγan 'тоо', AM toγān* Precl. (= Jig, Sul, Teh.); MM *to'ān* (KMQB, Mu.), *to'ā* (MNT, KMQB, TK.); CM *toa* (Mog.), *toā* (Oir.)

PM *qoγasun 'хоосон', AM qoγōsun* [< qoγāsun] Precl. (= Bod, Bur, Sub.); MM *qo'ōsun* [< qo'āsun] (MNT, KMQB)

PM *u + *γa > AM u + γā > MM u + wā > u + 'ā

PM *noγuγan 'ногоон', AM noγuγān* Precl. (= Bur.); MM *noγo'ān* [< noγuγān] (MNT, Hy, Tk.), *noγān* [< noγa'ān] (Mu. L.); CM *noǧān* (Kalm, Oir.)

PM *daluγan 'долоо', AM doluγān* Precl. (= Bod, Hin, Chang, Taq.); MM *dolo'ān* [< dolu'ān] (MNT, KMQB, Tk.), *dolān* [< dola'ān] (Mu, IM, Ist.); CM *dolān* (Kalm, Oir.)

AM *ǰiryuγān* 'зургаа', Precl. (= Bod, Aruγ, Hin, Bur.); MM *ǰiryu'ān* (Mu.), *ǰiryo'ān* [< ǰiryu'ān] (MNT, Ph.), *ǰiryān* [< ǰirya'ān] (Mu. L.); CM *džurǧān* (ÖMon.), *dzurǧān* (TMon.)

(b) ***γu*** гэсэн бүтэцтэй үеийн дотор үүссэн урт эгшиг

PM *a + *γu > AM u + γū > MM u + wā > u + 'ā

PM *ayula 'уул', AM ayūla* Precl. (= Manǰ.); MM *a'ūla* [< awūla] (MNT, Hy, D, Mu, IM, L.); *aula* (Mar. /L. Ligeti, AOH IV:1-3, 140/), Zir, Dag.), *aule* (But.), *aūl* (Kul.), *oula* (Leech. Kun.)

PM **tïlaγun* 'чулуу', AM *čilaγūn* Precl. (= Sub.); MM *čilawūn* (MNT, KMQB.), *čila'ūn* (MNT, Hy, Ph.); CM *tšilū* (SY, Ord, Kham.), *tšulū* (Oir, TMon, ÖMon.)

PM **daγun* 'дуу', AM *daγūn* Precl. (= Bod, Chang, Bur.); MM *dawūn* (Hy.), *dawū* (KMQB.), *da'ūn* (MNT, Mu.), *da'ū* (MNT, IM.), CM *daūn* (Zir.), *daun* (Her.), *daŭn* (Mog.), *dau* (Dag.), *dūn* (SY, Kalm.), *dū* (Oir, Bur, TMon.)

PM *ï + *γu > AM i + γū > MM i + yū > i + 'ū

PM **arïγun* 'ариун', AM *ariγūn* Precl. (= Hin, Jig, Ar.); MM *ariγūn* (Mu.), *ari'ūn* (Hy, Mu, IM.), *arūn* [< aru'ūn < ari'ūn] (Ist.); CM *arjūn* (Bur.), *ariūn* (TMon.), *arūn* (Zir, Dag, Ord.)

PM **γasïγun* 'гашуун', AM *yasiγūn* Precl. (= Bur.); MM *yasi'ūn* (MNT, KMQB.), *yašūn* [< γašu'ūn < γaši'ūn] (Mu.), *qašūn* (St, IM.); CM *ğašūn* (Mog, Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.)

PM **qarïγu* 'харуу', AM *qariγū* Precl. (= Γas, Alt.); MM *qariγū* (Mu.), *qari'ū* (Mu.), *qarū* [< qaru'ū< qari'ū] (Mu.); CM *χarjū* (Bur.), *χariū* (TMon.), *χarū* (AKhor, Cha.)

PM *u + *γu > AM u + γū > MM u + wū > u + 'ū > 'ū

PM **aduγusun* 'адуус', AM *aduγūsun* Precl. (= Bod, Taq, CTB, Sub.); MM *adu'ūsun* (MNT, D, Mu.), *adūsun* (KMQB, Mu.); CM *adūsʊn* (Kalm.), *adūhan* (Bur.)

PM **quruγun* 'хуруу', AM *quruγūn* Precl. (= Sub.); MM *quru'ūn* (MNT, Hy, TK, Ist.), *qurūn* [< quru'ūn] (Mu, L.); CM *qurūn* (Mog.), *χurūn* (ÖMon.), *χurū* (TMon, Ord.)

PM **furuγul* 'уруул', AM **χuruγūl, uruγūl* (Mo.); MM *hurūl* [< huru'ūl] (HY, Mu, IM, L, Ist.); CM *urūl* (TMon, ÖMon.)

(c) *ÿï* гэсэн бүтэцтэй үеийн дотор үүссэн урт эгшиг

PM *a + ÿï > AM a + ÿi > a + yī > MM a + yī > a + ’ī

PM **ayïl* ‘айл’, AM *ayīl* [< *aÿil] Precl. (= Turf.1); MM *ayīl* (MNT, Hy, D, Mu. IM, L, Ist.)

PM **sayïn* ‘сайн’, AM *sayīn* [< saÿīn] Precl. (= Bod, Chang, Ölj, Bur.); MM *sayīn* (MNT, KMQB, D, Mu, IM, L, Ist.)

PM **qayïti* ‘хайч’, AM *qayīči* [< qaÿīči] (Mo.); MM *qayīči* (MNT)

PM *o + ÿï > AM o + ÿī > o + yī > MM o + yī > o +’ī

PM **oyïra* ‘ойр’, AM *oyīra* [< oÿīra] (Precl. (Hin, Bur, Sub.); MM *oyīra* (MNT, KMQB, Mu, IM.), *oira* [< o’īra] (Mu, L, Ist.)

PM **qoyïna* ‘хойно’, AM *qoyīna* [< *qoÿīna] Precl. (= Bod, Hin, Ar, Taq.); MM *qoyīna* (MNT, KMQB, Mu.), *qoīna* [< qo’īna] (L.)

PM *u + *ÿï > AM u + ÿīn > u + yīn > MM u + yī > u + ’ī

PM **uyïla-* ‘уйл-’, AM *uyīla-* [< uÿīla-] Precl. (= Taq, Bur.); MM *uyīla-* (MNT), *uīla-* [< u’īla-] (Mu, L, Ist.)

PM **quyïla-* ‘хуйл-’, AM *quyīla-* [< quÿīla-] (Mo.); MM **quyīla-*

PM **uyïd-* ‘уйд-’, AM *uyīd* [< uÿīd-] Precl. (= Chang, Hin, Sub.); MM *uyīd-* (MNT/= *uyīdanya*/, KMQB /= *uyīdqari*/)

PM *ï + *ÿï > AM i + ÿī > i + yī > MM i + yī > i + ’ī

PM **tïyïray* ’чийрэг’, AM *čiyīray* Precl. (= Bur.); MM **čiyīray* [< čiÿīraÿ]

1.3.1.2.1.2 **Өргөлтөт эм эгшигээс үүссэн урт эгшиг**

(a) ***ge*** гэсэн бүтэцтэй үеийн дотор үүссэн урт эгшиг

PM *e + ge > AM e + gē > MM e + hē > e + ’ē

PM **degere* ‘дээр’, AM *degēre* Precl. (= Bod, Chang, Sul.); MM *de’ēre* (MNT, KMQB.), *dēre* (Mu, IM, L.); CM *dēre* (Dag, Bur.), *dērə* (Kalm, Oir, TMon, ÖMon.)

PM **kegeli* 'хээл', AM *kegēli* Precl. (= Bur.); MM *kehēli* (IM.), *ke'ēli* (MNT, HY.), *kēli* (Mu, L.); CM *kēli* (Dag.), *kēl* (Kalm, Oir, Ord.), χēl (TMon, ÖMon.)

PM **temegen* 'тэмээ', AM *temegēn* Precl. (= Turf. 9 */temegēd/*); MM teme'ēn (MNT, Hy, TK.), *temēn* (Mu, L.), temē (MNT, IM.); CM *temēn* (Kul, Kalm, Oir, ÖMon.)

PM *i + ge > AM i + gē > i + yē > MM i + yē > i + 'ē

PM **ǰige* 'зээ', AM *ǰigē* (Mo.); MM *ǰe'ē* [< ǰi'ē < ǰiyē] (HY.); CM *džiē* (Mngr.), *džē* (Dag, ÖMon.), *dzē* (TMon, ÖMon.), *zē* (Kalm, Bur.)

PM **kedige* 'хэзээ', AM *keǰiyē* [< keǰigē] Precl. (= Bod, Bur, Sub.); MM *keǰiyē* (Mu.), *keǰi'ē* (MNT, Ph.), *keǰe'ē* (KMQB.), *keǰē* (Mu.); CM *kidžiē* (Mngr.), *kedžē* (Ord.), *kedzē* (Oir.), *χedzē* (TMon.), *χezē* (Bur.)

PM **sigesün* 'шээс', AM *sigēsün* (Mo.), MM *si'ēsün* (IM.), *šēsün* [< še'ēsün < ši'ēsün] (Mu, Ist.); CM *šēsən* (Kalm.), *šēhen* (Bur.), *šēsə* (Oir, TMon.)

PM *ö + ge > AM ö + gē > MM ö + ē > e + ē

PM **bögere* 'бөөр', AM *bögēre* Precl. (= Bur.); MM *bö'ēre* (MNT, IM.), *bō̈re* [< bö'ēre] (L.); CM *bō̈re* (Dag, Bur.), *bō̈rə* (TMon.)

PM **kögersün* 'хөөс', AM *kögēsün* (Mo.); MM *kö'ēsün* (Mu.); CM *kō̈rsü* (Ord.), *kōrdze* (Mngr.), *kō̈sən* (Kalm.), *xō̈hen* (Bur.), *kō̈se* (Dag.)

PM **ǰögelen* 'зөөлөн', AM *ǰögēlen* Precl. (= Bur, Sub.); MM *ǰö'ēlen* [< ǰö'ēlen] (MNT, Hy, Mu.), *ǰō̈len* [< ǰö'ō̈len] (Mu, Ist.); CM *džō̈lön* (ÖMon.), *dzō̈lön* (Oir, TMon.), *zō̈len* (Bur.)

PM *ü + ge > AM ü + gē > MM ü + ē > ö + 'ē > e + 'ē

PM **dörüge* 'дөрөө', AM *dörügē* (Mo.); MM *dörö'ē* [< dörü'ē] (Hy.), *dörē* [< döre'ē< dörö'ē] (Mu, IM.); CM *dörā̈* (Kalm, Oir.), *dörō̈* (TMon, ÖMon.)

PM **nögüge* 'нөгөө', AM *nögügē* Precl. (= Bod, Hin, Chang, Taq.); MM *nögö'ē* [< nögü'ē] (MNT, KMQB, Ph.); CM *nögā̈* (Kalm, Oir.), *nögō̈* (TMon, ÖMon.)

PM **firüger* 'ерөөл', AM *irügēr* [< *χirügēr] (Aruγ, Bod, Sub.); MM *hirü'ēr* (MNT, Ph.), *hirēr* [< hire'ēr < hirü'ēr] (Mu.); CM *jörā̈ l* [< jöre'ēl < jörö'ēl] (Kalm, Oir.), *jörō̈ l* (TMon, ÖMon.)

(b) ***gü*** гэсэн бүтэцтэй үеийн дотор үүссэн урт эгшиг

PM *e + *gü > AM e + gū > MM e + wū > e + ’ū > ü + ’ū

PM *egülen ‘үүл’, AM egūlen Precl. (= Bur, Sub.); MM e’ūlen [< ewūlen] (MNT, Hy, Mu.), e’ūlen (L.), e’ūle (Tk.), ūlen [<ü’ülen < ö’ülen < e’ülen] (Mu, Ist.); CM eulən (Ha.), oülen (Kul.), ūlen (Bur.), ūlə n (Kalm, Oir.), ūlə (TMon.)

PM *köbegün ‘хүвүүн’, AM köbegūn Precl. (= Bod, Chang, Jig, Hin.); MM köbewūn (L.), köbe’ūn (D.); CM köbün (Tünk.), köwün (Kalm, Oir.), χüwūn (Bur.)

PM *ǰegüden ‘зүүд’, AM ǰegūden Precl. (= Bur.); MM ǰewūden (MNT), ǰe’ūden (Hy.), ǰūdün [< ǰü’üdün < ǰö’üdün] (Mu.); CM ǰeude (Ha, But.), ǰöudu (Mog.), dzūdə n (Dör.), dzūdə (TMon.)

PM *i + *gü > AM i + gū > MM i + wū > i + ’ū > ü + ’ū

PM *ebtigün ‘өвчүү’, AM ebčigūn Precl. (=Taq, Bur.); MM ebčewūn < ebčiwūn (Mu, L.), ebče’ūn [< ebčewūn] (MNT, Hy, Mu.), ebčūn [< ebčü’ün < ebče’ūn] (IM, Ist.); CM ebčeun (Mar, Zir.), ipeun (Man.), ebčūn (Mog.), öbtšūn (Oir, AKhor, Barin, Naim, Onn.)

PM *serigün ‘сэрүүн’, AM serigūn Precl. (= Bur, Sub.); MM seri’ūn (D, KMQB, Tk, Mu.), serūn [< serü’ün < seri’ūn] (Mu.); CM serūn (Dag, Kalm, Oir, TMon, ÖMon.), herjūn (Bur.)

PM *nigül ‘нүгэл’, AM *nigūl; MM ni’ūl [< niwūl] (D, Mu, IM.); CM nūl [< nü’ül < ni’ūl] (Kalm, Dör, Ord.)

PM *ü + *gü > AM ü + gū > MM ü + wū > ü + ’ū

PM *küǰügün ‘хүзүү’, AM küǰügūn Precl. (= Bur, Sub.); MM küǰü’ūn (MNT, Hy, Mu, IM, L, Ist.); CM kudzun (Mog.), kuzūn (Zir.), küdzūn (Oir.), küzūn (Kalm, Ur, Tor.), küdžū (ÖMon.), χüdzū (TMon.)

PM *üǰügür ‘үзүүр’, AM üǰügūr Precl. (= Hin, Sul, Bur, Sub.); MM üǰü’ūr (MNT, Ph.); CM üdžūr (ÖMon.), üdzūr (TMon, Oir.), üzūr (Kalm, Bur.)

PM *dügüreŋ ‘дүүрэн’, AM dügūreŋ Precl. (= Sul, Taq.); MM dü’ūreŋ (MNT, Hy, Mu.), dūren (Mu.); CM dūreŋ (TMon, ÖMon.), dūrün (Kalm, Oir, Bur.)

(c) ***gi*** гэсэн бүтэцтэй үеийн дотор үүссэн урт эгшиг

PM *e + *gi > AM e + gī > e + yī > MM e + yī > e + ’ī

PM *egimü ‘ийм’, AM *eyīmü* Precl. (= Jig, Taq, Teh, Bur.); MM *eyīmü* (MNT, Ph.); CM *īme* (Bur.), *īm* (Kalm, Oir, TMon, ÖMon.)

PM *negile- ‘нийл-’, AM *neyīle-* [< negīle-] Precl. (= Sub.); MM *neyīle-* (MNT), *neīle-* (Mu.); CM *nīle-* [< ni’īle- < ne’īle-] (Bur, ÖMon.)

PM *i + gi > AM i + gī > i + yī > MM i + yī > i + ’ī

PM *tigig ‘чийг’, AM *čigīg* (Mo.); MM *či’īg* [< čiyīg]; CM *tšīg* (Kalm, Oir, TMon, ÖMon.), *šīg* (Bur, Jar.)

PM *ü + gi > AM ü + gī > ü + yī > MM ü + yī

PM *kügiten ‘хүйтэн’, AM *küyīten* Precl. (= Bur.); MM *küiten* (Mu, L.), köyīten (Hy.); CM kuiten (Dag.), *kuīdiän* (Mngr.), *kuičien* (Dun.), xüiten (Bur, TMon.)

Монгол хэлний өргөлтөөс үүссэн урт эгшиг нь үгийн язгуур, үндэс төдийгүй, залгавар морфемийн дотор ч нэгэн адил тохиолдож байна. Тэдгээрийг байрлалынх нь талаас авч үзвэл мөн л V + CV (= u + γā, ü + gē, i + yā, i + yē) гэсэн авианы орчинд үүссэн байна.

AM *-luγā/-lügē* (Precl.) > MM *-lu’ā/-lü’ē* (MNT, Hy.) > *-la’ā/-le’ē* (MNT) > *-lā/-lē* (Mu, Ist.); CM *-lā/-lē* (Kalm.)

AM *-iγār/-igēr ~ -iyār/-iyēr*> MM *-iyār/-iyēr* (MNT, KMQB, D, Mu.) > *-i’ār/-i’ēr* (MNT, Hy, Mu.) >*-a’ār /-e’ēr* (Mu.); CM *-ār/-ēr ~ -ōr /-ȫ r* (Bur, TMon, ÖMon.)

Мөн эгшигээр төгөссөн үгийн дараа шүргэх ***γ/g, y*** гийгүүлэгчээр эхэлсэн залгавар морфем орвол тэдгээр шүргэх гийгүүлэгчийн арын эгшиг нь сунжиран уртаар хэлэгдэх болж, уламаар өмнөх эгшиг нь түүний нөлөөгөөр суларан сугарчээ.

AM |. . . V| + -γā/-gē (Precl.) > MM -’ā/-’ē (MNT, Mu.) > CM -a[4]

AM |.... V| + *-γār/-gēr ~ -bār/-bēr* (Precl.) > MM *-’ār/-’ēr* (MNT, Hy, Ph.) > CM *-ār/-ēr ~ -ōr/-ȫ r*

AM |.... V| + *-γād/-gēd* (Precl.) > MM *-’ād/-’ēd* (MNT, KMQB.) > CM *-ād/-ēd ~ -ōd/-ȫ d*

AM |.... V| + *-γūl/-gūl* (Precl.) > MM *-'ūl/-'ūl* (MNT, Ph.) > CM *-ūl/-ūl*

AM |.... V| + *-γīn* (Precl.) > MM *-γīn* (MNT, KMQB, Ph.) > *-īn* > CM *-īn*

Өвөг монгол хэлний утга ялгах өргөлтөт эгшигээс гаралтай үүсмэл урт эгшигийн тохиолдох байрлалыг хэлний хөгжилийн үе шат тус бүрээр харьцуулан үзүүлэе

	PM		AM		MM				CM				
γa	1. *a + γá	>	a + γā	>	a	+	hā	>	a	+	ā	>	ā
	2. *ï + γá	>	i + γā	>	i	+	yā	>	i	+•	ā	>	ā
	3. *o + γá	>	o + γā	>	o	+	wā	>	o	+	ā	>	ā
	4. *u + γá	>	u + γā	>	u	+	wā	>	u	+	ā	>	ā
γu	1. *a + γú	>	a + γū	>	a	+	wū	>	a	+•	ū	>>	ū ~ ō
	2. *ï + γú	>	i + γū	>	i	+	yū	>	i	+	ū	>>	ū
	3. *o + γú	>	o + γū	>	o	+	wū	>	o	+	ū	>>	ū ~ ō
	4. *u + γú	>	u + γū	>	u	+	wū	>	u	+	ū	>>	ū ~ ō
γï	1. *a + γǐ	>	a + γī	>	a	+	yī	>	a	+•	ī	>	ai
	2. *ï + γǐ	>	i + γī	>	i	+	yī	>	i	+•	ī	>	ī
	3. *o + γǐ	>	o+ γī	>	o	+	yī	>	o	+•	ī	>	oi
	4. *u + γǐ	>	u + γī	>	u	+	yī	>	u	+•	ī	>	ui
ge	1. *e + gé	>	e + gē	>	e	+	hē	>	e	+•	ē	>	ē
	2. *i + gé	>	i + gē	>	i	+	yē	>	i	+•	ē	>>	ē ~ ö
	3. *ö + gé	>	ö + gē	>	ö	+	wē	>	ö	+	ē	>>	ē
	4. *ü+ gé	>	ü+ gē	>	ü	+	wē	>	ü	+	ē	>>	ē
gü	1. *e + gű	>	e + gṻ	>	e	+	wṻ	>	e	+•	ṻ	>	ṻ ~ ȫ
	2. *i + gű	>	i + gṻ	>	i	+	yṻ	>	i	+	ṻ	>>	ṻ
	3. *ü+ gű	>	ü+ gṻ	>	ü	+	wṻ	>	ü	+	ṻ	>>	ṻ ~ ȫ
gi	1. *e + gí	>	e + gī	>	e	+	yī	>	e	+•	ī	>	ī
	2. *i + gí	>	i + gī	>	i	+	yī	>	i	+•	ī	>>	ī
	3. *ü + gí	>	ü+ gī	>	ü	+	yī	>	ü	+•	ī	>>	ī ~ üi

1.3.1.2.2 **Хагас эгшигээс урт эгшигүүссэн нь**

§ 82. **Хагас эгшигээс үүссэн урт эгшиг**. Нэрт монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов, N. Ропре нар монгол хэлэнд VW гэсэн цогцоос үүссэн урт эгшиг

байдаг тухай анх тэмдэглэсэн байдаг.[670] Тэр нь угтаа богино эгшигийн дараа орсон хагас эгшигийн өвөрмөц хувьсалтай холбогдох сонирхолтой асуудал юм.

Ер аливаа хэлэнд уруулын эгшигтэй адил байранд хэлэгддэг ***w***, тагнайн эгшигтэй адил байранд хэлэгддэг ***j*** гэсэн хоёр гийгүүлэгч байдаг бөгөөд тэдгээр нь эгшигийн өмнө орвол гийгүүлэгчийн шинж нь давамгайлж, эгшигийн дараа орвол эгшигийн шинж нь давамгайлж байдаг хоёрдмол шинжтэй байдаг байна. Түүнчилэн эртний монгол хэлний үед эгшигийн дараа орсон ***w, j*** нь өмнө талынхаа эгшигт нөлөөлөгдөн уруулын ***u/ü,*** тагнайн ***i*** болж, уламаар дундад үеийн монгол хэлний сүүлчээр ***ū*** (< u'ū < a'ū < aγū), ***ǖ*** (< ü'ǖ < e'ǖ < egǖ), ***ī*** (< i'ī < e'ī < eyī) -гийн аналогоор урт ***ū, ǖ, ī*** болжээ.[671] Монгол хэлний нийт үүсмэл урт эгшигийн дотор хагас эгшигээс үүссэн эгшиг харьцангуй цөөн юм.

PM **tawlaj* 'туулай', AM *taulai* Precl. (= Abaγa, Sub.); MM *taulai* (MNT, Hy, Tk, Mu, L, HQ.), *tūlai* [< taulai] (Mu, Ist.); CM *tūlai* (Bur, TMon.)

PM **tewke* 'түүх', AM *teüke* (Mo.); MM **tǖke* [< teüke]; CM *tǖkə* (Kalm, Oir.), *tǖxə* (TMon, ÖMon.)

PM **kej* 'хий', AM *kei* Precl. (= Bod, Bur, Sub.); MM *kei* (MNT, Hy, Tk, Mu, IM, Ist.); CM *kī* (Mngr, Kalm, Oir, Ord.), *χī* (Bur, TMon, ÖMon.)

<u>*Нэмэлт тэмдэглэл*</u>: Аливаа хэлэнд задгай үеэр төгөссөн ганц үет үгийн эгшиг нь заавал уртаар дуудагддаг нийтлэг хуультай байдагчилан монгол хэлний ганц үет задгай үеийн эгшигүүд ч мөн урт эгшиг болсон байна.

PM **ki-* 'хий-', AM *ki-* (Precl.); MM *ki-* [= ki-] (MNT, KMQB, Mu, IM, Ph.); CM *kī-* (Kalm, Oir, Ord.), *χī-* (Bur, TMon, ÖMon.)

PM **min* 'би', AM *bi* [< *bin] (Precl.); MM *bi* [= bī] (MNT, KMQB, Hy, D, Mu, IM, L, Ist.); CM *bi* [= bī]

PM **tin* 'чи', AM *či* [< *čin] (Precl.); MM *či* [= čī] (MNT, KMQB, Hy, MU, IM, L, Ist.); CM *tši* [= tšī], *si* [= šī]

PM **tan* 'та', AM *ta* [< *tan] (Precl.); MM *ta* (MNT, D, Muв); CM *ta* [= tā]

Өргөлтөт эгшиг болон хагас эгшигээс үүссэн урт эгшигээс гадна ерийн богино эгшигээс үүссэн урт эгшиг байдаг тухай Б. Я. Владимирцов, Г. Д. Санжеев, N.

---

[670] Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, 255-259; N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 68-70

[671] Д. Төмөртогоо, Орчин цагийн монгол хэлний урт эгшигийн гарал, хувьсал, Уб., 1981, 29 // Монгол хэлний түүхэн хэл шинжилэлийн судалгаа, Уб., 2017, 186-201

Роррe нар тэмдэглэсэн[672] боловч тэдгээрийн байр, авианы орчины талаас тодорхой тайлбар хийсэнгүй, зөвхөн монгол бичигийн хэлэнд хэвшин тогтсон бичлэгийг халх аялгууны үгстэй харьцуулан үзсэн төдий юм. Дээрхи эрдэмтэдийн эш татсан жишээнүүдийн дотор ***mini, čini, ki*** гэх зэрэг задгай үеийн богино эгшигтэй цөөн жишээ тохиолдож байгаас гадна өмнөө богино эгшигтэй ***ya/ge*** бүхий *aγar* 'агаар', *ǰigür* 'жигүүр', *čaγan* 'цагаан', *gegen* 'гэгээн' гэх зэрэг нилээд үгсийг жишээ татжээ. Монгол бичигийн хэлний *aγa, ege* бүхий үгийн бүтэцэн дэх шүргэх ***γ/g*** гийгүүлэгч нь суларан сугардаг атал дээрхи жишээнд уул гийгүүлэгч нь хэвээр хадгалагдаж байна. Гэвч дурдсан үгс нь ***aγār*** [< aγa'ar < aγaγar], ***ǰigūr*** [< ǰigü'ür < ǰigügür], ***čaγān*** [< čaγa'an < čaγaγan], ***gegēn*** [< gege'en < gegegen] гэсэн хувьсалуудыг дамжиж ирсэн байх боломжтой мэт. Түүнийг гэрчилэх баримт гэвэл сонгодог бичигийн өмнөх монгол бичигийн дурсхалуудад ***čaγaγan, gegegen*** гэсэн жишээнүүд цөөнгүй тохиолддог билээ. Гэвч бүтэцийнх нь талаас авч үзвэл, дурдсан үгс нь ****ča-*** {= ča-ki, ča-l, ča-yi}, ****ge-*** {= ge-re, ge-yi} гэсэн анхдагч язгуур, үг бүтээх *-γān, -gēn* гэсэн хоёр морфемийн нийлцээс бүтсэн гэдэг нь тодорхой байна. Тийн атал яагаад CV-CV-CVC гэсэн бүтэцтэй болов гэсэн асуулт гарна. Миний бодоход, бүр дундад үеийн монгол хэлний үед өргөлтөөс үүссэн дэд үеийн урт эгшигийг монгол бичигт *'уртадхал'* гэгдэх *γā/gē* гэсэн нэмэлт үеэр тэмдэглэсэн байхыг ч бас үгүйсгэх аргагүй.

Профессор N. Рорре-гийн авсан жишээнүүдийн дотор эдүгээгийн Монгор, Дагуур хэлэнд уламжилан үлдсэн *mōdi* 'мод',*dāχu* 'дах', *dāli* 'дал', *fōdi* 'од' анхдагч урт эгшигтэй үгс нилээд бий.

1.3.2 ХОС ЭГШИГИЙН ГАРАЛ, ХУВЬСАЛ

§ 83. Хос эгшигийн гарал, хувьсалыг судалсан нь. Орчин үеийн монгол хэл аялгуунуудын хос эгшигийн гарал, хувьсалын талаар монголч эрдэмтэд сүүлийн зуугаад жилийн турш анхааран судалсаар ирсэн боловч энэ талаар бие даасан тусхай судалгаа одоо хүртэл гарсангүй, их төлөв монгол хэлзүйн бүтээлүүд болон монгол хэл аялгуунуудын судалгааны зохиолуудад ажиглан тэмдэглэсэн зүйл нилээд буй.

Монгол хэлний хос эгшигийн гарал, хувьсалын талаар анх судалсан эрдэмтэн бол профессор G. J. Ramstedt юм. Тэрвээр '*Монгол бичигийн хэлийг Хүрээний халх аман аялгуутай харьцуулсан авиа зүй'* гэдэг бүтээлдээ монгол хэлний нийт хос эгшигүүдийг ***i***-тэй хос эгшиг, ***u/ü***-тэй хос эгшиг гэсэн хоёр үндэсэн хэсэгт хуваажээ.[673] Үүнд:

---

672 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 193, 260-262; Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, 77; N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 73-76

673 Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, 54-56

I. *i*-тэй хос эгшиг

aə/ă	ayi	xaətši	Mo. qayiči *'хайч'*
	ai	dalăē	Mo. dalai *'далай'*
oə	oyi	oərŏ	Mo. oyira *'ойр'*
	oi	oə	Mo. oi *'ой'*
uj/ŭi	uyi	ujlă-	Mo. uyila- *'уйл-'*
	ui	xarăŋxui	Mo. qarangγui *'харанхуй'*
üj/üi	eyi	tīmə	Mo. teyimü *'тийм'*
	ei	etsəŋ^{k}xī	Mo. ečengkei *'эцэнхий'*

II. *u /ü*-тэй хос эгшиг

ū	au	tūlăē	Mo. taulai *'туулай'*
ű	eü	xūxu~	Mo. keüken *'хүүхэн'*

Профессор G. J. Ramstedt-ийн Хүрээний халх аялгуунд дээр дурдсан хос эгшигүүдээс гадна ***i*** эгшигийн нугаралын уламаас үгийн тэргүүн ба дэд үеийн эгшигүүд нэгэн үед нийлэн ***iä, ia, ĭu, ĭu, ē, ī, ĭē*** гэх мэт хос эгшигүүд үүссэн хэмээн тэмдэглэжээ.[674] Хожим академич Б. Владимирцов халхын аман аялгууны хос эгшиг тус бүрийн гаралыг нилээд дэлгэрүүлэн судалжээ.[675] Түүний судалгааны гол үндэсийг эш татсан жишээнүүдээр нь төлөөлүүлэн авч үзэе.

ai	ayi < *aγï	aəl	Mo. ayil < *aγïl *'айл'*
	ayi < *awï	xaətši	Mo. qayiči < *qawiti *'хайч'*
	ai < *ay	dalaə	Mo. dalai < *dalay *'далай'*
oi	oyi < *oγï	oərŏ	Mo. oyira < *oγïra *'ойр'*
	oyi < *owï	toəg	Mo. toyig < *towiγ *'тойг'*
	oi < *oy	oə	Mo. oi < *oy *'ой'*
uĭ	uyi < *uγï	uĭl-	Mo. uyila- < *uγïla- *'уйл-'*
	uyi < *uwï	uĭd-	Mo. uyid- < *uwīd- *'уйд-'*
	ui < *uy	xui	Mo.qui < *quy' *хуй'*

---

674 ibid., 54

675 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 266-307

ī	eyi < *egi	dīl-	Mo.deyīle- <*degīle- *'дийл-'*
	eyi < *ewi	xīd-	Mo. keyīd- < *kewīd- *'хийд-'*
	ei < *ey	oldzī	Mo. öljei < *öljey *'өлзий'*
uĭ	üyi < *ügi	üimə-	Mo. üyime- < *ügime- *'үйм-'*
	üi < *üy	oduĭ:-	Mo. edüi < *edüy *'өдий'*
ī	iyi < *igi	xadzī	Mo. qajiyi < *qajigi *'хазай'*
	iyi < *iwi	gītši	Mo. giyiči < *giwiči *'гийч'*

Акад. Б. Я. Владимирцов энд монгол хэлний хос эгшиг үүссэн үндэсэн шалтгааныг хоёр үндэсэн зүйлээр тайлбарлажээ. Үүнд:

1-рт. V + γ (g) ~ w + i гэсэн цогцын эхний эгшиг дээр өргөлт ноогдож байсан бол уул цогцын доторхи ***γ*** *(g)* ~ ***w*** гийгүүлэгч арынхаа ***i*** ~ ***ĭ*** эгшигийн нөлөөгөөр ***y*** болж, уламаар хос эгшиг үүссэн.[676]

2-рт. *Vj гэсэн цогцын доторхи ***j*** гэсэн хагас эгшигийн аниралхаг шинж нь яваандаа алдагдаж XIII зууны үед хос эгшиг үүссэн.[677]

Мөн тэрвээр профессор G. J. Ramstedt-ийн нэгэн адил ****i*** эгшигийн эвдэрэлийн уламаас ***i*** + V (= a, e, u, ü) гэсэн өгсөх хос эгшигүүд үүссэн гэж тэмдэглэсэн байна.[678]

Түүний дараа профессор Г. Д. Санжеев монгол хэлний хос эгшигийн гаралыг монгол бичигийн хэлний үгийн тэргүүн үеийн ***aji, eji, oji, uyi, üyi,*** үгийн эцэсийн ***aj, ej, ui, üi*** гээс үүссэн болох талаар дурдсан[679] боловч түүний үүссэн шалтгааныг авианы хувьсалын үүднээс тодорхой тайлбарласангүй. Харин профессор N. Poppe *'Монгол хэлнүүдийн харьцуулсан судалгааны удирдхал'* гэдэг бүтээлдээ үгийн тэргүүн ба тэргүүн бус үеийн бүх хос эгшигүүдийг V + yi (*V + γi ~ *V + βi) гэсэн цогцоос үүссэн гэж үзээд уламаар тэдгээр цогцуудын цаашдын хувьсалыг XIII-XIV зууны үеийн бичигийн дурсхалууд болон эдүгээгийн олон монгол хэл аялгууны материал дээр тулгуурлан гаргажээ.[680] Хожим акад. Ш. Лувсанвандан орчин цагийн монгол хэл аялгуунуудын хос эгшигүүдийг нийтэд нь V + y + i гэсэн цогцоос үүссэн гэж тэмдэглэсэн нь[681] угтаа профессор N. Poppe-гийн саналтай бараг адил байна. Дээр дурдсан судалгаанаас гадна монгол хэлний бичигийн дурсхалууд

---

676 ibid.,279
677 ibid., 286
678 ibid., 302
679 Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, 1953, 80-81
680 N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 76
681 Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Авиа, авиалбар хоёр нь, 71

болон монгол хэл аялгуунуудын хос эгшигийн онцлог шинжийн талаар А. Д. Руднев, G. J. Ramsted, M. Lewicki, N. Poppe, L. Ligeti, Г. Д. Санжеев, M. Nomura, Sh. Iwamura, H. F. Schurmann, M. Weiers, A. Rona-Tas, Д. Амоголонов, Б. Х. Тодаева, Д. А. Павлов, С. Мөөмөө, Э. Вандуй, Ж. Цолоо нарын бүтээлүүдэд онцлон тэмдэглэсэн зүйл бий.[682]

1.3.2.1. ҮГИЙН ЭЦЭСИЙН ХОС ЭГШИГ

§ 84. **Үгийн эцэсийн хос эгшигийн гарал**. Монгол хэл аялгуунуудын үгийн эцэсийн хос эгшиг нь эртний монгол хэлний сүүлч үеэр үүсчээ. Тодоруулан хэлбэл, өвөг монгол хэлний үед байсан *Vj (= *aj, *ej, *uj, *üj) гэсэн цогцуудын доторхи ***j*** гэсэн хагас эгшигийн шинж нь давамгайлсаар яваандаа Vi (= ai, ei, ui, üi) болсон байна. Сонгодог бичигийн өмнөх монгол бичигийн хэл болон дундад үеийн монгол хэлний онцлогийг тусхасан бичигийн дурсхалуудад уул хос эгшигийг бүрэн тусхажээ.

PM *aj > AM aj > ai ~ MM ai ~ CM ai

PM **noqaj* ‘нохой’, AM *noqai* [< *noqaj] Precl. (= Sub.); MM *noqai* (MNT, Hy, Tk, Mu, L, Ist, HQ, Eč.), *noγai* (IM.); CM *noqai* (Zir.), *noqai* (Mar.), *nokai* (Leech.), *noqei* (Mog.); *noxoi* (Bur, TMon.), *noxuē* (Mngr.), *noγui* (Bao.), *noqoi* (SY.), *noxā* (Kalm, Ba, Dö, Kho.), *noxō* (Zakh, Tor, Ur, AKhor, Barin, Onn, Naim, Cha, Učab.)

PM **dalaj* ‘далай’, AM *dalai* [< *dalaj] Precl. (= Sul, Taq, Bur, Sub.); MM *dalai* (MNT, Hy, Mu.), *talai* (D.); CM *dalai* (Dag, Ha, Bur, TMon.), *dalā̈* (Kalm, Ord.), *dalā* (Oir, Cha, Učab, Šgol.), *dalē* (Gor, Jal, Khor.)

PM **tawlaj* ‘туулай’, AM *taulai* Precl. (= Abaγa, Sub.); MM *taulai* (MNT, Hy, Tk, Mu, L, HQ.), *tūlai* (Mu, Ist.); CM *tūlai* (Bur, TMon.)

Жич: Эртний монгол хэлний үгийн эцэсийн ***ai*** (< *aj) гэсэн хос эгшигтэй үгийн тэргүүн үеийн өргөлтөт эгшиг нь уруулын ***o*** байсан бол уул хос эгшиг нь орчин үеийн олонхи монгол хэл аялгуунуудад дэвшин ижилшилийн уламаас ***oi*** болжээ.

PM **foraj* ‘орой’, AM *orai* [< *χoraj] Precl. (= Sul.), *oroi* Precl. (= Bur, Sub.); MM *horai* (Mu.), *orai* (MNT); CM *oroi* (Ha, Bur, TMon.)

---

682 А. Д. Руднев, Материалы по говорам Восточной Монголии, 192-194, Хори-бурятский говор. Опыт исследования, тексты, перевод и примечания, XXVI-XXIX; G. J. Ramstedt, *Mogholica.* Beiträge zur Kenntnis der Moghol Sprache in Afghanistan, 51-53; N. Poppe, Skizze der Phonetik des Bargu-Burjätischen, 334-338, Über die Sprache der Daguren, 201-202, Khalkha-Mongolische Grammatik. Mit Bibliographie, Sprachproben und Glossar, 19-20; Г. Д. Санжеев, Грамматика бурят-монгольского языка, 12-13; M. Weiers, Die Sprache der Moghol der Provinz Heart in Afghanistan. Sprachematerial, Grammatik, Wortliste, 108-109; Д. Д. Амоголонов, Современный бурятский язык, 31-33; Д. А. Павлов, Развития дифтонгов в монофтонги в калмыцком языке, 218-225; Ж. Цолоо, Захчины аман аялгуу, 60-65, *idem.* Баруун халхын аман аялгуу, 33-35, Орчин цагийн монгол хэлний авиа зүй, 74-76

PM **toluγaj* 'толгой', AM *toluγai* [< *toluγaj] Precl. (= Bur.); MM *toluγai;* CM *tolγoi* (Bur, TMon.), CM *tolγoi* (Bur, TMon.), *toloγoi* (SY.)

PM *ej > AM ej > ei ~ CM ei

PM **kej* 'хий', AM *kei* [< *kej] Precl. (= Bod, Bur, Sub.); MM *kei* (MNT, Hy, Tk, Mu, Ist.); CM *kei* (Mog, Man, Mar, Her, Mngr, Min, Dun.), *keĭn* (Ha.), *hein* (But.)

PM **öljej* 'өлзий', AM *öljei* [< *öljej] Precl. (Chang, Bur, Sub.); MM *öljĭei* (MNT, KMQB, Hy.), *öljĭeé* (D.); CM *oljĭai* (Zir.), *ölzē* (Kalm.)

PM **delekej* 'дэлхий', AM *delekei* [< *delekej] Precl. (= Bod, Chang, Hin, Taq.); MM *delekei* (MNT, KMQB.), *delegeé* (D.); CM *delekəī* (Kham.), *delkəī* (Ha.), *delxei* (Bur.), *delxī* (TMon, ÖMon.); *delkā̆* (Kalm, Oir.)

Үгийн эцэсийн ****ej***-гээс үүссэн хос эгшиг нь өдгөөгийн Могол, Буриад зэрэг зарим хэлэнд зохих хэмжээгээр хадгалагдан үлдсэн боловч Төв ба Өмнөд монгол хэлний олонхи аялгуунуудад өмнө талын богино эгшигүүд нь арынхаа уйтан эгшигт татагдан ***ī*** болж, Халимаг, Ойрд хэлнүүдэд арын уйтан эгшиг нь өмнөх эгшигтээ татагдан ***ā̆*** , ***ē*** болсон байна.

PM *oj > AM oj > oi ~ MM oi ~ CM oi

PM *foj* 'ой', AM *oi* [< *xoj] Precl. (= Bur, Sub.); MM *hoi* (MNT, Hy.)

Эртний монгол хэлний үед үгийн тэргүүн бус үеэс хойш уруулын ***o*** эгшиг тохиолддоггүй байсан учир үгийн эцэсийн ***oj*** нь гагцхүү маш цөөн тохиолдолд ганц үет үгэнд ордог байна.

PM *uj > AM uj > ui > MM ui > CM ui

PM **qaraŋγuj* 'харанхуй', AM *qaraŋγui* [< *qaraŋγuj] Precl. (= Bur, Sub.), MM *qaraŋqui* (MNT), *qaraŋqu* (MNT), *qaraŋqu* (Mu.); CM *qaraŋgui* (Mog.), *qaraŋγui* (Her.), *χarăŋgui* (Ha.), *χaraŋgui* (Barin.), *χaraŋxui* (TMon.); *χaraŋğī* (Bur.), *χarăŋğū* (Kalm, Oir, ÖMon.)

PM **oγtarγui* 'огторгуй', AM *oγtarγui* [< *χoγtarγuj] Precl. (= Bod, Bur, Sub.); MM *hoγtorqui* (KMQB.), *hoqtorqui* (D.); CM *ogtorgui* (Barin.), *ugturğui* (Ord.), *oxtorğui* (TMon.), *ogtorğoi* (Bur.), *oktărğū* (Kalm, Oir.), *ogtorğū* (ÖMon.)

PM **daruj* 'даруй', AM *darui* [< *daruj] Precl. (= Hin, Qqot.); MM *darui* (KMQB, Hy.); CM *darŭi* (Kha, Ord.), *darū* (Kalm, Oir.), *darī* (Bur.)

PM *üj > AM üj >üi > MM üi > CM üi

PM **kedüj* ‘хэдий’, AM *kedüi* [< kedüj] Precl. (= Bur, Sub.); MM *kedüi* (MNT, KMQB, Hy.); CM *kedüi* (NÜd.), *xuduī* (Alar.); *kedū* (Zir, Kalm, Oir.); *χedī* (TMon, ÖMon.)

PM *edüj* ‘өдий’, AM *edüi* [< *edüj] Precl. (= Bod, Chang, Jig, Taq.); MM *edüi* (MNT, KMQB.); CM *ödüī* (Ord.), *uduī* (Alar.); *ödū* (Kalm, Oir.); *ödī* (TMon, ÖMon.)

Үгийн эцэсийн ***uj, üj***-гээс үүссэн хос эгшигүүд нь зарим хэл аялгуунд хадгалагдсаар ирсэн боловч Халимаг, Ойрд хэлнүүдэд их төлөв дэвшин ижилшиж, төв болон өмнөд монгол, буриад хэлний зонхилох аялгуунд ухаран ижилшсэн байна.

1.3.2.2 ҮГИЙН ЭЦЭСИЙН БУС ХОС ЭГШИГ

§ 85. **Үгийн эцэсийн бус хос эгшигийн гарал**. Орчин үеийн монгол хэл аялгуунуудын үгийн эцэсийн бус хос эгшигүүд нь ***V + yī*** гэсэн цогцоос үүсчээ. Тэр нь өвөг монгол хэлний үед ***V + yï/gi*** гэсэн цогц байсан бөгөөд эртний монгол хэлний үед дурдсан цогцын доторхи ***i*** эгшиг нь адил байранд байсан бусад эгшигүүдийнхээ нэгэн адил сунжиран урт эгшиг болсоны дараа түүний өмнө байсан шүргэх гийгүүлэгч нь суларан сугарсаар барагцаалвал, дундад үеийн монгол хэлний сүүлч үеэр бүрмөсөн сугарчээ. Тэрхүү сугарсан гийгүүлэгчийн хоёр талын эгшигүүд нь хэлэгдэх байдалаараа хүчин тэнцүү /= өмнө талын эгшигүүд нь богино боловч уужим, эсвэл уруулын; хойд талын эгшиг нь уйтан боловч урт/ байсан учир тэдгээр нь аль нэгийгээ өөртөө татан ижилшүүлж чадсангүй, харин тус тусынхаа хэлэгдэх шинжээ тогтвортой хадгалсан хэвээрээ нэгэн үед багтан нийлсэний үр дүнд одоогийн хос эгшигүүд үүссэн байна.

PM *V + γï /gi > AM V + γī/gī > MM V + yī > V + ’ + ī > Vi

Монгол хэлний үгийн эцэсийн бус хос эгшигүүд нь урт эгшигийн нэгэн адил өмнөө богино эгшигтэй CV-ийн дотор үүссэн бөгөөд түүний бүтэцэнд сугарсан гийгүүлэгчийн өмнө талын богино эгшиг болон утга ялгах өргөлттэй байсан арын эгшигийн аль аль нь орсон тул түүнийг VCV гэсэн цогцоос үүссэн гэж үзэх бүрэн боломжтой юм. Цаг хугацааны талаас нь авч үзвэл, үүсмэл урт эгшиг нь эртний монгол хэлний сүүлчээр үүссэн бол хос эгшиг түүнээс хойш, дундад үеийн монгол хэлний сүүлчээр үүсчээ. Тийнхүү дундад үеийн монгол хэлний сүүлчээр шинэ дутам үүсч байсан хос эгшигийн зарим жишээ тэр үеэс уламжилан үлдсэн бичигийн дурсхалуудад тэмдэглэгджээ.

MM *sain* (Mu, IM); *sayīn* (MNT, KMQB, Hy.); AM *sayīn*<{*saγïn}
MM *oira* (Mu, L); *oyīra* (MNT, KMQB, Hy.); AM *oyīra*<{*oγïra}
MM *uila-* (Mu, IM, L, Ist.); *uyīla-* (MNT); AM *uyīla-* <{*uγïla-}
MM *üile* (KMQB, Hy, D, Mu, IM.); *üyīle* (MNT); AM *üyīle*<{*ügile}

Гэвч үгийн эцэсийн бус хос эгшигийн гарал нь өргөлтөөс үүссэн урт эгшигтэй шууд холбоотой юм. Тухайлвал, үүсмэл урт эгшигийн нөлөөгөөр суларан сугарсан шүргэх гийгүүлэгчийн хоёр талын эгшигүүд ижилшсэн тохиолдолд цэвэр урт эгшиг үлдэж, ижилшээгүй тохиолдолд хос эгшиг шинээр үүссэн байна. Өөрөөр хэлвэл, үүсмэл урт эгшиг, үгийн эцэсийн бус хос эгшиг хоёр нь уртаа нэгэн хувьсалын хоёр өөр үр дүн юм.

PM	AM		MM		
*aγula	> aγūla	> awūla	> o'ūla	> u'ūla	> ūla > ūlɒ
*aγïl	> *aγīl	> ayīl	> a'īl	> a'īl	> aīl > ail

Дээрхи харьцуулсан жишээнээс ажиглавал, монгол хэлний урт, хос эгшигийн гарал нь шүргэх *γ/g* гийгүүлэгчийн хоёр талын эгшигүүд ижилшсэн эсэхээс шалтгаалсан нь тодорхой байна.

PM *aγï > AM aγī > ayī ~ MM ayī > a'ī > aī

PM **sayïn* 'сайн', AM *sayīn* [< *saγīn] Precl. (= Bod, Ölǰ, Qqor, Chang.); MM *sayïn* (MNT, KMQB, Hy, D, Mu, L, Ist.); *sain* (Mu, IM, L.); CM *sain* (SY, Dag, TMon.), *haiŋ* (Bur.); *sān* (Kalm, Oir.), *sēn* (ÖMon.)

PM **aγïl* 'айл', AM *ayīl* [*aγīl] Precl. (= Turf.1); MM *ayīl* (MNT, Mu.); CM *ail* (SY, *ag, TMon, Bur.); *āl* (Kalm, Oir.), *ēl* (ÖMon.)

PM **qaγïtï* 'хайч', AM *qayiči* [< *qaγīči] (Mo.); MM *qayīči* (MNT, Hy.), *qaiči* (Mu.); CM *χaiči* (Ha.), *qaitši* (Dun.), *χaitšə* (SY.), *kaiči* (But.), *χaitši* (TMon.), *χaiša* (Bur.), *χātši* (Kalm, Oir, Ord.), *χētš* (ÖMon.)

PM *oγï > AM oγī > oyī ~ MM oyī > o'ī > oī

PM **oγïra* 'ойр', AM *oyīra* [< *oγīra] Precl. (= Hin, Sul, Taq, Bur.); MM *oyīra* (MNT, KMQB, Hy, Mu, IM.), *oīra* (Mu, L, Ist.); CM *oira* (Zir,Kun.), *oira* (Mar.), *oiro* (SY, Bur.), *uira* (Dun.), *woair* (Ha.), *uaire* (But.), *wair* (Kul.), *oirŏ* (TMon, Cha, Šgol, Učab.), *ōr* (Kalm, Oir, ÖMon.)

PM **qoγïna* 'хойно', AM *qoyīna* [< *qoγīna] Precl. (= Bod, Hin, Ar, Sul.); MM *qoyīna* (MNT, KMQB, Hy, Ph.), *qoina* (Mu, L.); CM *qoina* (Mog, Mar, Zir.), *koina* (Leech.), *koină* (Her.), *χoina* (Kul.), *χoino* (Min, Bur, TMon, Cha.), *quina* (Dun.), *χoain* (Ha.), *χōnö* (Kalm, Oir.), *χōn* (ÖMon.)

PM **noγïr* 'нойр', AM *noyīr* [< *noγīr] Precl. (= Bur, Sub.); MM *noyīr* (MNT, Mu.); CM *noir* (Zir, Her, Bur, TMon.), *noĭr* (Ha, Cha, Šgol, Učab.), *nōr* (Oir, Kalm, ÖMon.), *nōr* (Mngr.), *nūr* (SY.)

PM *uγi > AM uγī > uγī ~ MM uγī > u'ī > uī

PM *_uγïla-_ 'уйл-', AM *ugīla-* Precl. (= Bur.), *uγīla-* Precl. (= Taq.); MM *uγīla-* (MNT), *ūla-* (Mu, IM, L, Ist.); CM *ūla-* (Mog.), *ujila-* (Man, Mar.), *uila-* (Dun, SY, Bur, Ord, Cha.), *uilă-* (Her, TMon.), *woail-* (Ha.), *waila-* (Kul.), *uaile-* (But.), *ūl-* (Kalm, Oir, ÖMon.)

PM *_uγïd-_ 'уйд-', AM *uγīd-* [< *uγīd-] Precl. (= Chang, Hin, Sub.); MM *uγīd-* (MNT /= uγīdanγa/, KMQB /= uγīdqari/); CM *uidɒ-* (Dör, Ba, Kho, Kha, Cha, Učab, Šgol.); *ūd-* (Zach, Tor, Ur, AKhor, Khor, Barin.)

PM *ügi > AM ügī >üγī ~ MM üγī > ü'ī > üī

PM *_kügiten_ 'хүйтэн', AM *küγīten* [< *kügīten] Precl. (= Bur.); MM *küγīten* (KMQB, Hy, MNT /= köγīten/), *küiten* (Mu, L.); CM *küiten* (Min, Ha, But, Ord.), *χüiten* (Bur, Kha.); *kītən* (Kalm, Oir.), *χūten* (ÖMon.)

PM *_tügimer_ 'түймэр', AM *tüγīmer* [<*tügīmer] Precl. (Bur.); MM *_tüγīmer;_ CM *tüimer* (Bur, Kha, Ord.), *tūmer* (AKhor, Barin, Khar, Gor, Jal.), *tūmər* (Kalm, Tor.), *tūmür* (Oir.)

Жич тэмдэглэх нь: Дундад үеийн монгол хэлний Vуī гэсэн цогцын доторхи шүргэх гийгүүлэгч суларан сугарч, хос эгшиг үүсэх тэр үед уртаар хэлэгдэж байсан уул ***ī*** эгшиг нь олонхи хэл аялгуунуудад үлэмжхэн огцомшиж, зөвхөн өмнөх эгшигээ хосорхог шинжтэй болгох төдий болжээ. Тэр ч байтугай, Халимаг, Ойрд, Өвөрлөгчидийн зонхилох аялгуунуудад уул уйтан эгшиг нь өмнө талынхаа уруулын эгшигт татагдан ижилшсэнээс ***ā, ū, ü*** гэх мэт уруулын урт эгшиг үүссэн байна. Харин хэлний урдуурхи эгшигийн ард байсан ***i*** нь маш цөөн тохиолдолд өмнөх эгшигээ өөртөө татан ижилшүүлжээ. Дээр дурдсан өвөрмөц хувьсалуудыг өмнө эш татсан жишээнүүдээс ажиглаж болно.

Нэмэлт тэмдэглэл:

(а) Орчин цагийн монгол хэлний үгийн эцэсийн бус хос эгшиг бүхий зарим үгсийг монгол бичигийн хэлний тогтсон бичлэг болон бичигийн дурсхалуудад тэмдэглэгдсэнтэй нь харьцуулан үзвэл тэдгээрийн хувьсан хөгжиж ирсэн байдал нь өөр хоорондоо адилгүй байна. Тухайлвал, монгол бичигийн хэлний *_үүи-_, *_güγü-_, *_ауи-_ зэрэг үгс нь авианы түүхэн хөгжилийн үр дүнд ***γū-***, ***gū-***, ***ū-*** гэсэн бүтэцтэй болох ёстой. Түүнийг монгол хэлний бичигийн дурсхалууд болон зарим хэл аялгууны материалаар бүрэн баталж болно.

AM *_үүи-_ /= *_үүγū_*/ Precl. (= Bod, Jig, Teh, Bur.); MM *_үүγū-_* (MNT, Hy, Mu.); CM *ğū-* (Kalm, Oir.)

AM *güγü-* /= *güγū*/ Precl. (= Sub.); MM *güγū-; CM *gū-* (Kalm, Oir, AKhor, Barin, Gor, Khar, Khor, Jal, Onn, Naim.)

АМ *ayu/= ayū/* Precl. (= Bod, Taq, Gü, Bur.); ММ *ayū-* (MNT, KMQB, Hy, D, IM.); СМ *ayū-* (Mngr, Ord.)

Гэтэл дээр дурдсан үгс нь орчин үеийн олонхи монгол хэл аялгуунд ***ai, ui, üi*** гэсэн хос эгшигтэй хэлэгдэж байна. Тэдгээрийн гаралыг авианы түүхэн хувьсалын үүднээс авч үзвэл, дээр дурдсан *yuyu-, güyü-, ayu*-гаас үүсээгүй, харин *yuyī-, güyī-, ayī-* гэсэн үндэсүүдээс үүссэн гэдэг нь эргэлзээгүй. Түүнийг нутлах жишээнүүд ч монгол хэлний бичигийн дурсхалуудад цөөнгүй тохиолдож байна.

АМ **yuyi-/=yuyī-/* Precl. (= Sul, Sub. /= yuyirinčin/); ММ *yuyī-* (MNT, Hy.), *yui-* [< yu'ī < yuyī-]; СМ *ǧuji-* (ÖMon.), *ǧoji-* (Dun.), *ǧui-* (Bao, Bur, Kha, Ord.), *ǧoi-* (Ha, But.), *ǧuē-* (Mngr.)

АМ **güyi-/= güyī/*; ММ *güyī-* (MNT), *güi-* [< gü'ī < güyī-] (Hy, Mu, IM.); СМ *guji-* (Man, Her.), *guī-* (Mngr, Jar.), *güi-* (Dag, Bur, Kha, Cha.), *gui-* (Mog, Ha, Ord.)

АМ **ayi-/= ayī-/*; ММ *ayī-* (Mu /= ayilγa-/); СМ *ayi-* (Mngr, Dun, Mar.), *a'i-* (Zir, KT, Her.), *aī-* (Mog.), *aī-* (Man.), *ai-* (SY, Bao, Dag, But, Kul, Bur, Kha, Cha.)

Монгол хэлний бичигийн дурсхалууд болон орчин үеийн монгол хэл аялгуунуудад буй дээр дурдсан жишээнүүдээс үзвэл, монгол хэлний хөгжилийн эртний шатанд *yuyu-/yuyi-, güyü-/güyi-, ayu-/ayi-* гэсэн хос хувилбарууд байсан гэдэгийг тогтоож болно.

(б) Орчин үеийн олонхи монгол хэл аялгуунуудад хос эгшигтэй хэлэгдэж байгаа *'дайр-', 'тойр-', 'буйр', 'суйр'* гэх мэт үгсийн гаралыг авч үзвэл, тэдгээр нь *dayir-, toyir-, buyir, suyir* гэсэн бүтэцтэй үгсээс үүсээгүй, харин *dayari-, toγari-, bayuri, sayuri* гэсэн үгсээс үүсчээ. Авианы түүхэн хувьсалын үүднээс авч үзвэл, гагцхүү дан урт эгшигтэй байх ёстой эдгээр үгсээс яагаад хос эгшигтэй хувилбар үүссэн бэ? Монгор, Буриад, Ордос зэрэг хэл аялгуунуудад их төлөв дан урт эгшигтэй хэлэгддэг эдгээр үгс нь Дагуур, Төв болон Өмнөд монгол хэлнүүдэд анхандаа мөн л дан урт эгшигтэй хэлэгдэж байгаад цаашдаа арынхаа тагнайн эгшигийн нөлөөгөөр урагшилан хос эгшиг бүхий шинэ хувилбартай болжээ.

АМ daγāri-

ММ da'āri- (MNT, KMQB.); СМ dāri- (Mngr,Ord.), dā̆r- (Kalm, Dör.), dā̆ ra- (Dg.), dēr- (AKhor,Barin, Gor, Khar, Khor, Jal, Tüm, Onn, Naim.)

СМ daire- (But.), daira- (Bur.), dair- (Kha, Cha.)

АМ toγāri-

ММ to'ōri- [< toγāri-] (MNT, Hy, Ph.), tōri- [< to'ōri-] (Mu.); СМ tōri- (Ord.), tōri- (Ha.), tōrə- (NÜd, Tünk), tō̆r- (Oir.)

СМ toirɒ- (Khar.), toir- (Kha, Bur.)

AM baγūri
- MM *ba'ūri; CM būri [< bu'ūri] (Bur, Ord.), būrə (Kalm.) bū̆rĭ (Tor.), bū̆r (Zach, Ba, Kho, Ur.)
- CM buir (Kha.)

AM saγūri
- MM sa'ūri (MNT), CM sūri (Ord.), sū́ri (Tson.), hūri (Bur.), sūr (Mngr.), sū̆rĭ (Kalm.), sū̆ŕ (Oir.)
- CM suir (Barin.), suir (Kha.)

1.3.3 ЭГШИГ АВИАНЫ ИЖИЛШИЛ

§ 86. **Эгшиг авианы ижилшилийг судалсан нь.** Монгол хэлний эгшигийн ижилшилийг авианы хувьсалынх нь хувид хамагийн анх ажигласан хүн бол А. Бобровников юм. Тэрвээр монгол, халимаг хэл ярианы материалыг бичигийн хэлтэй харьцуулан үзсэний үндэсэн дээр ижилшсэн эгшигүүдийн авианы орчин хийгээд хувьсах чиглэлийг тодорхойлжээ.[683] Үүнд:

... Буква *i* при согласных ***ш, ч, дж,*** всегда теряет собственный звук и произносится как следующая за нею гласная.

sidün	*sidar*	*čilaγun*	*ǰirüken*
шудун	шадар	чулуун	жирүкхэн

Буква *и* можеть, хотя не всегда, изменяться в следующую за нею гласную и при других согласных буквах.

nidün	*imaγan*	*ildü*
нюдун	ямаан	үлдү

Буква ***э***, находящаяся в первом слоге, когда за нею следует гласная ***γ***, обращается большею частью в ***ө***.

edür	*ergün*	*tegüs*
өдүр	өргүн	төгүс

Две последовательные гласные буквы ***γ*** и ***э***, или ***γ*** и ***а*** часто обращаются в две одинаковые гласные: ***ө,*** или ***о***.

dörben	*öngge*	*olan*	*qoyina*
дөрбөн	өнггө	олон	хоино

---

683 А. А. Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, Казань, 1849, 27-31

Если перед буквами ***ү*** и ***э***, или после них, находится еще буква ***э***, то и она, при изменении ***ү*** и ***э*** должна обратиться в ***ө***.

ebügen	*emüne*	*öber-e*
өбөгөн	өмнө	өбөрө

хэмээн дурдаад уламаар цааш нь: 1. *'Буква **а** может изменяться только от влияния предыдущих гласных,* 2. ***и, у, ү** изменяются только от влияния последующих,* 3. ***э** изменяется от влияния предыдущих и последующих гласных,* 4. ***о, и, ө** не подлежать изменением'* гэжээ.[1]

А. А. Бобровников энд монгол бичигийн хэл ба аман ярианы хэлийг харьцуулан үзсэний үндэсэн дээр монгол хэлний эгшиг авианы ижилшил, түүний хувьсах хөдөлгөөний чиглэлийг нилээд нарийн тодорхойлсон боловч уул ижилшил чухам хэдийд, ямар хүчин зүйлийн нөлөөгөөр явагдсан тухай асуудалыг тодоруулан гаргалгүй орхижээ.

Түүний дараа профессор G. J. Ramstedt *'Монгол бичигийн хэлийг Хүрээний аман аялгуутай харьцуулсан авиа зүй'* гэдэг бүтээлдээ монгол хэлний эгшиг авианы ижилшил хийгээд түүнд нөлөөлсөн зарим хүчин зүйлийн талаар цухас дурдсан байна. Үүнд:

*'Хэрэв эхний үед нь **і** эгшиг байгаад дараах үед нь өөр эгшиг орсон байвал тэр нь өмнөх эгшигтээ шингэн орж, өөрөөр хэлвэл, хөөмийн хөндий, хэлний уг хоёрын хооронд байгаа гийгүүлэгчийг бүтээхээс бүр өмнө дараах эгшигийнхээ дуудах байдалд ордог байна. ... Ном бичигийн хэл хийгээд шинэ монголын зарим аялгуунд эртний монгол хэлний **і** огт хэрэглэгдэхгүй болсон тохиолдол бий. Тухайлвал:*

***а**-гийн өмнө орсон **і** нь үгийн эхэнд **ja, jä** , бусад байранд **а**,ʲä , болсон*

mingγan	>	mʲä ŋğɒ	*'минга'*
imaγan	>	jamā	*'ямаа'*
miqan	>	maxxɒ	*'мах'*

***е**-гийн өмнө орсон **і** нь үгийн эхэнд ***jé**, бусад байранд ʲ**é, е**, болсон*

bider	>	bʲeddər	*'бидэр'*
nigen	>	neg, negə	*'нэг'*

***и**-гийн өмнө орсон **і** эгшиг ʲ**и, ӣ** болсон нь:*

čilaγun	>	tšulūn	*'чулуу'*
čisun	>	tsus	*'цус'*
ǰirγuγan	>	dzurγān	*'зургаа'*

ӣ-гийн өмнө орсон i нь үгийн эхэнд ӣ, бусад байранд ʲӣ, ī̈ болсон

sidün	>	šüd	*'шүд'*
ǰisün	>	ǰüs	*'зүс'*

o-гийн өмнө орсон i эгшиг o болсон нь:

čino	>	*tšono*	*'чоно'*
iruγar	>	*jorōl*	*'ёроол'*

ӧ-гийн өмнө орсон i эгшиг ӧ болсон нь:

irügel	>	*jörō̈ l*	*'ерөөл'*
čilüge	>	*tšölō̈*	*'чөлөө'*

*... Үгийн тэргүүн үеийн **i** эгшиг нь дэд үеийнхээ эгшигийн нөлөөгөөр хувьсан өөрчлөгдсөн нь хэлний хөгжилийн өөр өөр үед холбогдох бөгөөд эхлээд (XIII зууны үед) урагшилуу **i**, хожим хойшлуу **ï** нь өөрчлөгдсөн болохыг бид олж мэдэв. ... Хэрэв үгийн эхний үед богино **e** эгшиг байгаад дараагийн үед нь бүр эрт, эсвэл хожуу үеийн авианы хувьсалын уламаас **u/ü** орсон байвал эхний эгшиг нь уруулшин **ü** болсон байна. Жишээ нь:*

ebül	>	üwül	*'өвөл'*
edüi	>	üd^{ü}i	*'өдий'*
terigün	>	türūŋ	*'түрүүн'*

*Хэрэв эхний үеийн эгшиг нь **o, ӧ** байгаад дараах үеийн эгшиг нь **a** буюу **e** байсан бол олонхи аялгууны дэд үеийн эгшиг нь уруулшсан байна* [*684] гэжээ.

Халх аман аялгууг судалсан нэрт эрдэмтэн академич Б. Я. Владимирцов *'Монгол бичгийн хэлийг халхын аман аялгуутай харьцуулсан хэл зүй'* гэдэг алдарт бүтээлдээ монгол хэлний эгшиг авианы ижилшил, ялангуяа тэргүүн үеийн ***i*** эгшигийн ухаран ижилшилийн талаар нилээд тодорхой дурдсан байна. Тухайлвал,

*'Там где в монг.-письм. в первом слоге имеется **i** (< *ï и < *i), а в последующем слоге какой-нибудь гласный, напр., **a, e, u, ü**, в халхаском оказывается на месте **i** гласный последующего слога или очень ему близкий. Явление это объясняется тем, что гласный второго слога антиципировался, т.е. голосовой аппарат принял положение, необходимое для воспроизведения этого гласного до образования находя-щегося между **i** и последующим гласным согласного. Этот антиципированный гласный получил ударение, сделался главным гласным слога, а первоначальный гласный **i** или исчез совершенно, или же сохранился в виде краткого скользящего звука. ... Ввиду того, что подобных случаях последующий гласный как-бы проникает в первый слог, явление это, очень часто*

---

[684] Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, 51-52

встречающееся, получило название 'перелома' гэжээ.[685] Тэрвээр энд үгийн тэргүүн үеийн ***і*** эгшигийн хувьсалыг мөн л *'авианы эвдэрэл'*-ийн үүднээс авч үзсэн[686] аталаа ***і***-гээс бусад эгшигийн адил хувьсалыг эгшигийн солигдол, уруулшилын талаас тайлбарлажээ.[687]

Хожим профессор Г. Д. Санжеев *'Монгол хэлнүүдийн харьцуулсан хэл зүй'* гэдэг номдоо монгол хэлний эгшиг авианы ижилшилийн талаар '... *характер гласных первого слога влияет на состав гласных непервых слогов: olŏŋ 'много', öndör 'высоко' и. т. д. Это в меньшей степени относится к классическому языку, которой в непервых слогах не имел* ***о*** *(были а или и) и* ***ӧ*** *(были* ***е*** *или* ***ӥ*** *): öndür 'высоко', olan 'много', ebül 'зима' = халхаск. öböl, ойратск. üwül.'* гэж дурдсан байна.[688]

Тэрвээр уул зохиолдоо дундад үеийн монгол хэлний хоёр эгшигийн дундах зарим гийгүүлэгч сугарсаны дараа уул сугарсан гийгүүлэгчийн хоёр захын эгшиг ижилшсэн байдалын тухайд: *'Двоеслоги, состоящие из разных гласных (напр.,* ***о*** *+* ***а****,* ***а*** *+* ***и****,* ***е*** *+* ***ӥ****), удерживаются в течение более длительного времени, постепенно развиваясь в соответствующие дифтонги, как это в разной степени можно видеть и теперь в могольском и дагурском языках. Эти дифтонги, составные части которых подвергались иногда регрессивной (***о*** + ***а*** > ***а*** + ***а*** - в ойратских и прочих диалектах;* ***а*** + ***и*** > ***и*** + ***и****,* ***е*** + ***ӥ*** > ***ӥ*** + ***ӥ*** - во всех монгольских диалектах) или прогрессивной (***о*** + ***а*** > ***о*** + ***о*** в халхаских, бурятских, и прочих восточных диалектах) ассимиляции, затем уже быстро превратились в долгие гласные современного типа (ā/ō, ӣ/ӧ̄)'* гэжээ.[689] Зохиогч энд дундад үеийн монгол хэлний сугарсан гийгүүлэгчийн хоёр талын эгшигийн ижилшилийг нарийн зөв ажигласан боловч тэдгээрийн ижилшсэн шалтгааныг тодорхой тайлбарласангүй.

Академич Ш. Лувсанвандан монгол хэлний авиа зүйн бүтээлүүддээ монгол хэлний эгшиг авианы ижилшил, ялангуяа дундад үеийн монгол хэлний эгшигийн ижилшилийн талаар нилээд тодорхой дурджээ. Тэрвээр *'Орчин цагийн монгол хэлний зүй'* бүтээлдээ: *'Монгол хэлний өргөлтгүй үеийн эгшгүүд нь өмнөх өргөлттэй үеийнхээ эгшигтэй эр эмээр, уруулаар дэвшин ижилшнэ'*[690] хэмээн дурдаад эгшиг авианы дэвшин ижилшилтэд үгийн тэргүүн үеийн эгшигийн өргөлт голлох нөлөөтэй болохыг онцлон дурдсан байна. Мөн *'Орчин цагийн монгол хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд'* гэсэн үгүүлэлдээ дундад үеийн монгол хэлний хоёр эгшигийн дундах зарим гийгүүлэгч гээгдсэний дараах эгшиг авианы ижилшилийн талаар дурдахдаа: *'Дундад үеийн монгол хэлэнд* ***і****-тэй залгалдан орсон бусад эгшиг үзэгдэхээс* ***іи****,* ***аи****,* ***иа****-гаас гадна* ***ії****,* ***аӣ****,* ***иā*** *гэх мэтчилэн бусад эгшиг ч*

---

685 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 176

686 ibid., 176

687 ibid., 151-152, 176, 311

688 Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, 74

689 ibid., 78

690 Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Авиа, авиалбар хоёр нь, 56

*хос хосоороо залгалдан орж байсан байна. ... Гэвч дурдсан **аī, еī** мэтийн өгсөх хос эгшгийн богино **а, е** мэтийн эгшиг нь дараах урт **и, ӣ** эгшигтэйгээ ижилшиж **и, ӣ** болоод дараагаар нь биеэ даасан фонемынхоо чанарыг алдсан байж таарна. Жишээ нь:*

aγula	>	a'ūla	>	u'ūla	>	ūla
egüle	>	e'ūle	>	ü'ūle	>	ūle

*Гэвч **о'ā, ö'ē** гэсэн хос эгшиг нь өмнөх уруулшсан **о, ö** эгшигээ гээгдэхээс өмнө дараах урт **ā, ē** эгшиг нь өмнөх уруулшсан **о, ö** эгшигтэй ижилшиж урт **ō, ӧ̄** болсоны дараа өмнөх богино **о, ö** нь гээгдсэн байж таарна.*

ögéde	>	ögēde	>	ö'ēde	>	ö'ӧ̄ de	>	ӧ̄ d
toγá	>	toγā	>	to'ā	>	to'ō	>	tō

гэжээ.[691]

Дээрхи эрдэмтэдийн саналыг нийтэд нь ажиглан үзвэл, тэд цөм монгол хэлний эгшиг авианы ижилшилийг аль нэгэн хэмжээгээр тусхасан боловч эгшиг авиа ямар нөхцөлд дэвшин ижилшиж, ямар нөхцөлд ухаран ижилшдэгийг бүрэн тод илэрүүлэн гаргасангүй.

Түүнчилэн орчин үеийн монгол хэл аялгуунууд дахь эгшигийн ижилшилийн талаар Ш. Лувсанвандан,[692] В. И. Рассадин[693] нарын бүтээлд зохих хэмжээгээр туссанаас гадна эгшиг авианы ижилшилийг авианы орчинтой нь холбон тайлбарласан тусхай үгүүлэл гарсан бий.[694]

Бид энд монгол хэлний авиа зүйн судалалд гарч ирсэн *'і-гийн эвдэрэл'* (энэ нэр томъёо манайд *'і-гийн нугарал'*[695] гэдэг нэрээр хэвшжээ. Д.Т.) хэмээх асуудалын талаар бага зэрэг тодоруулан дурдая.

Монгол хэл шинжилэлд *'і-гийн эвдэрэл'* гэдэг ойлголтыг анх проф. G. J. Ramstedt үндэслэжээ. Тэрвээр Хүрээний халх аялгууны тухай бүтээлдээ: *'Үгийн тэргүүн үеийн і эгшигийн байранд дараах үеийнх нь эгшиг нэвтрэн орж ижилшээд... уридынхаасаа илүү уужим, дуутай, өргөлтөт эгшиг болжээ.'* гэж

---

691 Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд, 23-24

692 Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Авиа, авиалбар хоёр нь, 56, Орчин цагийн монгол хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд, ХЗ. 4, 1966, 23-24;

693 В. И. Рассадин, Очерки по исторической фонетике бурятского языка, 7-56

694 Д. Төмөртогоо, Дундад үеийн монгол хэлний эгшиг авианы ижилшил, МС 8:15, 1971, 191-202

695 Үгийн тэргүүн үед байсан эгшиг дараах үеийнхээ эгшигийн нөлөөгөөр хэлэгдэх шинжээ алдаж, өөр эгшиг болсоноос тухайн үгийн бүтэцэд гарсан хувьсал нь *'нугарал'* биш, харин *'эвдэрэл'* юм. Өөрөөр хэлвэл, энэ нь авианы бүрэлдэхүүнд гарсан хувьсалыг үгийн бүтэцийн талаас авч үзсэн нэрлэлт юм.

дурдсан байна.[696] Тэрвээр энд үгийн тэргүүн үеийн ***i*** эгшигийн хувьсалын эцэсийн үр дүнг зөв олж ажигласан боловч түүний учир шалтгааныг авианы түүхэн хувьсалын үүднээс хараахан тогтоосонгүй, харин герман хэлний зүйд байдаг *brechung* (авианы эвдэрэл) гэдэг ойлголтын талаас авч үзсэн байна. Мөн N. Poppe, S. Kaluzynski нар үгийн тэргүүн үеийн ***i*** эгшигийн ижилшилийн үр дүнг *'авианы эвдэрэл'*-д хамааруулжээ.[697] Хожим профессор Г. Д. Санжеев дээрхи хувьсалыг улам цааш дэлгэрүүлэн гурван үе шат дамжсан авианы онцгой түүхэн үзэгдэл гэж үзсэн байна.[698] Түүнийг хураангуйлан тайлбарлавал:

1. Монгол хэлний хамжих ****d*** гийгүүлэгчээс хамжин шүргэх ***dž*** үүсч амжаагүй байсан тэр үед (= барагцаалвал VII-X зуун) уул ***i***-гийн арын ****ï ~i*** нь өөр эгшиг болж хувирсаныг *'**i**-гийн нэгдүгээр эвдэрэл'* гэжээ.

*kadiγar > kadaγar > Mog. kadār

2. Хамжих ****d*** гийгүүлэгчээс хамжин шүргэх ***dž*** үүссэн тэр үед (= барагцаалвал X-XII зуун) уул ***d***-гийн арын ***ï ~ i*** эгшиг олонхи хэл аялгуунд дараах үеийнхээ эгшигтэй ижилшсэнийг *'**i**-гийн хоёрдугаар эвдэрэл'* гэжээ.

*kadiγar > kadžiγar > kadžaγar

3. Хамжих ****d*** гийгүүлэгчээс үүссэн хамжин шүргэх ***dž*** хэвээрээ хадгалагдаж байсан тэр үед (= барагцаалвал XIV-XV зуун) уул ***dž***-гийн арын эгшиг дараах үеийнхээ эгшигт ижилшин, уламаар нэгэн үед багтах болсоныг *'**i**-гийн гурав дугаар эвдэрэл'* гэж нэрлэжээ.

*kadiγar > kadžiγar > Ord. χadžār

Өмнөх эрдэмтэд гагцхүү үгийн тэргүүн үеийн ***i***-гийн хувьсалыг *'эвдэрэл'*-д хамааруулан үзэж байсан бол профессор Г. Д. Санжеев үгийн тэргүүн бус үеийн ***i***-гийн хувьсалыг ч бас *'эвдэрэл'*-д багтаан үзжээ. Энэ нь *'brechung'* (эвдэрэл) гэсэн хэл шинжилэлийн ойлголтыг зөрчсөн төдийгүй, дараалан орсон эгшигүүдийн харилцан нөлөөлөлийн үр дүнг бус, харин арын эгшигийнхээ нөлөөнд татагдан ухарч ижилшихийг *'эвдэрэл'* хэмээн үзсэн байна. Хожим профессор H. Kuribayashi монгол хэлний *'**i**-гийн эвдэрэл'*-ийн талаар цуварал үгүүлэл нийтлүүлжээ.[699]

---

696 Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, 51

697 N. Poppe, On the so-called Breaking of **i* in Mongolian, UAJb 28:1-2, 1956, 43-48; On Some Ceses of Assimilation of **i* in Mongolian, CAJ 8:3, 1963, 215-218; S. Kaluzynski, Zur Frage der *i*-Brechung im Mongolischen, UAJb 36, 1965, 340-347

698 Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, 108-114

699 H. Kuribayashi, On the 'Breaking of **i*' of Mongolian, Regularity and Irregularity of the Development of **i* in Mongolian, *Bulletin of the Japan Association of Mongolian Studies,* No 12, 1981, 32-49, On the 'Breaking of **i*' of Mongolian, Parallel Development of the Vowel **i* in Khalkha and Urdus Dialects, *Bull. of the Japan Assoc. of Mongolian Studies,* 13, 1982, 37-55, Some Problems in the 'Breaking of **i*' in Mongolian, JLSJ 82 (1982), 29-47

Тэрвээр эгшиг авианы хоёр өөр хувьсалын үр дүнд мөн хоёр өөр *'эвдэрэл'* болсон гэж үзээд эцэст нь *'i-гийн эвдэрэл' гэдэг нь үгийн тэргүүн үеийн i эгшиг дараах үеийнхээ эгшигтэй ухаран ижилшихийг хэлнэ'* гэж тодорхойлсон байна.[700]

Эцэст нь дүгнэж хэлэхэд, монгол хэл шинжилэлд үгийн тэргүүн үеийн эгшигүүдийн ухарах ижилшилийн дотороос зөвхөн *i* эгшигийн ижилшилийг дангаар нь таслан авч *'эвдэрэл'* хэмээн зохиомолоор нэрийдсээр иржээ. Гэтэл түүнийг үгийн тэргүүн үеийн бусад эгшигийн ижилшилтэй харьцуулан үзвэл тэр нь байрааараа ч, татагдах чиглэлээрээ ч, авианы гадаад нөлөөлөлөөрөө ч харилцан адил байна. Тийм учираас үгийн тэргүүн үеийн *i*-гийн ухарах ижилшил нь авианы хөгжилийн хэд хэдэн үе шатыг дамжсан *'эвдэрэл'* гэгч онцгой үзэгдэл биш, харин дундад үеийн монгол хэлний үед явагдсан нийт эгшиг авианы ухарах ижилшилийн нэгээхэн хэсэг нь юм.

Эгшиг авианы ижилшилийн тухай тэмдэглэл. Хэлний авианы харилцан бие биедээ нөлөөлөх хууль дээр үндэслэсэн эгшиг авианы хүчдэлээр зохьцох тогтолцоо бүр эртний монгол хэлний үед бүрэлдэн тогтсон байжээ. Эртний монгол хэлэнд үгийн тэргүүн үеийн эгшиг нь хэдийгээр дараах үеийнхээ эгшигийг цуваагаар захиран тогтоож байсан боловч тэдгээр нэгэн цувааны эгшигүүд нь өөр хоорондоо бүрэн харилцан ижилшээгүй байжээ. Тэрхүү зохицол нь цаашид улам боловсоронгуй болсоор дундад үеийн монгол хэлний үед нэгэн цуваанд багтаж байсан эгшигүүд нь зэрэгэлдээх үеийнхээ аль хүчтэй эгшигт татагдан хэлэгдэх байдалаараа түүнтэй улам бүр ойртсоор эгшиг авианы ижилших явц эхэлсэнийг тэр үеийн бичигийн дурсхалууд бэлхэнээ гэрчилж байна.

Бид энд дундад үеийн монгол хэлний үед ижилшсэн эгшигүүдийн байрлал, зэрэгэлдээх үеийнх нь эгшигийн хэлэгдэх байдал, тэдгээрийн харилцан нөлөөлөл буюу эгшигийн ижилшилд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйл, ижилшсэн учир шалтгаан, ижилшилийн чиглэлийн талаар авч үзэе.

Дундад үеийн монгол хэлний эгшиг авианы ижилшилийг тал бүрээс нь ажиглан үзвэл, зонхилох давуу шинж бүхий доор дурдсан гурван гол хүчин зүйл нөлөөлжээ. Үүнд:

1. Өвөг монгол хэлний үеэс тогтвортой хадгалагдаж ирсэн үгийн тэргүүн үеийн *өргөлт*. Тэрхүү өргөлт нь тэргүүн бус үеийн эгшигээсээ илүү тод, эрчимтэй хэлэгддэг тул дараах үеийнхээ эгшигүүдийг цуваагаар захиран зохьцуулж байдаг байна.

2. Үгийн тэргүүн болон тэргүүн бус үеийн эгшигийн *уруулшил*. Дундад үеийн монгол хэлний үед уруулын эгшигийн нөлөө улам нэмэгдэж, зэрэгэлдээх үеийнхээ уруулын бус эгшигт нөлөөлөн, түүнийг өөртөө татан ижилшүүлэхэд хүргэдэг байжээ.

---

[700] H. Kuribayashi, Some Problems in the 'Breaking of **i*' in Mongolian, JLSJ 82 (1982), 47

3. Эртний монгол хэлний утга ялгах фонемоос үүсэн бүрэлдсэн *урт эгшиг*. Үгийн тэргүүн бус үед орсон үүсмэл урт эгшиг нь өмнөх үеийхээ богино эгшигийн хэлэгдэх байдалд нөлөөлөн түүнийг өөртөө татан ижилшүүлсэн байна.

Монгол хэлний эгшиг авианы ижилшилийг татаж байгаа гадаад нөлөөлөлийн талаас нь бус, харин зэрэгэлдээх үеийнхээ хүчтэй авианд татагдан ижилшсэн хөдөлгөөний чиглэлээр нь *дэвшин ижилшил, ухаран ижилшил* гэж ялган үзэж болно. Эгшиг авианы ижилшилд дээрхи гурван гол хүчин зүйл нөлөөлсөн бөгөөд заримдаа өргөлтөт эгшиг-уруулын эгшиг, урт эгшиг-уруулын эгшиг гэсэн хоёр хүчин зүйл давхардсан тохиол ч байдаг байна.

Бид энд дундад үеийн монгол хэлний эгшиг авианы ижилшилд холбогдох жишээг XIII-XIV зууны монгол хэл аялгууны онцлог шинжийг тусхасан хитад, араб-перс, дөрвөлжин бичигийн дурсхалуудаас түүж авсан болно.

1.3.3.1 ЭГШИГ АВИАНЫ ДЭВШИХ ИЖИЛШИЛ

Хэрэв үгийн тэргүүн үеийн эгшиг дээр бүрэн тод хэлэгдэх өргөлт, уруулаар хэлэгдэх шинж хоёр давхардсан байвал дэд үеийн богино эгшиг нь түүнд татагдан дэвшиж ижилшсэн байна.

1.3.3.1.1 **Богино эгшиг богино эгшигтэй дэвшиж ижилших нь**

ММ o/o < АМ o/a

ММ *oron* ‘орон’ (MNT, KMQB) <*oran* (D, Mu.) ~ АМ *oran* Precl. (= Chang.); Cf. СМ *orɒn* (Kalm.; *oroŋ* (SY, Bur, TMon, ÖMon. oron (Dun, Bao.)

ММ *olon* ‘олон’ (MNT, KMQB, Mu.) < *olan* (D, Mu, IM, L.) ~ АМ *olan* Precl. (= Bod, Hin, Ölǰ, Taq.); Cf. СМ *woalan* (Ha.), *olon* (SY, Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.)

ММ *ǰobalaŋ* ‘зовлон’ (MNT, KMQB, Mu.) < *ǰobalan* (Mu, IM.) ~ АМ *ǰobalaŋ* Precl. (= Bod, Chang, Alt, Bur.); Cf. СМ *zowlɒn* (Kalm, Oir.); *džowoloŋ* (Ord.), *zowoloŋ* (Bur.), *džowlon* (ÖMon.), *dzowloŋ* (TMon, ÖMon.)

ММ *oŋqoča* ‘онгоц’ (Tk, Ist.), *oŋqočas* (D.) < *oŋqača* (Hy, Mu.) ~ АМ *oŋγača* Precl. (= Abaγa /= oŋγačačin/); Cf. СМ *oŋğɒtšɒ* (Kalm.), *oŋğotšo* (Ord.), o*ŋğotš* (AKhor, Barin, Khar, Tüm, Cha.), *oŋğotso* (Bur.)

MM **o/o** < AM **o/u**

MM *ordo* 'орд' (MNT, Hy.) < AM *ordu* Precl. (= Jig, Taq, Bur.); Cf. CM *ordo* (Bur.), *ordŏ* (TMon, ÖMon.)

MM *omoγ* 'омог' (MNT, KMQB.) < AM omuγ Precl. (= Hin, Sub.); Cf. CM *omog* (Bur, TMon, ÖMon.)

MM *dotora* 'дотор' (MNT, KMQB, Hy, D, Mu.) < *dotura* (Mu.) ~ AM *dotura* Precl. (= Bod, Jig, Taq, Sul.); Cf. CM *dotoro* (Ord.), *dotor* (Bur, TMon, ÖMon.)

MM *sonos-* 'сонс' (MNT, Hy.) <*sonus-* (IM, L.) ~ AM *sonus-* Precl. (= Bod, Chang, Taq, Bur.); Cf. CM *sonus-* (Mog.), *sonos-* (Dun, Dag, Bur, TMon, ÖMon.)

MM **ö/ö** < AM **ö/e**

MM *kökö* 'хөх' (MNT, Hy, TK.) < *köke* (Mu, IM, L.) ~ AM *köke* Precl. (= Bod, Bur, Sub.); Cf. CM *χöχə* (Alar.), xüxe (Bur.), *kuke* (Ha.), *kuka* (Mog.); *kökö* (Tünk, NÜd.), kökə (Kalm, Oir.), *χöχə* (TMon.), *göxö* (Ord.)

MM kölösün 'хөлс' (Hy.) < kölesün (MNT, Mu.) ~ AM kölesün Precl. (= Bur.): Cf. CM kulesun (Dun.), kulesun (SY.), köləsən (Tor.), xöləhən (Alar.), hulese (But.), kölösü (Ord. kölöhöŋ (NÜd, Tünk. xölös (TMon.)

MM *örgön* 'өргөн' (D.) < *örgen* (MNT, Hy.) ~ AM *örgen* Precl. (= Bod, Bur.); Cf. CM *örgän* (Kalm, Oir.), *ürgen* (Bur.), *örgön* (TMon, ÖMon.)

MM *ködöl-* 'хөдөл' (MNT) <*ködel-* (MNT, Mu.) ~ AM *ködel-* Precl. (= Sul, Bur, Sub.); Cf. CM *xüdel-* (Bur.), *χudel-* (Dag.), *gudel-* (SY.), *ködäl-* (Oir.), *χödöl-* (TMon, ÖMon.)

Эртний монгол хэлний үед үгийн тэргүүн бус үед тохиолддоггүй байсан ***o, ö*** эгшиг дундад үеийн монгол хэлний эгшигийн ижилшилийн үр дүнд шинээр гарч ирсэнийг дээрхи жишээнүүдээс ажиглаж болно.

Ер богино эгшигийн дэвших ижилшил нь дундад үеийн монгол хэлний үед бүрэн явагдаж дууссангүй, орчин үеийн монгол хэлний үед ч бас үргэлжилжээ. Тийм учираас дундад үеийн монгол хэлний бичигийн дурсхалуудад дэвшин ижилшиж амжаагүй байсан өдий төдий үг өдгөөгийн нилээд хэл аялгуунуудад бүрэн ижилшсэн байна.

MM *dörben* 'дөрвөн' (MNT, Hy, Tk, D, Mu, IM, L, Ist.); CM *dörwön* (TMon, ÖMon.), *dörwön* (Oir.)

MM mören 'мөрөн' (Mu, L, Ist.); *müren* (MNT, KMQB, Hy, Tk.); CM *mörön* (TMon, ÖMon.), *mörə n* (Oir.)

ММ *köŋgen* ‘хөнгөн’ (Ну.), *köngen* (Mu, IM.), *köngēn* (Ist.); СМ *köŋgön* (TMon, ÖMon.), *köŋöŋ* (NÜd.), *könöŋ* (Khori.)

ММ *öŋge* ‘өнгө’ (MNT, Ph.), *öŋge* (Mu.), *öŋgen* (IM.); СМ *öŋgö* (TMon, Ömon.), *öŋgə* (Kalm, Oir.

Богино эгшигийн дэвших ижилшил нь зөвхөн үгийн язгуур, үндэсийн хүрээнд төдийгүй, язгуур + дагавар, үндэс + нөхцөлийн хооронд ч нэгэн адил явагдсан байна. Эртний болон дундад үеийн монгол хэлний үед байсан уруулын бус богино эгшигтэй дагавар, нөхцөлүүд нь орчин үеийн буриад, Халимаг, Ойрд, Төв болон Өмнөд монгол хэлний олонхи аялгуунд уруулын ***o, ö*** бүхий шинэ хувилбаруудтай болжээ.

	АМ		ММ	СМ
дагавар:	-dal|-del	||	-dal|-del	-dal |-del + -dol|-döl
	-lan|-len	||	-lan|-len	-lan|-len + -lon|-lön
	-tan|-ten	||	-tan|-ten	-tan|-ten + -ton|-tön
нөхцөл	-tai|-tei	||	-tai|-tei	-tai|-tei + -toi|-töi
	-tal|-tel	||	-tal|-tel	-tal|-tel + -tol|-töl

1.3.3.1.2 **Урт эгшиг богино эгшигтэй дэвшиж ижилших нь**

ММ **ō < o’ō < o’ā <** АМ **oγā**

ММ *tō* ‘тоо’ (Mu, L.) < *to’ōn* (KMQB, Ph.) < *to’ān* (MNT, KMQB.) < АМ *toγā* Precl. (= Jig, Teh, Sul.); Cf. СМ *toa* (Mog.); *tō* (Mngr, Dag, Kalm, Oir, TMon, ÖMon.)

ММ *bōl* ‘боол’ (Mu, L.) < *bo’ōl* (MNT, KMQB, Ну.) < *bo’āl* (Mu, IM, R) < АМ **boγāl* Cf. СМ *bōl* (Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.)

ММ *tōsun* ‘тооc’ (IM, Ist.) < *to’ōsun* (MNT, Ну, Tk, Ph.) < **to’āsun* < АМ *toγāsun;* Cf. СМ *toarăl* (Ha.), *tuāse* (But.), *tōsɒn* (Kalm, Tor.); *tōsu* (Ord.), *tōsun* (Dör.), *tōhon* (Bur.), *tōs* (TMon.)

ММ *qōsun* ‘хоосон’ (Mu, IM.) < *qo’ōsun* (MNT, Ну.) < *qo’āsun* (Mu.) < АМ *qoγāsun;* Cf. СМ *ōdzen* (Mngr.), *χōsɒn* (Kalm, Oir.), *χōson* (TMon, ÖMon.), *χōhon* (Bur.)

Жич: Сонгодог бичигийн өмнөх үеийн монгол бичигийн дурсхалуудад хоёр эгшигийн хоорондох *-γ/g-* гийгүүлэгч сугарахаас өмнө түүний ард байсан ***ā*** эгшиг тэргүүн үеийнхээ уруулын эгшигт татагдан ижилшсэн байна. Иймм ижилшил нь эртний монгол хэлний сүүлч үед холбогдоно. Монгол бичигийн дурсхалууд болон монгол бичигийн хэлний хэвшсэн бичлэгт тулгуурлан *‘боол’, ‘тоос’, ‘хоосон’* гэх мэт үгсийн доторхи урт эгшигийг уулаас уруулын ***ū*** байсан гэж үзвэл тэдгээр үг нь

эгшиг ижилших зүй тогтолын дагуу *bu'ūl (< bo'ūl < boγūl), tu'ūsun (< to'ūsun < toγūsun), qu'ūsun* (< *qo'ūsun* < *qoγūsun*) гэсэн хувьсалыг дамжин орчин цагийн монгол хэлэнд *būl, tūs, xūsan* гэсэн бүтэцтэй үгс болох байсан билээ.

ММ ӧ̄ < ӧ'ӧ̄ < ӧ'ē < АМ ögē

ММ *bӧ̄ re* 'бөөр' (L.) < *bӧ̄ rek* (Ist.) < bӧ'ӧ̄ re < *bӧ'ēre* (MNT, Hy, IM.) < АМ *bögēre* Precl. (= Bur.); Cf. СМ *böär* (Dör.), *boara* (Mog.), *bӧ̄re* (Dag, Bur.), *bӧ̄rə* (Kalm.), *bӧ̄rö* (Ord.), *bӧ̄r* (Ha, TMon, ÖMon.)

ММ *čӧ̄n* 'цөөн' (Mu, IM.) < *čӧ'ӧ̄n* < *čӧ'ēn* (MNT, Hy.) < АМ *čögēn* Precl. (= Taq, Chang, Qqot.); Cf. СМ *tšӧ̄n* (AKhor, Barin, Tüm, Cha.), *tsӧ̄n* (Kha, Dg, Sgol.), *ötšӧ̄n* (Ord.), *üsӧ̄n* (Bur.)

ММ *bӧ̄sün* 'бөөс' (L, Ist.) < *bӧ'ӧ̄sün* < *bӧ'ēsün* (MNT, Hy, Mu.) < АМ *bögēsün* (Mo.), Cf. СМ *bōsun* (Zir.), *bӧ̄sən* (Kalm, Oir.), *bӧ̄hen* (Bur.), *bӧ̄s* (TMon, ÖMon.)

ММ *ǰӧ̄len* 'зөөлөн' (Mu, Ist.) < *ǰӧ'ӧ̄len* (MNT) < *ǰӧ'ēlen* (Hy, Mu.) < АМ *ǰögēlen* Precl. (= Bur, Sub.), Cf. СМ *ǰōlan* (Zir,Mar.), *zӧ̄lən* (Kalm, Oir.), *zӧ̄len* (Bur.), *dzӧ̄lön* (TMon, ÖMon.)

Урт эгшигийн дэвшин ижилшилийн үр дүнд эртний болон дундад үеийн монгол хэлний үед зөвхөн эр, эм хувилбартай байсан уруулын бус урт эгшиг бүхий дагавар, нөхцөлүүд нь орчин үеийн зонхилох хэл аялгуунд ***ō, ӧ̄*** эгшигтэй шинэ хувилбаруудтай болжээ.

<u>дагавар</u>:	-ān/-ēn ‖-ōn/-ӧ̄ n	[<ММ -'ān/-'ēn <АМ -ban/-ben ‖ -γan/gen]
	-ā/-ē‖-ō/-ӧ̄	[< ММ -'ā/-'ē< АМ -γā/-gē]
<u>нөхцөл</u>:	-ās/-ēs ‖-ōs/-ӧ̄ s	[<ММ -'ās/-'ēs <АМ -ača/-eče]
	-ār/-ēr ‖-ōr/-ӧ̄ r	[<ММ -'ār/ -'ēr <АМ -bar/-ber ~ -γar/-ger]
	-ād/-ēd ‖-ōd/-ӧ̄ d	[<ММ -'ād/-'ēd <АМ -γād/-gēd]

1.3.3.2 ЭГШИГ АВИАНЫ УХАРАХ ИЖИЛШИЛ

Хэрэв үгийн тэргүүн бус үеийн эгшиг нь хэлэгдэх хүчдэлээрээ өмнөх үеийнхээ эгшигээс давуу байвал өмнөх үеийн эгшиг нь дараа үеийнхээ хүчтэй эгшигт татагдан ухарч ижилшсэн байна. Тухайлвал, үгийн тэргүүн үеийн уруулын бус үеийн ***i, e***-ийн дараа уруулын бус уруулын богино ***u, ü*** эгшиг орсон бол өмнөх үеийн эгшиг нь арын эгшигтээ татагдан ухарч ижилшжээ.

1.3.3.2.1 Богино эгшиг богино эгшигтэй ухарч ижилших нь

AM **i/u** > MM **u/u**

AM *čisun* 'цус' Precl. (= Bur, Sub.) ~ MM *čisun* (MNT, Hy, Mu, IM, L.) > *čusun* ~ CM *čusun* (Mog, Zir, Dun, SY.), *tsusun* (Dör, Zakh, Ur.), džusu (Ord.), *suhuŋ* (NÜd, Tünk.)

AM *ǰiru-* 'зур' Precl. (= Bur.) ~ MM *ǰiru-* (IM.) > *ǰuru-* (Mu.) > CM *džuru-* (Ord.)

AM *nidur-* 'нудар' (Mo.) ~ MM *nidur-* (MNT) > *nudur-* (Mu, L.) ~ CM *nudur-* (Ord.)

AM *ǰirγuγān* 'зургаан' Precl. (Bod, Aruγ, Hin.) ~ MM *ǰirγu'ān* (Mu.) > *ǰurγu'ān* (Ist.)

AM **i/ü** > MM **ü/ü**

AM *ničügün* 'нүцгэн' Precl. (= Bur.) ~ MM *ničügün* (MNT, Mu.) ~ *ničigen* (IM.) > *nüčügen* (Mu.); CM *nütšügün* (Ord.), *mutšugun* (Dun.), *nusugun* (Khori.)

AM ǰirüken 'зүрх' Precl. (= Bur, Sub.) ~ MM *ǰirüken* (MNT) > *ǰürüken* (Hy, Mu.) ~ *ǰürüke* (IM.) ~ CM *ǰuruku* (Kul.), *džurugu* (Ha.), *dzürkün* (Oir.)

AM *sidün* 'шүд' Precl. (= Bur, Sub.) ~ MM *sidün* (Hy, Mu.) > *šidü* (MNT, Mu.) > *šüdün* (MNT) ~ CM *sudun* (Mog, Zir, Man, Mar.), *sudun* (Kun, Her.), *šuddun* (Leech.), *šüdü* (Ord.), *šüdən* (Dör, Zakh.)

AM **xildü ~ (h)ildü* 'илд' Precl. (= Maha, Bur, Sub.) ~ MM *hildü* (Mu.) > *üldü* (MNT, Hy.) // CM *uldu* (Zir, Man, Mar, Ord.), *urdu* (Mngr.)

AM **e/ü** > MM **ö/ü** > **ü/ü**

AM *ebül* 'өвөл' Precl. (= Bur, Sub.) ~ MM *ebül* (Mu.) >*öbül* (Mu, IM.) > *übül* (MNT, KMQB, Hy, Tk, Ph.); Cf. CM *öbül* (Tünk.), *öwöl* (TMon, ÖMon.), *ubul* (Mog.), *ugul* (Dag.), *ugur* (Mngr.), *ubun* (Dun.), *üwül* (Dör, Zakh, Kho.)

AM *edür* 'өдөр' Precl. (= Taq, Bur, Sub.) > MM *ödür* (Mu, IM, L, Ist.) > *üdür* (MNT, KMQB, Hy, Ph.) ~ *udur* (R.); Cf. CM *ödür* (Mar, Dör, Zakh.), *ödör* (TMon, ÖMon.), *udur* (Dag, Mog, Ord.), *udur* (Her, Mngr, SY)

AM *emüne* 'өмнө' Precl. (= Hin, Jig, Taq.) ~ MM *emüne* (MNT, KMQB, Hy, Tk.) > *ömüne* (Mu.), CM *ömün* (Ur), *ömönö* (TMon, ÖMon.)

AM *temür* 'төмөр' Precl. (= Bur.) ~ MM *temür* (MNT, KMQB, Hy, Mu, L.) > CM *tömör* (Oir, TMon, ÖMon.), *tumur* (Ha, Khori.)

Жич: Үгийн тэргүүн үеийн уруулын бус богино эгшиг нь ухаран ижилших явцдаа уруулын шинжтэй болсон тул тэр нь цаашдаа бүрмөсөн ухарч ижилшсэнгүй, харин дараах үеийнхээ уруулын богино эгшигийг өөртөө татаж, дэвшин ижилшүүлсэн байна. Тодоруулан хэлбэл, үгийн тэргүүн үеийн эгшиг нь уулын бүрэн тод хэлэгдэх шинж дээрээ уруулын шинжийг нэмж олсон тул үгүүлэгдэх байдалаараа дэд үеийнхээ эгшигээс давамгай хүчтэй болсон учир тухайн үгэн дэх ижилших хувьсалын чиглэл тийнхүү өөрчилөгдсөн байна.

AM **ö/ü** > MM **ü/ü**

AM *öndür* ‘өндөр’ Precl. (= Qqor, Bur.) ~ MM *öndür* (Mu.) > *ündür* (MNT, KMQB, Hy, Ph.), CM *undur* (Ha, Ord.), *ündür* (Kham, Barg.), *undu* (Dun.), *öŋdör* (Kha, Cha, Učab, Šgol.), *öndör* (Oir.)

AM *möŋgü* ‘мөнгө’ Precl. (= Sub.) ~ MM *möŋgü* (Mu.) > *müŋgü* (MNT, Hy.) ~ CM *muŋgü* (Ha, Ord, Kham.); *möŋgö* (Kalm, Oir, TMon, ÖMon.)

AM **χödün* ~ *(h)ödün* ‘өд’ Precl. (= Sub.) ~ MM *hödün* (Mu.) ~ *ödün* (MNT, Hy, Tk, IM, L.) ~ CM *udus* (Ha.), *udu* (Ord.), *ödə* (Kalm, Oir, TMon, ÖMon.)

AM *mörgü-* ‘мөргө’ Precl. (= Bod, Bur, Sub.) ~ MM *mörgü-* (Mu.) > *mürgü-* (MNT, Hy.) ~ CM *mürgü-* (Ord, Dag, Kham.), *mörgə* - (Kalm, Oir, TMon, ÖMon.)

Дээр дурдсан жишээнүүдийн тэргүүн үеийн богино эгшиг нь уулаас бүрэн тод хэлэгдэхийн дээр уруулын шинж давхардсан тул тэдгээр нь Халимаг, Ойрд, Төв болон Өмнөд монгол хэлнүүдэд их төлөв дэвшин ижилшсэн байна.

Хэрэв тэргүүн үедээ уруулын бус, уйтан ***i***-тэй үгийн дэд үед нь уруулын бус хүчдэлтэй, уужим ***a*** эгшиг орвол уул уйтан эгшиг нь дараах үеийнхээ уужим эгшигт татагдан ухарч ижилшдэг байна.

AM *miqan* ‘мах’ Precl. (= Bur, Sub.) ~ MM *miqan* (MNT, Hy, Tk, Mu.) ~ *miqa* (L, Ist.) > CM *maxa* (Mngr.), *magă* (Ha.), *maxɒn* (Kalm, Oir.), *maxɒ* (TMon, ÖMon.)

AM *ǰiγasun* ‘загас’ Precl. (= Bur, Sub.) ~ MM *ǰiγasun* (MNT, Hy, Mu.) ~ *ǰiqasun* (L.) > CM *džağasun* (Dun.), zağahan (Bur.), *džağasun* (Ord.), *džağas* (ÖMon.), *dzağas* (TMon.)

AM *ǰida* ‘жад’ Precl. (= Bur.) ~ MM *ǰida* (MNT, Hy, Tk, Mu, IM, Ist.) ~ *ǰada* (MNT) ~ CM *džad* (Cha, Šgol.), *žada* (Bur.), *džadɒ* (TMon.)

AM *čida-* ‘чад’ Precl. (= Chang, Jig, Hin, Taq.) ~ MM *čida-* (MNT, Hy, D, Mu, IM.) > CM *tšadɒ-* (Kalm, Oir, Kha, AKhor, Barin, Onn, Naim, Učab, Cha.), *šada-* (Bur, Gor, Khar, Khor, Jal, Tüm.), *tšadɒ-* (TMon.)

Жич тэмдэглэх нь: Уруулын бус, уужим ***a***-гийн өмнө орсон уйтан ***i***-гийн ухарах ижилшил нь дундад үеийн монгол хэлний сүүлч, орчин үеийн монгол хэлний эхний шатанд болжээ. Нөгөө талаар, үгийн тэргүүн үеийн ***i*** эгшиг нь нилээд хэл аялгуунд өмнөх эгшигээ тагнайшуулан салшгүй нэгэн цогц шинжтэй болсон тул тийм тохиолдолд уул ***i*** нь ухарч ижилшсэнгүй, хэвээрээ үлджээ.

АМ *miqan*, СМ *miqōn* (Mog.), *miqān* (Zir.), miğa (Dun.), *mixan* (Alar.) ‘мах’
АМ *ǰiγasun,* СМ *dšilğason* (Bao.), *džiäğase* (Mngr.) ‘загас’
АМ *ǰida,*СМ *džida* (Mngr, Dun, Ord.), *džid* (Kalm.), *džidĭ* (Oir.) *‘жад’*

Мөн нилээд тохиолдолд уужим ***a***-гийн өмнө орсон уйтан ***i*** нь өмнөх гийгүүлэгчээ хагас тагнайшуулж, дараах эгшигтэйгээ хагас ижилшсэн байна.

АМ *birayū* (Mo.), ММ *bira’ū* > *b'ira’ū* > *b'irȧ ’u* > *b'irȧ ’ū* ~ СМ *b'ȧ rū* (NÜd, Kha.), *b'ärū* (Dg.), *bėrū* (ÖMon.) ‘бируу’

АМ *miŋγan,* ММ *m'iŋγan* > *m'ȧŋğan* ~ СМ *m'aŋğan* (Kha.), *m'ėŋğan* (Dör, Ur, Kho, Üz, AKhor, Barin, Gor, Tüm, Khar, Khor.), *ḿȧŋğa* (Ha.) ‘минга’

АМ *nilqa,* ММ *nilqa* > *n'ilχa* > *n'ȧ lχa* ~ СМ *n'alxɒ* (Kha.), *nalxă* (Ha.), *njalxa* (Bur.), *nelxă* (Jal, Khor, Üz.) ‘нялх’

АМ *kilγasun,* ММ *kilγasun* > *khilγasun* > *χ'ilγasun* > *χ'ȧlγasun* ~ СМ *χ'ȧlğasu* ~ *χ'ȧlğasɒ* (Kha.), *xjalğāhan* (Bur.), *xélğas* (Üz.) *‘хилгас’*

1.3.3.2.2 **Богино эгшиг урт эгшигтэй ухарч ижилших нь**

Хэрэв үгийн тэргүүн бус үеийн эгшиг дээр уруулын болон уртаар хэлэгдэх шинж хоёр давхардсан байвал өмнөх үеийнх нь уруулын бус богино эгшиг арынхаа эгшигт татагдан ухарч ижилшсэн байна

АМ **a/ū** > ММ **o/ū** > **u/ū**

АМ *dayūn* ‘дуу’ Precl. (= Bod, Chan, Bur.) > ММ *dawūn* (MNT, Hy.) > *da'ūn* (MNT, Mu.) > *da'ū* (IM:) > *do'ū* > *du'ū* (Mu. /= du'ūla-/); Cf. СМ *daūn* (Zir, Kt.), *dau* (Min, Ha, But, Kul.); *doun* (Her.); *dūn* (Kalm, Oir, ÖMon.), *dū* (Bur, TMon.)

АМ *mayūn* ‘муу’ Precl. (= Bod, Hin, Chan, Sub.) ~ *mayūi* (Bur, Sub.) > ММ *mawūn* /= *mawū/* (KMQB, Hy.) ~ *mawūi* (MNT) > *ma'ū* (Mu, IM.) > *mo'ū* > mu'ū (Mu.); Cf. СМ *mau* (Dun, Min.); *mū* (Mngr, SY, Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.)

АМ *qayūčin* ‘хуучин’ Precl. (= Turf. 1, Sub.) > ММ *qawūčin* > *qa'ūčin* (MNT, KMQB, Hy.) > **qo'ūčin* > *qu'ūčin* > *qūčin* (Mu, IM.); Cf. СМ *χaučin* (Ha.), *kaučin* (But.); *koučin* (Min.), *χūtšin* (Kha, Dg, AKhor, Barin, Onn, Naim, Khar, Tüm, Ord.), *χūšin* (Bur, Jal, Khor, Gor.)

AM *sibaγūn* 'шувуу' Precl. (= Hin, Sul, Bur.) > MM *sibawūn* (MNT, Hy, L.) > *šiba'ūn* (D, Mu, L.) > *šibo'ūn* > *šibu'ūn* > CM *šubūn* (Bur.), *šuwū* (TMon, ÖMOn.)

AM **i/ū** > MM **u/ū**

AM *ariγūn* 'ариун' Precl. (= Hin, Jig, Bur, Sub.) > MM *ariγūn* (Mu.) > *ari'ūn* (Hy, Mu, IM.) > *aru'ūn* > *arūn* (Ist.); Cf. CM *ariun* (Mngr.), *arjūn* (Bur.), *arūn* (Khori, Kha.), *erūn* (AKhor, Barin, Jal, Gor, Khar, Khor.), *arūn* (Dag, Ord, Učab, Šgol.), *ärün* (Kalm, Oir.)

AM *niγū-* 'нуу' Precl. (= Bur, Sub.) > MM *niγū-* > *ni'ū-* (MNT, Mu.) > *nu'ū-* > *nū-* (Mu.); Cf. CM *niu-* (Dun.), *njū-* (Bur.), *nū-* (Kalm, Oir, TMon, ÖMon.)

AM *qariγū* 'харуу' Precl. (= Gaz, Alt.) > MM *qariγū* (Mu.) > *qari'ū* (Mu.) > *qaru'ū* > *qarū* (Mu.); Cf. CM *χarjū* (Bur.), *χarū* (Kha.), *χärǖ* (Kalm, Oir.), *χerū* (AKhor, Barin, Jal, Gor, Onn, Naim, Khar, Tüm, Khor.)

AM **e/ǖ** > MM **ü/ǖ**

AM *egülen* 'үүл' Precl. (= Bur, Sub.) > MM *ewülen* > *e'ülen* (MNT, Hy, Mu, L.) > *ö'ülen* > *ü'ülen* > *ülen* (Mu, Ist.); Cf. CM *ewulen* (Kul.), *eulen* (Dag.), *öülen* (Kul.), *ülə n* (Kalm, Oir.), *ülə* (Bur, TMon, ÖMon.)

AM *ǰegün* 'зүүн' Precl. (= Chan, Hin, Bur.) > MM *ǰewün* (MNT, L.) > *ǰe'ün* (Hy, Tk, Mu.) > *ǰö'ün* (Hy.) > *ǰü'ün* (Mu.) > *ǰün* (IM.); Cf. CM *ǰöun* (Mog.), *džün* (ÖMon.), *dzün* (Kalm, Oir, TMon.), *zün* (Bur, Kalm.)

AM *segül* 'сүүл' Precl. (= Sub.) > MM *sewül* (Ist.) > *se'ül* (MNT, Hy, Mu, IM.) > *sö'ül* > *sü'ül* (Mu.) >*sül* (Mu.), Cf. CM *seul* (Mar, Ha.), *söul* (Mog.), *sül* (Kalm, Oir, TMon, ÖMon.), *hül* (Bur.)

AM *següder* 'сүүдэр' Precl. (= Aruγ, Taq, Bur.) > MM *sewüder* (Hy, Tk.) > *se'üder* (MNT, MU, IM; IST.) > *sö'üder* > *sü'üder* > *süder* (Mu.), Cf. CM *seuder* (Kul.), *süder* (Kalm, Oir, TMon, ÖMon.), *hüder* (Bur.)

AM **i/ǖ** > MM **ü/ǖ**

AM *ǰigür* 'жигүүр' Precl. (= Ar.I, Sub, Yur.) > MM *ǰiwür* (Hy, Tk, Ist.) > *ǰi'ür* (MNT) > *ǰü'ür* > *ǰür* (L.), Cf. CM *džiwür* (Dör, Zakh, Jas.); *džür* (AKhor, Barin, Jal, Onn, Urad.)

AM *serigün* 'сэрүүн' Precl. (= Bur, Sub.) > MM *seriwün* > *seri'ün* (KMQB, Hy, Tk, D, Mu.) > *serü'ün* > *serün* (Mu.), Cf. CM *serün* (Kalm, Oir, TMon, ÖMon.), *herjün* (Bur.)

АМ *gičgigūr* ‘гишгүүр’ Precl. (= Bur.) > ММ *gičgiwūr* > *gičgi'ūr* // Cf. *gečgi'ūr* (Hy.) > *gičgü'ūr* > *gičgūr* (IM.), Cf. СМ *giškūr* (Kalm, Oir.), *gišxūr* (TMon.), *gešxūr* (Bur.)

АМ *terigūn* ‘тэргүүн’ Precl. (= Bod, Chang, Jig, Aruγ.) > ММ *teriwūn* > *teri'ūn* (MNT, Hy, Tk, Ph.) > *terü'ūn* > *terūn* (IM, L.) > *türūn* (Mu.), Cf. СМ *türūn* (Dag, Kalm, Bur, ÖMon.), *turū* (Mngr.)

Тэргүүн бус үеийн уруулын урт эгшиг нь өмнөх богино эгшигээ өөртөө татан ижилшүүлсэн тухайн тэр үгийн тэргүүн үед байсан уйтан ***i*** эгшиг нь урдах гийгүүлэгчээ тагнайшуулаагүй зарим хэл аялгуунд уул уйтан эгшиг нь арынхаа урт эгшигтэй ухаран ижилшсэн байна. Өөрөөр хэлбэл, тухайн үгэнд эхлээд хоёр, гуравдугаар үеийн хооронд, дараа нь нэг, хоёрдугаар үеийн хооронд ухаран ижилшил дараалан явагджээ.

АМ *birayū* > ММ *birawū* > *bira'ū* > *biru'ū* > *buru'ū* > *burū* (Mu.) ~ СМ *burū* (Mngr, Bur.), *bürū* (Kalm, Oir.) ‘бируу’

АМ *kirayū* > ММ *kirawū* > *kira'ū* > *kiru'ū* > *kuru'ū* > *kurū* ~ СМ *χurū* (Khor.), *χjurū* (Bur.), šurū (Ekh-Bul.) ‘хируу’

Хэрэв сугарсан гийгүүлэгчийн өмнөх богино эгшиг нь уруулын шинжтэй байсан ч өргөлтгүй байсан бол дараах үеийнхээ уруулын бус урт эгшигт татагдан ухарч ижилшдэг байсан бөгөөд өдгөө түүний ул мөр халимаг, ойрд хэлэнд байсаар байна.

АМ *čilügē* ‘чөлөө’ Precl. (= Bur.) > ММ *čilü'ē* > *čilö'ē* > *čölö'ē* > *čöle'ē* > *čölē* (Bod, Sub.); СМ *tšölēn* (Kalm.), *tšölā* (Oir.)

АМ *dörügē* ‘дөрөө’ (Mo.) > ММ *dörü'ē* > *dörö'ē* (Hy, Tk.) > *döre'ē* > *dörē* (Mu, IM, L.); СМ *dörā* (Kalm, Oir.), *döröä* (Dör, Zakh, Tor, Ur.)

АМ *noγuγān* ‘ногоон’ Precl. (= Bur.) > ММ *noγu'ān* > *noγo'ān* (MNT, HY, Tk.) > *noγa'ān* > *noγān* (Mu, L.); СМ *noğān* (Kalm, Oir.)

АМ *nögügē* ‘нөгөө’ Precl. (= Bod, Chang, Bur, Sub.) > ММ *nögü'ē* > *nögö'ē* (MNT, KMQB.) > *nökö'ē* (D.) > *nöge'ē* > *nögē*, СМ *nögā* (Kalm, Oir.)

Хэрэв дэд үеийнх нь уруулын богино эгшиг ***u, ü*** нь дараах үеийнхээ уруулын бус урт эгшигт татагдан ижилшиж ***ā, ē*** болсон ч гэсэн тэргүүн үедээ уруулын ***o, ö*** эгшигтэй байсан бол тэргүүн үеийнхээ эгшигт татагдан дэвшиж ижилшсэн байна. Өөрөөр хэлвэл, нэг үгэнд ухан ижилшил, дэвшин ижилшил хоёр дараалан явагдсан гэсэн үг. Иймэрхүү ижилшил өдгөөгийн Буриад, Төв болон Өмнөд монгол хэлэнд болжээ.

MM *dörü'ē* > *dörö'ē* > *döre'ē* > *dörē* ~ CM *dörā̆* (Kalm, Oir.) >*dörō̆* (NÜd, Tünk, Alar, Barg, Kha, Dg, Cha, Učab, Šgol.) 'дөрөө'

MM *noγu'ān* > *noγo'ān* > *noγa'ān* > *noγān* ~ CM *noğān* (Kalm, Oir.) > *noğōn* (Mngr, Bur, TMon, ÖMon.) 'ногоон'

MM *nögü'ē* > *nögö'ē* > *nöge'ē* > *nögē* ~ CM *nögā̆* (Kalm, Oir.) > *nögō̆* (Khori, Ekh-Bul, Kha, Dg, AKhor, Barin, Cha, Šgol, Učab.) 'нөгөө'

Тэргүүн үедээ уйтан ***i*** эгшигтэй үгийн дэд үеийнх нь уруулын богино эгшиг дараах үеийнхээ уруулын бус урт эгшигт татагдан ухарч ижилших явцдаа уруулын шинжээ алдахаасаа өмнө тэргүүн үеийнхээ уйтан эгшигт нөлөөлж түүнийг уруулын эгшиг болгосон байна.

AM **χirügēr* > *irügēr* Precl. (= Aruγ, Bod, Sul, Bur.) > MM *hirü'ēr* (MNT, Ph.) > *(h)irö'ēr* ~ *(j)irö'ēr* > *(j)örö'ēr* > *(j)öre'ēr* > *(j)örēr* ~ *(j)örēl* > CM *jöröl* (TMon, ÖMon.), *örō̆l* (Ord.) 'ерөөл'

AM *kirügē* (Mo.) > MM *kirü'ē* (MNT) > *kirö'ē* > *körö'ē* > *köre'ē* > *körē* > CM *körō̆* (Ord.), *χörō̆* (TMon, ÖMon.) 'хөрөө'

AM **χiruγār* > *(h)iruγār* Precl. (= Bur.) > MM *hiru'ār* (MNT, Hy, Tk, Mu.) > *(h)iro'ār* ~ *(j)iro'ār* > *joro'ār* > *jora'ār* > *jorār* ~ *jorāl* ~ CM *jorāl* (Kalm, Oir.) > *jorōl* (TMon, ÖMon.) 'ёроол'

AM *ǰiluγā* Precl. (= Qqor, Bur.) > MM *ǰilu'ā* (MNT) > *ǰilo'ā* (MNT) > *ǰolo'ā* > *ǰola'ā* > *ǰolā* (IM.) ~ CM *džolā* (Kalm, Oir.) > *džolō* (TMon, ÖMon.), *žolō* (Bur.), *jolō* (Bokh, Barg, Kach.) 'жолоо'

Ийм хувьсал нь дундад үеийн монгол хэлний сүүлчээс эхлээд орчин үеийн монгол хэлний үед явагдсан болох нь тодорхой. Тийм ч учираас дундад үеийн монгол хэлний дурсхалуудад дурдсан үгсийн эхний уйтан эгшиг хадгалагдсаар байсан байна.

Хэрэв дээрхи үгсийн дэд үеийн уруулын ***u***, ***ü*** эгшиг дараах үеийнхээ эгшигтэй бүрэн ижилшиж ***ā***, ***ē*** болсоны дараа тэргүүн үеийнх нь уйтан эгшиг ухаран ижилшсэн бол тэдгээр нь эдүгээ *erēl, χerē, jarāl, džalā* дуудлагатай үгс болох байсан билээ.

Монгол хэлний зарим аялгуунд дээр дурдсан үгсийн тэргүүн тэргүүн үеийн ***i*** эгшиг нь ижилшилийн үр дүнд үүссэн дараах үеийнхээ урт эгшигтэй ухаран ижилшээгүй хэвээр үлдсэн байна.

MM *hirü'ēr* > *hirö'ēr* > *hire'ēr* > *hirēr* (Mu.)
MM *hirü'ēr* > *hirö'ēr* > *hirö'ō̆ r* > *hirō̆ r* ~ CM *irō̆ l* (Dag, AKhor.)

MM *hiru'ār* > *hiro'ār* > *hira'ār* > *hirār* (Mu.)
MM *hiru'ār* > *hiro'ār* > *hiro'ōr* > *hirōr* (Mu.) ~ CM *irōr* (NÜd.), *irōl* (Ord.)

MM *kirü'ē* > *kirö'ē* > *kire'ē* > *kirē* ~ CM *kirē* (But.), *xirā̃* (Khar.)
MM *kirü'ē* > *kirü'ē* > *kirö'ō̃* > *kirō̃* (Mu.) ~ CM *kiro* (Tünk.), *iro* (Bao.)
MM *ǰilu'ā* > *ǰilo'ā* > *ǰila'ā* > **ǰilā*
MM *ǰilu'ā* > *ǰilo'ā* > *ǰolo'ō* > *ǰilō* ~ *CM džilō* (Ord.)

Хэрэв уйтан *i* эгшигтэй үеийн дараах үед нь уруулын бус урт эгшиг орсон байвал уул уйтан эгшиг нь хойнох эгшигтээ татагдан ухарч ижилшсэн байна.

AM **i/ā** > MM **a/ā**

AM *ačiγān* > MM *ačiyān* (Ist.) > *ači'ā* (MNT) > *ača'ān* (KMQB.) > *ačā* (Mu, IM.); Cf. CM *atšā* (Dag, TMon, ÖMon. /= Cha, Ord, Učab, Šgol./), *ašā* (Bur, Khor, Jal, Gor.) 'ачаа'

AM *ǰiγā-* Precl. (= Chang, Hin, Taq, Bur.) > MM *ǰiyā-* > *ǰi'ā-* (MNT) > *ǰa'ā-* (KMQB, Hy, Mu.) > *ǰā-* (Mu.); Cf. CM *džā-* (Mngr, SY, Bao, Dag, ÖMon.), *dzā-* (Oir, TMon.), *zā-* (Bur, Kalm.) 'заа-'

AM *niγā-* Precl. (= Sub.) > MM *niyā-* > *ni'ā* (MNT, Mu.) > *na'ā-* (Mu.) > *nā-* ~ CM *nā-* (Mngr, Oir, TMon, ÖMon.) 'наа-'

AM **i/ē** > MM **e/ē**

AM *inigē-* Precl. (= Bur, Sub.) > MM *iniyē-* > *ini'ē-* > *ine'ē-* (MNT, Hy, Tk.) > *inē-* (MNT, Mu, St, L.); Cf. CM *inē-* (TMon, ÖMon.), *inē-* (Kalm, Oir.) 'инээ'

AM *ǰigē* (Mo.) > MM *ǰiyē* > *ǰi'ē* > *ǰe'ē* (Hy.) > *ǰē* Cf. CM *džē* (Mngr, Dag, ÖMon.), *dzē* (Oir, TMon.), *zē* (Kalm, Bur.) 'зээ'

AM *sigē-* (Mo.) > MM *šiyē-* (Mu.) > *ši'ē-* (MNT) > *še'ē-* > *šē-* (Mu.); Cf. CM *šē-* (Dag, Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.) 'шээ-'

Урт эгшигийн өмнөх үеийн уйтан *i* эгшиг нь ухаран ижилшихдээ өмнөх гийгүүлэгчээ тагнайшуулсан эсэхээс шалтгаалан өөр хувилбартай болжээ.

AM ariγūn <

MM ari'ūn (Hy, Mu, IM.) > aru'ūn > arūn (Ist.) ~ CM arūn (SY, Zir, Dag, ÖMon. /= Ord, Sgol/)

MM ari'ūn > ari'ūn > ariūn ~ CM ariūn (Kha.), arjūn (Bur.), arūn (Zakh.), ärūn (Kalm, Oir.)

AM tariγān <

MM tari'ān (Mu, IM.) > tara'ān > tarān (L.) ~
CM tarān (SY, Kalm, Oir. /= Dör, Tor/, ÖMon.
/= Ord, Barin, Khar,Tüm./)

MM tari'ān > tari'ān > tariān ~ CM tariā
(Kha.),tarjā (Bur.), tarā̄ (Kalm, Oir.)

Үгийн тэргүүн үеийн уруулын бус богино эгшиг ухаран ижилших явцдаа уруулшиж ***o, ö*** болсон бол тэр нь цаашдаа дараа үеийнхээ уруулын урт ***ū, ǖ*** эгшигийг өөртөө татан ижилшүүлсэн сонирхолтой жишээ Дагуур, Төв ба Өмнөд монгол хэлний зарим аялгуунд тохиолдож байна.

AM *dayūn* 'дуу' Precl. (= Bod, Chang, Bur.) > MM *dawūn* (Hy.) > *da'ūn* (MNT, Mu.) > *do'ūn* > *do'ōn* ~ CM *dōn* (Khar, Tüm, Onn.), *dō* (Ha, Dar.)

AM *ayūla* 'уул' Precl. (= Manj.) > MM awūla > a'ūla (MNT, Hy, D, Mu, IM, L.) > *o'ūla* > *o'ōla* ~ CM *ōla* (Khar, AKhor, Tüm.), *ōlŏ* (Dar.)

AM *egǖden* 'үүд' Precl. (= Bur, Sub.) > MM ewüden (L.) > *e'ǖden* (MNT, Hy, Mu.) > *ö'ǖden* > *ö'ǒ den* > *ǒ den* ~ CM *öudan* (Mog.), *öude* (Kul.), *ǒ də* (Dar.)

AM *egǖlen* 'үүл' Precl. (= Bur, Sub.) > MM *ewülen* > *e'ǖlen* (MNT, Hy, Mu.) > *ö'ǖlen* > *ö'ǒlen* > *ǒlen* ~ CM *öulen* (Kul.), *ōlon* (Bao.), *ǒ lȯ* (Dar.)

Дундад үеийн монгол хэлний үед хоёр эгшигийн дундаас суларан сугарсан шүргэх ***-γ-/-g-*** гийгүүлэгчийн хоёр талын эгшиг нь их төлөв XIII-XIV зууны үед ижилшсэн боловч зарим хэл аялгуунд тэдгээр нь тус тусынхаа хэлэгдэх шинжийг зохих хэмжээгээр хадгалан, хосорхог шинжтэй болжээ.

AM *ayūla* 'уул' Precl. (= Manj.) > MM *awūla* > *a'ūla* (MNT, Hy, D, Mu, IM, L.) ~ CM *aula* (Zir, Mar.), *aulo* (Her.), *oulo* (Leech.), *aŭla* (Ha.), *aule* (But.), *aūl* (Kul.)

AM *dayūn* 'дуу' Precl. (= Bod, Chang, Bur.) > MM *dawūn* (Hy.) > *da'ūn* (MNT, Mu.) ~ CM *daūn* (Zir, KT.), *dau* (Ha, But, Kul.), *daun* (Her.), *daū* (Min.)

AM *egǖlen* 'үүл' Precl. (= Bur, Sub.) > MM *ewülen* > *e'ǖlen* (MNT, Hy, Mu.) ~ *eülen* (L.) ~ *eüle* (Tk.), CM *eulən* (Ha.), *euleŋ* (But, Kul.), *eulə* (Chi.)

AM *ǰegǖden* 'зүүд' Precl. (Bur.) > MM *ǰewüden* (MNT) > *ǰe'ǖden* (Hy.), CM *džėŭde* (Ha, But.), *džȯ ụdụ* (Mog.), *dženudžien* (Dun.)

1.3.4 ЭГШИГ АВИАНЫ СУЛАРАЛ

§ 87. Эгшиг авианы суларалын судалгааны тойм. Хэлний урт удаан хөгжилийн явцад эгшиг авиа суларч балархайшсан тухай асуудалыг түүхэн үүднээс авч үзсэн нь харьцангуй бага, харин тодорхой нэгэн хэл аялгууны хүрээнд судалсан нь илүүтэй байна.

Нэрт монголч А. Бобровников монгол, халимаг хэлний үгийн тэргүүн бус үеийн богино эгшигүүдийн дуудлагыг монгол бичигийн хэлтэй харьцуулан, уламаар тэдгээрийн хооронд зохих ялгаа гарсаныг тодорхой жишээтэйгээр дурдсан нь угтаа эгшиг авианы суларах үзэгдэлийг олж ажигласан хэрэг юм.[701] Хожим акад. Б. Я. Владимирцов халхын аман аялгууг монгол бичигийн хэлтэй харьцуулсан судалгаандаа XII-XIII зууны үеийн монгол хэлэнд хоёр төрөлийн балархай эгшиг байсан хэмээн тэмдэглэжээ.[702] Гэтэл профессор N. Ропре XIII-XIV зууны үеийн монгол хэлний үгийн тэргүүн бус үеийн богино эгшигүүд нь хувьсаагүй, хэвээрээ байсан гэж дурдсан билээ.[703] Халимаг хэлний эгшигийн тогтолцоог судалсан проф. П. Биткеев тухайн хэлний эгшигийн балархайшилыг монгол хэлний хөгжилийн нилээд эртний үед холбогдоно гэж үзжээ.[704]

Орчин үеийн монгол хэл аялгуунуудын балархай эгшигийн талаар хэл зүйн бүтээлүүдэд олонтаа дурдсанаас гадна сүүлийн үед энэ тухай тусхайлсан судалгаанууд ч цөөнгүй гарсан байна. Тухайлвал, Халимаг, Буриад, Төв монгол хэлний балархай эгшигийн талаар J. Street, Д. А. Павлов, П. Ц. Биткеев, В. И. Золхоев, N. Ропре, Ш. Лувсанвандан, Ж. Төмөрцэрэн, Д. Төмөртогоо нар тус тус ажиглан судалжээ.[705]

---

701 А. А. Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, 36

702 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 313

703 Н. Н. Поппе, Монгольский словарь Мукаддимат ал-Адаб, ч. I. 34

704 П. Ц. Биткеев, Неясные гласные калмыцкого языка, Уч. зап. КНИИЯЛИ, Вып. 3, Элиста, 1964, 74

705 John.C. Street, Kalmyk Shwa, *'American Studies in Altaic Linguistics'* {UAS 13}, Bloomington, Indiana, 1962, 263-291; Д. А. Павлов, Состав и классификация фонем калмыцкого языка, Элиста, 1963, 43-54; П. Ц. Биткеев, Неясные гласные калмыцкого языка, Уч. зап. КНИИЯЛИ, Вып. 3, Элиста, 1964, 69-92, Проблемы фонетики калмыцкого языка. (Квантативные и квалитативные изменения гласных), Элиста, 1975, 126-142, Редуцированные гласные и вопросы их восстановления на письме, Уч. зап. КНИИЯЛИ, 1978, 21-24; П. Ц. Биткеев, Калмыцкий и ойратский вокализм, Автореферат диссертации на соискание ученой степени доктора филологических наук, М., 1980, 32 стр.; В. И. Золхоев, Слогообразующие согласные в бурятском языке, Кр. сообщ. Х науч. -исслед. работах за 1961 г., Иркутск., 1963, 282-285; Сочетаемость согласных и редукция в бурятском языке, *'Вопросы бурятской филологии'*, Вып. I, Улан-Удэ., 1972, 18-24; N. Poppe, Mongolian Language Handbook {= *Center for Applied Linguistics*}, Washington, 1970, 45-46; Ш. Лувсанвандан, Монгол хэлний халхын аялгууны балархай эгшгийн тухай асуудалд, ШУАМ 2 (1964), 88-103, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Авиа, авиалбар хоёр нь, 59-60, 101-103, Монгол хэлний авиа зохьцох тухай асуудалд, МС. II/10/, 1975, 13; Ж. Төмөрцэрэн, Монгол хэлний үе эс

Олонхи эрдэмтэд монгол хэл аялгуунуудын балархай эгшигийг авиа зүйн шинжийн талаас нь голлон судалжээ. Акад. Б. Я. Владимирцов халхын аман аялгууны балархай эгшигийн шинжийг дөрвөн зүйлээр ангилсан байна. Үүнд: 1. уруулын, 2. уруулын бус, 3. уруулын ба уруулын бусын дундын шинжтэй, 4. хэлэгдэх шинжийг нь тодорхойлох боломжгүй хэт богино.[706]

Хожим академич Ш. Лувсанвандан халхын аман аялгууны балархай эгшигийн хэлэгдэх шинжийг тэдгээрийн байртай холбогдуулан доор дурдсан хоёр гол зүйл болгон хуваажээ.[707] Үүнд: 1. *заримдаг хэлбэржсэн* (= уруулын-уруулын бус, хэлний хойгуур-урдуур, уужим-уйтан шинж нь ялгарч мэдэгддэг), 2. *эс хэлбэржсэн* (= хэлэгдэх авиа зүйн бүх шинжийг нь ялган мэдэх боломжгүй, гагцхүү эр-эм шинж нь ялгарч мэдэгддэг).

Халимаг, Дагуур хэлний авиазүйн судалгаануудаас үзвэл, тэргүүн бус задгай үеийн богино эгшигүүд нь халхын аман аялгууныхтай нэгэн адил ихээхэн балархайшсан байдаг байна. Монгол хэл аялгууны балархайшсан эгшигийн фонологи шинжийн талаар судалсан зүйл нэн ховор байна. Академич Ш. Лувсанвандан орчин цагийн монгол хэлний үгийн тэргүүн бус үеийн балархай эгшигийг биеэ даасан фонем болж чадахгүй, харин зарим тохиолдолд өргөлтөт үеийнхээ эгшиг фонемийн хувилбар болж, заримдаа зөвхөн авиа зааглах үүрэгтэй байна гэж тэмдэглэжээ. Гэтэл профессор N. Poppe монгол хэлний өргөлтгүй үеийн хэт богино эгшиг нь бүрэн хэлбэржсэн эгшиг фонемуудтайгаа эсэргцэлдэн утга ялгаж чадна гэж үзсэн байна.[708] Авиа зүйч эрдэмтэн П. Ц. Биткеев халимаг хэлний үгийн тэргүүн бус үед /ə/ (эм үгэнд), /ʌ/ (эр үгэнд), /i/ (эр, эм үгийн аль алинд) гэсэн гурван фонем байна гэжээ.[709]

Орчин үеийн монгол хэл аялгуунуудын өргөлтгүй үеийн хэт богино эгшиг нь биеэ даан үе бүтээж чадах, эсэх талаар эрдэмтэдийн санал харилцан адилгүй байна. Профессор Г. Д. Санжеев ойрд хэлний үгийн тэргүүн бус үеийн эгшигүүд үлэмжхэн балархайсч, бүрмөсөн үгүй болсон тул зарим сонсхолонт гийгүүлэгч үе бүтээхэд хүрсэн гэж дурджээ.[710] Мөн хэл судалаач Ж. Төмөрцэрэн энэ талаар *'Орчин цагийн монгол хэлний ... задгай үеийн балархай эгшиг нэгдүгээр үеэс хойш олонхи нөхцөлд үе бүтээж чадахгүй'*[711] хэмээн тэмдэглэсэн байна. Гэтэл G. J. Ramstedt , П. Ц. Биткеев, Д. А. Павлов, Ш. Лувсанвандан нар халимаг хэл, халх

бүтээх эгшгийн учир, ШУАМ 1 (1968), 65-69; Д. Төмөртогоо, Монгол хэлний үе бүтээх балархай эгшиг, ХЗ. 21:13 (1988), 87-88

706 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 311

707 Ш. Лувсанвандан, Монгол хэлний халхын аялгууны балархай эгшгийн тухай асуудалд, ШУАМ 2, 1964, 88-103

708 N. Poppe, Mongolian Language Handbook, 39, 45-46

709 П. Ц. Биткеев, Проблемы фонетики калмыцкого языка. (Квантативные и квалитативные изменения гласных), 126-146

710 Санжеев, Г. Д., Сравнительная грамматика монгольских языков, ч. I, 34

711 Ж. Төмөрцэрэн, Монгол хэлний үе эс бүтээх эгшигийн учир, ШУАМ 1 (1968), 67

аялгууны аль алинд нь өргөлтгүй үеийн балархай эгшигүүд үе бүтээнэ гэж үзэцгээсэн байна.[712]

Авианы суларалын уламаас балархайшсан эгшигийн тухай судалгаа нь их төлөв үгийн тэргүүн бус үеийн эгшигт холбогдох бөгөөд харин Б. Х. Тодаева, В. И. Рассадин нарын зарим бүтээлд Монгор, Баоань, Шар Ёгур, Буриад хэлний үгийн тэргүүн үеийн эгшигийнсуларалын талаар цухас тэмдэглэжээ.[713]

Эгшиг авианы суларалын тухай тэмдэглэл. Үгийн доторхи аль нэгэн үеийн авиа нь зэрэгэлдээх хүчтэй авиандаа нөлөөлөгдөн фонетикийн шинж, фонологийн үүрэгээ алдах явцыг *авианы суларал* гэх бөгөөд түүний эцэсийн үр дүн нь эгшигийн хувид балархайшилаар, гийгүүлэгчийн хувид сугаралаар илэрдэг ажээ. *Эгшигийн суларал* нь үгийн аль ч үеийн эгшигт холбогдож болох бөгөөд түүнд нөлөөлсөн авианы гадаад орчин нь тухайн эгшигийн байраас шалтгаалан харилцан адилгүй, өөр өөр байдаг байна. Нөгөө талаар, хэлний авиа хэмнэгдэн хураагдах ерөнхий хандлагын дагуу тухайн үгийнхээ хүрээнд утга ялгах фонемийн үүрэгээ нэгэнт алдаж эхэлсэн эгшигийн хэлэгдэх хүчдэл нь суларч, дуудагдах хугацаа нь огцомшиж, өнгө хөгөө алдсаар заримдаа бүрмөсөн гээгддэг ажээ. Өөрөөр хэлбэл, *эгшигийн суларал* гэдэг нь үгүүлэх эрхтэний идэвхитэй үйл ажиллагаагаар бүтэж байгаад авианы хувьсалын явцад яваандаа сул үгүүлэх байранд хэлэгдэх болсон эгшигийг хэлдэг байна.

Монгол хэлний эгшиг авианы суларал чухам хэдийгээс эхэлсэн тухайд эрдэмтэдийн санал адилгүй байгаа тухай өмнө дурдсан билээ. Ер эртний монгол хэлний сүүлч үеийн үндэсэн онцлог шинжийг тусхасан сонгодог бичигийн өмнөх бичигийн дурсхалуудын хэлийг ажиглавал, үгийн тэргүүн болон тэргүүн бус үеийн эгшигүүд нь авианы бүрэн хэлбэржсэн шинжээ тогтвортой хадгалж байжээ. Тийм ч учираас тэргүүн үедээ уруулын бус эгшигтэй үгсийн тэргүүн бус үед уруулын эгшиг олонтаа тохиолдож байна. Харин дундад үеийн монгол хэлний онцлогийг тусхасан бичигийн дурсхалуудад үгийн тэргүүн бус үеийн уруулын богино эгшиг уруулын шинжээ алдаж, өмнөх үеийнхээ эгшигтэй дэвшин ижилшсэн жишээ цөөнгүй тохиолдож байгаа нь тухайн эгшигүүдийн хэлэгдэх байдал, утга ялгах шинжид зохих өөрчилөлт гарч эхэлсэний илэрэл юм. Эгшигийн суларал хэдийгээр дундад үеийн монгол хэлний үед эхэлсэн боловч түүний гол үр дүн нь орчин үеийн монгол хэлний шатанд болсон бөгөөд тэр нь хэл аялгуу тус бүрд харилцан адилгүй өөр өөр байна.

---

712 G. J. Ramstedt, Kalmückisches Wörterbuch, XII; П. Ц. Биткеев, Неясные гласные калмыцкого языка, Уч. зап. КНИИЯЛИ, Вып. 3, Элиста, 1964, 86; Д. А. Павлов, Состав и классификация фонем калмыцкого языка, Элиста, 1963, 43; Ш. Лувсан-вандан, Монгол хэлний халхын аялгууны балархай эгшигийн тухай асуудалд, ШУАМ 2 (1964), 88-103

713 Б. Х. Тодаева, Баоаньский язык, М., 1964, 8; *idem.* Монгорский язык. Исследование, тексты, словарь, М., 1973, 17-18; Э. Р. Тенишев, Б. Х. Тодаева, Язык желтых уйгуров, М., 1966, 45-81; В. И. Рассадин, Очерки по исторической фонетике бурятского языка, 162-164

1.3.4.1 ҮГИЙН ТЭРГҮҮН ҮЕИЙН ЭГШИГИЙН СУЛАРАЛ

§ 88. **Тэргүүн үеийн эгшигийн суларал**. Үгийн тэргүүн үеийн богино эгшиг хэлэгдэх онцлог шинжээ алдаж, суларсан тохиолдол Монгор, Баоань, Шар Ёгур зэрэг хэлэнд гарсан бөгөөд түүний гол учир нь тухайн хэлнүүдийн гол өргөлт эцэсийн үеийн эгшигт шилжсэнтэй холбоотой юм.[714]

Mo.	Mngr.	Bao.	SY.	Kha.
ayaγa	jäğa	jiğa	aiğa	ayağa
adali	dali	adeli		adil
emüs-	mose-	mese-	məs-	ömös-
ölüs-	lose-	olos-		ölös-
edür	dur	odor	odor	ödör
unaγa	nağa		nağan	unağa
usun	se	se	qsun	uša
üsün	sun	sun	hsun	üsə
öndür	ndur	onder	ondor	öndör

Орчин үеийн буриад хэлний зарим аман аялгуунд дэд үедээ хэлний урдуурхи, урт эгшиг бүхий үгийн тэргүүн үеийн богино эгшиг суларан гээгдсэн жишээ цөөвтөр үгэнд тохиолдож байна.[715]

Mo.	Bur.	Kha.
önüge-edür	nȫdör (Tünk.)	önȫdör
üniyēn	njēn (Barg.)	ünē
iniyē-	njē- (Barg, Kach.)	inē-
önügēki	nȫ xi (Tson.)	önȫ χ
abuγād orki-	bātxa- (Kach.)	awādaχ
ataγārqa-	tārxa- (Kach.)	atārχɒ’
emegēl	mēl (Okin.)	emēl

Жич тэмдэглэх нь: Дундад үеийн монгол хэлний үед үгийн тэргүүн үеийн богино эгшиг дараах үеийнхээ уруулын, урт эгшигт татагдан ижилшсэнийг зарим эрдэмтэн *‘эгшигийн суларал’* гэж үзжээ.[716] Гэтэл тухайн хувьсалын гол хандлага нь суларал биш, харин үгүүлэхийн хүч нь нэмэгдэж буй сөрөг хувьсал юм. Бүр

---

[714] Б. Х. Тодаева, Баоаньский язык, 8; *idem*. Монгорский язык. Исследование, тексты, словарь,17-18; Э. Р. Тенишев, Б. Х. Тодаева, Язык желты хуйгуров, 52,

[715] Д. А. Абашаев, Тункинский говор, *‘Исследование бурятских говоров’*, Улан-Удэ, Вып. I, 1965, 13; Ц. Б. Будаев, Цонгольский говор, *ibid.* 166, А. Г. Митрошкина, Говор качугских /Верхноленских/ бурят, *ibid.*,51, Э. Р. Раднаев, Баргузинский говор, *ibid,* 82; В. И. Рассадин, Очерки по исторической фонетике бурятского языка, 163

[716] В. И. Рассадин, Очерки по исторической фонетике бурятского языка, 162

тодоруулвал, дэд үеийнхээ эгшигээс сул хэлэгдэж байсан богино эгшиг ижилшилийн дараагаар уруулшсан нь урид хэлэгдэж байсанаасаа илүү хүчтэй болсон хэрэг даруй мөн.

1.3.4.2 ҮГИЙН ТЭРГҮҮН БУС ҮЕИЙН ЭГШИГИЙН СУЛАРАЛ

1.3.4.2.1 **Тэргүүн бус үеийн эгшигийн суларал.**

§ 89. Тэргүүн бус үеийн эгшигийн суларал. Үгийн тэргүүн бус үеийн богино эгшиг хэлэгдэх байдалаараа огцомшиж, уламаар хэлэгдэх гол онцлог шинжээ алдаж, суларсан жишээ орчин үеийн олонхи хэл аялгуунд түгээмэл тохиолдож байгаа бөгөөд тийнхүү суларсаны гол шалтгаан нь утга ялгах үүрэгээ алдсантай холбоотой билээ.

Монгол хэлний судалалд өргөлтгүй үеийн суларсан эгшигүүдийг хувьсалын эцэсийн үр дүнгээр нь *'балархай эгшиг'* хэмээн нэрийдсээр ирсэн бөгөөд тэдгээрийг цуваа цагийн үүднээс авч үзвэл *'эгшигийн суларал'* юм.

Үгийн тэргүүн бус үеийн богино эгшигийн суларал нь хэл аялгуу тус бүрд харилцан адилгүй, тухайлвал, Халимаг, Ойрд, Төв Монгол хэлэнд илүү суларч, Дагуур, Буриад, Ордос аялгуунд харьцангуй бага суларсан байна. Зарим судалаачид Халимаг, Ойрд хэлний үгийн тэргүүн бус үеийн хэт богино эгшигүүдийг бүрмөсөн гээгдсэн гэж үздэг боловч тэдгээр эгшиг одоо хүртэл үе бүтээх шинжээ хадгалсаар байгааг П. Ц. Биткеев, Д. А. Павлов нар лабораторийн судалгаагаар нэгэнт баталсан билээ.[717]

1.3.4.2.1 **Битүү үеийн богино эгшигийн суларал**

Орчин үеийн монгол хэл аялгуунуудад үгийн тэргүүн үеэс хойшхи битүү үеийн богино эгшигүүд нь тэргүүн үеийнхээ богино эгшигээс огцом бөгөөд ихэнхидээ харьцангуй тод (= уруул, хэлний шинжээ хадгалсан) хэлэгддэг байна. Гэвч тэр нь тухайн үгийнхээ тэргүүн үеийн эгшигийн уруулын шинжтэй шууд холбоотой юм.

I. Уруулын эгшигийн дараах богино эгшигийн суларал

A. *Уруулын эгшигийн дараах уруулын эгшиг*

Үгийн тэргүүн үеийн уруулын эгшигийн дараах битүү үед орсон уруулын богино эгшиг нь олонхи хэл аялгуунуудад дэвшин ижилшиж уруулын шинжээ хадгалж байгаа Халимаг, Ойрд хэл болон Төв Монгол, Өмнөд Монгол хэлний зонхилох аман аялгуунуудад уруулын шинжээ алдаж, заримдаа ихээхэн огцомшсон байна.

---

[717] П. Ц. Биткеев, Калмыцкий и ойратский вокализм, 23, Д. А. Павлов, Состав и классификация фонем калмыцкого языка, 43

o, ö-гийн дараа орсон u, ü

Mo.	odun	qonuγ	ödün	sögüd-
Dag.	odŏ	χonog	üdüs	sügdü-
Kalm.	odʌn	χonʌg	ödən	sökər-
Bur.	odon	χonog	üdün/üden	hügüd-
TMon.	odŏ	χonog	ödö	sögöd-
ÖMon.	odon /udu	χonog	ödö	sögöd-

u, ü-гийн дараа орсон u, ü

Mo.	uruγ	nuntuγ	üsüg	ükül
Dag.	uruğ/oroğ	notoğ	usug	ugul
Kalm.	urŭğ	nutŭğ	üsüg	ükəl
ÖMon.	uruk/urağ	nutuk/nutuğ	üseg	üχül/üχel
Bur.	uruğ/urağ	njutağ	üsüg/üseg	üχül/üχel
TMon.	uruğ/urağ	nutuğ/nutağ	üsüg/üseg	üχül/üχel

B. *Уруулын эгшигийн дараах уруулын бус эгшигийн суларал*

Үгийн тэргүүн үеийн уруулын эгшигийн дараах битүү үед орсон уруулын бус богино эгшиг нь хэдийгээр зарим хэл аялгуунд суларан, огцомшсон боловч нилээд хувь нь дэвшин ижилшиж, уруулын эгшиг болжээ. Харин тэргүүн бус үеийн ***i*** эгшиг олонхи хэл аялгуунуудад хэлэгдэх онцлог шинжээ тогтвортой хадгалсаар ирсэн байна.

o, ö-гийн дараа орсон a, e

Mo.	noyan	oran	dörben	mören
Dag.	nojon	oron	durwen	murun
Kalm.	nojʌn	orʌn	dörwən	mörən
Bur.	nojon	oron	dürbön	müren
TMon.	nojon	oron	dörwön	mörön
ÖMon.	nojon	oron	dörwön	mörön

u, ü-гийн дараа орсон a, e

Mo.	burqan	γurban	ünen	üker
Dag.	barkan	ğoarwɒn	unun	ukur
Kalm.	burxʌn	ğurwʌn	ünən	ükər
Bur.	burxan	ğurwan	ünün/ünen	üxür/üxer
TMon.	burxan	ğurwan	ünen	üxer
ÖMon.	burxan	ğurwan	ünen	ünen

o, ö-гийн дараа орсон i

Mo.	morin	qonin	döčin	kögšin
Dag.	mori	χoni	dutšin	
Kalm.	mörən	χõn	dötšən	kögšən
Bur.	morin	χoni	düšen	χügšən
TMon.	morĭ	χonĭ	dötšĭ	χögšin
ÖMon.	mori	χoni	dötšin	χögšin

u, ü-гийн дараа орсон i

Mo.	γulir	qurim	bürin	dürim
Dag.	ğolil	urin	burun	durun
Kalm.	ğujĭr	χurʌm	bürən	dürəm
Bur.	ğuril	χurim	bürin	dürim
TMon.	ğuril	χurim	büren	dürem
ÖMon.	ğulir	χorim	bürin	dürem

II. <u>Уруулын бус эгшигийн дараах богино эгшигийн суларал</u>

A. *Уруулын бус эгшигийн дараах уруулын богино эгшигийн суларал*

a, e-гийн дараа орсон u, ü

Үгийн тэргүүн үеийн уруулын бус эгшигийн дараах битүү үед орсон уруулын богино эгшиг нь олонхи хэл аялгуунуудад уруулын шинжээ алдаж, тэргүүн үеийнхээ эгшигтэй ижилшсэн байна. Гэвч энэ нь угтаа шилжих явцын үр дүн биш, харин фонетик, фонологийн шинжээ алдаж, суларсанаас шалтгаалсан хувьсал юм.

Mo.	tabun	qatun	kedün	ečüs
Dag.	tāŭn	qatun	keden	
Kalm.	tawʌn	χatʌn	kedən	
Bur.	taban	χatan	χeden	eses
TMon.	tawan	χatan	χeden	etses
ÖMon.	tawan	χatan	χeden	etšes

i-гийн дараа орсон u, ü

Үгийн тэргүүн үеийн *i*-гийн дараа орсон уруулын богино эгшигүүд нь олонхи хэл аялгуунуудад өмнөх эгшигээ өөртөө татан ижилшүүлээд дараа нь уруулын шинжээ бүрмөсөн алдсан байна.

Mo.	čisun	kimusun	nidün	šidün
Dag.	tšos	kimtši	nide	šidu/šide
Kalm.	tsusʌn	χumsʌn	nüdən	šüdən

Bur.	šuhan	χjumhan	njüden	šüde(n)
TMon.	tsusɒ	χumas	nüdə	šüdə
ÖMon.	tšus/džus	χumas	nüde	šüde

В. *Уруулын бус эгшигийн дараах уруулын бус эгшиг*

Үгийн тэргүүн үеийн уруулын бус эгшигийн дараах битүү үед орсон ***а, е*** эгшигүүд нь их төлөв хэлэгдэх үндэсэн шинжээ тогтвортой хадгалсаар иржээ. Харин тагнайн гийгүүлэгчийн дараах богино эгшиг зарим хэл аялгуунд өмнөх гийгүүлэгчийнхээ нөлөөгөөр ***і*** болсон байна.

а, е-гийн дараа орсон а, е

Mo.	ğaǰar	saqal	sečen	tergen
Dag.	ğadžir	sağal	setšin	terəg
Kalm.	ğadzʌr	saχʌl	tsetsen	tergen
Bur.	ğazar	haχal	sesen	terge
TMon.	ğadzar	saχal	tsetsen	tereg
ÖMon.	ğadžar	saχal	setšin	terge

Үгийн тэргүүн үеийн уруулын бус эгшигийн дараах битүү үед орсон тагнайн ***і*** эгшиг нь ихэнхидээ дэвшин ижилшсэнгүй, угийн хэлэгдэх байдалаа тогтвортой хадгалсаар иржээ.

а, е-гийн дараа орсон і

Mo.	amin	ǰarliγ	sedkil	teŋgis
Dag.	amĭ			serkil
Kalm.	am'n	zärlig	sedkəl	teŋgəs
Bur.	amin	zarlig	sedxil	teŋgis
TMon.	amĭ(n)	dzarlig	setxil/setxel	teŋgis/teŋges
ÖMon.	ämi(n)	džarlig	setgel	teŋges

1.3.4.2.2 **Задгай үеийн богино эгшигийн суларал**

Орчин үеийн монгол хэл аялгуунуудад үгийн тэргүүн үеэс хойшхи задгай үеийн богино эгшигүүд нь тэргүүн үеийнхээ эгшигээс үлэмж огцом (= *хэт богино*) бөгөөд ялангуяа Халимаг, Ойрд, Төв монгол хэлний үгийн эцэст чанга гийгүүлэгчийн дараа орсон богино эгшиг нь дуугүй хэлэгддэг учир сонсохын түвшинд ажиглагддаггүй. Гэвч тэдгээр эс хэлбэржсэн богино эгшигүүд нь байрааараа үе бүтээж, үе бүтээж байгаа тэр шинжээрээ үг, морфемийн утга ялгахад оролцдог байна. Өөрөөр хэлбэл, морфемийн харьцаанд илэрэн гарч байгаа үгийн эцэсийн хэт богино эгшигүүд нь тухайн морфемийн зааг дахь гийгүүлэгчийн байрыг зохьцуулж байдаг ажээ.

I. Уруулын эгшигийн дараах богино эгшигийн суларал

А. *Уруулын эгшигийн дараах уруулын эгшиг*

Үгийн тэргүүн үеийн уруулын эгшигийн дараах задгай үед орсон уруулын богино эгшиг нь үлэмжхэн огцомшсон боловч өмнөх үеийнхээ уруулын эгшигийн нөлөөгөөр уруулын шинжээ их төлөв хадгалсаар иржээ.

o, ö-гийн дараа орсон u, ü

Mo.	boru	ordu	ölüsün	mönggü
Dag.	boro		χüles	muŋgu
Kalm.	borʌ	ordʌ	kölsən	möŋgən
Bur.	boro	ordo	χülehen	muŋgen
TMon.	borŏ	ordŏ	χölös	möŋgö
ÖMon.	boro	ordo	χölös	möŋgö

u, ü-гийн дараа орсон u, ü

Mo.	urtu	sumu	bügüde	kündü
Dag.	orto	somo	bögede	kündü
Kalm.	utŭ	sumʌn	bügüdə	kündə
Bur.	utu	humu	bügüde	χünde
TMon.	urtŭ	sumŭ	bügedə	χündə
ÖMon.	urtu	sumu	bügüde	χünde

Б. *Уруулын эгшигийн дараах уруулын бус эгшиг*

Үгийн тэргүүн үеийн уруулын эгшигийн дараах задгай үед орсон уруулын бус эгшиг нь өмнөх эгшигийнхээ нөлөөнөөс шалтгаалан өөр өөр байдалтай байна. Тухайлвал, уруулын ***o, ö***-гийн дараа орсон эгшигүүд нь их төлөв уруулшиж, *u, ü*-гийн дараах үеийн эгшиг нь уруулшаагүй байна.

Mo.	qola	qongqa	köke	möngke
Dag.	χolo		küke	müŋke
Kalm.	χolʌ	χoŋχʌ	kökə	möŋkö
Bur.	χolo	χoŋχo	χüχe	müŋxe
TMon.	χolŏ	χoŋχŏ	χöχö	möŋxö
ÖMon.	χolo	χoŋχo	göχö	möŋxö

u, ü-гийн дараа орсон a, e

Mo.	dumda	qura	süke	üge
Dag.	doanda	χuar	suhe	uge
Kalm.	dundʌ	χurʌ	sükə	üge

Bur.	dunda	χura	hüxe	üge
TMon.	dundɒ	χurɒ	süxə	ügə
ÖMon.	dunda	χura	süxe	üge

Тэргүүн үедээ уруулын эгшигтэй үгийн эцэсийн задгай үед орсон тагнайн эгшиг нь өмнөх эгшигтэйгээ дэвшин ижилшсэнгүй, уулын хэлэгдэх шинжээ тогтвортой хадгалсаар иржээ.

Mo.	toli	ǰori-	söni	ǰöri-
Dag.	toli	džori-	suni	
Kalm.	tolĭ	zor-	sn̄	zör-
Bur.	toli	zori-	hüni	zöri-
TMon.	tolĭ	dzorĭ-	šönö	dzör-
ÖMon.	tölĭ	džori-	sönö	džöri-

u, ü-гийн дараа орсон i

Mo.	urida	qubi	tülki-	düri
Dag.	ordo	χobi	tulki-	dure
Kalm.	urĭdʌ	χöw	tülkə-	dürə
Bur.	urida	χuwĭ	tülχi-	düre
TMon.	uridɒ	χuwĭ	tülχə-	dürə
ÖMon.	urida	χuwi	tülχi-	düri

II. <u>Уруулын бус эгшигийн дараах богино эгшигийн суларал</u>

А. *Уруулын бус эгшигийн дараах уруулын богино эгшигийн суларал*

a, e-гийн дараа орсон u, ü

Үгийн тэргүүн үеийн уруулын бус эгшигийн дараах задгай үед орсон уруулын богино эгшиг нь орчин үеийн олонхи хэл аялгуунуудад суларан огцомшиж, уруулын шинжээ бүрмөсөн алджээ.

Mo.	batu	qamtu	metü	getüle-
Dag.	bata	χamta		getel-
Kalm.	batʌ	χamtʌ		getəl-
Bur.	bata	χamta	mete	getel-
TMon.	batɒ	χamtɒ	metə	getel-
ÖMon.	bata	χamta	mete	getel-

В. *Уруулын бус эгшигийн дараах уруулын бус эгшигийн суларал*

Үгийн тэргүүн үеийн уруулын бус эгшигийн дараах задгай үед орсон уруулын бус богино эгшигүүд нь нилээд хэл, аялгуунд суларч, заримдаа тухайлвал, үгийн эцэсийн задгай үед үлэмжхэн суларч хэт богино хэлэгдэх болжээ.

а, е-гийн дараа орсон а, е

Mo.	aqa	baγana	eke	ene
Dag.	agă	bahan	egə	ene
Kalm.	axʌ	baxɒnʌ	ekə	enə
Bur.	axa	bağană	exe	ene
TMon.	axɒ	bağanɒ	exə	enə
ÖMon.	axa/axɒ	bağana	exe	ene

а, е-гийн дараа і

Үгийн тэргүүн үеийн уруулын бус эгшигийн дараах задгай үед орсон эгшиг нь өмнөх үеийнхээ эгшигтэй дэвшин ижилшсэнгүй, уулын хэлэгдэх шинжээ тогтвортой хадгалсаар иржээ.

Mo.	bari-	qani	beri	eligen
Dag.	bari-	χani	beri/bere	χeleg
Kalm.	bärĭ-	χänĭ	berə	elkən
Bur.	bari-	χani	beri	elegen
TMon.	barĭ-	χanĭ	berə	elegə
ÖMon.	bärə-	χani/χen	bere	elege

і-гийн дараа орсон а, е

Mo.	ǰida	šira	sine	ire-
Dag.		šara	šinken	ire-
Kalm.	džidʌ	šarʌ	šinə	irə-
Bur.	žada	šara	šine/šene	ire-
TMon.	džidɒ	šarɒ	šinə	irə-
ÖMon.	džida	šara	šine	ire-

Дээр дурдсан жишээнүүдэд тулгуурлан дүгнэхэд, үгийн тэргүүн бус үеийн эгшигийн суларал (= *балархайшил*) нь хэлний хэмнэлийн зарчимын дагуу тухайн үгийг мөн тухайн харьцаанд нь хамагийн амар хилбар хэлэх боломжоос шалтгаалан нэг харьцаанд тод хэлэгдэж, нөгөө харьцаанд тод бус хэлэгдэж байдаг харьцангуй шинжтэй авианы үзэгдэл юм. Өөрөөр хэлбэл, өргөлтгүй задгай үеийн богино эгшигүүд, ялангуяа, үгийн эцэсийн задгай үеийн эгшигийн балархайшил нь зарим судалаачийн үздэгчилэн бүрмөсөн алга болж буй хэрэг бус, харин хэл ярианы урсхалд байр ба харьцаагаараа фонетик, фонологийн үүрэг гүйцэдхэсээр байгаа гэдэгийг дурдвал зохино.

2. ГИЙГҮҮЛЭГЧ АВИА

2.1 ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ ТОГТОЛЦОО

§ 90. **Гийгүүлэгч авианы тогтолцооны судалгааны тойм.** Монгол бичигийн хэл болон монгол хэл, аялгуунуудын гийгүүлэгч авианы тогтолцооны талаархи ажиглалт, судалгаа бүр XIX зууны тэргүүн хагасаас эхэлжээ. Нэрт монголч А. А. Бобровников, А. Д. Руднев, G. J. Ramstedt, Б. Я. Владимирцов, Г. Д. Санжеев, N. Poppe, Ш. Лувсанвандан, Чингэлтэй зэрэг олон эрдэмтэд монгол хэл зүйн бүтээлүүддээ гийгүүлэгч авианы бүтэц бүрэлдэхүүн, хэлэгдэх онцлог шинжийн талаар удаа дараа тэмдэглэсээр иржээ. Монгол хэлний гийгүүлэгчийн тогтолцоог түүхэн үүднээс авч үзсэн судалгаануудын дотор профессор G. J. Ramstedt,[718] N. Poppe[719] нарын харьцуулсан судалгаа чухал байр эзэлнэ. Мөн энэ талаар Z. Gombotz, D. Sinor, Yo. Saito нарын сонирхолтой үгүүлэлүүд ч бий.[720] Эртний болоод дундад үеийн монгол хэлний гийгүүлэгчийн тогтолцоог нарийвчилан тогтооход монгол бичигийн хэл болон монгол хэлний бичигийн дурсхалуудын судалгаа чухал баримжаа болж байна.[721]

Монгол хэлний бичигийн дурсхалууд болон монгол хэл аялгуунуудын авианы шинжийг түүхэн үүднээс харьцуулан судалсаны үндэсэн дээр гийгүүлэгч авианы ерөнхий тогтолцоог гаргаж болох бөгөөд энэ талаар профессор N. Poppe-гийн судалгаа чухал ач холбогдолтой.[722] Мөн тэрвээр алтайн хэлнүүдийн авиа зүйн тухай томоохон бүтээлдээ монгол хэлний гийгүүлэгчийг бусад төрөл хэлнүүдийн зохих гийгүүлэгчтэй харьцуулан авч үзсэн нь гийгүүлэгчийн тогтолцооны тухай түүхэн судалгааг улам гүнзгийрүүлжээ.[723]

---

[718] G. J. Ramstedt, Zur mongolische-türkischen Lautgeschichte, KSz. 15 (1914), 134-150, 16 (1916), 66-84, Ein anlautender stimmloser Labial in der mongolisch-türkischen Ursprache, JSFOu. 32:2 (1916-1920), 1-10

[719] Н. Н. Поппе, К консонантизму алтайских языков, ДАН СССР, 1924, 43-44, Система глухих смычных в алтайских языках, ДАН СССР, 1925, 11-13

[720] Z. Gomboz, Zur Lautgeschichte der altaischen Sprachen, KSz 13 (1912-13), 1-37; D. Sinor, Observations on a New Comparative Altaic Phonology, BSOAS 26 (1963), 133-144; Yoshio Saito, The Consonant System of West Middle Mongol, AH 21, 2011, 51-67

[721] Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, 6-10; N. Poppe, Das mongolische Sprachmaterial einer Leidener Handschrift, 1027-1032; Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 346-412; Н. Н. Поппе, Монгольский словарь Мукаддиматал-Адаб, ч. I. 44-59; M. Lewicki, La langue mongole des transcriptions chinoises du XIVe siècle, Le Houa-yi yi-yu de 1389, 81-94; N. Poppe, Grammar of Written Mongolian, 12-15; *idem.* The Mongolian Monuments in hP'ags-pa Script, 31-34; John. C. Street, The Language of the Secret History of the Mongols, 9-12; L. Ligeti, Notes sur le vocabulaire mongol d'Istanboul, AOH 16, 1963, 142-154; M. Weiers, Untersuchungen zu einer historischen Grammatik des präklassi-schen Schriftmongolisch, 23-62;

[722] N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 95-171

[723] N. Poppe, Vergleichende Grammatik der altaischen Sprache. Teil I. Vergleichende Lautlehre {= PLO. N. S. 4}, Wiesbaden, 1960, 9-90

Орчин үеийн олон монгол хэл аялгуунуудын гийгүүлэгч авианы тогтолцооны талаар бие даасан судалгааны нилээд бүтээлүүд гарчээ. Тухайлвал, Монгор, Дагуур хэлний гийгүүлэгчийн тогтолцооны талаар A. Rona-Tas, Yo. Saito, Энхбат нар[724] Халимаг, Буриад хэлний гийгүүлэгчийн тогтолцооны талаар П. Ц. Биткеев, И. Д. Бураев, В. И. Рассадин нар,[725] Төв ба Өмнөд монгол хэлний гийгүүлэгчийн тогтолцооны талаар Sh. Hattori, J. Ch. Street, Don Graham Stuart - M. Haltod, J. Bosson, B. Ünensečen, В. И. Золхоев, Ш. Лувсанвандан, С. Мөөмөө, Ж. Санжаа нар[726] судалжээ. Эдгээрээс гадна хэл, аялгуу тус бүрийн онцлог шинжийн тухай өдий төдий бүтээл гарсан бөгөөд тэдгээрт тухайн хэл, аялгуунуудын гийгүүлэгчийн тогтолцоотой холбогдох олон сонин ажиглалт, судалгаа буй. Энэ бүхэн нь олон монгол хэлнүүдийн авианы бүтэц, тогтолцоог харьцуулан судалах таатай боломж олгож байгаа бөгөөд энэ талаар томоохон харьцуулсан судалгааг Ж. Надмид хийж *'Монгол хэлнүүдийн харьцуулсан хэл зүй'* гэдэг хамтын бүтээлд багтаан нийтлүүлжээ.[727]

Гийгүүлэгч авианы тогтолцооны тухай тэмдэглэл. Монгол хэлний гийгүүлэгч авиа нь хэлний урт удаан хөгжилийн явцад хэлэгдэх онцлог шинжээ харьцангуй тогтвортой хадгалсаар иржээ. Хэдий тийм боловч хэлний авиа нь байнга хувьсан хөгжиж байдаг амьд эд эс мөний тул зарим гийгүүлэгч хэлэгдэх байдалаараа суларан, үг, морфемийн утга ялгах чадвараа алдаж байхад бас зарим гийгүүлэгч шинээр нэмэн гарч ирэх зэрэгээр харилцан бие биеэ нөхөн хөгжиж, нийт гийгүүлэгч авианы ерөнхий тогтолцоон дахь тоо чанарын тэнцвэрийг зохьцуулсаар ирсэн байна.

---

724 A. Rona-Tas, Remarks on the Phonology of the Monguor Language, AOH 10, 1960, 263-267; Yo. Saito, Phonemic System of Monguor, JSLJ 1987; M. Энхбат, Dayur kelen-ü abiyan-u sistem, ÖMYS 4, 1982, 134-171

725 П. Ц. Биткеев, Согласные фонемы калмыцкого языка: на материале экспериментальных исследований, Улан-Удэ, 1965, 3-67; И. Д. Бураев, Звуковой состав бурятского языка, Улан-Удэ, 1959, 3-194; Становление звукового строя бурятского языка, Новосибирск, 1987, 23-73; В. И. Рассадин, Очерки по исторической фонетике бурятского языка, 68-115

726 Sh. Hattori, Phonemic Structure of Mongol (Chakhar Dialect), JLSJ 19-20 (1951), 68-102; John. C. Street, Khalkha Structure, 47-53; Don. G.Stuart, M. Haltod, The Phonology of the Word in Modern Standard Mongolian, *Word* 13, 1957, 69-76, 79-81, 90-92; J. E. Bosson, B. Ünensečen, Some Notes on the Dialect of the Khorchin Mongols, *'American Studies in AltaicLinguistics'* {= UAS 13}, Bloomington, Indiana, 1962, 23-44; В. И. Золхоев, Фонологических функции бурятских гласных, Кр. сообщ. X науч. -исслед. работах за 1961 г., Иркутск., 1963, 286-288; Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Авиа, авиалбар хоёр нь, 49-53, 61-62, Орчин цагийн монгол хэлний гийгүүлэгчийн тогтолцоо, ХЗ 15:5, 1980, 34-38; С. Мөөмөө, Сиситема фонем современного монгольского языка (Skrypt dla studentow II-roku filologii mongolskiej), Warszawa, 1977, 67-91; Ж. Санжаа, Монгол хэлний гийгүүлэгч авианы тогтолцоо, Уб., 1986, 3-65

727 Монгол хэлнүүдийн харьцуулсан хэл зүй, Уб., 1985, 33-78

Монгол хэлний гийгүүлэгч авианы хувьсан хөгжих ерөнхий зүй тогтол хийгээд алтайн төрөл хэлнүүдийн гийгүүлэгчийн тогтолцоонд тулгуурлан өвөг монгол хэлний гийгүүлэгч фонемийн бүрэлдэхүүнийг баримжаалан тогтоож болно.

		Уруулын	хэлний гийгүүлэгч			
			урдуур	дундуур	хойгуур	
			хэлний үзүүр-шүдний	тагнайн	хойгуур	гүн угийн
хамжих	дуугүй		*t		*k	*q
	дуутай	*b	*d		*g	*γ
хамжин шүргэх	дуугүй		*č			
	дуутай		*ǰ			
шүргэх	дуугүй	*φ	*s	*j		
	дуутай					
хамарын		*m	*n		*ŋ	
хажуугийн			*l			
чичирэх			*r			

Монгол хэлний хөгжилийн цаашдын явцад, тухайлвал, эртний монгол хэлний гийгүүлэгчийн тогтолцоонд доор дурдсан хувьсал гарчээ.

- Өвөг монгол хэлний үед үгийн эхэнд байсан уруулын шүргэх *φ гийгүүлэгч суларч, уруулын шинжээ алдаад дуутай шүргэх *χ болжээ.

- Авианы харилцан биесдээ нөлөөлөх хуулийн дагуу ***i*** (< *i) эгшигийн өмнө орж байсан хамжих ***d**, **t*** гийгүүлэгч нь арынхаа эгшигийн нөлөөгөөр тагнайшин хамжин шүргэх ***č**, **ǰ*** болсон байна.

- Эртний монгол хэлний үед үгийн эхэнд байсан шүргэх ***χ*** (< *φ) нь улам суларч, сул шүргэх ***h*** болжээ.

- Өвөг монгол хэл болон эртний монгол хэлний үед ***i*** (< *ï) эгшиг-ийн өмнө тохиолдож байсан хэлний гүн угийн хамжих ***q*** нь арынхаа эгшигийн нөлөөгөөр тагнайшин хэлний хойгуур хамжих ***k*** болсон байна.

- Дундад үеийн монгол хэлний үеэс хойш гийгүүлэгч авианы ерөнхий тогтолцоонд гарсан нийтлэг шинжтэй хувьсалуудаас дурдвал:

- Дундад үеийн монгол хэлний үед үгийн эхэнд байсан сул шүргэх ***h*** орчин үеийн олонхи хэл аялгуунуудад бүрмөсөн сугарчээ.

- ***i*** (< *i)-гээс бусад эр эгшигийн өмнө тохиолдож байсан хэлний гүн угийн хамжих ***q*** нь олонхи хэл, аялгуунуудад шүргэх ***χ*** болжээ.

- Эм эгшигт үгэнд ордог хэлний угийн хамжих ***k*** нь мөн шүргэх ***χ*** болсон байна.

- Бүр өвөг монгол хэлний үеэс уламжилан ирсэн хамжин шүргэх ***č, ǰ*** нь олонхи хэл аялгуунуудад хамжин шүргэх ***dz, ts*** болжээ.

2.1.1 УРУУЛЫН ГИЙГҮҮЛЭГЧ

Монгол хэлний уруулын гийгүүлэгчийн хэлэгдэх онцлог шинж, тохиолдох байр, хувьсах онцлогийн талаар G. J. Ramstedt, Б. Я. Владимирцов, N. Poppe нар[728] хэл зүйн бүтээлүүддээ дурдсанаас гадна үгийн эхний уруулын хамжих, шүргэх гийгүүлэгчийн хувьсал хөгжилийн талаар G. J. Ramstedt, P. Pelliot, Sh. Hattori, P. Aalto, N. Poppe, Х. Лувсанбалдан нар судалж, олон сонирхолтой үгүүлэл нийтлүүлжээ.[729]

2.1.1.1 УРУУЛЫН ХАМЖИХ ГИЙГҮҮЛЭГЧ

b (< *b)

Хоёр уруулын хамжих, дуутай ****b*** гийгүүлэгч нь орчин үеийн олонхи хэл аялгуунуудад их төлөв хэвээр уламжилан ирсэн боловч авианы орчинооосоо шалтгаалан зарим хэл аялгуунд дуугүй хамжих ***p***, мөн олонхи хэл аялгуунуудад уруулын шүргэх [w] болсон байна.

PM	*b			Mog.	b [b, f]
AM	b			Dag.	b [b, w, u/u]
MM	b			Kalm.	b [b, w]
Mngr.	b	[b, p, w]		Oir.	b [b, w]
Dun.	b	[b, p, w]		Bur.	b
Bao.	b	[b, p]		TMon.	b [b, w]
SY.	b	[b, p]		ÖMon.	b [b, w]

728 Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, 18-19, 36; Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 385-386, 400-402; N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 96-102; *idem*. Vergleichende Grammatik der altaischen Sprache, 10-12, 20-21, 34-36, 42-49, 67-69

729 G. J. Ramstedt, Zur Geschichte des labialen Spiranten im Mongolischen, *'Festschrift Wilhelm Thomsen'*, 1912, 182-187; Ein anlautender stimmloser Labial in der mongolisch-türkischen Ursprache, JSFOu. 32:2 (1916-1920), 1-10; P. Pelliot, Les mots à *h*-initiale aujourd'hui amuie dans le mongol des XIII^e^ et XIV^e^ siècles, JA 206, 1925, 193-263; Sh. Hattori, Initial Plossives of Proto Mongolian and their Later Development with Additional Remarks, SL 3, 1972, 63-92; P. Aalto, On the Altaic Initial **P*, CAJ. 1, 1955, 9-16; N. Poppe, On the Initial *h* in the Yüan-ch'ao Pi-shih, *The Bull. of the Inst.of History and Philology*, Academia Sinica, vol. 39, Part 2, Taipei, Taiwan, 1969, 267-275; Х. Лувсанбалдан, Эртний монгол хэлний үгийн эхний ***h***-гийн тухай, МС 4:1-7, 1962, 113-120

(а) Олонхи хэл аялгуунуудад үгийн эхний уруулын хамжих ***b*** нь хэлэгдэх байдалаа хэвээр хадгалж үлдсэн бөгөөд тэр нь сул гийгүүлэгчийн өмнө дуугүй, чанга гийгүүлэгчийн өмнө дуугүй болдог байна. Харин Монгор, Дунсян, Баоань, Шар Ёгур хэлнүүдэд уул гийгүүлэгч нь дуугүй хамжих ***p*** болсон тохиолдол нилээд байна. Мөн түүнчилэн хэл ярианы урсхалд эгшиг болон ***-l, -r*** гийгүүлэгчээр төгөссөн үгийн дараа орсон үгийн эхний ***b*** нь шүргэж хэлэгддэг.

PM **bari-* ‘бари-’, AM bari- Precl. (= Chang, Jig, Aruγ, Sul.), MM *bari-* (MNT, KMQB, D, Mu, IM, L, Ist.); CM *bari-* (Mngr, Dun, Mog, Dag, TMon, ÖMon.), *barĭ-* (Ha, Bur, Kha.), *bär-* (Kalm, Oir.)

PM **bitik* ‘бичиг’, AM *bičig* Precl. (= Ar. I, Bod, Chang, Hin.); MM *bičig* (MNT, KMQB, D, Mu.), CM *bitik* (Ha.), *bitih* (Kul.), *bičik* (Mog, Dag, Ord.), *bitšig* (TMon, ÖMon.)

PM **bulaγ* ‘булаг’, AM *bulaγ* Precl. (= Sub.), MM *bulaγ* (MNT, Hy, Mu, Ist.), CM *bulak* (Alar, Ord.), *bulag* (Mngr, SY, Bur, TMon, ÖMon.), *bulɒg* (Kalm.), *bulug* (Oir.), *bulār* (Dag.)

(б) Үгийн дунд орсон ***b*** нь хоёр эгшигийн хооронд, эсвэл анирт чанга гийгүүлэгчийн өмнө болон ***b, l, m, n, ŋ***-ээс бусад гийгүүлэгчийн дараа тохиолдохдоо суларч ***w*** болдог байна. Харин хэлний үзүүрийн болон уруулын гийгүүлэгчийн өмнө орвол хамжих байдалаа хэвээр нь хадгалдаг байна.

PM **ebül* ‘өвөл’, AM ebül Precl. (= Bur, Sul.), MM *übül* (MNT, Hy, Tk, Ph.), *ebül* (Mu.), *öbül* (Mu, IM.), CM *ubul* (Mog, Bur.), *ubun* (Dun.), *ugul* (Dag.), *ugur* (Mngr.), *öwöl* (TMon, ÖMon.), *üwül* (Oir.), uwel (SY.), *uwen* (Dun.)

PM **ǰobalaŋ* ‘зовлон’, AM *ǰobalaŋ* Precl. (= Bod, Bur, Sub.), MM *ǰobolaŋ* (MNT, KMQB, Hy.), *ǰobalaŋ* (Mu, IM.), CM *džoboloŋ* (Kul.), *zoboloŋ*(Bur.), *džowoloŋ* (Ord.), *dzowŏloŋ* (TMon.), *dzowlan* (Dör, Ba, Kho.), *zowlŭn* (Tor, Ur, Zakh.), *džowloŋ* (ÖMon.)

PM **φarban* ‘арван’, AM *(h)arban*/< **χarban*/ Precl. (= Bod, Hin, Jig. Taq.); MM *harban* (MNT, KMQB, Hy, D, Tk, Mu, IM, L.); CM *χarban* (SY, Kul.) // *χarwan* (Mngr.), *harwan* (Bao.), *haruan* (Dun.), *arban* (Zir, Dag, Bur.), *arwan* (TMon, ÖMon.)

PM **kebte-* ‘хэвт-’, AM *kebte-* Precl. (= Sul, Bur, Sub.), MM *kebte-* (MNT, Mu, L.), CM *kebte- /kepte-* (Oir.), *keptə* - (Kalm.), *χebte-* (Bur.), */χewte-* (TMon, ÖMon.), *gewte-* (Cha, Ord, Onn, Naim, Šgol.), *kerte-* (Dag.)

PM **belbisün* ‘бэлбэсэн’, AM *belbisün* Precl. (= Taq. /= *belbisüd*/), MM *belbisün* (MNT, Hy.), *belbisün* (Mu.), CM *belbisün* (Dag.), *belbesen* (TMon, ÖMon.), *belbehen* (Bur.), *belewsün* (Dör.), *belwə sə n* (Kalm.), *belŭsün* (Ba, Dör, Kho.)

(в) Үгийн эцэсийн болон эцэсийн задгай үеийн өмнө орсон хамжих ***b*** нь олонхи хэл аялгуунд шүргэх ***w***, Могол хэлэнд ***f***, Дагуур хэлэнд дангаараа үе үл бүтээх ***u, ӣ*** болжээ. Харин Монгор, Дунсян, Баоань, Шар Ёгур хэл болон Өмнөд монгол хэлний зарим аялгуунд (= Харчин, Хорчин) уул гийгүүлэгч нь угийн хамжих шинжээ хадгалсаар ирсэн жишээ цөөнгүй тохиолдож байна.

PM **ab-* 'ав-', AM *ab-* Precl. (= Bod, Chang, Hin, Taq.), MM *ab-* (MNT, Hy, D, Mu, IM, L, Ist.), CM *ab-* (Bao, Zir, Bur, ÖMon.), *ap-* (Leech, SY.), *aw-* (Kalm, Oir, TMon, ÖMon. /= Cha, Šgol, Učab./), *awu-* (Mngr.), a*fu-* (Mog.), *au-* (Dag.)

PM **yabu-* 'яв-', AM *yabu-* Precl. (= Bod, Chang, Qqor, Jig.), MM *yabu-* (MNT, Hy, Mu, IM, Ph.), CM *jaba-* (Bur.), /*jawɒ-* (TMon, ÖMon.), *jawu-* (Dun, Ord.), *jawɒ-* (SY.), *jaw-* (Kul.), *jow-* (Kalm, Oir.), *jau-* (Dag.), *jū-* (Mngr.)

m (<*m)

Хоёр уруулын хамжих, хамарын, дуурхаг ****m*** гийгүүлэгч нь орчин үеийн монгол хэл, аялгуунуудад үгийн аль ч үед хэлэгдэх шинжээ тогтвортой хадгалсаар иржээ. Харин Монгор, Дунсян хэл болон бусад зарим хэлний үеийн эцэсийн ****m*** нь хамарын ***ŋ***-ээр солигдсон жишээ нилээд тохиолдож байна.

PM	*m	Mog.	m
AM	m	Dag.	m
MM	m	Kalm.	m
Mngr.	m	Oir.	m
Dun.	m	Bur.	m
Bao.	m	TMon.	m
SY.	m	ÖMon.	m

PM **modun* 'мод', AM *modun* Precl. (= Bur, Hin, Sub.), MM *modun* (MNT, Hy, Tk, D, Mu, IM, Ist.), CM *modun* (Mog.), *ṃodon* (Ord, Tüm.), *modŏn* (Dör, Ur, Zakh.), *modo* (Bur.), *modŏ* (TMon, ÖMon.)

PM **sumun* 'сум', AM sumun Precl. (= Bod, Bur, Sub.), MM *sumun* (MNT, Hy, Mu, L, Ist.), *sumu* (Tk, IM.), CM *sumŭn* (Oir.), sumu (Mngr, Dun, Ord.), *suman* (Bur.), *sumɒ* (TMon.), *somo* (Dag.)

PM **em* 'эм', AM *em* Precl. (= Bod, Chang, Sub.), MM *em* (Mu, L.), CM *em* (SY, Dag, Kalm, Bur, TMon, ÖMon.)

PM **dumda* 'дунд', AM *dumda* Precl. (= Bod, Teh, Bur, Sub.), MM *dumda* (MNT, Hy, D, Mu, IM, L.), *dunda* (D, Mu, IM, L.), CM *dunda* (Mngr, Dun, SY, Mog, Bur, Ord.), *dundɒ* (Kalm, Oir, TMon, ÖMon.), *dundŭ* (Oir.), *duanda* (Dag.)

2.1.1.2 УРУУЛЫН ШҮРГЭХ ГИЙГҮҮЛЭГЧ

*φ (< PA *ρ)

Хоёр уруулын шүргэх, дуутай **φ* гийгүүлэгч нь угтаа алтайн хэлний хамжих **ρ*-гээс гаралтай бөгөөд тэр нь уулаас зөвхөн үгийн эхэнд тохиолддог байжээ. Энэхүү шүргэх гийгүүлэгч нь цаашдаа уруулын шинжээ алдаж эртний монгол хэлний үед шүргэх **χ*, дундад үеийн монгол хэлний үед сул шүргэх ***h*** болоод уламаар олонхи хэл аялгуунуудад бүрмөсөн гээгдсэн байна. Энэ тухай хойно тусхайлан дурдах болно. Өвөг монгол хэлний үед байсан уруулын шүргэх *φ*-гийн ул мөр бичигийн дурсхалуудад огт үлдээгүй бөгөөд харин Монгор, Дунсян, Баоань хэлэнд цөөн үгийн эхэнд тохиолдож байна.

PM	*φ	Mog.	
AM	*χ	Dag.	χ [χ, š]
MM	h	Kalm.	
Mngr.	f [f, h, š]	Oir.	
Dun.	f [f, h]	Bur.	
Bao.	f [f, h]	TMon.	
SY.	h	ÖMon.	

PM **φon* ‘он’, AM *(h)on* [< **χon*] Precl. (= Aruγ, Chang, Hin, Jig.), MM *hon* (MNT, KMQB, Hy, D, Mu, IM, L, Ist.), CM *fän* (Mngr.), *χon* (Kul, Min.), *χōŋ* (Dag.), *χoŋ* (Dun, Bao.) // *hon* (SY.), *hōn* (But.) // *on* (Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.)

PM **φodun* ‘од’, AM *(h)odun* [< **χodun*] Precl. (= Bur.), MM *hodun* (MNT, Hy, Tk, Mu, IM.), *hodud* (D.), CM *fōdi* (Mngr.), *χodun* (SY.), *χotun* (Dun, Bao.), *χodon* (SY.), *χodoŋ* (Bao.), *χod* (Kul, Tši.) // *odon* (Bur.), *odŏn* (Oir.), *odɒn* (Kalm.), *odo* (Ha, Tson.), *odŏ* (TMon, ÖMon.)

PM **φulaγan* ‘улаан’, AM *(h)ulaγān* [< **χulaγān*] Precl. (= Maha, Bur.), MM *hula'ān* (MNT, Hy, Mu.), *hulān* (Mu, IM, L.), CM fulān (Mngr.), *felan* (Bao.), *fulan* (Dun.) // *χulān* (Dag.), *χulaŋ* (Dun, Mngr.) // *hlān* (SY.) // *ulān* (Ha, Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.), *ulōn* (Mog.)

PM **φünir* ‘үнэр’, AM *(h)ünir* [< **χünir*] Precl. (= Bur, Sub.), MM *hünir* (MNT, KMQB, IM.), *hünür* (MNT), CM *funir* (Mngr.), *funi* (Dun. |= funitie-|), *χunir* (Min.), *χunur* (Kul.), *honor* (SY.), *ünir* (NÜd, Tünk, Barga, Ord.), *üner* (Khori, Sart, Ekh-Bul, TMon, ÖMon.), *ünür* (Bur, Oir.)

PM **φödün* ‘өд’, AM *(h)ödün* [< **χödün*] Precl. (= Sub.), MM *hödün* (Mu.), *ödün* (MNT, Hy, Tk, IM, L, Ist.), CM *χoduŋ* (Dun.), *hoden* (SY.), *hude* (But.), *ödün* (Dör.), *ödən* (Kalm.), *üden* (Bur.), *üdü* (Ord.), *ödö* (TMon, ÖMon.)

PM **φarban* ‘арван’, AM *(h)arban* [< **χarban] Precl. (= Bod, Jig, Hin, Taq.), MM *harban* (MNT, KMQB, Hy, Tk, D, Mu, IM, L.), CM *χarban* (Min, SY, Kul.), *χarbaŋ* (Dag.), *χarwan* (Mngr, Hu.), *χaruan* (Dun.) // *arban* (Zir, Dag, Bur.), *arwan* (TMon, ÖMon, Oir.)

PM	*d	Mog.	d [d, t]
AM	d	Dag.	d [d, t]
MM	d	Kalm.	d
Mngr.	d [d, t]	Oir.	d
Dun.	d [d, t]	Bur.	d [d, t]
Bao.	d [d, t]	TMon.	d [d, t]
SY.	d	ÖMon.	d [d, t]

PM **dotora* 'дотор', AM dotora Precl. (= Bod, Jig, Taq, Sul.), MM *dotora* (MNT, KMQB, Hy, D, Mu, L.), CM *doatar* (Dag.), *duatare* (But.), *dotɒr* (Kalm.), *dotor* (Kul, Bur, TMon, ÖMon.) // *totor* (Kha.), *tudor* (Mngr.)

PM **dutaγu* 'дутуу', AM *dutaγū* Precl. (= Sub.), MM *duta'ū* (MNT), *dutū* (Mu, IM.), *tutū* (Mu.), CM *dutū* (Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.) // *tudū* (Mngr.), *tutū* (Kha.)

PM **sedkil* 'сэдхэл', AM *sedkil* Precl. (= Bod, Chang, Jig, Ölǰ.), MM *sedkil* (MNT, KMQB, Mu, L.), *setgil* (D.), CM *sedkǐl* (Oir.), *sedxil* (Ord.), *sedkəl* (Kalm.), *sedxel* (Bur.) // *setxil* (AKhor, Gor.), *setxel* (TMon, Mon.), /= Naim, Onn./, *setgel* (ÖMon. /= Cha. Khar, Khor, Sgol, Tüm, Učab./)

PM **udqa* 'утга', AM *udqa* Precl. (= Bod, Hin, Bur.), CM *udxa* (Bur, Ord.) // *utxa* (AKhor, Barin, Sgol, Učab.), *utağa* (Kha.)

PM **ed* 'эд', AM *ed* Precl. (= Bod, Chang, Jig, Bur.), MM *ed* (D.), CM *ed* (Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.)

2.1.2.1.2 **Хэлний урдуурхи хамжин шүргэх гийгүүлэгч**

č (< č, *t)

Хэлний үзүүр-тагнайн урдуур хамжин шүргэх, дуугүй ***č*** нь өдгөөгийн монгол хэл аялгуунуудад уламжилан ирсэн боловч авианы орчиноосоо шалтгаалан харьцангуй олон хувилбартай болсон байна. Энэ нь угтаа өвөг монгол хэлний үеэс уламжилан ирсэн анхдагч ***č***, хожим тагнайшилын нөлөөгөөр үүссэн ***tš*** хоёрын байрлалын ялгаатай шууд холбоотой юм.

a. <u>i-гийн өмнө орсон</u>

PM	č	*t (i)
AM	č	
MM	č	
Mngr.	tš [tš, dž]	
Dun.	tš	
Bao.	tš	
SY.	tš	

b. <u>бусад эгшигийн өмнө орсон</u>

*č
č
č
tš [tš, ts, d]
tš [tš, dž]
tš
tš

Mog.	tš	tš
Dag.	tš [tš, š]	tš
Kalm.	tš	tš [tš, ts]
Oir.	tš [tš, ts]	tš [tš, ts]
Bur.	tš [tš, š]	š [tš, š]
TMon.	tš [tš, ts, d]	tš [tš, ts, dž]
ÖMon.	tš [tš, dž]	tš [tš, dž]

(а) ***i***-гийн өмнөх ***č*** (< *č, *t) нь олонхи хэл аялгуунуудад хэлэгдэх онцлог шинжээ хэвээр хадгалан үлдсэн боловч Буриад, Өмнөд Монгол хэлний зарим аялгуунд дуугүй шүргэх ***š***, Төв болон Өмнөд Монгол хэлний зарим аялгуунд дуугүй чанга гийгүүлэгчийн өмнө орсон ***č*** нь дуутай, хамжин шүргэх ***dž*** болсон байна. Мөн Халимаг, Ойрд, Төв монгол хэлний зарим цөөн үгийн эхний ***č*** нь хэлний үзүүр-шүдний хамжин шүргэх ***ts*** болжээ.

PM **čïqïn* 'чих', AM *čikin* [< *čïqïn] Precl. (= Bur, Sub.), MM *čiqin* (Mu, IM.), *čikin* (MNT, Hy, Tk, IM, L.), CM *čiqin* (Kun.), *tšiqin* (Her.), *čiqən* (Zir, Mar.), *čikin* (Mog.), *tšikin* (Oir.), *tšikə n* (Kalm.), *čiki* (Dag.), *tšixĭ* (Kha.), *tšigi* (Mngr.)// *šikeŋ* (NÜd, Tünk.), *šixeŋ* (Khori.), šexen (Bur.), *šix* (Jal, Khor, Gor.) // *džixe* (Ord.), *džix* (Dg, Barin, Cha, Kesh, Naim, Onn, Sgol.)

PM **bitik* 'бичиг', AM *bičig* Precl. (= Ar, Bod, Chang, Hin, Jig.), MM *bičig* (MNT, KMQB, D, Mu.), CM *bitik* (Ha.), *bitih* (Kul.) // *bitšik* (Mog, Kul, Ord.), *bitšig* (TMon, ÖMon.) // *bišik* (Barg, NÜd, Tünk, Gor, Jal, Khor.)

PM **tïlaγun* 'чулуу', AM *čilaγūn* Precl. (= Sub.), MM *čilawūn* (MNT, KMQB.), *čila'ūn* (MNT, Hy, Ph.), CM *čilū* (SY.), *tšilū* (Ord, Kham.), *tšulū* (Oir,Alar, Tson, Kha, AKhor, Barin, Cha, Kesh, Khar, Naim, Sgol, Tüm, Učab.) // *šulū* (Bur, Jal, Gor, Khor.

PM **atïγan* 'ачаа', AM *ačiyān* (Mo.)[< *ačiγān], MM *ačiyā* (Ist.), *ači'ā* (MNT, Mu, IM.), *ača'ān* (KMQB, Mu.), *ačā* (Mu, IM.), CM *ačija* (Man.), *ačān* (SY.), *atšān* (Kalm, Tor, Cha, Ord, Khar, Sgol, Tüm, Učab.), *atšā* (Dör, Kha, Ord.) // *ašān* (Bur, Jal, Gor, Khor.)

PM**tïsun* 'цус', AM *čisun* ~ *čisu* Precl. (= Maha, Bur, Sub.), MM *čisun* (MNT, L.), CM *tšisu* (Her.), *tšiedzu* (Mngr.), *tšisoŋ* (Bao.), *čusun* (SY, Dun.), *tšusun* (Mog.) // *tsusun* (Dör, Zakh, Ur. 9), *tsusɒn* (Kalm.), tsusɒ (Kha.) // šuhuŋ (NÜd, Khori, Tünk.), *šuhŭ* (Barg.), *šuhan* (Bokh.), *šuhɒŋ* (Alar.), *šus* (Khor.), *šut* (Jal.) // *džusu* (Ord.), *džus* (Cha, Kesh, Naim, Onn, Učab.)

PM **tïraj* 'царай', AM *čirai* Precl. (= Chang, Maha, Taq, Bur, Sub.), MM *čirai* (MNT, KMQB, Mu.), CM *tširā̆* (Kalm, Oir.), *tšarā̆* (Ord.), *tšerā̆* (Üz.) // *tsarai* (Kha.) // *šarai* (Dag, Bur.), *šari* (But.)

(б) ***i***-гээс бусад эгшигийн өмнөх ***č*** (< *č) нь олонхи хэл аялгуунуудад хэлэгдэх байдалаа хэвээр хадгалан үлдсэн боловч Монгор, Халимаг, Буриад (= Цонгоол,

Сартуул), Төв монгол хэлэнд хэлний үзүүр-шүдний хамжин шүргэх *ts*-гээр, Монгор, Дунсян, Баоань хэлнүүд болон Өмнөд монгол хэлний зарим аялгуунд *dž*-ээр, буриад хэлний олонхи аялгуунд *s*-ээр тус тус хэлэгдэх болжээ.

PM **časun* 'цас', AM *časun* Precl. (= Sub.), MM *časun* (MNT, Hy, Mu, IM, L, Ist.), CM *časun* (Mog, Dun.), *čāsun* (Zir.), *časoŋ* (Bao.), *tšiäse* (Mngr.), čōsun (Mog.), *tšas* (Dag, AKhor, Barin, Khar, Tüm, Urad.) // *tsasan* (SY, Zakh.), *tsasɒn* (Kalm.), *tsasɒ* (Kha.) // *džasun* (Dun.), *džasən* (SY.), *džasu* (Ord.), *džas* (Dg, Cha, Kesh, Naim, Onn.) // *sahan* (Tünk, Ekh-Bul.), sahaŋ (NÜd, Tünk, Khori.), sahɒŋ (Alar.) *sahɒ* (Bar.) // *dzas* (Kha, Dg.)

PM **čeček* 'цэцэг', AM *čečeg* Precl. (= Bod, Bur, Sub.), MM *čeček* (Mu, IM.), *čečeg* (Hy, Mu.), CM *čečak* (Mog.), *čičik* (Bao.), *tšidžiag* (Mngr.), *tšidže* (Dun.),*tšitšig* (AKhor, Barin.) // *tsetseg* (Dör, Zakh, Sart, Kha.), *tsetsəg* (Kalm.) // *džitšik* (Ord.), džitšig (Cha.), *seseg* (Bur.) // *setsik* (Barin.), *sešig* (Jar.), *sesek* (Barg.) // *šišeg* (Gor, Jal, Khor.), *dzetseg* (Kha, Dg.)

PM **qačar* 'хацар', AM *qačar* (Mo.), MM *qačar* (MNT, Hy, Mu, IM, L.), *qačir* (Mu, L.), CM *χačir* (Mngr, Dag.), *kačire* (But.), *kačir* (Kul.), *ǧatšar* (Ord, Cha, Sgol.), *xetšar* (Barin.), *χetšir* (AKhor, Khar, Tüm.), *kača* (Dun.) // *χatsar* (Kha.), *χatsɒr* (Kalm.) // *χasar* (Bur.) // *χašar* (Gor, Jal, Khor.) // *χadžiär* (Mngr.)

PM **qanču* 'ханцуй', AM *qanču* (Mo.), MM *qanču* (MNT, Mu, IM.), CM *xantšu* (Ord.), *qamču* (Mog.), *qamči* (Man, Mar.), *xanči* (Ha.), *kanči* (But.), *χemtši* (AKhor, Barin, Khar, Kesh, Naim, Onn, Tüm.), *χanč* (Kul.) // *χantsui* (Kha.), *xantsɒn* (Dör, Zakh, Ur, Kalm.) // *xandži* (Mngr.), *ǧandžun* (Dun.), *χandžun* (SY.), *ǧandžon* (Bao.) // *χansui* (Tünk, Khori.), *χamsī* (Bur.) // *χemšī* (Gor, Jal, Khor.)

ǰ (< *ǰ, *d)

Хэлний үзүүр-тагнайн урдуур хамжин шүргэх, дуутай ***ǰ*** нь орчин үеийн олонхи монгол хэл аялгуунуудад хэлэгдэх байдалаа их төлөв хэвээр хадгалан үлдсэн боловч хэл тус бүрийн онцлог, авианы байрлалаасаа шалтгаалан хоёр үндэсэн хувилбартай болжээ. Энэ нь угтаа өвөг монгол хэлний үеэс уламжилан ирсэн **ǰ*, хожим тагнайшилын нөлөөгөөр үүссэн ***dž*** хоёрын ялгаатай шууд холбоотой юм.

	a. <u>і-гийн өмнө орсон</u>	b. <u>бусад эгшигийн өмнө орсон</u>
PM	ǰ, *d	*ǰ
AM	ǰ	ǰ
MM	ǰ	ǰ
Mngr.	dž	dž
Dun.	dž	dž
Bao.	dž	dž
SY.	dž	d

Mog.	dž	d
Dag.	dž	d
Kalm.	dž [dž, z]	z
Oir.	dž[dž, dz]	d[dž, dz, z]
Bur.	ž[ž, z, j]	dz [dz, z]
TMon.	dž [dž, dz]	dz
ÖMon.	dž	dž

(а) ***i*-гийн өмнөх *ǰ*** (< *ǰ, *d) нь олонхи хэл аялгуунуудад хэлэгдэх онцлог шинжээ хэвээр хадгалан үлдсэн боловч буриад хэлний зонхилох хэл аялгуунуудад тагнайн шүргэх ***ž*** болсон байна.

PM **dil* 'жил', AM *ǰil* Precl. (= Aruγ, Bod, Hin, Ölǰ.), MM *ǰil* (MNT, KMQB, D, L.), CM *dil* (NÜd.), *džil* (Her, Dag, Kalm, Oir, Bur /= Bar, Tson, Sart./, TMon, ÖMon.), *džir* (Mngr.), *džeŋ* (Dun.), *džel* (SY.) // *žil* (Bur. /= NÜd, Khori, Tünk, Alar./) // *jil* (Ekh-Bul., Khor.), *jel* (Bar.)

PM **diluya* 'жолоо', AM *ǰiluyā* Precl. (= Bur, Qqor.), MM *ǰilu'ā* (MNT), *ǰilo'ā* (MNT), *ǰolā* (IM.), CM *dilō* (Dag.) // *džilō* (Ord.), *džolā* (Kalm, Oir.), *džolō* (But, Bur. /= Bar, Tson./, TMon, ÖMon.), *dželū* (SY.) // *žolō* (Bur. /= Alar, Khori, Tünk./) // *jolō* (Bur. /= Ekh-Bul, Bokh, Kach./Jar.)

PM **adïrya* 'азарга', (Mo.); MM *aǰirya* (MNT, Hy, Mu, IM, L, St, HQ.), CM *adirag* (Dag.), *aderihe* (But.) // *adžirğa* (Min, Zakh, Dör, Barin, Jas, Üz.), *adžarğa* (Ord.), *adžerğa* (SY.), *edžirag* (ÖMon.) // *adzarağa* (Kha.) // *azarğa* (Bur.)

PM **diryalaŋ* 'жаргал', AM *ǰiryalaŋ* Precl. (= Bod, Sul, Bur, Sub.), MM *ǰiryalaŋ* (MNT, Hy.), *ǰirqalaŋ* (D.), CM *džirğalaŋ* (Ord.), *džirğɒlan* (Oir.), *džirɒlɒn* (Kalm.) // *žarğalaŋ* (Bur.) // *jarğalaŋ* (Alar.), *jarğal* (Ekh-Bul, Bar.)

(б) Халимаг, Ойрд, Буриад, Төв монгол хэлнүүдэд арынх нь ***i*** эгшиг ухаран ижилшилийн уламаас өөр эгшигээр солигдсон зарим цөөн үгийн эхний ***ǰ*** гийгүүлэгч нь хэлний үзүүр-шүдний хамжин шүргэх ***dz,*** эсвэл шүргэх ***z*** болжээ.

PM **ǰïγasun* ‘загас’, AM *ǰiγasun* (Mo.), MM *ǰiγasun* (MNT, Hy, Mu.), *ǰiqasun* (L.) CM. *džilğason* (Bao.), *džiäğase* (Mngr.), *džağasun* (Dun.), *džağasen* (SY.), *džağasu* (Ord.), *džağas* (AKhor, Barin, Cha, Khar, Khor, Kesh, Naim, Onn, Tüm.) // *dzağas* (Kha.), *dzağɵsɵn* (Oir.) // *zağahan* (Bur.), *zağān* (Bokh.), *zağɵsɵn* (Kalm.)

PM **dïruγ* ‘зураг’, AM *ǰiruγ* Precl. (= Bur.), MM *ǰiruγ*|= Cf. *ǰiru-* Mu.|), CM *džuruk* (Ord.), džurag (AKhor, Barin, Cha, Khar, Khor, Sgol, Tüm.) // dzurag (Oir, Kha.) // zurŭg (Kalm.), zurag (Bur.)

PM **dïsun* ‘зүс’, AM *ǰisün* Precl. (= Hin, Bur.), MM *ǰisün* (MNT), CM *džis* (Kul, SY.), *džüsü* (Ord.), *džüs* (Ha, AKhor, Barin, Cha, Khar, Khor, Sgol, Tüm, Učab.) // *dzüsüm* (Zakh, Tor, Ur.), *dzüsem* (Ba, Dör, Kho.), *dzüsə* (Kha.) // *zühen* (Bur.), *zusən* (Kalm.)

PM **dïrüken* ‘зүрэх’, AM *ǰirüken* Precl. (= Bur, Sub.), MM *ǰirüke* (MNT), *ǰürüken* (Hy, Mu.), *ǰürüke* (IM.), *ǰürke* (L.), CM *džirge* (Bao.), *džierge* (Mngr.), *džirgen* (SY.), *džürexe* (Ord.), *džuge* (Dun.), *džürxə* (ÖMon.), *džurka* (Mog.), *džurug* (Ha.), *džürkən* (Ba, Dör.) // *dzürkin* (Zakh.), *dzürkün* (Dör.), *dzürex* (Kha.) // *zürkən* (Kalm.), *zürxəŋ* (Alar.), *zürkün* (Kho.), *zürkin* (Ö, Tor, Ur.), *zürxen* (Bur.)

(в) ****i***-гээс бусад эгшигийн өмнө орсон ***ǰ***(< **ǰ*) нь Төв монгол хэлэнд ***dz***, Ойрдод ***dž, dz, z*** Буриадад ***dz, z,*** Халимагт ***z*** болсон байна.

PM **ǰaγun* ‘зуун’, AM *ǰaγūn* Precl. (= Aruγ, Chan.), MM *ǰawūn* (L, Ist.), *ǰa'ūn* (MNT, KMQB, Hy, Tk, Mu, IM.), CM *ǰaun* (But.), *džau* (Ha.), *džūn* (SY, ÖMon.) // *dzūn* (Dör, Sart, Tson, Kha.) // *zūn* (Kalm, Zakh, Tor, Ur. Bur.)

PM **ǰayaγan* ‘заяа’, AM *ǰayaγān* Precl. (= Bod, Chang, Jig, Bur, Sub.), MM *ǰaya'ān* (MNT, KMQB.), *ǰayān* (KMQB, Ph.), CM *džiyā* (Ha, Ord.), *džiäyān* (Mngr.), *džayān* (ÖMon.), *džān* (SY.) // *dzayā* (Zakh, Sart, Tson, Kha.) // *zajān* (Kalm.), *zajā* (Bur.)

PM **ǰegüden* ‘зүүд’, AM *ǰegūden* Precl. (= Bur.), MM *ǰewūden* (MNT, Hy.), *ǰūdün* (Mu.), CM *džeude* (Ha.), *džoudu* (Mog.), *džeudžien* (Dun.), *džudin* (Mngr.), *džudun* (Zir.), *džūde* (Ord.), *džūd* (ÖMon.) // *dzūdən* (Dör.), *dzūdə* (Kha.), *dzūd* (Üz.) // *zūdən* (Kalm.), *zūdün* (Zakh, Ö, Tor, Ur.), *zūde* (Bur.)

PM **ǰobalaŋ* ‘зовлон’, AM *ǰobalaŋ* Precl. (= Bod, Bur, Sub.), MM *ǰobalan* (Mu, IM.), *ǰobolan* (MNT, KMQB.), CM *džobolon* (Kul.), *džowoloŋ* (Ord.), *džowŏlŏŋ* (Ha, Üz.), *džowloŋ* (ÖMon.), *džōloŋ* (SY.) // *dzowlon* (Ba, Dör, Kho.), *dzowloŋ* (Kha.) // *zowolon* (Bur.), *zowlɵn* (Kalm.)

PM **ǰüg* ‘зүг’, AM *ǰüg* Precl. (= Chang, Bod, Hin, Bur, Sub.), MM *ǰüg* (MNT, KMQB, D, Mu.), CM *džug* (Zir, KT, Ha, ÖMon.), *džiäg* (Mngr.) // *dzüg* (Ba, Dör, Kho, Zakh, Kha.) // *züg* (Kalm, Bur.)

2.1.2.1.3 Хэлний урдуур шүргэх гийгүүлэгч

s (< *s)

***i*-гийн өмнөх хэлний үзүүр-шүдний дуугүй шүргэх *s* (< *s) нь бүр эртний монгол хэлний сүүлч, дундад үеийн монгол хэлний эхэн үеэр арынхаа эгшигийн нөлөөгөөр тагнайшиж *š* болсон бөгөөд түүний арын эгшиг нь зарим үгэнд ухаран ижилшиж, өөр эгшигээр солигдсон боловч урид нэгэнт үүссэн шүргэх *š* гийгүүлэгч өдгөөгийн олонхи хэл аялгуунд хэвээр хадгалагдан үлджээ. Тийм учираас *i*-гээс бусад эгшигийн өмнө ч *š* гийгүүлэгч тохиолдох болсон байна. Мөн түүнчилэн харь хэлнээс зээлдэн авсан зарим үгс, тэр ч байтугай авиа дууриах замаар үүссэн үгэнд ч *š* гийгүүлэгч *i*-гээс бусад эгшигийн өмнө тохиолдож байна. Дээр дурдсанаас бусад тохиолдолд шүргэх *š* гийгүүлэгч хэлэгдэх байдалаа хэвээр хадгалсаар иржээ.

	a. <u>i-гийн өмнө орсон</u>	b. <u>бусад эгшигийн өмнө орсон</u>
PM	*s	*s
AM	s [s, š]	s
MM	s [s, š]	s
Mngr.	š [š, s]	s [s, dz]
Dun.	š [š, s]	s [s, š]
Bao.	š [š, s]	s [s, š]
SY.	š [š, s]	s [s, š]
Mog.	š [š, s]	s [s, š]
Dag.	š	s [s, š]
Kalm.	š	s [s, š]
Oir.	š	s [s, š]
Bur.	š	s [s, š]
TMon.	š	s [s, š]
ÖMon.	š	s [s, š]

(а) ***i*-гийн өмнө орсон *s* нь орчин үеийн нийт монгол хэл аялгуунд арынхаа эгшигийн нөлөөгөөр хэлний үзүүр-тагнайн шүргэх *š* болсон бөгөөд харин Могол хэлэнд *i* (< *i)-гийн өмнө, монгор хэлэнд *i, u* эгшиг болон хамжин шүргэх *dž*-гээс бусад гийгүүлэгчийн өмнө ороxдоо хэлэгдэх байдалаа хэвээр нь хадгалж үлдсэн байна. Мөн Дунсян, Баоань хэлэнд ***i*-гийн өмнө байсан *s* гийгүүлэгч тагнайшаагүй үлдсэн жишээ хаяа тохиолдож байна.

PM **sine* ‘шинэ’, AM *sine* Precl. (= Ar. II, Bod, Jig, Qqot, Bur.), MM *šine* (D, Mu.), *šini* (MNT, Hy, Mu, Ist.), *šine* (Bao, Ord.), *šinə* (Kalm, Oir.), *šini* (Dun.), *šeni* (Bur.), *šiní* (TMon, ÖMon.)

РМ **sibar* ‘шавар’, АМ *sibar* Precl. (= Bur, Sub.), ММ *šibar* (MNT, Hy, Tk, Mu, IM.), СМ *šiwar* (SY.), *šabar* (Bur, AKhor, Barin, Gor, Jal, Khor.), *šawar* (Dag, Oir, Mon, ÖMon. /= Ord, Cha, Sgol, Učab./), *šawɒr* (Kalm.), *šaure* (But.), *šwar* (SY.), *šuwa* (Dun.) // *sawar* (Mngr.)

РМ **sibaγun* ‘шувуу’, АМ *sibaγūn* Precl. (= Hin, Sul, Bur.), ММ *šibawūn* (MNT, KMQB, Tk, Mu, L.), *siba'ūn* (Hy, D, Mu, L.), *suwu* (L.), СМ *šibū* (Min.), *šiwū* (Ord.), *šobū* (Barin.), *šowūn* (Kalm.), *šowō* (Dag.), *šubūn* (Barg, Tünk.), *šubūŋ* (Alar.), *šubū* (Bur.), *šuwun* (Oir, ÖMon.), *šuwū* (Kha.), *šū* (Mngr.)

РМ **sibüge* ‘шөвөг’, АМ *sibüge* (Mo.), ММ šibüge (MNT, Mu, IM.), СМ *šöwögō* (Ord.), *šöwög* (Mon, ÖMon.), *šübüge* (Khori, Bokh.), *šübge* (Bur.), *šöwgə* (Kalm.) // *sebgu* (Bao.), *sumege* (Dun.)

РМ **sidün* ‘шүд’, АМ *sidün* Precl. (= Bur, Sub.), ММ *šidün* (Hy, Tk, Mu, L, IM, Ist.), *šidü* (MNT), СМ *šidun* (Dun.), *šidu* (Dag.), *shudun* (Leech.), *šüdün* (Dör, Zakh.), *šüdü* (Ord.), *šüden* (Tünk.), *šüdən* (Alar, Khori.), *šüde* (Bur.), *šüdən* (Kalm.), *šüdə* (Kha.), *šüd* (ÖMon.) // *sudun* (Mog.), *sdi* (Mngr.)

(б) ****i***-гээс бусад эгшигийн өмнө орсон ***s*** гийгүүлэгч нийт монгол хэл аялгуунуудад хэвээр уламжилан үлдсэн боловч дундад үеийн монгол хэлний үед эгшиг авиа ижилшихээс өмнө арынхаа ****i***-гийн нөлөөгөөр тагнайшиж үүссэн *š* гийгүүлэгч одоогийн хэл аялгуунуудад ***i***-гээс өөр эгшигийн өмнө тохиолдож байна. Мөн уул ***s*** гийгүүлэгч нь буриад хэлний Ага, Алар, Барга, Эхирид-булагад, Хори аялгуунд сул шүргэх ***h***-гээр, Сартуул, Цонгоол, Хорчин, Жалайд, Дөрвөд аялгуунд хамжих ***d***, ***t***-гээр, Монгор хэлэнд хамжин шүргэх ***dž***-гээр хэлэгдэж байна.

РМ **saqal* ‘сахал’, АМ *saqal* Precl. (= Bur.), ММ *saqal* (MNT, Hy, Mu, IM, L, Ist.), СМ *sağal* (Mngr, Mog, Dag, SY.), *saghal* (Leech.), *sağaŋ* (Dun.), *saχal* (Oir, TMon, ÖMon.), *saqɒl* (Kalm.), *saχul* (Ord.) // *haχal* (Bur.)

РМ **sečen* ‘цэцэн’, АМ *sečen* Precl. (= Chang, Jig, Bur.), ММ *sečen* (MNT, KMQB, Hy, Ph.), СМ *sečin* (But.), *setšin* (Ord, Khar.), *setsen* (Gor, Kesh.), *sesen* (Bur.) // *šidžan* (Dun.)

РМ **söni* ‘шөнө’, АМ *söni* Precl. (= Hin, Bur, Chang.), ММ *söni* (MNT, KMQB, Hy, Tk, Mu, IM, L, Ist.), СМ *söni* (Zir, Mar.), *sön* (AKhor, Barin, Khar, Naim, Onn.), *suni* (Mog, Dag.), *sõnə* (SY.), *soni* (Mngr.), *sõ* (Kalm, Oir.), *šönĭ* (Kha.), *šön* (Kesh, Učab, Ab.), *šüni* (Tson.), *šünö* (Sart.) // *hönə* (Alar.), *hüni* (Aga, Bar.)

РМ **sumun* ‘сум’, АМ *sumun* Precl. (= Bod, Bur, Sub.), ММ *sumun* (MNT, Hy, KMQB, Mu, L, Ist.), *sumu* (Tk, IM.), СМ *sumun* (Oir.), *sumu* (Mngr, Dun, Ord.), *suman* (Bur.), *sumɒn* (Kalm.), *sum* (Cha, Kesh, Khor, Sgol, Učab.), *somo* (Dag.) // *homoŋ* (Alar, Tünk, Khori.), *hom* (Bar.)

PM **süke* 'сүх', AM *süke* Precl. (= Aruγ, Jig.), MM *süke* (MNT, Hy, Mu, IM.), CM *suke* (SY.), *süke* (Kham.), *sugie* (Mngr.), *suhe* (But.), *süxe* (Ord.), *süxə* (Kalm, Oir, Kha.), *suh* (Kul.), *soguo* (Mngr.) // *hüxe* (Bur.), *hüke* (Tünk.)

PM **usun* 'ус', AM Precl. (= Bod, Chang.), MM *usun* (MNT, Hy, KMQB, Tk, D, Mu, IM, L, Ist.), *usu* (MNT, Hy, Ph.), CM *usun* (Mog.), *usŭn* (Oir.), *husun* (SY.), *fudzu* (Mngr.), *usu* (Dun, Ord.), *usɒ* (Kha.), *oso* (Dag.), *os* (Khor, Gor, Jar, Tüm.) // *uhuŋ* (NÜd.), *uhaŋ* (Bokh, Tünk.)

PM **ulus* 'улс', AM *ulus* Precl. (= Qqor, Bur.), MM *ulus* (MNT, KMQB, Hy, D, Mu.), CM (Mog, Oir, Ord.), *ulŭs* (Ha, Bar.), *ulus* (Bur, Kha.), *ulɒs* (Kalm.)

2.1.2.1.4 **Хэлний урдуурхи хамарын гийгүүлэгч**

n (< *n)

Хэлний үзүүр-шүдний, дуутай, хамжих, хамарын ***n*** гийгүүлэгч нь орчин үеийн монгол хэл аялгуунуудад хэлэгдэх байдалаа тогтвортой хадгалж ирсэн бөгөөд харин үгийн эцэсийн ***n*** нь хэл, аялгуу тус бүрт харилцан адилгүй үлдсэн байна.

	a. <u>i-гийн өмнө орсон</u>	b. <u>бусад эгшигийн өмнө орсон</u>
PM	*n	*n
AM	n	n
MM	n	n
Mngr.	n	n [n, ∅]
Dun.	n	n [n, n, ∅]
Bao.	n	n [n, n, ∅]
SY.	n	n [n, n]
Mog.	n	n
Dag.	n	n [n, ∅]
Kalm.	n	n
Oir.	n	n
Bur.	n	n [n, ∅]
TMon.	n	n [n, ∅]
ÖMon.	n	n [n, ŋ, ∅]

(a) Үгийн эхэн, дунд орсон хэлний үзүүрийн ***n*** нь өнөөгийн хэл аялгуунуудад тогтвортой хадгалагдан үлджээ. Харин зарим хэл аялгуунд уул ***n*** нь ***l*** зэрэг гийгүүлэгчээр солигдсон боловч тэдгээр нь тухайн фонемийн хувилбар бус, гийгүүлэгчийн солигдолын үр дүн юм.

PM **namur* 'намар', AM *namur* Precl. (= Bod, Teh, Sub.), MM *namur* (MNT, KMQB, Hy, D, Mu, IM.), CM *namur* (Dag, Ord.), *namar* (Oir, Bur, TMon, ÖMon.), *namɒr* (Kalm.)

PM **nere* 'нэр', AM *nere* Precl. (= Chang, Jig, Hin, Bur.), MM *nere* (MNT, KMQB, D, Mu, L.), CM *nere* (Dun, SY, Bao, But, Bur, Ord.), *nera* (Mog.), *niere* (Mngr.), *nerə* (Kalm, Oir, TMon, ÖMon.)

PM **noyan* 'ноён', AM *noyan* Precl. (= Chang, Hin, Taq, Sul.), MM *noyan* (MNT, KMQB, Hy, Tk, Mu, IM, L, Ist.), *noyad* (D.), CM *nojan* (Dun.), *nojɒn* (Kalm, Oir.), *nojon* (Mngr, Bur, Ord.), *nojŏŋ* (Alar.), *nojōn* (Mngr.), *nojin* (Dör, ÖMon.), *nojĭn* (Kha.), *nojen* (Dun.)

PM **ene* 'энэ', AM *ene* Precl. (= Bod, Chang, Jig, Hin, Bur.), MM *ene* (MNT, KMQB, D, Mu, IM, L, Ist.), CM ene (Dun, Bao, SY, Bur, Ord.), *ena* (Mog.), *enə* (Ha, Oir, Kalm, TMon, ÖMon.)

PM * *qonin* 'хонь', AM *qonin* Precl. (= Jig. /= qonid/), MM *qonin* (MNT, Hy, Mu, Ist.), *qoni* (Tk, IM, L.), CM *qonin* (Mog.), *χonin* (Tünk.), *χoni* (Mngr, Dag, Bur.) // *χonĭ* (Ha, Kha.), *goni* (Dun.), *ğon* (Dag, Dg, Cha, Šgol, Učab.), *χ̄ōn* (Kalm, Oir.), *χ̄ōn* (AKhor, Barin, Gor, Khar, Naim, Onn, Tüm.)

(б) Үгийн эцэст орсон хэлний үзүүрийн ***n*** нь Монгор, Могол, Халимаг, Ойрд хэлнүүдэд тогтвортой хадгалагдаж ирсэнээс гадна Дунсян, Баоань, Шар Ёгур хэлэнд хэлний хойгуур хэлэгдэх өөр хувилбартай болж, Дагуур, Буриад, Төв монгол хэлнүүдэд гагцхүү хэлний хойгуурхи ***ŋ***-ээр хэлэгдэх болсон байна. Гэвч тэр нь морфемуудын харьцаанд хэлний урдуур хэлэгдэх байдалаа хадгалдаг ажээ. Таширамд дурдахад, олонхи нэр үгийн эцэсийн ***n*** нь харъяалах, өгөх-орших, гарах тийн ялгалын үндэсэнд илэрээд бусад харьцаанд нууц хувилбараар илэрдэг байна.

PM **edin* 'эзэн', AM *ejen* Precl. (= Bod, Chang, Maha, Bur, Sub.), MM *ejen* (MNT, KMQB, Hy, D, Mu.), CM *edžin* (But, ÖMon.), *edžiŋ* (Ha.), *edšen* (Dun, Kul.), *edžan* (Mog.), *eduin* (Ba, Ö, Zakh, Kho.), *edzeŋ* (Sart, Kha, Cha, Učab.), *ezen* (Bur.), *ezən* (Kalm.)

PM **modun / *mōdun* 'мод', AM *modun* Precl. (= Hin, Bur, Sub.), MM *modun* (MNT, Hy, Tk, Mu, IM, Ist.), CM *modun* (Mog.), *motun* (Dun.), *mōdun* (Zir, KT.), *mutun* (Her.), *modoŋ* (Khori, Tünk.), *modɒn* (Oir, Kalm.), *muden* (SY.) // *modo* (Bur.), *modŏ* (Kha.), *mudu* (Ord.), *mōdo* (Dag.), *mōdi* (Mngr.), *mod* (Dg, ÖMon.)

PM **morin* 'морь', AM *morin* Precl. (= Bur, Jig, Sub.), MM *morin* (MNT, Hy, Tk, D, Mu, L, Ist.), *mori* (MNT, D, IM, L, HQ.), CM *morin* (Mog, Bokh, Tünk.), *mörön* (Oir.), *mörən* (Kalm.), *mörin* (Barg.) // *mori* (Mngr, Dun, Dag, Bur.), *morĭ* (Ha, Kha.), *mor* (Dg, Cha, Sgol, Učab.), *mör* (ÖMon.)

PM * *usun* 'ус', AM *usun* Precl. (= Bod, Chang, Qqor, Hin, Sul.), MM *usun* (MNT, KMQB, Hy, Tk, D, Mu, IM, L, Ist.), *usu* (MNT, Ph.), CM *usun* (Mog.), *husun* (SY.), *usŭn* (Oir.), *usɒn* (Kalm.), *uhaŋ* (Aga, Alar, Ekh-Bul, Khori.) // *usu* (Her, Dun.), *uhu* (Bar.), *usɒ* (Kha.), *oso* (Dag.)

PM **füsün* 'үс', AM *(h)üsün* [< *χüsün] Precl. (= Taq, Bur, Sub.), MM *hüsün* (MNT, Hy, IM, L, Ist.), *hüsü* (MNT), *üsün* (Mu.), CM *usun* (Mog.), *üsün* (Oir.), *üsən* (Kalm.), *usuŋ* (Dun.), *suŋ* (Bao.) // *ühe* (Bur.), *üsü* (Dag, Ord.), *üsə* (Kha.)

2.1.2.1.5 Хэлний урдуур-хажуугийн гийгүүлэгч

l (< *l)

91. Хэлний урдуур-хажуугийн, дуутай, шүргэх ***l*** гийгүүлэгч нь уулаас үгийн эхэнд ордоггүй байсан бөгөөд хэлэгдэх байдалаа хэвээр хадгалан үлджээ. Харин тухайн зарим хэл аялгуунд ***m, n, r***-ээр солигдсон нь зөвхөн авиа зүйн үзэгдэл юм.

PM	*l	Mog.	l
AM	l	Dag.	l [l, l]
MM	l	Kalm.	l
Mngr.	l	Oir.	l
Dun.	l	Bur.	l
Bao.	l	TMon.	l
SY.	l	ÖMon.	l

PM **altan* 'алт', AM *altan* Precl. (= Chang, Hin, Jig.), MM *altan* (MNT, KMQB, D, Mu, L.), CM *altan* (SY, Zir, Oir.), *antan* (Dun.), *xardan* (Mngr.), *antaŋ* (Bao.), *alta* (Dag, Bur, Ord.), *altɒ* (Kha.), *alt* (Dör, Ur.)

PM **olan* 'олон', AM *olan* Precl. (= Ar 2, Bod, Chang, Jig, Hin.), MM *olan* (D, Mu, IM, L.), *olon* (MNT, KMQB, Hy, D, Mu.), CM *olɒn* (Kalm, Oir.), *oluon* (Mngr.), *oloŋ* (SY, Bur, TMon, Ömon.), *woalaŋ* (Dag.)

PM **γal* 'гал', AM Precl. γal (= Bur, Sub.), MM *γal* (MNT, Hy.), *qal* (IM.), *γal* (Mu.), *qāl* (Mu, L, Ist.), CM *ğal* (SY, Man, Kul, Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.), *γōl* (Mog.), *ğal* (Dag.)

PM **köl* 'хөл', AM *köl* Precl. (= Bur, Maha, Sub.), MM *köl* (MNT, Hy, Tk, Mu, L, Ist.), CM *köl* (Mog, SY, Kalm, Oir, Ord.), *kul* (Leech, Bao.), *kul* (Dag.), *χöl* (TMon, Ömon.), *χöl* (Bur.)

2.1.2.1.6 **Хэлний үзүүрийн чичирэх гийгүүлэгч**

r (< *r)

92. Хэлний үзүүрээр чичирэн шүргэх, дуутай ***r*** гийгүүлэгч нь уулаас үгийн эхэнд ордоггүй байсан бөгөөд хэлэгдэх онцлог шинжээ тогтвортой хадгалсаар иржээ. Харин одоогийн Баоань хэлэнд үгийн эхний өргөлтгүй эгшиг гээгдсэнээс *r*-ээр эхэлсэн нилээд үг гарч ирсэн байна.

PM	*r	Mog.	r
AM	r	Dag.	r [r, r]
MM	r	Kalm.	r
Mngr.	r	Oir.	r
Dun.	r	Bur.	r [r, r]
Bao.	r	TMon.	r
SY.	r	ÖMon.	r

PM **γar* ‘гар’, AM *γar* Precl. (= Alt, Bur, Sub.), MM *γar* (MNT, Hy, Mu.), *qar* (Mu, IM, L, Ist.), CM *ğar* (Mngr, SY, Mog, Kalm, Oir, TMon, ÖMon.), *qa*r (Bao.) юю *ğari* (Dag.)

PM **ger* ‘гэр’, AM *ger* Precl. (= Bod, Chang, Taq.), MM *ger* (MNT, KMQB, Mu, IM, L, Ist.), CM *ger* (Mngr, SY, Mog, Dag, Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.), *gir* (Leech.), *gehir* (Zir.)// *gerĭ* (Ha.)

PM **ere* ‘эр’, AM *ere* Precl. (= Bod, Jig, Hin.), MM *ere* (MNT, Hy, Tk, Mu, IM, L, Ist.), CM *ere* (SY, Bao, But, Kul, Bur, Ord.), *erə* (Kalm, Oir, TMon.), *er* (ÖMon.)

PM *nere* ‘нэр’, AM *nere* Precl. (= Chang, Hin, Jig, Bur.), MM *nere* (MNT, KMQB, D, Mu, L.), CM *nere* (Dun, Bao, SY, But, Bur, Ord.), *nerə* (Kalm, Oir, TMon.), *nera* (Mog.), *niere* (Mngr.), *ner* (ÖMon.)

2.1.2.2 ХЭЛНИЙ ДУНДУУРХИ ГИЙГҮҮЛЭГЧ

j (< *j)

Хэлний дундуурхи гийгүүлэгч. Хэлний дундуур шүргэх, дуутай ***j*** гийгүүлэгч нь үгийн эхэн, дунд хэлэгдэх байдалаа хэвээр хадгалан үлдсэн бөгөөд харин үгийн эцэсийн **j* нь хагас эгшигийн хуулиар ***i*** болсон байна. Энэ тухай 1.322-т тодорхой дурдсан болно.

PM	*j	Mog.	j
AM	j	Dag.	j
MM	j	Kalm.	j

Mngr.	j	Oir.	j
Dun.	j	Bur.	j
Bao.	j	TMon.	j
SY.	j	ÖMon.	j

PM **jasun* 'яс', AM *yasun* Precl. (= Jig, Hin, Bur, Sub.), MM *yasun* (MNT, Hy, Mu, IM, L.), *yāsun* (Ist.), CM *jasun* (Dun.), *jasu* (Dag, Ord.), *jōsun* (Mog.), *jasan* (SY.), *jasɒn* (Kalm, Oir.), *jahɒŋ* (Alar, Khori.), *jaha* (Bur.), *jasoŋ* (Bao.), *jase* (Mngr.), *jasɒ* (Kha.), *jas* (ÖMon.)

PM **jirsün* 'ec', AM *yisün* Precl. (= Bod, Bur.), MM *yisün* (MNT, Tk, Mu, IM, L, Ist.), *yesün* (KMQB, Hy.), CM *jisün* (Ur.), *jesün* (Dun, Dag.), *jesoŋ* (Bao.), *jise* (Dag.), *jisən* (Kalm.), *jisü* (Ord.), *jesən* (Ba, Dör, Kho.), *jis* (Kul, Ö, Zakh, Cha, Učab, Khar.), *jösö* (Kha.), *jühe* (Bur.), *isen* (SY.)

PM **jeke* 'их', AM *yeke* Precl. (= Bod, Qqor, Chang, Hin.), MM *yeke* (MNT, KMQB, Hy, D, Mu, IM, L.), CM *jike* (Tünk.), *jixe* (Khori.), *jige* (Ha.), *jeka* (Man.), *jih* (Khor.), *jexe* (Bur.), *jix* (ÖMon.), *ikə* (Kalm, Oir.), *ixə* (Kha.)

PM **ajaγa* 'аяга', AM *ayaγa* Precl. (= Jig, Bur.), MM *ayaγa* (MNT, Hy, Mu, IM.), *ayaqa* (D, Mu, L.), CM *ajağa* (Dag, Bur, Ord.), *ajɒğɒ* (Ha, Kha.), *ajağ* (Cha, Gor, Jal, Khor.), *ajig* (Üz, AKhor, Barin, Khar, Naim, Onn, Šgol, Tüm, Učab.)

PM **bajan* 'баян', AM *bayan* Precl. (= Hin, Taq, Sub.), MM *bayan* (MNt, Hy, Mu, IM.), CM *bajan* (Mngr, Dun, SY, Bao, Dag, Bur, ÖMon.), *bajɒŋ* (Alar, Kha, Kalm.), *bajin* (Kul, Dör, Zakh, Kha.), *bain* (But, Kul, AKhor, Gor, Onn.)

2.1.2.3 ХЭЛНИЙ ХОЙГУУРХИ ГИЙГҮҮЛЭГЧ

Хэлний хойгуурхи гийгүүлэгчийн онцлог шинжийн талаар алтайн хэл шинжилэл болон монгол хэл зүйн гол бүтээлүүдэд нилээд тодорхой тусхажээ.[735] Түүнчилэн хэлний хойгуурхи гийгүүлэгчийн эртний хувилбарууд, тэдгээрийн цаашдын хувьсал хөгжилийн талаар профессор N. Poppe, Sh. Hattori нарын нарийвчилсан судалгааны үгүүлэлүүд гарсан буй.[736]

---

[735] N. Poppe, Vergleichende Grammatik der altaischen Sprache. Teil I. Vergleichende Lautlehre, 16-20, 23-25, 53-62, 71-73; Б. Я.Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 386-395, 403-404; Г. Д. Санжеев, Грамматика бурят-монгольского языка, 8-10,13-20, 22-27, 33-36; N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 129-154, 170-171

[736] N. Poppe, On the Velar Stops in Intervocalic Position in Mongolian, UAJb. 31 (1959), 270-273; Sh. Hattori, The Length of Vowels in Proto Mongolian, *'Mongolian Studies'*, Budapest, 1970, 186-194 *idem.* Initial Plossives of Proto Mongolian and Their Later Development with Additional Remarks, SL. 3, 1972, 63-92

k (< *k, *q)

Хэлний хойгуур, хамжих, дуугүй ***k*** (< *k) нь ямагт эм эгшигтэй үгэнд, ***i*** (< *i)-гийн өмнөх ****q***-гаас үүссэн ***k*** нь эр эгшигт үгэнд тус тус ордог байжээ. Орчин үеийн олонхи монгол хэл аялгуунуудад уул гийгүүлэгч нь хэлэгдэх онцлог шинжээ ерөнхийдөө хадгалан үлдсэн боловч Буриад, Төв болон Өмнөд монгол хэлнүүдэд нилээд сугарч, ихэнхидээ шүргэх ***χ*** болсоноос гадна Монгор, Дунсян, Шар Ёгур хэлнүүдэд дуутай [g] хувилбартай болсон байна.

Жич: Дундад үеийн монгол хэлний зарим бичигийн дурсхалуудад эм эгшигт үгийн дуугүй хамжих ***k*** (< *k)-г дуугүй хамжих ***g***-гээр тэмдэглэсэн жишээ цөөнгүй байгаа бөгөөд тэдгээрийг бусад бичигийн дурсхалууд болон хэл аялгууны зохих үгтэй харьцуулан үзвэл тэр нь тухайн авианы зүй тогтолцоот хувьсалыг бодитой тусхасан хэрэг бус, харин хэл ярианы урсхалд гарсан түр зуурын шинжтэй хувилбар авиаг тусхасан байна.

	(a) k (< *k)		(b) k (< *q)	
PM	*k		*q	
AM	k		q	[q, k]
MM	k		q	[q, k]
Mngr.	k	[k, g]	k	[k, g]
Dun.	k		g	[g, q]
SY.	k	[k, g]	χ	[χ, g, k]
Mog.	k		q	
Dag.	k	[k, g]	k	[k, g]
Kalm.	k		k	
Oir.	k		k	
Bur.	χ		χ	[χ, š]
TMon.	χ	[χ, g]	χ	
ÖMon.	χ	[χ, g, k]	χ	[χ, k]

(a) PM **ken* ‘хэн’, AM *ken* Precl. (= Bod, Chang, Hin, Bur.), MM *ken* (MNT, KMQB, D, Mu, IM, L, Ist.), CM *ken* (Mngr, SY, Mog, Kalm, Oir, Ord, NÜd.), *keŋ* (Dag.), *kien* (Dun.), *kaŋ* (Bao.) // *χen* (Kul, Bur, TMon, ÖMon.)

PM **köke* ‘хөх’, AM *köke* Precl. (= Bod, Bur, Sub.), MM *köke* (MNT, Mu, IM, L, Ist.), *kökö* (MNT, Hy, Tk.), CM *kökə* (Kalm, Oir.), *koka* (Mog, Man, Mar.), *kökö* (NÜd, Tünk.), *kukə* (Dag.), *kuguo* (Mngr.), *kugie* (Dun.), *koge* (Bao.) // *χöχö* (Bur.) // *göχö* (Cha, Kesh, Naim, Onn, Sgol, Ord.)

PM **kümün / *kübün* ‘хүн’, AM *kümün* Precl. (= Bod, Chang, Jig, Hin.), MM *küwün* (Mu.), *kü'ün* (MNT, KMQB, Hy, Tk, D, Mu.), *kün* (Mu, IM, L.), CM *kümün* (Oir.), *kümən* (Kalm.), *kün* (Kalm.), *küŋ* (Dag, NÜd.), *kū* (Mngr, Dun, Bao, SY, Zir, Kun, Ha.) // *χün* (Bur, TMon, ÖMon.)

PM *eke* ‘эх’, AM *eke* Precl. (= Bod, Chang, Taq, Bur, Sub.), MM *eke* (MNT, KMQB, Hy, Mu, IM, L, Ist.), CM *ekə* (Kalm, Oir.), *ekie* (Dun.) // ege (Dag.) // *eχe* (Bur, Ord.), *eχə* (TMon, ÖMon.)

(b) PM **qïlγasun* ‘хилгас’, AM *kilγasun* [<*qïlγasun] (Mo.), MM *qilγasun* (Mu.), *kilγasun* (MNT), CM *qilγasun* (Mog.), *qelγasun* (Mar.) // *kilghasun* (Leech.), *kilğasun* (Dör.), *kilgɒsɒn* (Kalm, Tor.), *kilğašiŋ* (Zakh.), *kilğasu* (Ord.), *kilgäsän* (Ba, Dör, Kho.) // *χilğas* (Kha, AKhor, Barin, Khor.), *χalğasan* (SY.), *šilğāhan* (Alar, Bokh.)

PM **qïǰaγar* ‘хизгаар’, AM *qiǰaγār* (= Bod, Hin.), *qiǰiγār* (Jig.), *qiǰayār* (Sul.), *kiǰayār* (Bur, Sub.), MM *qiǰār* (Mu.), *kiǰa'ār* (MNT, Hy, Ph.), *kiǰār* (KMQB.), CM *kidžağār* (Ord.), *kidžğār* (Oir.), *kidžār* (Dag.), *kizār* (Kalm.) // *χidzğār* (Kha.), *χidzağār* (Gor.), *χizār* (Bur.), *χedžār* (Barin.), *χedğār* (Üz.) // *gidžiār* (Mngr.), *gedžār* (SY.), *ğudža* (Dun.)

PM **qïmulsun* ‘хумас’, AM *kimusun* [< *qïmulsun] Precl. (= Bur.), MM *qimusun* (Mu.), *kimusun* (Hy.), *kimul* (MNT), CM *qimsun* (Mog.), *qemsun* (Zir, Man, Mar.) // *χumusun* (Dör, Zakh, Kho.), *χumusu* (Ord.), *χumsɒn* (Kalm.), *χumas* (Kha.), *ghimsu* (Leech.), *ğumusun* (Dun.)

PM **salqin* ‘салхи’, AM *salki* [< *salqï] (Mo.), MM **salkin,* CM *salkin* (Zakh.), *sälkin* (Dör.), *salki* (Mngr.) // *salχin* (Ord.), *sälχin* (AKhor, Barin, Khar, Khor, Tüm.), *salχi* (Kha.), *halχi* (Bur.), *halšin* (Tünk.), *halšan* (Ekh-Bul.)

g (< *g)

96. Хэлний хойгуур, гүн бус угийн хамжих, дуутай ****g*** гийгүүлэгч нь гагцхүү эм эгшигт үгэнд тохиолдох бөгөөд олонхи хэл аялгуунд хэлэгдэх онцлог шинжээ хэвээр хадгалсаар иржээ. Гэвч уул ****g*** нь Монгор, Дагуур хэлэнд чанга гийгүүлэгчийн өмнө, Дунсян, Шар Ёгур хэлэнд ***e, i***-гийн өмнө дуугүй ***g*** болсоноос гадна Буриад хэлэнд тагнайн эгшигийн өмнө орохдоо тагнайшиж ***j*** болсон байна.

PM	*g	Mog.	g
AM	g	Dag.	g [g, k]
MM	g	Kalm.	g
Mngr.	g [g, k]	Oir.	g
Dun.	g [g, k]	Bur.	g [g, j]
Bao.	g	TMon.	g
SY.	g [g, k]	ÖMon.	g

PM **ger* ‘гэр’, AM *ger* Precl. (= Bod, Chang, Taq, Bur.), MM *ger* (MNT, KMQB, Hy, Mu, IM, L, Ist.), CM *ger* (Mngr, SY, Mog, Ha, Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.), *gié* (Dun.), *gir* (Ha.)

PM **görügesün* 'гөрөөс', AM *görügēsün* Precl. (= Bur, Sub.), MM *görü'ēsün* (MNT), *görö'ēd* (D.), *görēsün* (Mu, L.), CM *görēsən* (Kalm.), *gorasun* (Zir.), *görēs* (Oir.), *görős* (TMon, ÖMon.), *gürőhen* (Bur.) // *kuorose* (Mngr.)

PM **gedige* 'гэзэг' AM *geǰige* (Mo.), MM *geǰige* (MNT, Mu.), CM *gedige* (Dag.), *gedig* (Ha.), *geǰige* (SY, But, Ord.), *gedžig* (ÖMon.), *gedzeg* (Kha.), *gezege* (Bur.), *gidžigə* (Kalm.), *gidžig* (Oir.) // *kidžigi* (Dun.)

PM **ergi* 'эрэг', AM *ergi* Precl. (= Bur, Sub.), MM *ergi* (MNT, Hy.), *erge* (IM.), CM *ergi* (Ha.), *ergə* (Kalm, Oir.), *erge* (Ord.), *ereg* (TMon, ÖMon.), *erig* (Dör, Zakh, Ö, Tor, Ur.) // *erje* (Bur.)

q (< *q)

Хэлний хойгуур, гүн угийн хамжих, дуугүй ****q*** гийгүүлэгч нь өдгөө зөвхөн могол хэлэнд хэвээр үлдсэн бөгөөд бусад хэл аялгуунуудад авианы орчиноосоо шалтгаалан хэд хэдэн өөр хувилбартай болжээ. Тэдгээрийн хамагийн гол ялгаа нь тагнайн ****i***-гийн өмнө орсон эсэхтэй шууд холбоотой юм.

(a) i (<*i)-гийн өмнө орсон

PM	*q
AM	q [q, k]
MM	q[q, k]
Mngr.	tš [tš, d, g]
Dun.	g [g, q]
Bao.	h [h, g]
SY.	χ [χ, k, g]
Mog.	q
Dag.	k [k, g
Kalm.	k
Oir.	k
Bur.	χ [χ, š]
TMon.	χ
ÖMon.	χ[χ, k]

(b) Бусад эгшигийн өмнө

*q
q
q
χ [χ, g]
q [q, g]
χ
χ [χ, g]
q
χ [χ, g, k]
χ
χ
χ
χ [χ, g]
χ [χ, g]

(a) ***i*** (< *i)-гийн өмнө орсон хамжих ****q*** гийгүүлэгч нь арынхаа эгшигийн нөлөөгөөр тагнайшиж Дагуур, Халимаг, Ойрд хэлнүүд болон Ордосын аман аялгуунд ***k***, хамжин шүргэх ***tš***, ***dž***, Буриад хэлний зарим аман аялгуунд (= Алар, Бохан г.м.) тагнайн шүргэх ***š*** болсон байна. Бусад хэл аялгуунуудад уул гийгүүлэгч нь тагнайшихаасаа өмнө суларч их төлөв шүргэх ***χ***, ***g*** болжээ.

PM **qïtuγa* 'хутага', AM *kituγa* [< *qïtuγa] (Mo.), MM *qïtuγa* (Mu.), *kituqai* (MNT), *kituγa* (IM, L.), CM *qitqei* (Mog.), *qetγai* (Man, Mar.), *qutaγa* (SY.), *qutogo* (Dun.) // *kitoğo* (NÜd.) // *χutağa* (Bur, TMon.), *χutag* (AKhor, Barin, Gor, Dör, Jal,

Khor, Urad.) // *ğutağ* (Cha, Naim, Onn, Sgol, Kha.), *tšidoğuo* (Mngr.), *tšitoğo* (Min.) // *utɒğɒ* (Kalm.), *utağa* (Kha, Ord.), *utğɒ* (Ba, Dör, Kho.), *utχɒ* (Tor.)

PM **qïmulsun* 'хумас', AM *kimusun* [< *qïmulsun] (Mo.), MM *qïmusun* (Mu.), *qimusu* (Mu.), *kimul* (MNT), *kimusu* (MNT), *kimusun* (Hy.), CM *qimsun* (Mog.), *qemsun* (Man, Mar, Zir.) // *kimitš* (Ha.), *kimetši* (But.), *kimtši* (Kul.), *kumuhun* (NÜd.) // *χumusun* (Dör, Zakh, Kho.), *χumusu* (Ord.), *χumsɒn* (Kalm.), *χumas* (Kha.) // *ghimsu* (Leech.), *ğumusun* (Dun.), *ğomson* (Bao.) // *tšimudze* (Mngr.), *tšimese* (Min.)

PM **taqïya* 'тахиа', AM *takiyā* [< *taqïγān] (Mo.), MM *takiyā* (MNT, Hy, Ph.), *taqiyā* (L.), *taqi'ā* (Mu.), *daqā* (Tk.), *takān* (Kalm.), *takā* (Oir.), *tika* (Dun.) // *taχjā* (Bur.), *taχǐā* (Kha.), *teχā* (AKhor, Barin, Gor, Jal, Khor.), *deχā* (Naim, Onn, Kesh.), *daχā* (Cha, Ord, Šgol.) // *tağū* (Mngr.), *tasjā* (Bokh.)

PM **saqï-* 'сахи-', AM *saki-* [< saqï-] Precl. (= Jig, Bur.), *saqi-* (Hin, Taq, Maha.), MM *saqi-* (D, Mu.), *saki-* (KMQB.), CM *saki-* (Ord.), *sakɒ-* (Oir.), *sakǐ-* (Kalm.) // *saχi-* (Bur.), *saχǐ-* (Kha.), *sėχa-* (AKhor, Barin.) // *sagi-* (Dun, Mngr.), *sagǐ-* (Ha.), *sage-* (Bao.), *sāge-* (SY.)

(b) ***i*** (<*i)-гээс бусад эгшигийн өмнө орсон хамжих ***q*** нь Могол, Дунсянаас бусад хэлнүүдэд суларч шүргэх ***χ*** болсон бөгөөд тэдгээр нь Монгор, Дунсян, Дагуур, Төв болон Өмнөд монгол хэлнүүдэд мөн шүргэх ***ğ*** хувилбартай болжээ.

PM **qatun* 'хатан', AM *qatun* Precl. (= Bod, Bur.), MM *qatun* (MNT, L.), *qatud* (KMQB.), *χatun* (Mu.), CM *qotun* (Mog.), *χatun* (Mar.), *khatun* (Leech.), *katun* (Dag.) // *χatan* (Bur, TMon, ÖMon.), *χatɒn* (Kalm.) // *ğatun* (Ord.), *ğatan* (Cha, Šgol.), *ğaten* (SY.)

PM **qotan* 'хот', AM *qotan* Precl. (= Bur, Sub.), MM *qotan* (Mu.), *qoton* (MNT, KMQB.), CM *qudoŋ* (Dun.), *koton* (Kul, But.), *kudu* (Mngr.) // *χotɒn* (Kalm.), *χotɒ* (Oir.), *χoton* (Dag.), *χotoŋ* (Ha.), *χoto* (Bur.), *χotŏ* (Kha.), *χot* (AKhor, Barin, Jal, Khar, Khor, Tüm, Učab.) // *ğoto* (Ord.), *ğot* (Cha, Kesh, Naim, Onn, Šgol.)

PM **qudal* 'худал', AM *qudal* Precl. (= Ar. 2, Sub.), MM *qudal* (MNT, D, Mu, IM, L.), CM *qudōl* (Mog.), *qudal* (Man, Mar.), *qudol* (Her.), *qudāl* (Zir, KT.), *χudal* (Bur, TMon, ÖMon.), *χudɒl* (Kalm, Ö, Zakh, Tor, Ur.), *χudŭl* (Ba, Dör, Kho.) // *ğudal* (Mngr, SY.), *gutaŋ* (Dun.)

PM **saqal* 'сахал', AM *saqal* Precl. (= Bur.), MM *saqal* (MNT, Hy, Mu, IM, L, Ist.), CM *saχal* (Oir, TMon, ÖMon.), *saχɒl* (Kalm.), *haχal* (Bur.) // *sağal* (Mngr, SY, Mog, Dag.), *sağaŋ* (Dun.), *saghal* (Leech.)

γ (< *γ)

Хэлний хойгуурхи, гүн угийн хамжих, дуутай ***γ*** гийгүүлэгч нь орчин үеийн монгол хэл аялгуунуудад хэлэгдэх байдалаа тогтвортой хадгалсаар иржээ. Монгол хэлний урт удаан хөгжилийн явцад ***i*** (< *ï)-гийн өмнө орсон ***γ*** нь арынхаа эгшигийн нөлөөгөөр урагшилан гүн бус угийн ***g*** болсон бөгөөд Монгор, Буриад хэлний зарим аялгуунд тэр нь бүр тагнайшиж ***tš, j*** болсон байна.

Жич: Үүсмэл урт эгшигийнөмнө орж байсан ***γ/g*** нь дундад үеийн монгол хэлний үед арынхаа эгшигийн нөлөөгөөр суларан сулрсаар яваандаа бүрмөсөн сугарсан бөгөөд энэ талаар хойно тусхайлан дурдах болно.

PM	*γ	Mog.	γ [γ, q]
AM	γ	Dag.	g [ğ, g]
MM	γ [γ, q]	Kalm.	g [ğ, g]
Mngr.	γ [g, tš]	Oir.	g [ğ, g]
Dun.	g [g, q]	Bur.	g [ğ, g, j]
Bao.	g [g, χ]	TMon.	g [ğ, g]
SY.	g	ÖMon.	g [ğ, g]

PM **γar* ‘гар’, AM *γar* Precl. (= Maha, Alt, Bur, Sub.), MM *γar* (MNT, Hy, Mu.), *qar* (Mu, IM, L, Ist.), CM *ğar* (Mngr, Mog, Kalm, Oir, Bur, TMon, ÖMon.), *ghar* (Leech.), *ğar* (SY.), *ğari* (Dag.) // *χar* (Bao.), qa (Dun.)

PM **γurban* ‘гурван’, AM *γurban* Precl. (= Bod, Čin, Hin, Sul, Bur.), MM *γurban* (MNT, Hy, Mu, L.), *qurban* (D, IM, Mu, L.), CM *ğurbōn* (Mog.), *ğurbān* (Zir.), *ğurban* (Man, Mar.), *ğurban* (SY.), *ğurwaŋ* (Dun.), *ğurban* (Bur.), *ğurwan* (TMon, ÖMon.), *ğurwŭn* (Ba, Dör, Kho.), *ğuarba* (Ha.), *ğurān* (Mngr.), *ğoraŋ* (Bao.), *ğurwɒn* (Kalm, Tor.) // *qurban* (Her.)

PM **mïŋγan* ‘минган’, AM *miŋγan* Precl. (= Bod, Chang, Hin, Jig.), MM *minγan* (MNT, Hy, Tk, IM.), *minqan* (Mu, L, Ist.), *miŋqan* (D.), *manqan* (L.), CM *miŋğan* (Mngr, Bur, Ord, Cha, Sgol, Učab.), *miŋğɒn* (Kalm.), *miŋğa* (Zakh.), *miŋğa* (Kha.), *menğan* (Dör, Kho, Ur.), *menğan* (SY.), *meŋğa* (Üz.), *meŋğan* (AKhor, Barin, Gor, Jal, Khar, Khor, Tüm.)

PM **bulaγ* ‘булаг’, AM *bulaγ* Precl. (= Sub.), MM *bulaγ* (MNT, Hy, Mu, Ist.), CM *bulag* (Mngr, SY, Bur, TMon, ÖMon.), *bulɒg* (Kalm.), *bolog* (Khar, Tüm.), *bulār* (Dag.), *bula* (Dun.)

PM **ǰalγi-* ‘залги-’ AM *ǰalgi-* Precl. (= Bur.), MM *ǰalgi-* (MNT), *ǰalγi-* (Mu.), CM *džalgi-* (Ord, Cha, Učab.), *džalgĭ-* (Ha.), *dželgi-* (ÖMon.), *dzalgi-* (Ba, Dör, Kho.), *dzalgi-* (Bur.), *zalgĭ-* (Kalm.), *tšiärgi-* (Mngr.), *zalja-* (Alar.)

n (< *n)

Хэлний хойгуурхи, хамарын ***n*** гийгүүлэгч нь уулаас гагцхүү үеийн эцэст тохиолддог бөгөөд өдгөөгийн монгол хэл аялгуунуудад хэлний хойгуур хэлэгдэх шинжээ хадгалсаар иржээ.

Жич: Орчин үеийн Дунсян, Баоань, Дагуур, Буриад, Төв Монгол зэрэг нилээд хэлнүүдэд уулаас хэлний үзүүрийн ***n*** гийгүүлэгчээр төгөссөн үгс нь хэл зүйн тодорхой нөхцөлөөр хэлбэржээгүй байхдаа /= өөрөөр хэлбэл, зөвхөн нэрлэх тийн ялгалын нууц нөхцөлөөр хэлбэржсэн нэр үг болон хамжсан тододхол/ хэлний хойгуур хэлэгдэх боловч хэл зүйн тодорхой харьцаанд орохдоо хэлний үзүүрээр хэлэгддэг байна. Ийнхүү хэл зүйн зарим харьцаанд түр зуурын шинжтэй тохиолддог хойшилсон гийгүүлэг-чийг уулаас хэлний хойгуур хэлэгддэг ***n***-тэй адилдхан үзэх аргагүй юм.

PM	*ŋ	Mog.	ŋ
AM	ŋ	Dag.	ŋ[ŋ, n]
MM	ŋ[ŋ, n]	Kalm.	ŋ
Mngr.	ŋ	Oir.	ŋ
Dun.	ŋ	Bur.	ŋ[ŋ, n]
Bao.	ŋ	TMon.	ŋ[ŋ, n]
SY.	ŋ	ÖMon.	ŋ

PM *ǰobalaŋ ‘зовлон’, AM ǰobalaŋ Precl. (= Bod, Bur, Sub.), MM ǰobolaŋ (MNT, KMQB.), ǰobalan (Mu, IM.), CM džowoloŋ (Ord.), džowŏlŏŋ (Ha, Üz.), džowloŋ (ÖMon.), zoboloŋ (Bur.), dzowloŋ (Kha.), dzowlan (Ba, Dör, Kho.), zowlun (Zakh, Ö, Tor, Ur.)

PM *siŋgen ‘шингэн’, AM siŋgen (Mo.), MM šiŋgen /= šiŋge- MNT, Mu./, CM šiŋgen (Mngr, TMon, ÖMon. /= Cha, Ord, Sgol, Učab./), šiŋgən (Ha.), šiŋen (AKhor, Jal, Gor, Khor.), šeŋgen (SY, Bur.), šiŋgōn (Mog.), šiŋgon (Bao.), šiŋgen (Dag, Kha.), šeŋgien (Dun.)

PM *qaraŋγui ‘харанхуй’, AM qaraŋγui Precl. (= Bur, Sub.), MM qaraŋγui (MNT), qaranqu (Mu.), CM qaraŋğui (Mog.), χaraŋğui (Kha.), χarɒŋğui (Ha.), χaraŋğū (ÖMon.), χaraŋğū (Kalm, Ö, Tor, Ur, Zakh.), χaraŋχū (Ba, Dör, Kho.)

PM *aŋqan ‘анх’, AM aŋqa Precl. (= Chang, Hin, Bur, Sub.), MM aŋqa (MNT, Mu.), CM aŋχan (Bur.), aŋχa (Ord.), aŋχɒ (Kha.), aŋχɒn (Kalm.), ān (Mngr.)

2.2 ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ БАЙР

§ 91. **Гийгүүлэгч авианы байрын судалгааны тойм**. Монгол хэлний гийгүүлэгчийн байрын асуудалыг монгол хэл зүйчид лавтайяа XIII-XIV зууны үеэс нааш нарийвчилан боловсруулсаар иржээ. Уламжилалт хэл шинжилэлд бичигийн хэлний бүх гийгүүлэгчийг *‘дэвэсхэрлэх үсэг’, ‘эс дэвэсхэрлэх үсэг’* гэж ангилсан нь

гийгүүлэгч-гийгүүлэгч, гийгүүлэгч-эгшигийн байрлалын тухай асуудал юм. Тодоруулан хэлбэл, гийгүүлэгчээр эхэлсэн тэргүүн бус үеийн өмнөх үеийг хааж орсон арван нэгэн гийгүүлэгч (b, γ/g, d, l, m, n, ï, r, s, w, y)-ийг *'дэвэсхэрлэх үсэг'* гэж нэрлэсэн бөгөөд тэдгээр нь үеийн заагт өөр гийгүүлэгчийн өмнө орж чаддаг байна. Гэтэл *'эс дэвэсхэрлэх үсэг'*-т багтах бусад гийгүүлэгч нь хэзээ ч өөр гийгүүлэгчийн өмнө тохиолддоггүй, гагцхүү үеийн эхэнд эгшигийн өмнө ордог байна. Мөн эр эгшигт үгэнд ордог *'дэвэсхэр үсэг'*-ийг *'чанга дэвэсхэр'*, эм эгшигт үгэнд ордог *'дэвэсхэр үсэг'*-ийг *'хөндий дэвэсхэр'* гэж ангилсан нь тухайн гийгүүлэгчийн зөөлөрсөн, эс зөөлөрсөн байдалыг тусхасан артикуляцийн хуваарь юм. Түүнчилэн *'дэвэсхэр үсэг'*-ийг бас *'хатуу дэвэсхэр'* (b, γ, r, s, d), *'зөөлөн дэвэсхэр'* (l, m, n, ŋ, g, y, w) гэж хуваасан нь үг, морфемуудын зааг дахь авианууд, тухайлвал, үгийн эцэсийн гийгүүлэгч болон түүний дараа шууд орох залгавар морфемийн эхний гийгүүлэгчийн байрыг нарийвчилан тогтоосон ангилал ажээ. Энэхүү *'дэвэсхэр үсэг'*-ийн дүрэмийг орчин үеийн монгол хэлний гийгүүлэгчийн байрын талаас авч үзвэл, гагцхүү хагас эгшигийн шинжтэй ***y, w***-гээс бусад нь одоо ч үеийн заагт, өөр гийгүүлэгчийн өмнө тохиолддог байрлалаа тогтвортой хадгалсаар байна.

Монгол хэлний гийгүүлэгчийн байртай холбогдох ажиглалт, судалгааг европ зүгийн эрдэмтэд бүр XIX зууны дунд үеэс эхлэн хийжээ. Тэд юуны өмнө монгол бичигийн хэлний ***γ, q*** болон ***g, k***-гийн ялгааг олж ажигласан байна. Хожим акад. Б. Я. Владимирцов халхын аман аялгууны хэлний хойгуур хамжих ***χ, g*** болон хэлний урдуур хамжих ***x, k***-гийн ялгааг бичигийн хэлний ***γ/g, q/k***-гийн хувьсалтай нягт холбон тайлбарлаж, уламаар тэдгээрийн байрыг эгшигийн зохьцолтой холбон авч үзсэн байна.[737] Түүний дараа профессор Г. Д. Санжеев гийгүүлэгчийн байрын тухай судалгааны хүрээг өргөжүүлэн монгол бичигийн хэл хийгээд зарим хэл аялгууны гийгүүлэгчийн тохиолдох байрыг харьцуулан гаргажээ.[738] Мөн тэрвээр хожим нийтлүүлсэн *'Хуучин монгол бичигийн хэл'* гэдэг номдоо бичигийн хэлний бүх гийгүүлэгчийг эгшигийн өмнө тохиолддог эсэхээр нь хоёр хэсэг болгон ангилжээ. Энэ нь угтаа уламжилалд хэл шинжилэлд нарийн боловсоруулсан *'дэвэсхэрлэх ёс'*-ыг орчин үеийн хэл шинжилэлийн үүднээс авч үзсэн хэрэг юм.[739]

Мөн түүнчилэн профессор N. Poppe, И. Д. Бураев зэрэг эрдэмтэд хэл зүйн бүтээлүүддээ төв монгол, буриад хэлний гийгүүлэгчийн байрыг нилээд нарийвчилан гаргасан байна.[740]

Орчин цагийн монгол хэлний гийгүүлэгчийн байрын талаар акад. Ш. Лувсанвандан анхааран судалж хэд хэдэн бүтээлдээ тодорхой дурджээ. Тэрвээр

---

737 Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 123-125

738 Г. Д. Санжеев, Грамматика бурят-монгольского языка, 89-90

739 Г. Д. Санжеев, Старо-письменный монгольский язык, 44

740 N. Poppe, Buriat Grammar {= UAS 2}, Bloomington, Indiana, 1960, 15-18; Mongolian Language Handbook {= Center for Applied Linguistics}, Washington, 1970, 52-54; Грамматика бурятского языка. Фонетика и морфология, М., 1962,43-45

орчин цагийн монгол хэлний гийгүүлэгч-гийгүүлэгч, гийгүүлэгч-эгшигийн байрыг нарийвчилан тогтоосоноос[741] гадна уламжилалт хэл шинжилэл дэх *'дэвэсхэр усэг'*-ийн дүрэмд тулгуурлан гийгүүлэгчийн байрыг дөрвөн зүйлээр дүрэмчилэн тогтоожээ.[742] Үүнд:

1. Үе төгөсгөх гийгүүлэгчийн дараа үе үл төгөсгөх гийгүүлэгч шууд залган орж болно.

2. Үе үл төгөсгөх гийгүүлэгчийн дараа үе төгөсгөх гийгүүлэгч шууд залган орж болохгүй.

3. Үе төгөсгөх гийгүүлэгчийн дараа мөн үе төгөсгөх гийгүүлэгч (ардаа эгшиггүйгээр) шууд залган орж болохгүй.

4. Үе үл төгөсөгөх гийгүүлэгчийн дараа мөн үе үл төгөсгөх гийгүүлэгч шууд залган орж болохгүй.

Монгол бичигийн хэлний гийгүүлэгчийн байр буюу дэвэсхэр үсэгийн талаар Өвөр Монголын их сургуулийн профессор Жалсан, Чойжинжав нарын тусхай үгүүлэлүүд нийтлэгджээ.[743]

Эгшиг авианы суларалын тухай товч тэмдэглэл. Монгол хэлний үгийн бүтэцэн дэх авианы байрлалыг ерөнхийд нь ажиглавал, гийгүүлэгч, эгшиг салаавчилан ордог нийтлэг зүй тогтолцоотой билээ. Өөрөөр хэлбэл, үгийн дотоод бүтэц болон морфемуудын харьцаанд хоёр эгшиг, хоёр гийгүүлэгч дараалан ордоггүй, хэрэв ороход хүрвэл эгшиг нь гийгүүлэгчээ, гийгүүлэгч нь эгшигээ зааглаж байдаг нарийн зүй тогтолтой ажээ. Харин зөвхөн үгийн бүтэцэн дэх хоёр үеийн зааг болон язгуур-дагавар, үндэс-нөхцөлийн заагт тодорхой тооны гийгүүлэгч, тодорхой тогтсон байрлалд хиллэн орох тохиолдол байдаг байна. Тийм учираас гийгүүлэгчийн байрын тухай авч ярихдаа гийгүүлэгч-эгшигийн байр, гийгүүлэгч-гийгүүлэгчийн байр гэж ялган үзвэл зохино.

2.2.1 **ГИЙГҮҮЛЭГЧ-ЭГШИГИЙН БАЙР**

§ 92. **Гийгүүлэгч-эгшигийн байр.** Монгол хэлний гийгүүлэгч-эгшиг нь авианы харилцан бие биедээ нөлөөлөх хуулийн хүрээнд тодорхой тогтсон байранд тохиолддог байна. Өөрөөр хэлбэл, гийгүүлэгч, эгшигийн аль аль нь ямар ч байранд чөлөөтэй дараалан орж болдоггүй ажээ. Гийгүүлэгч-эгшигийн байрлалыг зохьцуулагч гол төв нь юуны өмнө тухайн гийгүүлэгчийн авианы орчин нь болж

---

741 Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Авиа, авиалбар хоёр нь, 92-95; Монгол хэлний халх аман аялгууны чанга, сул гийгүүлэгчийн зарим онцлог, МС 3, 1961, 21-52

742 Ш. Лувсанвандан, Эртний монгол хэлний фонемийн систем, МС 5, 1965, 3-47

743 Жалсан, Mongγol kelen-ü «*dabqur debisker*» gegči-yin učir, ÖMYS 3, 1991, 1-13; Чойжинжав, Mongγol bičig-ün kelen-ü debisker, Kökeqota, 2016, 1-124

байгаа зэрэгэлдээх эгшигүүд юм. Тодоруулан хэлбэл, зарим гийгүүлэгч эр эгшигийн орчинд, нөгөө зарим нь эм эгшиг болон тагнайн эгшигийн орчинд тохиолддог тодорхой зохьцолтой байдаг байна. Үүнээс үзвэл, гийгүүлэгч-эгшигийн байрлал нь авианы хүчдэл дээр тулгуурласан артикуляцийн шинжтэй дараалал юм. Ийнхүү эгшигийн шинжээс гийгүүлэгчийн байр шалтгаалдаг өвөрмөц ёсыг монгол хэл зүйчид бүр эртнээс танин мэдээд, эр эгшигт үгэнд ордог гийгүүлэгчийг *'чанга'*, эм эгшигт үгэнд ордог гийгүүлэгчийг *'хөндий'* хэмээн ялган нэрлэсээр иржээ.

Ер монгол хэлний нийт гийгүүлэгч фонемийн дотороос гагцхүү **γ, *q, *g, *k* дөрөв нь тухайн үгийнхээ эгшигтэй эр, эмээр нь ялган зохьцдог онцлогтой байсан учир тэдгээрийг уул онцлогийнх нь дагуу доор дурдсан хоёр ангилалд хуваан үзэж болно.

А. Эр эгшигт үгэнд ордог **q, *γ*-гийн байр

Хэлний гүн угийн хамжих **q, *γ* гийгүүлэгч нь зөвхөн хэлний хойгуурхи **a, *ï, *o, *u* эгшиг бүхий үгэнд тохиолддог бөгөөд **q* нь ямагт тухайн үеийнхээ эхэнд (эгшигийн өмнө), **γ* нь эгшигийнхээ аль ч талд ордог байжээ. Гэхдээ **q, *γ*-гийн аль аль нь тухайн үеийнхээ эгшигийн өмнө, өмнөх задгай үеийнхээ эгшигийн дараа, өөрөөр хэлбэл, хоёр үеийн заагт эгшигийн хооронд тохиолдож болдог байна. Хэлний хөгжилийн цаашдын явцад авианы орчиноосоо шалтгаалан дурдсан гийгүүлэгчидийн хэлэгдэх байдалд зохих хувьсал гарч, заримдаа бүрмөсөн суларан сугарахад ч хүрчээ.

РМ	*q *γ	*qaγan *γar	*qïlbar *ǰalγï-
АМ	q [q] [k] (i-гийн өмнө)	qaγān (Bod.)	qïlbar (Bod.) kilbar (Sub.)
	γ[γ] [g] (i-гийн өмнө)	γar (Maha.)	ǰalgi- (Bur.)
ММ	q[q] [k] (i-гийн өмнө)	qahān (MNT)	qïlbar (Mu.) kilbar (MNT)
	γ[γ] [g] (i-гийн өмнө)	γar (Mu.)	ǰalgi- (Mu.)
СМ	x[q, χ] [k, χ] (i-гийн өмнө)	χāŋ (Oir, Bur.)	kilbar (Oir.) χilbar (Kha.)
	g[ğ] [g] (үеийн эцэст)	ğar (Oir, Bur.)	dzalgi- (Kha.)

В. Эм эгшигт ордог **k, *g*-гийн байр

Хэлний гүн бус угийн хамжих ****k***, ****g*** гийгүүлэгч нь зөвхөн хэлний урдуурхи ****e***, ****i***, ****ö***, ****ü*** эгшиг бүхий үгэнд тохиолдох бөгөөд ****k*** нь ямагт тухайн үеийнхээ эхэнд (эгшигийн өмнө), ****g*** нь эгшигийнхээ аль ч талд орж болдог байна. Гэхдээ ****k***, ****g***-гийн аль аль нь хоёр үеийн заагт эгшигийн хооронд тохиолдож болно.

PM	*k *g	*kelen *ger	*kündü *gedige
AM	k g	kelen (Bod.) ger (Bod.)	kündü (Hin.) geǰige (Mo.)
MM	k g	kelen (MNT, Mu.) ger (MNT, Mu.)	kündü (MNT, Mu.) geǰige (MNT, Mu.)
CM	k [k] [χ]	kelən (Kalm, Oir.) χele (Bur, TMon.)	kündü (Oir.) χündə (TMon.)
	g	ger (Oir, Bur, TMon)	gedzeg (TMon.)

Жич: Дээр дурдсан дөрвөн гийгүүлэгчээс бусад нь эр, эм эгшигт үгийн алинд ч, эгшигийн өмнө, хойно, мөн хоёр эгшигийн хооронд ч орж чадна. Харин сул шүргэх ***h***, уруулын шүргэх ****f*** нь ямагт үгийн эхэнд, хэлний хойгуурхи ***ŋ*** нь гагцхүү үеийн эцэст тохиолдоно. Мөн ***l***, ***r*** хоёр нь жинхэнэ монгол үгийн эхэнд орохгүй, харин үгийн тэргүүн бус үед эгшигийн өмнө ч, хойно ч орж болдог.

Монгол хэлний гийгүүлэгч-эгшигийн байрын тухай асуудалыг авч үзэхдээ эр, эм эгшигт үгэнд зохьцон ордог онцлог шинжээс нь гадна үеийн дотор эгшигийн өмнө, хойно орох байдалаар нь ялган үзэж болно. Ер монгол хэлний нийт гийгүүлэгч фонемийн дотороос зөвхөн цөөн хэд нь үеийн дотор тогтвортой байранд тохиолддог бөгөөд тэдгээрийг зохих байрынх нь дагуу дор дурдсан хоёр ангилалд хуваан үзэж болно.

А. Үеийн эхэнд (эгшигийн өмнө) ордог гийгүүлэгч

Монгол хэлний гийгүүлэгч фонемуудын дотороос ****f***, ****t***, ****č***, ****ǰ***, ****q***, ****k*** нь үеийн эцэст огт тохиолддоггүй, гагцхүү үеийн эхэнд ордог бөгөөд тэдгээрээс ***h*** (< *f) нь ганцаараа зөвхөн үгийн эхэнд тохиолддог байжээ. Орчин үеийн зарим хэл аялгуунд уламжилан үлдсэн шүргэх гийгүүлэгч (= f, χ, h) ч мөн гагцхүү үгийн эхэнд тохиолдож байна.

		1	2	3	4	5	6
1	PM	*φ	*t	*č	*ǰ	*q	*k
2	AM	*χ	t	č	ǰ	q [q] [k]	k
3	MM	h [h] [o]	t	č	ǰ	q [q] [k]	
4	CM	h [h] [o]	t	č [tš] [ts]	ǰ[dž] [dz]	x [χ] [q]	k [k] [χ]

1:1 *feligen
2:1 *χeligen
3:1 heligen (MNT, IM.)
4:1 helegen (SY) /elegen/(Bur.)

1:2 *tata-
2:2 tata- (Jig, Bur.)
3:2 tata- (MNT, D, Mu.)
4:2 tata- (Bur, Ord.)

1:3 *čerig
2:3 čerig (Hin, Chang.)
3:3 čerig (MNT, D, Mu.)
4:3 tširеg (ÖMon.) /tsereg (Kha.)

1:4 *ǰobalaŋ
2:4 ǰobalaŋ (Bod,Bur.)
3:4 ǰobalaŋ (Mu, IM.)
4:4 džowoloŋ (Ord.)

1:5 *qara
2:5 qara (Hin, Bur.)
3:5 qara (MNT, Mu, IM.)
4:5 qara (Mog.) /χara/(Bur.)

1:6 *köke
2:6 köke (Bod, Bur, Sub.)
3:6 köke (MNT, Mu)
4:6 kökə (Oir)

В. Үеийн эцэст (эгшигийн дараа) ордог гийгүүлэгч

Монгол хэлний нийт гийгүүлэгч фонемийн дотороос ганцхан ***ŋ*** гийгүүлэгч л үеийн эхэнд хэзээ ч ордоггүй, гагцхүү үеийн эцэст, эгшигийн дараа тохиолддог байна.

PM	*aŋqa	*maŋlaj
AM	aŋqa (Chang, Bur.)	maŋlai (Bod, Chang.)
MM	aŋqa (MNT)	maŋlai (MNT, Hy, Mu.)
CM	aŋχɐ (Bur, TMon.)	maŋnā (Oir.)

Жич: Дээр дурдсанаас бусад бүх гийгүүлэгч, тухайлвал, ***b, m, d, s, š, y, γ, g, l, r, n*** нь үеийн эхэнд ч, эцэст ч тохиолдоно. Харин хэлний хөгжилийн явцад үгийн эцэсийн ***y*** гийгүүлэгчийн эгшигийн шинж давамгайлан тагнайн ***i*** болсон тул тэр нь цаашдаа зөвхөн үеийн эхэнд тохиолдох болжээ.

2.2.2 ГИЙГҮҮЛЭГЧ-ГИЙГҮҮЛЭГЧИЙН БАЙР

§ 93. **Гийгүүлэгч-гийгүүлэгчийн байр**. Монгол хэлний гийгүүлэгч авианы байрын тухай асуудал нь хоёр үеийн заагт дараалан орох гийгүүлэгчийн тухай асуудал юм. Тийнхүү үеийн заагт тохиолдох гийгүүлэгчийн байрыг тогтоохын тул юуны өмнө үе төгөсгөх, үе эхлэх гийгүүлэгчидийг ялган тогтоох ёстой бөгөөд түүнийг монгол хэл зүйчид бүр XIII-XIV зууны үеэс эхлэн боловсоруулжээ. Тухайлвал, үеийн зааг дахь гийгүүлэгчийн байрлалыг *'дэвэсхэрлэх ёс'*хэмээн нэрлэдэг тухай өмнө дурдсан билээ. Ер *'дэвэсхэр үсэг'* гэдэг нь зөвхөн үе төгөсгөх гийгүүлэгч юм. Харин *'дэвэсхэрлэх ёс'* гэдэг нь үе эхлэх гийгүүлэгчийн өмнө үе төгөсгөх гийгүүлэгч тохиолдохыг хэлнэ. Өөрөөр хэлвэл, үе төгөсгөх гийгүүлэгч, үе эхлэх гийгүүлэгч хоёр үеийн заагт дараалан орж байгаа хэрэг юм. Гийгүүлэгчийн байрын талаар судалсан зарим нэг судалгаа бий боловч монгол хэлний хөгжилийн өөр өөр үе шатан дахь гийгүүлэгчийн байрыг цуваа цагийн үүднээс харьцуулсан судалгаа энэ хэр гараагүй байна.

Энд бид юуны өмнө үе төгөсгөх болон үе эхлэх гийгүүлэгчид үеийн заагт дараалан орох бүх боломжийг бүрдхэн тэмдэглэж, уламаар эртний ба дундад үеийн монгол хэлний онцлогийг тусхасан бичигийн дурсхалууд хийгээд орчин үеийн зарим хэл аялгуунууд, ялангуяа, Төв монгол хэлний жишээнүүдийг харьцуулан гаргахыг зорив.

Үе төгөсгөх гийгүүлэгч		Үе эхлэх гийгүүлэгч													
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
		b	γ/g	r	s	d	l	m	n	š	t	č	ǰ	q	k
1	b				+	+	+			+	+			+	+
2	γ/g	+			+	+	+			+	+	+	+	+	+
3	r	+	+		+	+	+			+	+	+	+	+	+
4	s	+	+			+	+				+	+		+	+
5	d	+			+		+				+	+		+	+
6	l	+	+		+	+		+			+	+	+	+	+
7	m	+	+		+	+	+		+	+	+	+	+	+	+
8	n				+	+	+				+	+			
9	ŋ		+		+		+			+	+	+	+	+	+
10	š		+				+				+				+

AM	MM	CM
1:4 /bs/:		
ǰabsar (Bur.)	ǰabsar (Hy, Mu.)	zabsar(Bur.) // dzawsar (Kha.)
debse- (Bur.)	debse- (Mu.)	dewse- (Kha.)
1:5 /bd/:		
ebde- (Bod.)	ebde- (Bod.)	ebde- (Bur.) // ewde- (Kha.)
ǰabdu- (Bod.)	ǰabda-	zabda- Bur.) // zawdɒ- (Kha.)
1:6 /bl/:		
abliγa (Tuγ.1)	abliγa (MNT)	awilağa (Kha.)
ǰöble- (Bur.)	ǰöble- (Mu.)	züble- (Bur.) // dzöwöl(Kha.)
1:9 /bš/:		
ǰöbšiye- (Ar.1)	ǰöbšiye- (MNT)	zübšō̆-(Bur. // dzöwšō̆r(Kha.)
tübšin (CTB)	tübšin (MNT)	tübšen(Bur.) // tüwšin (Kha.)
1:10/bt/:		
dabta- (Bur.)	dabta- (MNT)	dabta- (Bur.) // dawta- (Kha.)
kebte- (Sul.)	kebte- (MNT)	χebte- (Bur.) // χewte- (Kha.)
1:11/bč/:		
nabčin (Qqor.)	nabčin (Hy.)	nabtši // nawtši (Kha.)
tebči- (Turf.)	tebči- (Mu.)	tebtši- // tewtši- (Kha.)
1:13/bq/:		
dabqur (Qqor.)	dabqur (MNT)	dabχar(Bur.) // dawχar(Kha.)
ǰabqa- (Bur.)	ǰabqa- (MNT)	zabχar-(Bur.) // dzawχar (Kh.)
1:14/bk/:		
ebke- (Mo.)	ebke- (Hy.)	ewkə- (Oir.) // ebχe- (Bur.)
ǰöbken (Sub.)	ǰöbken	zübχen (Bur.) // dzöwχön (Kh.)
2:1/γb/:		
asaγbai (Bur.)	asaγba (MNT)	
ögbei (Bur.)	ögbe (MNT)	ögwöl (Kha.)
2:4/gb/:		
ǰoγsa- (Jig.)	ǰoγsa- (MNT)	zogso (Bur.) // dzoχsŏ (Kha.)
bögse (Mo.)	bögse (MNT)	bügse (Bur.) // böχsȯ (Kha.)

2:5/γd/:

boγda (Taq.)	boqdas (D.)	bogdo (Bur, Kha.)
buγdai (Yur.)	buγdai (Mu, IM.)	buγdai (Zir, Mar.)

/gd/:

degde- (Alt.)	degde- (MNT)	degde- (Bur, Kha.)
üǰegde- (Taq.)	üǰegde- (MNT)	üdzegde- (Kha.)

2:6 /γl/:

aγlaγ (Bod.)	aγlaγ (MNT, Mu.)	aglag (Kha.) // aglak (Oir.)
nuntuγla- (Hin.)	nuntuγla- (MNT)	nutağɒl- (Kha.)

/gl/:

öglige (Bur.)	öglige (MNT)	öglög (Kha.) // ögläk (Oir.)
ǰügle- (Bur.)	ǰügle-	dzügle- (Bur, Kha.)

2:9 /γš/:

baγši (Bod.)	baγši (Hy.)	bagši (Ord.) // baχši (Kha.)
doγšin (Trkm.)	doγšin (MNT)	dogšin // doχšin (Kha.)

/gš/:

tegši (Turf.)	tegši (Mu.)	teχši (Kha.) // tekši (Oir.)
kögšin (Sub.)	kögšin	kögšin (Oir.) // χöχšin (Kha.)

2:10 /γt/:

aγta (Hin.)	aγta (MNT)	aχta (Kha.) // akta (Oir.)
maγta- (Qqor.)	maγta- (Hy.)	magta- // maχta- (Kha.)

/gt/:

ögte- (Bur.)	ögte- (MNT)	
biligtü (Sub.)	biliktü (Mu.)	biligtə (Kha.)

2:11/γč/:

γaγča (Bod.)	γaγča (MNT)	ğagtsɒ // ğaχtsɒ (Kha.)
oγčam (Bur.)	oγčam	ogtsom // oχtsom (Kha.)

/gč/

küsegčid (Bod.)	küsegčin (D.)	χüsegtšid (Kha.)
nögči- (Bod.)	nögči- (MNT)	nögtsö- // nöχtsö- (Kha.)

2:12/gǰ/:

kögǰi- (Taq.)	kögǰi- (Mu.)	χögdžĭ- (Kha.)
tügǰi- (Mo.)	tügǰi-	tügdžĭ- (Kha.)

2:13 /γq/:

asaγqa- (Bur.)	asaγqu (MNT)	asχe- (Bao.)

2:14/gk/:

ögküi (Bur.)	ögküi (MNT)	ögöχ (Kha.)

3:1/rb/:

arban (Qqor.)	harban (MNT)	arwan (Kha.)
γurban (Čin.)	γurban (MNT)	ğurban (Bur.)

3:2/rγ/:

arγa (Bod.)	arγa (MNT)	arağa (Kha.) // arğa (Ord.)
ǰirγalaŋ (Bod.)	ǰirγalaŋ (Hy.)	džirğal (Kha, Oir.)

/rg/:

irgen (Chang.)	irgen (MNT)	irgen (Bur, Kha, ÖMon.)
mergen (Bur.)	mergen (MNT)	mergen (Bur, Kha.)

3:4 /rs/:

arslan (Maha.)	arslan (MNT)	arsalan (Bur, Kha.)
dürsü (Chang.)	dürsün (Hy.)	dürsün (Oir.) // dürse (Bur.)

3:5 /rd/:

qurdun (Manǰ.)	qurdun (MNT)	χurdan (Bur, Kha,)
erdem (Bod.)	erdem (MNT)	erdem (Bur, Kha.)

3:6/rl/:

ǰarliγ (Bur.)	ǰarliγ (MNT)	dzarlig(Kha.)
dotorla- (MNT)		dotorŏl- (Kha.)

3:9 /rš/:

qarši (Taq.)	qarši (MNT)	χarši(Kha.) // χarša (Bur.)
aldarši- (Bod.)		aldarši- (Kha.)

3:10 /rt/:

erte (Qqor.)	erte (MNT)	erte (Bur.)
urtu (Chang.)	urtu (MNT)	urtɒ (Kha.)

3:11 /rč/:

qurča (Bur.)	qurča (MNT)	χurtsɒ (Kha.)

3:12 /rǰ/:

urǰi (Teh.)	urǰudur (IM.)	urdidar (Kha.)

3:13 /rq/:

burqan (Bod.)	burqan (MNT)	burχan (Bur, Kha.)
soyurqal (Chang.)	soyurqal (Mu.)	sojorχol (Bur, Kha.)

3:14 /rk/:

erke (Taq.)	erke (MNT)	erke (Oir.) // erχe (Bur.)
berke (Hin.)	berke (MNT)	berke (Oir.) // berχe (Bur.)

4:1/sb/:

egüsbe (Alt.)	e'ūsbe	ūswel (Kha.)
daγusba	dawūsba (MNT)	dūswal (Kha.)

4:2/sg/:

ösge- (Bur.)	ösge- (MNT)	ösgö- (Kha.) // üsχe- (Bur.)
esgel (Mo.)	esgel (MNT)	esχel (Kha.)

4:5/sd/:

sonusda- (Bod.)	sonosda- (MNT)	sonosdŏ- (Kha.)
tesde- (Bur.)	tesde-	

4:6/sl/:

qomusla- (Sub.)	qomosla-	χomosloχ- (Kha.)
ösle- (Sub.)	ösle-	öslöχ- (Kha.)

4:10 /st/:

ǰokistu (Bur.)	ǰoqistu (Mu.)	dzoχist (Kha.)
aγtastu	aγtastu (MNT)	agtastai // aχtastai (Kha.)

4:11 /sč/:

bayasču (Bur.)	bayasču (MNT)	bayastšĭ (Kha.)
bosču (Bur.)	bosču (MNT)	bostšĭ (Kha.)

4:13 /sq/:

bayasqu (Taq.)	bayasqa- (MNT)	bajasχalaŋ (Kha.)
anisqa (Bur.)	hanisqa (Mu.)	anisχa (Dör.)

4:14 /sk/:

ölüsküleŋ (Jig.)	ölösküleŋ (Mu.)	ölösχölöŋ(Kha.)
üǰeskü leŋ (Bur.)	üǰeskü leŋ (Mu.)	üdzesχeleŋ (Kha.)

5:1/db/:

udbala (Bur.)	udbala	udwal (Kha.)

5:4 /ds/:

odsuγai (Bur.)	odsuγai	odsuğai
sögüdsü		

5:6 /dl/:

edle- (Bod.)	edle-	edleχ (Kha.)

5:7 /dm/:

dadmaγai (Hin.)	dadmaγai	dadamğai (Bur, Kha.)
sögüdmü (Bod.)	sögödmü	sögödmü

5:10 /dt/:

edten (Sub.)	edten	edtei (Kha.)
čadtala (MNT)		tsadtal (Kha.)

5:11 /dč/:

ebedčin (Chan.)		öwtšin (Dör, Kha.)
uduridču (Bur.)		udirdadžĭ (Kha.)

5:13 /dq/:

udqa (Bod.)		udχa (Bur.) // utağa (Kha.)
todqur (Bod.)	todqur (MNT)	todχor (Bur, Kha.)

5:14/dk/:

sedkil (Bod)	sedkil (MNT)	setkil (Oir.) // sedχel (Bur.)
čidkür (Sub.)	čidkür (Hy.)	tšödχör (Kha.)

6:1/lb/:

alba (Turf.)	alban (KMQB.)	alba (Bur, Kha.)
kilbar (Bod.)	kilbar (MNT)	kilbar (Oir.) // kilbar (Ord.)

6:2 /lγ/:

ǰolγa- (Alt.)	ǰolγa- (MNT)	džolğo- (ÖMon.)
qaγalγa (Qqor.)	qa'ālγa (Hy.)	χālğa (Kha.)

/lg/:

delger (Chang.)	delger (MNT)	delger (Bur, Kha.)
kölgen (Bod.)	kölgen (KMQB.)	χölgön (Kha.)

6:4 /ls/:

mölsün (Taq.)	mölsün (MNT)	molse (Mngr.)
čaγālsun	ča'ālsun (Hy.)	tšāldze (Mngr.)

6:5/ld/:

aldar (Bod.)	aldar (MNT)	aldar (Bur, Oir, Kha.)
eldeb (Maha.)	eldeb (MNT)	eldew (Kha.) // eldeb (Bur.)

6:7 /lm/:

ǰaγalmai (Alt.)	ǰaγalmai (Hy.)	dzağalmai (Kha.)
gölme (Mo.)	gölme (MNT)	gölme (Dör) // gölöm (Kha)

6:10 /lt/:

altan (Qqor.)	altan (MNT)	alta (Bur, Kha.)
siltaγān (Chan.)	šilta'ān (Hy.)	šaltğān (Bur, Kha.)

6:11/lč/:

ilčin (Chang.)	elčin (MNT)	eltšin (Kha.) // elšen (Bur.)
belčir (Bur.)	belčir (MNT)	beltšir (Kha.)

6:12 /lǰ/:

olǰa (Bod.)	olǰa (MNT)	oldžo (Ord.) // oldzŏ (Kha.)
ölǰei (Chang.)	ölǰei (MNT)	öldzī (Kha.)

6:13 /lq/:

nilqa (Jig.)	nilqa (MNT)	nilχɒ (Dör, Kha, Ord.)
qalqa (Hin.)	qalqa (MNT)	χaɬχɒ (Bur, Kha.)

6:14 /lk/:

törülki (Bod.)	törölki (MNT)	türelχi (Bur.)
ölke (Sub.)	ölkeg (MNT)	

7:1/mb/:

yambar (Bod.)	yambar (MNT)	jamar (Bor, Oir, Kha.)
embüre- (Sub.)	embürü (MNT)	

7:2/mγ/:

tamγa (Bod.)	tamγa (Hy.)	tamğa (Kalm.)

/mg/:

nimgen (Taq.)	nimgen (Hy.)	nimgen (Bur.) // niŋgen (Kha.)

7:4/ms/:

qamsa- (Ar.1)	qamsa- (MNT)	χamsa- (Kha.)
uqamsar (Mo.)	uqamsar (MNT)	uχamsar (Kha.)

7:5/md/:

dumda (Bod.)	dumda (MNT)	duŋda (Bur, Kha, Oir.)
temdeg (Chang)	temdeg (MNT)	temdeg (Bur, Kha.)

7:6/ml/:

qurimla- (Bod.)	qurimla- (MNT)	χurimlaχ (Kha.)

7:8/mn/:

simnanča (Bod.)	imne- (Mu.)	imne- (Kha.)
kemne- (Mo.)	kemne-	kemne- (Oir.)

7:9 /mš/:

umši- (Bod.)	humši- (Mu.)	umši- (Oir.) // unši- (Kha.)
γutumšiγ (Sub.)	γutumšiγ	ğutumšig (Kha.)

7:10 /mt/:

qamtu (Chang.)	qamtu (MNT)	χamta (Bur, Kha.)
golumta (CTB)	γolumta (MNT)	ğolomtŏ (Kha.)

7:11 /mč/:

čamča (Maha.)	čamča (MNT)	tsamtsɒ (Kha.)
emčü (Jig.)	emčü (MNT)	

7:12 /mǰ/:

ǰalγamǰi (Taq.)	ǰalγamǰi	dzalğamdžĭ (Kha.)
ülemǰi (Ölǰ.)	ülemǰi (Mu.)	ülemdžĭ (Kha.)

7:13 /mq/:

qumqan (Bur.)	qumqan (Mu.)	χumχa // χumaχ
čamqaγ (Sub.)	čamqaγ	tsamχag (Kha.)

7:14 /mk/:

qamki- (Turf.)	qamki-	χamki- (Kha.)
kemkele- (Mo.)	kemkele- (MNT)	kemkel- (Oir.)

8:4/ns/:

sansar (Bod.)	sansar	saŋsar (Kha.)

8:5 /nd/:

öndür (Sul.)	ündür (MNT)	öndör (Kha, ÖMon.)
kündü (Hin.)	kündü (MNT)	χünde (Kha, ÖMon.)

8:6 /nl/:

qanliγ (Taq.)	qanliγ (KMQB.)	χanlig // χanlag (Kha.)
noyanla-(Mo.)	noyanla- (KMQB)	nojol- (Kha.)

8:10/nt/:

nuntuγ (CTB)	nuntuγ (MNT)	nutug // nutag (Kha.)
unta- (Bur.)	unta- (Mu.)	unta- (Bur, Kha, ÖMon.)

8:11/nč/:

qilinča (Bod.)	kilinče	χilintsə (Kha.)

8:12 /nǰ/:

inǰe (Chang.)	inǰe (MNT)	indži (Kha.), enže (Bur.)
anǰasun (Jig.)	anǰasun (Hy.)	andžis (Kha.)

9:2/nγ/:

miŋγan (Bod.)	miŋqan (D.)	miŋğan (Bur, Kha, Ord.)
oŋγoča (Bur.)	oŋγača (MNT)	oŋgots (Kha.)

/ŋg/:

köŋgele- (Taq.)	köŋgen (Hy.)	köŋgön (Oir.)
öŋge (Bod.)	öŋge (MNT)	öŋgö (Kha, ÖMon.)

9:4/ŋs/:

deŋsel- (Bur.)	deŋsel- (MNT)	deŋsel- (Kha.)
taŋsuγ (Ar.1)	taŋsuγ	taŋsag (Kha.)

9:6/ŋl/:

maŋlai (Bod.)	maŋlai (MNT)	maŋlai (Kha.)
kiliŋle- (Bur.)	kiliŋle- (MNT)	χiligneχ (Kha.)

9:9/ŋš/:

uŋši- (Öt.)	uŋši- (Hy.)	uŋši- (Kha.)

9:10 /ŋt/:

bayasqulaŋtu (Bod.)	bayasqulaŋtu	bajasχalaŋtɒ (Kha.)
ǰirγalaŋtu (Bod.)	ǰirqalaŋtu (D.)	džirğalaŋtɒ (Kha.)

9:11 /ŋč/:

teŋčeldü- (Qqor.)	teŋče'ül- (Mu.)	teŋtsə - (Kha.)

9:12 /ŋǰ/:

günǰü (Qqor.)	günǰü (MNT)	günǰdži (Kha.)
ölenǰi- (Alt.)	neŋǰi- (MNT)	

9:13 /ŋq/:

aŋqa (Chang.)	aŋqa (MNT)	aŋχɒ (Kha.)
muŋqaγ (Qqor.)	muŋqaγ (MNT)	muŋχag (Bur, Kha.)

9:14 /ŋk/:

möŋke (Hin.)	möŋke (MNT)	möŋkȯ (Oir, Kha.)
eŋke (Qqor.)	eŋke (MNT)	eŋkə (Oir, Kha.)

10:2 /šg/:

ašgi- (Sub.)	ašgi- (MNT)	
aγūšgi (Mo.)	a'ūšgi (MNT)	ūšχi // ūšig (Kha.)

10:6 /šl/:

bišlaγ (Mo.)	bišlaq (IM.)	bišlig // bašlag (Oir.)
qošla- (Mu.)		

10:10 /št/:

öšten (Mo.)	öšten (MNT)	öštön // östön (Kha.)

Монгол хэлний гийгүүлэгч авианы байрын гол хууль болох *'дэвэсхэр үсэг'*-ийн дүрэм ёсоор дэвэсхэр үсэгийн дараа дэвэсхэрлэх ба эс дэвэсхэрлэх үсэгүүд залган орж болох мэт боловч жинхэнэ хэрэг дээрээ үеийн зааг дахь дуутай, дуугүйн зохьцолоос шалтгаалан гийгүүлэгч бүхэн бие биестэйгээ чөлөөтэй хиллэн орж болдоггүй байна. Ер нь үе төгөсгөх ба үл төгөсгөх гийгүүлэгчийн гол ялгаа нь чанга-сул, дуутай-дуугүйн шинж бөгөөд чанга гийгүүлэгч фонемийн дуугүй хувилбарын өмнө сул гийгүүлэгч фонемийн дуугүй хувилбар ордог сонсол зүйн зарчимын дагуу үе төгөсгөх гийгүүлэгч нь дараах гийгүүлэгчийнхээ өмнө дуугүй болдог байна. Нөгөө талаас авч үзвэл, дуутай, дуугүй гийгүүлэгчид үеийн зааг залган орж болохгүй тул үе үл төгөсгөх гийгүүлэгчийн дараа үе төгөсгөх ба үл төгөсгөх гийгүүлэгчийн аль нь ч огт тохиолддоггүй ажээ. Мөн зарим гийгүүлэгч, тухайлвал, ***r, y*** хоёр нь үеийн эхэнд гийгүүлэгчийн өмнө огт тохиолддоггүй, гагцхүү эгшигийн өмнө ордог байна. Энэ бүхэнээс авч үзвэл, гийгүүлэгч-гийгүүлэгчийн байрлал нь зөвхөн үе төгөсгөх, үл төгөсгөх шинжээр зогсохгүй, тухайн байрлалд, тухайн гийгүүлэгчийн дуутай, дуугүй хэлэгдэх байдал дээр түшиглэсэн акустикийн шинжтэй дараалал юм. Гэхдээ үе төгөсгөх гийгүүлэгч бүхэн үеийн эцэст дуугүй болдоггүй, зөвхөн заримдаг дуутай зарим гийгүүлэгч (b, γ, r, s, d) л дуугүй болж, бусад нь (l, m, n, n) дуутай шинжээ хадгалдаг тул үгийн эцэст орсон үе төгөсгөх гийгүүлэгчид нь ***d/t, č/ǰ***-гээр эхэлсэн нөхцөлийг харилцан адилгүй авдаг байна. Монгол хэл зүйчид энэ онцлогийг нарийн ажиглаж нийт *'дэвэсхэр үсэг'*-ийг дотор нь *'хатуу дэвэсхэр'*, *'зөөлөн дэвэсхэр'*гэж ялгасан тухай өмнө дурдсан билээ. Тэр нь хэрэг дээрээ зөвхөн саланги үгсийн түвшин дэх гийгүүлэгчийн байр төдийгүй, морфемуудын харьцаан дахь /= язгуур-дагавар, үндэс-нөхцөл/ гийгүүлэгч авианы байрыг нарийвчилан тогтоосон хэрэг юм.

Жич: Зарим бичигийн дурсхалд морфемуудын заагт нэг фонемийн ижил хувилбар хаяа тохиолдож байна.

-bb-abba (MNT)	abbasu (CTB)
-ss-	egüssü (Alt.)

Мөн түүнчилэн морфемуудын заагт ***-ll-*** тохиолдох боломж ч бас бий билээ. Дээр дурдсанаас гадна дундад үеийн монгол хэлний зарим бичигийн дурсхалуудад *n*-ээр төгөссөн нэрийн үндэсэнд эгшигээр эхэлсэн нөхцөлийг залгахдаа тухайн үгийн эцэсийн гийгүүлэгчийг давхарлан тэмдэглэсэн нь цөөнгүй байна.

Gen. qahān-nu (MNT); eǰen-nü (Hy.)
D-L. qahān-na (MNT); eǰen-ne (Hy.)
Acc. noyan-ni (MNT); irgen-ni (Hy.)
Abl. olan-nača (MNT); kü'ün-neče (Hy.)
Instr. arasun-niyar (MNT); ünen-niyer (Hy.)
Reffl. qan-niyan (MNT); qahān-niyan (Hy.)

Монгол хэлний үеийн заагт гийгүүлэгч давхарлах тухай Yo. Saito, Д. Төмөртогоо нарын үгүүлэл гарсан буй.[744]

Монгол хэлний хөгжилийн цаашдын явцад зарим гийгүүлэгч авианы хэлэгдэх байдалд суларах, солигдох зэрэг өөрчилөлт гарсаны уламаас үеийн заагт тохиолддог гийгүүлэгчийн байрлалд ч бас зохих өөрчилөлт гарахад хүрсэн боловч ерөнхийд нь авч үзвэл эртний монгол хэлний гийгүүлэгчийн байр өдгөө хүртэл үндэсэндээ тогтвортой хадгалагдан үлдсэн байна.

Монгол хэлний эгшигийн байрын хууль нь тухайн үгэн дэх бүх эгшигийг хамардаг бол гийгүүлэгчийн байрлал нь зөвхөн үеийн заагт дараалан орсон гийгүүлэгчийг л хамардаг бөгөөд үе төгөсгөх гийгүүлэгч нь дараах үеийнхээ эхний гийгүүлэгчийг, язгуурын эцэсийн гийгүүлэгч нь дараах дагаварынхаа эхний гийгүүлэгчийг, үндэсийн эцэсийн гийгүүлэгч нь дараах нөхцөлийнхөө эхний гийгүүлэгчийг тус тус ялган тогтоодог байна. Монгол бичигийн хэлний дурсхалууд дахь гийгүүлэгчээр эхэлсэн залгавар морфемуудын байрлалыг ажиглавал, эгшигээр эхэлсэн үгэнд шууд (а), үе төгөсгөх гийгүүлэгчийн дараа дэвэсхэр үсэгийн дүрмээр (б), үеийн заагт хиллэн ордоггүй гийгүүлэгч байвал хооронд нь ***u/ü*** эгшиг жийрэглэх (в), ***n, r***-гээр төгөссөн үгэнд бол эцэсийн гийгүүлэгчийн байранд шууд залгах (г) ийм дөрвөн янзын арга хэрэглэж байжээ. Түүнийг жишээгээр үзүүлвэл:

(a) elige + bči = eligebči; ayta + či = aytači; ǰirγa + lan = ǰirγalan; ami + du = amidu; šibü + ge = šibüge; egeči + med = egečimed

(b) üker + čin = ükerčin; obuγ + tan = obuγtan; ol + ǰa = olǰa; monγol + ǰin = monγolǰin; tayil + buri = tayilburi

(c) γol + (u) + mta = γolumta; bos + (u) + γči = bosuγči; γar + (u) + ča = γaruča; ölüs + (ü) + mser = ölüsümser

744 Yoshio Saito, Geminate Consonants in Middle Mongolian. One Phenomenon in the Texts of Chinese Transcriptions, *Bulletin of the Japan Society for Mongolian Studies,* No. 20, Tokyo, 1989, 1-19; Consonantal Geminnation in Mongolian, *'A Phonetic Study of theMiddle Mongolian Language in Arabic Transcriptions'*, Tokyo, 1997, 55-63; Д. Төмөртогоо, Бүтээвэрийн харьцаанд гийгүүлэгч давхарлах ёс, *'Монгол хэл шинжилэлийн онол, түүхийн асуудалууд'*, Уб., 2002, 149-153

(d) noyan + kin = noyakin; bayan + d = bayad; modun + d = modud;
baγātur + d = baγātud; üdür + d = üdüd; γar + d = γad

Гийгүүлэгчийн байрын тухай асуудал нь зөвхөн үе хоорондын болон морфем хоорондын асуудал төдийгүй, хэлэхүйн түвшинд авч үзвэл бас зарим талаар үгүүлбэрийн доторхи үгс хоорондын заагтай ч холбоотой асуудал юм. Тухайлвал, үе, морфемийн зааг дахь гийгүүлэгчийн байрыг үе төгөсгөх гийгүүлэгч л зохьцуулдаг бол хэл ярианы урсхал дахь үгс хоорондын авианы байрыг дараах үгийнх нь эхний гийгүүлэгч зохьцуулах тохиолдол ч бас байдаг байна.

2.3 ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ ХУВЬСАЛ

§ 94. **Гийгүүлэгч авианы хувьсал**. Хэлний авианууд хэл ярианы урсхалд үгүүлэхийн эрхтэнээр дамжин гарах явцдаа өөр хоорондоо зохьцон, солигдох, сэлгэх, нэмэгдэх, хураагдах зэрэгээр хувисдаг байна. Гэвч тийм хувьсал нь авиануудын эмх замбараагүй сарнил биш, харин тэдгээрийн харилцан бие биедээ нөлөөлөх түгээмэл хуулийн дагуу явагдаж байгаа тодорхой зүй тогтолт хувьсал юм. Авианы хувьсалын эцэсийн үр дүн нь нэг талаар ойртон ижилших шинжтэй, нөгөө талаар холдон ондоошох шинжтэй байдаг учир түүнийг тухайн тодорхой үзэгдэлийн үүднээс авч үзэх нь зүйтэй юм.

2.3.1 ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ ТАГНАЙШИЛ

§ 95. **Гийгүүлэгч авианы тагнайшилын судалгааны тойм.** Монгол хэлний гийгүүлэгч авианы тагнайшил нь олон талтай бөгөөд түүний дотроос тагнайшилын үр дүнд хамжин шүргэх гийгүүлэгч шинээр үүссэн тухай асуудалыг эрдэмтэд анх түрүүн олж ажигласан байна. Энэ талаар G. J. Ramstedt, Б. Я. Владимирцов нар анхлан судалсан билээ.[745] Хожим N. Poppe, Г. Д. Санжеев нар тагнайшилын нөлөөгөөр үүссэн хамжин шүргэх гийгүүлэгчийн хувьсал хөгжилийн талаар улам нарийвчилан судалж, зарим талаар бусад төрөл хэлнүүдийн зохих авиатай харьцуулан авч үзсэн буй.[746] Монгол хэл зүйн бүтээлүүд болон хэл аялгуунуудын авиа зүйн зохиолуудад тагнайшсан гийгүүлэгчийн талаар тэмдэглэсэн зүйл олон буй бөгөөд мөн энэ талаар дагнан судалсан үгүүлэлүүд гарсан байна.[747] Монгол хэлний гийгүүлэгч авианы тагнайшилыг авианы бие даасан

---

745 Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, 10-11; *idem.* Die Palatalization in den altaischen Sprachen, *Annales Ac. Sc. Fenn.* 27, 1932, 239-251; Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 396-398

746 N.Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, 103-104, 114-115, 118-119; Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, ч. I, 91-103; N. Poppe, The Mongolian Affricates **č* and **ǰ*, CAJ. 2:3 (1956), 205-207

747 М. Базаррагчаа, Орчин цагийн монгол хэлний хамжин шүргэх гийгүүлэгч, Уб., 1980, 3-28; П. Ц. Биткеев, Палатальность консонантов в алтайских языках, *'Проблемы алтаистики и монголоведения'*, Элиста, 1972, 7-8; *idem*. Мягкие согласные в алтайских языках, *'Проблемы алтаистики и монголоведения'*, Вып. 2, М., 1975, 340-353; Г. Гантогтох, Халхын аялгууны хамжин шүргэх гийгүүлэгчийн сэлгээ, ХЗ 13, 1979, 98-

үзэгдэлийн хэмжээнд авч үзсэн профессор В. И. Рассадины судалгаа нэн чухал ач холбогдолтой болсоныг онцлон дурдвал зохино.

Гийгүүлэгч авианы тагнайшилын тухай тэмдэглэл. Монгол хэлний хөгжилийн эртний шатанд хэлний хойгуурхи, хүчдэлтэй ***i*** эгшигийн хэлэгдэх байдалд гарсан хувьсал нь өмнөх гийгүүлэгчдээ нөлөөлж, тагнайшихад хүргэсэн байна. Хэлний урдуурхи, хүчдэлгүй ***i*** ч мөн нэгэн өмнөх гийгүүлэгчээ тагнайшуулжээ.

Ер гийгүүлэгчийн тагнайшил нь бүр эртний монгол хэлний үеэс орчин цагийн монгол хэлний үеийг хүртэл урт удаан хугацаанд үргэлжилсэн түүхэн үзэгдэл билээ. Тийм учираас тагнайшсан гийгүүлэгчийн хувьсал хөгжилийг цуваа цагийн үүднээс авч үзэхдээ тухайн гийгүүлэгчийн анхдагч шинжид тулгуурлан доорхи байдалаар ангилж болно.

2.3.1.1 ХАМЖИХ ГИЙГҮҮЛЭГЧИЙН ТАГНАЙШИЛ

Өвөг монгол хэлний үед ****i, *ï***-гийн өмнө орсон ****t, *d, *q*** гийгүүлэгчид эртний монгол хэлний үед арынхаа эгшигийн нөлөөгөөр тагнайшин, монгол хэлэнд уулаас байсан ****ǰ, *č, *k***-гийн шинэ хувилбар болсон бөгөөд тэдгээрийг байрлалаар нь ялган таних бүрэн боломжтой юм.

č < *t

PM **tïnar* ‘чанар’, AM *činar* [< *tinar] Precl. (= Bur, Sub.), MM *činar* (MNT, Ph.), CM *tšinar* (Dag, Kha, Ord.), *tšinər* (Kalm.), *tšinɒr* (Oir. /= Dör, Ba, Kho./), *tšinĭr* (Oir. /= Zakh, Tor, Ö, Ur./)

PM **tïlaγun* ‘чулуу’, AM *čilaγūn* [< *tilaγūn] Precl. (= Sub.), MM *čilawūn* (MNT, KMQB, Hy.), *čila'ūn* (D.), CM *čilū* (SY.), *tšilū* (Ord, Kham.)

PM **tïŋna-* ‘чагна-’,// Cf. AT. *tiŋla-* id./, AM *čiŋna-* [< *tiŋna-] (Mo.), MM **čiŋna-*, CM *tšiŋla-* (Mngr.), *tšiŋna-* (Ord.), *tšiŋnə* - (Kalm, Tor.), *tšiŋni-* (Oir. /= Zakh, Ö, Tor, Ur./), *tšiŋnə* - Oir. /= Ba, Dör, Kho./)

PM **bïtik* ‘бичиг’, // Cf. Ma. bitxe id., AM *bičig* [< *bitig] Precl. (= Jig, Chang, Hin, Ölǰ, Taq.), MM *bičig* (MNT, KMQB, D, Mu, IM, Ist.), *biti-* (R.), CM *bitig* (Ha.), *bitih* (Kul.) // *bitšig* (Kha, ÖMon, Oir.), bišig (Bur.)

104; Монгол хэлнүүдийн хамжин шүргэх гийгүүлэгчийн сэлгэх, тохирох боломж, ХЗ 15:14, 1980, 115-132; Ж. Надмид, Монгол хэлний тагнайшсан гийгүүлэгч, Уб., 1986, 18 х.

ǰ < *d

PM *dïluγa ‘жолоо’, //Cf. Ew. *dil ‘толгой’/ AM ǰiluγā [< *diluγā] Precl. (= Qqor, Bur.), MM *ǰilu'ā* (MNT), CM *dilō* (Dag.) // *džilō* (Ord.)

PM *adïrγa ‘азарга’, //Cf. Tung. *adirğa* id./, AM *aǰirγa* [< *adirγa] (Mo.), MM *aǰirγa* (MNT, Hy, Mu, IM, L, St, HQ.), CM *adirğa* (Dag.) // *adžirğa* (Oir. /= Dör, Zakh./, ÖMon. /= Barin, Jas./)

PM *qadïγar ‘хазаар’, AM *qaǰaγār* [< *qaǰiγār < *qadiγar](Mo.), MM *qada'ār* (Hy.), *qadār* (MNT, Mu, L, Ist.), CM *qadār* (Mog.) // *χadžār* (Ord, Cha.)

PM *gedige ‘гэзэг’, // Cf. Ew. *gedimuk* ‘дагз’, Lam. *gedeke* id./, AM *geǰige* [< *gedige] (Mo.), MM *geǰige* (MNT, Mu.), CM *gedige* (Dag.) // *gedžige* (Ord.), *gedžig* (ÖMon.), *gidžigi* (Dun.), *gidžig* (Oir.)

Дунсян хэлэнд хэлний урдуурхи ***e*** нь үлэмжхэн урагшилж хэлэгдэх болсоноос түүний өмнө орсон хамжих ***d*** гийгүүлэгч тагнайшин, хамжин шүргэж хэлэгдэх болсон байна.

AM *degēsün* ‘дээс’, Precl. (= Alt.), MM de'ēsün (Hy.), CM dēs (Kha.), džiėsun (Dun.)

AM *degēre* ‘дээр’Precl. (= Bod, Chang, Sul, Sub.), MM *de'ēre* (MNT, KMQB, Ph.), CM *dērə* (Kha.) // džiere (Dun.)

AM *gedesün* ‘гэдэс’ (Mo.), MM *gedesün* (Hy.), *getesün* (Mu.), *gesesün* (L.), CM *gedes* (Kha.), *kidžesun* (Dun.)

AM *dörben* ‘дөрвөн’ Precl. (= Bod, Hin, Taq, Sul.), MM *dörben* (MNT, KMQB, D, Tk.), CM *dörwön* (Kha.) // *džierwen* (Dun.)

k < *q

PM *qïdiγar ‘хизгаар’, // Cf. qidiγ AT. id./, AM *qiǰiγār* (Jig.), *kiǰaγār* [< *kiǰiγār < *qidiγar] Precl. (= Bur, Sub, Bod, Hin.), MM *qiǰār* (Mu.), *kiǰār* (KMQB.) // CM *kidžğār* (Ord.), *kidžār* (Dag.), *kizā r* (Kalm.)

PM *qïlγasun ‘хилгас’, // Cf. AT. *qil* id./, AM *kilγasun* [< *qilγasun] (Mo.), MM *qilγasun* (Mu.), *kilγasun* (MNT), CM *qilγasun* (Mog.), *qelγasun* (Mar.) // *kilghasun* (Leech.), *kilğasun* (Dör.), *kilğasan* (Kalm, Tor.), *kilğašiŋ* (Zakh.), *kilğasu* (Ord.), *kilgäsan* (Ba, Dör, Kho.)

PM *qïtuγa ‘хутага’, AM *kituγa* [< *qituγa] (Mo.), MM *qituγa* (Mu.), *kituγai* (MNT), *kituγa* (IM, L.), CM *qitqei* (Mog.), *qetγai* (Man, Mar.) // *kitoğo* (NÜd.)

РМ **qïmulsun* ‘хумас’, АМ *kimusun* [< *qimulsun] Precl. (= Bur.), ММ *qimusun* (Mu.), *kimul* (MNT), *kimusun* (Hy.), СМ *qimsun* (Mog.), *qemsun* (Man, Mar, Zir.) // *kimič* (Ha.), *kimeči* (But.), *kimči* (Kul.), *kumuhuŋ* (NÜd.)

Жич:

1. Буриад хэлний зарим аялгуунд ***i***-гийн өмнө орсон ***g*** нь арынхаа эгшигийн нөлөөгөөр тагнайшиж *j* болсон байна.

Bur. jalai-(< jilai- < gilai < gilayī-) *’гилай-’*
Bur. jalba- (< jilba- < gilba-) *’гилба-’*
Bur. erje (< erji < ergi) *’эрэг’*
Bur. anjar (< anjir < angir) *’ангир’*
Bur. doljōn (< doljo’ōn < dolji’ōn < dolgi’ōn < dolgi’ān < dolgiyān)
’долгион’
Bur. zalgi- (zalji- < ǰalgi-) *’залги-’*

2. Мөн буриад хэлний Эхирид-булагат аялгуунд ***i***-гийн өмнө орсон ***ǰ*** гийгүүлэгч арынхаа эгшигийн нөлөөгөөр тагнайшиж ***j*** болсон жишээ буй.

Bur. jarğal (< jirγal < ǰirγal) *‘жаргал’*
Bur. ǰorō (< jirō < jiro’ō < jiru’ā < ǰiruγā) *‘жороо’*
Bur. jel (< jil < ǰil) *‘жил’*

Дээрхи жишээнүүдээс ажиглавал, тагнайн ***i*** эгшигийн нөлөөгөөр тагнайшсан гийгүүлэгчийн арын эгшиг нь орчин үеийн хэл аялгуунуудад зэрэгэлдээх үеийнхээ эгшигтэй ижилшин өөр авиа болсон тохиолдолд ч уул тагнайшсан гийгүүлэгч нь хэвээр хадгалагдан үлдсэн байна.

Ер орчин үеийн монгол хэл аялгуунуудын зарим үгсийн дотоод бүтэцийг ажиглавал урид тухайн үгийн дотор байсан тагнайн бус гийгүүлэгч нь тагнайшиж, тагнайшуулсан эгшиг нь өөр эгшигтэй ижилшээд өнгөцхөн харвал тийм хувьсал огт болоогүй мэт санагдмаар байна. Нөгөө талаар, гийгүүлэгчийн тагнайшил нь хэл аялгуу тус бүрд харилцан адилгүй болсон хийгээд нэгэнт тагнайшсан гийгүүлэгч ч бас цаашдаа харилцан адилгүй хувиссан учир тэдгээрийн түүхэн хувьсалыг ялган танихад зарим талаар бэрхшээлтэй болжээ.

Мөн монгол хэлний хөгжилийн эртний шатанд арынхаа эгшигийн нөлөөгөөр тагнайшсан ****d, *q*** зэрэг гийгүүлэгч нь дундад үеийн монгол хэлний зарим бичигийн дурсхал болон орчин үеийн Могол, Дагуур зэрэг хэлэнд тагнайшаагүй хэвээр үлдсэн жишээ нилээд тохиолдож байна. Энэ нь тухайн гийгүүлэгч хожуу тагнайшсаны гэрч юм.

2.3.1.2 ШҮРГЭХ ГИЙГҮҮЛЭГЧИЙН ТАГНАЙШИЛ

Өвөг монгол хэлний үед ***ï, i***-гийн өмнө байсан шүргэх ****s*** гийгүүлэгч нь эртний монгол хэлний үед арынхаа эгшигийн нөлөөгөөр тагнайшиж, монгол хэлэнд урид байгаагүй шүргэх ***š*** шинээр буй болжээ. Гэвч энэхүү шүргэх гийгүүлэгч нь эртний монгол хэлний олон аялгуунуудад нэгэн зэрэг үүсээгүй бөгөөд түүнийг нилээд хожим болтол монгол бичигт ялган тэмдэглэлгүй, гагцхүү байраар нь ялган дуудсаар байв.

PM **sine* ‘шинэ’, AM *sine* Precl. (= Bod, Ar.2, Jig, Qqot, Bur.), MM *šine* (MNT, KMQB, Hy, Mu, Ist.), CM *šine* (Bao, Ord.), *šinə* (Kalm, Oir, Kha.), *šini* (Dun.)

PM **sibar* ‘шавар’, AM *sibar* Precl. (= Bur, Sub.), MM *šibar* (MNT, Hy, Tk, Mu, IM.), CM *šiwar* (SY.)

PM **sibayun* ‘шувуу’, AM *sibayūn* Precl. (= Hin, Sul, Bur.), MM *sibawūn* (MNT, KMQB, Tk, L.), *šiba'ūn* (Hy, D, Mu.), CM *šibū* (Min.), šiwū (Ord.)

PM **sidün* ‘шүд’, AM *sidün* Precl. (= Bur, Sub.), MM *šidün* (Hy, Tk, Mu, IM, L, Ist.), *šidü* (MNT), CM *šidün* (Dun, Ur.), *šidu* (Dag.)

Жич: Эртний монгол хэлний үед тагнайшилын уламаас буй болсон дээрхи гийгүүлэгчидээс гадна ***w, g, d, l, m, n, r, t, x*** зэрэг гийгүүлэгч мөн ***i***-гийн нөлөөгөөр тагнайших тохиолдол өдгөөгийн Дагуур, Буриад, Төв монгол хэлнүүд болон Өмнөд монгол хэлний зарим аялгуунд (= Цахар, Улаанцав, Шилийн гол) түгээмэл байна. Орчин цагийн монгол хэлний хувид гэвэл ***g, dz, ts, s***-ээс бусад гийгүүлэгч цөм *i*-гийн өмнө орохдоо тагнайших бөгөөд тэдгээрийн дотороос ***dž, tš, š, j*** нь ямагт тагнайшиж хэлэгдэнэ. Ер орчин цагийн монгол хэлний гийгүүлэгчийн тагнайшилыг авиа зүйн түвшинд авч үзвэл тэр нь олонхи гийгүүлэгчийг хамарсан түгээмэл шинжтэй боловч фонологийн түвшинд авч үзвэл харьцангуй цөөн гийгүүлэгчийг хамарч байна.

2.3.2 **ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ СУЛАРАЛ**

§ 96. **Гийгүүлэгчийн суларал**. Монгол хэлний гийгүүлэгч авианы түүхэн хувьсалын нэг гол хандлага бол суларал бөгөөд түүнийг гол төлөв авианы сугаралаар тайлбарласаар иржээ. Гэтэл гийгүүлэгчийн сугарал нь авианы хувьсалын биеэ даасан үзэгдэл бишц, харин гийгүүлэгч суларах үзэгдэлийн эцэсийн үр дүн юм. Авиа суларах үзэгдэл нь авианы харилцан бие биедээ нөлөөлөх түгээмэл хуулийн дагуу зэрэгэлдээ авианыхаа давамгайлах нөлөөн дор явагддаг бөгөөд бас заримдаа үг, морфемийнхоо утга ялгах үүрэгээ алдсан авиа суларах тохиолдол ч бий. Гийгүүлэгч авиа ийнхүү суларах явцдаа хамжихаас шүргэх, шүргэхээс сул шүргэх зэрэгээр үгүүлэгдэх хам шинжээ алдсаар эцэсийн эцэст фонем, морфемийнхоо үүрэгийг бүрмөсөн суларан сугардаг байна. Гийгүүлэгчийн суларах явцад гарсан аливаа хувьсалыг уг үзэгдэлийн ерөнхий хандлага, мөн

чанараас нь салгаад, ижилшил, солигдол гэх мэт өөр хувьсалаар тайлбарлавал оновчгүй болно.

2.3.2.1 ҮГИЙН ЭХНИЙ ГИЙГҮҮЛЭГЧИЙН СУЛАРАЛ

§ 97. **Үгийн эхний гийгүүлэгчийн суларал**. Монгол хэлний гийгүүлэгч авианы түүхэн хувьсалын нэгэн гол хандлага нь *'суларал'* мөн билээ. Энэхүү суларалыг монгол хэлний судалалд *'гийгүүлэгчийн сугарал'* хэмээн нэрийдсээр иржээ. Гэтэл *'сугарал'* гэдэг нь авианы хувьсалын бие даасан үзэгдэл биш, харин тухайн авианы суларалын эцэсийн үр дүн юм. Ер гийгүүлэгч авианы суларал гэдэг нь авианы харилцан нөлөөлөлийн хүрээнд тухайн нэг авиа нь зэрэгэлдээх авианыхаа давамгайлах нөлөөн доор хамжихаас шүргэх, шүргэхээс сул шүргэх, сул шүргэхээс амисхалын түрэлт болох зэрэгээр үгүүлэгдэх хам шинжээ аажим алдсаар яваандаа утга ялгах үүрэгээ бүрмөсөн алдахыг хэлж байна.

Монгол хэлний гийгүүлэгч авианы суларалыг байрлалаар нь үгийн эхний, дундах, эцэсийн хэмээн гурван зүйлээр ангилж болно.

Үгийн эхний гийгүүлэгчийн суларалын судалгааны тойм. Монгол хэлний гийгүүлэгч авианы суларал нь тохиолдох байрлал, гадаад нөлөөлөлийнхөө талаар өөр өөр шинжтэй байдаг учир тэдгээрийн судалгааг ч бас дээрхийн адилаар ялган үзэж болно. Үгийн эхний ***h***-гийн гарал үүсэл хийгээд түүний цаашдын хувьсалын тухай асуудал нь зөвхөн монгол хэлээр барахгүй, нийт алтайн хэлнүүдийн хүрээнд анхаарал татсан сонирхолтой асуудал учираас түүнийг юуны өмнө алтайч эрдэмтэд ихээхэн анхаарч судалсан байна.

Үгийн эхний ***h***-гийн гарал үүсэл хийгээд түүний цаашдын хувьсалын талаар хамагийн анх профессор G. Ramstedt уул ***h*** гийгүүлэгчийг түүхэн үүднээс авч үзээд уламаар түүнийг ****φ*** < ****ρ*** гэсэн хувьсалыг дамжин үүссэн тухай онолыг анх дэвшүүлсэн байна.[748] Түүний дараахан нэрт монголч эрдэмтэн P. Pelliot дундад үеийн монгол хэлний бичигийн дурсхалуудын үгийн эхний ***h*** гийгүүлэгчийн гаралыг мөн дээрхийн адилаар тайлбарласан нь[749] эдүгээ хүртэл тухайн гийгүүлэгчийн тухай тулгуур онолын үндэс нь болсоор иржээ. Түүнчилэн P. Aalto, N. Poppe, G. Doerfer, R. A. Miller нар уул шүргэх гийгүүлэгчийн түүхэн хувьсалыг алтайн хэлнүүдийн хүрээнд авч үзсэн хэд хэдэн үгүүлэл нийтлүүлсэн байна.[750] Мөн дундад үеийн монгол хэлний бичигийн дурсхалуудад тохиолдож буй үгийн эхний

---

748 G. J. Ramstedt, Ein anlautender stimmloser Labial in der mongolisch-türkischen ursprache, JSFOu 32:2, 1916-1920, 1-10

749 P. Pelliot, Les mots à ***h***- initiale aujourd'hui amuie dans le mongol des mongol des XIII^{e} et XIV^{e} siècles, JA 206, 1925, 193-263

750 P. Aalto, On the Altaic Initial ****P***, CAJ 1, 1955, 9-16; N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studeis, 96-98; G. Doerfer, Altersstufen des Türkischen im Mongolischen **P*, *Mongolo-Tungusica* {= Tungusica 3}, Wiesbaden, 1985, 148-150; R. A. Miller, Proto Altaic **χ*, CAJ. 31, 1987, 16-63

шүргэх ***h***-гийн талаар N. Poppe, M. Lewicki, L. Ligeti, Х. Лувсанбалдан нар тодорхой дурдсан бий.[751]

Үгийн эхний гийгүүлэгчийн суларалын тухай тэмдэглэл. Орчин үеийн Халимаг, Ойрд, Буриад, Төв болон Өмнөд монгол хэлнүүдэд эгшигээр эхэлж байгаа үгсийн нилээд хувь нь хитад, араб-перс, дөрвөлжин үсэгээр тэмдэглэсэн дундад үеийн монгол хэлний бичигийн дурсхалуудад шүргэх ***h***-гээр эхэлсэн байгаа билээ. Мөн монгол хэлний хөгжилийн харьцангуй эртний шинжийг тусхасан Дунсян, Баоань, Шар Ёгур хэлнүүдэд ч гэсэн дээрхийн нэгэн адил төвөнхийн дуугүй, сул шүргэх *h* нилээд үгийн эхэнд уламжилан үлджээ.[752] Тэдгээрээс гадна Дагуур, Монгор, Дунсян, Баоань хэлнүүдэд хэлний угийн дуугүй шүргэх ***χ***, Монгор, Дунсян, Баоань хэлнүүдэд уруулын шүргэх ****f***-гийн ул мөр хадгалагдан үлдсэн байна.[753]

Алтайн төрөл хэлнүүдийн хувид гэвэл, Түрэг хэлний баруун ба зүүн өмнөд бүлэг хэлнүүд болон Иран дахь Халажи хэл, мөн Эвенки, Ламут хэлнүүд төвөнхийн шүргэх ***h***, Негидал, Орочи, Үдэ хэлнүүдэд хэлний хойгуур шүргэх ***χ***, Манжид уруулын шүргэх ***f*** тус тус тохиолдож байна.

Монгол хэл болон бусад төрөл хэлнүүдэд тохиолдож байгаа дээрхи гийгүүлэгчид нь угтаа өвөг алтайн хэлний хамжих ****ρ***-гээс гаралтай гэдэг нь эргэлзээгүй бөгөөд харин өвөг монгол хэлний үед мөн тийм хамжих гийгүүлэгч үгийн эхэнд байсан гэдэг нь эргэлзээтэй юм.

Өвөг алтайн хэлний үгийн эхний ****ρ*** нь хэлний хөгжилийн цаашдын явцад суларч хамжих шинжээ алдаад уруулын шүргэх ****f*** болсон нь өвөг түнгүүс болон өвөг монгол хэлэнд уламжилан үлдсэн бөгөөд өдгөө түүний ул мөр одоо ч зарим хэл аялгуунд байдаг тухай өмнө дурдсан билээ. Цаашид уул ****f*** нь улам суларан уруулын шинжээ алдаж хэлний хойгуур шүргэх ****χ*** болсон нь өдгөөгийн Монгор, Дагуур, Дунсян, Баоань хэлнүүдэд, түүний дараа сул шүргэх ***h*** болсон нь Дунсян, Баоань, Шар Ёгур хэлэнд тус тус уламжилан үлдсэн байна.

---

751 N. Poppe, Das mongolische Sprachmaterial einer Leidener Handschrift, 1030-1031; Монгольский словарь Мукаддимат ал-Адаб, 44-47; The Mongolian Monuments in hP'ags-pa Script, 22, 31; *idem.* On the Initial ***h*** in the Yüan-ch'ao Pi-shih, *The Bull. of the Inst. of History and Philology,* Academia Sinica, vol. 39, Part 2, Taipei, Taiwan, 1969, 267-275; Х. Лувсанбалдан, Эртний монгол хэлний үгийн эхний ***h***-гийн тухай, МС 4:1-7, 1962, 113-120; M. Lewicki, La langue mongole des transcriptions chinoises du XIVe siècle, Le Houa-yi yi-yu de 1389 {= *Travaux de la Société et des Lettres de Wroclaw*, Sér. A, Nr. 29}, Wroclaw, 1949, 111-112; L. Ligeti, Notes sur le vocabulaire mongol d'Istanboul, AOH 16, (1963, 142-145

752 Б. Х. Тодаева, Дунсянский язык, 13-14; Böke, Düngsiyan kelen-ü üges, 32-36; Баоаньский язык, 14; Э. Р. Тенишев, Б. Х. Тодаева, Язык желтых уйгуров, 50; Bulučilaγu, Jegün Yoγur kelen-ü üges, 44-49

753 Н. Н. Поппе, Дагурское наречие, 129-130; Б. Х. Тодаева, Дунсянский язык, 13; Баоаньский язык, 13-14; Монгорский язык, 35-37; Дагурский язык, 28-29

PM **fodun* 'од', // Cf. Mngr. *fõdi* id./, AM *(h)odun* [< *χodun] Precl. (= Bur.), MM *hodun* (MNT, Hy, D, Mu, IM, Ist.), CM *χoduŋ* (Dun.), *χodoŋ* (Bao.), *χodo* (Dag.) // *hodon* (SY.) // *odŏn* (Dör, Zakh, Kho.), *odoŋ* (Bur.), *odŏ* (Kha.)

PM **farban* 'арван', AM *(h)arban* Precl. (= Bod, Hin, Jig, Taq.), MM *harban* (MNT, Hy, D, Mu, IM.), CM *χarban* (Mngr, Dag.) // *harban* (SY.), *harwaŋ* (Bao.), *haruan* (Dun.) // *arban* (Bur.), *arwan* (Kha, ÖMon.)

PM **fekin* 'эхэн', (толгой), /Cf. Ma. *fexi* 'тарих', Gol. *pejə* 'магнай'/; AM *(h)ekin* [< *χekin] Precl. (= Sub.), MM *hekin* (Mu.), *heki* (MNT, KMQB.), CM *χeki* (Dag.), *χegi* (Mngr.) // *ekin* (Mog, Dör.)

PM **fulaγan* 'улаан', // Cf. Ma. *fulgān* id./, AM *(h)ulaγān* Precl. (= Bur.), MM *hula'ān* (MNT, Hy, Mu.), *hulān* (Mu, L.), CM *fulān* (Dun.), *fulaŋ* (Bao.) // χulān (Dag.) // *ulān* (Kalm, Oir, Bur, TMon, OMon.)

PM **füsün* 'үс', // Cf. Mngr. *fudze* id./, AM *(h)üsün* Precl. (= Alt, Taq, Bur, Sub.), MM *hüsün* (MNT, Hy, IM, Ist.), CM *χusu* (Dag.), *usun* (Mog.), *usuŋ* (Dun.), *üsə n* (Kalm, Oir.), *üheŋ* (Bur.)

Хэлний хойгуур шүргэх *χ нь зөвхөн эртний монгол хэлний үед, төвөнхийн шүргэх ***h*** нь гагцхүү дундад үеийн монгол хэлний үед л байсан гэж албаар зааглан тогтооход зарим талаар учир дутагдалтай мэт. Тухайлвал, биеэ даан үг, морфемийн утга ялгаж чадахгүй болсон төвөнхийн шүргэх ***h*** нь эртний монгол хэлний зарим аялгуунд байсан бололтой. Тийм учираас монгол бичигт анхнаасаа үгийн эхний шүргэх гийгүүлэгчийг тэмдэглэсэнгүй гэж үзэж болно. Дундад үеийн монгол хэлний бичигийн дурсхалуудад ч гэсэн тухайн нэг үгийг заримдаа ***h***-тэй, заримдаа ***h***-гүй тэмдэглэсэнээс үзвэл тэр нь фонемийн үүрэгээ нэгэнт алдсан боловч фонетик шинжээ хадгалсаар байсан бололтой.

MM *hasaγ-* 'асуу-', *hasag-*(MNT), *hasug-* (IM.), *hasa'ūlča-* (D.) // *asag-* (MNT, Mu.), id.

MM *heligen* 'элэг', *helige* (MNT, IM.), *helegen* (L.) // *eligen* (Hy, Mu.) id.

MM *huǰa'ūr* 'язгуур', *huǰa'ūr* (MNT, Hy, D, Ist.), *huǰawūr* (L.) // *uǰa'ūr* (Mu.), *uǰūr* (Mu.)

Жич: Орчин үеийн Ойрд, Төв болон Өмнөд монгол хэлний зарим аялгуунд үгийн эхний хамжих ***b***, ***q***, ***k*** зэрэг гийгүүлэгч сугарах тохиолдол байгаа бөгөөд энэ талаар судалаачид ажиглан тэмдэглэсээр иржээ.[754] Гэвч тэдгээр нь авианы тодорхой

---

[754] Х. Лувсанбалдан, Үгийн эхний ***x*** авиа гээгддэг цөөн үгийн учир, ХЗ. 2, 1964, 119-124; Э. Вандуй, Үгийн эхний зарим гийгүүлэгч гээгдэж байгаа нь, ХЗ 13:6, 1979, 54-56; М. Базаррагчаа, Үгийн эхний гийгүүлэгч гээгдэх нь, ХЗ. 20:3, 1984, 40-54

орчиноос шалтгаалан суларсангүй, харин тухайн үгэндээ үүрэгтүй болсоноос шууд сугарсан байна.

Mo. *qačar* 'хацар', TKha. *χatsar,* BKha. *atšir*
Mo. *qusuγur* 'хусуур', TKha. *χusūr,* BKha. *usūr*
Mo. *qudqu-* 'хутага', TKha. *χutχa-,* ÖKha. *udχa-*
Mo. *kituγa* 'хутага', TKha. *χutağa,* BKha, ÖKha, Ord, *utağa,* Oir. /= Ba, Dör, Kho. */utğa*
Mo. *köbči* 'хөвч', TKha. *χöwtši,* BKha. *öwtši*
Mo. *bargil* 'баргил', Kha. *bargil / argil*
Mo. *barǰaγar* 'барзгар', Kha. *bardzɒğar /ardzɒğar*
Mo. *kelterkei* 'хэлтэрхий', Kha. *χelterχī / elterχī*

Таширамд дурдахад, орчин цагийн монгол хэлэнд *'айван-тайван', 'армаг-тармаг', 'өд-сөд', 'өм-цөм'* гэх мэт өдий төдий хоршоо үгс байгаа бөгөөд тэдгээрийн бүрэлдэхүүн дэх хос хувилбар нь дээр дурдсанчилан үгийн эхний гийгүүлэгч сугарсан уу, эсвэл эгшигээр эхэлсэн үгийн эхэнд гийгүүлэгч нэмж үүссэн үү гэдэг асуудал өдгөө төдий л тодорхой биш байна.

2.3.2.2 ҮГИЙН ЭХНИЙ БУС ГИЙГҮҮЛЭГЧИЙН СУЛАРАЛ

2.3.2.2.1 **Үгийн дундах гийгүүлэгчийн суларал.**

§ 98. Үгийн дундах гийгүүлэгчийн суларал. Эртний монгол хэлний хоёр эгшигийн хоорондох шүргэх ***γ/g*** гийгүүлэгчийн суларан сугарсан хувьсалыг олонхи эрдэмтэд урт эгшиг үүсэн бүрэлдсэнтэй холбон авч үзсэн байна. Тухайлвал, G. J. Ramstedt, Б. Я. Владимирцов, Г. Д. Санжеев, N. Poppe зэрэг эрдэмтэд[755] монгол бичигийн хэлний хоёр эгшигийн дунд байсан ***-γ/g-*** гийгүүлэгч сугарсан тухай дурдсан нь уггаа үгийн дундах гийгүүлэгчийн суларалын тухай асуудал юм. Түүнчилэн K. Thomsen, Н. К. Верба, H. Kuribayashi нар эртний монгол хэлний ***uγa/üge*** гэсэн цогцын цаашдын хувьсалын талаар тусхайлан судалсан нь бас л хоёр эгшигийн дундах гийгүүлэгчийн суларалд холбогдоно.[756] Харин проф. Sh. Hattori *эртний монгол хэлний үгийн дунд хамжих[G], сул шүргэх [g]* гэсэн хоёр янзын «Г» байсан гэдэг таамаглалыг анх дэвшүүлсэн байна.[757] Тэрвээр дээр дурдсан хоёр өөр «Г»-гийн эхний хамжих гийгүүлэгч нь одоо хүртэл хадгалагдаж, сүүлчийн шүргэх

---

755 Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка, 22; Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка, 193; Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, 77-78; N. Poppe, Introduction to Comparative Studies, Helsinki, 1955, 60

756 K. Thomsen, Entwicklung der Gruppe ***uγa (*üge)*** im Mongolischen, AOH 23, 1958, 263-267; Н. К. Верба, Монгольские письменные сочетания ***V + j + i*** и репрезентация в современных монгольских языках, *'Вопросы грамматической системы монгольских языков',* Элиста, 1980, 40-52; H. Kuribayashi, The Development of ****uγa*** *and* ****üge*** in Mongolian, JLSJ. 85 (1985), 22-48

757 GK (Journal of the Linguistic Society of Japan), 1939, No. 3

гийгүүлэгч нь сугарч алга болсон гэжээ.[758] Энэ нь нэг талаар, сугарсан гийгүүлэгчийн дотоод мөн чанар, нөгөө талаас, түүний авианы гадаад орчиныг тодоруулсан шинэ, чухал дүгнэлт юм. Мөн профессор N. Ропре *'Монгол хэлний хоёр эгшигийн хоорондох тагнайн хамжих гийгүүлэгч'* гэдэг үгүүлэлдээ монгол бичигийн хэлэнд хоёр эгшигийн хооронд *сугардаг, сугардаггүй* хоёр янзын «Г»-байдаг тухай дурдаад цааш нь богино эгшигийн өмнөх ***g*** сугардаггүй, урт эгшигийн өмнөх ***g*** сугардаг болохыг тогтоожээ.[759] Ийнхүү хоёр эгшигийн хоорондох «Г»-гийн хэлэгдэх шинж, тохиолдох байрыг тодорхойлсон нь тухайн гийгүүлэгчийн түүхэн хувьсалын тухай асуудалыг ихээхэн урагшилуулжээ. Харин тухайн гийгүүлэгчийн суларан сугарсан шалтгааны талаар тодорхой дурдалгүй орхигдуулсан байна. Хожим академич Ш. Лувсанвандан хоёр эгшигийн дундах ***γ/g*** нь арынхаа урт эгшигийн нөлөөгөөр сугарсан гэж үзсэн нь тухайн гийгүүлэгчийн хувьсалын шалтгааныг авианы харилцан нөлөөлөлийн талаас авч үзсэн хэрэг юм.[760]

2.3.2.2.1.1 Шүргэх гийгүүлэгчийн суларал. Эртний монгол хэлний үед үүсмэл урт эгшигийн өмнө (өмнөө заавал богино эгшигтэй Д. Т.) орж байсан шүргэх ***-γ/g-*** гийгүүлэгч нь арынхаа урт эгшигийн нөлөөгөөр суларан суларсаар дундад үеийн монгол хэлний үед бүрмөсөн сугарчээ. Монгол хэлний урт эгшиг нь уулаасаа **VCV** (= aγa, aγu, ***ege, egü*** гэх мэт) цогцын дотор үүссэн бус, харин өмнөө богино эгшигтэй шүргэх ***γ/g***-гийн арын өргөлтөт эгшигээс үүссэн учир уул ***-γ/g-*** гийгүүлэгчийн сугарал нь урт эгшиг үүсэхийн шалтгаан болсон бус, харин нэгэнт үүсчихсэн урт эгшигийн нөлөөгөөр суларан сугарсан хэрэг юм. Өөрөөр хэлвэл, өмнөө богино эгшигтэй, ардаа урт эгшигтэй шүргэх ***-γ/g-*** гийгүүлэгч л арынхаа эгшигийн нөлөөгөөр сулардаг байна.

Үгийн дунд, хоёр эгшигийн хооронд байсан шүргэх ***γ/g*** нь авианы харилцан нөлөөлөлийн хуулиар суларах явцдаа зэрэгэлдээх авианыхаа хэлэгдэх онцлог шинжээс шалтгаалан хэд хэдэн өөр хувилбарыг дамжсан байна. Тэдгээр хувилбарууд нь бие биеэ нөхсөн авианы бүрхэвчийн ялгаа бүхий нэг фонемийн хувилбарууд юм.

$$\emptyset < h < \gamma/g$$

Хэрэв шүргэх ***γ/g***-гийн арын эгшиг нь ерийн урт ***ā*** (< á), ***ē*** (< é) байсан бол тэр нь суларахдаа төвөнхийн сул шүргэх ***h*** болж, уламаар цаашдаа бүрмөсөн сугарсан байна. Харин дундад үеийн монгол хэлний бичигийн дурсхалуудад уул шүргэх ***γ/g***-гийн хувилбарыг ялган тэмдэглэсэн жишээ нэн ховор байна. Учир нь төвөнхийн сул шүргэх ***h*** нь хоёр эгшигийн хоорондоос сугарсан гийгүүлэгчийн байранд үлдсэн үе зааглах төдий үүрэг бүхий амисхалын түрэлтээс фонетикийн талаар ч,

---

[758] Sh. Hattori, The Length of Vowels in Proto Mongolian, *'Mongolian Studies'*, Budapest, 1970, 186-194

[759] N. Poppe, On the Velar Stops in Intervocalic Position in Mongolian, UAJb. 31 (1959), 270-271

[760] Ш. Лувсанвандан, Орчин цагийн хэлний урт эгшгийн гарлын тухай асуудалд, 5-26

фонологийн талаар ч төдий л ялгаагүй байсан тул түүнийг их төлөв авиа зааглах тэмдэгээр тэмдэглэсэн байна.

PM **qayan* 'хаан', AM *qayān* Precl. (= Bod, Hin, Jig, Chan.), MM *qahān* (MNT, KMQB, Hy.) >*qa'ān* (MNT, Tk, D, Ist.) >*qān* (L.)

PM **bayatur* 'баатар', AM *bayātur* Precl. (= Hin, Bur, Sub.), MM *bahātur* (IM, L.) > *ba'ātur* (MNT, Hy.) > *bātur*// Cf. *bādur* (Mu.)

PM **gegegen* 'гэгээн', AM *gegegēn* Precl. (= Bod, Jig, Hin, Bur.), MM **gegehēn* > *gege'ēn* (MNT, KMQB, D, Hy.) >*gegēn* (MNT, Mu.)

PM **temegen 'тэмээ'*, AM *temegēn* Precl. (= Cf. *temegēd* Turf.), MM **temehēn* > *teme'ēn* (MNT, Hy, Tk.) >*temēn* (Mu.)

Ø< w <γ/g

Хэрэв шүргэх ***γ/g***-гийн арын эгшиг нь уруулын, урт ***ū*** (< u), ***ǖ*** (<ü) байсан бол тэр нь сулархдаа уруулын шүргэх ***w*** болж, уламаар цаашдаа бүрмөсөн сугарчээ. Дундад үеийн монгол бичигийн дурсхалуудад уул шүргэх ***w***-г зохих хэмжээгээр тусхасан байна.

PM **bayu-* 'буу-', AM *bayū-* Precl. (= Čin, Ar 2, Jig, Sul.), MM *bawū-* (MNT, Hy.) > *ba'ū-* (D, Mu.)

*PM *dayun* 'дуу', AM *dayūn* Precl. (= Bod, Chang, Taq.), MM *dawūn* (MNT, Hy.) > *da'ūn* (Mu.)

PM **sibayun* 'шувуу', AM *sibayūn* Precl. (= Sul, CTB, Hin.), MM *šibawūn* (MNT, Hy, L.) > *šiba'ūn* (D, Mu, L.)

PM **ǰegün* 'зүүн', AM *ǰegǖn* Precl. (= Hin, Qqot, Bur.), MM *ǰewǖn* (MNT, L.) > *ǰe'ǖn* (Hy, Mu.)

PM **negü-* 'нүү-', AM *negǖ-* Precl. (= Hin, Qqot, Ked.), MM *newǖ-* (MNT) > *ne'ǖ-* (KMQB, Mu.)

PM **següder'* сүүдэр', AM *segǖder* Precl. (= Aruγ, Taq, Bur.), MM *sewǖder* (Hy, Tk.) > se'üder (MNT, Mu, IM.)

Ø < y < γ/g

Хэрэв шүргэх ***γ/g***-гийн арын эгшиг нь тагнайн урт ***ī*** (< i) байсан бол тэр нь цаашид сулархдаа тагнайн шүргэх ***y*** болж, уламаар бүрмөсөн сугарсан байна. Түүнийг сонгодог бичигийн өмнөх монгол бичигийн дурсхалууд болон дундад үеийн монгол хэлний дурсхалуудад тодорхой тусхасан байна. Урт ***i*** эгшигийн

өмнөх ***γ/g*** гийгүүлэгч шүргэх ***y*** болсон нь зөвхөн суларал төдийгүй, тагнайшил учираас тэр нь бусад шүргэх гийгүү-лэгчид ***/= h, w/***-ээсээ харьцангуй өмнө, тухайлвал, эртний монгол хэлний сүүлч үеэр үүссэн байна.

PM **sayïn* 'сайн', AM *sayīn* [<*saγi̯ n] Precl. (= Bod, Aruγ, Öl, Qqor.), MM *sayīn* (MNT, KMQB, Hy, D, Mu, IM, L, Ist.) > *saīn* (Mu, IM.)

PM **tegimü* 'тийм', AM *teyīmü* [< *tegīmü] Precl. (= Taq, Bur.), MM *teyīmü* (MNT) >*te'īmü*> *ti'īmü*> *tīm* (Mu.)

PM **oγïra* 'ойр', AM *oyīra* [< *oγi̯ ra] Precl. (= Öl, Sul, Hin, Chang.), MM *oyīra* (MNT, KMQB, Hy, Mu, IM.) > *oīra* (Mu, L, Ist.)

PM **uγïla-* 'уйл-', AM *ugīla-* Precl. (= Bur.) > *uyīla-* (Taq.), MM *uyīla-* (MNT) > *u'īla-* > *uīla-* (Mu, IM, L.)

Дундад үеийн монгол хэлний шүргэх ***γ/g***-гийн арын урт эгшигүүд нь түүнийг суларуулах нөлөөтэй байсан бол өмнөх богино ***i*** эгшиг болон ***ǰ, č, š*** зэрэг гийгүүлэгчид нь түүнийг тагнайшуулах нөлөөтэй байжээ. Гэвч тийм хоёр өөр нөлөөлөлийн үр дүнд гагцхүү хэлний дундуур, сул шүргэх ***y*** гийгүүлэгч л үүссэн байна. Учир нь гэвэл, уул ***y*** гийгүүлэгч нь нэг талаар ***γ/g***-гийн суларсан хувилбар, нөгөө талаар, мөн түүний тагнайшсан хувилбар юм.

PM **atïya* 'ачаа', AM *ačiyān* [< *ačiγān], MM *ačiyā* (Ist.) > *ači'ā* (MNT, Mu, IM.)

PM **tarïyačin* 'тариачин', AM *tariyāčin* [< *tariγāčin] Precl. (= Sub.), MM *tariyāčin* (MNT, Ph.) ~ *tariyāči* (Hy.) >*tari'āči* (Mu.)

PM **kedige* 'хэзээ', AM *keǰiyē* [< *keǰigē] Precl. (= Bod, Bur, Sub.), MM *keǰiyē* (Mu.) > *keǰi'ē* (MNT, Ph.)

PM **ǰöbsige-* 'зөвшөө-', AM *ǰöbsiyē-* [< *ǰöbsigē-] Precl. (Ar. 2, Sub.), MM *ǰöbšiyē-* (MNT) > *ǰöbši'ē-* (KMQB.)

Таширамд тэмдэглэхэд, шүргэх ***γ/g*** гийгүүлэгчийн суларах явцад үүссэн [h, w] зэрэг хувилбарууд нь монгол хэлний түүхэн хөгжилийн маш богино зурвасхан үеийг эзэлэх бөгөөд харин тагнайшсан [y] хувилбар нь эртний монгол хэлний сүүлч үеэс дундад үеийн монгол хэлний сүүлч үе хүртэл хэлэгдэх байдалаа хэвээр хадгалсаар байжээ.

2.3.2.2.1.2 Хамжих гийгүүлэгчийн суларал. Монгол хэлний урт эгшигийн гаралыг судалсан эрдэмтэд эртний монгол хэлний үед хоёр эгшигийн хооронд байсан ***b, m*** зэрэг хамжих гийгүүлэгчийн сугаралын тухай олонтаа тэмдэглэсэн байдаг билээ. Гэвч тэдгээрийн сугарсан нөхцөл, шалтгааны талаар тодорхой дурдсан зүйл бараг үгүй байна.

Монгол хэлэнд хоёр эгшигийн хооронд байсан хамжих ***b*** суларан сугарсан цөөн тохиолдол бий бөгөөд түүнийг бичигийн дурсхалд тэмдэглэсэн нь ч бүр ч цөөн юм.

PM **γoba* 'гоо', AM *γowa* [< *γoba] (Mo.), MM *γowā* (Mu.) > *γo'ā* (MNT, Mu.) > CM *ǧō* (Kh.)

PM **čobaqur* 'цоохор', AM **čobāqur* > MM *čowāqur* > *čo'āqur* > *čo'ōqur* > *čōqur* (Mu.) > CM *tšōχor* (ÖMon.)

Зарим залгавар морфемийн бүтэцэн дэх уруулын хамжих **b* гийгүүлэгч ч мөн арынхаа урт эгшигийн нөлөөгөөр суларан сугарсан байна.

MM dawū-bār (MNT) > dawū-'ār (MNT)
MM önge-bēr (MNT) > önge-'ēr (MNT)
MM hači-bān (MNT) > hači-'ān (MNT)
MM dotora-bān (MNT) > dotora-'ān (MNT)
MM yabubāsu (MNT) > yabu'āsu (MNT)
MM surabāsu (MNT) > sura'āsu (MNT)

Дээр дурдсанчилан урт эгшигийн өмнө орсон уруулын хамжих ***b***-гээс гадна өдгөөгийн Дагуур, Халимаг, Ойрд, Төв болон Өмнөд монгол хэлнүүдэд богино эгшиг болон ***b, l, m, n, ŋ***-гээс бусад гийгүүлэгчийн дараа орсон хамжих ***b*** нь суларан, шүргэх ***w*** болсон бөгөөд тэр нь Дагуур хэлэнд бүр хагас эгшигийн шинжтэй, тэр ч байтугай заримдаа урт эгшиг болсон тохиолдол ч байна. Уруулын хамжих ***b*** гийгүүлэгч тийнхүү урт эгшиг болсон жишээ Ойрд, Төв монгол хэлний зарим аялгуунд ч бас бий билээ.

Mo. yabu-, TMon. ÖMon. jaw-, Dag. jau- *'яв-'*
Mo. qabur, TMon. ÖMon. χawar, Dag. χaur *'хавар'*
Mo. ebed-, TMon. ÖMon. öwöd-, Dag. eude- *'өвд-'*
Mo. ebesün, TMon. ÖMon. öwös-, Dag. euse *'өвөс'*
Mo. arbin, TMon. Ord. arwin, Dag. arūn, Oir. ärūn *'арвин'*
Mo. tataburi, TMon. tatwar / tatūr, Oir. tatūr *'татвар'*
Mo. bolbasun, TMon. bolowson, Oir. bolūsan *'боловсон'*
Mo. belbisün, TMon. belewsen, Oir. belūsen *'бэлэвсэн'*
Mo. toγtaburi, TMon. toχtowor, ÖKh. toχtūr, Oir. toktūr *'тогтвор'*
Mo. bolbasu, TMon. bolwol / bolūl *'болвол'*

Хоёр эгшигийн хоорондох уруулын хамжих ****m***-ийн хувид гэвэл, тэр нь авианы тодорхой орчин, тухайлвал, урт эгшигийн өмнө орсон нөхцөлд арынхаа эгшигийн нөлөөгөөр суларан сугарах ямар ч боломжгүй юм. Тэгвэл сонгодог бичигийн өмнөх үеийн бичигийн дурсхалуудад байсан *kümün, keme-, qamiγa* гэх мэт үгс дундад үеийн монгол хэлний дурсхалуудад яагаад *kü'ün, ke'ē-, qa'ā* болсон бэ гэдэг асуудал зүй ёсоор гарна. Дээр дурдсан үгсийн урт эгшиг бүхий хувилбарууд дундад үеийн монгол хэл болон орчин үеийн монгол хэлнүүдэд байгаа нь угтаа уул хамжих ****m*** гийгүүлэгч суларан сугарсаны үр дүнд үүссэн бус харин суларан

сугарах боломж бүхий өөр хувилбар авианы хувьсалын үр дүнд үүссэн гэж бид үзэж байна. Тэгвэл тэр нь ямар авиа байсан бэ? Бидний бодоход, эртний монгол хэлний хоёр эгшигийн хооронд байсан уруулын хамжих ***m*** нь мөн уруулын хамжих ****b***-тэй сэлгэдэг байсан бололтой. Хэрэв тийм байсан бол дээр дурдсан үгс нь *kümün̄/kübün̄, kemē/kebē-, qamiγā/qabiγā* гэсэн зэрэгцээ хувилбартай байгаад хоёрдугаар хувилбарын доторхи хамжих ***b*** гийгүүлэгч суларан шүргэх ***w*** болж, уламаар цаашид бүрмөсөн сугарсанаас дээр дурдсан хувилбарууд үүссэн гэж үзэж болно. Үүнийг батлах нэг сонин баримт бол сонгодог бичигийн өмнөх зарим бичигийн дурсхалд *qamiγā* гэсэн үгийн *qabiγā* (Bur, Sub.) гэсэн хувилбар юм.

Орчин үеийн монгол хэл аялгуунуудад *kümün̄, qamiγā* гэсэн үгсийн *kümən* (Kalm, Oir.), *χamā* (Kalm, Oir.), *χämǟ* (Gor, Jas.) гэх мэт хувилбарууд байгаагаас гадна мөн түүний **kübün̄, qabiγā* гэсэн хувилбаруудаас үүссэн *kün̄* (Kalm, Oir, Barg, Bokh.), *kün̄ŋ* (Ha, Alar, Khori.), *χā* (Bur, TMon, ÖMon.) зэрэг үгс тохиолдож байна.

Жич: Үгийн дундаас сугарсан дээрхи гийгүүлэгчээс гадна эртний монгол хэлэнд их төлөв шүргэх ***s***-ээр эхэлсэн үеийн өмнө үе хааж орсон ***l, r*** гийгүүлэгч сугарсан жишээ нилээд тохиолдож байна. Гэвч энэ нь зэрэгэлдээх авианыхаа давамгайлах нөлөөнөөс шалтгаалсан бус, харин тухайн үгийнхээ хувид утга ялгах үүрэгээ алдсантай холбоотой байж магадгүй юм. Эсвэл үгийн үндэсэн дээр ***-ls-*** гэсэн гийгүүлэгчийн дараалал алдагдсанаас ч шалтгаалсан байж болно.

AM *mölsün* ‘мөс’, Precl. (Taq.), MM *mölsün* (MNT, Hy, Tk, Mu, L, Ist.), CM *mulihen̄* (Khori.), *mülühün̄* (Alar.), *mordze* (Mngr.), *mesun̄* (Dun.), *mešu* (Bao.), *mosen* (SY.), *meis* (Dag.), *mösön* (Dör.), *mösü* (Ord.), *mösö* (TMon.)

AM *čaγālsun /čaγārsun* ‘цаас’, (Mo.), MM *ča'ālsun* (MNT, Hy.), *čālsun* (Mu.), CM *čāldze* (Mngr.), *sārhan* (Bur.), *tsāse* (SY.), *tšāsu* (Ord.), *tsāsɒn* (Kalm.), *tšās* (ÖMon.), *tsās* (TMon.)

AM *qimulsun* ‘хумас’, Precl. *kimusun* (Bur.), MM *qimusun* (Mu.), *kimusun* (Hy.), *kimul* (MNT), CM *qimsun* (Mog.), *tšimudze* (Mngr.), *ǧumusun̄* (Dun.), *ǧomson̄* (Bao.), *kimič* (Dag.), *χumsɒn* (Kalm.), *χumŭsŭn* (Oir.), *χumusu* (Ord.), *χumas* (Bur, TMon.)

AM *yutulsun* ‘гуталт’, Precl. *yutusun* (Sub.), MM *yutusun* (Mu.), CM *ǧudusun* (Dun.), *kutusun* (Bao.), *ǧutuse* (Mngr.), *ǧutul* (Ord.), *ǧutahan̄* (Alar.), *ǧutal* (Bur, TMon, ÖMon.)

AM **χaryalsun* ‘аргал’, MM *haryal* (Mu, IM.), CM *arǧasan* (Oir.), *χarǧal* (Dag.), *harǧal* (SY.), *arǧal* (Bur, TMon, ÖMon.), *arǧāhan* (Alar.), *arǧasa* (Tson.)

AM **kölersün* ‘хөлөс’, Precl. *kölesün* (Bur.), *kölüsün* (Sub.), MM *kölesün* (MNT, Mu, L.), *kölösun* (Hy.), *köler* (IM.), CM *kuonordze* (Mngr.), *koliesun̄* (Dun.), *kölsün* (Dör.), *kölöhön̄* (Khori, NÜd, Tünk.), *kölösü* (Ord.), *kölsə n* (Kalm.), *χölös* (TMon.)

AM **kögērsün* ‘хөөс’, MM *kö'ēsün* (Mu.),CM *kōrdze* (Mngr.), *kō̄rsü* (Ord.), *kō̄sən* (Kalm, Oir.), *χō̄hen* (Bur.), *kō̄se* (Dag.), *χō̄s* (TMon.)

2.3.2.2.2 Үгийн эцэсийн гийгүүлэгчийн суларал

§ 99. Үгийн эцэсийн гийгүүлэгчийн суларал. Дундад үеийн монгол хэлний онцлогийн тусхасан хитад, дөрвөлжин үсэгээр тэмдэглэсэн дурсхалуудад үгийн эцэсийн *γ/g-* гийгүүлэгч болон олон тооны ***-ud/-üd*** дагаварын өмнөх гийгүүлэгч суларан сугарсан жишээ нилээд нийтлэг тохиолдож байна. Гэвч энэ нь тухайн гийгүүлэгчийн түүхэн хувьсал биш, зөвхөн урт эгшигээр эхэлсэн дагаварын өмнө, морфемийн заагт түүний шүргэх шинж давамгайлсантай холбогдох түр зуурын суларал юм. Тийм ч учираас тэрхүү гийгүүлэгч авианы өөр орчинд бүрэн хэлэгдэж байна.

Mo. *čerig-üd* ‘цэрэгүүд’, MM *čeri'ūd* (MNT, KMQB, Ph.), Cf. *čerig* (MNT, Hy, D, Mu.), *čerik* (L.)

Mo. *uruγ-ud* ‘урагууд’, MM *uru'ūd* (MNT), Cf. *uruq-ud* (D.), *uruγ* (MNT, KMQB.), *uruq* (Mu.)

Mo. *ǰarliγ-ud* ‘зарлигууд’, MM *ǰarli'ūd* (D.), Cf. *ǰarliγ* (MNT, KMQB), *ǰarliq* (D, Mu.)

Mo. *külüg-üd* ‘хөлөгүүд’, MM *külü'ūd* (MNT), Cf. *külüg* (MNT, Ph.)

Mo. *inaγ-ud* ‘янагууд’, MM *ina'ūd* (MNT), Cf. *inaq* (Mu.)

Mo. *ayimaγ-ud* ‘аймагууд’, MM *ayima'ūd* (D.), Cf. *ayimaγ* (MNT, KMQB.), *ayimaq* (Mu.)

Гийгүүлэгч авианы суларалын тухай нэмэлт тэмдэглэл

Орчин үеийн монгол хэл аялгуунуудын гийгүүлэгч авианы суларал нь их төлөв бидний дээр дурдсанчилан сугаралаар илэрэхээс гадна бас заримдаа солигдолоор илэрч байна. Гийгүүлэгч авианы ийм хувьсалыг гагцхүү авианы сэлгэлт, солигдолоор тайлбарласаар ирсэн бол профессор В. И. Рассадин түүнийг авианы суларалтай холбон тайлбарлажээ.[761] Өдгөөгийн монгол хэл аялгууны гийгүүлэгчийн суларалыг ажиглавал тэдгээр нь эрчимтэй тод хэлэгдэх хам шинжээ алдсаар эцэсийн эцэст шүргэх шинжтэй болсон бөгөөд тэр нь тухайн авианы байрлалаас шалтгаалан үгийн аль ч үед тохиолдож болдог байна.

[761] В.И. Рассадин, Очерки по исторической фонетике бурятского языка, 132-161

Хамжих гийгүүлэгчийн суларал

χ < *q

Хэлний хойгуурхи эгшигт үгэнд ордог хамжих ***q*** нь өдгөөгийн Монгор, Могол, Дунсян хэлэнд хамжих ***q***, ***g***, буриад хэлний зарим аялгуун /= Доод Үд, Ононы Хамниган/-д мөн хамжих ***k***, ***k***^{x}, бусад хэл аялгуунуудад хэлний хойгуур шүргэх ***χ*** болжээ. Өөрөөр хэлбэл, дээр нэр дурдсанаас бусад хэл аялгуунуудад эртний монгол хэлний хамжих ***q*** гийгүүлэгч хэлэгдэх байдалаараа суларч шүргэх гийгүүлэгч болсон байна.

PM **qadiγar* 'хазаар', AM *qaǰaγār* [< *qaǰiγār] (Mo.), MM *qada'ār* (Hy.), *qadār* (MNT, Mu, L, Ist.), CM *qadār* (Mog.), *χadžār* (Ord, Cha.), *χadzār* (Oir, TMon.), *χazār* (Bur.)

PM **qoniǐn* 'хонь', AM *qonin* Precl. (= Ber.), MM *qonin* (Mu, Ist.), *qoni* (Tk, IM, L.), CM *qonin* (Mog.), *qoni* (Dun.), *χonin* (Bur.), *χoni* (Mngr, Dag, Bokh, Sart, Ord, Kha.), *χ̄ön* (Kalm, Oir.), *χön* (ÖMon.), *χōne* (SY.)

PM **qurdun* 'хурдан', AM *qurdun* Precl. (= Sul, Sub.), MM *qurdun* (MNT, Mu, IM, L, St, HQ.), CM *qurdun* (Mog.), *ǧurdun* (Mngr.), *ǧudun* (Dun.), *ǧordon* (SY.), *χurdun* (Kul, Ord.), *χurdan* (Bur, TMon, ÖMon.)

PM **qïmulsun* 'хумас', AM *kimusun* [< *qimulsun] (Mo.), MM *qimusun* (Mu.), *qimusu* (Mu.), *kimul* (MNT), *kimusu* (MNT), *kimusun* (Hy.), CM *qimsun* (Mog.), *qemsun* (Man, Mar, Zir.), *kimitš* (Ha.), *kimetši* (But.), *kimtši* (Kul.), *kumuhun* (NÜd.), *χumusun* (Dör, Zakh, Kho.), *χumsʊn* (Kalm.), *χumas* (Kha, Cha, Učab, AKhor, Naim, Šgol.)

χ < *k

Хэлний урдуурхи эгшигт үгэнд ордог хамжих ***k*** нь орчин үеийн олонхи хэл аялгуунуудад хэвээр хадгалагдан үлдсэн бөгөөд харин Төв болон Өмнөд монгол, Буриад хэлний ихэнхи аялгуунуудад шүргэх ***χ*** болсон байна.

PM **kelen* 'хэл', AM *kelen* Precl. (= Bod, Bur.), MM *kelen* (MNT, Hy, Tk, Mu, L, Ist.), CM *kelan* (Mog.), *kilie* (Mngr.), *kielien* (Dun.), *kelen* (SY.), *kelə n* (Kalm, Oir.), *kelen* (NÜd.), *kele* (Ord.), *keli* (Dag.), *χele* (Bur.), *χelə* (TMon, ÖMon.)

PM **kökü* 'хөх', AM *kökü* Precl. (= Bur.), MM *köken* (Mu, L.), CM *koka* (Mog.), *kuguo* (Mngr.), *kökön* (Dör.), *kökʊn* (Zakh.), *kökə n* (Kalm.), *kökün* (NÜd.), *gök*^{x}*ö* (Ord.), *χöχö* (TMon, ÖMon.), *χuχe* (Bur.)

PM **küǰügün* 'хүзүү', AM *küǰügūn* Precl. (= Bur, Sub.), MM *küǰü'ūn* (Hy, Mu.), *küǰeūn* (L.), *küǰūn* (Mu, IM, L, Ist.), CM *kudžūn* (Mngr.), *küdžūn* (Dör, Ba, Zakh, Kho.), *kudzū* (Dag.), *küzūn* (Kalm, Tor.), *küzūn* (NÜd.), *χüdžū* (ÖMon.), *χüdzū* (TMon.), *χüzū* (Bur.)

PM **kümün/kübün* 'хүн', AM *kümün* Precl. (= Bod, Chang, Jig, Hin.), MM *kümün* (Mu.), *kü'ün* (MNT, KMQB, Hy, Tk, D, Mu.), *kün* (Mu, IM, L.), CM *kümün* (Oir.), *kümə n* (Kalm.), *kün* (Kalm.), *küŋ* (Dag, NÜd.), *kü* (Mngr, Dun, Bao, SY, Zir, Kun, Ha.), *χün* (Bur, TMon, ÖMon.)

w < *b

Хоёр уруулын хамжих ****b*** гийгүүлэгч олонхи хэл аялгуунд хэлэгдэх байдалаа хэвээр хадгалж ирсэн боловч үгийн дунд хоёр эгшигийн хооронд, эсвэл анирт гийгүүлэгчийн өмнө болон ***b, l, m, n, ŋ***-ээс бусад гийгүүлэгчийн дараа орохдоо суларч шүргэх ***w*** болсон байна. Мөн үгийн эцэсийн хамжих ****b*** гийгүүлэгч ч суларч, шүргэж хэлэгдэх болсон жишээ элбэг тохиолдож байна. Ер нь хамжих ****b*** сулрах ийм хувьсал нь Халимаг, Ойрд, Төв болон Өмнөд монгол хэлнүүдэд илүү нийтлэг тохиолдож байна.

PM **ebül* 'өвөл', AM *ebül* Precl. (= Bur, Sub.), MM *übül* (MNT, Hy, Tk, Ph.), *ebül* (Mu.), *öbül* (Mu, IM.), CM *ubul* (Mog, Bur.), *ubun* (Dun.), *öwöl* (TMon, ÖMon.), *üwül* (Oir.), *uwel* (SY.)

PM **ǰobalaŋ* 'зовлон', AM *ǰobalaŋ* Precl. (= Bod, Bur, Sub.), MM *ǰobolaŋ*(MNT, KMQB, Hy.), *ǰobalaŋ* (Mu, IM.), CM *džobolon* (Kul.), *zoboloŋ* (Bur.), *džowoloŋ* (Ord.), *dzowoloŋ* (TMon.), *dzowlan* (Ba, Dör, Kho.), *zowlun* (Tor, Ur, Zakh.), *džowloŋ* (ÖMon.)

PM **farban* 'арван', AM *(h)arban* [< *χarban] Precl. (= Bod, Hin, Jig, Taq.), MM *harban* (MNT, KMQB, Hy, Tkm D, Mu, IM, L.), CM *χarban* (SY, Kul.), *arban* (Zir, Dag, Bur.), *χarwan* (Mngr.), *harwaŋ* (Bao.), *arwan* (TMon, ÖMon.)

Хамжин шүргэх гийгүүлэгчийн суларал

š < *č

Эртний монгол хэлний үед тагнайн ***i*** (< *ï, *i) -гийн өмнө орж байсан хамжин шүргэх ***č*** (= tš) нь өдгөөгийн буриад хэлний олонхи аялгуу, Өмнөд монгол хэлний Горлос, Жалайд, Дөрвөд, Хорчин зэрэг аялгуунуудад суларч, хамжих шинжээ алдаад, шүргэх ***š*** болсон байна. Мөн Дагуур хэлэнд ч иймэрхүү жишээ хааяа тохиолдож байна.

Mo. *činu-a* 'чоно', MM *činō* (MNT), *čino* (Hy.), *čina* (Mu, HQ.), CM *šono* (Alar, Barg, Ekh-Bul, Kach, Kham, Khori, Tünk, Gor, Dör, Jal, Khor.)

Mo. *čisun* 'цус', MM *čisun* (MNT, L.), CM *šuhan* (Khori, Bokh, Alar.), *šuhun* (NÜd, Tünk.), *šuhu* (Bar.), *šus* (Khor.), *šut* (Jal, Dör.)

Mo. *čilaγūn* 'чулуу', MM *čilawūn* (MNT, Hy.), *čila'ūn* (MNT, Ph.), CM *šulūn* (Barg, Tünk, Gor, Jal, Khor, Dör.), *šuluŋ* (Khori.)

Мо. *čimüge* 'чөмөг', ММ *čimegen* (Hy.), СМ *šimuge* (Dag.), *šimug* (But.), *šumug* (Ha.), *šömög* (Jal, Gor, Dör, Khor.)

Мо. *čikin* 'чих', ММ *čikin* (MNT, Hy, IM, L, Ist.), СМ *šiken* (NÜd.), *šix* (Jal, Gor, Dör, Khor.), *šexen* (Khori, Tünk.), *šexe* (Ekh-Bul.)

s < *č

Эртний монгол хэлний үед *i*-гээс бусад эгшигийн өмнө орж байсан хамжин шүргэх ***tš*** гийгүүлэгч нь өдгөөгийн Буриад хэлний олонхи аялгуу, Өмнөд монгол хэлний Горлос, Жалайд, Дөрвөд, Хорчин зэрэг аялгуунд суларч, хамжих шинжээ алдаад шүргэх ***š, s*** болжээ.

Мо. *čaγān* 'цагаан', ММ *čaγa'ān* (MNT, Ph.), *čaγān* (Mu, IM, Ist.), СМ *sağān* (Alar, Barg, Ekh-Bul, Khori, Tünk.), *šağān* (Jal, Gor, Khor, Dör.)

Мо. *časun* 'цас', ММ *časun* (MNT, Mu, Hy, IM, L, Ist.), СМ *sahan* (Alar, Barg, Ekh-Bul, Kach, Khori, Tünk.), *šas* (Gor, Jal, Khor, Dör.)

Мо. *čečeg* 'цэцэг', ММ *čeček* (Hy, Mu, IM.), СМ *seseg* (Alar, Barg, Ekh-Bul, Kach, Khori, Tünk.), *šišeg* (Gor, Jal, Khor.)

Мо. *qačar* 'хацар', ММ *qačar* (MNT, Hy, Mu, IM, L.), СМ *χasar* (Alar, Khori, Tünk, Barg, Ekh-Bul, Kach.), *χašar* (Gor, Jal, Khor, Dör.)

dz, dš < *č

Төв монгол хэлний Дорнод халх, Дариганга аялгуу болон Өмнөд монгол хэлний зонхилох аялгуунууд, мөн Дунсян, Шар Ёгур хэлний зарим цөөн үгэнд анирт чанга гийгүүлэгчийн өмнө орсон хамжин шүргэх ***tš***гийгүүлэгч нь суларч, түрэлтээ алдаад ***dž, dz*** болсон байна.

Мо. *časun* 'цас', ММ *časun* (MNT, Hy, Mu, IM, L, Ist.), СМ *džasuŋ* (Dun.), *džasen* (SY.), *džasu* (Ord.), *džas* (Cha, Kesh.), *dzas* (DKha, Dg.)

Мо. *čidkür* 'чөдхөр', ММ *čitkür* (IM.), *čitkör* (Hy.), СМ *džödgör* (DKha, Dg, Cha, Ord, Šgol, Onn, Naim.)

Мо. *čikin* 'чих', ММ *čikin* (MNT, Hy, Tk, IM, L, Ist.), СМ *džixe* (Ord.), *džix* (DKha, Dg, Cha, Šgol, Onn, Naim, Kesh.)

Мо. *čisun* 'цус', ММ *čisun* (MNT, L.), *džusu* (Ord.), *džus* (Cha, Učab, Onn, Naim, Kesh.), *dzus* (DKha, Dg.)

j < *ǰ

Эртний монгол хэлний үед тагнайн ***i*** (< *ï, *i)-гийн өмнө байсан хамжин шүргэх ****j*** (= d) нь орчин үеийн олонхи хэл аялгуунуудад хэлэгдэх байдалаа хэвээр хадгалсаар ирсэн боловч буриад хэлний зарим аялгуунд хамжих шинжээ алдаж, шүргэх ***j*** болсон байна.

Mo. *ǰiryal* 'жаргал', MM *ǰiryalan* (MNT, Hy.), CM *jarğalaŋ* (Alar.), *jarğal* (Barg, Ekh-Bul, Bokh, Kach.), *žarğalaŋ* (Khori.)

Mo. *ǰida* 'жад', MM *ǰida* (MNT, Hy, Tk, Mu, IM, Ist.), CM *jada* (Barg, Bokh, Ekh-Bul, Kach.), *žada* (Khori.)

Mo. *ǰil* 'жил', MM *ǰil* (MNT, KMQB, D, L.), CM *jil* (Bokh.),*jel* (Barg, Ekh-Bul, Kach.), *žel* (Khori.)

Mo. *ǰiruγā* 'жороо', MM *ǰoriya* (L.), *ǰoria* (Ist.), CM *jorō* (Barg, Ekh-Bul, Kach.), *orō* (Khori.)

Жич: Хамжин шүргэх ****ǰ*** гийгүүлэгчийн сураалтай холбогдуулан буриад хэлний олонхи аялгуунд (= Сартуул, Цонгоолоос бусад) уул гийгүүлэгч нь *ž, z* болсоныг дурдвал зохино.

Шүргэх гийгүүлэгчийн суларал (*h*<*s*). Бүр өвөг монгол хэлний үеэс уламжилан ирсэн шүргэх ***s*** гийгүүлэгч нь орчин үеийн олонхи хэл аялгуунуудад уулын хэлэгдэх шинжээ хэвээр хадгалсаар ирсэн бөгөөд гагцхүү буриад хэлний ихэнхи аялгуунд (= Сартуул, Цонгоол, Хамниганаас бусад) суларч төвөнхийн шүргэх ***h*** болжээ. Өдгөөгийн олон монгол хэлнүүдийн дотороос зөвхөн буриад хэлний гийгүүлэгчийн тогтолцоонд гарсан энэхүү өвөрмөц хувьсалыг Эвенки хэлний нөлөө гэж авиа зүйч эрдэмтэн И. Д. Бураев тэмдэглэсэн нь анхаарал татаж байна.

Mo. *sara* 'сар', MM *sara* (MNT, KMQB, Mu, IM, L.), CM *hara* (Alar, Barg, Ekh-Bul, Kach, Khori Tünk.), *sara* (Sart, Tson.)

Mo. *sayin* 'сайн', MM *sayīn* (MNT, KMQB, Hy, Mu, IM, L, Ph.), CM *hain* (Alar, Barg, Ekh-Bul, Kach, Khori.), *sain* (Sart, Tson.)

Mo. *usun* 'ус', MM *usun* (MNT, KMQB, Hy, Tk, D, Mu, IM, L, Ist.), CM *uhan* (Alar, Barg, Ekh-Bul, Kach, Tük.), *usa* (Sart.), *usu* (Tson.)

Mo. *ǰiγasun* 'зарас', MM *ǰiγasun* (MNT, Hy, L, Mu.), CM *zağahan* (Alar, Barg, Ekh-Bul, Khori, Tünk.), *zağas* (Tson.), *dzağas* (Sart.)

2.3.3 ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ СОЛИГДОЛ

§ 100. Гийгүүлэгч авианы солигдолыг судалсан нь. Монгол хэлний гийгүүлэгч авианы солигдолын талаар хэл зүйн бүтээлүүдэд удаа дараалан тэмдэглэж байсанаас гадна энэ талаар тусхайлан судалсан ном үгүүлэлүүд гарчээ. Тухайлвал, Түрэг-Монгол хэлний гийгүүлэгчийн солигдолын харьцуулсан судалгааг халимаг эрдэмтэн Номинханы Цэрэндорж, залгамал хэлний авиа солигдох ёсны үүднээс Т. А. Бертагаев, монгол хэлнүүдийн авианы солигдолын талаар халимаг эрдэмтэн Г. Ц. Пюрбеев нар тус тус судалжээ.[762]

Орчин үеийн монгол хэл аялгуунуудыг дагнан судалсан бүтээлүүдэд тухай тухайн хэлнүүд дэх гийгүүлэгч авианы солигдолын талаар ажиглан тэмдэглэсэн зүйл олон бөгөөд сүүлийн үед орчин цагийн монгол хэлний гийгүүлэгч авианы солигдлын ерөнхий зүй тогтлын талаар залуу эрдэмтэн Г. Гантогтох, М. Базаррагчаа, Ж. Санжаа нарын судалгааны ном үгүүлэлүүд гарлаа.[763]

Гийгүүлэгч авианы солигдолын тухай товч тэмдэглэл

Бид энд *'солигдол'* гэдэг нэр томъёоны дор тухайн нэгэн гийгүүлэгч нөгөө гийгүүлэгчээр солигдох хувьсалыг авч үзэж байна. Ер гийгүүлэгч авианы солигдол гэдэг нь хэл ярианы урсхалд авианы харилцан бие биедээ нөлөөлөх хуулийн дагуу тухайн гийгүүлэгч нь зэрэгэлдээх гийгүүлэгчтэйгээ хэлэгдэх байдалаараа ойртон ижилших буюу эсвэл холдон ондоошох байдалаар анхныхаа хэлэгдэж байсан шинжээ алдаж байгаа хэрэг юм. Тодоруулан хэлвэл, авианы солигдол нь гадаад орчиныхоо хувид ижилшиж, дотоод бүтэцийнхээ хувид ондоошин солигдож байдаг. Ер морфемийн харьцаан дахь гийгүүлэгчид нь эгшигийн зохицолын нэгэн адил тодорхой тогтсон байрлалд байдаг тул солигдож буй тухайн гийгүүлэгч нь авианы гадаад орчиныхоо нөлөөгөөр ижилшиж, байгаа хэдий ч дурын гийгүүлэгч дурын гийгүүлэгчтэй солигддоггүй, авианы хэлэгдэх тодорхой шинжийн хүрээнд солигддог байна. Нөгөө талаар, фонетик, фонологийн шинжээрээ бие биеэсээ холдон салсан орчин үеийн монгол хэлнүүд дэх гийгүүлэгчийн ижилшил, ондоошил нь өөр хоорондоо харилцан адилгүй байдаг тул тэдгээрийн нийтлэг зүй тогтлыг нарийвчилан гаргах боломж монгол хэл судалалын өнөөгийн түвшинд бараг алга байна. Тийм учираас бид энд гийгүүлэгчийн хувьсалыг нийтэд нь *'солигдол'* гэдэг нэгэн ерөнхий нэрийн дор авч үзлээ.

---

